Кур'ан-и Кэримийн Туяанд
Пайгамбарчуудын цуваа



Хазрат-и
Мухаммед Мустафа

-Саллаллаху Алэйхи вэ Сэллэм-

Осман Нури Топбаш

1 [МАККАГИЙН ЭРИН]

ЭРКАМ НИЙТЛЭЛ

بسم الله الرحمن الرحيم

Истанбул 1433 / 2012

Истанбул 2012
Эркам Нийтлэл
Ikitelli Organize Sanayi Bölgesi
Turgut Özal Cad. No: 117/2-C
Başakşehir, Истанбул – Түркия
Tel.: +90 (212) 671 07 00 pbx.
Fax: +90 (212) 671 07 17
e-mail: info@islamicpublishing.net
http: www.islamicpublishing.net

ISBN : 978-9944-83-***-*

Номын Түрк хэлний эхний жинхэнэ хэр:
Hazreti Muhammed Mustafa (Mekke Devri) – 1

Зохиолч нь : Осман Нури Топбаш
Найруулсан нь : Нямын Заяа
Хавтас : Расим Шакироглу
Хэвлэсэн газар : Расим Шакироглу (Wordgraphics)
Хэвлэсэн газар : Эркам Нийтлэл

Кур’ан-и Кэримийн Туянд
Пайгамбарчуудын цуваа

Хазрат-и Мухаммед Мустафа

-Саллаллаху Алэйхи вэ Сэллэм-

- 1 -

Осман Нури Топбаш

ЭРКАМ НИЙТЛЭЛ

Аллах Таала ингэж айлдана:

وَإِنَّكَ لَعَلى خُلُقٍ عَظِيمٍ

“Аяа Элч минь ээ,Гарцаагүй чи агуу ёс суртахуун дээд мөн!” (эл-Калэм, 4)

لَقَدْ كَانَ لَكُمْ فِي رَسُولِ اللهِ أُسْوَةٌ حَسَنَةٌ لِمَنيَرْجُوا اللهَ وَالْيَوْمَ ٱلآخِرَ وَذَكَرَ اللهَ كَثِيرًا

“Аяа итгэгчид ээ! Тангараг өргөе, Расулаллахад таны төлөө, Аллах болон ахират өдөрт хүрэхийг найдагсад ба Аллахыг ихээр дурдагсдын төлөө үсвэ-и хасэнэ (хамгийн гоё нэгэн жишээ) **бай-даг.”** (эл-Ахзаб, 21)

إِنَّ اللهَ وَمَلائِكَتَهُ يُصَلُّونَ عَلَى النَّبِيِّ يَا أَيُّهَا الَّذِينَ آمَنُوا صَلُّوا عَلَيْهِ وَسَلِّمُوا تَسْلِيمًا

“Мэдээж Аллах болон мэлэкчүүд нь Пайгамбарт (ихээр) **салат хийнэ. Аяа итгэгчил ээ! Та ч Түүнд салат авчирч бүрэн бууж өгөөд мэнд хүргэцгээ.”** (эл-Ахзаб, 56)

وَمَا آتَاكُمُ الرَّسُولُ فَخُذُوهُ وَمَا نَهَاكُمْ عَنْهُ فَانْتَهُوا وَاتَّقُوا اللهَ إِنَّ اللهَ شَدِيدُ الْعِقَابِ

“...Элч манд юу өгвөл тэрийг авцгаа! Танд юуг хориглосон бол тэрнээс ч татгалзан Аллахаас айцгаа! Учир нь Аллахын тамлал цээрлэл нь хатуу шүү.” (эл-Хашр, 7)

يَا أَيُّهَا الَّذِينَ آمَنُوا أَطِيعُوا اللهَ وَأَطِيعُوا الرَّسُولَ وَلاَ تُبْطِلُوا أَعْمَالَكُمْ

“Аяа итгэгчид ээ! Аллах болон Пайгамбарын үгэнд ороод үйлсээ дэмийн гаргуузай!” (Мухаммед, 33)

وَمَنْ يُطِعِ اللهَ وَالرَّسُولَ فَأُولَئِكَ مَعَ الَّذِينَ أَنْعَمَ اللهُ عَلَيْهِمْ مِنَ النَّبِيِّينَ وَالصِّدِّيقِينَ وَالشُّهَدَاءِ وَالصَّالِحِينَ وَحَسُنَ أُولَئِكَ رَفِيقًا

“Хэн ч Аллах ба Расулын үгэнд орвол, тэд Аллахын шим хишгийг пайгамбарчууд, шударгачууд, шэхидчүүд ба салихчуу-дын хамт хүртэнэ. Тэд ямар сайхан андууд вэ.” (эн-Ниса, 69)

أَلَمْ يَعْلَمُوا أَنَّهُ مَنْ يُحَادِدِ اللهَ وَرَسُولَهُ فَأَنَّ لَهُ نَارَ جَهَنَّمَ خَالِدًا فِيهَا ذلِكَ الْخِزْيُ الْعَظِيمُ

“Тэд, хэн нь ч Аллах ба Элчид нь эсэргүүцэхээр оролдвол түүнд үүрдийн тамын галд унахыг мэдээгүй гэж үү? Энэ нь том гамшиг мөн.”

Расулаллах –саллаллаху алэйхи вэ сэллэм- ингэж айлдана:

“Андашгүй нь би сайхан ёс суртахууныг бүтээхээр илгээгдэв.” (Муватта’, Хүснү’л Хулук, 8)

“Жин ба хүмүүсийн босогчдоос гадна газар тэнгэр хоёрт оршигчид намайг Аллахын Элч буйг мэддэг.” (Ахмад бин Ханбэл, Мүснэд, III, 310)

“Танд хоёр юм үлдээнэ. Эдгээрийг бат барих тусам замаасаа төөрөхгүй: Аллахын судар Кур’ан-и Кэрим ба Элчнийх нь Сүннэт.” (Муватта’, Кадэр, 3)

Хазрат-и Мевланагаас:

“Уг амь энэ биед байх хугацаанд би Кур’аны боол юм; Мухаммед -саллаллаху алэйхи вэ сэллэмийн- замын хөрс юм...

Хэн нэгэн миний үүнээс гадна юм дамжуулбал тэр хүнээс ч хол юм, тэр үгнээс ч...”

Өмнөх Үг

Элч нарын Анхан болон Эцсийн Чагт,
Хоёр Оршлын Эзэн, Хоёр Талын Элч,
Хоёр Хотын Тэргүүн, Оршигчийн Туяа,
Орчлонгийн Энэрэл

Хазрат-и
Мухаммед Мустафа

-Саллаллаху Алэйхи вэ Сэллэм -

Хамаг оршигчдын бий болох учир нь Мухаммедын Туяа байсан тул, Хазрат-и Пайгамбар –саллалаху алэйхи вэ сэллэм- Түүний онцгой гайхалтай анхаарал татсан амьдралыг хэдхэн үг өгүүлбэрээр бүрэн дүүрэн илэрхийлэх боломжгүй юм. Гэтэл Түүнийг ойлгох ба ойлгуулах талаар хүн бүр хүч чадлынхаа хэмжээгээр зүтгэх нь тоолшгүй ачтай билээ. Ингэснээр Хазрат-и Пайгамбар –саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн үлгэр жишээ зан чанараас хумхын тоосон чинээ ч гэсэн хувь авах нь, Түүний ёс суртахуунаас сурах вь бидний хувьд нэр хүндийн хамгийн том хишиг буян мөн. Аллахын Элч –саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн гайхамшигт үнэн нь гэрэл халхалсан хар хөшгийг зүүгээр цоолоход тусах хурц туяа адил, сум мэт чигээрээ гэж ойлгож болно. Учир нь Орчлонгийн Агуу Туурвигчийн:

لَقَدْ كَانَ لَكُمْ فِي رَسُولِ اللَّهِ أُسْوَةٌ حَسَنَةٌ لِّمَن كَانَ يَرْجُو اللَّهَ وَالْيَوْمَ الْآخِرَ وَذَكَرَ اللَّهَ كَثِيراً

Мэдээж **Аллах ба мэлэкчүүд нь Пайгамбартай мэндэлнэ. Аяа итгэгч ээ! Та ч Түүний амрыг эрж сэтгэл зүрхнээсээ мэнд хүргэ!”** (эл-Ахзаб, 56) хэмээн айлдсанаар тоолшгүй мэлэкийн хамт “салат ү салам” хийсэн бөгөөд: لَعَمْرُكَ **“Чиний насанд Тангараг өргөе...”** (эл-Хижр, 72) хэмээн айлдсанаар эрхэм хүндэт Пайгамбаруудын Хаан төгс эрдмийг ёсоор нь ухаарахад, бидний үг хэл ярианы боломж огт хүршгүй юм.

Сонгодог уран зохиолын агуу яруу найрагчдаас Шэйх Галибын Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм-д хайр ба хүндэтгэлээ илэрхийлсэн халуун магтаалын уг мөрүүд энэ үнэнийг маш сайхан илэрхийлнэ:

“Чи пайгамбаруудын султан, цуут нэгэн хаан мөн, Эзэн минь ээ! Аргагүйчүүдэд мөнхийн арга мөн, Эзэн минь ээ! Тэнгэрлэг онгонд сүүлчийн өдөр цуглахад хамгийн тэргүүнд байрлах халамжтай хамгаалагч мөн Эзэн минь ээ! Аугаа Эрхийн «Чиний насанд Тангараг өргөе!» хэмээн үг хэлсэн, тэнгэрлэг тангаргаар баталсан Пайгамбар мөн Эзэн минь ээ!..

Чи Хазрат-и Ахмад, Махмуд, Мухаммед мөн, Эзэнминь ээ! Аугаа Эрхийн бидэнд хайрласан, тэнгэрлэг батлалтад хүрсэн нэгэн хаан мөн, Эзэн минь ээ…”

Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн Аллахын үнэ цэнэ маш агуу учраас, Аугаа эрх түүний үгэнд орохыг өөрийнхөө үгэнд орохтой тэнцүү үзэж, Түүнийг өчүүхэн жижиг үл тоохыг хамаг үйлсийг дэмий болгох шалтгаанаар тоолж, Түүнийг хүндтгэхийг сэтгэлийн таквагийн шалгалт бол-

гов. Элчид нь зохисгүй хандахыг мунхаглалын туйл гэж тоолов. Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-д ихээр салат ү салам авчирч, Түүнийг хэзээ ч сэтгэл болон ухаанаасаа гаргахгүй байх хэрэгтэйг мэдүүлэв. Түүнчлэн, мөргөл үйлдэхдээ Тахийат болгонд Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-д:

اَلسَّلاَمُ عَلَيْكَ أَيُّهَا النَّبِيُّ وَرَحْمَةُ اللّٰهِ وَبَرَكَاتُهُ

гээд мэнд хүргэхийг маань шаардав. Мөргөлд байхдаа хэн нэгэнд мэнд хүргэх нь мөргөл эвдэх гэм байсан ч Аллах Таала Элчид нь мэнд хүргэхийг мөргөлийн важиб шаардлага болгов.

Имам Газалий ингэж хэлнэ:

“Мөргөлд сууж байхдаа Пайгамбар Эзнийхээ дүр төрх болон агуу зан чанарыг нь зүрхэндээ бий болго! «эс-сэламу алэйкэ эйюхэ’н-нэбиййү вэ рахматуллахи вэ баразкатүх» гэсэн! Чиний мэнд Аллахын Элчид хүрэх бөгөөд Тэр ч чамд сайхан хариу өгнө гэдэгт итгэ.” (*Ихяу Үлүми’д-Дин*, I, 224)

Халид Багдадий Хазрат ч *Мэктубат*ынхаа дөрөв дэх захидалд Аллама Шихаб ибн-и Хажар эл-Мэккийгээс эдгээрийг дамжуулжээ:

“Мөргөлд уншдаг Тахиатын «эс-сэламу алэйкэ» үг нь Пайгамбар Эзэнд маань л хандана. Энэ нь бараг Аллах Таала Эзэнд маань мөргөл үйлдэж буй үммэтийн мэдүүлснийг зааж, ингэхдээ Эзэн маань -алэйхиссалатү вэссэлам- мөргөл үйлдэгчдийн дэргэд бэлэн байж сүүлчийн өдөр тэдний талаар хамгийн эрдэмтэй үйлсээр нь гэрчлэгч болохтой адил юм. Түүнчлэн Түүнийг бэлэн байхыг мэдвэл итгэгчийн сэтгэл хөөрөх болно.”[1]

1. *Мэктубат-и Мэвлана Халид*, х. 118; *Рисалэтү’р-Рабита,* (Мэвлана сафийюддин, *Рэшахат* тэмдэгт) х. 225-226.

Ийм алдар хүндтэй Орчлонгийн Тэргүүн -саллаллаху алэйхи вэ сэллэм- Эзнээ ёсоор нь ухаарч ойлгуулахын бэрхшээл ил харагдана. Бид ч жинхэнэ үнэн нь чимээгүйдлийн үүрдээр нээгдүүштэй энэ тухай үгсээ, зөвхөн Түүний ариун нэрийг дурдахаар үнэлж дээшлүүлэх зорилгын нэр хүндийг нэхэхээр нэрээ оруулав. Ийм л учраас хүндэт уншигчдаасаа үгсийн маань ийнхүү хүчгүйдлийн хүрээнд хүлээж авахыг гуйя.

Мэдээж Түүнийг ёсоор нь ойлгохтой адил, жинхэнэ бүрэн дүүрэн тайлбарлахад ч хэл ярианы хүч огт хүрэхээргүй. Тэр нь өөрт нь мэдэрсэн хайр ба хүндэтгэлийн эрчмийн харьцаагаар нэвтрүүштэй эцэсгүй туяа ба нууцын орчлон мөн. Түүний ариун байдал ба хандлагыг ухааруулахыг хичээсэн үг өгүүлбэрүүдийнхээ төлөө, өгөөмөр Аллахын хайр ба тусламжийг хүсэн ерөөе.

Салихчуудын тэргүүлэгч нь:

“Раб минь! Чи зөвхөн бууж өгсөн боолчуудаа өршөөх юм бол, нүгэлтнүүд нь хаана очиж ,хэнд хоргодох вэ? Раб минь! Чи зөвхөн таква бүхий боолчууддаа энэрэл үзүүлэх болбол, гэмт хэрэгтэн хэнээс тусламж гуйх вэ!” хэмээн залбирсан байдаг.[2]

Бид ч Орчлонгийн Мөнхийн Хүндэт Хазрат-и Мухаммед Мустафа -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн ариун амьдралыг үгсийн хязгаарт боломжийн хүрээнд илэрхийлэхээр зорилго тавихдаа, хүч чадал дутсан болоод, өөрийн мэдэлгүй гаргасан алдаанаас болж Раббынхаа энэрлийн далайд хоргодъё.

Аяа Раббий! Тэр Орчлонгийн Хүндэт Хазрат-и Мухаммед Мустафа -саллаллаху алэйхи вэ сэллэм- Эзний маань нэр алдраар биднийг өршөөх болтугай! Амин!

2. Бэйхакий, *Шуабу’л-Иман,* II, 26; Газалий, *Ихяа*, I, 338.

Эрхэм хүндэт уншигчид аа!

Өмнө нь *Пайнамбаруудын цуваа* гэсэн ерөнхий гарчигтай дөрвөн ботиор та бүхнийг дайлсан билээ. Одоо түүнээ өргөтгөж нийтлэхээр бэлтгэв. Хүндэт Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- Эзнээс маань өмнөх пайгамбаруудын амьдрал түүхийг гурван ботиор нийтэлж гаргав. Өмнөх хэвлэлд дөтгөөр ботид гарсан Хазрат-и Мухаммед Мустафа -саллаллаху алэйхи вэ сэллэм- Эзний маань амьдрал шинэ хэвлэлд нэгэн Макка нөгөө нь Мадинагийн эрин болох тустай хоёр боть болж бэлтгэв.

Уг сүүлийн хоёр ботийг өргөтгөж гүйлгэхэд хадис болон сиерийн ишлэлийг анхааралтай нарийн шинжилснийг нь анзаарсан Мурат Каяа болон бусад эрдэмтэд дүү нартаа талархлаа илэрхийлж, тус бүтээлийг садака буюу хандиваар Аллахын онгонд бүтээгдэхийг хүсэн ерөөе. Түүнчлэн ашигласан номуудын зохиогчдыг Аллахын энэрлээр дурдаж, Раббаасаа тэдний төлөө өршөөл хүсэн ерөөе.

Вэ мина’ллахи’т-тэвфик!..

Осман Нури ТОПБАШ
2005/01 сар
Үскүдар

Орц

Исламыг Ойлгох ба Амьдралд Сиер-и Нэбигийн (Хазрат-и Пайгамбарын Амьдралын) онцлог

Хүний төрснөөс эхлээд хүмүүжиж, боловсроход нь нөлөөлөх маш олон нөхцөл шалтгаан байдаг. Нэгдүгээрт нь хүнд бүх талаар үлгэр жишээ болж удирдах нэгэн хүн хэрэгтэй байдаг. Учир нь тэр хэл, шашин, ёс суртахуун, хэвшил г.м. амьдралыг нь дүрслэх хамаг бодол, үнэмшил ба үйлсийг, байнга түүний төлөө толилуулсан жишээ болон тэднээс олж авсан сэтгэгдлээрээ бий болгоно. Зарим жижиг алдаа байсан ч, энэ нь ердөө байдаг зүйл.

Жишээлбэл нэгэн хүүхэд аав-ээж нь ямар хэлээр ярина, эхлээд тэр хэлийг л сурч авна. Дараа нь үлгэр жишээ болгож авсан бусдын жишээгээр хоёр дахь, гурав дахь түүнчлэн дөрөв дэх хэлийг ч сурч болно.

Хүнд заяасан дуурайх эрмэлзэл нь тэр хүний зан чанар төлөвших хамгийн гол шалтгаан болно. Ийм учраас хүний боловрол ч гэсэн эерэг эсвэл сөрөг жишээнээс суралцсаны үр дүн юм. Эдгээрээс хамгийн гол нь төрүүлж өсгөсөн эцэг эх гэр бүл амьдралын орчин нийгмийн байдал оршин байгаа газар орны нөлөөгөөр эерэг эсвэл сөөрөг хүн болж нийгэмшинэ.

Гэхдээ хүн төрөлх болон гадаад хэлээр ярьж сурах нь тийм ч их бэрхшээлтэй зүйл биш,харин шүтлэг бишрэл энэ ба хойд

насны тухай үзэл бодол төлөвших гэдэг амар биш юм. Учир нь энэхүү ухаарч даган дууpайж төлөвших замд томоохон шалгуур болох нүгэл хилэнцийн саад тотгор амьдралынх нь нэг хэсэг болж салахгүй дагасаар байдаг нь буруу замаар оруулж ч магадгүй юм.Ийм учраас далд ертөнцийн тухай агуу хүмүүс , пайгамбарууд ба Эрхийн андууд үлгэрлэн үзүүлэх хэрэгтэй юм. Эс тэгвээс хүн гэдэг мэдэхгүй мунхаг байдлаасаа болж өөрийгөө аварч чадахгүй. Ингээд мөнхийн жаргалаа гунигтай хохирлоор сольж ч магадгүй.

Үүнээс үзвэл хүн төрөлхтөнд уян зөөлөн,нарийн мэдрэмжтэй,ухаалаг удирдамж хэрэгтэй байдаг. Хүн төрөлхтөн -эрэг эсвэл сөрөг- удирдамжаар хүлээн авсан хүмүүстээ дурлана, дурласан хүнээ чадах чинээгээрээ дуурайхыг хичээнэ. Өнөөдөр бузар болон нүгэлд автсан зарим хүмүүсийг өөртөө үлгэр жишээ болгож тэдэн шиг болох тул өөрсдөө мөнхийн жаргалаа алдагсад ямар их хохиролтой вэ!.. Энэ гамшигт алдаа эндүүрэл нь сэтгэлийн хоосныг дүүргэхээс өөр юу ч биш юм.

Хазрат-и Мавлана -күддисэ сиррух- хүний тус сонин хачин байдлыг ингэж илэрхийлнэ:

“Хурга чоноос зугтах нь андашгүй. Угаасаа чоно хурганы дайсан ба анчин мөн. Гэтэл андуурах зүйл нь хурга чонод “дурлах” нь юм!..”

Ийнхүү түр зуурын шалгалтын хорвоод чонод дурлаж мөнхийн хохиролд автахгүйн тулд Аугаа Эрх боолчууддаа **“Үсвэ-и Хасэнэ”** буюу хамгийн гоё жишээ хүн болгож дайлсан, Орчлонгийн Тэргүүн, Элч нарын Эзэн, Хазрат-и Мухаммед Мустафа -саллаллаху алэйхи вэ сэллэм- Эзэнээ алдалгүй дагах хэрэгтэй. Түүнийг сэтгэлийнхээ суудлын ганцхан хаан ба амьдралынхаа удирдамж болгох хэрэгтэй. Учир нь Түүнийг хайр-

лах нь бидэнд фарз болсон байдаг.[3] Аллах Таала Кур'ан-и Кэримдээ:

اَلنَّبِيُّ أَوْلَى بِالْمُؤْمِنِينَ مِنْ أَنْفُسِهِمْ

"Пайгамбарын хувьд итгэгчид нь өөрийн аминаас илүү байдаг..." (эл-Ахзаб, 6) хэмээн айлдав. Тэр бидэнд аминаасаа илүү хайртай.

Хадис-и шарифад ч Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийг хайрыг жинхэнэ итгэлийн шалтгаанаар дурдсан байдаг:

"Нэфсийг минь хүчит гараар барьсан Аллахад Тангараг өргөе; таныг ээжээс, ааваас, хүүхдээсээ ба бусад хамаг хүмүүсээс илүү хайрлаагүй бол жинхэнэ нь итгэсэн гэж тоолохгүй." (Бухарий, Иман, 8)

Өөр нэгэн хадис-и шарифад бол итгэгчийн гурван шинжийг агуулсан хүн амсч чадахыг мэдүүлсний дараа, *"Аллах болон Элчийг нь бүхнээс илүү хайрлах эдгээрийг тэргүүлснийг илэрхийлсэн байдаг.*[4]

Абдуллах бин Хишамын дамжуулсан уг яриа, Расулаллахыг ямар төвшинд хайрлах хэрэгтэйг зааснаараа маш гүн утгатай байдаг:

3. Хар. эт-Тавба, 24.
4. Бусад хоёр шинж бол, "хайрласнаа Аллахын төлөө хайрлах" ба "Аллах түүнийг күфүрийн намгаас аварсны дараа дахиад күфүрт буцахыг галд хаягдах шиг муухай ба аюултай гаж үзэх" юм. (Хар. Бухарий, Иман, 9, 14; Мүслим, Иман, 67.)

“Нэг удаа Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн хамт байцгаав. Хүндэт Элч тэнд байгчдаас Хазрат-и Умарын гарыг атган байж:

“–Аяа Расулаллах! Би чамд аминаасаа илүү биш гэхэд, хамаг юмаас илүү хайртай!” гэхэд Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- Эзэн маань:

“–Үгүй, чи надад аминаасаа илүү хайртай байх ёстой!” хэмээн айлдав.

Хазрат-и Умар - шууд:

“–Тэгвэл чамд аминаасаа ч илүү хайртай, аяа Расулаллах!” гэв. Тэгэхлээр нь Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-:

“–Одоо л боллоо,” хэмээв. (Бухарий, Эйман, 3)

Хайрын шалтгаан ба анхны жимс бол хайрласнаа үл мартах, түүнд үгээр, үйлээр, байдлаар болон санаагаараа бууж өгөх юм. Пайгамбар Эзний маань хайраар дүүрэн нэгэн зүрх зөөхийн тулд эхлээд Түүний сүннэтийг ягштал сурч аваад эдгээрийг хүндэтгэл ба гүн мэдрэмжээр байдал хандлагадаа илэрхийлэхийг шаардах юм.

Учир нь Түүний амьдралыг мэдэлгүй, зүрхээ Түүний хайраар чимэглэлгүй Исламын зөв амьдрал болж чадахгүй юм. Энэ нь Пайгамбарын маань амьдралтай холбогдсоны дараа мэдрэх, гүн гүнзгий онцгой мэдрэмж юм. Түүнийг танилгүйгээр жинхэнэ хайрыг нь мэдрэх , Түүний хайрын төгс төгөлдөрт хүрэлгүй жинхэнэ итгэл үнэмшилд хүрэх боломжгүй юм. Аллахын хайраас хүртэх нь Түүнийг дагахтай хамаатай байдаг. (Хар. Ал-и Имран, 31) Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- Эзэн маань ийм л учраас хайрын тухай ийм нарийн ярьж дахин дахин хайртай хамаатай нарийн учрыг дурдах хэрэгтэйг мэдэрсэн юм.

Пайгамбарчуудын тэргүүн буй Хазрат-и Мухаммед Мустафа -саллаллаху алэйхи вэ сэллэм- Эзний маань амьдрал нь уудам их далайтай адил юм. Түүний шинж байдал нь өөрөөс нь өмнө ирсэн 124 мянга гаруй пайгамбарын мэдсэн мэдээгүй хамаг ерөнхий болон онцгой шинжийг агуулсан, сайхан ёс суртахууны болон бэлгэ тэмдгийн оргилд хүрсэн байдаг. Тэр өөрийнх үе хүртэл хүн төрөлхтний бодол ухаарал ба аж байдлын үзсэн дэвшил дээр хүн төрөлхтний сүүлчийн өдөр хүртэл бий болох хамаг хэрэгцээг ч хангах нэгэн үлгэр жишээ болохоор “Төгсгөл Үеийн Номлогчоор” томилогдов. Тэр “Номлогчдын Сүүлчийнх” мөн.

Түүхэнд бүхэл амьдрал нь хамгийн нарийн зүйл хүртэлээ тогтсон ганцхан Пайгамбар бөгөөд түүнчлэн ганцхан төгс хүн бол Хазрат-и Мухаммед Мустафа -саллаллаху алэйхи вэ сэллэм- Эзэн маань мөн. Пайгамбарчуудын буухиа хүн төрөлхтнийг Эрх ба буянд чиглүүлэх талаар нэгэн жишээ болохуйц төгс хандлагаас манай үед зөвхөн тодорхой цөөн дурсгал хүрсэн байдаг. Гэтэл Төгсгөл Үеийн Номлогч -алэйхиссалатү вэссэлам- Эзний маань хамгийг хялбараас хамгийн төгс хүртэлх хамаг үйлс, үгс ба илэрхийлсэн, түүхэнд нэр алдрын оргил болгож бүртгэсэн байдаг. Түүнчлэн Аллахын үлэмж тусаар хэдэн зуун эриний цаанаас киямат буюу сүүлчийн өдөр хүртэл ирэх хамаг хүн төрөлхтөнд мэдрэгдэх шинжийг хүргэсэн байдаг.

Исламын ёс суртахууныг онолоос дадлагад дэвшүүлж ёс суртахууны бусад онлоос давуу болгосон нь ч Пайгамбар Эзний маань ариун амьдралын хэв маяг буюу Түүний үлгэр жишээ байдал ба хандлагыг “эф’ал-и Пайгамбарий” гэсэн нэрээр нямбай тогтоож зуун зууны турш бат бэх хадгалж манай үед хүрч ирсэн нь байдаг.

Бид нэгэн адил хүн болохоор амьдралын тус тустай гай гамшгийн өмнө өөрсдийгөө муу муухайгаас хамгаалахын тулд шүкүр, тэвэккүл, хувь заяагаа таатай хүлээн авах, гай зовлонг тэвчих, хүндэт зан, өгөөмөр зан, сэтгэлийн баялаг, бусдад санаа зовох, даруу зан мэтийн ёс суртахууны агуу шинж тэмдэг агуулахын хамт, аливаа үйл явдал, саад бэрхшээлийн үед тэнцвэр алдахгүй байх ёстой. Аугаа Эрхийн энэ бүхний талаар төгс нэгэн жишээ болохоор хүн төрөлхтөнд бэлэглэж өгсөн хамгийн агуу төгс сургагч нь элдэг, цэвэр, сонгодог амьдралаараа Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм- Эзэн маань мөн.

Аугаа Эрх нь Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийг хүний нийгэм дотор байдаг дорой буурай “өнчин хүүхдээс” эхлээд амьдралын хамгийн дээд төвшнийг давж хүч мэдлээрээ хамгийн дээрх цэг буюу пайгамбар тэргүүний орон сэнтийд залрав. Эзний маань хамаг амьдрал үе бүх нь хүний амьдралын бүх зовлон жаргал,уруудах өгсөхийн олон жишээг толилуулна. Ийм л учраас Түүний амьдрал -ямар төвшин,байдалд байсан ч- хамаг хүн төрөлхтөнд өөрийнх чадал ба боломжоороо дуурайж чадах үйлийн, биеийн төгс жишээ бүрдсэн байдаг. Өөрөөр хэлбэл Ислам нь төвшин бүрийн хүний амархан ойлгож чадахаар тийм боловсронгуй болсон байдаг.

Аугаа Эрхийн энэ барагдашгүй бэлгийн хариуд бидний үүрэг бол Сиер-и Нэби буюу гэгээн Мухаммедийн амьдралаас суралцаж, хамгийн сайнаар сурч амьдрахыг хичээх юм.

Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн бидэнд цорын ганцхан удирдамж ба жишээ буйг мэдэх ч Тэр үлгэр жишээ болохдоо ямар хэмжээтэй байхыг мэдэх бөгөөд маш чухал албатай юм. Учир нь Түүний шинж хандлага нь хоёр хуваагдана:

1. Зөвхөн өөрт нь хамаатай.

Жишээлбэл хааяа биш, байнга хөлөө хавдтал шөнөжин мөргөж өнгөрөөдөг нь, тасралтгүй мацаг барих нь, Ухуд уулын чинээ алттай байсан ч -өрөөсөө гадныг- бусдад тарааж байсан нь, өөрөө болон гэр бүлийнхнээ зэкат садака төрлийн хандив авахыг киямат өдөр хүртэл хориглосон гэх мэт...

Ийм учраас:

"Би зөвхөн та нар шиг нэгэн хүн..." (Бухарий, Салат 31, Ахкам 20) хэмээсэн ч хэрэгтэй тохиолдолд:

"Би таны аль нэгэн шиг биш; намайг Аллах идүүлж уулгадаг..." хэмээв. (Бухарий, Савм 49; И'тисан 5; Мүслим, Съям 57-61)

Итгэгчид энэ талбайд Түүнийг дагах хүч хүрэхгүй, Түүний ил далд увьдсаар хийх үйлсийг хийж чадахгүй, Түүн шиг байж чадахгүй. Пайгамбарчуудад үммэтдээ жишээ болох нь гол байсан ч, ийнхүү шинж бэлгэ нь Аллахын Элчийн биед харъялагдсан тул үммэтийн жишээ агуулдаггүй.

2. Түгээмэл шинж нь.

Бид зөвхөн Түүнд заясан агуу эрдмээс үлгэр жишээ болгон даган дуурайдаг. Угаасаа эгэл жирийн бидэнд тийм өндөр төвшний байдал, хандлага өөрөөр хэлбэл оддын хэмжүүр болох тэр хэмжээст хүрэх боломжгүй юм. Гэхдээ өөрийн бололцоо хэмжээгээр түүнийг даган дуурайж,гэрэлт мөрөөр нь явах хэрэгтэй.

Тэгэхлээр, Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм- бол нийгмийн салбар давхарга бүрт хүмүүсийн төлөө -хүн төрөлхтний шаардлага ба хүчээр хэрэгжүүлсэн үйлсийн талаар- бодит нэгэн жишээ мөн гэсэн үг. Үүнд ч зарим хандлага нь сүннэт, заримын бол зөвшөөрөл буйд анхаарал тавих

хэрэгтэй. Тус ялгааг жинхэнэ утгаар нь ухаарахад том амжилт толилуулсан үндэстэн маань бие хүн болгондоо "Мэхмэтчик" буюу жижиг Мухаммед гэсэн нэр өгч хүн бүрийг өөрийнх хүч болон боломжоор нь Түүний жижиг нэгэн загвар болоход залахыг хүссэн байдаг.

Сирэт-и Нэбэвий буюу Пайгамбарын амьдрал түүх нь Кур'ан-и Кэримийг ойлгож зориулалтыг нь ухаарах ба түүний далд ертөнцтэй танил болох талаар чухал байр суурь эзэлнэ. Учир нь аетуудад:

نَزَلَ بِهِ الرُّوحُ الْاَمِينُ عَلَى قَلْبِكَ لِتَكُونَ
مِنَ الْمُنْذِرِينَ بِلِسَانٍ عَرَبِيٍّ مُبِينٍ

"Рух-и Эмин (Жэбраил)**, тэр** (Кур'аныг) **Чамайг сануулагчдаас болох гэж ил далангүй Араб хэлээр Чиний зүрхэнд буулгав,"** (эш-Шуара, 193-195) хэмээн айлдсан ба Кур'ан-и Кэрим нь Эзний маань -саллаллаху алэйхи вэ сэллэм- хорин гурван жилийн пайгамбарын үүргээр төгс төгөлдөр тайлбарласан байдаг. Жишээлбэл Хазрат-и Аиша эх маань ч; "Түүний ёс суртахуун нь Кур'ан байв," хэмээн (Мүслим, Мүсафирийн, 139). Ийм учраас нэгэн мусульман нь Пайнамбар Эзний маань хадис-и шариф болон амьдралыг сайхан сурахгүйгээр Кур'ан-и Кэримийг ёсоор нь ойлгох нь боломжгүй юм.[5]

5. Үгээр илэрхийлсэн үнэнийг үйлт жишээгээр дэмжихгүй бол хэрэгжүүлэхэд алдаа хийхээс аргагүй байх болно. Учир нь онолын юмыг хүн бүр нь өөрийнхөө туршлага ба ухааны хэмжээнд ойлгоно. Бодит жишээ нь тухайн онолын үнэнийг үйлдэхэд болох хэрэгтэй аргыг нь маргалдаангүйгээр илрүүлнэ. Ийм л учраас хүн төрөлхтөнд эрх ба буяныг санал болгох зорилгоор ярьсан хамаг үзэл саналууд бодит хэмжээс харуулдаггүй учраас эдгээрийг хэрэгжүүлэхэд маш олон ялгаа илэрсэн байдаг. Исламын бодол энэ талаараа бусад ямар ч бодолтой зүйрлэшгүй баялагтай ба төгс байдаг. Үүнийг хангасан ч Хазрат-и

Түүнчлэн нэгэн мусульманы Исламын соёлыг зөв ухаарч эзэмших нь ч Орчлонгийн Хүндэт -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн хорин гурван жилийн пайгамбарын амьдрал нь эгэл бор амьдралаас эхэлж гүн мэдрэмж болон зүрхний төгс төгөлдөрт хүрсэн байдаг. Сэтгэлийн хорвоо нь Аллахын Элчээс үүссэн эрдэм буюу эерэг энергээр дүүрэхдээ ч төгс төгөлдөр болно. Учир нь Исламын зарчим болон шийдвэрийн хамгийн нарийн зүйл хүртэл нь толилуулсан ганцхан зураг нь Оршигчдыг Туяа -саллаллаху алэйхи вэ сэллэм- Эзний маань онцгой амьдрал мөн.

Хүмүүсийг Исламын энх тайван ба жаргалаар дүүрэн амьдрах арганд урьж буй мэдээлэгч болон сургагч нарын ч ухаан болон зүрхний эв ээ, ухаанаас гарсан юм. Учир нь Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- Эзэн маань боловсрол, сургаал ба мэдээлэх талаараа ч хамгийн бат ба төгс нэгэн жишээ мөн.

Товчоор нь шударга ба итгэмжтэй болох юм, Аллахын урих энэ замыг сонговол эрдэм чадал, сайхан сургаал ёс суртахуунд хүрч, эрдэм чадал,ур ухаан төгс төрийн удирдагч тэргүүн болохыг, үлгэр жишээ өрхийн тэргүүн байхыг, улс үр хүүхдүүд болон хань ижилдээ халамж ба энэрлээ зориулдаг аав, хэзээ хаяаж тушааж залахаа мэддэг цэргийн авьяаслаг жанжин, товчоор хэлбэл нас, зэрэг, төвшин нь хэр байсан ч мусульман бүрийн хувьд хамгийн зөв сайхан байж болох оргилын хэмжээнүүдийг Сиер-и Нэбий толилуулна.[6] Ийм учраас Исламыг бүх талаар нь

Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм- онолын хамаг үнэнийг амьдрал ба хандлагаараа бодитжуулсан ба эдгээрийг сахабийчууд анхны ээлжээр тогтоож бидэнд хүргэсэн нь байдаг.

6. Энэ үнэнийг өрнөдийн нэгэн гүн ухаанч нь энэ үгээрээ илчлэхээс аргагүй болов:
"Хэн ч Хазрат-и Мухаммедын зарчмаас урагш алхаж чадахгүй. Европод олон янзын амжилт хувь болсон ч Европчуудын тогтсон хамаг хуулиуд Исламын соёлтой харьцуулбал дутуу байдаг. Бид Европын үндэстнүүд

ойлгож хэрэгжүүлэхийн тулд Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн амьдралаас сайхан сурах нь хамгийн чухал юм.

Гарцаагүй Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн амьдрал нь сурах, сургах ба амьдрах хүн төрөлхтөнд амьдралын төгс нэгэн жишээ хайрлах болно.

Исламыг Төрөхөд
Араб орон Өлгий нь болсны учир.

Исламыг төрөхөд Арабын Хойгийн өлгий буюу анх илрэх газраар сонгосны учрыг ойлгохын тулд нэгдүгээрт нь Арабчуудын Исламаас өмнөх байдал явдлыг, ааш занг, тэдний амтларч байсан орчны газар зүй, улс төр болон нийгмийн шинжийг мэдэх хэрэгтэй болно.

Тэр үеийн хоёр агуу улс асан Византи Иран Арабчуудын хөрш байв. Византи колони байсан улс орнуудад шашны маргалдаан болж хямрал болж байв. Удирдагчид Христийн шашныг өөрсдийн хүслэнгийн дагуу тоглоом болгосон байв. Консул гэдэг хурлуудад хүссэн номыг судар гэж зарлаж, хүсээгүй шийдвэрийг хүчингүй болгож, шашны дүрэм журмыг өөрийнх хүслийн дагуу өөрчилдөг байв. Тэргүүлсэн эзэн нь нэг өмнөхийг афороз буюу шашнаас гаргаж, шашны гол дүрмийг хүссэнээрээ өөрчилдөг байв. Иргэд татварт дарлуулж, эзэд дээдэс хээл хахуульд автагдан ёс суртахууны доройтолд орж,энэ нь улмаар их гүрний ирээдүйг бүрхэг болгож байв.

иргэншлийг хөгжсөн олон завшаантай байсан ч Хазрат-и Мухаммедын сүүлийн гишгүүрт нь хүрэх анхны шат юм. Андашгүй нь хэн ч энэ уралдаанд Түүнийг гүйцэж чадахгүй. Мөн энэ ном нь (Кур'ан) ч хэтэрхий хялбар байсан тул нөлөөгөө үүрд мөнх алдахгүй ба бусад үндэстнүүдийг эргэн тойрондоо хураах болно.” (Йохан Волфганг вон Гөтэ)

Иран бол улс төрийн талаар ч ёс суртахууны талаар ч маш их холимог байдалтай байв. Эрчүүдийг өөрийнхөө ээж эсвэл охинтой гэрлэхийг зөвшөөрсөн ба хүний нэр газарт унажээ. Мухар сүсэг мунхрал дээд цэгтээ тулж, буруу номын үзэл бодол агуулсан “Маздакизм” агаар, салхи, усыг хамтдаа хэрэглэдэг шигээ, бүх юмыг дундаа хамтдаа хэрэглэхийг хэлээд эмэгтэй бүрийг бузар хэмээн хамаг хөрөнгийг дундын гэж зарласан байв.

Грекийн иргэншил буруу тойрогт орж гүн ухааны маргалдаан болон мухар сүсгийн дарангуйлалд байхад Энэтхэгийн иргэншил ч ёс суртахуун болон нийгмийн талаар туйлын доройтолд ухарчээ.

Харин Арабчууд бол ийм олон холимог маргалдаанаас хол, эргэн тойрон нь цөлөөр бүсэлсэн, цэргийн дайралтаас, соёл болон иргэншлийн довтолгоонд өртөөгүй ариун байдалтай аюулгүй, амар амгалан амьдарч байв. Боолчлол гэсэн гамшгийг хэзээ ч амсаагүй байв. Арабчуудын байгаль газар нутаг ба ааш зан,зан үйл ямар нэгэн юманд өртөөгүй, ороогүй, эвдрээгүй байв. Ааш зангийн шинж чанар нь алдаагүй байв. , амласнаа биелүүлдэг, өгөөмөр зан, үнэнч сэтгэл, тэвчээр ба зориг мэтийн магтамаар бусад шинж агуулдаг байв. Гэхдээ тэд үнэнийг заах удирдамж үгүйгээр, мунхгийн харанхуйд амьдарч байцгаав.

Мунхаглал ба харанхуй байдал нь нүгэл хийх,буруу замд оруулах,зөв замаас төөрүүлэх нөхцөл болно. . Нэр алдраа хамгаалах шалтгаанаар нялх охидоо, эхийнх нь зүрхийг галзууруулан амьдаар нь газарт булж, эд хөрөнгөө алдан ядуурч, өс хонзон саналцан цуст дайн байлдаан өдөөж байв. Исламын шашаин үүссэнээр мунхаглалын ёс суртахууны шинж тэмдэг нь учир утгаар том нэгэн өөрлөлт үзээд зохимжтой байдалд нь орж, төгс төгөлдөр болов. Өөрөө хэлбэл Пайгамбар Эзний

маань өөрчлөлтөөр хуучны хүмүүнлэгийн ойлголт аюултай хамаг хэтэрхий байдлаас нь арилгаж иргэн байдалд оров.

Исламын илрэх байрлалаар Арабыг сонгосны өөр нэгэн учир ч, Пайгамбар Эзний маань -саллаллаху алэйхи вэ сэллэм- элч ба номлогчийн үүргийн тухай хэн нэгний зүрхэнд нэгэн сэжиг төрөхгүйг батлах зорилго мөн. Арабчууд унших-бичиг мэддэггүй, үммий нэгэн үндэстэн байв. Ийм учраас хөрш улсуудын барагдсан бөгөөд муудсан соёл ба гүн ухааны нөлөөнд ороогүй байцгаав.

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- үммий хэн нэгэн биш, хөрш улс ба иргэншлүүдийн түүх ба соёлыг, өмнөх тэнгэрлэг судруудын агуулгыг эзэмшсэн нэгэн буйгаараа номлох үүргээрээ хүн төрөлхтний өмнө гарсансан бол, мэдээж хүмүүсийн Түүний авчирсан юмыг тэнгэрлэг вахий гэж хүлээж авах нь ийм амархан болохгүйсэн. Исламын зорилго тэр чигээр Грек, Византи эсвэл Иран мэтийн соёл иргэншлийн талаар тодорхой хөгжил давсан улсуудын нэгэнд илэрсэнсэн бол, хүмүүсийн Исламын зарчим ба дүрмийг хүлээн авахад хэцүү болох нь ил байв. Учир нь энэ удаа, Исламын шашин тэнгэрлэг үүсэлтэй байсныг -магадгүй- хүлээж авалгүй, эдгээр соёл иргэншлийг нэгнээс үүссэн гэсэн бодол ба сэжиг төрөх байв. Үүнээс үзвэл Исламын шашин тэнгэрлэг үүсэлтэй байсны эсрэг ямар нэгэн санаа төрөхгүйн тулд, Пайгамбар Эзнийг маань -саллаллаху алэйхи вэ сэллэм- үммий буюу сурч боловсроогүй нэгэн буйгаараа томилогдсон байв.

Арабын хойг, Ази, Африк ба Европ тивийн уулзсан цэгт ба янз янзын улсуудын яг дунд оршсоны улмаас Исламыг тарахад байрлалын ч давуу талтай байв.[7]

7. Хар. Мухаммед Иляс Абдүлганий, *Тарихү Макка,* х. 12-13.

Исламын төрөхөд өлгийгөөр сонгосон Маккаг Кур'ан-и Кэрим **"газар тариалан болдоггүй нэгэн хөндий"** гэж таниулна.[8] Ийм учраас тэнд хүмүүс зөвхөн наймаа хийдэг байв. Газар тариалан эрхэлсэн хүмүүс хөрсөнд холбоотой, их хол газар явж сураагүй хүмүүс мөн. Гарын уртай хүмүүс мэргэжлээсээ болж хөдөлгөөнөөс хол байдаг. Зөвхөн наймаачин хүмүүс хол аялалд явах тэсвэртэй, нутгаасаа хол газар явж өөр хүмүүстэй харилцах боломжтой байдаг. Исламыг ойлгоход, нээж мэдэж авахад хөдөлгөөнтэй нүүдэлчин амьдрал шаарддаг тул, ийм шинж агуулсан Маккагийнхан Исламын анхны хүмүүс болсон юм.

Тэнгэрлэг шийдвэр нь Исламын урилга, Аллахын үгсийн орчуулагч ба мэдээлэх арга болох нэр хүндийг Араб хэлэнд хайрласан байдаг. Олон хэлний хооронд харьцуулж үзвэл Араб хэлний сонсголон, үгийн бүтэц ба бүтээх арга, үйл үгийн хэв ба аялга дүрэм зэргээрээ бусад хэлнүүдээс давуу байсан нь харагдана. Араб хэл өчүүхэн зүйлийг ч орхихгүй оновчтой нэрлэсэн зүйр үг хэлэх боломжтой хэл мөн. Араб хэл сэтгэл зүй, мэдрэмж бодлыг, гайхмаар зөв ба элдгээр илэрхийлж чаддаг. Арван таван зууны турш дүрэм журамд нь ямар нэгэн өөрчлөлт болоогүй нь Араб хэлний бүр тэр үед тогтмол байдалд төгс төгөлдөр болсон хэл болохыг илтгэнэ. Ийм байдлаараа дэлхий даяар тэр үед байсан хэлнүүдээс зөвхөн Араб хэл Тэнгэрлэг шийдвэрийг дааж илэрхийлэх төгс төгөлдөр байдалтай байв.

Арабын Хойг зөвхөн Исламын биш, маш олон үнэн шашин дэлгэрсэн элбэг нэгэн орон мөн. Пайгамбар Эзний маань омог Хазрат-и Ибрахим -алэйхиссэлам- энд амьдарч Кабаг барьсан юм. Маккагийнхан ч үүний мэдлээр өөрсдийгөө Ибрахим ба Исмаил -алэйхимэссэлам-ын өв залгамжлагч гэж үздэг байв.

8. Хар. Ибрахим, 37.

Тийм учраас Исламын шашин ийм газар оронд үүссэн нь түүнийг хүлээн авах ба ойлгохыг хялбар болгож байв.

Түүнчлэн, хүн төрөлхтний түүхтэй чацуу шашны нэгэн төв буй Кабагийн энд оршсон нь ч чухал учрын нэг юм.

Эдгээр бүхнээс гадна бидний мэдэж чадахгүй өөр олон нууц учир байсан нь ч үнэн. Тэнгэрлэг шийдвэрийг зарим нууц учраар томилох ба хязгаарлах аргагүй юм. Ийм л учраас энэ тухай үгс Аллах шийдснээ хамгийн сайн мэдэгч мөн, ” гээд өндөрлөе.

اَللّٰهُ أَعْلَمُ بِمُرَادِهِ

Үммү’л-Кура: Макка

Макка нь Кур’ан-и Кэримд “Үммү’л-Кура”, “Бакка” ба “эл-Бэлэдү’л-Эмин” гэсэн нэрээр дурдагдсан байдаг. Макка ба Бакка нь Бабилын хэлэнд “гэр” гэсэн утгатай бөгөөд Амаликчууд тус газрыг түүгээр нэрлэсэн байдаг.

Макка өмнөд Йеменд, хойд Цагаан тэнгист, дорнодод Басрагийн булан ба өрнөдөд Улаан тэнгисийн боомт Жиддэгийн хөрш болж Африкын чигээр явах олон замын уулзах цэг дээр, эдийн засгийн талаар маш зохимжтой нэгэн байрлалд оршиж байв. Хот байршуулсан хэсгийг “Батн-и Макка”, Мэсжид-и Харам оршдог газрыг бол “эл-Батха” гэж нэрлэдэг.

Хазрат-и Ибрахим -алэйхиссэлам- Сара эхээс маань хүүхэдтэй болоогүй байв. Сара эх маань Хажар гэсэн нэртэй шивэгчинээ чөлөөлж Ибрахим -алэйхиссэлам-тай гэрлүүлэв. Энэ гэрлэлтээс Хазрат-и Исмаил хорвоод мэндэлж, Мухаммедын туяа Исмаил -алэйхиссэлам-д дамжив. Сара эх маань үг туяаг өөрийн хүүхдээ дамжуулахыг бодож байв. Ийм учраас хэт гунив. Ибрахим -алэйхиссэлам-аас Хажар

эхийг маань өөр нэгэн нутагт аваачихыг гуйв. Ибрахим -алэйхиссэлам- ч Аллахын тушаалаар Хажар эхийг маань болон хүү нь Хазрат-и Исмаилыг, тэр үеэр зэлүүд нэгэн орон асан Маккад авчрав. Жэбраил -алэйхиссэлам- Түүнийг удирдаж байв. Маккад хүрээд:

“–Аяа Ибрахим! Гэр бүлээ энд суурьшуул!” гэв.

Хазрат-и Ибрахим:

“–Энэ газар тариаланд ч малын аж ахуйд ч зохимжтой биш!” гэхлээр нь Жэбраил -алэйхиссэлам-:

“–Тийм, чиний зөв, гэтэл энд чиний хүүгийн удмаас Үммий Пайгамбар гарч «эл-Кэлимэтү’л-улъяа: хамгийн агуу үг буй тэвхид» Түүнтэйгээр бүтэх болно,” хэмээв. (Ибн-и Са’д, I, 164)

Абдуллах бин Аббас[9] -радщяаллаху анх- ингэж мэдүүлнэ:

9. **Абдуллах бин Аббас** -радъяллаху анх- Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн авга ах Хазрат-и Аббасын хөвүүн юм. Ээж нь Хазрат-и Хатижагийн яг араас мусульман болсон Үммү’л-Фадл Лүбабэ юм. Ибн-и Аббас нь хижрэтээс гурван жилийн өмнө Маккад төрөхөд, түүнийг аваачаад Хүндэт Расулын тэвэрт тавьцгаав. Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- ариун амандаа идэж байсан нэгэн хасарвааныг түүний тагнайд түрхэв. Ибн-и Аббас “тахник” гэдэг ийм шинжээрээ асхабны дунд маш агуу авъяас эзэмшив. Дараа нь Пайгамбар -алэйхиссэлам- түүний төлөө хоёр удаа залбирч, эдгээрээс нэгэнд; *“Аллах минь! Түүнийг шашны том нэгэн эрдэмтэн (факих) болгож түүнд Кур’аныг сургах болтугай!”* хэмээв. Ийм л учраас тэр нь Кур’ан-и Кэримийг хамгийн сайн мэдсэн сахабий болж, түүнд **“Тэржүману’л-Кур’ан”** буюу Кур’аны орчуулагч гэсэн цол олгосон байдаг. Үммэтийн хамгийн эрдэмт гэсэн утгаар **“Хибрү’л-Үммэ”** гэж ч нэрлэсэн байдаг. Давтсаны хамт 1660 хадис-и шариф дамжуулав. Амьдралын сүүлийн жилүүддээ хараагүй болжээ. Хижрэтийн тооллын 68 / билгийн тооллын 687 онд, Таифад, 71 настай байхдаа өөд болов.

"Ибрахим -алэйхиссэлам- Хажар эхийг маань болон Исмаил -алэйхиссэлам-ыг Маккад аваачив. Ирээдүйд оргилж буй «Зэмзэм» худгийн дэргэд нэгэн модон доор үлдээв. Хажсууд нь хасарвааниар дүүрэн сагс ба усаар дүүрэн ваар тавив. Дараа нь буцаж явав... Хажар эх маань араас нь дуудав:

«–Биднийг энд орхихыг чинь Аллах тушаав уу?»

Ибрахим -алэйхиссэлам-:

«–Тийм!» гэж хариулав.

Хажар эх маань том бууж өгөлтөөр:

«–Тэгвэл Раб минь биднийг хамгаална, үрэхгүй!» гэв. Араас нь Исмаил -алэйхиссэлам-ын дэргэд буцав.

Хажар эх маань болон Исмаил -алэйхиссэлам- хараанаас гарахлаар Ибрахим -алэйхиссэлам- гараа дэлгэж Рабдаа ингэж залбирав:

رَبَّنَآ اِنّٖيٓ اَسْكَنْتُ مِنْ ذُرِّيَّتٖي بِوَادٍ غَيْرِ ذٖي زَرْعٍ عِنْدَ بَيْتِكَ الْمُحَرَّمِ رَبَّنَا لِيُقٖيمُوا الصَّلٰوةَ فَاجْعَلْ اَفْـِٔدَةً مِنَ النَّاسِ تَهْوٖيٓ اِلَيْهِمْ وَارْزُقْهُمْ مِنَ الثَّمَرَاتِ لَعَلَّهُمْ يَشْكُرُونَ

«Аяа Раб маань! Мөргөлөө шударга үйлдэг гэж би удмаасаа хэсгийг тариалан эрхэлдэггүй нэгэн хөндий буюу Чиний Хүндэт Гэрийн Кабагийн **дэргэд байрлуулав. Одоо Чи ч хэсэг хүмүүсийн сэтгэлийг тэдэн рүү хандуулж жимснээс тэдэнд шим хайрла! Тэд талархах нь найдвартай.»** (Ибрахим, 37)" (Бухарий, Энбияа, 9)

Гагцхуу хөвүүн ба эхнэрээ зэлүүд нэгэн цөлд орхисон Ибрахим -алэйхиссэлам- тэдний төлөө ингэж залбирав:

رَبِّ اجْعَلْ هٰذَا بَلَدًا اٰمِنًا وَارْزُقْ اَهْلَهُ
مِنَ الثَّمَرَاتِ مَنْ اٰمَنَ مِنْهُمْ بِاللّٰهِ وَالْيَوْمِ الْاٰخِرِ

“...Аяа Раб минь! Энэ газрыг аюулгүй нэгэн орон болгох болтугай! Ардаас нь Аллах болон ахират өдөрт итгэсэн хүмүүсийг янз янзын жимсээр тэтгэх болтугай!..” (эл-Бакара, 126)

Аугаа Эрх Хазрат-и Ибрахимын итгэгсдийн төлөө хийсэн залбирлыг зөвшөөрөв. Дараа нь үгүйсгэгчдийг сүрдүүлж ингэж айлдав:

قَالَ وَمَنْ كَفَرَ فَاُمَتِّعُهُ قَلِيلًا ثُمَّ اَضْطَرُّهُٓ
اِلٰى عَذَابِ النَّارِ وَبِئْسَ الْمَصِيرُ

“…Үгүйсгэснийг бол, түүнийг (дэлхийн шимээр) **богино хугацаанд ашиглуулж, дараа нь түүнийг тамын зовлонд чирнэ. Тэр нь очихоор ямар муухай газар юм бэ!”** (эл-Бакара, 126)

Уг залбирлын ачаар Аллах Таала хаж ба үмрэ хийдэг итгэгчдийн сэтгэлийг Маккагийн хайраар дүүргэж, сүнснүүд тэнд энх амгаланд хүрдэг юм.

Ибрахим Ибрахим -алэйхиссэлам-ын Хажар эх маань болон Хазрат-и Исмаилын дэргэд үлдээсэн нэг ваар ус их удахгүй дуусав. Хажар эх маань ус олох найдвар өвөрлөж Сафа Марва хоёр давааны хооронд долоон удаа гүйхээрээ яваад ирэв. Уг хоёр давааны хооронд ойролцоогоор дөрвөн зуун метр орчим байдаг. Хажар эх маань нэг талаас гүйж, нөгөө талаас ч Хазрат-и Исмаилыг харж байв. Тэр хавьд хүн байтугай, нисэх нэгэн шувуу ч байгаагүй. Хаа ч амьд амьдралын нэгэн бэлгэ тэмдэг харагдахгүй байв. Хазрат-и Хажар Марва даваанд гарах-

даа нэгэн чимээ сонсов. Өөртөө “Дуугаа! Сонс!” гэв. Дараа нь сайхан сонор үзүүлж, ижил чимээг дахин сонсов.

“–За, чамайг сонслоо. Чадвал бидэнд тусал!” гэж дуудав. Нэг харвал Зэмзэм орших газар нэгэн Мэлэк өсгийгөөрөө -эсвэл далавчаараа- газрыг ухаж байна!

Эцэст нь ус харагдав. Асар их баяраар Рабдаа шүкүр буюу талархлаа илэрхийлэв. Хажар усыг урсгахгүй гэж усыг гараараа хүрээлж, усыг алгаараа тулмандаа хийж эхлэв. Усанд **“Зогс, зогс!”** гэсэн утгаар **“Зэм, зэм!”** гэв. Хажар усыг алгадаж авах тусам, алгадсан хэмжээгээр газраас гарч байв.

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- ингэж айлдав:

“Аллах, Исмаилын ээж Хажарт рахмат хийх болтугай! Хэрэв тэр Зэмзэмийг чөлөөт гараараа хүрээлэхгүйсэн бол, андашгүй нь Зэмзэм байнга урсах нэгэн булаг болохсон.” (Бухарий, Энбияа, 9)

Ээж-хүү хоёр гандуу ба зэлүүд уг оронд амьдралаа зөвхөн Зэмзэмтэйгээр үргэлжлүүлж байв. Тэндээс өнгөрч яваа Жүрхүм аймгийнхан, шувууд байнга нэг газар луу бууж дахиад хөөрөхийг харав. Энэ нь амьдралын тэмдэг байж магадгүй, тийш нь хоёр хүнээ илгээв. Ирэгсэд Зэмзэм усыг харахлаараа Хажар эхээс маань:

“–Бид энд суурьшиж болох уу?” гэж зөвшөөрөл гуйв.

Хажар эх маань “усыг эзэмших хүсэлт тавихгүй” нөхцөлөөр зөвшөөрөл олгов. Ингээд Маззад анх суурьшсан аймаг Жүрхүмийчүүд болов.

Цаг хугацаа өнгөрөх тусам Макка хөгжиж улс төрийн төв хот болов. Йеменээс нүүсэн Хузаагийн хүмүүс Жүрхүмийчүүдээс суурьших зөвшөөрөл гуйв. Зөвшөөрөөгүй байхад тэдэнтэй

байлдаж хотыг 207 онд эзэлж авав. Исмаилынхан тус дайнд талгүй байсан тул Хузаачууд тэдэнд гар хүргээгүй. Хузаачууд Маккаг удаан хугацаагаар эзэлсэн. Цаг хугацаа өнгөрөхөд Ибрахим -алэйхиссэлам-ын шашнаас их хэмжээгээр төөрч баримал шүтлэгийг тарааж хүмүүсийг мунхаглалд автуулав. Хүбэл гэсэн нэрт нэгэн онго барьж түүнд залбирав. Хазрат-и Исмаилын удам асан Курайш хүчтэй болохлоор, Кусайн тэргүүлснээр хөдөлж Хузаачуудыг 440 онд хотоос холдуулав.

Кусай нь Макка хотын төрийн их хурлын хүчинд асан “Дару’н-нэдвэ”г байгуулж, нийгмийн удирдлага, шашны үүргийг гүйцэтгэх тухай холбоог байгуулав. Дару’н-Нэдвэгийн тэргүүний, дайны тугийг хадгалах, Кабагийн үйлчилгээ, хажичуудад усаар дайлах ба татвараар олсон орлогоор хажийчуудад хоол өгөх мэтийн үүргийн Кузай өөрөө дийлж байв. Нас барахдаа тус үүргүүдийг дөрвөн хөвүүнээс хоёр байсан Абду’д-Дар ба Абди Мэнафад өв болгож үлдээв. Эдгээр үүргүүдээ аав нь хүүдээ өв болгож залгамжилдаг байв.[10]

Маккагийн дөчин нас хүрсэн хамаг иргэн нь хурлын уулзалтад орж болох байв. Гэтэл нэгэн заншил болж, тодорхой гэр бүлийн тэргүүн болон аймгийн тэргүүдээс бусдыг уг уулзалтад ер нь оруулдаггүй байв. Сонин нь, тус Дару’н-Нэдвэ удаан хугацааны дараа, Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн урилгыг саатуулахын төлөө хийсэн уулзалтын тавцан болсон юм.

Дару’н-Нэдвэ ба орон нутгийн уулзалтын газар асан “Хадий”нууд нь улс төр болон цэрэгтэй холбоотой шийдвэр гаргах орон байсан мөртлөө, мөн нийгмийн үйл ажиллагаа хэрэгжүүлэх орнууд байв.

10. Хар. Ибн-и Хишам, I, 135-142.

Маккагийн мүшрикчүүд Аллахыг бүхний туурвигчаар хүлээн авсан боловч, олон асуудалд баримал шүтээнийг Түүний түнш түүнтэй адилхан гэж үздэг байв.

Маккагийн газар нутаг тариаланд зохимжтой биш тул, тэнд амьдарсан хүмүүс хүнс идээгээ наймаагаар олдог байв. Ийм учраас Макка Арабын хойгт шашны талаар ч худалдааны талаар ч чухал төв газар эзэлдэг байв. Макка дахь наймааны үйл ажиллагаа өвөл-зунгүй үргэлжилдэг байв. Зуны аялал Сирийн тийш, өвлийн аялал бол Йемений тийш явдаг байв. Зарим жилүүдэд барааг тэмээгээр зөөж, заримдаа тэмээний тоо хоёр мянга таван зуу хүрдэг байв. Наймааны жинчид Маккагийн хавьд чухал байсан учраас, Аллах Таала нь Курайшчуудыг итгэн үнэмших ба залбирахад урихдаа тэдэнд хайрласан уг тусгай ивээлээ сануулж байв:

لِاِيلَافِ قُرَيْشٍ اِيلَافِهِمْ رِحْلَةَ الشِّتَآءِ وَالصَّيْفِ فَلْيَعْبُدُوا رَبَّ
هٰذَا الْبَيْتِ اَلَّذِي اَطْعَمَهُمْ مِنْ جُوعٍ وَاٰمَنَهُمْ مِنْ خَوْفٍ

“Тийм, Курайгид зун ба өвлийн аялал хялбар болгосон тул, тэд өөрсдийгөө цатгаж төрөл бүрийн айдаснаас аюулгүй болгосон уг гэрийн (Кабагийн) **Раббад боолчлол хийчих.”** (Курайш, 1-4)

Улс төрийн ноёрхолгүй ба замбараа муутай асан Арабын хойгт эдийн засгийн ийнхүү санаачилгааг аюулгүйгээр хийх нэлээд хэцүү байсан ч, харам хэмээн нэрлэсэн саруудад ийм аюулгүй байдлыг бүрэн хангадаг байв. Маккаг энэ тухай ч тусгай байсан нь харагдана. Учир нь бусад хамаг яармагийн төлөө зөвхөн Рэжэб сарыг харам гэж үздэг байтал, Макка нь “Эшхүрү’л-Хурум: харам буй дөрвөн сар”ыг бүгдийг нь эзэлдэг байв. Түүнчлэн Басл гэсэн байгууллагаар Макка дахь зарим

гэрбүлийн бараа нь дээрэмдэхийн аюулын эсрэг бусад найман сарын турш хамгаалалттай байв.[11]

Маккагийн хавьд Указ, Мэжэннэ ба Зү'л-Мэжаз гэсэн яармаг болдог байв. Мунхаглалын үед ч нэгэн залбирал үйлчилгээ байсан хажжийн үеэр байгуулж байсан эдгээр яармагууд маш өргөн дэлгэр болдог байв. Эдгээрийн ачаар худалдаанд элбэг орж, Маккагийн наймаачид их орлого олдог байв.

Макка хотын байрлал нь дээр үеэс эргэн тойрны улсуудын анхаарлыг татдаг байв. Бэйтуллах буюу Каба оршдог орон байсны учлаас маш чухал газар байв. Маккаг эзлэхээр олон удаа оролдлого болсон ч хөрш улсууд эзэлж чадсангүй, түүхийн турш эрх чөлөөгөө хадгалсан байв. Бизансчууд ч Маккад нөлөөлөх гэж байнга хичээсэн, гэвч амжилтад хүрээгүй юм.



11. Хар. Хамидуллах, I, 24-25.

Кабагийн Түүх ба Ариун Шинж нь

Каба гэдэг нь Толь бичигт “куб дүрст зүйл” буюу дөрвөлжин гэсэн утгатай хэмээн Кур’ан-и Кэримд хоёр удаа дурдсан байдаг. Аетуудад “Бэйт, Бэйтуллах, эл-Бэйтү’л-атик, эл-Бэйтү’л-харам, эл-Бэйтү’л-мухаррам, эл-Мэсжиду’л-харам” гэх мэт нэрээр ч дурдсан байдаг. Кабаг хүмүүс ер нь “Каба-и Муаззама” гэцгээнэ.[12]

---

12. Каба нь ойролцоогоор 1,5 метр өргөн суурь дээр барьсан байдаг. Маккагийн хавиас авчирсан базалт чулуугаар хийсэн Кабагийн хананд янз бүрийн хэмжээтэй 1614 чулуу байдаг. Дорнод буланд нь, газраас 1,1 метр өндөрт мөнгөн хамгаалалт дотор **“Хажар-и Эсвэд”** бөгөөд, тавафын эхлэх ба дуусах цэгийг тэмдэглэдэг. Каба дээр орсон бороны ус урсдаг ховилыг (**Мизаб-и Каба**) нь **“Алтан Ховил”** хэмээдэг . Кабагийн баруун хойд ханы эсрэг талд, шалнаас 1,32 метр өндөр ба 1,55 метр зузаант хагас дугуй хэлбэрэй ханаар хүрээлсэн газрыг Кабагаас эхлээд анхны 3 метр хэсэг газрыг **Хатим** гэдэг. Хазрат-и Ибрахим -алэйхиссэлам-ын хийсэн Каба байр энэ хэсгийг ч агуулдаг байв. Курайш Кабаг засахдаа боломж нь хүрээгүй тул энэ хэсгийг гадаа үлдээв. Бусад 5,46 метрийн хэсгийг **Хижр-и Каба, Хижр-и Исмаил** эсвэл **Хатира** гэж нэрлэдэг. Ибрахим -алэйхиссэлам- нь Хажар эх маань болон хөвүүн Исмаилынхаа төлөө энд гич модоор сүүдрэвч хийсэн байдаг. Хазрат-и Хажар ба хүү Исмаил -алэйхиссэлам-ын **Хижр** хэсэгт оршуулсныг хамруулжээ. Тавафыг Хижрийн гаднаас хийх важиб гэж үзсэн байдаг. Кабагийн хаалга нь, байрны баруун хойд талдаа шалнаас 2,25 метр өндөр байдаг. Ханы хаалганаас Хажар-и Эсвэдийг хоорондох хэсгийг **“Мүлтэзэм”** гэдэг. Каба нь 14 метр өндөр юм. Мүлтэзэмийн тал урт нь 12,84 метр, Хатим талын урт нь 11,28 метр, Хатимаас өмнөд булангийн хооронд 12,11 метр, өмнөд булан Хажар-и Эсвэдийн хооронд 11,52 метр юм. Кабагийн дотор таазанд тулсан гурван багана байдаг. Эдгээр нь дундуур, өмнөд хананаас Хатимын тийш жагсдаг. Хаалгаар ороход баруун гар талд дээш гардаг нэгэн шат байдаг. Шатны төгсгөлд нэгэн хаалга байх бөгөөд **“Тавбагийн Хаалга”** хэмээн нэрлэдэг. Кабагийн дотуур хана ба таазыг торгомсог ногоон даавуугаар өнгөлсөн байдаг. (Мухаммед Илъяс Абдүлганий, х. 33-66; Камил Мирас, *Тэжрид Орчуулсан нь,* VI, 17-20)

Хазрат-и Адам -алэйхиссэлам- дэлхийд ирэхдээ Маккад Бэйтуллахын орших газар нэгэн сүм барихаар томилогдсон байв.[13]

Аллах Таала ингэж айлдана:

اِنَّ اَوَّلَ بَيْتٍ وُضِعَ لِلنَّاسِ لَلَّذِي بِبَكَّةَ مُبَارَكًا وَهُدًى لِلْعَالَمِينَ

“Гарцаагүй орчлонгуудад элбэг ба авралын булаг болохоор хүмүүсийн төлөө барьсан анхны сүм **нь Макка дахь** Каба **мөн.”** (Ал-и Имран, 96)

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- ч Эбү Зэрр[14] -радъяллаху анх-ын нэгэн асуултын хариугаар дэлхий дээр анхан барьсан сүмийн “Мэсжид-и Харам”, хоёр дахь барьсан нь бол “Мэсжид-и Акса” болсныг илэрхийлсэн юм.[15]

Үүнээс үзвэл Маккагийн хөндий анхны хүний хамт сонгогдож ариун орон болсон байдаг.

Каба нь Нухын Үерийн дараа удаан хугацаагаар элсэн доор үлдэв. Хазрат-и Ибрахим олон жилийн дараа эхнэр болон хүүгээ үлдээсэн Маккад ирээд Исмаил -алэйхиссэлам-д:

---

13. Хар. Табэрий, *Тарих*, I, 124.
14. **Эбү Зэрр** Хазрамын нэр нь Жүндэб бин Жүнадэ бөгөөд Гяфар аймгийн харъяа юм. Ийм учраас Эбү Зэрр эл-Гяфарий гэж алдаршсан байдаг. Мусульманчуудын тав дахь нь юм. Зүхд, таква, ханамжтай зантай нэгэн хүн байв. Ийм учраас Аллахын Элчийг түүнд “Исламын Есүс” (Мэсихү’л-Ислам) хоч өгсөн гэж мэдээлсэн байдаг. Исламыг тараахаар их хичээдэг байв. Байнга Хазрат-и Пайгамбарыг ашигладаг байв. Сурахдаа их хүсэл ба сонирхолтой , Мэдээгүй хамаг юмыг Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ээс асуудаг байв. Хазрат-и Али түүнийг “шинжлэх ухааны уут” гэсэн гэдэг. 281 хадис-и шариф дамжуулав. Хижрэтийн 31 онд Маккагийн ойрхон Рэбэзэд нас барав. Түүгээр өнгөрч явсан цөөн сүсэгтэн оршуулах мөргөлийг нь үйлдэж нутаглуулжээ.
15. Хар. Бухарий, Энбияа, 10.

“–Раббаас минь тушаал бий. Нэгэн бэйт барина. Чи ч надад тусална!” гэв.

Исмаил -алэйхиссэлам- чулуу зөөж, Хазрат-и Ибрахим ч бэйтийн ханыг барив. **Макам-и Ибрахим** хэмээн алдаршсан бөгөөд дээрээ Ибрахим -алэйхиссэлам-ын хөлийн мөртэй гантиг ч, Кабагийн ханыг барихад лифтийн ажил хийв.[16]

Ает-и кэримэ ингэж айлдав:

وَاِذْ يَرْفَعُ اِبْرٰهِيمُ الْقَوَاعِدَ مِنَ الْبَيْتِ وَاِسْمٰعِيلُ
رَبَّنَا تَقَبَّلْ مِنَّا اِنَّكَ اَنْتَ السَّمِيعُ الْعَلِيمُ

“Дээр үед Ибрахим нь Исмаилын хамт Бэйтуллахын суурийг өргөж, (ингэж хэлээд байв:) **«Аяа Раб маань! Биднээс үүнийг хүлээн авах болтугай; мэдээж Чи сонсогч, мэдэгч мөн.»”** (эл-Бакара, 127)[17]

Ибрахим -алэйхиссэлам- нь хүмүүсийн Кабаг таваф буюу эргэхийн им болог гэж Хажар-и Эсвэл хэмээн хар чулууг Кабагийн нэгэн буланд байрлуулав.

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн мэдүүлснээр уг хар чулуу нь Диваажинаас илгээгдэхдээ сүүнээс ч цаснаас ч

---

16. Саид Бэкташ, *Фадлу’л-Хажэри’л-Эсвэд вэ Макам-и Ибрахим (а.с.),* х. 108; Мухаммед Иляс Абдүлганий, х. 71-73.
Нэгэн үгэнд дамжуулснаар Ибрахим -алэйхиссэлам- дараа нь энэ макам дээр өгсөж хүмүүсийг хажжид урив. (Саид Бэкташ, х. 111) Аллах Таала Макам-и Ибрахимын эрдмийг мэдүүлэн ингэж айлдана:
وَاِذْ جَعَلْنَا الْبَيْتَ مَثَابَةً لِلنَّاسِ وَاَمْنًا وَاتَّخِذُوا مِنْ مَقَامِ اِبْرٰهِيمَ مُصَلًّى
“Бид, Бэйтийг (Кабаг) **хүмүүст цуглах орон ба аюулгүй газар болгов. Та нар ч макамаас мөргөлийн газар олцгоо** (тэнд мөргөл үйлдэцгээ)**...”** (эл-Бакара, 125)
17. Дэлгэрэнгүй мэдээлэл олохоор хар. Бухарий, Энбияа, 9.

цагаан байсан атлаа, хүмүүсийн нүглээс ийнхүү тас хар болжээ. (Тирмизий, Хаж, 49/877; Ахмад, I, 307)[18]

Түүнчлэн мунхаглал ба Исламын үед гарсан олон түймрээс болж түүнийг бүр хар болгосон гэдэг. Жишээлбэл, тус хар өнгө зөвхөн гаднаас харагдах хэсэгт буй, Хажар-и Эсвэдийн Кабагийн хана хэсгийг одоо ч цагаан буйг нь мэдэгдсэн байдаг.

Мүжахид ингэж хэлсэн юм:

“Абдуллах бин Зүбэйр -радъяллаху анх- нь Бэйтуллахыг шинэчлэхээр нураахад Хажар-и Эсвэд харжээ; Бэйтийн дотор хэсэг нь цагаан байв.”

Карматийчууд Хажар-и Эсвэдийг Хижрийн тооллын 339 онд буцааж өгөхөд, байранд нь оруулахаас өмнө Мухаммед бин Хафий эл-Хузаий түүнийг ажиглаж ингэж хэлсэн байдаг:

“Хажар-и Эсвэдийг харснаар; хар өнгө зөвхөн гадна өнгөнд байсан, дотор болон бусад хэсэг цагаан байв.”

Дараа нь Хижрэтийн 1039 онд Каба аймшигт үерийн үеэр нурсан байв. Сэргээн босгох үед тэнд байсан Ибн-и Аллан эл-Маккий, барилгын бүтэц бүрийг үзэн дэлгэрэнгүй тэмдэглэсэн бөгөөд Хажар-и Эсвэдийн тухай эдгээрийг хэлсэн байдаг:

“Хүмүүсийн хэлснээр Хажар-и Эсвэдийн Кабагийн доторх хэсгийн өнгө нь Макам-и Ибрахим шиг цагаан мөн…”[19]

---

18. Эрдэмтэд ингэж хэлэв: Нүгэл нь чулууг хүртэл ямар хар болгосныг мэдвэл, зүрхэнд ямар мөр үлдээхийг эрхбиш ойлгож нүглээс хамаг хүчээрээ болгоомжлох хэрэгтэй.
19. Хар. Саид Бэкташ, х. 36-38; Др. Мухаммед Иляс Абдүлганий, х. 43.

Кабагийн барилгыг дуусахлаар нь Хазрат-и Ибоахим ба Хазрат-и Исмаил -алэйхимэссэлам- нь Аллахад ингэж залбирав:

رَبَّنَا وَاجْعَلْنَا مُسْلِمَيْنِ لَكَ وَمِنْ ذُرِّيَّتِنَآ اُمَّةً مُسْلِمَةً لَكَ وَاَرِنَا مَنَاسِكَنَا وَتُبْ عَلَيْنَا اِنَّكَ اَنْتَ التَّوَّابُ الرَّح۪يمُ

رَبَّنَا وَابْعَثْ ف۪يهِمْ رَسُولًا مِنْهُمْ يَتْلُوا عَلَيْهِمْ اٰيَاتِكَ وَيُعَلِّمُهُمُ الْكِتَابَ وَالْحِكْمَةَ وَيُزَكّ۪يهِمْ اِنَّكَ اَنْتَ الْعَز۪يزُ الْحَك۪يمُ

“Аяа Раб маань! Биднийг Чамд бууж өгөгсөд болгох болтугай! Удмаас маань Чамайг дагах үммэт гаргах болтугай; бидэнд залбирах үйлчилгээг зааж тавбаг маань хүлээн авах болтугай; угаасаа тавбаг ихээр зөвшөөрч, агуу энэрэлтэй нь зөвхөн Чи л мөн. Аяа Раб маань! Тэдэнд тэдний дотроос Чиний аетуудыг тэдэнд унших, Судар ба эрдмийг сургах ба тэдний (нэфсүүдий)**г засах нэгэн пайгамбар илгээх болтугай! Угаасаа давагчид, бүхнийг ёсоор нь хийгч зөвхөн Чи л мөн!”** (эл-Бакара, 128-129)

Кабагийн барилга дууссаны дараа Аллах Таала нь Ибрахим -алэйхиссэлам-д хамаг хүмүүсийг хаж мөргөлд урихыг тушаав:

وَاَذِّنْ فِي النَّاسِ بِالْحَجِّ يَاْتُوكَ رِجَالًا وَعَلٰى كُلِّ ضَامِرٍ يَاْت۪ينَ مِنْ كُلِّ فَجٍّ عَم۪يقٍ

“Хүмүүсийг хажид урь; явганаар эсвэл алс холоос ядарч туйлдсан ч урт замыг туулан чамд хүрээд ирцгээг.” (эл-Хажж, 27)

Уг тэнгэрлэг зарлигийн дагуу Хазрат-и Ибрахим Эбү Күбэйс Уулан дээр гарч эсвэл Макам-и Ибрахим дээр өгсч

дөрвөн зүг найман зовхист дуулан Аллахын Кабаг хажид ирэхийг хүмүүст фарз болгосныг мэдээлэв.[20]

Ибрахим -алэйхиссэлам- үүний дараа Жэбраил -алэйхиссэлам- ирж, түүнд Сафа Марва хоёр ба Харам-и Шарифын хязгаарыг заасан, тэмдэг болохоор нэг нэгээр чулуу босгохыг хэлэв. Дараа нь хажийн хамаг фарзыг сургаж өгөв.

Үүнээс хойш ойр ба хол орноос зочид Хижазад ирээд Бэйтуллахад зочилж эхлэв. Каба нь чухал нэгэн шашгы төв болж хамаг хүмүүсийн хүндэтгэлийг олов.

Нөгөө талаас Кабагийн үнэ цэнэ ба ариун шинжид атаархсан тэрсүүд нарын довтолгоонд ч өртөв. Йемений эзэн Эбрэхэгийн өст довтолгооноос өмнөх эринд баримал Йемений шүтэгч байсан өөр гурван эзэн ч Кабаг нураахыг хүссэн байв. Эдгээр довтолгооны нэг Хүзэйлийн удмаас зарим нь Кабаг нурааж тэндэх санг авахаар Түбба'г[21] өдөөв. Түүнийг ийнхүү өшөөт нэгэн довтолгоонд уриалсны учир нь Түбба'гаас аврагдсанд байв. Учир нь Хүзэйлийн удам Кабагийн ариун гэдэгт итгэл үнэмшилтэй бөгөөд түүнийг олон туршлагаар мэднэ. Түүний аливаа эсрэг хандлага мэдээж нэгэн хохирлын учир болохыг маш сайн мэдэж байв.

Кабаг нураахаар хөдөлсөн Түбба' болон түүний хамтрагчид замдаа элсэнд живж Түбба' хамт явсан эрдэмт хүмүүсийн сануулгаар Кабагийн эсрэг бузар муухай зорилгоо болив. Бэйтуллахыг хүндэтгэн Маккагийн хүмүүст ч олон юм дайлахаа амлаж, ингээд хохирлоос аврагдав.[22]

---

20. Хар. Камил Мирас, *Тэжрид Тэржэмэси,* VI, 20-21; Саид Бэкташ, х. 111.
21. Түбба': Йемений эздэд олгосон цол юм. Хаан гэсэн утгаар хэрэглэдэг.
22. Хар. Ибн-и Хишам, I, 19-20; Абдүррэззак, V, 153.

Энэ мэт төсөөтэй явдлууд Кабагийн үнэ цэнийг ил болгож, үүний хэрээр ард түмний дунд нэр хүнд нь ч дээшлэв. Арабын суурьшигчид Каба, Макка ба Курайгчуудын тэнгэрлэг хамгаалалт доор байсны итгэлийг хүлээж авав.

Хазрат-и Ибрахимын дараа Бэйтуллахад залбирал үйлчилгээ нь баримал шүтлэг эхэлтэл тэвхид зарчмын ёсоор үргэлжлэв. Гэтэл Маккад баримал шүтлэг тарахын хамт мүшрикчүүд Кабагийн дотор ба эргэн тойронд нь маш олон шүтээн босгосон байв. Тэгсэн ч Каба хэзээ ч шүтээнүүдийн нэрээр дурдаагүй, байнга “Бэйтуллах” хэмээн нэрээр байдаг.[23]

Маккагийн эзэлсэн өдөрт, Кабагийн доторх шүтээн бүхнийг хугалж хаясан, Кабагийн дотно гадныг Пайгамбар Эзэн минь тэргүүлэн Зэмзэмээр угаасан юм. Тэр өдрөөс хойш Кабаг Тахилын баярын битүүнд Зэмзэм ба сарнайн үнэрт усаар угааж цэвэрлэх ба дэвсгэрийг нь шинэчилнэ.

Мунхаг харанхуй эринд мүшрикчүүдийн маш их үнэлж байсан Муаллакатү’с-Сэб’а мэтийн зохиолын бүтээлүүд ба мусульманчуудтай бүх төрлийн харилцаагаа таслах шийдвэрийг бичсэн шаардах бичиг мэтийн улс төрийн чухал баримтыг Кабагийн хананд өлгөж байсан нь түүний бүх талаараа маш том чухалчлал эзэмшиж байсныг заадаг юм.

Кабатай хамаатай барьсан өдрөөс нааш гүйцэтгэсээр байдаг зарим тусгай үүрэг байсан бөгөөд, эдгээрийг анх Хазрат-и Исмаил даасан байв. Араас нь уг нэр хүндтэй үүргүүдийг Исмаил -алэйхиссэлам- хүүдээ залгамжилсан, дараа нь Жүрхүмийчүүд ба тэднээс ч зарим аймгууд залгамжлуулан эцэст нь Курайшид

23. Хүмүүс ширкэд автаж маш олон чулуу болон модыг шүтэж ихээр хүндэтгэн Каба, Хажар-и Эсвэл болон Макам-и Ибрахимд ерөөсөө залбираагүй байв. Энэ нь Аллах Таалагийн тусгай нэгэн бэлэг юм.

хүрсэн байв. Дараа нь байгуулсан Макка хотын улсад ч анхааралтай гүйцэтгэсэн эдгээр үүргүүд нь:

1. **Сиданэ эсвэл Хижавэ:** Кабагийн хөшгийг нээх ба түлхүүрийг хадгалах үүрэг.[24]

2. **Сикае:** Хажичуудад амтат ус дайлах ба Зэмзэмийн худагтай хамаатай үүрэг.

3. **Риданэ:** Ядуу хажичуудыг хооллох, тэднийг хонуулах үүрэг.

Эдгээр үүргүүдийг биелүүлэх нь хамгийн том нэр хүндэд тооцдог байв. Эдгээр үйлчилгээнүүд Жаргалын Үед Маккагийн алдартай удмуудын хооронд хуваагдсан байв. Хазрат-и Умар Калиф болсон үедээ дурдсан үйлчилгээний төлөө төсөв зориулж, Хазрат-и Муавиегээс эхлээд ч эдгээр үүргүүд нэгэн эмх цэгцээр тогтсон байдаг. Османы эзэнт гүрний удирдлагад бол Кабагийн үйлчилгээнд жил бүр Харамэйний төсвөөс хувь гаргасан байв.

Кабагийн Тэнгэрлэг Хамгаалалт Доор Байсныг илэрхийлэх Сургамжтай Нэгэн Явдал: Зааны түүх

Аллах Таалагийн тушаалаар барьсан Каба байнга тэнгэрлэг хамгаалалт доор байдаг. Түүхэнд “Зааны түүх” хэмээн

24. Кабад анх удаа дэвсгэр нөмөргөсөн хүн Исмаил -алэйхиссэлам- байсныг мэдээлсэн байдаг (Абдүррэззак, V, 154). Исламын түүхэнд Кабагийн дэвсгэрийг том нэгэн эзэн хаан, калиф эсвэл Маккагийн захирал хийлгэдэг байв. Дотуур ба гадуур гэсэн хоёр хэсгээр хийлгэсэн Кабагийн дэвсгэрүүдийг, 1517 онд Калифын уол Османт гүрэнд орсны дараа хэсэг хугацаагаар Египетэд нэхсэн бөгөөд, Султан Сүлэйманы эринд дотуур дэвсгэрийг нь Истанбулд нэхээд, Султан III Ахмадын эринд гадуур ч дотуур ч дэвсгэрийг нь Истанбулд хийж эхлэжээ. Османы Эзэнт Гүрэн нэхсэн хамгийн сүүлийг дэвсгэрээ 1916 онд илгээсэн, энэ оноос хойш бол Шариф Хүсэйн дооромжилсон тул илгээгүй байв. Дараа нь хэсэг хугацаагаар Египетэд нэхсэн дэвсгэрийг манай одоо Маккад байгуулсан тусгай нэгэн үйлдвэрт үйлдвэрлэдэг.

мэдэгдсэн явдал, үүнийг илрүүлсэн сургамжтай жишээний нэг юм.

Йемений эзэн захирагч Эбрэхэ нь Римийн Эзний ч тусламжтайгаар Сан’ад бариулсан сүм нь хүссэн хэрээр анхаарал татаагүйг мэдээд ихэд хилэгнэв. Дараа нь Арабчуудад ариун гэж хүлээн зөвшөөрөгдсөн Кабаг нураахаар шийдэв. Тэд өнөөгийн танктай зүйрлэмээр олон заантай цэргийн том хүч бэлтгэж Маккагийн тийш илгээв. Түүний бодлоор хүмүүсийг ингэж өөртөө татаж эргүүлж чадах байв.

Эбрэхэгийн нүд нь улайрсан тул, хулгайлсан тэмээгээ буцааж авахаар ирсэн Абдүлмутталибд гайхан:

“–Би Кабаг хураахаар ирсэн. Чи бол тэмээгээ бодоод байна!” гэсэн бөгөөд Абдүлмутталибын Кабагийн цтухай:

“–Тэр өөрийн эзэнтэй! Тэрээр түүнийг хамгаална!” гэхэд хариуд нь ихэмсэг зан гарган:

“–Миний эсрэг түүнийг хэн ч хамгаалж чадахгүй” гэж хашхирсан байв. Маккад дөхсөн цэрэгтээ Каба руу дайрах тушаал өгөв. Гэтэл Мина Мүздэлифэ хоёрын хооронд Мухассир Хөндийд хүрээд л заанууд явахгүй болов. Тэнгэр эбабил гэдэг уул хараацайгаар дүүрэв. Тэд хөлөөрөө зөөсөн чулуугаар Эбрэхэгийн цэргүүд дээр мөндрийн ширхэг шиг асгаруулж эхлэв. Эдгээр чулууд хэнийг оновол түүнийг мөхөөж байв. Маккагийн өмнө ингээд хүн ба зааны оршуулгын газар болов. Ийнхүү өчүүхэн жижиг шувууд,аварга том заануудыг нам дарав. Тэр аймшигтай үйл явдал таарсан оныг “Зааны он” гэж нэрлэв.

Аллах Таала уг явдлыг Кур’ан-и Кэримд ингэж дурджээ:

اَلَمْ تَرَ كَيْفَ فَعَلَ رَبُّكَ بِاَصْحَابِ الْفِيلِ
اَلَمْ يَجْعَلْ كَيْدَهُمْ فِي تَضْلِيلٍ وَاَرْسَلَ عَلَيْهِمْ طَيْرًا اَبَابِيلَ
تَرْمِيهِمْ بِحِجَارَةٍ مِنْ سِجِّيلٍ فَجَعَلَهُمْ كَعَصْفٍ مَاْكُولٍ

“Раббынхаа зааны эздэд юу хийснийг хараагүй юү? Тэдний муухай төлөвлөгөөг дэмий гаргаагүй юү? Тэдэн дээр сүрэг сүргээр шувуу илгээв. Эдгээр шувууд тэдэнд халаасан шавраар чулуу хаяж байв. Эцэст нь тэднийг хожиж тарианы гишгэсэн навчаар эргүүлэв.” (эл-Фил, 1-5)

Учир нь Каба Аугаа Эрхийн тэнгэрлэг тушаалаар барьсан тул “Ханэ-и Бирр” нь байв. Тэнд нь Аллахад боолчлох газар болж ариун болгосон байв. Ийм учраас тэнгэрлэг хамгаалалт доор авсан байв.

Эбрэхэгийн хийсэн буруу үйл нүглийн хариуд өгсөн уг ял бол киямат өдөр болж мэдэх ижил үйлсийн талаар ч нэгэн сануулга шинж агуулж байдаг.

Өөр нэгэн ает-и кэримэ ингэж айлдана:

وَمَنْ اَظْلَمُ مِمَّنْ مَنَعَ مَسَاجِدَ اللّٰهِ اَنْ يُذْكَرَ فِيهَا اسْمُهُ وَسَعٰى
فِي خَرَابِهَا اُولٰئِكَ مَا كَانَ لَهُمْ اَنْ يَدْخُلُوهَٓا اِلَّا خَٓائِفِينَ لَهُمْ فِي
الدُّنْيَا خِزْيٌ وَلَهُمْ فِي الْاٰخِرَةِ عَذَابٌ عَظِيمٌ

“Аллахын мэсжидүүдэд Түүний нэрийг дурдахад саад хийж тийм газрыг эвдэхээр хичээгчээс харгис нь хэн байж мэдэх вэ? Тэдэнд өөр гарах газаргүй тул айсаар орох хэрэгтэй юм. Тэдний төлөө дэлхийд

нэгэн гамшиг, дахиад тэдний төлөө ахиратад ч хойд насанд ч маш том зовлон байдаг.” (эл-Бакара, 114)

Зовлонгоо улам нэмж буруу замаар орсон Эбрэхэ нь эцэст нь өөртөө дуусашгүй содон хүч байсныг буруу зүйлд зориулжээ. Үүний хариугаар Аллах Таала түүнийг цөл дэх арслан, бар эсвэл хорт могой мэтийн аймшигт хүчтэй амьтдаар биш маш хүчгүй ба жижиг оршигчид буй хараацай шувуудын хаясан вандуйгаас жижиг чулуугаар мөхөөв. Жишээлбэл Аллах Таала нь Фарон, Нэмрүт, Жалут мэтийн ихэмсэг зантуудыг байнга тэднээс жижиг ба хүчгүй харагдах оршигчдоор мөхөөж, тэдний үнэндээ хэдий чинээ чадалгүй оршигчид буйг ба ихэмсэг зангийнх нь утгагүй буйг илрүүлсэн байдаг.

Эбрэхэ агуу ихэмсэг зангаараа гарсан Йеменд тархай бутархай болсон биеэрээ, маш их тааруу байдалтай, мөлхөж арай л хүрч чадав. Түүний үг байдал нь ихэмсэг зантуудын дэлхийд байхдаа ч гутамшигт унасны ил далангүй сургамжийн зураг мөн.

“Зааны он” нь Курайшчуудын хооронд нэг төрлийн он цагийн эхлэл болов. Уг яриа нь үүний сайхан нэгэн шижээ юм:

Кубаш бин Үшэйм:

“–Би ба Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм- Зааны онд төрөв,” гэв.

Усман бин Аффан -радъяллаху анх- түүнд:

“–Чи чинь том уу, эсвэл Пайшамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм- нь том уу?” гэж асуув.

Ариун сахабий хүмүүжлээр дүүрэн уг хариуг өгөв:

“–Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм- нь надаас маш их том байдаг. Төрөхдөө бол би Түүнээс хуучин юм![25] Би заантай ялагдагсдыг харав.” (Тирмизий, Мэнакиб, 2)

Ибрахим -алэйхиссэлам- ба Ханиф шүтлэг

Маккад ерөнхийдөө баримал шүтээн түгээмэл байсан ч тэвхидийн мөр нь бүрэн арилаагүй байв. Хазрат-и Ибрахимын сургасан тэвхидийн шашныг бага ч гэсэн зарим хүмүүс үргэлжлүүлж байв.

“Аллахыг анд” гэсэн утгаар “Халилуллах” хэмээн нэр авсан Ибрахим -алэйхиссэлам- нь “үлү’л-азм” пайгамбарчуудын нэг мөн. Маш олон пайгамбарын, ялангуяа Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- Эзний маань омог мөн. Аллах Таала нь Ибрахим -алэйхиссэлам-д арван хуудаст нэгэн вахий хайрлав.

Хазрат-и Ибрахимын нэр Кур’ан-и Кэримд хорин таван сурад жаран есөн удаа явж, **Эввэх** (ихээр ёологч), **Халим** (уяхан сэтгэлт) **Мүниб** (Аллахад хоргодогч), **Канит** (Аллахад боолчлогч), **Шакир** (Аллахад ихээр шүкүр буюу талархлаа илэрхийлэгч) ба **Ханиф** мэтийн нэр ба бэлгээр нь ярьж, магтаалаар дурдсан байдаг.

Ибрахим -алэйхиссэлам-ын шашныг “**Ханиф шүтлэг**” хэмээн нэрлэдэг. Ханиф нь толь бичигт тахирыг орхиж шулуун явагч, чигээрээ явагч, бусад шашин ба мухар сүсгээс зугтаж ганц буй Аллахад итгэж үнэмшсэн “муваххид” гэсэн утгатай байдаг.

25. Асхаб-и кирам нь уг үгэнд байсан шигээ байнга Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн хамгийн давуу ба хамгийн агуу оронд буйг ухаарсан байцгаав. Тийм учраас энэ тухай мэдрэмж үзүүлдэг байцгаав. Түүний арьсанд хүрч чадагсад, ихээр бахархаж:
“Энэ хоёр гараараа Расулаллахад бий’ат хийлээ,” гээд гараа үзүүлдэг байцгаав. (Ибн-и Са’д, IV, 306; Хэйсэмий, VIII, 42)

Аугаа Эрх нь Кур’ан-и Кэримд ингэж айлдана:

وَقَالُوا كُونُوا هُودًا اَوْ نَصَارٰى تَهْتَدُوا
قُلْ بَلْ مِلَّةَ اِبْرٰهِيمَ حَنِيفًا وَمَا كَانَ مِنَ الْمُشْرِكِينَ

Еврей ба Христчүүд мусульманчуудад **«Еврей эсвэл христ болоод зөв замыг олцгоо,» гэцгээв.** Аяа Хабиб минь! **«Эсрэгээр нь бид зөв замд чиглэсэн бөгөөд Аллахыг танихгүй нь Ибрахимын шашныг дага» гэв!”** (эл-Бакара, 135)

مَا كَانَ اِبْرٰهِيمُ يَهُودِيًّا وَلَا نَصْرَانِيًّا
وَلٰكِنْ كَانَ حَنِيفًا مُسْلِمًا وَمَا كَانَ مِنَ الْمُشْرِكِينَ

“Ибрахим еврей ч христ ч байгаагүй. Гэтэл Тэр нь Аллахыг мэдсэн шулуун шударга ханиф **нэгэн мусульман байж, мүшрик байгаагүй.”** (Ал-и Имран, 67)

Мунхаглалын үед бүх төрлийн төөрөг зан ба баримал шүтээнээс эргэж Эрхэд чиглэсэн, Хазрат-и Ибрахимын шашныг дагаж зөвхөн ганц буй Аллахад итгэж үнэмшсэн хүмүүсийн ч ханиф гэдэг байв. **Варака биэ Нэвфэл, Абдуллах бин Жахш, Усман бин Хүвэйрис, Зэйд бин Амр, Кусс бин Саидэ** мэтийн хүмүүс ханифчуудаас зарим нь мөн. Ханифчууд нь амьгүй, хэлгүй, юу ч мэдрэхгүй баримлын өмнө бөхийж тэдэнд залбирахыг муухай үздэг байв.

Ибн-и Умар -радъяллаху анхүма-[26] ингэж ярина:

---

26. **Абдуллах бин Умар** -радъяллаху анхүма- би’сэтийн гурав дахь онд төрөв. Аав нь Хазрат-и Умарын хамт хижрэт хийв. Эбү Эйюб эл-Энсарийг ч агуулсан цэргийн хамт **Истанбулын** дайнд оролцов. Эгч нь Хазрат-и Хафса нь Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн эхнэр байсан тул,

“Пайгамбар Эзэн маань -саллаллаху алэйхи вэ сэллэм- номлогч болохоос өмнө, Бэлдахын[27] доод хэсэгт байхад нь тэндэх хүмүүс түүнийг хоолонд урив. Хоолонд Зэйд бин Амр бин Нүфэйл ч байв. Тэд Орчлонгуудын Эзнийг махаар дайлав. Орчлонгийн Магтаал Эзэн маань уг хоолноос идээгүй шиг, Зэйд ч идэхээс татгалзав. Зэйд махыг идээгүйгийнхээ учрыг ингэж тайлбарлав:

Орчлонгийн Хүндэт Эзний маань ойрхон орчинд байх завшаантай байв. Дахисны хамт 2630 хадис-и шариф дамжуулан Эбү Хүрэйрэ -радъяллаху анх-ын дараа хамгийн олон хадис дамжуулсан долоон сахабийгаас (Мүксирүн) хоёр дахь нь болов. Ибн-и Умар -радъяллаху анх- нь бас хамгийн олон фатва өгсөн долоон сахабийн нэгэн байв.

Аллахын Элчийн аж ахуйг нарийн дагах ба Түүний тушаалыг хэрэгжүүлэх талаар ижилгүй нэгэн байв. Хүндэт Элчийг өөд болсны дараа Түүнд байсан хайрынхаа хөөрөөс болж Расулаллах -алэйхиссалатү вэссэлам-ын мөргөл үйлдсэн газруудын мэдэж тэнд мөргөл үйлдэж, сүүдэрлэсэн модон доор сууж, хатаахгүйн төлөө түүнийг усалдаг байв. (Бухарий, Салат, 89; Ибн-и Хажар, *эл-Исабэ,* II, 349)

Нэгэн өдөр хөлийн шөрмөс нь татсан байв. Хажууд нь байсан Абдурарахман бин Са’д:

“–Хамгаас их хайртай хүний нэрийг дурд,” гэв.

Тэр ч:

“–Аяа Мухаммед!” гээд, тэгэнгүүт хөл нь сайжрав. (Ибн-и Са’д, IV, 154)

Ибн-и Умар -радъяллаху анх- Асхаб-и кирамын хамгийн баядын нэг байв. Хөрөнгөө их цуглахад огт зөвшөөрөхгүй, олсон юмаа ядуучуудад тараадаг байв. Эзэлсэн юмсын дундаас хамгийн дуртайгаа Аллахын замд тахил болгох эсвэл хандив болгохоор тусгай тавьдаг байв. Сайхан байдлыг нь харсан ба ялангуяа мөргөл үйлдсэнийг нь мэдсэн хамаг боолчуудаа чөлөөлж эхэлсэн байв. Андуудаас нэг нь түүнд зарим боол гагцхүү чөлөөлөгдөхийн тулд мэсжид явсныг хэлэв. Хазрат-и Абдуллах зүрхэн дэх Аллахын хайрыг заасан энэ сайхан хариуг өгөв:

“–Бидний Аллахтай хамт хуурч болохгүй болохоор санаа зовохгүй байна.”

Янз бүрийн учиртай мянга гаруй боолыг чөлөөлөв. Хижрэтийн тооллын 73 / билгийн тооллын 692 онд наян таван настай байхдаа Маккад өнгөрөв.

27. Бэддах нь Маккад ойрхон нэгэн хөндий юм.

«–Би таны баримлын нэрээр төхөөрсөн махаас идэхгүй. Би зөвхөн Аллахын нэрийг дурдаж төхөөрснөөс л иднэ.»

Зэйд нь Курайш аймгийн малаа баримлын нэрээр төхөөрснийг буруушааж ингэж хэлдэг байв:

«–Хонийг Аллах туурвив. Түүний төлөө тэнгэрээс бороо буулгаж газраас өвс ургуулав. Гэтэл та тэрийг Аллахын нэрийг дурдалгүй төхөөрнө!»” (Бухарий, Мжнакибү’л-Энсар, 24; Зэбаих, 16)

Өөр нэгэн яриа ч ийм байдаг:

“Зэйд бин Амр нь Варака бин Нэвфэлийг дагуулан жинхэнэ шашныг сураглаж дагахаар Дамаскад очив. Тэнд еврей нэгэн эрдэмтэнтэй тааралдав. Түүнээс шашны талаар юм асууж:

«–Таны шашинд орж магадгүй, надад түүний тухай мэдээлэл өг,» гэв.

Еврей нв:

«–Чи, Аллахын хилэнгээс хувиа авалгүй манай шашинд орж чадахгүй!» гэж хариулав.

Зэйд:

«–Би Аллахын хилэнгээс зугтаад энд хүрээд ирэв, (хилэн биш тааламж ба энэрэл хайж байна). Аллахын хилэнгээс ямар ч хувь авах зорилго огт үгүй! Чи надад өөр нэгэн шашин заагаач би түүнд оръё!» гэв.

Еврей эрдэмтэн:

«–Би Ханифаас өөр шашин мэддэггүй!» гэж хариулав.

Зэйд:

«–Ханифын шашин гэж юу вэ?» гэж асуув.

Еврей эрдэмтэн:

«–Хазрат-и Ибрахимын шашин юм. Тэр нь еврей ч биш, христ ч биш байв, Аллахаас өөр юуг ч шүтдэггүй байв,» гэж хариулав.

Зэйд түүнээс салсны дараа христийн эрдэмтдээс нэгтэй нь тааралдав. Түүнээс ч ижил юмыг асуув.

Тэр ч:

«–Чи Аллахын хараалаас хувиа аваагүй байхдаа манай шашинд орж чадахгүй!» гэв.

Зэйд түүнд ч:

«–Би угаасаа Аллахын хараалаас зугтаж энэ хавьд хүрээд ирлээ. Чадах чинээгээрээ хэзээ ч Аллахын хараалаас юу ч авахгүй. Чи надад өөр нэгэн шашин зааж чадна уу?» гэв.

Тэр эрдэмтэн ч еврей эрдэмтэн шиг ханифын шүтлэгийн тухай хэлэв. Зэйд тэдний Хазрат-и Ибрахим тухай үгсийг сон-сохлоороо тэндээс салав. Гадагш гарахлаараа:

«Аллах минь, Чамайг гэрчээ болгоё, би Ибрахим -алэйхиссэлам-ын шашин дээр байна!» гэв.” (Бухарий, Мэнакибү’л-Энсар, 24)

Эсма бинт-и Эби Бэкир -радъяллаху анхүма- ингэж хэлнэ:

“Зэйд бин Амрын нуруугаараа Кабад налуулж босоод ингэж хэлснийг сонслоо:

«–Аяа Курайш нийгэм! Валлахий надаас гадна танаас хэн ч Ибрахим -алэйхиссэлам-ын шашин дээр биш юм!»

Зэйд нь амьд буйд булах охидын амийг авардаг байв. Охиноо алах болсон хүнд:

«–Түүнийг битгий ал, хариуцлагыг нь би хүлээнэ» гээд охиныг авдаг байв. Охин нь торниж өсөхлөөр нь аавд нь:

«–Хүсвэл түүнийг чамд буцааж өгье, хүсвэл хэрэгцээг нь би өгч байя,» гэдэг байв.” (Бухарий, Мэнакибү’л-Энсар, 24)

Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- нь Ханифчуудаас Варакагийн тухай:

“Түүнийг диваажины дунд, тайж торгон хувцас өмссөн буйгаар харлаа,”

Зэйдийн тухай ч:

“Тэр нь киямат өдөр Есүс -алэйхиссэлам- бид хоёрын хооронд тустай үммэт болоод амьжина,” хэмээв. (Хэйсэмий, IX, 416)

Дурдсан энэ Ханифчууд нь түрүүны ариун судруудыг бага ч гэсэн таньсан тул “Сүүлчийн Пайгамбар”ын цаг дөхсөнийг мэдэж, тэсэн ядан Түүнийг хүлээж байв.

Исламын эрдэмтдийн ихэнхийн үзлээр Пайгамбар -алэйхиссалатү вэссэлам-ын эцэг эх нь ч Макка дахь Ханифчууд мөн.

Ханиф шүтлэг нь Исламын тэвхид шүтлэгээс өөр зүйл биш юм. Ийм учраас Аугаа Эрх нь Пайгамбар Эзэнд маань ханиф асан Ибрахим -алэйхиссэлам-ын шашинд орохыг Кур’ан-и Кэримд ингэж тушаав:

ثُمَّ اَوْحَيْنَآ اِلَيْكَ اَنِ اتَّبِعْ مِلَّةَ اِبْرٰهِيمَ حَنِيفًا

وَمَا كَانَ مِنَ الْمُشْرِكِينَ

“Дараа нь (аяа Хабиб минь) **Чамд: «Зөв замд чиглэж Ибрахимын шашинд ор! Тэр мүшрикчүүдээс биш байв,» гэж вахий илгээв.”** (эн-Нахл, 123)

Ийм л учраас Ханиф гэсэн хэр нь Исламын тухай ч хэрэглэсэн, чин сэтгэлийн үнэнч мусульман бүрт “ханиф” гэсэн бэлгийг өгсөн байдаг. Жишээлбэл Пайгамбар Эзэн маань:

“Би өршөөлөөр ханиф шашин дээр илгээгдэв,” хэмээсэн байдаг. (Ахмад, V, 266)[28]

28. Мөн хар. Бухарий, Иман, 29.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Номлохоос Өмнөх Хазрат-и Мухаммед

-саллаллаху алэйхи вэ сэллэм-

Хазрат-и Пайгамбарын Мэндэлсэн ба Бага Нас

Нүр-и Мухаммедий

Аллах Таалагийн орон цагийн хэмжүүр төсөөлшгүй. Тэрээр бидний цаг ба орны хэмжүүрээс дээш юм.[29] Мөнхийн урьд цагт өөрөө бий болсон бөгөөд бий болохоор өөр нэгэн бий болгогчид хэрэгцээгүй байсан Аугаа Эрх нь мэдэгдээд мэдэгдэхийн ёсоор залбирч үйчлэгдэхийг хүссэн тул, **"алэм-и кэсрэт"** (олны хорвоо буюу орчлон) гэдэг масиваллахын[30] туурвив. Уг туурвилд анх бие болсон нь нэгэн **"туяа"** мөн. Тэр туяа ч **"Мухаммедын Үнэн"**ий цөм, гол ба хөрөнгө мөн.

Жинхэнэ үнэт эрдэнийг дангаар тавьдаггүй, эргэн тойронд нь чимэглэн гоё ганган баглаа боодолтой байдаг шиг хамаг оршигчид ч **"Мухаммедын Туяа"**ны тийм л зүйл юм. Түүний нэр хүндээр л туурвисан байдаг. Үүнээс үзвэл оршигчийн анхны учир нь Аугаа Эрхийн өөрийнх хэмээн Аугаа Бие нь, хоёрт

29. Хүний тархи бол туурвигдахдаа цаг ба орны нөхцөлөөр өөр өөр шинжтэй байдаг. Танил хорвоогоос авсан үзэгдлийг хэрэглэж -тодорхой хэмжээнд байсан ч- үнэнд хүрнэ. Гэрчлэх талбайны гаднах хорвоотой хамаатай үнэний төлөө бол гэрчилж чадсан хорвоогоос авсан сэтгэлгээг хэрэглэх ёстой буй хүн төрөлхтөн, физикийн цаана хамаг үнэний тухай, агуулга эсвэл нэр олгохдоо төсөөт үгсийг хэрэглэх ёстой байдаг.
30. Масиваллах: Аллахаас холдуулах бүхний тухай хэрэглэдэг нэгэн үг юм.

дахь учир бол “Мухаммедын Туяа”г нэр хүнд ба үнэ цэнээс нь улмаас бусад оршигчдоор бүсэлж чимэглэх хэрэгцээ мөн.

Өөрөөр хэлбэл Исламийн шашны судлалаар оршигчдын дараалалд анхны шат нь (эхлэл), Фаил-и Мухтар (хүссэнээ хийхдээ чөлөөт) буйгаараа Аугаа Эрх; учир болсон нь ч “Мухаммедын Туяа” мөн. Өөрөөр хэлбэл туурвил, үүслийн анхдагч мөн.

Исламын үзлээр орчлон нь олон гүн ухаантны хэлсэн шиг “эхлэлгүй” биш. Өөрөөр хэлбэл дараа нь бий болсон юм. Эхлэлгүй нь зөвхөн Аугаа Эрх мөн. Дараа нь туурвигсдын анхных нь бол “Мухаммедын Туяа” мөн. Ийм л учраас Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-:

“Адамыг нь сүнс шарил хоёрын хооронд байхад би номлогч байв,” хэмээн айлдав. (Тирмизий, Мэнакиб, 1)

Өөрөөр хэлбэл Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм- нь Аллахын элчит туяа ба номлогч үүрэг даалгавартай Хазрат-и Адам -алэйхиссэлам-аас өмнөх мөн. Махбодид шилжиж бидний хорвоод илэрснээрээ бол сүүлийн хуудас юм. Учир нь номлогчийн цаг хугацаа нь оршигчийн анхдагч буй “Мухаммедын Туяагаар” эхэлсэн; сүүлийн хуудас ч “Мухаммедын Бие”эр төгссөн юм.

“Оршигчийн Туяа” бол анх туурвигдсан оршигч буй **“Мухаммедын Туяа”**ны нэр хүндээр туурвигдсан хамаг оршигчдын түүнтэй харьцааг нь илэрхийлнэ. Тус оршигчдод өөрийнхөө нэр хүнд бий болохгүй, тэд нэр хүндээ **“Мухаммедын Туяа”**тай харьцуулан олдог.

Эдгээр хадис-и шарифууд ч уг үнэнийг илэрхийлнэ:

“Адам -алэйхиссэлам- нь дибаажинаас гаргах учир болсон зэЭллэг хийсэндээ алдаагаа ухаарч:

«–Аяа Раббий! Мухаммедын эрхээр Чамаас өршөөл гуйя,» гэв.

Аллах Таала:

«–Аяа Адам! Намайг арай туурвиагүй байхад Мухаммедын чи хаанаас мэдээ вэ?» хэмээв.

Адам -алэйхиссэлам- нь:

«–Аяа Раббий! Чи намайг туурвиж надад сүнснээсээ үлээхэд толгойгоо өндийлгөвөл, Огторгуйн багана дээр "Ла илахэ иллаллах, Мухаммедүн Расулаллах" өгүүлбэр бичсэнийг харлаа. Чамайг өөрийнхөө нэрт зөвхөн туурвигдсаны хамгийн хайртын л зэрэглэхийг мэдлээ!» гэв.

Тэгэхлээр нь Аллах Таала:

«–Чиний зөв Адам! Үнэхээр Тэр нь, миний хувьд оршигчдын хамгийн энхрий нь мөн. Түүний нэр хүндээр надад залбир. Одоо чи залбирсан, Би ч чамайг өршөөв. Хэрэв Мухаммед байгаагүй бол чамайг туурвихгүй байв!» хэмээн айлдав." (Хаким, II, 672)

Ибн-и Аббас -радъяллаху анхүма-гаас ингэж дамжуулна:

"Аллах Таала нь Есүс -алэйхиссэлам-д вахий өгч ингэж айлдав:

«Аяа Есүс! Мухаммедад итгэн үнэмшиж үммэтээсээ Түүнд хүрэгчдэд Түүнд итгэн үнэмшихийг тушаа! Хэрэв Мухаммед байгаагүйсэн бол Би Адамын туурвихгүйсэн! Мухаммед байгаагүйсэн бол диваажинийг ч тамыг ч туурвихгүйсэн. Огторгуйг усан дээр туурвихлаар минь найгаж эхэлсэн, дээр нь "Ла илахэ иллаллах Мухаммедын Расулаллах" бичихлээр тайвшрав.»" (Хаким, II, 672)

Нэгэн өдөр Жабир -радъяллаху анх- нь Пайгамбар Ээзнд маань -саллаллаху алэйхи вэ сэллэм- хүрч ирээд:

"–Эцэг эх минь чамд золиос болог аяа Расулаллах! Надад анх туурвигдсан юм юу байсныг мэдүүлнэ үү?" гэж асуув.

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-:

"–Жабир аа! Аллах Таала нь бүгдээс өмнө, өөрийнхөө туяанаас чиний пайгамбарын туяаг туурвив…" хариултыг өгөв.[31]

Ибн-и Арабий Хазрат нь энэ тухай ийм санаа илэрхийлнэ:

"Аллах Таала нь Мухаммед -алэйхиссэлам-д номлогч болсныг мэдэгдэхэд Адам -алэйхиссэлам- арай байгаагүй, ус шавар хоёрын хооронд байв… Ингэхдээ нэбий ба расулчуудын аргаар илэрсэн шэриат буюу хуулийн эхлэл болох нь Аллахын Элчний хувьд хэрэгжсэн болов. Пайгамбар маань бүр тэр үед шэриал эзэмшиж байсан, учир нь хадис-и шарифдаа: *«Адамыг сүнс ба шарилын хооронд байхад би номлогч байв,»* хэмээсэн байдаг. «Би хүн байв» эсвэл «Би бий байв» хэмээгээгүй. Номлогч нэр нь зөвхөн Аллах түүнд шэриат өгсөн тохиолдолд хэрэгжинэ." (Ибн-и Арабий, *эл-Футухат,* II, 171; IV, 66-67)

Ибн-и Арабий Хазрат өөр нэгэн номдоо ингэж хэлнэ:

"Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- нь хүний төрлийн дотор оршигчдын хамгийн төгс төгөлдөр нь мөн. Ийм л учраас номлох Түүнээр эхэлсэн, Түүгээр төгсөв." (Ибн-и Арабий, *Фүсүсү'л-Хикэм,* IV, 319)

Хазрат-и Мевлана нь *Мэснэвий*дээ ингэж хэлнэ:

31. Хар. Ажлуний, I, 265.

“Аяа сэтгэл, ир! Жинхэнэ баяр Аугаа Мухаммедад хүрэх мөн. Учир нь дэлхийн гэрэл нь Тэр ариун оршигчийн гоо сайхны туяанаас мөн.”

Сүлэйман Чэлэби Хазрат ч *Мэвлид-и Шарифдаа* Мухаммедын Туяаг ингэж дурдана:

“Тэр Туурвигч Аллах эхлээд Мухаммед Мустафа -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн туяаг туурвиж Түүнийг хайрлав.”[32]

Товчоор нь **Мухаммедын Үнэн** хэмээн нэрлэдэг Мухаммедын Туяа нь Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн сүнсний биеийг төлөөлөх нэгэн туяа, үнэн эсвэл эрдэнэ мөн. Аллахын онгонд хамгийн энхрий ба үнэт нь Тэр мөн. Оршигчдын бий болох учир нь, Аугаа Эрхийн туурвилын анхдагч буй Мухаммедын Туяаг хайрласан нь юм. Ийм учраас хамаг орчлон нь Мухаммедын Туяаны нэр хүндээр ба Түүнийг хүрээлэхээр туурвигдсан байдаг. Хамаг оршигчид нь Түүний үнэнийг дэлгэрэнгүй илэрхийлэхээр л туурвигдсан. Ийм л учраас, нэгэн аяганд далайг багтаах нь аргагүй шиг, Мухаммедын Туяаг ёсоор нь ухаарах нь ч боломж үгүй юм.

Пайгамбар Эзний маань Ариун Удам Угсаа

Пайгамбарын маань эцэг Хазрат-и Абдуллах, эх нь Хазрат-и Амина юм. Түүний ариун угсаа нь Хазрат-и Исмаилын хөвүүн Кайзарын удмын хамгийн нэр алдартай нь Аднан хүртэл явна.[33]

---

32. ?????
?????
?????
33. Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн хүндэт удам нь ийм байдаг: Мухаммед бин Абдуллах бин Абдулмутталиб бин Хашим бин Абди Мэнаф бин Кусай бин Килаб бин Мүррэ бин Ка’б бин Луэй бин Галиб

Пайгамбарын маань их омог асан Аднан нь Исмаил -алэйхиссэлам-ын удмаас мөн.[34] Аднаны хөвүүн Мэаддын Есүс -алэйхиссэлам-ын эринийх асан нь мэдүүлдэг.

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- нь Курайш аймгийн дотор эцгийнх ч эхийнх ч талаараа хамгийн цэвэр ба хамгийн нэр хүндтэй айлд харъяалагдав. Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- нь угсааныхаа цэвэр ба шилмэл буйгийн тухай ингэж айлдав:

“Би мунхаг харанхуй үеийн муу муухайнаас юу ч түрхэлгүй, ээжааваасаа бий болов. Би бүр Адамаас ээжид ба аавд минь хүртэл байнга гэрлэлтээр төрөв, ерөөсөө ёсгүйгээр бий болоогүй!” (Ибн-и Кэсир, *эл-Бидае,* II, 260)

Түүний нэгэн нэр ч **Мустафа** юм. Тус нэр нь түүхийн уг шилмэл байдлыг илэрхийлнэ:

Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн харъяалагдсан нийгэм хэзээ ч хоёрт хуваагдвал, Аллах Таала нь Элчээ хамгийн буянт нийгэмд байлгав. Түүний оршигчийг гийгүүлэх туяа нь Хазрат-и Адам -алэйхиссэлам-аас хойш хамгийн цэвэр эх эцгээс дамжиж өөрт нь хүрсэн байдаг.[35]

Ибн-и Аббас Хазрат нь Шуара Сурагийн 219-р аетыг, уг утгыг илэрхийлэн ингэж тайлбарлав:

“Чи буюу чиний туяа, байнга мөргөгчдөөр дамжуулан Чамд хүрэв.” (Куртубий, XIII, 144, Хэйсэмий, VIII, 214)

бин Фихр бин Малик бин Надр бин Кинанэ бин Хүзэймэ бин Мүдрикэ бин Иляс бин Мудар бин Низар бин Мэадд бин Аднан. (Бухарий, Мэнакибу’л-Энсар, 28; Ибн-и Хишам, I, 1-3; Ибн-и Са’д, I, 55-56)

34. Хар. Ибн-и Хишам, I, 1, 5.
35. Хар. Ахмад, I, 210.

Орчлонгийн Хүндэт -саллаллаху алэйхи вэ сэллэм- нь уг шинжээ хадис-и шарифдаа ингэж илэрхийлэв:

"Би Адамынхны хамгийн буянт бөгөөд хамгийн цэвэр байгсдаас, үеэс үеэд, айлаас айлд гаталж эцэст нь тус дотуур буй айлаас бий болов!" (Бухарий, Мэнакиб, 23)

"Аллах Таала нь Ибрахимынхнаас Исмаилыг сонгов. Исмаилынхнаас Кинанэгийнхныг сонгов. Кинанэгийнхнаас Курайшийг сонгов. Курайшаас Хашимынхныг сонгов. Хашимынхнаас Абдүлмутталибынхныг сонгов. Абдүлмутталибынхнаас ч намайг сонгов." (Мүслим, Фэдаил, 1; Тирмизий, Мэнакиб, 1)

Исламын суут эрдэмтэн Ибн-и Халдун нь Пайгамбар Эзний маань угсааны ийм бат ба цэвэр мэдэх ба нэр хүндээрээ үргэлжлэх тухай ингэж хэлдэг:

"Хазрат-и Мухаммед -саллаллаху алэйхи вэ сэллэм-ээс гадна хэн нэгэн боолын угсаа ч ийм тодорхой биш, Адам -алэйхиссэлам-аас өөрт нь хүртэлх угсааны ариун язгуур ч таслалтгүй үргэлжлээгүй юм. Энэ нь Аллах Таалагийн Мөнхийн Хайртдаа тусгай нэгэн бэлэг юм." (Ибн-и Халдун, I, 115)

Хазрат-и Пайгамбарын Эцэг Абдуллах Эх Аминатай гэрлэсэн нь

Хазрат-и Пайгамбарын хорвоод мэндлэхэд ойр үед тэвхидийн шүтлэг алга болж, Каба нь ястан ба аймгуудын баримлаар дүүрсэн, Зэмзэмийн худаг ч гараагүй байв.

Пайгамбар Эзний маань өвөө Абдүлмутталиб нэгэн шөнө Хижрэд унтаж байхдаа, зүүдэндээ түүнд Зэмзэмийн худгийг малтаж илрүүлэхийг сонсгов. Дараа нь авсан тэмдгээр малтах хэрэгтэй газрыг түүнд заав.

Абдүлмутталибыг малтах ажилд эхлэхлээр Курайшчууд:

"–Сүмийнхээ дэргэдийг малтуулахгүй," гээд түүнийг саатуулав. Абдүлмутталиб арай тэдэнд хариу өгөх хүчтэй байгаагүй. Ингэхлээр нь Абдүлмутталиб нь Аллах өөрт нь арван хүүхэд өгөөд, тэд ч түүнийг хамгаалах үед хүрвэл, тэднээс нэгийн Кабагийн дэргэд тахил барихаар зориулав.

Хэсэг хугацааны дараа Курайшчууд Абдүлмутталибд харсан зарим ер бусын байдал ба үйлсээс болж зөөлөрч түүнд зөвшөөрөл олгов. Абдүлмутталиб худгийг малтаж Зэмзэмийг илрүүлэв. Цаг хугацааны өнгөрөх тусам арван хүүхэдтэй болж, тэд түүнийг хамгаалах цагт хүрэв. Тэгэхлээр зүүдэндээ:

"–Зорьсноо хэрэгжүүл!" гээд олон жилийн өмнө Аллахад өгсөн амыг сануулав. Зориулснаа хэрэгжүүлэхээр хуц ба үхэр тавьсан Абдүлмутталибаас, удаа бүрт томыг нь нэхэв. Тэр нь:

"–Том нь юу вэ?" хэмээн асуухлаар:

"–Хөвүүдээс нэгийг тахил болгохыг зориулсан байв!" хэмээв. Тэгэхлээр нь хөвүүдээ цугласан Абдүлмутталиб нь Аллах амласнаа хэрэгжүүлэхээр тэднийг бууж өгөхөд урив. Тэд ч эсэргүүцэлгүй:

"–Чи амласнаа хэрэгжүүл, хүссэнээ хий!" гэцгээв.

Абдүтмутталиб тэдний хооронд сугалаа татаж байхдаа:

"Аллах минь! Би хүүхдүүдээс нэгийг Чамд тахил болгохыг зориулж байна. Тэднээс сугалаа татна, тэднээс хүссэндээ оноогоорой!" гэж залбирав.

Сугалаа нь Пайгамбар Эзний маань эцэг болох Абдуллахад таарав. Абдүлмутталиб тахил барихаар хүүгээ Каба дээр аваачихад, Маккагийнхан хүү тахил болгохыг заншил болохоос

айж түүнд саад хийв. Абдүлмууталибыг ятгаж нэгэн эрдэмтэн дээр аваачив. Эрдэмтэн нь:

“–Танайд нэгэн хүний **үнэ** хэд байдаг вэ?” гэж асуув.

“–Арван тэмээ юм” гэж хариулцгаав. Тэгэхлээр нь эрдэмтэн нь:

“–Тэгвэл Абдуллах ба арван тэмээний хооронд сугалаа татацгааж, сугалаа нь Абдуллахад таарвал арван тэмээ нэмж Абдуллах ба хорин тэмээний хооронд дахиад сугалаа татацгаа. Уг сугалааг тэмээнд таартал арав арваар нэмцгээ!” гэж санал болгов.

Арван тэмээ ба Абдуллахын хооронд сугалаа татахад, сугалаа нь Абдуллахад таарав. Арван тэмээ нэмж,дахин сугалахад дахиад Абдуллахад таарав. Тэмээний тоог зууд хүртэл сугалаагаа ихэсгэсээр байв.Тэмээний тоо зуу хүрэхэд сугалаа тэмээнд таарчээ. Абдүлмутталиб бат итгэлтэй болох тулд сугалааг гурван удаа дахив. Энэ хооронд босч хүүг аврахын төлөө Аллахад залбирав. Дахих бүрт сугалааг тэмээнд таарсныг хараад, тэндэх хүмүүс баяр хөөрөөс тэкбир авав (Аллаху экбэр гэцгээв). Дараа нь Абдүлмутталиб тэмээг тахил болгож махыг нь хандив өргөж тараав.[36]

Өнөөдөр Исламын хуулиар нэг хүний **төлбөрт** зуун тэмээ эсвэл түүний үнэтэй тэнцэх мөнгө хэмээн тогтсон нь үүнээс үүдэлтэй юм.

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- Эзэн маань омог Исмаил -алэйхиссэлам- болон эцэг Абдуллахынхаа тахил барихаар сонгогдсоныг зааж:

36. Хар. Ибн-и Хишам, I, 163-168; Ибн-и Са’д, I, 83-85; Хаким, II, 604/4036.

"Би хоёр тахилын хөвүүн мөн," хэмээн айлдав. (Хаким, II, 609/4048)

Дахиад ийм л учраас Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- нь "Ибн-и Зэбихайн: Хоёр тахилын хүү" гэж ч дурддаг байв.[37]

Хазрат-и Абдуллах нь гадны төрх ба ёс суртахуунаар өөрийнхөө дүү нарын ч Курайшийн бусад залуусаас ч хамгийн царайлаг нь байв. Оюун ухаан ба хүч чадлаараа ч тэднээс давуу байв.[38] Ийм учраас Курайшийн хамаг залуу бүсгүйчүүд түүнтэй гэрлэх хүсэлтэй байв. Варака бин Нэвфэлийн охин дүү Рукайе нь Абдуллахын магнай дахь пайгамбарын туяа байсныг ойлгож, хүлээж буй сүүлийн пайгамбарын эх болох нэр алдарт хүрэхээр хичээж Хазрат-и Абдуллахад гэрлэх санал хэлж зуун тэмээ инжинд өгөх санал болгосон байв.[39]

Абдүлмутталиб хүү Абдуллахдаа Бэний Зүхрэ аймгийн тэргүүн Вэхб бин Абди Мэнафын охин Аминаг гуйв. Курайшийг угсаа ба нэр хүндээр хамгийн давуу охин байсан Амина ч зөвшөөрч гэрлэжээ.

Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн эх Хазрат-и Аминагийн угсаа нь Вэхб бин Абди Мэнаф бин Зүхрэ бин Килаб бин Мүррэ гэснээр явна. Зүхрэ нь Хашимынхны омог асан Кусай бин Килабын дүү байсан тул Хазрат-и Аминагийн угсаа Хазрат-и Абдуллахтай Килабд нэгдэнэ.[40]

37. Хар. Хаким, II, 604/4036.
38. Хар. Халэбий, I, 51-62.
39. Хар. Ибн-и Хишам, I, 168-169.
40. Хар. Ибн-и Са'д, I, 59-60.

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- эхийн хэвлийд унангуут Абдуллахын духан дахь туяа Хазрат-и Аминад нэвтэрч дамжина.[41]

Пайгамбар Эзний маань Эцэг Абдуллах Өөд Болсон нь

Пайгамбар Эзний маань эцэг Хазрат-и Абдуллах гэрлэснээс хойш удалгүй Дамаск хүртэл наймаачдын жинд явжээ. Наймаагаа дуусгаж буцах замдаа өвдөв. Мадинад ирэхдээ найзууддаа:

“–Би энд нагац Нэжжарынхны дэргэд түр байж байя,” гээд тэнд нэг сар амрав.

Нагац нар нь хэдий их хичээсэн ч сэхсэнгүй, тэнд нас барав. Мадинад оршуулав. Хазрат-и Абдуллах нас барахдаа 25 настай байв.[42]

Хазрат-и Амина нь нөхөр нь Хазрат-и Абдуллахын өөд болсныг дуулаад ихэд гуниглан олон хоног нулимс мэлмэрүүлэн уйлж, түүнийг олдошгүй нэгэн байсныг, хүн бүхний хайрт байсныг, маш өгөөмөр ба энэрэлтэй байсныг илэрхийлсэн магтаалууд дуулав.[43]

Пайгамбарын маань илчлэх батлах бэлгэ тэмдэг

Пайгамбар Эзнийг маань төрөхөөс өмнө маш олон тэнгэрлэг бэлгэ тэмдэг илрэв. Хамаг орчлон бараг Түүнийг үгүйлсэн юм шиг байв. Энэ нь түүний утга учир байв.

41. Хар. Ибн-и Хишам, I, 170.
42. Хар. Ибн-и Са’д, I, 99.
43. Хар. Ибн-и Са’д, I, 100.

Нэгдүгээрт нь өмнөх пайгамбарчуудаас Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-д итгэн үнэмшиж ирсэн аман гэрээс авсан байдаг. Энэ нь Түүний илрэхийн хамгийн том бэлгэ тэмдэг юм. Ает-и кэримэ ингэж айлдана:

وَاِذْ اَخَذَ اللّٰهُ مِيثَاقَ النَّبِيّٖنَ لَمَآ اٰتَيْتُكُمْ مِنْ كِتَابٍ وَحِكْمَةٍ ثُمَّ جَٓاءَكُمْ رَسُولٌ مُصَدِّقٌ لِمَا مَعَكُمْ لَتُؤْمِنُنَّ بِهٖ وَلَتَنْصُرُنَّهُ قَالَ ءَاَقْرَرْتُمْ وَاَخَذْتُمْ عَلٰى ذٰلِكُمْ اِصْرٖي قَالُوٓا اَقْرَرْنَا قَالَ فَاشْهَدُوا وَاَنَا مَعَكُمْ مِنَ الشَّاهِدٖينَ

“Дээр нэгэн удаа Аллах Таала пайгамбарчуудаас ам авсан байв: «–Үнэхээр би танд судар эрдэм өгөв; танд буйг батлуулах нэгэн пайгамбар ирнэ, та Түүнд заавал итгэн үнэмших ба Түүнд заавал тусална, энэ үгийг итгэж зөвшөөрөв үү?» хэмээсэн байв. «–Итгэлээ» гэцгээж Аллах ч: «–Гэрч болцгоо, Би ч таны хамт гэрч мөн,» хэмээв.” (Ал-и Имран, 81)

Хазрат-и Ибрахим ба хөвүүн Хазрат-и Исмаил Кабагийн барилгыг бүтээсний дараа гараа өргөж Пайгамбар-алэйхиссалатү вэссэлам-ын төлөө ингэж залбирсан байв:

رَبَّنَا وَابْعَثْ فٖيهِمْ رَسُولًا مِنْهُمْ يَتْلُوا عَلَيْهِمْ اٰيَاتِكَ وَيُعَلِّمُهُمُ الْكِتَابَ وَالْحِكْمَةَ وَيُزَكّٖيهِمْ اِنَّكَ اَنْتَ الْعَزٖيزُ الْحَكٖيمُ

“Аяа Раб маань! Тэдэнд тэдний дотроос Чиний аетуудыг унших, судар эрдмийг сургах ба тэдний(нэфсий)**г цэвэрлэх** (муу муухайнаас арилгаж төгс төгөлдөрт хүргэх) **нэгэн пайгамбар илгээх болту-**

гай! Учир нь эрхэмсэг бөгөөд бүхнийг ёсоор нь хийгч нь зөвхөн Чи л мөн!” (эл-Бакара, 129)

Хазрат-и Есүс -алэйхиссэлам- ч пайгамбар болсноо Исраилынханд мэдэгдэж байхдаа Оршигчдын Туяаны сайхан мэдээг хүргэж байв:

وَاِذْ قَالَ عِيسَى ابْنُ مَرْيَمَ يَا بَنِيٓ اِسْرَآءِيلَ اِنِّي رَسُولُ اللّٰهِ
اِلَيْكُمْ مُصَدِّقًا لِمَا بَيْنَ يَدَيَّ مِنَ التَّوْرٰيةِ
وَمُبَشِّرًا بِرَسُولٍ يَاْتِي مِنْ بَعْدِي اسْمُهُٓ اَحْمَدُ

“Мэрвемийн хөвүүн Есүс: «Аяа Исраилынхан! Үнэхээр би нада-ас өмнө ирсэн буй Тэвратыг батлах, миний дараа ирэх ба Ахмад гэсэн нэртэй болох пайгамбарын сайхан мэдээг хүргэгч, Аллахын танд илгээсэн нэгэн пайгамбар мөн!» гэсэн байв…” (эс-Сафф, 6)

Эх нь Хазрат-и Амина нь хэвлийдээ үр бүрэлдээд удаагүй эхний өдрүүдэд нэгэн зүүд зүүдлэв. Зүүдэндээ:

“Аяа Амина! Чи бие давхар болжээ. Түүнийг хорвоод мэн-дэлмэгц нь: «Атаач бүрийн муу муухайгаас хамгаалж цорын ганц буй Аллахад даатга!» Түүнд «Мухаммед» гэсэн нэр өг!” хэмээхийг сонсов.[44]

Ийм л учраас Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- ингэж айлдав:

“Би омог Ибрахимынхаа залбирал, дүү Есүсийнхээ сайхан мэдээ ба эхийнхээ зүүд мөн.” (Хаким, II, 453; Ахмад, IV, 127-128)

Түүнчлэн Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн нэр ба бэлгэ нь Тэврат ба Инжилд бичсэн бөгөөд еврей болон

44. Хар. Ибн-и Хишам, I, 170.

христийн эрдэмтэд энэ тухай бүрэн мэдлэг эзэмшсэн байв. Жишээлбэл эд нараас уяхан сэтгэлтийн тухай Кур'ан-и Кэрим ингэж айлдана:

اَلَّذِينَ يَتَّبِعُونَ الرَّسُولَ النَّبِيَّ الْاُمِّيَّ الَّذِي يَجِدُونَهُ
مَكْتُوبًا عِنْدَهُمْ فِي التَّوْرٰيةِ وَالْاِنْجِيلِ

"Тэд нэр ба бэлгэ тэмдгийн тухай олж үзсэн Расулын үгэнд орно…" (эл-А'раф, 157)

Түүнчлэн эхл-и китабын эрдэмтэд нь Пайгамбар Эзнийг маань өөрийнх хүүхэд шигээ таньдаг байв:

اَلَّذِينَ اٰتَيْنَاهُمُ الْكِتَابَ يَعْرِفُونَهُ كَمَا يَعْرِفُونَ اَبْنَآءَهُمْ
وَاِنَّ فَرِيقًا مِنْهُمْ لَيَكْتُمُونَ الْحَقَّ وَهُمْ يَعْلَمُونَ

"Өөрсөд нь бидний судар олгосон хүмүүс Түүнийг өөрийнх хүүхдээ таньсан шигээ танина. Гэвч андашгүй тэднээс хэн нэгэн мэдсэн байгаагаа үнэнийг нууна." (эл-Бакара, 146)

Жишээлбэл еврейчүүдийн хамгийн агуу эрдэмтдийн нэг байхдаа мусульман болсон Абдуллах бин Сэлам -радъяллаху анх-:[45]

45. **Абдуллах бин Сэлам** -радъяллаху анх-ын хоч нь Эбү Юсүф бөгөөд Юсүф -алэйхиссэлам-ын удмынх юм. Жинхэнэ нэр нь Хусайн байхад Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм- түүний нэрийг Абдуллах болгож солив. Бэний Кайнука еврейчүүдийн эрдэмтдээс байв. Манай Эзэн Маккагаас Мадинад нүүхдээ Кубад хүрэхэд Абдуллах Түүний дэргэд очиж зарим зүйлс асуусан байв. Пайгамбар Эзний маань тэдгээр асуултад өгсөн хариугаар, ийм хариуг зөвхөн нэгэн Пайгамбар хэлж чадахыг хэлээд Исламд оров. Дараа ч хамаг гэр бүлийнхэн болон зарим садан хамаатны Исламд орохын учир болов. Пайгамбар Эзний

“–Би Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийг өөрийнх хүүгээсээ сайн танина!” гэхлээр нь Хазрат-и Умар -радъяллаху анх-:

“–Аяа Ибн-и Сэлам аа! Ингэж яаж болох вэ?” гэж асуув. Тэр бол:

“–Би Мухаммед -алэйхиссалатү вэссэлам-ын үнэхээр Аллахын Элч буйг ойроос гэрчилнэ. Түүний пайгамбар гэдэгт огт эргэлзэхгүй! Учир нь Түүний Аллах илгээсэн Пайгамбар бөгөөд магтаал ба бэлгэ нь бидний сударт байдаг…” гэв.

Тэгэхлээр нь Хазрат-и Умар -радъяллаху анх-:

“–Аяа Ибн-и Сэлам аа! Аллах чамайг үнэнд амжилттай хүргэв!” гээд духанд нь үнсэв. (Вахидий, х. 47; Разий, *Тэфсир,* IV, 116)

Ает-и каримэ нь манай Пайгамбар болон асхабынхаа бэлгэ, байдал ба нэр алдрыг Тэврат ба Инжилд ингэж илэрхийлснийг мэдүүлнэ:

مُحَمَّدٌ رَسُولُ اللّٰهِ وَالَّذٖينَ مَعَهُ اَشِدَّٓاءُ عَلَى الْكُفَّارِ رُحَمَٓاءُ بَيْنَهُمْ تَرٰيهُمْ رُكَّعًا سُجَّدًا يَبْتَغُونَ فَضْلًا مِنَ اللّٰهِ وَرِضْوَانًا سٖيمَاهُمْ فٖي وُجُوهِهِمْ مِنْ اَثَرِ السُّجُودِ ذٰلِكَ مَثَلُهُمْ فِي التَّوْرٰيةِ وَمَثَلُهُمْ فِي الْاِنْجٖيلِ كَزَرْعٍ اَخْرَجَ شَطْئَهُ فَاٰزَرَهُ فَاسْتَغْلَظَ فَاسْتَوٰى عَلٰى سُوقِهٖ

маань диваажинд орох сайн мэдээллийг өгсөн Абдуллах -радъяллаху анх- сахабагийн хооронд хүндэлсэн нэгэн хүн байв. Ахкаф Сурагийн 10-р ба Ра’д Сурагийн 43-р аетыг түүний тухай буусан гэдэг. 25 хадис-и шариф дамжуулсан ба Муавияг калиф байхад хижрэтийн тооллын 43 / билгийн тооллын 663 он Мадинад өнгөрөв.

يُعْجِبُ الزُّرَّاعَ لِيَغِيظَ بِهِمُ الْكُفَّارَ وَعَدَ اللّٰهُ الَّذِينَ اٰمَنُوا وَعَمِلُوا الصَّالِحَاتِ مِنْهُمْ مَغْفِرَةً وَاَجْرًا عَظِيمًا

“Мухаммед нь Аллахын Элч мөн. Түүний хамт байгчид нь үгүйсгэгчдэд хатуу, бие биедээ бол нэрэлхүү байдаг. Тэднийг бөхийж, мөргөж байхыг харах болно. Тэд Аллахаас сайхан ба тааламж гуйна. Тэдний бэлгэ нь царайн дахь мөргөлийн мөр, мөргөлийн гэрээ юм. Энэ нь тэдний Тэвратад дурдсан бэлгэ мөн. Инжилд бол ингэж дурддаг байв: Соёолж эхлээд, тэрийгээ бэхжүүлсэн, бүдүүн болсон, биеэ даах болсон, тариачдын таатай тариа шиг юм. Аллах эд нарыг ингэж арвижуулж бэхжүүлээд үгүйсгэгчдийг хилэгнүүлнэ. Аллах нь итгэж сайхан үйлс хийгчдэд өршөөл ба том нэгэн шагнал амласан байдаг.” (эл-Фэтих, 29)

Абдуллах бин Аббас -радъяллаху анхүма- нэгэн өдөр Ка’б эл-Ахбараас:[46]

“–Тэвратад Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн бэлгэ тэмдгийг яаж ярьдаг вэ?” гэж асуухад нь, Хазрат-и Ка’б -рахимэхуллах- ингэж хариу өгөв:

“–Түүний бэлгэ тэмдгийн тухай Тэвратад ингэж бичдэг:

Мухаммед бин Абдуллах, Маккад төрөх, Табэд (Мадинад) нүүх, Дамаскыг эзлэх болно. Өөрөө муухай үг ч хэлэхгүй, захаар явж байхдаа чанга дуугаар ч ярихгүй. Муухайд муухайгаар хариулахгүй, эсрэгээр нь өршөөнө. Үммэт нь ч элбэгт ч хэцүүд ч хаа байсан ч Аллахад хамд хийж Тэрээрийг магтацгаана. Хэвлийдээ хормой уяцгаана. Гараа угаацгаана (авдэст авцгаана).

46. **Ка’б эл-Ахбар** -рахимэхуллах- табиийнаас бөгөөд Бэний Исраилын тухай үг дамжуулснаараа алдаршив. Хазрат-и Эбү Бэкир -радъяллаху анх-ын эринд мусульман болж хижрэтийн тооллын 32 онд өнгөрөв.

Дайнд цугласан шигээ мөргөлдөө ч цуглацгаана. Мэсжидээс нь зөгийн дүнгэнэх чимээ шиг (Кур'ах ба зикир) дуу гарна. Эзаны дуу хязгаарыг дүүргэнэ." (Даримий, Мукаддимэ, 2)

Ата бин Есар -рахимэхуллах- ярина:

"Абдуллах бин Амр -радъяллаху анхүма-тай[47] тааралдаад:

«–Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн Тэвратад дурдсан бэлгэ тэмдгийг надад хэлээд өгнө үү?» гэсэн. Тэгэхлээр минь:

«–За тэгье! Аллахад Тангараг өргөе, Тэр нь Кур'анд дурдсан зарим бэлгээрээ Тэвратад ч дурдсан байдаг. (Тэнд): "Аяа Пайгамбар! Бид чамайг хүмүүст гэрч, сайхан мэдээлэгч, сануулагч ба үммийчүүдэд хамгаалагчаар илгээв. Чи миний боол ба Расул мөн. Би чамайг **Мүтэвэккил** хэмээн нэрлэв… Аллах нь эвдсэн шашныг хүмүүсийн **"Ла илахэ иллаллах"** гэснээр засах ба тэр шашнаар сохор нүдийг, дүлий чихийг, зэвэрсэн зүрхийг нээхгүйгээр Түүний амийг авахгүй," хэмээн айлдана,» гэв." (Бухарий, Бүюү 50; Тэфсир 48/3)

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийг бүх бэлгээрээ мэдсэн еврейчүүд өөрийнх нь ирэх цагийг хүлээж байв.

47. **Абдуллах бин Амр бин Ас** -радъяллаху анхүма- нь аав Амрын хамт хижрэтийн тооллын долоо дахь онд Мадинад нүүв. Хуучны соёлыг эзэмшсэн, уншиж-бичиж мэддэг нэгэн сахабий байв. Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ээс сонссон хадисыг бичдэг байв. Энэ тухай Хүндэт Элчээс тусгай зөвшөөрөл авсан байв. Абдуллах нь хадис ба фикхийн талаар өргөн ухаанаасаа болж сахабагийн дунд "**Абадила**" гэж алдаршсан дөрвөн Абдуллахын нэгэн юм. Аав нь Хазрат-и Амрын хамт Дамаскын ялалтад ба Ермүк дайнд оролцож, уг дайнд аавын тугийг барив. Египетийг эзлэхэд аавынхаа хамт Египетэд суурьшиж тэнд амьдрав. Аавaасаа өмнө мусульман болсон Абдуллах 72 настай байхдаа Египетэд нас барав. Булш нь Каир дахь Амр бин Ас Мэсжидэд байдаг юм.

Жишээлбэл Мадинагийн баримал шүтэгч Эвс ба Хазраж аймгуудтай еврейчүүд хэзээ ч маргалдаж гомдвол, еврейчүүд:

"–Ойрдоо нэгэн пайгамбар илгээхээр болсон байх юм. Түүний ирэх нь маш ойр. Тэр пайгамбарыг ирэхлээр бид Түүнийг дагаж, Ирэм ба Ад үндэстэн шиг таныг алаад мөхөөнө!" гэдэг байв. (Ибн-и Эсир, *эл-Камил,* II, 95-96)

Пайгамбар Эзний маань хатан Сафия бинт-и Хүей -радъяллаху анха-гийн дамжуулснаар, Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийг хижрэт болоход Куба тосгонд ирэхлээр, аав нь еврей Хүей бин Ахтаб авга ах нь Эбү Ясир хоёр шууд тэнд очиж, нар жаргахад маш ядарсан ба гунигтай буйгаараа гэртээ харив. Эбү Ясир дүүгээсээ:

"–Энэ хүн ирэхийг хүлээж байсан Пайгамбар мөн үү?" гэж асуув. Хүей:

"–Тийм, валлахи тэр мөн!" гэв. Эбү Ясир:

"–Үүнийг тэр Пайгамбар буйд итгэлтэй байна уу? Сайхан тогтоов уу?" гэж асуув. Хүей:

"–Тийм!" гэж хариу өгөв.

"–Тэгэхлээр, зүрхэндээ Түүний тухай юу байна вэ?" гэж асуухлаар нь ч Хүей:

"–Валлахи амьд байхдаа байнга Түүний дайсан байх болно!" гэж. (Эбү Нуайм, *Дэлаил,* I, 77-78)

Еврейчүүд ирэхийг нь хүлээж байсан сүүлийн пайгамбар тэдний удмаас буюу Исраилынхнаас болохыг хүсдэг байв. Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- бол Исмаил

-алэйхиссэлам-ын удмаас ирсэн Арабчуудаас байсан тул еврейчүүд атаархаж, Түүнд итгээгүй юм.[48]

Уг үнэнийг Ибн-и Аббас -радъяллаху анхүма-гийн уг дамжуулсан яриа ч илэрхийлдэг:

Хайбарын еврейчүүд Гатафан хоёрын хооронд дайн болоод еврейчүүд уулзах бүрт хожигдож байв. Эцэст нь:

“Аяа Аллах маань! Төгсгөлийн үед илгээхээр амласан тэр үммий пайгамбарын эрхээр Чамаас биднийг ялагч болгохыг чинь хүсэн ерөөе!” гэж залбирахаар шийдэв. Гатафантай таарлдахдаа ингэж залбирцгаав. Ингээд Пайгамбар Эзний маань нэрээр юм гуйв. Дайны дүнд Гатафаныг тараав. Гэтэл Аллах Таала нь еврейчүүдийн залбиралдаа нэрийг нь хэрэглэсэн Хазрат-и Мухаммед -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийг пайгамбар болгож илгээхэд Түүний пайгамбар буйг үгүйсгэв. Тэгэхлээр нь Аллах Таала:

وَكَانُوا مِنْ قَبْلُ يَسْتَفْتِحُونَ عَلَى الَّذِينَ كَفَرُوا فَلَمَّا جَاءَهُمْ مَا عَرَفُوا كَفَرُوا بِهِ فَلَعْنَةُ اللّٰهِ عَلَى الْكَافِرِينَ

“...Өмнө нь тэр пайгамбарын нэрийг хэрэглэн, Түүний эрхээр гээд **кафирчуудад ялалт хүсээд байсан боловч, тэр таниад хүлээж байсан** Пайгамбар **тэднийд хүрэхэд, Түүнийг үгүйсгэв. Аллахын хараал[49] нь ийнхүү кафирчууд дээр байдаг,”** (эл-Бакара, 89) аетыг буулгав. (Куртубий, II, 27; Вахидий, х. 31)

48. Хар. Ибн-и Са’д, I, 155.
49. Кур’ан-и Кэримд ба дараа үзэхээр Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн хадисуудад ердөө хүн дурдахгүйгээр зарим нүгэлтнүүдийг бүгдийг нь хараадаг. Үүнд ёс суртахууны\ итгэл үнэмшлийн ба эдийн засгийн талаар том төөрөлтийг төлөөлсөн ойлголт, үйл ажиллагаа

Орчлонгийн Хүндэт Эзний маань илрэхийг мэдээлсэн уг явдал ч нэлээд анхаарал татам юм:

Сэйф бин Зий Езэн нь Ираны Кисрагийн зарлигаар Йемений ханы ширээнд томилогдоход, бүх талаас Араб хамт олнууд ирээд түүнд баяр хүргэв. Маккагаас ирсэн арван хүний хамт олныг Пайгамбарын маань өвөө Абдүлмутталиб тэргүүлж байв. Тэр нутгийн эзэнд:

"–Аяа Эзэн минь! Бид нар, Аллахын гар хүрэлгүй болгосон Харамын ард ба Бэйтуллахын үйлчлэгчид мөн. Чиний хан болсны мэнд хүргэх зорилготой ирцгээв!" гэв.

Йемений эзэн тэднийг сайхнаар хүлээн авч удаан хугацаагаар зочин болгов. Нэгэн өдөр Абдүлмутталиыг дуудан ингэж хэлэв:

"–Аяа Абдүлмутталиб! Би нэгэн нууц мэднэ, тэр нууцаа өөр хэнд ч хэлээгүй байв. Гэтэл би түүний уурхайг чамаас харав. Ийм учраас чамд хэлье. Аллах Таала зөвшөөртөл уг нууцыг чи хадгал.Гарцаагүй Аллах тушааснаа хэрэгжүүлнэ. Өөртөө зориулж бусдад хаалттай хадгалсан Судрт маш чухал нэгэн мэдээ бий бөгөөд, амьдралын нэр хүнд, үхлийн үнэ цэнэ түүнд бий; хамаг хүн төрөлхтөн, чиний хамт олон, ялангуяа чамтай маш ойр хамаатай юм!" гэв.

Абдүлмутталиб:

"–Аяа Эзэн минь ээ! Хамаг нүүдэлчин ард түмэн чиний төлөө золиос бологтун! Тэгээд тэр том нууц чинь юу вэ?" гэж асуув.

хараасан байдаг. *"Би хараагчаар биш, энэрлээр л илгээгдлээ,"* (Мүслим, Бирр, 87) хэмээсэн боловч Аллахын Элчийг зарим үйлсийг хийгчдийг хараасан нь тухайн үйлс Исламын нийгмийн бүтэц ба аж ахуйн талаар маш хүнд ба сөрөг нөлөөтэй буйг заадаг.

Эзэн:

“–Тихамэ тойрогт нэгэн хүү төрнө. Тэмдэг нь хоёр далны хооронд нэгэн мэнгэ байх болно. Киямат өдөр хүртэл тэр тэргүүн, та нарыг удирдах болно,” гэв.

Сэйф бин Зий Езэн ингэж үргэлжлүүлэв:

“–Одоо Түүний төрөх цаг мөн. Мэндэлсэн ч байж магад. Түүний нэр **Мухаммед** мөн. Аав ээж нь өнгөрсөн байх болно. өвөө авга ах хоёр нь өсгөхийг даана. Аллах Түүнийг пайгамбар болгон илгээнэ. Бидний хэсэг хүмүүс Түүний туслах байх болно. Тэд хамтран андуудаа бэхжүүлж, дайснаа номхотгоно. Тэр дэлхийн хамгийн үнэт газар орныг эзэлж авна. Түүнийг төрхөд мэжүсийчүүдийн залбирдаг гал унтарна. Цорын ганц Рахманд л үйлчилнэ. Күфүр ба хэтэрсэн үйлсийг хоригло-но, баримал хиймэл шүтээнийг эвдэнэ.чөтгөрийг зайлуулна. Түүний үг үнэн худал хоёрыг ялгана, шийдвэр нь гагцхуу эрх тэгшийг эрхэмлэнэ. Тэр байнга сайн сайхныг тушааж хэрэгжүүлнэ, муу муухайг хориглож үгүй болгоно,” гэв.

Абдүлмутталиб:

“–Чиний нас урт, цуу алдар өндөр, хааны үүрэг үүрд байх болог! Энэ ярьсан чинь миний угсаа юм. Эзэн нь энэ тухай жаахан илүү тайлбар хийж өгөөд намайг баярлуулах ажаамуу?” гэв.

Сэйф:

“–Дэвсгэрээр бүрдсэн Бэйтуллахад, гайхамшиг ба тэнгэрлэг судруудад Тангараг өргөе, аяа Абдүтмутталиб! Огт худал үгүй!” гэхлээр нь, Абдүлмутталиб баяр хөөртэй мөргөв.

Эзэн:

“–Толгойгоо өндийлгө! Чиний сэтгэл амар, нас урт, алдар өндөр болог! Миний чамд ярьсан бэлгэ тэмдгээс харсан зүйл бий юу?” гэв.

Абдулмутталиб:

“–Тийм, аяа Эзэн ээ! Надад маш хайртай, байнга сахисан нэгэн хүү байв. Түүнийг аймгийнхаа алдарт нэгэн хүний охин Аминатай гэрлүүлсэн. Амина нэгэн хүү төрөв. Түүнд **Мухаммед гэдэг нэр** өгөв. Хоёр далныхаа хооронд нэгэн мэнгэтэй. Сая ярьсан бэлгэ тэмдэг бүгд түүнд байдаг. Түүний аав ээж хоёулаа нас барав. Түүнийг өсгөхөөр авга ахтай би даав,” гэв.

Тэгэхлээр нь эзэн Сэйф:

“–Хүүгээ сайхан хамгаал! Еврейчүүдээс сэргийл! Учир нь еврейчүүд Түүний дайсан мөн. Гэтэл Аллах энэ тухай тэдэнд завшаан олгохгүй. Энэ хэлснийг минь найзууддаа ерөөсөө хэлүүзэй! Тэднийг танд заяасан давуу талыг атаархаж ач хүүд чинь төвөг гаргахгүй гэдэгт итгэлтэй биш байна. Хэрэв би Түүнийг пайгамбар болохоос өмнө үхэхгүйгээ мэдэхсэн бол, морьт ба явган цэргийнхээ хамт очоод, Есрибийг (Мадинаг) нүүдлийн орон, улс төрийнхөө нийслэл болгох байсан. Яасан ч Түүнийг осол гамшгаас би хамгаалахыг хүсч байна. ! Жилийн дараа түүний тухай надад мэдээ авчир!” гэв.

Даанч Сэйф бин Зий Езэн жил өнгөрөлгүй алагдав.[50] (Ибн-и Кэсир, *эл-Бидая,* III, 26-28; Диярбэкрий, I, 239-241)

---

50. Тэврат болон Инжилд Хазрат-и Пайгамбар ирэх ба зарим бэлгэ тэмдгийг зарласан нь, тэдний үнэндээ тэнгэрлэг үүсэлтэй бөгөөд, эвдсэн ч өнөөдөр агуулсан бичигт эхээс нь зарим хэсэг болж мэдэхийн нэгэн баримт мөн. Ийм л учраас мусульманчууд Тэврат болон Инжилийг хүчингүй болсон хууль мэт хүлээн зөвшөөрсөн боловч, тэднийг хэзээ ч үл хүндэтгэн үздэггүй.

Пайгамбар Эзний мөөнь өвөө Абдүлмутталибад, ачийнхаа ирээдүйн тухай өгсөн өөр нэгэн сайхан мэдээ ч ийм юм:

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- нэгэн өдөр хүүхдүүдийн хамт тоглож байхдаа анзааралгүй Рэдм хороолол хүртэл явав. Тэнд Мүдлижийнхнээс хэсэг хүмүүс Пайгамбар Эзнийг маань хажуудаа дуудаж хөлийг нь харж мөрийг нь шинжлэв. Тэр хооронд Абдүлмутталиб ирэв. Түүнтэй тэврэлдэв. Тэд:

"–Энэ хүүхэд чиний удмаас юм уу?" гэж асуув. Абдүлмутталиб:

"–Миний хүү юм," гэв.

Мүдлинийнхэн:

"–Түүнийг сайхан хадгал! Учир нь бид Макам-и Ибрахим дахь хөлийн мөртэй энэ хүүхдийнхээс илүү төсөөтэй хөлийн мөр хараагүй," гэцгээв.

Тэврат болон Инжилд болсон шигээ Зороастризм, Хиндуизм ба Буддизм мэтийн дорнодын шашнуудын ариун хэмээн үздэг судруудад ч Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ын ирэх мэдээлсэн байдаг. Зороастын ариун судар хэмээн мэддэг Зэнд Авэста нь Хазрат-и Пайгамбарын нэрийг "Соешъянт" хэмээн дурдсан бөгөөд "Орчлонгуудад Энэрэл" гэсэн утгатай байдаг. Хамаг хүмүүсийн Пайгамбар болохыг мэдүүлсэн бөгөөд бусад олон бэлгэ тэмдгийг ч дурдсан байдаг. Хиндуизмын ариун судар Ведануд, Упанишадууд ба Пурананууд ч Сүүлийн Номлогчийн сахлыг сүннэт болгож, гахайн махыг хориглох ба маш олон бэлгэ тэмдгийг нь дурддаг. Мөн Буддын судруудад ч Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн номлохыг мэдээлсэн ба бэлгийг нь дурдсан маш олон бүлэг байдаг. (Хар. Рэмзи Каяа, *Тэнгэрлэг Судруудад Хазрат-и Мухаммед*, х. 221-239; А. Х. Виярти - У. Али, *Дорнодын Ариун Бичгүүдэд Хазрат-и Мухаммед,* Истанбул, 1997; Ибрахим Жанан, XIV, 79-81)
Дэлхийд анхны шашин зөв шашин буй, хүн төрөлхтөн олон мянган пайгамбар илгээгдсэн боловч хүмүүсийг заримдаа зөв замаас төөрснийг анзаарвал, Зороастризм, Хиндуизм, Буддизм мэтийн шашнуудын сүүлийн пайгамбарыг мэдээлсэн үнэнд гайхахгүй байх хэрэгтэй.

Абдүлмутталиб, хүү Эбү Талибдаа:

“–Хар! Эдний хэлснийг сайхан сонс!” гэв. Ийм учраас Эзэн маань -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн авга ах Эбү Талиб ачийгаа нямбай сахиж хамгаалав.[51]

Пайгамбар Эзэн маань -саллаллаху алэйхи вэ сэллэм- хорвоод мэндлэхээс өмнө хамаг орчлон сүнсний талаар айхтар харанхуйд автсан байв. Хүмүүс хэтэрхий азгүй мунхаглалд живээд уйлж байв. Хүн төрөлхтөн нэр алдраа алдсан байв. Хүмүүсийн харгислалаас амьтад ч бүрэн залхсан байв. Амьдрал дийлэгдэшгүй болсон байв. Орчлон гунигтай, оршигчид зовнилтой, бүхний сэтгэл зовлонтой байв. Хүчгүйчүүд инээхийг мартсан байв. Амьдрах хүчтэйчүүдийн эрхэнд байв. Мэхмэт Акифын хэлснээр:

Хүн махчин байдлаараа чононоос давсан байв;
Хэн нэгэн хүчгүй байвал, түүнийг ах дүүс нь иднэ.

Кур’ан-и Кэрим уг үнэнийг ингэж илэрхийлнэ:

ظَهَرَ الْفَسَادُ فِي الْبَرِّ وَالْبَحْرِ بِمَا كَسَبَتْ أَيْدِي النَّاسِ

“Хүмүүсийн өөрсдийн хийсэн үйлээс газар ба тэнгист замбараагүй байдал илрэв…” (эр-Рум, 41)

Агуу мэндлийг дөхөх тусам хүн бүр, түүнчлэх бүх юм улам бүр илүү үгүйлэн Тэр агуу туяанаас тусламж амжиж өөрсдийгөө харанхуйгаас аврахыг хүлээж, Тэр амин уснаас өөрсдөө дайлсан байхыг хүсч байв. Хамаг хүн төрөлхтөн Түүнд хандсан, Түүнд бэлэн байв. Үүний бэлгэ тэмдгийн авсан ба заримдаа ч авсаар байв.

51. Хар. Эбү Нуайм, *Дэлаил,* I, 165; Ибн-и Са’д, I, 118.

Сүлэйман Чэлэби *Мэвлид-и Шарифдаа*, нарныг ч Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм-д хайрлаж Түүнийг дэнгийн эрвээхий шиг эргэн тойрсныг өгүүлрэн, агуу мэнд-лийн сайхан мэдээг Хазрат-и Аминагийн сэтгэлийн хэлээр ингэж бичнэ:

Тэр Хайртын эх, харсан, гэсэн
Сонин нэгэн сар, дэнгийн эрвээхий шиг
Мэлэкчүүд тэнгэрээс цувж бууцгаав
Гэрийг минь Каба шиг тойрцгоов
Хэлэв: Чиний хүү шиг ямар ч хүү
Хорвоод мэнлэлсэн биш, туурвигдснаас нааш
Энэ ирэгч нь тэнгэрлэг ухааны султан мөн
Энэ ирэгч нь эрдмийн нэгдлийн хаан мөн…

Агуу Мухамед Мэндэлсэн ба Ер Бусын Явдлууд

Эцэст нь хүлээгдэж байсан туяа, билгийн тооллын 571 оны 4 сарын 20нд таарах Рабиулэввэлийн 12ны Даваа гаригийг өглөө, үүрийг цайж байхад, ил хорвоод соёрхон Абдуллах ба Аминагийн хайрын зул манай хорвоог мэндэлж бахархуулав.

Энэ үед хамаг оршигчид өгүүлрэн:

“Тавтай морилно уу аяа Расулаллах!” гээд баяр хөөрт автав.

Сүлэйман Чэлэби хорвоод хамаг жижиг зүйлсийн уг агуу зочныг баяр хөөрөөр угтсаныг ингэж илэрхийлнэ:

Сайн байна уу, аяа агуу султан сайн байна уу!
Сайн байна уу аяа эрдмийн хаан сайн байна уу!
Сайн байна уу аяа Фурканы нууц сайн байна уу!
Сайн байна уу аяа өвчний эмчилгээ сайн байна уу!
Сайн байна уу аяа орчлонгуудын энэрэл сайн байна уу!
Сайн байна уу Чи л өвчнийг анагаах нь мөн!..

Түүний илэрч ирснээр Аллахын энэрэл энэ хорвоод хөөрч цалгив. Өглөө ба үдэш нь бараг өнгөө солив. Мэдрэл нь гүнзгийрэв. Үгс, яриа, амт нь өргөдөв; бүх юм өөр нэгэн утга, өөр нэгэн амт олж авав. Баримлууд найгаж нурав. Кисрачуудын нутаг Мэдайины ордуудын багана ба цамхагууд нурав. Тэр үеийн хүмүүсийн ариун хэмээн үзэж байсан Савэ Нуур нь[52] харгислалын намаг байснаа хатав / хувхайрав.[53]

Дэлхийн цаг ба оронд хэрэгжсэн уг явдал, тэр ариун оршигчийг илэрхийлэх анхны элбэг байв. Тус элбэг хамаг орчлонг бүслэв. Тэр оныг элбэгийн он гэж нэрлэцгээв. Ийм учраас сэтгэлийн урлагийн хүмүүсийн үзлээр Кадир шөнийн дараа хамгийн үнэт шөнө нь Расулаллахын төрсөн шөнө гэж тогтсон байдаг.

Тэр шөнө нэгэн сарнай шиг дэлгэрсэн Орчлонгуудын эзний элбэгээр дүүрсэн сэтгэлээс цалгих үгс шүлэгчдийн мөрт өөр нэгэн гоо сайхнаар бүрддэг:

“Цэцэрлэгч сарнайг услахаар дэмий зүтгэх хэрэггүй! (Учир нь), сарнайн мянган цэцэрлэг усалсан ч (аяа Райсулаллах) Чиний царай шиг сарнай (хэзээ ч) дэлгэрэхгүй!..”

Тэр сарнай хүрээд ирснээр хамаг юмын урсгал ч өөрчлөв. Энэрлийн илэрхийлэл сувдны ширхэг шиг орчлон цацагдсан, туяаг үгүйлсэн сэтгэлүүд баяр хөөрт автсан байв.

Ибн-и Аббас -радъяллаху анхүма- ингэж дамжуулан ярина:

“Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм- Даваа гаригт төрсөн, Даваа гаригт пайгамбар болсон, Даваа гаригт

52. Савэ нь Хамдан Кум хоёрын хооронд, Тегераны 125 км. зүүн урд талд нэгэн нуур байв. Ус нь ширгээд тэнд Савэ хот байгуулав.
53. Хар. Ибн-и Кэсир, *эл-Бидая,* II, 273.

Маккагаас Мадина руу нүүж эхэлсэн, Даваа гаригт Мадинад хүрсэн, Даваа гаригт өөд болсон. Даваа гаригт (Кабад шүүгч хийгээд) Хажар-и Эсвэдийг байран тавив. Даваа гаригт Бэдрийн ялалтын олов. Даваа гаригт اَلْيَوْمَ أَكْمَلْتُ لَكُمْ دِينَكُمْ **«...Өнөөдөр танд шашныг тань бүрэн бүтээв...»** (эл-Маида, 3) хэмээн ает буув." (Ахмад, I, 277; Хэйсэмий, I, 196)

Түүний төрсөн, номлосон, нүүсэн ба өөд болсны тэнгэрлэг тэмдэг шиг байнга Даваа гаригт таарсан нь тус өдрийн чухал талыг заана. Аллахын Жэмал ба Жэлалын илрэлт болоод баяр хөөрийн бишрэлт ба гунигийн гашуудал нэг доор явж байдаг.

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн хорвоод мэндэлсэн ариун шөнөд зарим ер бусын явдлууд бий болсон юм. Эдгээр гайхамшгаас зарим нь ийм юм:

Хазрат-и Аминагийн мэдүүлснээр өөрөө бэлбэсэн үедээ ч төрөхдөө ч төвөг огт мэдрээгүй бөгөөд Аллахын Элчийг төрж байхад дорнод өрнөд хоёрын хооронд гийгүүлэх нэгэн туяаг өөрийнх биеэсээ гарч байсныг харав. Пайгамбар -алэйхиссалатү вэссэлам- цэвэр буйгаараа, хоёр гараа доор тулж төрсөн ба толгойгоо тэнгэр өөд өндийлгөв.[54]

Тэр мөчид шэйтан, амьдралдаа огт болоогүй чанга дуугаараа орилов.[55]

Ираны тэргүүн кадий буюу заргач ба лам асан Мүбэзан зүүдэндээ чөлөөт зарим тэмээг шилдэг олон морийг хөөж Тигрис мөрнийг гаталж Ираны нутаг дэвсгэрт тарсныг харав.

Сэмавэ Хөндийг[56] ус автав.

54. Ибн-и Са'д, I, 102, 150.
55. Ибн-и Кэсир, *эл-Бидая,* II, 271.
56. Сэмавэ нь Күфэ Дамаск хоёрын хооронд, Багдатын 235 км. зуун урт талд, Кэлб гэсэн газрын чулуугүй нэгэн цөл юм.

Кисрагийн ордны 14 багана нурав.

Иранчуудын сүмд мянган жилийн турш тасралтгүй асаж байсан гал унтрав.[57]

Аиша -радъяллаху анха-гийн ярьснаар Маккад наймаа хийж байсан нэгэн еврей нь, Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн төрсөн шөнө, Аллахын Элчний хорвоод мэндэлсний тэмдэг болох од мандсныг харсан, Курайшийн цуглаанд нэгэнд орж:

“–Аяа Курайгчууд! Таны хооронд өнөө шөнө хүүхэд төрсөн нь бий юү?” гэж асуув.

“–Валлахи мэдэхгүй!” гэхлээр нь еврей:

“–Аяа Курайшчууд аа! Миний танд хэлсэн юмыг сайхан тогтооцгоо! Өнөө шөнө төгсгөл үеийн пайгамбар төрсөн юм. Түүний хоёр далны хооронд, дээрээ үстэй, хар шарын холимог нэгэн мэнгэ байдаг,” гэв.

Цуглалтынхан еврейний хэлснийг гайхаж тарав. Гэртээ очихлоороо еврейний үгсийг гэр бүлийнхэнд ярьж өгөв. Заримын гэрийнхэн:

“–Абдуллахын хүү төрсөн. Түүнийг Мухаммед гэж нэр өгчээ!” гэв. Тэгээд тэд еврейний гэрт очоод:

“–Маккад нэгэн хөвүүн төржээ, мэдэв үү?” гэцгээв. Еврей:

“–Намайг танд хэлсний дараа юу, өмнө үү?” гэж асуув.

“–Өмнө төржээ, нэр нь Ахмад!” гэцгээв.

57. Ибн-и Кэсир, *эл-Бидая,* II, 273.

Хүслэнгийнх нь дагуу түүнийг Хазрат-и Аминагийн гэрт аваачицгаав. Хазрат-и Амина ариун хүүгээ тэдэнд үзүүлэв. Еврей нь Орчлонгийн Хүндэт -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн сээр дээрх номлогчийн тамгыг харангаа ухаан балартав. Сэрсэнд нь түүнээс:

“–Яасан бэ?” гэж асууцгаав.

Еврей:

“–Валлахи одоо номлогч үүрэг Исраилынхнаас арилав! Тэдний гараас ном ч арилав! Сүүлчийн пайгамбарыг Исраилынхныг алах ба лам нарынх нэр алдрыг буулгах нь бичсэн байдаг. Арабчууд номлогчтойгоороо том нэр алдарт хүртэнэ. Аяа Курайгийн хамт олон! Баясаарай, валлахи та, мэдээлэл нь дорнодоос өрнөдөд хүрэх нэгэн хүч эзэмшинэ!” гэв. (Ибн-и Са’д, I, 162-163; Хаким, II, 657/4177)

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн төрсөнд хамаг Маззагийнхан баяссан байв. Түүнчлэн Эбү Лэхэб нь ариун ачийнх төрснийг мэдээлсэн шивэгчин Сүвэйбэгээ чөлөөлж шагнав.[58]

Тус явдалтай хамаатай, дараа нь Аббас -радьяллаху анхүүнийг ярина:

Эбү Лэхэбийг үхснээс жилийн дараа зүүдэндээ харав. Муухай байдалтай байв:

“–Чамд хэр хандаж байгаа вэ?” гэж асуусан.

Эбү Лэхэб:

“–Мухаммедын төрсөнд баясч Сүвэйбэг чөлөөлсөн учраас Даваа гаригт зовлон жаахан хөнгөлж байдаг. Тэр өдөр эрхий

58. Халэбий , I, 138.

долоовор хоёр хурууныхаа хоорондох энэ жижиг нүхнээс гардаг усаар сэрүүднэ,” гэж хариулав. (Ибн-и Кэсир, *эл-Бидае,* II, 277; Ибн-и Са’д, I, 108, 125)

Пайгамбар Эзний маань Нэрүүд

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-д олон ариун нэр байдаг. Эдгээрээс түрүүлсэн нь, Кур’ан-и Кэримд дурдсан “Мухаммед” ба “Ахмад” мөн. Мухаммед нь ихээр магтагдсан; Ахмад бол ихээр хамд хийгч гэсэн утгатай юм.

Кур’ан-и Кэримд Мухаммед дөрвөн удаа, Ахмад ч нэг удаа дурдсан байдаг. Инжилд бол эдгээр нэрүүдтэй ижил утгын “Фараклит” гэсэн үг хэрэглэсэн байдаг.

Пайгамбар Эзэн маань -алэйхиссалатү вэссэлам- нэгэн хадис-и шарифдаа ингэж айлдана:

“Би Мухаммед ба Ахмад мөн.

Би тэр Махий буюу Мөхөөшч юм[59] *чинь Аллах миний номлолтоор күфрийг тусгаарлана.*

Би тэр Хашир буюу Цуглуулагч юм чинь (киямат өдөрт) хүмүүс намайг дагаж цугларна.

Би Хатумү’л-Энбия буюу сүүлийн номлогч юм, миний дараа хэн ч номлогч болохгүй.” (Бухарий, Мэнакиб, 17; Мүслим, Фэдаил, 125)

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн ариун нэр ба бэлгэ нь олон бүтээлд дурдсан байдаг. Жишээлбэл эндээрээс *“Дэлаил-и Хайрат”* гэсэн бүтээлд хоёр зуу орчим нь илрүүлсэн байдаг. Өнөөдөр Равза-и Нэбий хэмээн Пайгамбарын Онгоны

59. Махий (الماحي) Мөхөөгч

киблэг харсан ханыг гайхалтай уран бичлэгээр чимэглэсэн тус ариун нэр ба бэлгэ нь зарим нь ийм юм:

Ахмад, Махмуд, Мухаммед, Хамид, Хамийд, Бэшир, Нэзир, Бурхан, Эмин, Эввэл, Ахир, Духа, Хабибуллах, Хадий, Хатэм, Мухтар, Мустафа, Мутаххар, Мүжтэба, Нэбий, Нур, Рауф, Рахим, Расулаллах, Расулү'с-Сэкалэйн, Рахмэтэн ли'л-Алэмийн, Сэййидү'л-Мүрсэлийн, Сэййидү'л-Кэвнэйн, Имамү'л-Харамэйн, Имамү'л-Мүттакийн, Үэфиу'л-Мүзнибийн, Шэмс, Та-ха, Үммий, Яа-син...

Сүүний Эхэд Өгсөн нь

Оршигчийн Туяа нь хорвоог өнчин буйгаараа мэндлэв. Ает-и кэримэд Аугаа Эрх үүнийг ингэж айлдана:

أَلَمْ يَجِدْكَ يَتِيماً فَآوَى

"Тэрээр чамайг өнчин олж хамгаална?" (эд-Духа, 6)

Орчлонгийн Хүндэт Эзнийг маань анхны хэдэн хоног ээж нь Хазрат-и Амина хөхүүлэв. Дараа нь Сүвэйбэ Хатан, хүү Мэсрүхийнхээ хамт Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийг хөхүүлж Орчлонгийн Эзний сүүний эх болов.[60] (Ибн-и Са'д, I, 108)

Үнэнч сэтгэлийн төлөөлөгч асан Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- ч амьдралынхаа дараах үед сүүний эх Сүвэйбэ Хатанд байнга анхаарал үзүүлэв. Маккад байхдаа Аллахын Элч ч Хатижа эх маань ч түүнд сайхнаар хандаж асарч байцгаав.

60. Сүвэйбэ Хатан нь Хазрат-и Хамза болон Эбү Сэлэмэг хөхүүлсэн тул, энэ сахабийчууд Аллахын Элчийн сүүний дүү байцгаав. (Ибн-и Са'д, I, 108-110)

Оршигчийн Туяа нь Мадинад нүүхлээр Сүвэйбэ Хатанд байнга идээ ба хувцас илгээж, хэрэгцээг нь хангав. Нүүдлийн долоо дахь жилд Хайбарын дайнаас харихдаа түүний нас барсны мэдээг авсан Аллахын Элч:

"–Хүү нь Мэсрүх юу хийж байна?" хэмээн асуув.

"–Тэр ээжээсээ өмнө нас барав!" гэцгээв.

Тэгэхлээр нь Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- түүний садан хамаатнаас амьд хэн нэгэн байх эсэхийг сураглаж хэнийг ч үлдээгүйг мэдэв. (Ибн-и Са'д, I, 108, 109)

Пайгамбар Эзний маань Сүвэйбэ Хатанд заасан уг хүндэтгэл ба сонирхол, үнэнч сэтгэлийн учрыг нь ухааршгүй нэгэн үлгэр жишээ мөн.

Орчлонгуудын Эзэнд сүүний эх болох нь Сүвэйбэ Хатаны дараа Халима Хатны заяа болов.

Тэр үед Арабчуудад нэгэн заншил байв. Сайхан төрсөн хүүхдүүдийг сүү хөхөг гэж цөлд амьдардаг аймгуудад өгдөг байв. Цөлийн уур амьсгаа нь хүмүүсийн илүү эрүүл ба зоригт болгосноос үл барам, тэндэх хүмүүсийн яриаг ч зөв ба уран байв. Ингээд хүүхдүүд эрүүл ба зөв яриатай хүн болоод өсч байв.

Уг ариун хүү ч Арабын заншлын улмаас сүүний эх нь аз жаргалтай эмэгтэй Халима Хатанд өгсөн байв. Учир нь Бэний Са'д аймаг нь Араб аймгууд дотор хамгийн зөв яриат нь байв. Хүмүүсийн хамгийн ойлгомжтой ба уран яриат нь байсан Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- ингэж ярих урлагийн оргил болох Кэламуллах буюу Кур'ан судрыг сургах үүрэгтээ бага наснаасаа эхлэн бэлдсэн байдаг.

Жишээлбэл Хазрат-и Эбү Бэкир -радъяллаху анх-:

“–Аяа Расулаллах! Чамаас сайхан ярьсан хэнийг ч хараагүй,” гэсэнд, Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-:

“–Үүнд гайхах юу байна вэ! Би Курайш аймгийн харъяа бөгөөд Са’дынханд сүүний эхэд өгөгдөв,” хэмээв. (Али эл-Муттакий, VI, 174/15247)

Халима бинт-и Харис -радъяллаху анха- нь Орчлонгуудын Султанд сүүний эх болсноо ингэж ярина:

“Гандуу хэцүү нэгэн жил байв. Цагаан нэгэн илжиг унаж Са’дынхнаас зарим эмэгтэйчүүдийн хамт Макка руу замд гарав. Идэх юм огт үлдээгүй байсан, бид нэгэн хөгшин ингэтэй байв. Гэтэл түүнээс дусал ч сүү гардаггүй. Бас нэгэн хүүхэдтэй байв. Надад ч ингэнд ч түүнд хүрэхүйц сүү байгаагүй тул хүүхдийн уйлсны чимээнээс унтдаг чадахааргүй болсон байв. Эцэст нь Маккад хүрч оров. Мухаммед -алэйхиссалатү вэссэламыг санал болгоогүй хэн нэгэн эмэгтэй ч үлдээгүй. Гэтэл хэн ч түүнийг аваагүй. Учир нь, хүн бүр нь аав нь амьд хүүхэд хайж байв. Харин Тэр өнчин байв. Гэхэд надаас гадна хүн бүр хөхүүлэх хүүхэд олж, аваад явав. Би ч нэгэн хүүхэд авалгүй буцах юмсангүй. Нөхөртөө ингэж хэлэв:

«–Би очоод тэр өнчин хүүхдийг л авна!»

Тэгээд очоод Түүнийг авч майхандаа буцав. Миний нөхөр:

«–Түүнийг аваад сайхан асарсан. Магадгүй энэ хүүхдийн ачаар Аллах бидэнд буян ба элбэгийг хайрлана,» гэв.

Валлахи хүүхдийг тэвэрч авангуут сүү минь цалгив. Түүнийгээ хөхүүлсэн, Тэр цадав; сүүний дүүг нь ч хөхүүлсэн, тэр ч хантлаа ууж цадав. Шөнө болохлоор миний нөхөр настай ингэнийхээ дэргэд очив. Нэг харвал мээм нь сүүгээр дүүрсэн байжээ! Хүссэн чинээгээрээ саасан, хатлаа ууж цадав. Тэр

шөнө өлссөн ч үгүй, цагнасан ч үгүй. Манай хүүхдүүд ч амар тайван унтав. Миний нөхөр:

«–Валлахи миний бодлоор чи маш ариун нэгэн хүү авав!» гэхээс аргагүй болов.

Илжигээ унаж замдаа гарав. Өмнө нь хамгийн хойно үлдэж байсан илжиг минь, хамт олны хамаг амьтдыг давч, би түүнийг арай л удирдаж чадаж байв. Хүн бүр нь андуурсан:

«–Энэ нааш ирэхдээ унасан илжиг чинь биш юм уу?» гэж асууж байв. Би бол:

«–Тийм,» гэж байсан. Эцэст нь нутагтаа очив. Тэнд нь нэлээд цорлог газар байв. Гэтэл манай хонь бэлчсэн газраас мээм нь сүүгээр дүүрсэн буйгаар эргэж байв. Бусдын хонь бол ядарсан, өлөн ба цангасан харьж байв. Хүн бүрийн хонь сүүгүй байхад бид хонио сааж элбэг сүү ууж байв. Малын эзэд хариулагчдаа загнан:

«–Гутамшиг танд! Малыг маань Халимагийн хариулагчийн бэлчээсэн газар бэлчээхгүй юу?» гэж байв.

Ингэхээс аргагүй байлаа. Учир нь малчид ижил газар бэлчээдэг байсан ч тэдний хонь өлөн ба цангасан харьж байхад, манайхны малын дэлэн сүүгээр дүүрэн байв.

Мухаммед -алэйхиссалатү вэссэлам- нэгэн өдөрт бусад хүүхдүүдийн нэг сарт өссөн шиг торниж байв. Нэгэн сард жилийн хүүхэд шиг өсч байв. Ойдоо хүрэхэд ихэд үзэсгэлэнтэй болсон байв.

Бидний дэргэд хэдэн жил байсны дараа эцэст нь түүнийг ээжид нь аваачив. Сүүний аав нь Амина Хатанд:

«–Хүүг минь надад буцааж өг. Макка дахь тахлын халдвараас айж байна,» гэж ахин дахин хэлэв. Мөн Түүний элбэгийг

ч алдмааргүй байсан. Хэт олон дахин хэлсэнд маань, эцэст нь ээж нь:

«–За, Түүнийг дахиад авч яваарай!» гэхээс аргагүй болов.” (Хэйсэмий, VIII, 221; Ибн-и Кэсир, *эл-Бидая,* II, 278-279)

Оршигчийн Туяа нь сүүний эхийнхээ дэргэд байхдаа, нэгэн өдөр сүүний дүү Шэймагийн хамт үдийн халуунд хургын дэргэд очсон байв. Тэдний харихад Халима Хатан охин Шэймадаа:

“–Ийм их халуунд яагаад гадаа гараа вэ?” гэв.

Шэйма бол үзсэн тэнгэрлэг бэлгийг ингэж илэрхийлэв:

“–Ижии! Бид нарны хэт халууныг огт мэдрээгүй. Дүүгийн минь толгойн дээр байнга нэгэн үүл яваад биднийг сүүдэрлэж байв...” (Ибн-и Кэсир, *эл-Бидая,* II, 279; Ибн-и Са’д, I, 112)

Халима Хатан ярьсаар байна:

“Бидний дэргэд жаахан удав. Учирсан ер бусын байдлаас болж Түүнд ямар нэгэн юм таарахаас эмээж байв. Ийм учраас Түүнийг авч шууд замд гарав. Маккагийн дээд хэсэгт арвин хүмүүсийн хооронд Түүнийг алдав.” (Ибн-и Хишам, I, 179; Ибн-и Са’д, I, 112)

Маккагийнхан бүгд сандралдаж, хүн бүр Тэр гэмгүй хүүхдийг хайж эхлэв. Харин олж чадсангүй. Абдүлмутталиб Кабад залбирч байв. Тэр хооронд тэнгэрээс нэгэн дуу:

«–Аяа нийгэм, битгий хашхираад байцгаа! Мэдээж Мухаммедын Раб байдаг. Түүнд тусална, түүнийг орхихгүй, түүнийг хаяхгүй!» гэснийг сонсов.

Абдүлмутталиб:

«–Аяа бидэнд дуудсан нь! Түүнийг хаана буйг мэдээл!» гэв.

Тэр дуу:

«–Тэр Тихама Хөндийд, баруун гар тал дахь модон доор юм,» гэж мэдээлэв.

Тэгээд Абдүлмутталиб шууд тэр чигээр яавж ач хүүгээ олж авав. (Диярбэкрий, I, 228)

«–Би чамд золиг болъё! Би Чиний өвөө Абдүлмутталиб юм!» гэв. Түүнийг үнсч, элгэндээ чанга тэврэв" (Халабий, I, 154)

Духа Сура дахь:

وَوَجَدَكَ ضَالًّا فَهَدٰى

"Чамайг багадаа төөрөхөд олж зөв замд хүргэсэн?" (эд-Духа, 7) ает-и кэримэг уг байдлыг заасан нь дамжуулан хэлдэг.[61]

Халима Хатан явдлын үргэлжлэлийг ингэж ярина:

"Эх нь Аминагийн дэргэд очиход:

«–Хүүг минь дахин дахин гуйсаар аваад явсан, одоо яагаад буцаагаа вэ?» гэж асуув.

Би:

«–Валлахи бид үүргээ хийсэн, хариуцлагаа дутуугүй бүтээв. Дараа нь түүнд таарсан явдлаас айгаад авч гэр бүлийнхэнд буцааж өгье гэсэн,» гэж хариу өглөө.

Ээж нь:

«–Би гуйж байна, Түүнд юу таарсныг яриад өгөөч» гэв.

Хэт олон дахин хэлсэн учраас ярихаас аргагүй болов. Бидний ярьсны эсрэгээр огт гайхаагүй. Бидэнд:

61. Зэмахшэрий, VI, 240.

«–Угаасаа миний хүүгийн хүнийг гайхуулах олон байдал болсон байдаг. Түүний төлөө санаа бүү зов. Би ч танд Түүнтэй хамаатай харсан юмаа ярья,» гээд төрсөнд нь илэрсэн ер бусыг байдлыг яриад өгөв. Дараа нь:

«–Одоо Түүнийг орхиж сэтгэл амар нутагтаа буцаарай!» гэв.” (Хэйсэмий, VIII, 221; Ибн-и Кэсир, *эл-Бидая,* II, 278-279)

Халима Хатан ингэж хэлнэ:

“Абдүлмутталиб намайг хамгийн гоё бэлгийг өгч үдэв. Би нутагтаа тайлбарлаж чадахааргүй олон ба үнэт бараатайгаар буцав. Мухаммед нь өвөөгийнхөө дэргэд үлдэв. Абдүлмутталибад Түүний таарсан бүх юмыг ярьж өгөв. Абдүлмутталиб Түүнийг чанга тэвэрч уйлаад:

«–Аяа Халима! Гарцаагүй хүүгийн минь нэр алдар маш агуу байх болно. Би тэр үед хүрэхийг маш их хүсч байна!» гэв.” (Бэйхарий, *Дэлаил,* I, 145)

Хазрат-и Пайгамбар -алэйхиссалатү вэссэлам- сүүний хамаатандаа амьдралынхаа турш байнга үнэнч сэтгэлээр хандсан байдаг. Халима Хатныг харах бүртээ: *“Ижии! Ижии!”* гээд, түүнд чин сэтгэлийн хайр ба хүндэтгэл үзүүлж, нөмрөгөө газар дэвсэлж дээр нь суулгаад, ямар нэгэн хүсэлтэй байвал шууд биелүүлдэг байв. (Ибн-и Са’д, I, 113, 114)

Халима Хатан нэгэн өдөр Пайгамбар Эзэнтэй маань уулзахаар Маккад ирсэн байв. Эзэн маань тэр үед Хазрат-и Хатижатай гэрлэсэн байв. Халима Хатныг зочин болгож маш сайхан дайлцгаав. Хазрат-и Халима нутагтаа дарсан ган ба малын үхсний тухай гомдоллов. Орчлонгийн Хүндэт Эзэн

маань Хазрат-и Хатижатай ярилцав. Хатижа эх маань түүнд дөчин хонь ба уналга ачилганд нэгэн тэмээ бэлэглэв.[62]

Маккагийн ялалтаар Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- Эбтах гэх оронд байхад Халима Хатны охин дүү Түүнийг зочлохоор ирсэн байв. Нэгэн уутан дотор бяслаг, тос мэтийн зүйлсийг бэлэглэсэн байв. Аллахын Элч түүнээс шууд сүүний эхээ асуув. Нас барсныг мэдэнгээ Пайгамбар Эзний маань нүд нулимсаар дүүрэв. Хойно хэн үлдсэнийг асуув. Дараа нь тэр эмэгтэйд хувцас өмсүүлэхийг, нэгэн тэмээ ба хоёр зуун дирхэм мөнгөн зоос өгөхийг тушаав. Эмэгтэй нь нутагтаа баяртай буцаж байхдаа:

“–Чи чинь багадаа ч одоо ч маш сайхан хэлсэндээ хүрдэг өгөөмөр байна!” гэв. (Вакидий, II, 869; Бэлазурий, I, 95)

Нэг дэх Шэрх-и Садр: Зүрхийг нь Нээсэн Байдал

Аллах Таала тэнгэрлэг нууцыг авахаар болохын тулд Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн цээжийг олон удаа нээсэн, дотрыг нь цэвэрлэж амар амгалан, энэрэл, хала-амж, итгэл үнэмшил ба эрдэм мэтийн агуу шинжээр дүүргэсэн байдаг. Ийм явдал Пайгамбар Эзний маань сүүний эхийн дэргэд байхад бий болсон юм. Үүнийг Орчлонгийн Хүндэт Эзэн маань өөрөө ярив.

Хэн нэгэн Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ээс:

“–Таны пайгамбар болохын анхны бэлгэ тэмдэг юу байв?” гэж асуув. Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- ингэж айлдав:

62. Ибн-и Са’д, I, 114.

“–Миний сүүний эх минь Са’д бин Бэкрийнхнээс байв. Би сүүний дүү нарын хамт малаа авч явав. Хажуудаа идэх юм ч аваагүй байв. Сүүний дүүгээ:

«–Миний дүү, ээждээ очоод жаахан хоол аваад ирээрэй!» гэлээ.

Тэр яваад би малын дэргэд үлдэв. Удахгүй цагаан өмсгөлтэй хоёр мэлэк ирэв. Нэгэн нөгөөнөөс:

«–Энэ мөн үү?» гэж асуув.

Нөгөөх нь:

«–Мөн,» гэв.

Шууд миний дэргэд ирээд, намайг гэдрэг харуулан хэвтээж өврийг минь нээв. Дараа нь миний зүрхийг гаргаж хагалаад дотроос нь хоёр хар элэгшсэн цус гаргаж авав.

Тэгээд нэгэн нөгөөд нь:

«–Очоод надад цасны ус аваад ир!» гэв.

Түүгээр минйи дотрыг угаацгаав. Дараа нь дахиад:

«–За, одоо ч мөндөрийн ус аваад ир!» гэв. Аваад ирээд, түүгээр ч миний зүрхийг угаацгаав. Тэгээд:

«–За, одоо амар амгаланг аваад ир!» гэв.

Түүнийг миний зүрхиэнд байрлуулав.

Тэгээд нэгэн нөгөөд нь:

«–За, хаагаад Түүнийг пайгамбарын тамгаар тамгал!» гэв.

Мэлэк ч минйи зүрхийг хааж пайгамбарын тамгаар тамгалав... Тэгээд салж явцгаав. Би үнэхээр маш их айсан байлаа.

Дараа нь эргэж гэртээ хариад надад болсон сониныг сүүний ээждээ нэг нэгээр нь яриад өгөв…" (Ахмад, IV, 184-185; Ибн-и Кэсир, *эл-Бидая,* II, 280; Хэйсэмий, VIII, 222)

Зарим номуудын мэдүүлснээр уг явдал Оршигчийн Туяаг дөрвөн настай байхад хэрэгжсэн юм.[63]

Энэс -радъяллаху анх-:

"Би Аллахын Элчний цээжин дэх тэр шархын байнга харад байв," гэв. (Мүслим, Иман, 261)

Хүндэт Элч Эзний маань цээжний сорвины нууц учрын зарим нь ийм байдаг:

Аллах Таала нь ингэж Элчнийхээ байдал ба алдрыг хүмүүст мэдээлсэн, Түүнийг багаас нь эхлээд вахийд бэлтгэсэн байдаг. Сүнсний талаар цэвэрлэгээний үйл ажиллагаа байсан уг байдлын, хүмүүсийн гэрчлэх шинжтэй болсон нь Түүний пайгамбар буйг итгэж батлахыг илүү хангах нууц учиртай хамаатай байдаг. Үнэхээр ийм байдлууд хүмүүсийн Түүнд итгэж үнэмшихийг хялбаршуулсан байдаг.

Мадинагийн Аялал ба Ээж нь Нас Барсан нь

Зургаан настай байхад нь ээж нь Хазрат-и Амина нь аавынх нь шивэгчин асан Үммү Эймэнийг ч дагуулан "Оршигчийн Туяа"г аав нь Хазрат-и Абдуллахын оршуулах газрыг зочлохоор Мадинад аваачив. Мадина дахь нагацынхаа гэрт нэг сар байцгаав.

Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- Мадинад нагацынхаа хүүхдүүдтэй тоглож, усанд сэлэхийг ч энэ удаа оролдоод л сурав.[64]

63. Хар. Ибн-и Са'д, I, 112.
64. Хар. Ибн-и Са'д, I, 116.

Орчлонгийн Хүндэт Эзэн маань тухайн өдрүүдтэй хамаатай дурсамжаа ярьж байхдаа ингэж айлдав:

“Еврейчүүдээс зарим хүмүүс миний дэргэд ирж, над руу харсаар байв.” (Ибн-и Са’д, I, 116)

“Дахиад нэгэн өдөр еврейчүүдээс нэгэн хүн надад анхааралтай харсны дараа эргэж явав. Ганцаар байсан нэгэн өдөр дахиад миний дэргэд ирээд:

«–Аяа хүүхэд! Чиний нэр хэн бэ?» гэж асуув.

«–Ахмад!» гэлээ.

Сээрийг минь хараад:

«–Энэ хүүхэд уг үммэтийн пайгамбар мөн!» гэв.

Манай нагац нар үүнийг ээжид ярьж өгөхөд, ээж миний төлөө санаа зовж эхлэв. Тэгэхлээр Макка руу буцахаар шууд замдаа гарав.” (Эбү Нуайм, *Дэлаил,* I, 163-164)

Хазрат-и Амина замдаа өвдөөд Эбва гэдэг газарт гучтай байхдаа өөд болов. Тэнд олшруулав. Өнгөрөөс өмнө өнчин хүүгээ хайр ба халамжаар дүүрэн нүдээрээ удаан удаан харж, Түүнийг элгэндээ тэврч ариун хүүдээ үүнийг хэлэв:

“Аллах Чамайг ариун байлгах болтугай! Хэрэв зүүдэндээ харсан минь зөв гарвал, Чи жалал ба кэрэмтэй Аллахын талаар Адамынханд харам ба халалыг мэдүүлэхээр илгээгдэнэ. Аллах Чамайг баримал ба баримлын шүтлэгээс хамгаалах болно. **Амьд бүр үхнэ, шинэ бүр нь хуучирна, өссөн бүр нь муудаж, үгүй болно. Би ч үхнэ гэтэл үүрд мөнх дурдагдана. Би цэвэр нэгэн хүү төрүүлсэн бөгөөд хойноо буянтай нэгэн дурсгал үлдээж явж байна!..”** (Диярбэкрий, I, 229-230; Камил Мирас, *Тэжрид Орчуулсан нь*, IV, 549)

Эдгээр үнэнийг зүрхэндээ мэдэрсэн шүлэгч Ариф Нихат Асъя нь Хазрат-и Аминад ингэж хандана:

Аяа Эбваад хэвтсэн шарил!
Чиний цэцэрлэгт дэлгэрэв,
Дэлхийн хамгийн гоё сарнай!..

Орчлонгийн Туяа -алэйхиссалатү вэссэлам- нь ингэж ээжгүй ч үлдээд Үммү Эймэний хамт Маккад буцав.

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- амьдралынхаа турш асрагч нь Үммү Эймэнийг олон удаа зочилж түүнд: *"Ээж!"* хэмээн хандаг байв. Тийм учраас: *"Ээжийнхээ дараах ээж!" "Энэ миний гэр бүлээс амьд үлдсэн ганцхан хүн мөн!"* нээд магтаж, хайр ба ба хүндэтгэл үзүүлдэг байв.[65]

Өвөө Абдүлмутталибын Хамгаалалт

Аллах Таала нь эхлээд аавыгаа дараа нь ээжийгээ алдсан ч хайр халамжаар дутаагүй. Ариун өнчнийг өвөө нь Абдүлмутталиб элгэндээ авав. Хүүхдүүдийнхээ хэнд ч үзүүлээгүй халамж ба хайрыг Түүнд үзүүлэв.

Абдүлмутталибыг унтаж эсвэл өрөөндөө ганцаараа байхад хажууд нь хэн ч орч чадахгүй байв. Гэтэл хоёр хорвоогийн наран өвөөгөөсөө орт салдаггүй, өрөөндөө ганцаараа байхад, мөн түүнчлэн унтаж байхад ч хажууд нь чөлөөтэй орж гардаг байв.[66]

Кабагийн сүүдэрт байсан Абдүлмутталибын дэрэн дээн аавыгаа авгайлахаар хөвүүдээс хэн нэгэн ч суудаггүй байв. Тэд аавынхаа дэргэд босоо байхад Орчлонгийн Хүндэт Эзэн маань

65. Хар. Ибн-и Эсир, *Усдү'л-Габэ,* VII, 303-304; Ибн-и Са'д, VIII, 223.
66. Ибн-и Са'д, I, 118.

ирээд өвөөгийнхөө дэргэд чөлөөтэй суудаг байв. Түүнийг дэрнээс босгох юмсан авга харт нь Абдүлмутталиб:

“–Хүүг минь тавь аа! Валлахи Түүний нэр алдар агуу байх болох юм!” гэж, хажууд нь суугаад нурууг нь илдэг байв. Хамгийн гоо сайхан ачийнхаа хийсэн бүх юм өвөөд нь таалагддаг байв.[67]

Абдүлмутталиб нь Орчлонгийн Эзэн болох жижиг ач нь ширээнд ирэлгүй хоол иддэггүй, “Хүүг минь хажууд авчраарай!” гэдэг байв.[68]

Хоол нь ирэхлээр ч Түүнийг хажуудаа аваад, заримдаа өвөр дээр суулгаж хоолны хамгийн гоё хэсгийг Түүнд идүүлдэг байв.[69]

Ган дарсан, хүмүүсийн маш төвөгт автсан өдрүүдэд, Маккагийнхан борооны залбирал хийхээр Эбү Күбэйс Ууланд гарсан байв. Абдүлмутталиб ч долоон насны Хүндэт Хайрт Эзнийг маань мөртөө суулгаж уулны оргилд гарав. Хамт олон түүний дэргэд жагсав. Абдүлмутталиб мөртөө Оршигчийн Туяаг буйгаараа гараа өргөж залбирав. Хүмүүс зогссон газраасаа арай салаагүй байхад, бараг тэнгэр хагалж усаа чөлөөт оруулж эхэлсэн бөгөөд Маккагийн Хөндий нь энэрэлд автав.[70]

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- найман нас хүрэхэд өвөө нь Абдүлмутталиб ч өөд болов.

Ингээд хэсэг зуур хамаг тулгуураа алдав. Үүнээс хойш Түүний эзэн, хамгаалагч ба хүмүүжүүлэгч зөвхөн Раб нь байв.

67. Ибн-и Хишам, I, 180.
68. Ибн-и Са’д, I, 118.
69. Бэлазурий, I, 81.
70. Хар. Ибн-и Са’д, I, 90; Ибн-и Эсир, *Үсдү’л-Габэ*, VII, 112; Диярбэкрий, I, 239.

Түүнчлэн амьдралынхаа хамгийн хүчгүй үед харагдсан уг түр зуурын гадны тулгуурууд гагцхуу Түүний бүх төрлийн үйл ажиллагаандаа хүн төрөлхтөнд дууриах боломжтой ба төгс төгөлдөр нэгэн жишээ болохтой нь хамаатай байв.

Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн цаг хугацааны тусам аав-ээжгүй болгосон нь ч зарим нууц учиртай байв. Эдгээрээс хамгийн чухал нь номлох эрдэм сургаалыг ааваас нь эсвэл өвөөгөөс нь авсан байж таарна гэх бломжгүй гэсэн үг юм.

Түүнчлэн Аллахын Элч аав-ээж ба өвөөгөөсөө хагацса-наараа ааваас залгамжилсан тэр үеийн зан-заншлаас хамгаалаг-дсан, хүний гар хүрэлгүй, иж бүрэн Раббынхаа хүмүүжил доор өссөн байдаг. Жишээлбэл нэгэн хадис-и шарифдаа:

“Намайг Раб минь хүмүүжүүлж, хүмүүжлийг минь маш сайхан заав,” хэмээн айлдав. (Сүюүтий, I, 12)

Нөгөө талаас Пайгамбар Эзний маань аав-ээж үгүй байх-даа ч агуу ёс суртахуунаар өссөн нь Түүний номлогч байсны баталгааны нэг юм.

Түүний өнчин буйгаараа өссөний өөр нэгэн нууц учир ч, зүрхийг нь илүү нарийн ба мэдрэмжтэй болох ба зөвхөн Аллахад итгэх төвшинд хүрэх нь мөн. Жишээлбэл Орчлонгийн Хүндэт -саллаллаху алэйхи вэ сэллэм- өнчин ба хүчгүй боло-хын гашуудлын хамгийн ихээр амссан учраас, амьдралынхаа турш байнга хүчгүй хүмүүсийн хамгаалагч болсон байдаг. Нэгэн хадис-и шарифдаа:

“Өөрийнхөө өнчнийг эсвэл бусдын өнчнийг хамгаалсан хэн нэгэнтэй би диваажинд ийм зэрэг байх болно,” хэмээж долоо-вор дунд хоёр хуруугаа зэрэг үзүүлэв. (Мүслим, Зүхд, 42; Хар. Бухарий, Эдэб, 24; Талак, 14)

Өөр нэгэн нууц учир бол ийм юм: Аллах Таала нь амьдралын төвшин бүр дэх хүний Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийг үлгэр жишээ болгож авахын төлөө Түүнийг амьдралд нийгмийн хамгийн хүчгүй байдал болох өнчнөөс эхлүүлж, тус тустай төвшин давуулсны дараа улс төрийн тэргүүн болтол дээшлүүлэв.

Авга Ах Эбү Талиб Асарсан нь

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн өвөө Абдүлмутталиб, нас барахдаа ойрт хамаг хүүхдүүдээ цуглуулав. Тэдэнд гагцхүү ач хүүгэ сайн харж хандахыг гэрээс болгов. Зүбэйр ба Эбү Талиб нь Орчлонгийн Эзний аав Хазрат-и Абдуллахтай нэг эхийнх тул сугалаа татав. Сугалаа нь Эбү Талибт таарав.

Эбү Талиб нь Пайгамбарт маань авга ах нарынхаа хамгийн энэрэлт хамгийн халамжтай нь байв.[71] Түүнд хэдэн тэмээнээс өөр хөрөнгө байгаагүй. Гэр бүлийнхэн бол өнөр байв. Ийм ядуу байсан ч Эбү Талиб Курайшийн ноён байв. Үгийг нь сонсдог, тушаалыг нь эсэргүүцдэг байв. Аав Абдүлмутталиб шигээ тэр согтууруулах ундаа амсдаггүй байв.[72]

Эбү Талиб нь ариун ач хүүг энэрч, Түүнийг өөрийнхөө хүүхдүүдээс илүү хайрладаг байв. Орчлонгийн Эзнийг хажуудаа авахгүйгээр унтдаггүй, хэзээ ч нэг тийш явах болбол Түүнийг ч хамт авч явдаг байв.

Эбү Талибын гэр бүлийнхэн Оршигчийн Туяа -алэйхиссалату вэссэлам- байхгүйгээр хоол идвэл өлсч, Түүнтэй хамт идэхдээ л цадах байв. Түүнчлэн хоол нь ихэсдэг байв. Шигээнд ганц

71. Ибн-и Эсир, *Усдү'л-Габэ,* I, 22.
72. Халэбий, I, 184.

нэгэн хүнд хүрэхээр хийсэн сүүнээс эхлээд ариун өнчин ууж, дараа нь бусдад өгөхлөөр, бүгд нь уг сүүнээс ханатлаа уудаг байв. Ийм учраас Эбү Талиб нь гэр бүлийнхэн хоолонд эхлэхээс өмнө:

"–Байз! Миний хүү ирэг!" гэдэг байв.[73]

Эбү Талибын эхнэр Фатима Хатан нь хэт эрдэмтэй, уяхан сэтгэлтэй нэгэн эмэгтэй байв. Орчлонгийн Хүндэт Эзэн маань Исламтайгаар нэр хүндэд хүртэж Мадинад нүүсэн уг ариун Хатныг ихээр зочилж, түүний гэрт бага үдийн нойр авдаг байв.[74]

Фатима Хатныг өөд болоход Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- ариун нүднээс сувдан ширхэг шиг нулимс бөмбөрүүлэн, *"Өнөөдөр миний ээж өөд болов!"* хэмээж цамцаа түүнийг ороомог кэфэн болгож, оршуулгын мөргөлийг нь үйлдүүлээд булшид нь түр хэвтсэн гэдэг. Тэгсний учрыг асууход ингэж айлдав:

"–Эбү Талибаас хойш надад энэ эмэгтэйгээс илүү сайн сайхан хийсэн өөр хэн ч үгүй! Ахиратад диваажины хувцас өмсөг гэж түүнд цамцаа кэфэн болгож өглөө. Булшдаа амархан дасахын төлөө ч түр тэнд хэвтлээ!"

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- Түүний ийм их гунигласанд гайхагсдад:

"–Тэр миний хоёр дахь эх байв. Өөрийнх нь хүүхдүүд өлсөж байхад тэр эхлээд намайг цатган, үсийг минь самнаж сарнайн тос түрхдэг байв. Тэр миний ээж байв!" хэмээн айлдав. Дараа нь түүний төлөө ингэж залбирав:

73. Ибн-и Са'д, I, 119-120, 168.
74. Ибн-и Са'д, VIII, 222.

“Аллах чамайг өргөөж буянаар шагнах болтугай! Аллах чамд рахмат хийх болтугай, ижии! Та миний хоёр дахь ээж минь билээ! Өөрөө өлөн байж, намайш цатгадаг байв! Өөрөө өмсөхгүй, надад өмсүүлдэг байв! Хамгийн амттай шимүүдийг надад амсуулна, өөрөөсөө харамладаг байв! Үүнийг гагцхуу Аллахын тааламж ба ахират орныг найдан хийдэг байв!..” (Хаким, III, 116-117; Хэйсэмий, IX, 256-257; Я’кубий, II, 14)

Хоёр дахь Шэрх-и Садр: Пайгамбарын Зүрхийг Энэрэл, Халамж ба Рахматаар Дүүргэсэн нь

Эбү Хүрэйрэ[75] -радъяллаху анх- нь Пайгамбар Эзэн маань -саллаллаху алэйхи вэ сэллэм-ээс хэний ч асуухаар зориг үзүүлээгүй зүйлсийг асуух талаар хэт зоригтой хандан, ерөөсөө татгалздаггүй байв. Нэгэн өдөр Орчлонгийн Хзндэт Эзнээс маань:

“–Аяа Расулаллах аа! Номлогч болох тухай анх харсан бэлгэ тэмдэг юу байв?” гэж асуув.

75. **Эбү Хүрэйрэ** -радъяллаху анх-ын түрүүний нэр нь Абдүшэмс байв. Мусульман болсны дараа Абдуррахман гэсэн нэр авав. Нэгэн өдөр өвөртөө нэгэн муур аваачирчээ. Түүнийг харсан Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-:
“–Тэр юу вэ?” хэмээн асуув. Эбү Хүрэйрэ:
“–Муур” гэж хариулав. Тэгсэнд нь Аллахын Элч түүнд “Муурын эцэг” гэсэн утгаар “Эбү Хүрэйрэ” гэж тоглов. Тэр өдрөөс хойш ийм нэрээрээ танигдаж, жинхэнэ нэр нь мартагдав. Өөрөө ч жинхэнэ биш Хүндэт Элчийн өгсөн энэ хочоор нь дуудахын хүсдэг байв. Эбү Хүрэйрэ -радъяллаху анх- нь хижрэтийн тооллын долоон онд Мадинад ирэв. Мэсжид-и Нэбэвийгийн буйданд унтдаг ба Асхаб-и Сүффэ гэгч ядуу мусульманчуудын нэгэн байв. Өдөр шөнөгүй Пайгамбар Эзнээс маань салдаггүй, түүнээс сонссон хадисуудыг сурахыг хичээдэг байв. Пайгамбар Эзний маань өөрөөс нь ба бусад сахабийгаас сонссоны хамт 5374 хадис-и шариф дамжуулав. Ингэж Асхаб-и кирамаас хамгийн илүү хадис дамжуулсан хүн болов. Хижрэтийн тооллын 59 онд Мадинад 78 настай байхдаа Аллахын энэрэлд хүрэв.

Хоёр хорвооны жаргалын удирдагч Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- ингэж айлдав:

"–Аяа Эбү Хүрэйрэ! Чи нэг асуусан чинь, хэлье. Би арван настай байхдаа нэгэн өдөр хөдөө явж байв. Толгой дээрээс ирсэн дуугаар цочлоо. Нэгэн хүн нөгөөхөөс асуув:

"–Энэ нь тэр мөн үү?"

Нөгөөх нь хариулав:

"–Тийм, тэр мөн."

Тэр мөч хүртэл хэнд ч хараагүй нүүр, хэнд ч олоогүй сүнс ба хэнд ч хараагүй хувцастайгаар миний өмнө гарч ирцгээв. Алхаад над руу ирсэн тэр хоёр хүнээс аль нэг нь ч нэг гараар минь барьсан ч тэдний хүрснийг би огт мэдрээгүй.

Нэгэн найздаа:

"–За, Түүнийг хэвтүүл!" гэв.

Хамтдаа намайг газар дээр хэвтүүлэв. Би ямар ч өвдөхийг мэдсэнгүй. Дахиад нэгэн нөгөөд нь:

"–За, цээжийг нь нээ!" гэсэн, тэр ч нээв. Гэтэл цус ч хараагүй, өвчин ч мэдрээгүй. Түүнд дахиад ингэж хэлэв:

"–За, тэндэх ***өшөө*** *ба* ***атаархлыг*** *гарга!"*

Тэр ч тэндээс бүлэгнэсэн цус шиг юм гаргав. Тэгээд түүнийг шидэж хаяв.

"–За, одоо түүний оронд ***халамж*** *ба* ***энэрлийг*** *оруул!" гэв. Гаргасан юмын хэмжээтэй ба мөнгөний төсөөтэй юм гаргасныг харлаа. Дараа нь баруун хөлийн эрхий хурууг минь чимхэн хөдлүүлж:*

"–За, мэнд сайхан яв!" гэв.

Намайг босч явахад миний дотор халамж ба энэрлээр дүүрэн байв. Түүнээс хойш ч байнга багачуудад халамж, ахмадуудад ч энэрэл мэдэрлээ.'' (Ахмад, V, 139; Хэйсэмий, VIII, 223)

Хазрат-и Пайгамбарын Залуу Нас

Пайгамбар Эзний маань Тэнгэрлэг Хамгаалалт Доор Өссөн нь

Аллах Таала нь Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийг пайгамбар цолоор алдаршуулах үед түүнийг мунхаглал үеийн хамаг муу муухайнаас хамгаалсан байдаг. Түүний өнчин бага ба залуу үе нь, хамгийн гялбаат ирээдүйд бэлтгэл илэрхийлэх нэгэн шилмэл ба агуу байдал дор өнгөрөв. Түүний байнгын ялгах бэлгэ шинж нь “эл-Эмин” ба “эс-Садик” болоо юм.

Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- номлохоос өмнө ч хүн чанараар аймгийнхаа хамгийн агуу, ясаараа хамгийн алдартай, ёс суртахуунаараа хамгийн сайхан нь байв. Хөршийн эрхийг хамгаас илүү чухалчилсан, үнэнчээрээ хамгийн давуу, итгэмжээрээ хамгийн тэргүүн, хүмүүст муугаар ба харгис хандахаас хамгийн хол байсан нь Тэр байв. Хэнийг ч буруушаасан, хэнтэй ч маргалдсан нь харагдаагүй юм. Ингээд Аугаа Эрх нь хамгийн гоё чадвар ба бэлгэ чанар Түүнд цугласан учир аймгийнхан нь Түүнд «эл-Эмин» хэмээн нэр өгсөн байдаг.[76]

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ээс нэгэн өдөр:

“–Аяа Расулаллах аа! Та Аллахаас бусдад хэзээ ч залбиран үйлдэв үү?” гэж асууцгаав.

76. Ибн-и Хишам, I, 191; Ибн-и Са’д, I, 121.

“–Үгүй!” хэмээн хариулав.

“–Та архи амсч үзэв үү?” гэж асууцгаав.

“–Үгүй! Би ном ба итгэл үнэмшлийг мэдээгүй байхдаа ч үйлсийн куфур буйг мэддэг байв,” хэмээн айлдав. (Диярбэкрий, I, 254-255)

Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- бага байхад Аллах Таалагийн Түүнийг яаж хамгаалсныг ингэж айлдана:

“Курайшийн хүүхдүүдийн хамт тоглож байхад нэгэн газраас чулуу зөөж байв. Хүүхдүүд изар буюу хормойгоо өргөж мөртөө тавьсан, чулууг тэрэн дээр зөөж байв. Мөрийг минь өвдөхгүйн тулд би ч тэдэн шиг хиймээр байхад, миний хараагүй нэгэн хүч намайг өвдүүлэх атгаар цохиж:

«–Хормойгоо нуруундаа уя!» гэв.

Би ч шууд хормойгоо нуруундаа уялаа. Найз нарынхаа хооронд зөвхөн би л чулууг хормой нь нуруундаа буйгаараа зөөв.” (Ибн-и Хишам, I, 197)

Орчлонгийн Хүндэт Эзэн маань Кабаг дахиад засвар болоход авга ах Аббасынхаа хамт чулуу зөөж байв. Аббас -радъяллаху анх- нь чулуу нүцгэн мөрийг нь гэмтээхгүйн тулд Аллахын Элчид:

“–Хормойгоо мөртөө тавь!” гэв. Оршигчдын Туяа нь хормойгоо мөртөө тавих гэсэндээд газар дээр унаж нүдээ тэнгэр өөд хараад авга ахдаа:

“–Надад хормойг минь үзүүл!” хэмээв. Шууд тэрийг авч дээрээ нөмрөв. (Бухарий, Нас, 42)

Тэр үеийн нийгэмд хувцасгүй явах нэлээд хэвийн үзэхээр болсон ч Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- хэзээ ч

ичгүүрийн хязгаарын гадуур үйл толилуулаагүй юм. Хадис-и шарифт ч илэрхийлснээр авга ахынхаа залснаар ийм нэгэн байдалтай тааралдсанд бол Аллах Таала Түүнийг хамгаалсан байдаг.

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- арман хоёр насны хүүхэд байхад, Түүнд Христийн Лам Бахираг:

"–Миний хүү, Лат ба Уззагийн эрхээр асууж байна, хариул!" гэхлээр нь;

"–Лат ба Уззагийн хэрээр тангараг өргөж надаас юм битгий асуу! Валлахи Би тэдгээрээс өшсөн шигээ юунаас ч өшдэггүй!" хэмээв. (Ибн-и Исхак, х. 54; Ибн-и Са'д, I, 154; Мөн хар. Ахмад, V, 362)

Үммү Эймэн -радъяллаху анха- ингэж ярина:

Курайшийн мүшрикчүүд жилд нэгэн өдөр хүндэтгэх зорилгоор Буванагийн баримлын дэргэд цуглаж, шөнө болтол тахил барих, үсээ авахуулах ба ганцаардалд орох аргаар ёслол хийдэг байв. Эбү Талиб ч уг баярын төлөө бэлдсэн байв.

Орчлонгийн Туяа тэднийг дагахаас татгалзвал авга ах ба эгч нар нь Түүнд маг их уурласныг харлаа.

Эгч нар нь:

"–Чамайг бидний бурхадаас нүүрээ буруулсан учраас нэгэн гамшигтай тааралдахаас айж байна!" гээд хэт их алгадсан юм, Орчлонгийн Хүндэт Эзэн маань тэдний хамт явахаас аргагүй болов.

Хэсэг хугацаа алга болж, дараа нь аймшгаас царай нь шарласан буйгаар буцаж бидний дэргэд ирэв.

Эгч нар нь:

“–Чи юу болоо вэ?” гэж сандран асуув.

Тэр ч:

“–Би сүм хүрэхээс айж байна!” хэмээв.

Эгч нар нь:

“–Аллах Чамайг шэйтанд автуулахгүй! Чамд бүх төрлийн сайхан шинж байдаг. Хэлчихэж мэднэ биздээ” гэцгээв.

Пайгамбар маань:

“–Намайг баримлын дэргэд дөхөх бүрт өндөр нуруутай цагаан нэгэн хүн илэрч даран:

«–Аяа Мухаммед аа! Буц, түүнд гараа бүү хүргэ!» гээд хашхирч байв!” хэмээв.

Үүнээс хойш Оршигчдын Туяа нь, Түүнд номлох үүрэг олготол тэдний баярын ёслолд огт оролцоогүй.[77]

Хазрат-и Али -радъяллаху анх-ын дамжуулснаар Хүндэт Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- Эзэн маань ингэж айлдав:

“Би мунхаглалын хүмүүсийн хийсэн нэг юмыг хоёр удаа хийхээр оролцсон байлаа. Гэтэл Аллах -аззэ вэ жэллэ- нь намайг тэднээс хамгаалж соёорхов.

Нэгэн шөнө, Маккагийн дээд хэсэгт, Курайшаас хэдэн залуусын хамт хонио бэлчээж байв. Би найздаа:

«–Хэрэв миний хонийг харвал, би ч бусад залуус шиг Маккад очоод тэдний ярианы цуглаанд оръё,» гэлээ.

Миний найз:

«–Болно, хүссэнээрээ бай!» гэв.

77. Ибн-и Са’д, I, 158.

Тэгэхлээр нь би замдаа гарлаа. Маккад очихдоо хэнгэрэг, лимбэ ба исгэрэх дуу сонсов.

«–Энэ юу вэ?» гэж асуулаа.

«– эр, эм хоёр гэрлэж байна!» гэцгээв.

Шууд суугаад тэр чигээр харж эхэллээ. Тэр хооронд Аллах -жэллэ жэлалүхү- чихэнд минь нэгэн жин тавьж би тэндхэн унтчихлаа. Аллахад тангараг өргөе, нар миний дээр мандтал сэрж чадаагүй. Шууд эргэн найзынхаа дэргэд очлоо.

«–Юу хийсэн бэ?» гэж асуув.

«–Юу ч хийгээгүй!» гээд надад юу болсны тухай ярилаа.

Өөр нэгэн шөнө, энэ явдал давтагдав. Би дахиад Маккад шөнийн ярианд очихдоо, Аллах Таалагаар миний дээр буусан хүнд жингээр нар мандтал унтлаа. Эргээд найзынхаа дэргэд очлоо.

Раббыг минь намайг пайгамбар болгож хүндэл эдгээрээс гадна ямар ч муухай зүйлд сонирхоогүй!” (Ибн-и Исхак, х. 58-59; Ибн-и Кэсир, *эл-Бидая*, II, 292)

Пайгамбар Хонь Хариулсан нь

Оршигчдын Туяа нь авга ах Эбү Талиб амьд байхад ба наймаа эхлэхээс өмнө хэсэг хугацаагаар “мал хариулсан” байв. Энэ ажил Арабчуудын хооронд энгийн үйл биш, хүндэт баян хүмүүсийн хүүхдүүдийн ч хийсэн ажил байв. Түүнчлэн тал хариулах ажлыг хамаг дайгамбарчууд хийсэн байдаг. Ингээд Аллах Таала тэдэнд мэдүүлэх ажил олгохоос өмнө удирдахад хэрэгтэй зарим шигж олгосон байдаг.

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- нэгэн өдөр:

"Аллах Таалагийн илгээсэн пайгамбар бүр нь заавал хохь хариулсан юм," хэмээн айлдав.

Тэгэхлээр нь сахабийчууд нь:

"–Та ч хонь хариулав уу, аяа Расулаллах аа?" гэж асууцгаав.

Хорвоогийн Тэргүүн -алэйхиссалатү вэссэлам- Эзэн маань:

"–Тийм, төлбөртэйгөөр нь[78] *Маккачуудын хонийг хариулдаг байлаа,"* хэмээв. (Бухарий, Ижарэ, 2, Энбия, 29; Ибн-и Мажэ, Тижарэт, 5)

Өөр нэгэн хадис-и шарифдаа ингэж айлдав:

"Муса -алэйхиссэлам- пайгамбар болж томилогдсон байв, өөрөө хонь хариулдаг байв. Давуд -алэйхиссэлам- пайгамбараар томилогдсон, Тэр ч хонь хариулдаг байв. Би ч пайгамбараар томилогдсон бөгөөд Эжядад манайхны хонийг хариулдаг байв." (Ибн-и Са'д, I, 126)

Энэрлийн Пайгамбар тэр үеэр хорь орчим настай байв.

Орчлонгийн Хүндэт -алэйхи эфдалү'с-салэват- Эзэн маань:

"Аж ахуйн хамгийн буянт аргыг баригсдаас нэгэн ч, нэгэн даваан дээр эсвэл хөндийн дотор хонио малласан хүн мөн. Тус хүн мөргөлөө үйлдэж, зэкатаа өгч, нас барах болт-

78. Хадис-и шарифад дурдсан **"Кararит"** гэсэн үгийн, Маккад нэгэн газрын нэр байсан нь гэсэн шигээ, мөнгөний нэгж буй "кират"ын олон тоо байсан нь ч илэрхийлсэн байдаг. Хоёр дахь үзлээр Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм- нь өдөр бүр хонь бүрт динарын хорины нэг буй нэгэн кират аваад Маккачуудын хонийг малласнаас үүсчээ гэж мэдээлсэн байв.

лоо Рабдаа залбиран үйлчлээд хүмүүст байнга сайн сайхныг хийнэ," (Мүслим, Имарэт, 125; Ибн-и Мажэ, Фитэн, 13) хэмээн айлдаж мал хариулахын эрдэмт ажлын нэг буйг илэрхийлэв.

Мал хариулсан хүмүүсийн бодох хязгаар, хүндэт зан ба энэрлийн мэдрэмж хөгжинө. Аллахын Элч үүнийг зааж:

"Чимээгүйдэл ба хүндэт зан хонь хариулагчдын хамт юм," хэмээв. (Бухарий, Мэнакиб, 1; Мүслим, Иман, 84/52)

Хонийг залаад зэрлэг араатнаас хамгаалахыг хичээх нь хүнд тэвчээр ба эзэн болох мэдрэмжийг хөгжөөнө. Жишээлбэл хамаг оршигчид энэрэл үзүүлэх, тэдний бүдүүлэг ба ойлголтгүй байдлыг тэсэх нь пайгамбарчуудад байх шаардлагатай хамгийн гол шинж мөн.

Авга Ах нарынхаа Хамт Аялсан нь

Оршигчийн Туяа нь арван хоёр настайдаа наймаа хийхээр анх Эбү Талибын хамт Сирид очив. Хоёр дахь аялалаа арван зургаатай байхад Йеменд хийв.

Курайшчууд Дамаскад очихоор бэлдэж байв. Эбү Талиб ч энэ жингийн хамт явмаар байв. Замд гарах болсонд нь хамаг дүү нар нь Эбү Талибыг үдэхээр ирэв. Эбү Талиб хайрт ачаасаа:

"–Чи ч надтай хамт явна уу?" гэж асуув.

Авга ах-эгч нар нь Пайгамбар Эзний маань нас бага учраас өвдөж мэдэхийг нь илэрхийлж эсэргүүцэв. Эбү Талиб Түүнийг Маккад орхихоор шийдвэл, Пайгамбар Эзэн маань гуньж уйлав.

Эбү Талиб:

“–Аяа дүүгийн хүү! Яасан? Чамайг аваачихгүй учраас уйлж байна уу?” гэж асуув.

Хоёр Хорвоогийн Нар Эзэн маань түүний тэмээний ногтыг барьж:

“–Ахай, намайг хэнд орхиж байна вэ? Надад аав ч ээж ч үгүй!” хэмээв.

Эбү Талиб уяран:

“–Валлахи Чамайг ч авч явна! Чи надаас би ч Чамаас хэзээ ч салалцахгүй!” гэв. (Ибн-и Исхак, х. 53; Эбү Нуайм, *Дэлаил,* I, 168)

Дараа нь Орчлонгуудын Эзэн арван зургаатай байхдаа авга ах Зүбэйрийнхээ хамт Йеменд очив. Зүбэйр нь Оршигчийн Туяаны элбэгийг ашигламаар байв. Ийм учраас Эбү Талибаас ариун дүүгээ түүний хамт илгээхийг гуйв.[79]

Наймааны жингийн зам нэгэн хөндийд учрахад, догшир- сон нэгэн ат нь хэнийг ч тэндээс явахыг зөвшөөрөхгүй байв. Хамт олны буцахыг бодож байсанд Орчлонгуудын Эзэн:

“–Түүнийг надад үлдээ!” хэмээж хамт олны өмнө гарав.

Ууртай тэмээ нь Пайгамбар Эзнийг маань харангаа тайв- шрав.

Орчлонгийн Хүндэт Эзэн маань өөрийнх тэмээнээс бууж түүнийг унав. Хөндийг гаталсны дараа түүнийг орхиж өгөв.

Аялалаас буцахад бол үер автсан нэгэн хөндийн тааралда- ад гаталж чадаагүй. Пайгамбар Эзэн маань:

79. Диярбэкрий, I, 260.

“–Та намайг дагаад ирцгээ!” гэв. Хамт олон Түүний араас явж эсэн мэнд гатлав. Бодвол Аллах Таала тэндэх усыг хатааж зам болгосон байв. (Ибн-и Кэсир, *эл-Бидая*, II, 282)

Лам Бахиратай Учирсан нь ба Бахирагийн Шннжээ

Эбү Талиб нь Курайшийн ахмадуудаас хэсэг хүмүүстэй Дамаскад очсон байв. Пайгамбар Эзэн ч түүнтэй хамт байв. Замдаа Лам Бахирагийн сүмд ойрхон нэг газар хонов. Бахира тэр үеийн христчүүдийн хамгийн эрдэмтэй нь байв.

Бахира нь жинг дөхөж байхад нэгэн үүл тэдний хооронд нэгийг сүүдэрлэж, модны сүүдэрт буухлаар нь ч дахиад ижил хүн дээр цухуйсныг харсан байв. Тэгэхлээр нь:

“–Аяа Курайшийнхан! Би таны төлөө хоол хийв. Бага-том, боол-чөлөөт та бүхнийг ширээнд урья!” гэж жинд мэдээ илгээв.

Үнэндээ бол Бахира тэдний өмнөх ирсэнд дэргэд нь огт очдоггүй, тэднийг сонирхдоггүй байв. Жингийнхэн бүгд хоолонд очсон, зөвхөн Орчлонгийн Хүндэт Эзэн маань барааны дэргэд байж байв. Бахира ирэгсдийг нэг нэгээр ширтэж, номд уншсан шинжийг аль нэгэнд ч хараагүй.

“–Аяа Курайшчууд аа! Танай жинчдээс энд ирээгүй хэн нэгэн бий юү?” гэж асуув.

Курайшийнхан:

“–Аяа Бахира! Хойн нэгэн хүүхдээс гадна хэн ч үлдээгүй. Насаараа хамгийн залуу маань байсан тул Түүнийг барааны дэргэд орхилоо,” гэцгээв.

Бахира:

“–Түүнийг ч дуудаарай! Энэ хоолонд тэр ч байг!” гэв.

Мухаммедү’л-Эминийг авчирч ширээнд суулгав. Лам нь Түүнийг үзмэгцээ анхааралтай хараад дээрээс доош шинжилж эхлэв. Дараа нь гарыг нь барьж:

“–Энэ нь Орчлонгуудын Эзэн мөн. Энэ нь Орчлонгуудын Раббын Элч мөн. Аллах Түүнийг орчлонгуудад энэрэл болгож томилно!” гэв.

Курайшийн ахмдууд түүнээс:

“–Хаанаас мэдээ вэ?” гэж асуув.

Лам:

“–Би Түүний бэлгэ тэмдгийг бидэнд буулгасан судраас уншлаа. Тэгээд таныг дөхөж байхад, Түүний төлөө бөхийсөнгүй чулуу ч мод ч үлдээгүй, бүгд нь мөргөв. Уг амьгүй зүйлс зөвхөн нэгэн пайгамбарт мөргөнө. Би Түүнийг пайгамбарын тамгаар л таньсан, уг тамга хоёр далны хооронд байна,” гэв.

Бахира нь Пайгамбар Эзнээс маань болон авга ахаас нь зарим зүйлс асууж, авсан хариулт нь мэдсэнтэйгээ таарсныг харангаа лав шийдвэр гаргав. Эбү Талиб руу эргэн:

“–Ач дүүгээ даруй нутагтаа аваач! Еврейчүүд түүнд гэмт учруулахаас хамгаал! Валлахи еврейчүүл Түүнийг харж тахивал, заавал алахаар оролдоно. Энэ хүүхэд Арабчуудаас юм. Гэтэл еврейчүүд ирэх пайгамбар Исраилынхнаас болохыг хүсдэг. Чиний ачийн байдал ба алдар маш агуу байх болно,” гэв.

Эбү Талиб ч Бахирагийн саналын дагуу ариун ачийгаа хажуудаа аваад шууд Маккад харив. (Ибн-и Исхак, х. 54-55; Ибн-и Са’д, I, 153-155; Тирмизий, Мэнакиб, 3)

Христийн үгүйсгэгчид ийм явлаас болж Исламд толбо үлдээх зорилгоор Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн Лам Бахирагаас зарим санаа авсныг санал болгоод байдаг. Энэ бол бүрэн үнэн бусын нэгэн буруушаал юм. Кур'ан ба тэвхид дүрмийн эсрэг юм. Учир нь Бахира христийн лам байв. Кур'ан-и Кэрим нь эвдсэн буй Тэврат ба Инжилийг зассаар байхад, Аллахын Элчний ийм эвдэрхий нэгэн шашны төлөөлөгчөөс ухаан авсныг яаж бодож чадах вэ?!

Нөгөө талаас Бахирагийн шашин асан Христийн шашинд Аллах гэсэн ойлголт нь антропоморфик буюу хүний шинжээр төхөөрсөн тусгай бүтэц толилуулдаг. Гэтэл Аллахын Элч -алэйхиссалатү вэссэлам-ын авчирсан Ислам шашин нь тэвхид суурь дээр Аллахаар илгээсэн тод нэгэн шашин мөн. Аллах гэсэн ойлголт нь мүтэал буюу ухааны цааш бөгөөд хамаг дутагдлаас арилсан байдал эзэмшдэг.

Уг үнэний улмаас Кур'ан-и Кэрим нь эхл-и китабаас, манай пайгамбарын үүнээс өмнө байсан ч зөвхөн тэнгэрлэг чиглэл дээр байгсдын авралтад хүрч мэдэхийг ингэж мэдээлнэ:

اِنَّ الَّذٖينَ اٰمَنُوا وَالَّذٖينَ هَادُوا وَالنَّصَارٰى وَالصَّابِئٖينَ مَنْ اٰمَنَ بِاللّٰهِ وَالْيَوْمِ الْاٰخِرِ وَعَمِلَ صَالِحًا فَلَهُمْ اَجْرُهُمْ عِنْدَ رَبِّهِمْ وَلَا خَوْفٌ عَلَيْهِمْ وَلَا هُمْ يَحْزَنُونَ

Гарцаагүй итгэн үнэмшигчид, еврейчүүд, христчүүд ба сабиичууд(аас) **Аллах болон ахират өдөрт итгэж сайхан үйл хийгчдэд айх юм байдаггүй ба тэд бас гуниглахгүй.”** (эл-Бакара, 62)

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- нь хамаг үе ба орны хамгийн сүүлийн пайгамбар болж томилогдсон учраас,

Түүнээс өмнөх хамаг шашнууд цуцалсан буюу хүчингүй болсон байдаг. Тийм учраас Аллахад итгэн үнэмшиж Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм-д итгэхгүй байх нь күфүр юм. Иим л учраас өнөөдрийн эхл-и китабын итгэгчид ч дээрх аетын агуулгын гадна юм.

Дүрмийн дараа шашинд тулгуурлах бусад зүйлс нь залбирал үйлчилгээний амьдрал болон нийгмийн үйлс юм. Ислам шашин эмх цэгцтэй залбирал үйлчилгээний амьдрал оруулсан, хүмүүсийн хоорондын харилцааг (муамэлат буюу нийгмийн үйлс) эрх, хууль ба ёс суртахууны суурь дээр дахин байгуулж ялын шийдвэрийг ч агуулсан нэгэн хууль сургасан байдаг. Бахирагийн шашин асан Христэд бол залбирал үйлчилгээний амьдрал эвдсэн байдаг. Муамэлат ба ялууд бол огт үгүй.

Өөр нэгэн сэдэв, Пайгамбар Эзэн маань Кур’аны мэдээлсэн ба түүх ч гэрчилснээр **“үммий”** буюу уншиж бичиж мэддэггүй байв. Ает-и кэримэчүүд ингэж айлдана:

وَمَا كُنْتَ تَتْلُوا مِنْ قَبْلِهِ مِنْ كِتَابٍ وَلَا تَخُطُّهُ بِيَمِينِكَ اِذًا
لَارْتَابَ الْمُبْطِلُونَ بَلْ هُوَ اٰيَاتٌ بَيِّنَاتٌ فِي صُدُورِ الَّذِينَ اُوتُوا
الْعِلْمَ وَمَا يَجْحَدُ بِاٰيَاتِنَآ اِلَّا الظَّالِمُونَ

“Чи үүнээс өмнө нэгэн бичиг ч уншдаггүй, эсвэл түүнийг гараараа ч бичдэггүй байв. Тийм байсансан бол мунхагийг дагагчид сэжиглэхсэн. Үгүй, тэр Кур’анд өөрт нь ухаан өгөгдсөн хүмүүсийн цээжилсэн аетууд мөн. Аетуудыг маань зөвхөн харгисчууд л үгүйсгэнэ.” (эл-Анкэбүт, 48-49)

Орчлонгийн Хүндэт -саллаллаху алэйхи вэ сэллэм- нь Лам Бахиратай уулзсандаа арван хоёр настай байв. Бахирагийн дэргэд маш богино хугацаагаар байж, маш богино уулзалт хийсэн байв. Ийм байхад үммий нэгэн хүүхдийн зургаан мянга гаруй аетыг богино хугацаанд цээжилж хорин найман жил ухаандаа хадгалах ба дөчин наснаасаа хойш гэнэтхэн эдээрийг санаад ярьж эхлэх нь боломжгүй юм. Дахиад ийм л нөхцөл доор Ислам шиг төгс төгөлдөр ба түгээмэл шашныг сурч тэр шашны залбирал, нийгмийн харилцаа, ялын шийдвэр болон ёс суртахууны эмх цэгцтэй байдлыг илрүүлэх нь боломжгүй буйг эрүүл хамаг ухаан маш амархан ойлгож хүлээн зөвшөөрөх юм.

Хэрэв Бахира уг үнэнийг мэдэж байсан бол, яагаад өөрөө зарлаагүй ба уг нэр алдрыг нэгэн хүүхдэд, түүнчлэн огт таньсангүй нэгэн хүүхдэд орхио вэ?!

Түүнчлэн Бахирагийн уншиж байсан хэл нь Еврей, Кур'ан-и Кэрим бол ил ба ойлгомжтой Араб хэл юм. Аллах Таала ийнхүү саналын тухай ингэж айлдана:

وَلَقَدْ نَعْلَمُ أَنَّهُمْ يَقُولُونَ إِنَّمَا يُعَلِّمُهُ بَشَرٌ لِّسَانُ الَّذِي يُلْحِدُونَ
إِلَيْهِ أَعْجَمِيٌّ وَهَـٰذَا لِسَانٌ عَرَبِيٌّ مُّبِينٌ

"Бид кафирчуудын: «Кур'аныг Мухаммедад хүн сургана,» гэснийг мэднэ. Энэ үндэсгүй саналыг илэрхийлэхдээ заасан хүн гадаад хэлтэй юм. Энэ Кур'ан бол цэвэр Араб хэлтэй юм." (эн-Нахл, 103)

Мөн түүнчлэн Кур'ан нь уг хэлний давуу талаараа Арабчуудын хамгийн хүчтэй шүлэгчдийг, түүнчлэн хамаг хорвоог халз тулалдаанд дуудах чинээ дээд төвшинд байдаг. Жишээлбэл Исра Сурагийн 88-р аетад:

قُل لَّئِنِ اجْتَمَعَتِ الإِنسُ وَالْجِنُّ عَلَى أَن يَأْتُواْ بِمِثْلِ هَذَا الْقُرْآنِ
لاَ يَأْتُونَ بِمِثْلِهِ وَلَوْ كَانَ بَعْضُهُمْ لِبَعْضٍ ظَهِيراً

“Ингэж хэл: Хүмүүс ба дуганууд бие биедээ туслаад энэ Кур’аны нэг төсөөтийг бүтээхээр цугласан ч, Тангараг өргөе, яасан ч нэг төсөөтийг нь бүрдэж чадахгүй,” хэмээн айлдана.

Мөн, Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн Бахиратай уулзахад тэдний дэргэд олон Курайш хүн ч байв. Хэрэв үгүйсгэгчдийн саналд өчүүхэн ч гэмээр үнэн байсан-сан бол, номлохын анхны өдрөөс эхлэн амь насаа Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийг үгүйсгэх ба Түүнд өстөн болоход зориулсан мүшрикчүүдийн явдлыг илэрхий-лэн эсэргүүцэх нь хэрэгтэй болох байв. Гэтэл Курайшийн мүшрикчүүд энэ тухай ганц үг ч хэлээгүй байдаг. Учир нь тэд ийм санал ямар ч үндэсгүй буйг маш сайн мэддэг байв.

Хилфү’л-Фүдүүл

Харам саруудад хийсэн дайныг Арабчууд “Фижаар Дайн” гэдэг байв. Фижаар дайн нь дөрвөн удаа болов. Курайш Кинанэ хоёр аймаг ба Хэвазины хооронд бий болсон дарав дэх Фижаар дайнд Пайгамбар Эзэн маань -алэйхиссалатү вэссэлам- ч орол-дов.

Тэр байнга зөв ба зүйтийн дэргэд болсон мөн. Энэ дайнд хорь орчим настай байхдаа авга ах нарын хамт оролдсон, гэтэл хэний цусыг ч асгаагүй юм. Зөвхөн дайсны эгнээнээс харвасан сумыг цуглуулж авга ах нартаа өгөв.[80]

80. Ибн-и Хишам, I, 198; Ибн-и Са’д, I, 126-128.

Энэ дайнаас буцсаны дараа, харам сарын нэг буй Зилкадэ сард, Зүбэйд аймгаас нэгэн Йемен хүн, худалдаж зарахаар Маккад бараа авчирсан байв. Курайшийг хүндэт ноёдоос Ас бин Ваил энэ барааг худалдан авч, харин мөнгийг нь төлөөгүй. Тэр хүн, Абдуддар, Махзум, Жумах, Сэхм, Адий бин Ка'бынхан мэтийн Маккагийн алдартай айлуудад очоод тусламж гуйв. Гэтэл тэд энэ хуурагдсан хүнд туслахын оронд, Ас бин Ваилыг хамгаалан тэр хүнийг загнав.

Аргагүй үйлсэн хүн Курайшийн алдартнуудыг Кабагийн эргэн тойронд сууж байхад Эбү Күбэйс ууланд гарч; "Аяа Фихрийн Ураг!" гэж хашхираад шүлэг уншив. Учирсан харгислал ба ёсгүй байдлыг зарлан тусламж нэхэв. Туслахаар анх хөдөлсөн нь Пайгамбар Эзний маань авга ах Зүбэйр болов. Курайшаас алдартнуудын хамт Абдуллах бин Жүд'аны гэрт цуглав.

Абдуллах тэдэнд хоол дайлав. Дараа нь "хэн ч хамаагүй, Маккад харгислалтай уулзсан хүний эрхийг буцааж автал харгисын эсрэг хүчгүйг хамгаалах" зорилгоор ам өгөцгөөв. Далай тэнгист нэгэн хялгасыг ус болгож, Хира ба Сэбир уул нь байрандаа байхад амласандаа үнэнч байхдаа тагараг өргөцгөөв.

Хилфү'л-Фүдүүл Холбоо нэгдүгээрт нь Ас бин Ваилаас Зүбэйд хүний эрхийг аваад ажиллаж эхлэв. Дараа ч Маккад харгислал ба ёсгүй байдалтай тааралдсан олон хүний тусламжид гүйж, эрх тэгшийг хангахаар хичээв.[81]

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн мунхаглалын эринд баталж элссэн ганцхан холбоо нь "Хилфү'л-Фүдүүл" юм. Учир нь энэ нь эрх тэгшийн холбоо байв. Харгис ба ёсгүй байдалд саад хийхээр байгуулсан байв. Пайгамбар Эзэн маань

81. Ибн-и Кэсир, *эл-Бидая,* II, 295-296; Ибн-и Са'д, I, 128-129.

-саллаллаху алэйхи вэ сэллэм- уг холбооны тухай номлож эхэлсний дараа ингэж айлдав:

“Абдуллах Бин Жүд’аны гэрт авга ахынхаа хамт, Хилфү’л-Фүдүүлд бэлэн байлаа. Тэр цуглалд би маш их таатай байсан, түүний хариуд надад улаан тэмээ (буюу дэлхийн хамгийн үнэт бараа) өгсөн ч, тэр чинээ баясахгүй байв. Тийм гэрээнд намайг одоо дуудвал, дахиад очно.” (Ибн-и Кэсир, *эл-Бидая,* II, 295)

Расулаллах Эзэн Худалдаа Хийсэн нь

Маккагийнхаан амьдралаа худалдаа хийгээд авч явдаг байв. Наймааны жингээр хөрш орнуудаас авчирсан барааг Маккад зохион байгуулсан яармагт зарч, Маккад үйлдвэрлэсэн барааг хөрш орнуудад аваачдаг байв.

Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- залуудаа авга ах нарын хамт наймааны жинд оролцож, Сири ба Йеменээр аялсан байв. Дараа жилүүдэд, Хазрат-и Хатижагийн өмнөөс Йемений Жүрэш захад хоёр удаа наймааны аялал хийсэн, аялал бүрт Түүнд хөлс болж залуу нэгэн буур өгсөн байв.[82]

Оршигчийн Туяа нь Хазрат-и Хатижагийн наймааны жинг Тихамэ дахь Хубаша захад ч аваачсан байв. Энэ аялалд Хатижа -радъяллаху анха-гийн үйлчлэгч Мэйсэрэгийн хамт гарсан, тэндээс Тихамэгийн давуу авчраад Хаким бин Хизамд зарж элбэг мөнгө олсон байв.

Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-:

“Би Хатижагаас буянтай тунш хараагүй,” гээд түүнийг магтсан, хийсэн ажлын хариуг ихээр амссанаа илэрхийлсэн байдаг. (Халэбий, I, 221; Айний, X, 104)

82. Хаким, III, 200/4834.

Авга ах Эбү Талиб нэгэн өдөр Пайгамбар Эзэнд маань:

"–Аяа минйи дүүгийн хүү! Би ядуу хүн. Энэ жилийн ган бидэнд хөрөнгө ч наймаа ч үлдээгээгүй! Наймааны нэгэн жин Дамаск руу явахаар бэлдэж байна. Хатижа бинт-и Хүвэйлид ч энэ жингээр бараагаа аваачих нэгийг хайж гэнэ. Тэр Чам шиг итгэмжтэй, цэвэр ба үнэнч хүний хэрэгцээтэй. Чамайг наймаанд төлөөлөгч болгоход нь түүнтэй ярилцвал сайн. Чамайг үнэнч хүн учраас бусдад илүү үзэхийг нь бодож байна. Үнэндээ Дамаскын тийш явахыг чинь би хүсэхгүй байв. Еврейчүүд чамд нэгэн аюул хүргэхээс айж байна. Гэтэл өөр арга ч үгүй!" гэв.

Оршигчийн Туяашийг авга ахтай хийсэн яриа Хазрат-и Хатижад хүрэхлээр:

"–Би Мухаммедын үүнийг хүсэхийг мэдэхгүй байлаа!" гэв. Шууд Орчлонгуудын Эзэнд мэдээ илгээж, бусдад өгснөөс илүү төлбөрөөр наймааны барааг нь Дамаскад аваачихыг санал болгов.

Учир нь Хазрат-и Хатижа нь Эзэн маань -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийг хэт итгэмжтэй, үнэнч ба сайхан ёс суртахуунтай хүн байсныг маш сайн мэдэж байв.[83]

Авралтын Туяа Эзэн маань -саллаллаху алэйхи вэ сэллэм- нь Хатижагийн туслах Мэйсэрэгийн хамт Маккагаас замд гарав. Хазрат-и Хатижа Мэйсэрэд:

"–Мухаммедад юу байсан ч бүү эсэргүүц! Юу хэлсэн ч бүү үгүйсгэ!" гэж сануулав.

Замдаа бараа ачсан тэмээнээс хоёр нь ядарч хоцроход Мэйсэрэ тэмээнд санаа зовов. Орчлонгийн Хүндэт Эзний маань дэргэд хүрч байдлыг мэдүүлэв. Хорвоогийн Тэргүүн Эзэн маань

83. Ибн-и Хишам, I, 203; Ибн-и Са'д, I, 129; Ибн-и Кэсир, *эл-Бидая*, II, 297.

гараа тэмээний хөл дээр тавьж илсний дараа хоёр тэмээний хөл хөнгөрөн, сүргийн эхэнд одов. Хүмүүс ч үүнийг хараад Эзний маань үйлчилгээ ба хамгаалалтанд илүү анхаарал тавив.[84]

Элчдийн Султан -алэйхи экмэлү'т-тэхаяа- Эзэн маань амьдралынхаа турш наймааны ажлын хариуцагчдаа ба бусдад хэт шударга хандсан байдаг. Нэг нэгэнд ам өгвөл тэрийг юу болсон ч хэрэгжсэн байдаг.

Ибн-и Аббас -радъяллаху анхүма- нь Эзний маань амьдралыг хамгийн нарийн зүйл хүртэл нь мэдсэн хүн болохоороо ингэж хэлдэг:

"–Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- нэг юм хэлбэл тэрийг заавал хийдэг байв." (Бухарий, Шэхадат, 28)

Саиб бин Эби'с-Саиб -радъяллаху анх- ч ингэж ярьдаг:

"Аллахын Элчийн дэргэд орлоо. Асхаб-и кирам намайг магтаж миний тухай сайхан юм хэлж эхлэв. Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-:

«–Би түүнийг танаас сайн танина!» хэмээв.

Тэгээд би ч:

«–Зөв хэллээ, эцэг эх минь Чамд золиос болог. Чи миний түнш байв, маш сайн түнш. Эсэргүүцээ ч үгүй, маргалдаа ч үгүй,» гэлээ." (Эбү Давуд, Эдэб, 17/4836; Ибн-и Мажэ, Тижарат, 63)

Түүнд эл-Эмин ба эс-Садик хэмээн тэмдэг нэрийг олгосон олон үлгэр жишээнээс нэгийг Абдуллах бин Эби'л-Хамса -радъяллаху анх- ингэж ярина:

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-тэй нэгэн наймаа хийсэн байлаа. Түүнд өртэй болсон, түр хүлээвэл шууд авчра-

84. Диярбэкрий, I, 262.

хаа амлаж тэндээс саллаа. Гэтэл амалснаа мартжээ. Гурван хоногийн дараа санаад ярьсан газар очвол, Түүнийг нөгөө газар хүлээж байхад оллоо.

Итгэл ба үнэнчийн хүршгүй оргилд байсан Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- нь намайг загналгүй зөвхөн:

«–Аяа залуу! Намайг аварлаа шүү, гурван хоног болж энд чамайг хүлээж байна,» хэмээв." (Эбү Давуд, Эдэб, 82/4996)

Түүний арай номлох үүрэг олгохоос өмнө толилуулсан энэ ба төсөөт шинжүүд нэг нэгнээс гоё, сургамжтай ба эрдэмтэй байдаг. Угаасаа эдгээр пайгамбар болох хүнд л илэрч мэдэх байв.

Аллах Таала хүссэнсэн бол багаас нь аж ахуйн араас гүйлгүй тансаг амьдрал олгох байв. Гэтэл тэнгэрлэг нууц учир, Аллахын Элчний амьдралаа өөрийнхөө гараар олж үммэтдээ үлгэр жишээ болохыг нь хүссэн байв. Жишээлбэл Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм- Эзэн маань ч:

"Хэн нэгэн өөрийнхөө олсноос буянтай юм хэзээ ч идээгүй байдаг..." хэмээн айлдав. (Бухарий, Бүюү' 15; Энбияа 37)

Мөн, хүмүүст удирдамж болох хэн нэгэн аж ахуйгаа эргэн тойрны өгөх хандив ба бэлэгт холбосон хугацаанд, учрынх нь хүмүүсийн хооронд ямар ч үнэ цэнэ, хүнд ба чухал тал нь үлдэхгүй. Жишээлбэл Аугаа Эрх хамаг пайгамбар нартаа:

وَمَا أَسْأَلُكُمْ عَلَيْهِ مِنْ أَجْرٍ إِنْ أَجْرِيَ إِلَّا عَلَى رَبِّ الْعَالَمِينَ

"Би мэдээлэхийн хариуд танаас ямар ч төлбөр нэхэхгүй. Миний төлбөрийг Орчлонгуудын Раб л хинэ," (эш-Шуара, 109, 127, 145, 164, 180. Мөн хар. Юунус, 72; Хүд, 29) гэхийг тушаав.

Шүлэгч нь энэ нарийн учрыг маш сайхан илэрхийлэв:

Хэний ч ивээлээс битгий нэх,
Үнэ нь эрх чөлөөний эрдэнэ мөн!

Эрхэм Хайрт -саллаллаху алэйхи вэ сэллэм- өөрийнхөө олсноор амьдралаа авч явсан учраас хүмүүсийн хамгийн чөлөөт нь болов.

Лам Настурагийн Тогтоосон нь

Хазрат-и Пайгамбар бүхий наймааны жин Дамаскын ойролцоо Бусрад хүрсэн байв. Эзэн маань -саллаллаху алэйхи вэ сэллэм- Бусрагийн захад Лам Настурагийн хийдэд ойрхон нэгэн чидун модны доор буув. Мэйсэрэтэй өмнө нь танилцсан Лам Настура нь Пайгамбар Эзнийг маань зааж:

“–Аяа Мэйсэрэ! Тэр модон доорх хүн хэн бэ?” гэв асуув.

Мэйсэрэ:

“–Тэр Курайш аймгаас нэг хүн юм!” гэв.

Лам:

“–Нүд нь жаахан улаан бий юү?” гэж асуув.

Мэйсэрэ:

“–Тийм, нүд нь байнга улаан байдаг!” гэв.

Настура:

“–Тэр мөн, пайгамбарчуудын сүүлийнх юм! Би Түүний номлохоор томилогдох үед хүрэхийг хүсч байна!” гэв. (Ибн-и Са’д, I, 130-156; Ибн-и Кэсир, *эл-Бидая*, II, 297-298)

Жин нь Макка руу буцахаар Бусрагаас салав. Мэйсэрэ хэт халуун үед хоёр мэлэк Пайгамбар Эзнийг маань сүүдэрлэснийг гэрчлэв. Эцэст нь их ашиг олзтой Маккад буцав.[85]

Хазрат-и Хатижатай Гэрлэсэн нь

Мэйсэрэ Дамаск аялалд харсан ер бусын олон явдлыг, Пайгамбар Эзний маань төрх ба зангийн гоо сайхан болон ер бусын байдлыг буцсахдаа Хазрат-и Хатижад дэлгэрэнгүй ярив. Тэгэхлээр нь Хатижа эхэд маань Орчлонгийн Эзэнтэй гэрлэх хүсэл төрөв.

Хазрат-и Хатижагийн хайз Нэфисэ бинт-и Үмэйе энэ гэрлэлтийн тухай ингэж ярина:

“Хатижа бинт-и Хүвэйлид авьяастай, хичээнгүй, бат зантай ба нэр хүндтэй эмэгтэй байв. Аймгийнхаа эрчүүд түүнтэй гэрлэхийг улиглан хүсч байв. Гэтэл Хазрат-и Хатижа нь Орчлонгийн Хүндэт -саллаллаху алэйхи вэ сэллэм- Эзний маань ааш занг таалав. Хазрат-и Мухаммед -алэйхиссэлам-ыг Дамаскын наймаанаас буцсаны дараа Хатижа нь, гэрлэх санаа байх эсэхийг ойлгох зорилгоор намайг түүнд илгээв:

«–Аяа Мухаммед! Чи яагаад гэрлэхгүй байна вэ?» гэж асуулаа.

«–Эдийн засгийн талаар нөхцөлгүй байхдаа яаж гэрлэх вэ?» хэмээв.

«–Хэрэв боломжтой болбол бараа, алдар ба гоо сайхантай нэгэнтэй гэрлэх үү?» гэж асуулаа.

«–Энэ эмэгтэй нь хэн бэ?» хэмээв.

85. Ибн-и Са’д, I, 130, 156-157.

«–Хатижа!» гэлээ.

«–Чиний бодлоор энэ нь боломжтой юу?» хэмээв.

«–Тэрийг надад орхи!» гэлээ.

«–Тэгвэл би ч чиний хэлснээр байх болно!» хэмээв.

Шууд очоод үүнийг Хатижад мэдээллээ.” (Ибн-и Са’д, I, 131)

Хазрат-и Хатижа нь Нэфисэ Хатаны мэдээний дагуу Эрхэм Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- Эзэнд гэрлэхийг санал болгов. Орчлонгуудын Эзэн энэ тухай авга ах Эбү Талибд мэдээлэв. Эбү Талиб нь Хазрат-и Хатижагийн авга ах Амр бин Эсэд дээр очоод худ болов.

Эбү Талиб ба Хазрат-и Хатижагийн авга ахын хүү Варака бин Нэвфэл харилцан гэрлэлтийн үг хэлэв. Дараа нь Хазрат-и Хатижагийн авга ах Амр босч:

“–Аяа Курайшийн хамт олон! Гэрч болцгоо, би Хатижа бинт-и Хүвэйлидийг Мухаммед бин Абдуллахад никах хийлээ!” гэв.[86]

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- Хазрат-и Хатижад мэхир болгож 20 залуу тэмээ өгөв.[87]

Оршигчийн Туяа нь гэрлэхдээ 25 орчим настай байв. Аз жаргалтай язгуурт эмэгтэй Хазрат-и Хатижа бол Оршигчийн Туяанаас арван тав эгч ба бэлбэсэн байв.

Хазрат-и Хатижа эх маань хөрөнгөөрөө Пайгамбар Эзэнд маань хүчний шинэ нэгэн эх болов.

86. Диярбэкрий, I, 264; Я’кубий, II, 20.
87. Ибн-и Хишам, I, 206; Ибн-и Эсир, *Усдү’л-Габэ,* I, 23.

Цуутай нэгэн айлын гишүүн асан Хазрат-и Хатижад агуу ёс суртахуунаас нь болж Исламаас өмнө "Афифа" ба "Тахира", Исламын дараа ч "Хитижатү'л-Күбра" гэсэн байдаг.[88]

Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-:

"Ахиратын хамгийн буянт эмэгтэй нь Мэрьем бинт-и Имран мөн. Дэлхийн хамгийн буянтай эмэгтэй бол Хатижа бинт-и Хүвэйлид мөн," хэмээн айлдав. (Бухарий, Мэнакибu'l-Энсар, 20; Мүслим, Фэдаилү'с-Сахаба, 69)

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн уг гэрлэлт Түүний махбодийн хүслэнд эрмэлзсэн хүн байгаагүйг, түүнчлэн эдгээрийг огт үнэлээгүйг илрүүлнэ. Хэрэв тийм байсансан бол, Аллахын Элчний өөрөөсөө насаараа эгч бэлбэсэн ба хүүхэдтэй эмэгтэйтэй биш, залуухан хэн нэгэнтэй гэрлэх байв. Гэтэл Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- гэрлэх эмэгтэйд залуу нас, гоо сайхан мэтийн түр зуурын шинжээс байтугай; нэр алдар, эрдэм ба сайхан ёс суртахуун мэтийн агуу бэлгэ шинж эрэв.

Аллахын Элч Олон эхнэр авдгийн Нууц Учир нь

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- зөвхөн тавин таван наснаас хойш нэгээс илүү хатантай гэрлэв. Түүний аль нэгэн гэрлэлт нь олон ил ба нууц учиртай байдаг. Аугаа Эрхийн:

لَقَدْ كَانَ لَكُمْ فِي رَسُولِ اللّٰهِ اُسْوَةٌ حَسَنَةٌ لِمَنْ كَانَ يَرْجُوا اللّٰهَ
وَالْيَوْمَ الْاٰخِرَ وَذَكَرَ اللّٰهَ كَث۪يرًا

88. Ибн-и Са'д, VIII, 14-15.

“Тангараг өргөе, Расулаллахад таны төлөө; Аллах ба ахират өдөрт учрахыг найдагсад ба Аллахыг ихээр дурдагсдын төлөө нэгэн үсвэ-и хасэнэ (хамгийн гоё үлгэр жишээ) **байдаг,”** (эл-Ахзаб, 21) айлдаж хүн төрөлхтөнд үлгэр жишээ зан болгож дайлсан нэгэн хүний тухай муухай санал зөөх ба түүнчлэн гүтгэх нь, зөвхөн шашны үнэнийг мэдээгүй байх ба мунхаглалаас цааш муухай зорилготой байхын бэлгэ тэмдэг юм.

Учир нь манай Раб бидэнд Хайрт Пайгамбарыг маань бүх талаар үлгэр жишээ болгов. Эдгээрээс хамгийн тэргүүн ба хамгийн чухал нь гэр бүлийн амьдрал юм. Бид энд Пайгамбарын маань гэрлэлтийн тухай нь бидний хязгаарыг давах бөгөөд, бидний үг хэл ч үүнд хүрэхгүй юм. Харин гэрлэлтүүдийн тодорхой бэлгэ учир утгыг ярих нь зөв санал болж мэдэх байх.

Хүнд махбодийн хүслэн хамгийн ид оргилох үе нь, мэдээж залуу насны үе юм. Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- Эзний маань залуу насыг санавал, Түүний тухай хэлэхүйц ганцхан үг; Тэр үнэхээр даруу төлөв цэвэр ичимтгий нэгэн мөн. Үүнийг Маккачуудын Түүнд өгсөн **“эл-Эмин”** нэгээс амархан ойлгох боломжтой. Дахиад мүдрикчүүд нь Пайгамбар болсноо зарласнаас өөд болтол нь хэзээ ч Аллахын Элчийн тухай ийм муухай нэгэн гүтгэлэг хэлээгүй юм.

Пайгамбар Эзэн маань -саллаллаху алэйхи вэ сэллэм- Маккагийн эринд хоёр удаа гэрлэв. Хазрат-и Хатижатай анх гэрлэхдээ Пайгамбар маань 25 настай, Хазрат-и Хатижа 40 настай, бэлбэсэн ба хүүхэдтэй эмэгтэй байв. Хатижа эхийг маань өөд болтол яг хорин таван жил явсан уг гэрлэтийн турш Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- өөр эмэгтэйтэй гэрлээгүй. Гэтэл тэр үеийн заншилаар өөр эмэгтэйтэй гэрлэх боломжтой байв.

Гэтэл Хатижа эхийг маань өөд болсны дараа дахиад настай бэлбэсэн нэгэн эмэгтэй байсан **Хазрат-и Сэвдэтэй** гэрлэв. Хазрат-и Сэвдэгийн нөхөр Абиссинийн нүүдлийн дараа тэнд нас барсан, Хазрат-и Сэвдэ ганцаараа үлдсэн байв. Тэр мусульман болсон учраас хамаатан садны дарамт их байв. Энэ гэрлэлт нь номлохын арав дахь жилд хэрэгжив. Хазрат-и Хатижа ба Сэвдэ ба бусад гэрлэлтүүд бүгд Мадинагийн эринд хэрэгжив.

Мадинад нүүснээр шив шинэ нэгэн эрин эхэлсэн юм. Тэр -саллаллаху алэйхи вэ сэллэм- нэгэн Пайгамбар болохын зэрэгцээ цэргийн дарга ба төрийн тэргүүн байв. Олон эриний турш бүх төрлийн хүнд илгээмжээ хамгийн сайнаар хүргэх хэрэгтэй нэгэн боловсрогч байв. Эдгээр шинжүүд гэрлэлтүүдэд нь маш тодорхой туссаныг анзаарахуйц юм. Түүний гэрлэлтүүд шашны, нийигмийн, эдийн засгийн ба ёс суртахууны маш олон ил ба нууц учир агуулдаг байв.

Пайгамбар Эзний маань гэрлэсэн эмэгтэйчүүдээс зөвхөн **Хазрат-и Аиша** -радъяллаху анха- нь залуу ба ариун бүсгүй байв. Энэ гэрлэлт хижрий буюу нүүдлийн нэгдүгээр онд Мадинад хэрэгжив. Нэлээн залуу байсан ч маш ухаантай асан Аиша эхийн маань ачаар эмэгтэйчүүдтэй хамаатай шашны дүрэм журмыг мэдэгдэв, Пайгамбарын маань өөд болсноос ойролцоогоор тавь-жаран жилийн дараа хүртэл дүрэм журам уг хэргүүд нэг дэх амнаас асхаб"и кирамд, тэдний эхнэр ба охидод, түүнчлэн ач-зээ нарт хүргэсэн байв. -Саллаллаху алэйхи вэ сэллэм- Эзэн маань:

"Шашныхаа гуравны нэгийг Аишагийн гэрээс сурцгаа!" (Дэйлэмий, II, 165/2828) хэмээн айлдаж уг үнэнийг заасан байдаг. Жишээлбэл Пайгамбараас маань хамгийн олон хадис дамжуулсан (Мүксирүүн) долоон хүнээс нэгэн асан Хазрат-и Аиша 2210 хадис дамжуулсан байдаг. Эдгээрээс 194 нь Бухарийнд ч

Мүслимд ч зэрэг (мүттэфэкүн алэйх болж) дамжуулсан байдаг.

Үнэхээр Хазрат-и Агша эх маань Кур'ан-и Кэримийн, халалуудыг, харамуудыг, фикхийг, анагаах ухааныг, шүлгийг, Араб туульсыг, угсааны зүйг маш сайн мэддэг байв. Асхаб-и кирам ямар сэдэвт санал зөрвөл түүнээс лавладаг байв. Мөн түүнчлэн асхабыг тэргүүлэгчид ч шийдэж чадаагүй асуудалд түүнээс лавладаг байв.[89]

Жишээлбэл Эбү Муса -радъяллаху анх-:

“Дамжуулсан ямар нэгэн хадист хэцүү юмтай тааралдвал тэрийг Аишаагаас асуудаг байв. Түүнд заавал нэг тайлбар хэлдэг байв,” гэнэ. (Тирмизий, Мэнакиб, 62)

Түүнчлэн Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- Эзэн маань Хазрат-и Аигатай гэрлэсэн нь анд Хазрат-и Эбү Бэкиртэй хамаатны харилцаагаа батлуулсан байдаг.Мөн Пайгамбар Эзэн маань Хазрат-и Умарын охин **Хазрат-и Хафсатай** хижрий гурван онд гэрлэсэн нь мөн тийм холбоог хэрэгжүүлсэн юм. Хазрат-и Умар - нөхөр нь Бэдирт шархдаж дараа нь шэхид болсон охин Хафсаг эхлээд Хазрат-и Эбү Бэкир дараа нь Хазрат-и Усмантай гэрлүүлэх гэтэл тэд уг саналыг хариулаагүй байсаар Хафса зовж, . Эцэст нь хижрий гурван онд Пайгамбар Эзэн маань Хазрат-и Хафсатай гэрлэв. Тэгээд энэ гэрлэлт хуучин найз нарын харилцааг засав.

Пайгамбар Эзний маань хижрий таван онд хэрэгжсэн **Хазрат-и Зэйнэбтэй** гэрлэсэн нь их маргаантай боловч маш олон нууц учиртай юм. Учир нь Пайгамбар Эзэн маань авга эгчийн охин асан Зэйнэбийг -өөрөө нэг их хүссэнгүй байсан ч- чөлөөлсөн боол ба өргөмөл хүү Зэйдтэй гэрлүүлж, ингэхдээ

89. Хар. Ибн-и Хажар, *эл-Исабэ,* IV, 360.

“баян-ядуу, язгуурт-боол” мэтийн ялгааг цэглэснээ, хүмүүсийг нэгэн самны шүд шигээ ижил буйг, хамгийн ойр хамаатны арга-ар зарлав. Уг гэрлэлтийн дараа Зэйнэб болон түүний хамаатны хэтэрсэн сөрөг бодол өөрчлөгдөв. Нөхөр нь Зэйд -радъяллаху анх-ын Аллахын Элчинд хийсэн салах бүртгэлүүд ч үр дүнгүй болов. Гэтэл Зэйд -радъяллаху анх- энэ байдлыг дийлэлгүй, эцэст нь Зэйнэб -радъяллаху анха-гаас салав.

Дагасан өдрүүдэд буусан аетад[90] Пайгамбар Эзний маань авга ахынхаа охин Зэйнэбтэй гэрлэхийг Аллах тушаав. Ингээд Пайгамбар маань мунхаглал үеийн, “өргөмөл хүүгийн хуучин эхнэртэй гэрлэх хориг”ийг энэ үйлээрээ цуцалж, “төрсөн хүү” ба “өргөмөл хүү”гийн ялгаатай буйг илэрхийлэв.

Энэ байдлын тухай “Хазрат-и Пайгамбар нь Зэйнэбийн гоо сайханд шохоорхон түүнтэй гэрлэв,” мэтийн ухаангүй ба зоригт зангаар яригсад чимээгүй болсон юм:

1. Зэйнэб Пайгамбар Эзний маань авга эгчийн охин мөн. Багасаа хойш түүнийг олон удаа харсан юм.

2. Пайгамбар Эзэн маань Зэйнэбтэй гэрлүүлэхээс өмнө гэрлэх санал болгосон бол Зэйнэб дуртай зөвшөөрөх байсан бөгөөд гэрлэхэд ямар ч саад байгаагүй. Гэтэл Оршигчийн Туяа нь түүнийг өөрөө бусадтай гэрлүүлэхийг хэлсэн ч Зэйнэб олон удаа татгалзсан байв.

Товчоор нь Исламын хуулийн зарим дүрэм журам нь Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн амьдралд хэрэг-жсэнээр бий болоод тэдний дагуу хуулийн тулгуур болохын тулд эдгээр бүх нь бий болох хэрэгтэй байв.

90. Хар. эл-Ахзаб, 37.

Хайбар дахь Еврей охин **Сафийе**тэй гэрлэсэн нь еврейчүүдтэй харилцааг -хамаатны холбоо сүлбээ тогтоохын төлөө юм. Хижрий долоо дахь жилд хэрэгжсэн энэ гэрлэлт ч улс төрийн зорилт агуулдаг юм. (Ибн-и Хажар, эл-Исаба, 4, 347)

Дахиад нэгэн аймгийн тэргүүний охин байсан **Жүвэйрие**-тэй хижрий таван онд гэрлэсэн нь дайны олон зуун барьцааг нэг дор чөлөөлж хүргэх ба тэдний хидаят буюу мусульман болгохын учир болсон байдаг. (Эбү Давуд, Итк, 2)

Аллахын Элчний Эбү Сүфяны охин **Үммү Хабибатай** хижрий долоо дахь жилд гэрлэсэн нь зовлон эдэлсэн итгэгч хатныг хүндэтгэх үүднээс байдаг. Учир нь Үммү Хабиба -радъяллаху анха- нөхөр нь Абиссинид Христийн шашинд элсээд өөрөө маш хэцүү нөхцөлд автсан боловч шашнаа хамгаалсан ба шашны мэдрэмж ба эрхэмсэг зангаас болж тэр үед Маккагийн тэргүүн асан аав Эбү Сүфъянаасаа лавлаагүй байв. Пайгамбар Эзэн маань -саллаллаху алэйхи вэ сэллэм- түүнтэй гэрлээд түүнийг хамгаалалтгүй үлдэхээс аврав. Түүнчлэн уг гэрлэлтийн ачаар Маккагийн мүшрикчүүдтэй мусульманчуудын хоорондын дайсны байдал ч гийсэн байв. (эл-Мүмтэхинэ, 7; Вахидий, х. 443)

Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- махбодийнхоо хүслэнгээр гэрлэсэнсэн бол, Мадинад Мухажирчууд ба Энсарын үзэсгэлэнт маш гоё охид байв. Хэн нэгэн мусульман охиноо Хазрат-и Пайгамбарт өгөхийг алдраар тооцож, охид ч “Пайгамбарын эхнэр” ба “итгэгчдийн эх” болоход өрсөлдөн хүсэх байв. Гэтэл Хүндэт Элч Эзэн маань уг аргад хэзээ ч эрмэлзээгүй юм.

Ийнхүү ба төсөөт шашны, ёс суртахууны, нийгмийн болон улс төрийн бодлогын маш олон учир ба ялангуяа Исламын хуульд эмэгтэйчүүдийг хамаарсан сэдвээр хүрэмжийн мэдлэгтэй, туршлагатай, боловсорсон хүний хэрэгцээний улмаас,

Хүндэт Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- нь Аугаа Элхийн зөвшөөрснөөр нэгээс олон эмэгтэйтэй гэрлэв. Учир нь зарим фикхий сэдэвт ганцхан нэгэн эмэгтэйн бодол хүрэхгүй байж мэдэх байв. Хамаг цаг ба орныг агуулах буй Исламын эмэгтэй ба гэр бүлтэй хамаатай хуулийн ойлголт нэгэн хүнээс иж бүрэн бидэнд хүрч чадахгүй байж мэдэх байв. Түүнчлэн тэр эмэгтэй нь Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм- Эзнээс маань өөд болохгүй талаар хэн ч баталж чадахгүй байв. Энэ бол Исламын эмэгтэйн хууль иж бүрэн төгс төгөлдөр болоогүй гэсэн утга агуулах байв.

Маш олон хэрэгт, эмэгтэйчүүд тэрийг эрэгтэй хүнээс асуухаас ичнэ. Гэтэл нэгэн эмэгтэй ижил юмын өөр нэгэн эмэгтэйтэй санаа амар ярьж мэднэ. Ийм учраас Исламын иргэншилд байнга боловсорсон, мэдлэгтэй эмэгтэйчүүд хэрэгтэй байдаг. Ийнхүү хэргүүдэд, Пайгамбар -алэйхиссалатү вэссэлам-тай хамт амьдарсан, хэргийг шууд Түүнээс мэдэж авсан бөгөөд Түүний нүд хандсан эхнэрүүдээс нь илүү мэдлэгтэй эмэгтэй нь бодох боломжтой юу?

Эдгээр бүхнээс цааш, тэд бүх нь амьдарсан байдлаараа бид болон бидний гэр бүлийнхэнд хамгийн сайхан үлгэр жишээ болцгоов.

“Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн олон удаа гэрлэсэн нь одоогийн хүмүүст нэгэн жишээ байж болох уу?” гэсэн нэг асуулт гарвал, ингэж хариу өгч мэднэ:

Пайгамбар Эзний маань өөртөө хамаатай зарим үйлс нь үммэттээ жишээ биш юм. Учир нь, Тэр нэгэн шашны анхны төлөөлөгч, байгуулагч, хэрэгжүүлэгч, ба Аллахыг элч буйгаараа маш ялгаатай нэгэн байв. Ийм учраас бусад хүмүүсээс ялгаатай болохоор зөвхөн Түүнд шөнө бүр тэхэжжүд мөргөлд босох нь фарз болгосон, хэдэн хоног амаа нээхгүйгээр мацаг

байрихад нь (савм-и висал) зөвшөөрөл олгосон, Тэр болон гэр бүлийнхэнд зэкат авах хориглосон байдаг. Иж бүрэн шашны, нийгмийн болон улс төрийн бодлогын учраар хийсэн, нэг дор дөрвөөс илүү гэрлэсэн нь ч Исламын эрдэмтдийн бүгдийн батласнаар, үммэтэд нь жишээ болохгүй.

“Тэаддүд-и зэвжат”ын манай шашны үүднээс утгыг нь асуувал:

Эхлээд үүнийг хэлэх хэрэгтэй: олон эхнэртэй гэрлэлтийг Ислам эхлүүлээгүй, энэ талаар явж байсан байдлыг тодорхой хязгаарт аваад зассан байдаг. Исламаас өмнө гэрлэлтэд тооны хязгаар байгаагүй. Ислам нь үүнийг гол зарчим буйгаараа “дөрөв”өөр хязгаарлав. Эхнэрчүүдийн хооронд эрх тэгш хандах талаар асуудал байвал, “нэг” эхнэртэй гэрлэхийн дээр буйг мэдүүлэв.[91]

Хоёрдугаарт нь, арван эхнэр авах нь хамаг итгэгчдийн талаар **“тушаал”** биш, зарим тохиолдолд олгосон **“зөвшөөрөл”** юм.[92] Энэ нь дайн, өвчин, гэмтэл бэртэл, удаан салах, хамгаалалт г.м. маш олон шалтгаанаар гэр бүл тархахгүйн, эмэгтэйчүүд хамагаалалтгүй үлдэхгүйн төлөө авсан нэгэн арга хэмжээ юм. Жишээлбэл хүүхэд төрж чаддаггүй эсвэл бие-биологийн байдал нь боломжгүй нэгэн эмэгтэйтэй гэрлэсэн хэн нэгэн, тэр эмэгтэйгээс салалгүй хоёр дахь нэг эхнэр авч мэднэ. Ийнхүү шаардлага үргэлжилсэн байдалд, гэр бүлийг нэмсээр байсанч

91. Хар. эн-Ниса, 3.

92. Элмалыгаас Мухаммед Хамди Гуай энэ сэдвийг ингэж тайлбарлана: Нэгээс илүү эхнэр авах гэвэл: Үүнийг үнэндээ зөвхөн нэгэн зөвшөөрөл бөгөөд эрхгүй хандах сэжиг байхад бузар байны тухай хэлэх үг үгүй. Гэтэл ает нь нэгээс илүү эхнэр авах зарим тохиолдолд мэндүб, түүнчлэн важиб буйг мэдээлэхээс ч хол үгүй юм. Үүнийг бол хамгийн ихэд эрчүүдийн талд ч эмчүүдийн талд ч зинагийн аюул илрэх тохиолдолд хайх хэрэгтэй юм. (*Үнэн Шашны Кур’аны Хэл,* II, 1290)

энэ түүг "дөрөв"тэй хязгаарласан байдаг. Ингэхдээ нэгэн гэр бүлийн тархсанаас үүсэх эд ба сүнсний алдагдал доод хэсэгт татсан байдаг.

Үнэхээр, дайн учирсан нэгэн нутагт нэгээс илүү эхнэр авахыг урамшуулах нь багассан хүн амны тоо болон хүмүүжилгүй явдлыг саатуулах талаар нэгэн шаардлага болж мэднэ. Үүний жишээнүүд өнгөрсөнд илэрсэн шигээ ирээдүйд ч илэрч мэднэ. Хүн төрөлхтний жаргал ба эсэн мэндэд манлай болох гол зарчмуудыг агуулсан Исламд, ийнхүү ер бусын байдал гарсан тохиолдолд ер бусын шийдвэрийг хэрэгжүүлэх боломж нь, "рухсат" хэмээн зөвшөөрлөөр олгосон болдог. Амьдралыг тэнииж байгалийн үргэлжлэлийг хангасан уг дүрэм зөвхөн гэрлэлтэд биш, бүх зүйлд хүчинтэй байдаг.

Ийнхүү шинж нь Исламын цаг ба орон бүрийн талаар аж ахуйн хэрэгцээг хангах шинжтэй буйг үзүүлнэ.

Нэгээс илүү дөрөв хүртэл эхнэртэй эрчүүдэд эхнэрүүдийн хооронд **"эрх тэгшийг хангах"** үүрэг даалгасан байдаг. Эс тэгвээс Аллахын зовлонгоор сүрдүүлсэн байдаг. Жишээлбэл ает-и кэримэ:

وَاِنْ خِفْتُمْ اَلَّا تُقْسِطُوا فِي الْيَتَامٰى فَانْكِحُوا مَا طَابَ لَكُمْ
مِنَ النِّسَآءِ مَثْنٰى وَثُلٰثَ وَرُبَاعَ فَاِنْ خِفْتُمْ اَلَّا تَعْدِلُوا فَوَاحِدَةً
اَوْ مَا مَلَكَتْ اَيْمَانُكُمْ ذٰلِكَ اَدْنٰى اَلَّا تَعُولُوا

"Хэрэв, хамгаалж буй эд бараатай өнчин охидтой гэрлэхдээ тэдэнд эрх тэгшгүй хандахаас айвал, тэднээс нэгтэй нь гэрлэ дээр нь шивэгчинтэйгээ ханил.тэдэнтэй эрх тэгш хандаж чадвал танд таалагдсан өөр эмэгтэйтэй хоёр, гурав, дөрөв хүртэл гэрлэ. Эрх тэгш

хандлагаа алдсанаас ингэсэн нь илүү тохиромжтой мөн,” (эн-Ниса, 3) хэмээн айлдав.

Өөр нэгэн ает-и кэримэ ч:

وَلَنْ تَسْتَطِيعُوٓا اَنْ تَعْدِلُوا بَيْنَ النِّسَآءِ وَلَوْ حَرَصْتُمْ
فَلَا تَمِيلُوا كُلَّ الْمَيْلِ فَتَذَرُوهَا كَالْمُعَلَّقَةِ وَاِنْ تُصْلِحُوا
وَتَتَّقُوا فَاِنَّ اللّٰهَ كَانَ غَفُورًا رَحِيمًا

“Хэдий их хичээсэн ч, эмэгтэйчүүдийн хооронд эрх тэгшид хүчээ хүргэж чадахгүй. Тэгэхлээр нь, нэгэнд нь бүтнээр эрмэлзэж нөгөөг нь хайхрахгүй битгий орхиорой. Хэрвээ сүнсээ боловсорч, Аллахаас айгаад эрх тэгшгүй байхаас болгоомжилбол; андашгүй нь, Аллах Гафур ба Рахим буюу, юунаас ч их энэрэлтэй, өршөөлтэй мөн,” (эн-Ниса, 129) хэмээн айлдав.

Пайгамбар Эзэн маань -саллаллаху алэйхи вэ сэллэм- ч нэгэн хадис-и шарифдаа:

“Нэг эрийн гэрлэлт хоёр эмэгтэй болж хооронд нь эрх тэгшийг хангахгүй бол, киямат өдөр нэг талдаа саа дайрснаар босно,” хэмээн айлдав. (Ибн-и Мажэ, Хиках, 47)

Гэхдээ эрэгтэйн нэгээс илүү эмэгтэйтэй гэрлэх эрхээ хэрэглэх нь эмэгтэйн гэрлэлт болоход шаардах нөхцөлөөр хязгаарлаж болно. Энэ нь эмэгтэйд олгосон нэгэн эрх мөн.[93]

Туурвилын тэнгэрлэг зорилгыг анхааралгүй, шулуухан учиртайгаар харвал, эмэгтэй хүн ч нэгээс илүү нөхөртэй болох нь зүйтэй гэвэл энэ нь ерөөсөө зөв биш юм. Ийм тохиолдолд

93. Хайрэддин Караман, *Исламын Зүйрлэсэн Хууль,* б. I, х. 290, Истанбул, 1996.

төрөх хүүхдийн угсаа нь маргалдаант байх болно. Хэний удамд орохыг нь хэн ч мэдэж чадахгүй. Ийм учраас **“фүжүүр”** гэсэн уг гэрлэлтийг ямар ч шашны, түүнчлэн шашин бусын хуулийн систем зөвшөөрөөгүй зэрэг, Ислам ч зөвшөөрөхгүй. Мөн, Ислам нь уг угсааг тогтоох талаар мэдрэмжтэй бодлоос болоод, салах болсон тохиолдолд, шинэ гэрлэлтэд хамгийн бага хугацаагаар хязгаар тавина. Өнөөгийн нийгмийн хуулиудын анхаарсангүй уг үнэн ч, Исламын хууль хүний үнэнийг хамгийн зөв үнэлж шийдсэний нэгэн баталгаа мөн.

Эдгээр бүхэн нөхцөлийг тооцоолбол, Исламын амьдралын төвшин бүрийг ба хамаг төрлийн байдлыг бодон “ханийн тоон”д зөвшөөрөл өгсний нууц учрыг ойлгож мэднэ. Үнэхээр тэр нь зөвхөн эрчүүдийн биш, настай ба хүчгүйчүүдийн ч шашин мөн. Тэр зөвхөн хэвийн болон тавтай үеийн биш, хамаг төвгийн хамт ер бусын ба хэцүү үеийн ч шашин мөн. Тэр зөвхөн эрэгтэйн биш, анзаарах хэрэгтэй хамаг эрх болон хэрэгцээг ч хамгаалан эмэгтэйн ч шашин мөн. Гэр бүлийн учиргүйгээр тархахад, хүүхдүүдийн хохиролд автахад нүдээ хаахгүй чинээ бие хүнийг ч нийгмийг ч боддог, хүний нэр алдрыг хамгаалах ганцхан шашин мөн.

Пайгамбарын Зэйд бин Харисэг Чөлөөлөн Өргөж Авсан нь

Зэйд бин Харисэг найман настай байхад, Бэний Кайн морьтдын нэгэн дайралтад түүнийг барьцаалж боол болохоор зарахаар Указ Яармагт авчирчээ. Хаким бин Хизам түүнийг авга эгч Хазрат-и Хатижад дөрвөн зуун дирхэмээр худалдаж авав. Орчлонгуудын Эзэн нь Зэйдийг харангаа:

“–Энэ боол минийх байсансан бол түүнийг заавал чөлөөлөхсөн!” хэмээв.

Хазрат-и Хатижа:

“–Тэгвэл Чиний л байг!” гэв.

Пайгамбар Эзэн маань ч түүний даруй чөлөөлөв. (Ибн-и Хишам, I, 266; Ибн-и Са’д, III, 40)

Зэйдийн аав хүүгээ алдсандаа маш их санаа зовсон, түүнийг эрэхээр гарсан байв. Хажийчуудаас Зэйдийн Маккад байсныг мэдэхлээрээ шууд дүүгийнхээ хамт ирээд Орчлонгуудын Эзнийг олов. Зэйдийн үнийг асууж, энэрэлтэй болохыг нь гуйцгаав. Эзэн маань:

“–Үүнээс өөр шийдэх арга байж болохгүй юу?” хэмээн асуув.

“–Юу вэ?” гээд асуухлаар нь, Орчлонгийн Хүндэт -саллаллаху алэйхи вэ сэллэм- Эзэн маань:

“–Түүнийг дуудаад, сонгоход чөлөөт орхицгоо! Хэрвээ таныг сонговол ямар ч үнэ төлөх хэрэггүй! Хэрэв намайг сонговол, валлахи надтай баймаар байгааг хэнд ч өгөхгүй!” хэмээв.

Зэйдийн аав ба авга ах нь:

“–Чи бидэнд маш энэрэлтэй хандсан, том тусламж үзүүлсэн!” гээд тааламжаа илэрхийлэв.

Зэйд бол:

“–Валлахи аа Эмин! Би юуг ч Чамаас илүүд үзэхгүй! Чи миний хувьд эцэг эхийн оронд. Би Чиний л дэргэд үлдэнэ,” гэв.

Аав ба авга ах нь загнавал:

“–Би энэ хүний дэргэд зарим зүйлс харсан, хэнийг ч Түүнээс илүүд үзэж чадахгүй. Түүнээс хэзээ ч салахгүй!” гэв.

Оршигчийн Туяа нь Зэйдийн үнэнч байдлыг харахлаараа гарыг нь барьж Кавад аваачаад:

"–Хүмүүс ээ! Та нар гэрч байцгаа, Зэйд миний хүү, би түүний залгамжлагч мөн, тэр ч миний залгамжлагч байх болно,"[94] гээд түүнийг өргөөд хүү болгож авав.

Зэйд -радъяллаху анх-ын аав ба авга ах нь үүнийг харахлаараа сэтгэл амар нутагтаа харьцгаав. (Ибн-и Хишам, I, 267; Ибн-и Са'д, III, 42)

Зэйд -радъяллаху анх-ын дүү Жэбэлэ бин Харисэ -радъяллаху анх- ингэж ярина:

"Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм-д очоод:

«–Аллахын Элч ээ! Дүү Зэйдийн минь надтай хамт илгээ,» гэлээ.

«–Өөрөө мэд. Хэрвээ чамтай явбал би саад хийхгүй,» хэмээв.

Гэтэл Зэйд:

«–Аллахын Элч ээ! Би хэнийг ч Чамаас илүүд үзэхгүй!» гэв.

Дараа нь минйи дүү Зэйдийн бодол нь минийхээс зөв буйг үзэж ухаарав." (Тирмизий, Мэнакиб, 39/3815)

Пайгамбар Эзэн Хазрат-и Алиг Хажуудаа Авсан нь

Эбү Талибын эдийн засгийн байдал хүчгүй, гэр бүлийнхэн бол нэлээд өнөр байв. Ийм учраас төвөгтэй байв. Пайгамбар Эзэн маань нөгөө авга ах Хазрат-и Аваас дээрээ очоод:

94. Тэр өдрөөс хойш Зэйдийг Зэйд бин Мухаммед гэж эхэлцгээв. Энэ нь Ахзаб Сурагийн 5 болон 40-р аетад өргөдөл хүү хэргийг цуцалтал ингэж үргэлжлэв.

"–Ахай! Чиний дүү Эбү Талибын гэр бүл маш өнөр гэдгийг мэдээ биз дээ. Хүмүүс ган ба өлсгөлөнд автжээ, хичээгээд байна. Одоо Эбү Талибын дэргэд очоод түүнтэй ярилцая. Хөвүүдээс нэгийг би хажуудаа авъя, нэгийг ч чи ав! Ингээд ачааг нь жаахан хөнгөлье!" гэв.

Аббас -радъяллаху анх- уг сэтгэл харамгүй саналыг хүлээн зөвшөөрч, хоёулаа Эбү Талибын дэргэд очив. Тэр:

"–Акийлийг надад үлдээ, бусдаас хүссэнээ авч болно!" гэв.

Тэгэхлээр нь Мухаммед -алэйхиссэлам- Алиг, авга ах нь Аббас ч Жафарыг авав.

Эзэнд маань пайгамбар цол хайрлатал Хазрат-и Али нь Түүний дэргэд өсөв. (Ибн-и Хишам, I, 264)

Пайгамбар Эзний Хүүхдүүд

Орчлонгийн Хүндэт -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн Хазрат-и Хатижатай гэрлээд Каасим, Абдуллах, Зэйнэб, Рукайяа, Үммү Гүлсүм ба Фатима нар төрөв. Анхны хүү нь Каасим гэсэн нэртэй байсан тул, Пайгамбар Эзэнд маань -алэйхиссалатү вэс-сэлам- "Эбү'л-Каасим" бүртгэлийн нэр өгөв.

Каасим нь хоёр настайдаа өөд болов.

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн нөгөө хөвүүн Абдуллахад, Исламын эринд төрсөн учраас Тайейб ба Тахир ч гэдэг байв.[95] Түүнийг ч өөд болохлоор нь Курайшийн мүшрикчүүдээс Ас бин Ваил манай Пайгамбарын тухай:

95. Ибн-и Са'д, I, 133.

"–Түүнийг орхицгоо! Тэр удам нь үргэлжлэхгүй нэгэн эр хүн. Үхэхлээр нь нэрийг нь хэн ч дурдахгүй. Та ч түүнээс аврагдаж тав тухад хүртэнэ," гэв.

Тэгэхлээр нь Аллах Таала Кэвсэр Сураг буулгав:

إِنَّا أَعْطَيْنَاكَ الْكَوْثَرَ. فَصَلِّ لِرَبِّكَ وَانْحَرْ. إِنَّ شَانِئَكَ هُوَ الْأَبْتَرُ

" Бид Чамд Кэвсэрийг[96] өгөв. Тэгвэл Раббынхаа төлөө мөргөл үйлдэж, тахил барь. Үнэндээ нэр хүнд нь мартагдах хүн бол Чамд өшөөтэй хандсан хүн мөн." (эл-Кэвсэр, 1-3) (Ибн-и Са'д, III, 7; Вахидий, х. 494)

Аллахын Элчний хөвүүнийг бага настай өөд болохлоор нь Хазрат-и Хатижа -радъяллаху анхаа-:

"–Аллахын Элч ээ! Миний хүүгийн сүү цалгив. Аллах түүний амийг сүүний цагийг дуустал балгасан нь дээр байв!" гэв.

Тэгэхлээр нь Пайгамбар Эзэн маань -саллаллаху алэйхи вэ сэллэм-:

"–Тэр сүүний үеэ диваажинд дүүргэнэ!" хэмээв.

Хазрат-и Хатижа эх маань:

"–Аяа Расулаллах аа! Хэрэв үүнийг мэдсэн бол хүүгийн минь өнгөрсөн нь арай эрт байв!" гэв.

---

96. **Кэвсэр** гэсэн үгийн утга нь олон, элбэг, бүхний олон юм. Кэвсэрийг номлох, Кур'ан, Ислам, буян, жаргал, аврал, мөргөл ба Пайгамбар Эзэн маань -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн гайхамшигт хэмээн тайлбарласан байдаг. Итгэмжтэй дамжуулсан үгсээс харвал Кэвсэр нь Хазрат-и Пайгамбарын диваажин дахь нуурын нэр юм. Мухаммедын үммэт нь киямат өдөр тэр нуурын эрэгт цуглах болно. (Бухарий, Тэфсир, 108)

Орчлонгийн Хүндэв -саллаллаху алэйхи вэ сэллэм-:

“–Хүсвэл Аллахад залбиръя, тэгээд чамд түүний дууг сонсгоё,” хэмээв.

Гэтэл Хатижатү’л-Күбра -радъяллаху анхаа- бууж өгөх ба үнэнч бэлгээ дахин үзүүлэн:

“–Үгүй, Расулаллах аа! Би Аллах ба Элчийг нь баталж байна,” гэв. (Ибн-и Мажэ, Жэнаиз, 27)

Аллахын Элч дөрвөн байдаг. Хамгийн том нь Хазрат-и Зэйнэб байв. Түүнийг төрөхөд Орчлонгийн Хүндэт -алэйхи эфдалү’с-салэват- гучин настай байв. Дараа нь Хазрат-и Рукайяя төрөв.[97]

Рукайяагийн дараа Хазрат-и Үммү Гүлсүм, түүний дараа ч Хазрат-и Фарима төрөв. Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- тэр үед гучин таван настай байгаад, Каба дахин бариглдаж байв.[98]

Сүүлээр хижрий найман онд Мария эхээс маань Эзний маань хүү Ибрахим хорвоод мэндлэв. Ибрахимын эхийг Үммү Рафий барив. Түүний нөхөр Эбү Рафий төрөлтийг Аллахын Элчинд мэдээлэв. Уг мэдээлэлд их хөөрсөн Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- түүнд олон бэлэг гардуулав. Хажуугийнхандаа ч:

“–Өнөө шөнө миний хүү төрөөд, омог Ибрахимынхаа нэрийг өглөө,” хэмээв. (Мүслим, Фэдаил, 62)

Ибрахим арван долоо эсвэл арван найман сартай байхдаа өвдөөд удахгүй өөд болов.[99]

97. Диярбэкрий, I, 273-274.
98. Ибн-и Са’д, VIII, 19-26.
99. Хар. Асри Чубукчу, *ДИА,* “Ибрахим” зү., XXI, 273-274.

Кабад Шүүгч Хийсэн нь

Маккад үер болж, Каба нь нэлээд сүйдсэн байв. Тэгэхлээр аймгууд засвар хийхээр гар нийлэв. Кабаг суурь хүртэл нь нурааж дахиад барихаар шийдэлцэв.

Тэр хооронд, нэгэн онгоцны ширүүн салхинд Маккад ойр Шуайба боомт руу чирэгдэн тэнд эх газарт мөргөж бутарсны мэдээг авав. Онгоц нь зөөлөн шулуун чулуу, дүнз, төмөр мэтийн барилгын бараа тээж байв. Очоод онгоцтой дүнзийг худалдаж авав. Кабаг нураах ба барих ажлын сугалаагаар хуваалцав.

Курайшчууд Кабагийн өөрсдөд оносон хэсгийг нурааж барихдаа эхлэх болоход, Эбү Вэхв бин Амр босоод:

"–Еэ Курайшийн нийгэм! Кабагийн барилганд орлогынхоо цэвэр ба халал үгүй хэсгийг битгий холиул! Түүнд хууль бусын аргаар олсон бараа, хүүт мөнгө, эсвэл хэн нэгнээс эрх бусаар авсан мөнгө бүү орог!" гэв. (Ибн-и Хишам, II, 210; Ибн-и Кэсир, *эл-Бидая,* II, 305)

Курайшчууд Кабаг нураасан тохиолдолдоо зовлонтой учрахаасаа айж байсан тул шийдвэргүй байв. Арабчуудын хооронд бий байсан Кабаг авгайлан хүндэтгэх санаа нь Ибрахим -алэйхиссэлам-ын шэриатаас нааш дамжуулан ирсэн тэнгэрлэг нэгэн үүрэг байв. Курайшийн нийгмийн алдартнуудаас Вэлид бин Мугира:

"–Таны Кабаг нураах зорилго юу вэ? Сайн уу эсвэл муу юу?" гэж асуув.

"–Мэдээж сайн байна!" гэцгээв.

Вэлид:

"–Миний аймгийнхан! Та Кабаг нураагаад түүнийг засахыг хүсэхгүй байна уу? Аллах Таала засагчдыг хохироохгүй!"

гээд Кабаг нураахаар нэгдүгээрт тэр л эхлэв. Бусад нь ч түүнийг дагаж ажиллав. (Абдуррэззак, V, 319)

Кабагийн хананд нэгэн эгнээ чулуу, нэгэн эгнээ модон холбоосон дамнуур өрөөд дээшлүүлэв. Оршигчдын Туяа ч Кабагийн засварт авга ах Абаасынхаа хамт оролцов. Хажар-и Эсвэдийг байранд оруулах ээлж болоход, аймаг бүр нь уг хүндэт үүргийг өөрөө хиймээр байсан тул ширүүн маргалдаан гарав. Хэрэг нь атаа ба хүслэнгээр эргэв. Бараг цус асгахаар дөхөв. Абдуддарынхан цусаар дүүрэн нэгэн аяга авчраад, үхтлээ байлдахаар Адий бин Ка'бынхантай гэрээ тогтоож дайнд бэлдэв. Тангаргаа батлуулахаар ч гараа цусаар дүүрэн аяганд дүрэв. Курайшчууд ийнхүү байдлаар дөрөв эсвэл тав хонов.

Эцэст нь Курайшийн хамгийн ахмад асан Эбү Үмэйе чанга дуугааараа:

"–Аяа улс минь ээ! Бид зөвхөн ач буяныг хүсч, муу муухайг хүсэхгүй байна. Та энэ тухай атаархлын уралдаанд битгий ороорой. Өрсөлдөхөө бай! Бид уг асуудлыг хоорондоо шийдэж чадаагүй байтал, Харамын хаалгаар анх ороод ирэх хүнийг хоорондоо шүүгчээр томилъё. Шийдвэрийг нь зөвшөөрье!" гээд гараараа Мэсжид-и Харамын Бэний Шэйбэ хаалгыг үзүүлэв.

Тэгэнгүүт нь Орчлонгийн Эзэн Харамын үүдэнд харагдав. Хүн бүрийн царайд сайхан мишээл бүрдэв. Учир нь ирэх хүн нь Мухаммедү'л-Эмин байв. Курайшийн Пайгамбар Эзэнд маань -саллаллаху алэйхи вэ сэллэм- хайр, хүндэтгэл ба итгэл нь өдөр тутам ихэссэн байв. Түүнчлэн, нэгэн тэмээ төхөөрөхөөр болбол Орчлонгийн Тэргүүн Эзнийг маань дууддаг, Тэр ч очоод тэдний ажлыг элбэг дэлбэгийн төлөө залбирдаг байв.[100]

Ийм учраас Курайшчууд Түүнийг хармагцаа:

100. Абдуррэззак, V, 319; Ибн-и Кэсир, *эл-Бидая,* II, 304.

"–Энэ нь эл-Эмин! Манай хооронд түүний шүүгч болохыг бид бүхэн зөвшөөрнө!" гэцгээв.

Асуудлаа түүнд ярьж өгөв. Тэр ч аймаг бүрээс нэгийг сонгож, нөмрөгөө тайлаад газар дэвсэв. Дараа нь Хажар-и Эсвэдийг нөмрөг дээрээ тавиулж сонгосон хүн бүрийг захаас нь бариулав. Ариун чулууг хамтдаа зөөв. Орчлонгийн Туяа түүнийг гараараа байранд нь оруулав. Ингээд аймгуудын хооронд гарах магадлалт нэгэн дайныг саатуулав.[101]

Түүний ийнхүү тэгш хадан, хүрэгдэшгүй ёс суртахуун толилуулсан ба төсөөт бэлгэ тэмдэг нь Түүнийг "Султану'л-Энбияа" буюу Пайгамбарчуудын Хааны суудалд өргөх номлох үүргийн, тэр үед мэдэгдээгүй бэлгэ тэмдэг байв. Маккад төрж өссөн Мухаммед Мустафа -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн пайгамбар болох нь арай мэдэгдээгүй байсан магадгүй, гэтэл тэвхийдээс салаагүй зарим сайн боолчууд Төгсгөлийн Үеийн Пайгамбар ирэхийг мэдээд цагийн дөхсөнийг ч мэдэрч байв. Кусс бин Саида эд нарын нэг байв.

Кусс бин Саидагийн Яриа

Кусс бин Саида нь Ияад аймгиын тэргүүн бөгөөд Есүс -алэйхиссэлам-ын шашинд, тэвхийдчин ба шүлэгч нэгэн байв. Түүний Указ Яармагт, хооронд нь Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм- ч байсан хэсэг хүмүүст хэлсэн бөгөөд Пайгамбарын илрэхийг дурдсан тус яриа нь маш сургамжтай ба ухаантай байдаг:

"Хүмүүс ээ!

Ирээрэй, сонсоорой, тогтоогоорой, сургаал аваарай!

101. Ибн-и Хишам, I, 209-214; Абдүррэззак, V, 319.

Амьдарсан нь үхнэ, үхсэн нь мууг олон, болох нь болно. Бороо орно, өвс ургана; хүүхдүүд төрөөд аав ээжийхнээ байрыг авна. Дараа нь бүгд нь мөхөж явна. Явдал нь хэзээ ч дуусашгүй; бүгд нэг нэгийг дагаж явна.

Анхааараарай, хэлэх юмд минь сонор хандаарай! Тэнгэрээс мэдээ бий; газар сургамж авах зүйлс бий! Дэлхий газар дэвссэн нэгэн гудас, тэнгэр нь өндөр нэгэн тааз. Одод явна, тэнгис зогсоно. Ирсэн нь үлдэхгүй, явсан нь ирэхгүй. Очсон газартаа таатай байсдаа буцахгүй байна уу; эсвэл баригдаад нойрт автаж байна уу...

Би тангараг өргөе, Аллахын онгонд нэгэн шашин бий, одоогийн шашнаас илүү энхрий юм.

Бас, Аллахын ирэх нэгэн Пайгамбар бий, Түүний ирэх цаг маш ойр юм. Түүний сүүдэр манай толгой дээр тусав. Түүнд итгэж, Тэр цуут хүний хидаяатад хүртсэн хүнд ямар их баяр хөөр юм бэ! Түүнийг эсэргүүцэж бослого хийсэн хүн ямар хайран юм бэ!

Амьдралаа мунхаглал дотор өнгөрөөгсдөд гутамшиг юм!

Хүмүүс ээ!

Мунхаглалаас татгалзаарай! Бүх юм түр зуурын юм, зөвхөн Аугаа Эрх л Мөнх юм. Тэрээр цорын ганц, түнш ба шадар үгүй. Залбиран үйлчлэх зөвхөн Тэрээр л байдаг. Тэрээр төрөөгүй, төрүүлээгүй юм.

Өмнө нь болж өгшөрөгсдөд бидний төлөө олон сургаал байдаг.

Аяа Ияад аймгийнхан! Танай аав өвөө хар хаана вэ? Шилмэл байшингууд, чулуун байрнууд хийсэн Ад ба Сэмүүд хаана? Дэлхийн баялагаараа ихэмсэг зан гаргаж улстаа хан-

дахдаа «Би таны хамгийн том Раб мөн,» гэсэн Фарон ба Нэмрүд хаана байна?

Энэ газар тэднийг тээрэмдээ нүдэж нунтаглав. Тэдний яс ч үлдсэнгүй. Гэр нь нурж хүнгүй үлдэв. Тэдний байранд одоо нохойнууд жаргана. Тэдэнд шиг мунхаглалд битгий уна аа. Тэдний замаар битгий яв. Бүх юм түр зуурын, зөвхөн Аугаа Эрх л Мөнх юм.

Үхлийн мөрөнд орох олон газар бий, гэтэл гарах газар үгүй!.. Том багагүй хүн бүр нүүж явдаг. Хүн бүрт болсон нь надад ч таарах юм." (Бэйхарий, *Китабу'з-Зүхд,* II, 264; Ибн-и Кэсир, *эл-Бидая,* II, 234-241; Хэйсэмий, IX, 418)

Куус бин Саида ийм гоё үгсийг хэлж байхдаа дурдсан сүүлийн пайгамбар болох Хазрат-и Мухаммед Мустафа -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн тэнд байсныг мэдэхгүй байв. Хэсэг хугацааны дараа нас барав. Харин түүний аймаг номлох үүрэг эхлэхээр ирээд Аллахын Элчид итгэснээ илэрхийлэв.

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- тэдэнд:

"–Кусс бин Саидагийн, Указ Яармагт тэмээн дээрээ: «Амьдарсан нь үхнэ, үхсэн нь мууг олно, болох нь болно!» гээд хандсан нь миний санаанаас огт гардаггүй. Уг хутбаг уншиж чадах хэн нэгэн бий юу?" хэмээн асуув.

Хамт олон нь тэр хутбаг тэдний аймгаас бараг хүн бүр уншиж чадахыг хэлэв. Орчлонгийн Эзэн үүнд маш их баясав.

Тэнд байсан Эбү Бэкир -радъяллаху анх- ч:

"–Аяа Расулаллах аа, тэр өдөр би ч тэнд байлаа, түүний хэлсэн бүх нь миний цээжинд бий," гээд хутбаг эхээс дуустал нь уншив.

Дараа нь Ияад аймгаас нэгэн босч Кусс бин Саидагийн шүлгээс уншив. Тус шүлгүүдэд Пайгамбарын маань угсаа бай-сан Хашиныхнаас том нэгэн пайгамбар илрэхийг ил далангүй мэдээлсэн байв. (Ибн-и Кэсир, *эл-Бидая,* II, 234-241)

Агуу Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- Эзэн маань Кусс бин Саидагийн тухай ингэж айлдав:

"Аллах Таала нь Кусс бин Саидад рахмат хийх болтугай! Тэр нь киямат өдөр тустай нэгэн үммэт болж сэрэх юм!" (Ибн-и Кэсир, *эл-Бидая,* II, 239)

Хира Агуйн Ганцаардал

Мухаммедын номлох цаг дөхөх тусам Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- ердөө ганцаардалд ороод удаан хугацаагаар бодлогошрон далайн гүнзгийд умбадаг байв. Заримдаа гэрээсээ гарч, Маккагаас холдоод, дуу чимээгүй газар тийш явдаг байв. Тэр хооронд тааралдсан мод ба чулууд: "эс-Саламү алэйкэ яа Расулаллах!" гээд түүнтэй мэндчилдэг байв. Орчлонгийн Хүндэт -алэйхи экмэлү'т-тахийят- Эзэн маань шууд эргэн тойрноо харж, гэтэл мод ба чулуунаас өөр юм олдоггүй байв.[102]

Шашны тухай Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-:

"Би Маккад намайг пайгамбараар томилогдохоос өмнө надад мэнд хүргэдэг нэгэн чулуу мэднэ. Түүний хаана байгааг одоо ч мэднэ," хэмээв. (Мүслим, Фэдаил, 2)

Хазрат-и Али -радъяллаху анх- ч ингэж ярина:

"Пайгамбар Эзнийхээ хамт Маккад байлаа. Хоёулаа Маккагийн зарим хэсгээр явав. Уул ба моддын дундуур яваад

102. Ибн-и Са'д, I, 157.

байв. Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн тааралдсан хамаг уул ба мод нь: «эс-Саламү алэйкэ яа Расулаллах!» гээд байв.” (Тирмизий, Мэнакиб, 6/3626)

Оршигчийн Туяа -алэйхиссалатү вэссэлам- Рамазан сараар Хира Агуйд[103] нэг сарын итикафад ордог байв. Тэр хооронд Түүнд очсон ядуу гэргүй хүмүүсийг цатгаж, хэрэгцээг нь хангадаг байв. Итикафаас гараад гэртээ харихаас өмнө Кабаг тойрдог байв.[104]

Улс ардаа баримално шүтсэнийг харах тусам тэднээс холдож, ганцаараа байхыг бүр илүү хүсдэг байв. Түүний ганцаараа ингэж залбирах нь бодох, омогт Ибрахим -алэйхиссэлам- шигээ тэнгэр ба газрын мэдэлтдээс сургаал авах ба Кабаг ширтэн суудаг байв.[105]

Расулаллах -алэйхиссалатү вэссэлам- Хирад очихдоо хажуудаа жаахан хүнс авдаг байв. Хүнс нь багасах тусам Хазрат-и

---

103. Хира нь Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-д анхны вахий ирсэн агуйг оршсон уулын нэр юм. Хира Уул нь Маккагийн зүүн урд талд, ойролцоогоор 5 км. хол байдаг. Жэбэл-и Нур буюу Туяаны Уул хэмээн ч мэдэгдэнэ. Орчлонгийн Хүндэт Эзний маань амьдралд чухал газар эзэлсэн Хира Агуй нь уулны оргилоос цөөн хэдэн метр доош байдаг. Энэ газар нь үнэндээ овоолсон том хаддын хоорронд үлдсэн туннелтай төсөөт хонгилоор бүрдсэн байдаг. Урдын нээлттэй хэсгээр Кабаг харна. Өндөр нь хэн нэгний толгой таазанд нь хүрэхгүй босоо байж чадах чинээ, өргөн нь бол газар хэвтэж чадах чинээ байдаг. Уг агуй нь Кабаг харсан, орчныг хянадаг газар оршсон бөгөөд бодлогошироход зохимжтой байдаг. Пайгамбар Эзнээс маань өмнө ч Макка дахь ханифчууд Хира Ууланд заримдаа ганцаардалд ордог байв. Хазрат-и Пайгамбарын өвөө Абдүлмутталиб ч эднээс нэгэн байв. Тэр нь Аллах буйд, ял ба шагналын газараар ахират буйд итгэж үнэмшсэн, заримдаа Хира Ууланд хоргодож өөрийгөө залбирал үйлчилгээнд зориулдаг байв. (Фуат Гүнэл, *ДИА,* “Хира” зү., XVIII, 121-122)
104. Ибн-и Хишам, I, 253-254.
105. Айний, I, 61; XXIV, 128.

Хатижагийн дэргэд харьж идэх зүйлс аваад дахиад Хирад очдог байв.[106]

Хирад заримдаа Хазрат-и Хатижагийн хамт очсон удаатай.[107]

Орчлонгийн Хүндэт -алэйхи эфдалү'с-салэват- Эзэн маань ганцаараа байхдаа туяа харж, дуу чимээ сонсдог байв. Эдгээрийг жин буюу дугана эсвэл зөнтэй хамаатай гэж бодоод айдаг байв. Хазрат-и Хатижад:

"–Хатижа! Зөнч болохоос айж байна. Валлахи, уг баримал шүтэгчид ба мэргэ харагчдаас өшсөн шигээ хэнээс ч өшихгүй!" хэмээж, тэр ч:

"–Авга ахын минь хүү![108] Тэгж битгий хэл ээ! Аллах Чамайг хэзээ ч мэргэ харагч болгохгүй…" гээд тайтгаруулдаг бай. (Ибн-и Са'д, I, 195)

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн Хирад Рабтайгаа ганцаараа үлдсэн эрин, хөрсөн доорх үрийн байдалтай төсөөтэй юм. Энд нь дэлгэрэнгүй мэдээлэл нь хүн төрөлхтөн үүрд мөнхөд мэдэгдэхгүй нэгэн бий болохын байрлал юм. Итгэл үнэмшлийн үр энд таригдаж, мөнхийн жаргалын бамбар энд шатаасан ба авралын удирдамж буй Кур'ан-и Кэримийг хүн төрөлхтөнд бэлэглэхийг дахиад энд л эхэлсэн байдаг.

Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийг Хира Агуйд даянчилсан нь гаднаас харвал ард түмнийг автсан төөрмөл зам, харгислал ба ядуурлыг сэтгэлд нь ойлгосон

106. Мүслим, Иман, 252.
107. Ибн-и Хишам, I, 254.
108. "Авга ахын хүү", "дүүгийн хүү" мэтийн үгсийг Арабчууд хоорондоо хүнд хандахдаа ихээр хэрэглэдэг. Ихэнхдээ бол хол харилцааг илэрхийлдэг.

зовлон ба хамаг орчлонд зориулсан энэрэл байв. Үнэндээ бол хүн төрөлхтөнд мөнхийн жаргалын удирдамж буй Кур’ан-и Кэримийн тэнгэрлэг онгоноос Мухаммедийн ариун цэвэр зүрхээр дамжуулан хүний ухаанд хүрэхийг хангах бэлтгэлийн шат байв. Энэ явдал нь нэг төрлийн өндөр хүчдэлийн цахилгааныг хөрслөхтэй төсөөтэй сүнсний очийн тайз байсан, Аллах ба Түүний хооронд нэгэн нууц асан тул нүднээс хол нэгэн агуйд болох шаардсан байв. Хирагийн эрин нь вахий хандсан буюу эгэл хүмүүсийн талаар дийлэх боломжгүй хүнд ачааг зөөх тухай бэлгэ тэмдэг илрэх улирал байв. Яг түүхий төмөр боловсорч болд болохтой адил...

Уг нууцыг ёсоор нь даах зорилгоор хүрээ нь тархахгүй нэгэн ухаан хэрэгтэй байсан бөгөөд түүнийг төгс төгөлдөр илэрхийлэх хүний үг яриа гэж огт байдаггүй.

Расулаллах -алэйхиссалатү вэссэлам-ын Хира дахь ганцаардлаас дараах үедээ ч хэрэгжүүлсэн итикафаас нь ч нэгэн мусульман хэр их залбиран үйлчилсэн ч, заримдаа ганцаардалд ороод нэфсийнхээ тооцоог хийж, орчлон дахь тэнгэрлэг хүчдэлийн урсгалыг бодохгүйгээр жинхэнэ хэргээр нь төгс төгөлдөрт хүрч чадахгүйг ойлгож байна. Энэ нь итгэгч бүр хийх хэрэгтэй багахан нэгэн үүрэг юм. Хүмүүст удирдамж болох хүмүүст бол уг бодогшрол ба тооцоо илүү хэрэгтэй байдаг.

Кур’ан-и Кэрим нь анхны аетаас сүүлийн ает хүртлээ хүн төрөлхтөнд бодохыг сургаж бодлын төвд Рабд боолчлолыг байрлахыг санал болгоно. Ингээд итгэл нэгэн сайхан амт байх болно. Боол нь бүх цаг ба оронд Эрхийн тааллыг эрэхийг хичээнэ. Эцэст нь тэнгэрлэг хүчдэлийн урсгалын зүрхэн дэх нууц учрын илэрхийллээр боол нь Эрхэнд ойртож Тэрээрт хүрнэ.

Итгэгчийн хувьд хамгийн чухал сэдвийн нэг бол мухаббатуллах буюу Аллахын хайр мөн.[109] Аллахын хайрыг олохын итгэх үнэмшихээс дараах ганцхан арга нь Аллахын бэлэг ба сайн сайхныг байнга бодох, Тэрээрийн содон ба хүчдэлийг бодогшрох, дараа ч зүрх ба хэлээрээ Тэрээрийг ихээр дурдах мөн.[110] Эдгээр бол зүрхийг дэлхийн үйл ажиллагаанаас иж бүрэн хадгалж, ухаан төвлөрсөн үед л боломжтой байх болно.

Энд үүнийг ч илэрхийлэх хэрэгтэй; ганцаардлын зорилго хүмүүсээс холдох, уул ба агуйг орон нутаг болгох биш юм. Ингэж хандах нь, Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм- болон Түүний асхабын даалгавартай зөрнө.

Жишээлбэл Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-:

“Хүмүүсийн хооронд хольж тэдний төвгийг даасан мусульман нь тэднээс хол байж төвгийг нь даасангүй мусульманаас илүү буянтай юм,” хэмээн айлдав. (Тирмизий, Киямат, 55)

---

109. Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- залбиралдаа Аллах Таалагийн хайрыг нэхэн ерөөж:

اللهم إني أسألك حبك وحب من يحبك والعمل الذي يبلغني حبك.

اللهم اجعل حبك أحب إلي من من نفسي وأهلي ومن الماء البرد.

“Аллах минь! Чамаас чиний хайрыг, Чамд хайртуудын хайрыг ба Чиний хайрт хүргэх үйлийг нэхье. Аллах минь! Хайраа надад нэфсээс, гэр бүлээс, бараагаас минь ба хүйтэн уснаас илүү хайртай болгох байтугай!” хэмээдэг байв. (Тирмизий, Дэават, 72)

110. Ибн-и Аббас -радъяллаху анх-: يَآ اَيُّهَا الَّذِينَ اٰمَنُوا اذْكُرُوا اللّٰهَ ذِكْرًا كَثِيرًا **“Аяа итгэгчид ээ! Аллахыг ихээр дурдацгаа!”** (эл-Áхзаб, 41) ает-и́ кэримэгийн тэфсирт ингэж хэлэв:
“Аллах Таала боолчууддаа фарз болгосон хамаг үйлд тодорхой нэгэн хил тавьсан байдаг. Энэ тухай шалтгааныг ч хүлээн зөвшөөрөв. Харин зикир нь үүнээс гадаа юм. Аллах Таала түүнд хүрэх нэгэн хил тогтоогоогүй. Ухаанаа алдагсдаас гадна зикирийг орхисон хэнийх шалтгааныг ч хүлээн зөвшөөрөхгүй. Тэрээр хүмүүст ямар ч байдалд зикир давтахыг тушаасан байдаг.” (Табэрий, XXII, 22; Куртубий, XIV, 197)

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн өөрөө хонь хариулсан, Фижар Дайн ба Хилфү'л-Фүдүүлд оролцсон, наймааны амьдрал ба Кабаг дахиад барихад биеэрээ ажиллаcан мэтийн олон үйл нь Түүний номлохоос өмнө ч байнга амьдралын дотор байсны илрүүлнэ. Тэр нь нийгмийн хамаг эрдэмд оролцсон, муу муухайнаас бол холдсон, хэзээ ч тэдэнд ойртоогүй юм.

Ганцаардалд орохын зорилго бол, байдлаа боловсруулах юм. Сэхээ олохоор уусан эмчилгээ нь цагаараа ба хүрэмжтэй хэмжээнд байх ёстой. Хэрэгтэй чинээнээс илүү авах тохиолдолд, ашиг байтугай аюул авчирах нь андашгүй юм.[111]

Хүүхэд ба Залуу Үеийнх нь Шинж

Аллах Таала нь орчлонгуудад энэрэл болгож илгээх Хайрыгаа хүн төрөлхтний литийн анхны хуудаснаас эхлэн хамгийн цэвэр ба хамгийн язгуурт угсаанаас шүүж оршигчдын хорвоод авчирсан байдаг. Уг шилдэг угсааг бусдаас олон талаараа дээд болгож Хайрынхаа хамаг овог дээдсийг өөрийнх үедээ хүндэтгэл хүртмээр хүмүүс болгов. Шүлэгч нь ийм байдлыг маш сайхан илэрхийлэв:

Сарнайн гол сарнай байдаг
Пайгамбарын угсаа нь сарнай байдаг ...

Анхны хүн ба анхны Пайгамбар Хазрат-и Адам -алэйхиссэлам-аас эхлэн хамаг пайгамбарчуудаас, Түүнд итгэж илрэхийг нь мэдээлэх талаар ам авахуулсан ба ирэхийг нь мэдээлэх маш олон явдал илэрсэн байдаг.

Ингээд Аллах Таала нь хүн төрөлхтөнд хайрлах хүндэт пайгамбараа хамаг бэлгэ тэмдгээр нь хүн төрөлхтөнд таниулж,

111. Бутий, х. 79-82.

эрүүл ухаантай боолчуудынхаа Түүнд итгэж үнэмшихийг хялбаршуулав.

Түүнийг эцэг эхгүй үлдээснээрээ боловсролыг нь өөрийнх хүчит гартаа авсан ба хамгийн сайхнаар хүмүүжүүлсэн байдаг. Хүчгүй ба аргагүйдлийн хамгийн томыг Түүнд амсуулаад, хүмүүст халамж, энэрэл ба тусламж үзүүлэх талаар оргилд өгсөхийг нь хүсэв.

Хайрыгаа мунхаглалын бүх төрлийн муу муухайнаас хамгаалж амьдралын хуудсанд өчүүхэн ч толбо хийилгээгүй ба ёс суртахууны төгс төгөлдрийг түүнд илрүүлэв.

Хүмүүс Түүнийг үнэнч, итгэмжтэй, шударга, энэрэлт, өгөөмөр зангаар нь, оюун ухаан мэтийн давуу талаар нь таньсан, бүх төрлийн ажилдаа Түүнд итгэсэн байв. Аллах Таала сайн сайхан бүхнийг, хамаг давуу авъяасыг Түүнд цуглуулав. Дайсад нь ч Түүний сайхан ёс суртахууныг үгүйсгэж чадаагүй. Түүнчлэн вахий ба номлох үүрэг ирэхээс өмнө Түүнд **эл-Эмин** нэрийг өөрсдөө өгсөн байв. Хорвоогийн Хүндэт Эзний маань Каба дахь шүүгч болсон нь ч Түүний Курайшийн ахмадуудын хооронд ээлсэн шилмэл байрыг нээлттэй илхүүлнэ. Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийг ярихад үгийнх нь зөв байснаас, хамт ажил хийвэл ёс суртахууны сайхан байснаа, тусламж гуйх юм уу Түүнд итгэвэл дотно сэтгэлээс нь хэзээ ч сэжиглэхгүй байв.

Аллах Таала Түүнийг ааш зангаар нь хамгийн төгс хүн болгож туурвисан ба амьдруулсан юм. Учир нь Тэр хамаг хүн төрөлхтөнд сайхан нэгэн үлгэр жишээ байх болоод тэднийг авралтын замд залах байв. Хүмүүс бол орон суудлаас байтугай хүний занд илүү дурлана. Суутнуудыг хүндэтгэнэ, гэтэл зөвхөн агуу зантай хүмүүсийг л дагаж явна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ



Номлол, Маккагийн Эрин

Номлол, Маккагийн Эрин

Вахийн Эхлэл: Зөнч Зүүднүүд

Орчлонгуудын бий болох учир Пайгамбар Эзэн маань шилмэл залуу үе ба гэр бүлийн жишээ амьдралаар толилуулсан шилдэг төгс төгөлдрийн араас дөчин настай байхдаа номлогчийн төвшинд хүрэв. Дөчин наснаас зургаан сар дутуу байхад, тэнгэрлэг хүч Түүнд Макка дахь Хира Агуйг ариун нэгэн сургууль болгож нээв.

Тэнгэрлэг сургаал ном, дэвтэр ба үзэггүйгээр хэрэгжсэн боловсрол ба эрдмийн хичээлийн уг тэнхимд, Пайгамбар Эзэн маань Рабтайгаа зөвхөн тэдний хооронд мөнхийн нууцтай хичээл үзэв. Тэнгэрлэг вахийд бэлдэв.

Уг бэлтгэлийн анхны зургаан сарын шат, бидний оюун ухаанд багтсан талаар "үнэнч зүүднүүд" буйгаар хэрэгжив. Өөрөөр хэлбэл Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- зүүдэндээ юу харсан ч тэр нь тэр чигээрээ хэрэгжиж байв. Хазрат-и Аиша -радъяллаху анхаа- ингэж айлдана:

"Хүндэт Элч Эзэнд маань ирсэн вахий нь унтахад зөнч зүүдээр эхлэв. Түүний харсан зүүд бүр нь өглөөний гэрэл шигээ ил тод хэрэгждэг байв." (Бухарий, Бэд'ү'л-Вахй, 3)

Номлох нь маш том ба хүнд үүрэг буй тулд, Пайгамбар Эзний маань уг чухал үүрэгтээ бэлдэх төлөө Жэбраил -алэйхиссэлам- Түүнд эхлээд зүүдэнд нь хүрч эхлэв.

Алкама бин Кайсын дамжуулснаар, пайгамбарчуудад илгээсэн мэдээ, тушаал ба хоригууд, тэдний зүрхийг тайвширтал эхлээд зүүдээр хүргэг, дараа ч вахий болгож буулгадаг аж.[112]

Ийм учраас пайгамбарчуудын вахий авах аргын нэгэн ч зүүд мөн. Үүнд, Ибрахим -алэйхиссэлам-ын ает-и кэримэд мэдүүлсэн:

يَا بُنَيَّ اِنّ۪ٓي اَرٰى فِي الْمَنَامِ اَنّ۪ٓي اَذْبَحُكَ فَانْظُرْ مَاذَا تَرٰى

“…Хүү минь! Зүүдэндээ чамайг төхөөрснөө харж байна; нэг бод, чи юу гэх вэ?..” (эс-Саффат, 102) гэсэн үг нь баталгаа мөн.

Гэхдээ, пайгамбарчуудын нүд унтана, зүрх нь унтахгүй.[113] Тийм учраас тэдний зүүдэндээ ч вахий авахад ямар ч саад байдаггүй.

Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм- дараа нь зөнч зүүдний тухай; *“номлохын дөчин зургааны нэг юм...”* хэмээв. (Бухарий, Табир, 26; Мүслим, Рүяа, 6)

Үнэхээр зургаан сарын хугацаа, хорин гурван жил явсан нь номлох -хугацаагаараа- дөчин зургаа болох юм.

112. Ибн-и Кэсир, *эл-Бидая,* III, 55.
113. Бухарий, Мэнакиб, 24.

Номлохын Анхны Гурван Жил:
Далд Урих Эрин

Анхны Вахий ба Вахий Тасарсан нь

Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- дөчин настай байв. Вахий хандах сүнсний боловсролд хүрэхийн тулд өнгөрөөсөн бэлтгэлийн зурган сарын хугацаа нь дууссан байв.

Ариун Рамазан сарын 17ны өдөр байв.[114] Хүндэт Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- Эзэн маань хэвээрээ Хира Агуйд байв. Жэбраил -алэйхиссэлам- ирээд Хазрат-и Пайгамбарт:

“–Унш!” гэв.

Пайгамбар Эзэн маань:

“–Би уншиж мэддэггүй!” хариултыг өгөв.

Тэгэхлээр нь мэлэк нь Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийг хүчгүй байтал нь шахав. Дараа нь дахиад:

“–Унш!” гэв.

Хорвоогийн Хүндэт Эзэн маань дахиад:

“–Би уншиж мэддэггүй!” хариултыг өгөв.

114. Ибн-и Са’д, I, 194.

Жэбраил -алэйхиссэлам- хоёр дахь удаа Түүнийг хүч нь тасартал шахав. Дараа нь дахиад:

“–Унш!” гэв.

Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм- дахиад:

“–Би уншиж мэддэггүй! Юу унших вэ?” гэв.

Жэбраил -алэйхиссэлам- нь Оршигчийн Туяаг гурав дахь удаа шахаж шаардав. Араас нь тэнгэрлэг вахийг Түүнд ингэж мэдүүлэв:

اِقْرَاْ بِاسْمِ رَبِّكَ الَّذِي خَلَقَ خَلَقَ الْاِنْسَانَ مِنْ عَلَقٍ اِقْرَاْ وَرَبُّكَ الْاَكْرَمُ اَلَّذِي عَلَّمَ بِالْقَلَمِ عَلَّمَ الْاِنْسَانَ مَا لَمْ يَعْلَمْ

“Туурвисан Раббынхаа нэрээр унш! Тэрээр хүнийг таримал эснээс **туурвив. Унш, Раб чинь дуусашгүй баялгийн эзэн мөн. Тэрээр үзгээр бичихийг сургав. Хүнд мэдээгүй зүйлсийг сургав.”** (эл-Алак, 1-5)

Тус тэнгэрлэг тушаалаар Аллахын Элчийн өмнөөс хамаг хүн төрөлхтөнд Раббын хамгийн том бэлэг буй Кур’ан-и Кэрим бууж эхлэв.

Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм- тэнгэрийн үүднүүдээс дэлхийд энэрэх ба анагаахаар бууж эхэлсэн Кур’ан-и Мүбинээс анх эдгээр аетуудыг ухаарав. Жэбраил -алэйхиссэлам-ыг салаад явахлаар нь вахийн хүчинд зүрх нь чичирч Хазрат-и Хатижа эхийн маань дэргэд очиж:

“–Намайг нөмөргөж ороогоорой; Намайг нөмөргөж ороогоорой!” хэмээв.

Хэсэг хугацаа амарсны дараа болсон явдлаа, хамт хүн төрөлхтөнд үлгэр жишээ гэр бүл байгуулсан Хатижатү’л-Күбра эхэд яриад, зовнилтойгоор:

“–Еэ Хатижа минь! Одоо надад хэн итгэх вэ?” гэв.

Тэр ариун гэргий Оршигчийн Туяа Эзэндээ:

“Аллахад тангараг өргөе, Аллах -жэллэ жэлалүхү- Чамайг хэзээ ч ичээхгүй. Учир нь Чи садан хамаатнаа хамгаалж, ажлаа хийх чадваргүйчүүдийн ачааг ачиж, ядууд тарааж, хэнийг ч хийхгүй чинээ сайн үйл хийж, зочноо дайлж, Эрхийн учирт илэрсэн хэргүүдэд (хүмүүст) тусална...

Аяа Аллахын Элч ээ! Чамайг эхлээд би хүлээн зөвшөөрнө. Аллахын замд эхлээд намайг л урь!” гээд Түүнийг анх батлан дэмжигч болов.

Өөрөөр хэлбэл Хазрат-и Хатижа эх маань нэг төрлийн Түүнд тайвшруулан энгийн яриагаар:

“–Сайн сайхан нь зөвхөн сайн сайхныг авчирна! Сайхан үйлсийн хариу сайхнаас өөр юу болох вэ!” гэж байв.

Ингэхдээ Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн цэвэр шилдэг саруул нэгэн ирээдүйн мэдээлэгч байх учраар үнэлж байв. Энэ тухай Аугаа Эрх ч ингэж айлдана:

هَلْ جَزَاءُ الْإِحْسَانِ إِلَّا الْإِحْسَانُ

“Сайн сайхны хариу нь сайн сайхан л биш үү?” (эр-Рахман, 60)

❁

Үүний дараа Хазрат-и Хатижа -радъяллаху анхаа- Хүндэт Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийг дагуулан авга ахынхаа хүү Варака бин Нэвфэл дээр очив.

Варака бин Нэвфэл нь мунхаглалын үед баримал шүтсэнгүй ховор ба шилдэг хүмүүсийн нэг байв. Христийн шашинд орсон байв. Еврей хэл мэдэж, Инжилээс бичиж бичдэг байв. Нэлээд насалсан тул нүд нь харахааргүй болсон байв. Хазрат-и Хатижа эх маань түүнд:

"–Авга ахын хүү! Үүнийг сонс оо; чиний дүүгийн хөвүүн юу ярьж байна?" гэв.

Тэгэхлээр нь Варака сонирхон:

"–Юу болоо вэ, миний дүүгийн хүү?" гэж асуухлаар нь Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- харсан хэргийг түүнд мэдээлэв.

Сонссоноосоо төгсгөл үеийн хамгийн агуу үнэнийг ухаарсан Варакагийн царай эхлээд мишээж гялалзав; дараа ч гүн бодолд автаж тайвширч:

"–Чиний энэ харсан нь Аллах Таалагийн Мусад илгээсэн Намус-и Экбэр (Жибрийл) мөн. Яахав Чиний урилгын өдөрт би залуу байсан болъё! Чиний ард чамайг нутгаас чинь гаргахад амьд байсан болъё!" гэв.

Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- андууран:

"–Тэд намайг нутгаас хөөх юм уу?" хэмээн асуув. Тэр ч:

"–Тийм! Учир нь чиний авчирсан шиг шашин авчирсан пайгамбар бүр нь дайсан ба өстөний хариуд автаж нутгаасаа хөөгдсөн байдаг. Хэрвээ Чиний урилгын өдөрт хүрвэл би Чамд маш их тусална," хариуг өгөв.

Уг ярианаас их удалгүй Варака өөд болов. Вахий ч фэтрэт үед орсон буюу хэсэг хугацаагаар тасрав. (Бухарий, Бэд'ү'л-Вахй 1, Энбияа 21, Тэфсир 96; Мүслим, Иман 252)

Аллах Таала дараа буулгасан ает-и кэримэчүүдэд Элчдээ хандан ингэж айлдав:

وَكَذٰلِكَ اَوْحَيْنَآ اِلَيْكَ رُوحًا مِنْ اَمْرِنَا مَا كُنْتَ تَدْرِي مَا الْكِتَابُ وَلَا الْاِيمَانُ وَلٰكِنْ جَعَلْنَاهُ نُورًا نَهْدِي بِهٖ مَنْ نَشَآءُ مِنْ عِبَادِنَا وَاِنَّكَ لَتَهْدِيٓ اِلٰى صِرَاطٍ مُسْتَقِيمٍ

“Ингэж Чамд тушаалтайгаараа Жэбраилыг илгээв; Кур’аныг вахий хийв. Чи ном нь юу, иман нь юу гэдгийг мэддэггүй байв! Харин Бид түүнийг боолчуудаас хүссэнээ зөв замд оруулсан нэгэн туяа болгов. Андашгүй нь Чи зөв замыг заадаг!” (эш-Шура, 52)

اِنَّآ اَوْحَيْنَآ اِلَيْكَ كَمَآ اَوْحَيْنَآ اِلٰى نُوحٍ وَالنَّبِيّٖنَ مِنْ بَعْدِهٖ

“Бид Нухад ба түүний дараах пайгамбаруудад вахий хийсэн шигээ Чамд ч вахий хийв...” (эн-Ниса, 163)

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-д ирсэн анхны вахийн анхны үгийг **“Унш!” гэж** байсны улмаас үүнийг сэтгэлийн хүмүүс ингэж тайлбарлав:

“Унш! Бүх юмыг унш! Аллахын номыг унш! Аллахын аетуудыг унш! Орчлон хэмээх номыг унш! Байнга унш! Авралтад хүрэх, мунхаглалаас холдохын тулд унш! Итгэл үнэмшлээ бүтээхийн тулд унш! Аллахын нэрээр унш! Туурвисан Раббынхаа нэрээр унш! Хүнийг элэгшсэн цусаар туурвисан ч түүнд бүх юмыг унших, гийгүүлэх, ойлгох ба ойлгосноороо амьдрах боломж олгосон агуу Раббынхаа нэрээр унш! Хүнд унших шимийг хайрлан хамгийн том бэлэг олгосон Аллахын нэрээр унш! Мэдэхийн төлөө унш! Үсэг бичгийн хорвоод зур-

сан мөр бүрийг унш! Хүнд дуугүй юмыг сургасан Аллахын нэрээр унш!”

Энэ тухай Мэвлана Хазрат нь ил номыг уншсан эринийхээ төлөө **“би түүхий байв”**; орчлонгийн нууцыг унших эринийхээ төлөө **“буцлав”**; тэнгэрлэг нууцыг уншиж түүний халуунаар бараг хуурагдсан учраас ч **“шатав”** гэсэн үгсийг хэрэглэж өнгөрөөсөн сүнсний шатуудыг илэрхийлэв.

Ает дахь **“унш”** хэмээсэн тушаал нь хэт чухал байдаг. Гэтэл уг уншихыг **Аллахын нэрээр** болох нь ч тэр чинээ чухал байдаг. Учир нь “унш” тушаалыг хэр дагахыг тайлбарладаг юм.

“Унш” хэмээсэн тушаал нь зөвхөн ил унших тушаал биш, зүрхний цэвэрлэгээ ба засварын үр дүнгээр ном ба эрдмийг авагч болох нь юм. Түүгээр илрэгчдийн ухаарч буй зүрхээр бүх юмыг уншиж чадахыг илэрхийлдэг. Өөрөөр хэлбэл орчлонгийн нэг ном болох нь, зүрхний орчлонгийн хуудсыг эргүүлэн тэнгэрлэг нууцыг уншиж чадах нь, товчоор нь хүний орчлонг, өөрийгөө, Кур’ан-и Кэримийг унших, ухаарах ба амьдрах нь мөн.

Анх буусан уг ает-и кэримэчүүдээс ийм дүгнэлт гаргах нь ч боломжтой:

Хамаг ажлаа Аллахын нэрээр эхлэх хэрэгтэй.

Элэгшсэн цусаар туурвиж хамгийн гоё дүрсэнд оруулсан хүн нь тэнгэрлэг хүчний өмнөх хүчгүйдлээ хэзээ ч мартах ёсгүй юм.

اَلَّذِي عَلَّمَ بِالْقَلَمِ عَلَّمَ الْاِنْسَانَ مَا لَمْ يَعْلَمْ

“Үзгээр бичихийг ба хүнд мэдээгүй юмыг сургасан” (эл-Алак, 4-5) аетуудад хүн шинжлэх ухааны чухлыг мэдээлж, түүнчлэн

хүний мэдсэн хамаг юмыг Аугаа Эрхийн сургасныг, үүний тэнгэрлэг нэгэн бэлэг гэдгийг зааж байдаг.

Тэгэхээр хүн төрөлхтөн нь Раббынхаа аугаа шинжийг байнга ухаандаа байлгаж, хэзээ ч ач тус санах ёстой байдаг.

❁

анхны вахийн дараа удаан хугацаагаар вахий ирээгүй. Энэ нь нэг талаар Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- ийн дараалалтай ирэх вахийнуудад сайхан бэлдүүлэхийн төлөө байв. Учир нь вахийг ухаарах нь маш гайхамшигт нэгэн үүрэг байсан тул, түүнийг амархан гүйцэтгэх боломж байгаагүй. Энэ тухай Аугаа Эрх:

إِنَّا سَنُلْقِي عَلَيْكَ قَوْلًا ثَقِيلًا

“Үнэндээ Бид Чамд хүргэхэд **хэцүү нэгэн үг өгнө,”** (эл-Мүззэмбил, 5) ает-и кэримэтэйгээр үүнийг зарлав.

Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- зөнч зүүднүүдийн араас гэнэтхэн вахийн мэлэкийн өөдөөс харангаа сандарсан байв. Хазрат-и Хатижагийн тайтгаруулсан ба Варакагийн баталснаар сэтгэлд нь ханамж мэдрэгдэв. Одоо Тэр, вахий дахиад эхлэхийг чин сэтгэлээрээ хүсч, тэсэн ядан хүлээж байв. Заримдаа анхны вахий ирсэн Хира Ууланд гараад тэнгэрлэг вахийг хүлээж байв.

Эдгээр фэтрэт буюу таслалтын өдрүүдэд Түүнд хамгаас илүү түшиг болсон нь Хазрат-и Хатижа эх маань байв. Ийм л учраас Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм- түүний сүнсний гүн, харийн ба эелдэг байдлын хэзээ ч мартаагүй. Хазрат-и Хатижа өөд болсны дараа нэгэн тахил барихаар болбол, нэгэн хэсгийн нь байнга түүний садан хамаа-

танд илгээдэг байв. Тэр нь бүх талаараа Аллахын Элчийн хүндэт ба мартагдашгүй нэгэн дурсаж байв.

❁

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн амьдрал нь өнгөрсөн пайгамбарчуудад заяа болоогүй мөрөөдлийн цаадах хүндэтгэлийн олон үзэмжээр дүүрэн байдаг. Аллах -жэллэ жэлалүхү- “Хабиб минь” буюу Хайр минь гэж зөвхөн Түүнд л хандсан байдаг. Мираж буюу огторгуйн оргилд очих нь пайгамбарчуудын дундаас зөвхөн Түүнд л заяасан байдаг.

Түүний түгээмэл бэлгэ нь Мэсжид-и Аксад хамаг пайгамбаруудад имам хийснээр нь тодруулав. Муса -алэйхиссэлам-дахь “لن تراني” нууц нь Түүнд “قاب قوسين أو أدنى” буйгаар илрэв.[115]

115. “لن تراني: **Намайг хэзээ ч харж чадахгүй!”** (эл-А’раф, 143)**:** Муса -алэйхиссэлам- Тур-и Синад Аллах Таалатай уулзах өмнө бэлтгэлийн үед оруулав. Гучин хоног мацаг бариад, үүнд арав нэмээд дөчид хүргэв. Энэ нь нэфсийн амьдралаас тусгаар гараад Аллахтай хийх уулзалтдаа бэлтгэл байв. Аугаа Эрх нь Муса -алэйхиссэлам-тай хэл эсвэл дуу мэтийн бодит аргаар биш, эртгүй өнгөрсний кэлам бэлгээрээ л ярив. Хазрат-и Мусагийн дэргэд гэрч болохоор авчирсан далан хүн ба Жэбраил -алэйхиссэлам-энэ тэнгэрлэг яриаг дуулаагүй ба мэдрээгүй. Муса -алэйхиссэлам- нь ийм тэнгэрлэг илрэлээс болж ухаан балартав. Дэлхийд эсвэл ахиратад байх эсэхээ мартаад цаг ба орноос гадаа гарав. Аугаа Эрхийн махбодийг харахаар дотуур нь том нэгэн хайр, бишрэл ба хүсэл төрөв. Харин Аугаа Эрхээс: **“Лэн тэрани”** тэнгэрлэг зарлиг илрэв. Муса -алэйхиссэлам-тэнгэрлэг махбодийг харахаар, оюунгүйгээр олон дахин хэлэхлээр нь, Аугаа АЛЛАХ нэгэн улаанд илрэхээ, хэрэв уул нь дийлж чадвал Түүнд ч харагдахаа мэдээлэв. Дамжуулсан яриагаар Аугаа Эрхийн махбодиос нэгэн туяаг нь шүүрч ууланд тусангуут, уул нь тэсрэв. Ийм аймшигтай үзвэрт Муса -алэйхиссэлам- ухаан балартав. Сэрэхдээ хилээ давсандаа Аугаа Эрхийг тэсбих хийж өршөөл гуйв.

Кур’аны энэ туульсаас ийм үр дүн хураах болно: Энэ хорвоод Аллахын махбодийн илрэхэд дийлж чадах газар байдаг үгүй. Энэ шинж нь уулын өөдөсний өөдөс ч үлдэхгүйгээр тэсэрч тогтсон байдаг. Аугаа аллах махбодиороо нууц, бэлгэ тэмдгээрээ ил юм. Ийм л учраас, Кур’ан-и Кэрим нь итгэгчдийг тайлбарлахдаа олон дахин “الذين يؤمنون بالغيب” буюу **“Тэд нууцад итгэдэг,”гэсэн** тэнгэрлэг томьёог хэлдэг.

Эрхтэй учрах цаг буй мөргөл нь үммэтэд ч сэтгэлийн оронд үзэх нэгэн мираж болохоор бэлэглэв. Түүнчлэн мөргөл нь эхлээд тавин удаа тушаасан байхад, Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн гуйснаар Мухаммедийн үммэтэд таван удаа болгож фарз болгов.

Өнчин ба үммий байсан Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм- тэнгэрлэг боловсролоор хамаг хүн төрөлхтөнд удирдамж, нууц хорвоогийн үнэний орчуулагч ба үнэний сургуулийн багш болж ирэв. Зияа Жанжины хэлснээр:

Нэгэн сургуульд элсэв
Аллах Түүнд багшлав

Хазрат-и Муса -алэйхиссэлам- зарим дүрэм журам авчирсан байв. **Хазрат-и Давуд** -алэйхиссэлам- Аллахад залбирах ба ерөөлийг залах талаар шилдэг байв. **Хазрат-и Есүс** -алэйхиссэлам- хүмүүст төгс ёс суртахууныг, дэлхийгээс зүрхээрээ салах ба зүхдийг сургахаар томилогдсон байв. Исламын Пайгамбар **Хазрат-и Мухаммед Мустафа** -саллаллаху алэйхи вэ сэллэм- бол эдгээр бүхнийг авчрав. Дүрэм журам авчрав. Нэфсийг засч тун-

Өөр нэгэн үнэн бол Аугаа аллах махбодийн илрэхэд хүний ухаан дааж чадахгүй нь юм. Энэ шинж ч Муса -алэйхиссэлам-ын ухаан балартсанаар тогтсон байдаг. Үүнээс харвал манай хорвоод “махбодь илрэх” үгүй. Энэ үнэн нь махбодь илэрснийг мэдэхэд хүн ба сүнсний ухаан хүрдэггүй учиртай юм.

“قاب قوسين أو أدنى: **хоёр нумын зайгаар эсвэл түүнээс ч бага** (зайтай)” (эн-Нэжм, 9)**:** Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм- Мираж Шөнөд Жэбраил -алэйхиссэлам-ыг агуулсан ямар ч оршигчийн хилийг огт давж чадаагүй Сидрэ-и Мүнтэхагаас цааш гатлуулав. Аетаар хүний ухаанд **“нэгдсэн хоёр нумын зайгаар эсвэл түүнээс ч бага** (зайтай)” хэмээн мэдээлсэн шинжээр, боолчуудын ойлгох балархай ба нууц нэгэн уулзалт хэрэгжив.

Эдгээр Хазрат-и Муса ба Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм-д хандсан хоёр том илрэлийн манай ухааны төвшинд буулгасан илэрхийилэлт л мөн.

галаг эрүүл зүрх ба амрагийн зүрхээр Аллахад залбирахыг сургав. Хамгийн сайхан ёс суртахууныг зааж өгөөд амьдралаараа тус ёс суртахууны үлгэр жишээ болов. Дэлхийн хуурамч гоо сайханд автахгүйг зөвлөв. Товчоор хэлбэл хамаг пайгамбаруудын мэдэл ба үүргийн бүхлийг бие болон үйлсэндээ цуглуулав. Угсаа ба хүмүүжлийн язгуур, гоо сайхан ба төгс төгөлдрийн жаргал, бүнд Түүнд хураагдсан байв.

Түүний дөчин нас хүрсэн нь андашгүй хүн төрөлхтний түүхийн эргэлтийн нэгэн цэг болов. Дөчин жил мунхаглалын харанхуйд автсан нэгэн нийгэм дотор амьдрав. Дараа илрүүлэх гоо сайхны ихэнхийг ард түмэн нь арай мэдэхгүй байв. Нэгэн улс төрийн хүн, үг хэлэгч эсвэл номлогчоороо таньдаггүй байв. Цэргийн том нэгэн дарга байсны дурдахаас байтугай, энгийн нэгэн цэргийн гавьяа ч байгаагүй.

Өнгөрсөн улс ба пайгамбаруудын түүхийн, киямат өдрийн, диваажин ба тамын тухай ярьсан удаагүй байв. Зөвхөн өөрийнх буйгаараа агуу нэгэн ёс суртахуунаар шилмэл амьдрал авч явдаг байв. Гэтэл Хира Агуйгаас тэнгэрлэг заавраар харихдаа иж бүрэн өөрчлөгдсөн байв.

Вахийн Үнэн ба Ирэх Аргууд нь

Вахий нь хурдан дохио, бичвэр, элчлэл, онго ба нууц үг мэтийн зарим утга агуулдаг. Аллах Таалагийн хүссэн юмаа пайгамбарчууддаа, хүссэн аргаар мэдээлсэн нь энэ юм. Аугаа Аллах ингэж айлдана:

وَمَا كَانَ لِبَشَرٍ اَنْ يُكَلِّمَهُ اللّٰهُ اِلَّا وَحْيًا اَوْ مِنْ وَرَآئِ حِجَابٍ اَوْ
يُرْسِلَ رَسُولًا فَيُوحِيَ بِاِذْنِهِ مَا يَشَآءُ اِنَّهُ عَلِيٌّ حَكِيمٌ

“Аллах хэн нэгэнтэй вахий аргаар эсвэл хөшгийн араас л ярина. Эсвэл нэгэн элч илгээж зөвшөөрлөөрөө түүнд хүссэнээ вахий хийнэ. Андашгүй нь Тэрээр маш агуу, мэдэл ба шийдвэртэй мөн.” (эш-Шура, 51)

Хазрат-и Аиша -радъяллаху анха-шийг дамжуулснаар Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ээс:

“–Аяа Аллахын Элч ээ! Чамд вахий яаж ирдэг вэ?” нэж асуухлаар нь ингэж айлдав:

“–Тэр заримдаа бяцхан хонхыг дуу шиг ирдэг бөгөөд вахийн надад хамгийн хэцүү санагдах арга нь энэ мөн. Аллах Таалагийн айлдсаныг ухаарч цээжилсний дараа мэлэк надаас сална. Заримдаа ч мэлэк надад хүний төрхөөр ирнэ. Надтай яриад, хэлснийг би шууд ойлгоно.” (Бухарий, Бэд’ү’л-Вахй, 1/2; Мүслим, Фэдаил, 87)

Исламын эрдэмтэд янз бүрийн дамжуулалтад хандан вахий ирэх аргуудыг ингэж ангилуулав:

1. Вахий нь заримдаа нойронд харагдаж, харагдсанаараа хэрэгжсэн зөнч зүүд шиг ирдэг байв.

2. Вахий хийх үг нь, мэлэк харагдалгүй Пайгамбар -алэйхиссалатү вэссэлам-ын зүрхэнд оруулдаг байв.

3. Вахийн мэлэк нь “Жибрийлийн Хадис”анд[116] болсон шиг хүний төрхөнд ороод вахий хийх юмаа мэдээлдэг байв.

116. Нэгэн өдөр Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм- Эзэн маань мэсжидэд байхад Жэбраил -алэйхиссэлам- хүний төрхөд дэргэд нь ирээд Иман, Исам, ихсан ба кияматын тэмдгийн тухай асуулт асуусан байв. Ингээд Асхаб-и кирамын шашнаас гарч авахыг хүссэн байв. Ийнхүү байдлыг ярьсан хадисыг “Жибрийлийн Хадис” гэсэн байдаг. (Хар. Бухарий, Иман, 37; Мүслим, Иман, 1, 5)

Абдуллах бин Аббас -радъяллаху анхүма-гийн дамжуулсан энэ үг ч вахийн хэрэгжих аргын сайхан нэгэн жишээ юм:

“Аав Аббастайгаа хамт Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн дэргэд байлаа.

Аллахын Элч -алэйхиссалатү вэссэлам-ын дэргэд нэгэн хүн байсан бөгөөд Эзэн маань түүнтэй шивнэлцэж байв. Ийм учраас миний аавд хандаагүй. Хажуугаар нь гарахдаа аав минь:

«–Миний хүү! Аллахын Элчийн надад хандаагүйг хараа биз дээ?» гэв. Би ч:

«–Аав аа! Хажууд нь нэгэн хүн байж, түүнтэй ярьж байв,» гэлээ.

Тэгэхлээр минь шууд Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн дэргэд очлоо. Миний аав:

«–Аяа Расулаллах аа! Би Абдуллахад ингэж хэлсэн, тэр ч Таны дэргэд нэг хүнтэй шивнэлцэж байсныг хэлэв. Үнэхээр таны дэргэд хэн нэгэн байв уу?» гэв.

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- надад хандан:

«–Яа Абдуллах! Чи түүнийг хараа юу?» хэмээн асуув.

Би:

«–Тийм! Харсан,» гэлээ.

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- Эзэн маань:

«–Тэр Жэбраил байв. Ийм л учраас чамтай ярилцаж чадаагүй,» хэмээв.” (Ахмад, I, 293-294; Хэйсэмий, IX, 276)

4. Вахий заримдаа ч айхтар хонхны дуу шиг ирдэг байв. Вахийн байдал өнгөрөхлөөр, Пайгамбар Эзэн маань мэлэкийн хэлсэн юмыг сайхан сурсан байх болов.

5. Жэбраил -алэйхиссэлам- хоёр удаа вахийг жинхэнэ төрхөөрөө авчрав. Эдгээрээс нэг дэх нь фэтрэт эриний араас Пайгамбар Эзнийг маань Хира Агуйгаас бууж байхад, хоёр дахь нь бол Мираж Шөнөд Сидрэ-и Мүнтэхад хэрэгжив.

6. Аллах Таала нь Миражид болсноор хооронд вахийн мэлэк болохгүйгээр тэнгэрлэг хүлээн авалтад хүртүүлж Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-д шууд хандсан удаатай.

7. Жэбраил -алэйхиссэлам- Аллахын Элчид унтаж байхад вахий авчрав. Зарим мүфэссирчүүд Кэвсэр Сура ингэж буусныг илэрхиилнэ.

Асхаб-и кирамаас заримын ярьснаар вахийг бууж байхад Пайгамбар Эзэнд маань хэцүү нэгэн төвөг илэрч, царайг нь сарнай шиг ягаарч, нүдээ аниад, толгойгоо бөхийлгөдөг байв. Асхаб нь толгойгоо бөхийлгөдөг байв. Вахийн байдлыг дуустал аль нь ч толгойгоо өндийлгөж Орчлонгийн Хүндэтийн гоо сайхныг харж чадахгүй байв.

Заримдаа вахий ирэхэд дэргэд нь зөгийн хүнгэнэх чимээ шиг дуу сонсгодог байв. Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- нь тэр хооронд хурдан хурдан амьсгаа авдаг байв. Хамгийн хүйтэн өдөрт ч духнаас нь сувдан ширхэг шиг хөлс дусалдаг байв.[117]

117. Бухарий, Бэд'ү'л-Вахй 1/2, Үмрэ 10; Мүслим, Фэдаил 87, Худуд 13; Тирмизий, Тэфсир 23/3173; Ахмад, V, 327.

Вахийн нарийн бичигчдээс Зэйд бин Сабитын[118] мэдээлснээр ирсэн вахийн хүнд нь буусан шийдвэрийн хүндтэй харьцаатай болдог байв. Өөрөөр хэлбэл буусан вахий шагнал эсвэл сайхан мэдээний шинжтэй байвал Жэбраил -алэйхиссэлам- хүний төрхөнд ирж, энэ бол Пайгамбар Эзэнд маань төвөг тусдаггүй байв. Гэтэл вахий нь тамлалтайгаар айлгах шинж агуулахад ч, аймшиг мэдээлдэг нэгэн хонхны дуу шиг ирдэг байв.

Вахий нь Аллахын Элчийг тэмээн дээр ирэхэд амьтан вахийн хүндийг тэсч чадахгүй, хөл нь нугалаад сөхөрдөг байв. Жишээлбэл Пайгамбар Эзэн маань Абда гэсэн нэртэй тэмээн дээрээ байхдаа Маида Сурагийн гуравдугаар ает нь бууж эхлэхлээр Абдагийн хөл хугарах дөхсөн, Аллахын Элч тэмээнээс буусан байв.[119]

Зэйд бин Сабит -радъяллаху анх- ингэж хэлнэ:

“Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн дэргэд сууж байлаа. Тэр хооронд Аллахын Элчид вахийн байдал оров. Өвдөг нь миний өвдөг дээр байв. Валлахи тэр мөч хүртэл Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн өвдөгнөөс хүнд

118. **Зэйд бин Сабит** -радъяллаху анх- нь Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн вахийн нарийн бичигчдээс нэгэн юм. Хүндэт Элч Эзнийг маань Мадинад нүүхэд Зэйд арван нэгэн настай нэгэн өнчин байв. Багадаа арван долоон сура цээжилсэн байв. Аллахын Элч түүнд Сири ба Еврей хэлийг сурахыг тушаав. Тэр ч дөч хонолгүй хоёр хэлийг ч сураад Хазрат-и Пайгамбар -алэйхиссалатү вэссэлам-ын Сири ба Еврей хэлтэй бичгийн ажлыг хариуцав. Түүний хийсэн хамгийн хүндэт ажлаас нэгэн хоёр сахабийгийн хамт Кур’ан-и Кэримийг цуглуулж ном болгосон нь юм. Хижрэтийн тооллын 45 онд Мадинад нас барав. Ерэн хоёр хадис-и шариф дамжуулав.

119. Ахмад, II, 176; VI, 445; Ибн-и Са’д, I, 197; Табэрий, *Тэфсир,* VI, 106.

юм мэдрээгүй байлаа. Бараг миний өвдгийг бяцарна гэж бодлоо." (Ахмад, V, 190-191)

❁

Кур'ан-и Хакимын тэнгэрлэг судар буйг үгүйсгэсэн мүшрикчүүд, вахийг Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн бодогширсноос зүрхэнд төрсөн онго байсан мэтийн зарим мухар санаагаар буруушаасан байдаг. Андашгүй нь тэдний оруулсан эдгээр саналуудыг тэдний зүрхний хайнга байдал, ухааны сул дорой байдал ба өшөө хорслын ширүүн байдлаас өөр юмаар тайлбарлахааргүй байдаг.

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн анхны вахийг ирэхэд мэлэкийг харангаа айсан нь, вахийн мүстэшрикчүүдийн санал болгосон шиг халусинацитай[120] холбох хүний дотор хорвоогийн хэрэг байгаагүйг ил далангүй илрүүлдэг. Угаасаа Хазрат-и Пайгамбарын вахийг авах нь өөрийнх нэфистэй хамаагүй, гадны нэгэн үнэнийг ухаарах нь мөн. Жэбраил -алэйхиссэлам-ын Аллахын Элчийг гурван удаа шахсан бөгөөд удаа бүрт "унш" гээд орхисон нь, вахийн дотно хорвоогоос биш гаднаас буюу Аллах Таалагаас ирснийг баталдаг.

Вахийг хэсэг хугацаагаар тасарсан нь ч түүний Пайгамбар Эзний маань гүн бодлын үр дүнгээр сүнсэнд бий болсон дотор нэгэн хэрэг гэсэн саналуудын хамгийн хатуугаар үгүйсгэдэг. Учир нь вахий тасарсан бөгөөд Пайгамбар Эзний маань удаан хугацаагаар вахийн дахиад ирэхийг хүлээсэн нь вахийн Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- Эзний маань мэдлийн бус бий болсон гадны нэгэн хэрэг байсныг үзүүлдэг.

120. **Галлюцинаци**: Францаар hallucination (санаархал). Сэтгэл зүйд: 1. Ихэнхдээ элий балай, паранойя мэтийн өвчтөнүүдэд илэрсэн ба мэдрэмжгүйгээр төрсөн санал. 2. Үнэндээ байдаггүй зүйлсийг бий юм шиг бодох.

Мөн Орчлонгийн Хүндэт -саллаллаху алэйхи вэ сэллэм- эхлээд өөртөө вахий ирэхийг мэдэхгүй байв. Ает-и кэримэ нь ингэж айлдана:

وَمَا كُنْتَ تَرْجُوٓا اَنْ يُلْقٰىٓ اِلَيْكَ الْكِتَابُ اِلَّا رَحْمَةً مِنْ رَبِّكَ فَلَا تَكُونَنَّ ظَهِيرًا لِلْكَافِرِينَ

“Чи уг Номын Чамд вахий болохыг найдахгүй байв. Энэбол **зөвхөн Раббаас чинь нэгэн энэрэл** болгож ирүүлсэн **мөн. Тэгвэл кафирчуудад хэзээ ч битгий тусал!”** (эл-Касас, 86)

Ает-и кэримэнүүд ба хадис-и шарифүүдийн хоорондын тодорхой ялгаа ч Кур’ан-и Кэримийн вахийн үр дүн байсны хамгийн хатуу баталгааны нэг юм.

Заримдаа Хазрат-и Пайгамбарын -саллаллаху алэйхи вэ сэллэм- яаралтай хариу өгөх ёстой болсон ч вахийг иртэл хойшилсон зарим тохиодол болж байв. Жишээлбэл “Ифк Байдал” болон еврейчүүдийн асуусан зарим хэргүүдэд болсон шиг. Орчлонгуудын Эзэн ийнхүү асуултын хариуг вахийгаар өөрт нь мэдээлсний дараа л өгч чаддаг байв. Хэрэв санал болгосны шиг Кур’ан-и Кэрим нь Пайгамбар Эзний маань оюун ухааны үр дүн байсансан бол, ийм нэгэн төвөгт авталгүй асуулыг шууд хариулсан нь хэрэгтэй болох байв.

Мөн түүнчлэн вахий нь заримдаа Аллахын Элчийн бодол алдаатай байсныг илэрхийлж, заримдаа ч Түүний хүсээгүй юмыг тушааж байв. Бас тэнгэрлэг тушаалыг мэдүүлэх талаар түр хоцорвол ширүүн үгсээр загнаж байв. Эдгээр бүхэн Кур’ан-и Кэримийн Пайгамбар Эзний маань оюун ухааны үр дүн байсан гэсэн саналын үндэсгүйг ил далангүй илрүүлдэг.

Жишээлбэл нэгэн өдөр Пайгамбар Эзэн маань -саллаллаху алэйхи вэ сэллэм- Курайшийн зарим хүндэт хүмүүст Исламыг ярьж байв. Тэр хооронд хажууд нь өмнө нь мусульман болсон сохор сахаби Абдуллах бин Үмм-и Мэктүм -радъяллаху анх- ирэв. Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- Эзэнд маань Аллахын Түүнд мэдээлсэн үнэнээс заримыг сурмаар байгаагаа хэлэв. Гэтэл уулзаж буй Курайшийн хүндэтчүүдийг ятгахаар оролдсон Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- түүнд анхаарал үзүүлж чадаагүй ба Ибн-и Үмм-и Мэктүмийн дахин дахин нэхсэний улмаас царайгаа жаахан ярвайлгав. Тэгсэнд нь уг тэнгэрлэг сануулга ирэв:

اَمَّا مَنِ اسْتَغْنٰى فَاَنْتَ لَهُ تَصَدّٰى وَمَا عَلَيْكَ اَلَّا يَزَّكّٰى

وَاَمَّا مَنْ جَٓاءَكَ يَسْعٰى وَهُوَ يَخْشٰى فَاَنْتَ عَنْهُ تَلَهّٰى

كَلَّٓا اِنَّهَا تَذْكِرَةٌ فَمَنْ شَٓاءَ ذَكَرَهُ

“Чамайг өөртөө хэрэгтэй гэж үзээгүй хүн ирвэл, Чи түүнд хандана. Харин түүний цэвэрлэж арилгах нь Чиний хариуцлага биш. Гэтэл Аллахаас **айгаад Чамайг ирсэн ч оролдохгүй байна! Үгүй** тэгж болохгүй; **энэ Кур’ан нь нэгэн сургаал мөн, хүссэн нь сонсч сургаал авна.”** (Абэсэ, 5-12)

Энэ ает буусны дараа Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- Ибн-и Үмм-и Мэктүмд олон сайхан үг ба идээ ундаагаар дайлсан байдаг. Түүнчлэн түүнтэй тааралдахдаа ч:

“Тухай нь Раббын намайг загнасан хүн, сайн байна уу!” хэмээв. (Вахидий, х. 471)

Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм-д тэнгэрлэг тушаал нь заримдаа мүжмэл[121] болж ирдэг байв. Аллах Таала тайлбарлаагүй байхад Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- Эзэн маань мүжмэл сэдвүүдийг өөрөө тайлбарладаггүй байв. Үүний жишээгээр уг аетийг дурдаж болно:

لِلّٰهِ مَا فِي السَّمٰوَاتِ وَمَا فِي الْاَرْضِ وَاِنْ تُبْدُوا مَا فِيٓ اَنْفُسِكُمْ
اَوْ تُخْفُوهُ يُحَاسِبْكُمْ بِهِ اللّٰهُ فَيَغْفِرُ لِمَنْ يَشَآءُ وَيُعَذِّبُ مَنْ يَشَآءُ
وَاللّٰهُ عَلٰى كُلِّ شَيْءٍ قَدِيرٌ

"Тэнгэрүүд ба газар дээр буй бүхэн Аллахынх мөн; дотор юмаа илрүүлсэн ч нуусан ч Аллах танаас түүний тооцоог асууна..." (эл-Бакара, 284)

Энэ ает-и кэримэг буухлаар, анзааралгүй зүрхэнд төрсөн санаанаас ч хариуцуулахаа бодсон асхаб-и кирам:

"–Аяа Расулаллах аа! Энэ аетыг бид яаж даах вэ?" гэцгээв.

Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм- хариулан:

"–Юу вэ! Эсвэл эхл-и китаб еврейчүүд ба христчүүд шиг «Сонссон харин эсэргүүцсэн!» гэмээр байна уу? Та «Сонсоод бууж өгөв. Аяа Раб маань! Биднийг өршөөхийг чинь гуйя, Чамд л буцна!» гэх ёстой!" хэмээв. (Мүслим, Иман, 200; Ахмад, I, 233; Вахидий, х. 97)

121. Мүжмэл: Утга нь товч ба далд бөгөөд тайлбарлахгүй байхад учир нь яг ойлгошгүй үгс юм.

Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- аетын утга мүжмэл байсан тул мэдэл нь хүрэлгүй, учрыг нь тайлбарлаж чадаагүй. Сахабагаас Аллахад бууж өгөөд итгэхийг нэхэв. Хэсэг хугацааны дараа доорх ает-и кэримэ буугаад, далд бай-сан утгыг ингэж тайлбарласан болов:

لَا يُكَلِّفُ اللّٰهُ نَفْسًا اِلَّا وُسْعَهَا لَهَا مَا كَسَبَتْ وَعَلَيْهَا مَا اكْتَسَبَتْ رَبَّنَا لَا تُؤَاخِذْنَآ اِنْ نَسِينَآ اَوْ اَخْطَاْنَا رَبَّنَا وَلَا تَحْمِلْ عَلَيْنَآ اِصْرًا كَمَا حَمَلْتَهُ عَلَى الَّذِينَ مِنْ قَبْلِنَا رَبَّنَا وَلَا تُحَمِّلْنَا مَا لَا طَاقَةَ لَنَا بِهِ وَاعْفُ عَنَّا وَاغْفِرْ لَنَا وَارْحَمْنَا اَنْتَ مَوْلٰينَا فَانْصُرْنَا عَلَى الْقَوْمِ الْكَافِرِينَ

“Аллах хэнээс ч илүү давуу юм шаардахгүй. Хүн бүрийн олж авсан сайн сайхан өөрийнх нь гавьяа, муу муухай ч өөрийнх нь алдаа. Та ингэж залбираарай: **Раб маань! Мартах буюу андуурвал бидэнд битгий хариуцуул! Раб маань! Бидэнд өмнөх шиг хүнд ачаа битгий ачаарай! Раб маань! Бидэнд хүч хүрэхээргүй юмыг битгий үүрүүл! Биднийг уучил, биднийг өршөө, бидэнд энэрэл үзүүл! Бидний аврал маань Чи мөн. Кафирчууд бидэнд тусламж үзүүл!”** (эл-Бакара, 286)

Асхаб-и кирам энэ ает-и кэримэгийн ачаар зүрхэнд төрсөн санааныхаа талаар “хүч хүрэхээр чинээ” хариуцахаа ойлгов.

Пайгамбар Эзэн маань -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн аетын мүжмэл байхад тайлбар нь иртэл ямар ч тайлбар хийгээгүй нь номлохын нэгэн үнэн байж, Кур’ан-и Кэримийн тэнгэрлэг үүсэлтэй буйн эсэргүүцэхээргүй өөр нэгэн баталгаа мөн. Эс тэгвээс нэг бол ийм мэдээ өгөхгүй эсвэл өгсөн мэдээ-лэлд шууд нэгэн тайлбар хийж мэдэх байв. Ийм нэгэн байдал

бий болсон нь Кур’ан-и Кэримийн гайхамшгийн өөр нэгэн заалт мөн.

Кур’ан-и Кэримийн нууцаас өгсөн мэдээлэл ч түүний тэнгэрлэг вахийн үр дүн буйн ил далангүй нэгэн баталгаа мөн.

Кур’ан-и Кэрим нь эрт дээр цагийн тухай өгсөн мэдээллийг ч үнэн зохимжтой ярьж өгдөг. Эдгээр мэдээллийн талаар VII зууны Маккад шинжлэх ухааны нэрээр нэгэн байгууллага эсвэл ерөнхий соёл эзэмшсэн ганц хүн байгаагүй. Түүхийн хамаг мэдээлэл нь наймаачдын алдаагаар дүүрэн домог болгосон нэг хэдэн Пэрс туульсаас цааш үгүй байв. Гэтэл Кур’ан-и Кэримд буй өнгөрсний тухай мэдээлэл нь бүтнээр харагдаж, хэн нэгэн хүний ухаан эсвэл таамгаар илрүүлэх төрлийн мэдээлэл байгаагүй юм.

Тэгэхлээр ухаантай хүн нь бодох хэрэгтэй: Мунхаг нэгэн нийгэмд гарсан үммий нэгэн хүн, тэнгэрлэг нэгэн үүслээс аваагүй байхдаа Кур’аны ижилгүй утгын булаг болж чадах уу? Энэ нь мэдээж хэзээ ч боломжгүй юм!..

Үүний ч зааснаар, Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн заасан хамаг мэдээлэл нь Аллахын онгоноос ирсэн юм.

Кур’ан-и Кэрим нь ирээдүйтэй холбоотой нууц мэдээлэл ч өгсөн, эдгээр ч цаг нь ирэх тусам Кур’аны мэдээлснээр бий болсон бөгөөд болсоор ч байдаг. Кур’ан-и Кэрим байнга түрүүлж, шинжлэх ухаан бол түүнийг дагаад л явдаг.

Жишээлбэл Кур’ан-и Кэримд дурдсан уг байдал, үүний жишээнээс зөвхөн нэг л юм:

Улаан тэнгисийн эргүүлгийн нэгэнд үйх шахан арайхийн итгэлийн чагтыг алдах шахсан Фаронд Аллах Таала:

آٰلْـٰٔنَ وَقَدْ عَصَيْتَ قَبْلُ وَكُنْتَ مِنَ الْمُفْسِدِينَ

“Одоо л итгэж байна **уу?! Харин чи үүнээс өмнө** дандаа **эсэргүүцэж, байнга өөр шалтгаан хайдаг байв!** Өөрөөр хэлбэл, ямар нэгэн гай тохиолдвол санаад, мэнд сайханд хүрэхээрээ дахиад мартдаг байв! Одоо ч тэр чигээр учраас одоо чиний итгэл үнэмшил хүчингүй юм!” (Юүнүс, 91) хэмээн айлдаж хэцүү байдлын итгэл үнэмшлийг хүлээн зөвшөөрөөгүй ба ингэж үргэлжлүүлэв:

فَالْيَوْمَ نُنَجِّيكَ بِبَدَنِكَ لِتَكُونَ لِمَنْ خَلْفَكَ اٰيَةً وَاِنَّ كَثِيرًا مِنَ النَّاسِ عَنْ اٰيَاتِنَا لَغَافِلُونَ

“Фарон! **Бид өнөөдөр чамайг** амьгүй нэгэн цогцос газарт хаягдаж өмхийрөхөөс **аварна, ингээд чи араасаа ирэгчдэд сурга-ал байх болно!** Гэтэл **хүмүүсийн ихэнх нь бидний аетуудыг үнэхээр ухаардаггүй.”** (Юүнүс, 92)

Зэмахшэрий нь уг аетыг ингэж тэфсирлэнэ:

“Бид чамайг тэнгисийн дэргэд нэгэн буланд хаяна. Шарилыг чинь бүтэн, дутагдалгүй, өмхийрөөгүй, нүцгэн чамайг олон зууны дараа ирэгчдэд нэгэн сургамж болгож хад-гална.” (Зэмахшэрий, III, 24)

Саяхан хийсэн судалгаагаар Фароны шарил тэнгисийн хөвөөнөөс бүрэн бүтнээрээ олдсон байдаг. Энэ түүний амьсгал хураахаас өмнөх сүүлийн мөч, Сүүлийн хоромд учирсан айдас-ны нөлөөгөөр итгэн үнэмшсэн, гэтэл аргагүй болсон учраас түүний иман хүлээн аваагүй юм. Ингээд ойролцоогоор гурван мянган жилийн турш шарил нь өмхийрөлгүй үлдсэн бөгөөд ает-и оэримэд илэрхийлснээр хүн төрөлхтөнд нэгэн сурга-

ал толилуулахаар өнөөдөр илэрсэн байдаг. Одоо уг шарилыг Бритиш Музейд толилуулаад байгаа. Энэ үнэн Аугаа Эрхийн Кур'ан-и Кэримд мэдээлсэн, киямат хүртэл үргэлжлэх гайхамшгийн зөвхөн нэг л юм.

Гэтэл Кур'ан-и Кэримийн гол зорилго нь тэвхидийг мэдүүлж хүмүүсийг авралд урих буй тул, ийнхүү гайхамшигт үнэнүүд буюу шинжлэх ухаан ба түүхийн үнэнүүд түүнд туслагч сэдэв юм. Үүнийг санаж байх хэрэгтэй:

وَعِنْدَهُ مَفَاتِحُ الْغَيْبِ لَا يَعْلَمُهَآ اِلَّا هُوَ وَيَعْلَمُ مَا فِي الْبَرِّ وَالْبَحْرِ
وَمَا تَسْقُطُ مِنْ وَرَقَةٍ اِلَّا يَعْلَمُهَا وَلَا حَبَّةٍ فِي ظُلُمَاتِ الْاَرْضِ
وَلَا رَطْبٍ وَلَا يَابِسٍ اِلَّا فِي كِتَابٍ مُبِينٍ

"...Нойтон, хуурай юу байсан ч бүгд нь мубийн буюу үнэнийг хуурамчаас ялгахаар илгээсэн **нэгэн номд байдаг,"** (эл-Эн'ам, 59) тэнгэрлэг зарлалаар бүх төрлийн үнэн түүнд орсон байдаг. Үүнээс үзвэл Кур'ан-и Кэрим нь орчлон дахь хамаг үнэний төгс төгөлдөр нэгэн яруу найраг бөгөөд хамаг үнэн түүнд нэгэн цөмөөр бий байдаг. Кур'аны гайхамшгийн хэргээр болсон уг байдал нь үйл явдлаар хөгжсөн ба хүмүүсийн ухаанд дэвшлийн харьцаагаар илүү сайн гийгүүлж ойлгосон болж мэднэ.

Хэрэв орчлонд Аллахын хэвшлээр хадгалсан уг мэдээлэл Кур'ан-и Кэримд товчоор биш, дэлгэрэнгүй болохсон бол, Кур'ан нь олон номын санг дүүргэх хэмжээнд хүрэх байв. Түүнчлэн хүн төрөлхтөн өөрийнхөө үед арай нээгдэж батлагдаагүй мэдээг хүлээн авахаар бэлэн байгаагүй тулд Кур'анд итгэх үнэмших нь киямат хүртэл хэрэгжихгүй болох байв. Нэгэн жишээ өгье гэвэл, цурагттай холбоотой үнэн нь өхөөдөр бидний мэдснээр тэр үед илэрхийлсэнсэн бол, цурагт

нь үйлээр нээгдэж тогтохгүй байхад хүмүүсийн ухаан түүнийг агуурахгүй, тийм учраас ч Кур'аныг үгүйсгэх байхсан. Хамаг үнэнийг дотроо агуулсан буй Кур'аны эдгээрийн том хэсгийг нууц үгсээр зарласны нууц учир нь ийм юм.

Кур'ан-и Кэрим дурдсан хамаг сэдвийг тэвхидийн зорилготой хамаатай оруулна. Шинжлэх ухааны үнэнийг дурдсан нь ч ийм хүрээнийх юм. Энэ шинж нь Кур'ан-и Кэримийн киямат хүртэл хамаг үе ба оронд үргэлжлэх тусгай нэгэн гайхамшиг бөгөөд түүний содныг мөч бүрт нээлт бүрээр дахиад батлаж байдаг.[122]

Кур'ан-и Кэрим болон Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн нэр алдрыг шингээж чаддаггүй зарим мүстэшрикчүүд нь Пайгамбар Эзний маань вахий авахдаа орсон байдлыг нь "унадаг өвчний хөдлөлт" байсныг хамгаалах шиг оюун ухаанаар тайлбарлахын аргагүй нэгэн саналыг илэрхийлсэн байдаг.[123] Ийм үндэсгүй саналд товчоор ингэж хариу өгч болно:

---

122. Энэ тухай жишээний төлөө хар: Осман Нури Топбаш, *Энэрлийн Сэвшээ,* Истанбул 2001, х. 184-239.

123. Юахийг хэрэгжиж байхад Пайгамбар Эзний маань байдалд илэрсэн ба дээр ангилсан өөрчлөлтөөс болж зарим үгүйсгэгчид үүнийг Эпилепси (унадаг өвчин) шиг ойлгосон ба энэ чигийн зарим санал илэрхийлсэн байцгаав. Эцэст нь ийм саналаа Хазрат-и Пайгамбарын сэтгэл мэдрэлийн өвчтэй байсны төвшинд хүргэж, үүнийг "Францын Үндэсний Анагаах Ухааны Академи"д батлуулахаар сэдвийг тэнд шинжлэх ухааны шүүх юм шиг шинжлэхээр болов. Энд эриний хамгийн алдарт эмч нараас бүрдсэн нэгэн хамт олон, 1842 онд саналыг шинжилж, анагаах ухааны хүрээнд ийм юм боломжтой огт болохгүйн тухай урт ба учиртай нэгэн тайлан нийлүүлэв. Үүний тухай дэлгэрэнгүй мэдээлэл авмаар байвал, Проф. Др. Фэридун Хафиз Узлукын орчуулсан "*Илтгэл*" гэсэн нэрээр нийтлүүлсэн бүтээлд хандаж болно. Уг бүтээл нь, 1996 онд Сэбил Хэвлэлээр Истанбул хэвлэсэн байдаг.

-Унадаг өвчтэй хүн давсан хөдлөлтийн дараа туйлдаж маш хүнд өвдөөд, хэтэрхий зовлонд автана, сэтгэл нь тааруу байх болно. Гэтэл Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- Эзэн маань дурдсан төвгийг үзээгүй байснаас байтугай, хоёр вахийн хоорондын хугацааг бараг фэтрэт шиг үзэж, шинэ вахий ирэхийг тэсэн ядан хүлээж, ирэхээр нь тайлбарлах аргагүй баяр хөөрт автдаг байв.

-Вахий болоход илэрсэн байдал нь вахийг ирэх бүрт нь хэрэгжихгүй, заримдаа Хазрат-и Пайгамбарын энгийн байдал нь хэвээрээ үргэлжилж байв.

-Анагаах ухааны ч тогтсоноор унадаг өвчин нь хөдөлсөн хүн нь бодох ба ухаарах чадлаа алдаж, эргэн тойрондоо болох үйлсийг анзаардаггүй ба ингээд оюун ухаан нь бүрэн хаалттай байдаг байсан ч, Пайгамбар Эзэн маань -саллаллаху алэйхи вэ сэллэм- авсан вахийн зэрэг хүн төрөлхтөнд хууль, ёс суртахуун, залбирал үйлчилгээ, туульс, сургаал мэтийн маш олон сэдвийн хамгийн төгс төгөлдөр жишээнүүдийг агуулсан гайхамшигт Кур’аны аетуудыг мэдээлж байв.

-Унадаг өвчтэй нь хүчтэй чичирсэн боловч, энэ байдал вахий болоход харагдаагүй юм.

-Унадаг өвчтэй бол учир утгагүй үгс ярина. Гэтэл Хазрат-и Пайгамбарт ийм байдал огт гэрчлэгдээгүй юм. Түүний ариун амнаас гарсан үгс нь хүний сонссон хамгийн ухаантай, хамгийн утгатай ба хамгийн ойлгомжтой үгс мөн.

Гэтэл ямар ч бие махбод зургаан мянга гаруй аетын буултын хэрэгжүүлэх чинээ удаан хугацаагаар унадаг өвчний адил түгшилтийг дааж чадахгүй ч анагаах ухаанаар зарласан байдаг.

Ийм олон зориуд мэт үзэгдлүүд Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн үнэнийг үгүйсгэж чадахгүй байхын үр дүн бөгөөд оюун ухааны ямар ч тайлбар ч үгүй юм.

Нүбүввэт ба Рисалэт

Аллах Таала нь боолчууддаа тэдний дотроос сонгож пайгамбарын үүрэг олгосон шилдэг хүмүүсийн адил хандахыг хүссэн байдаг. Аллахын уг хэвшлийг ает-и кэримэнүүд ингэж мэдээлнэ:

وَرُسُلًا قَدْ قَصَصْنَاهُمْ عَلَيْكَ مِنْ قَبْلُ وَرُسُلًا لَمْ نَقْصُصْهُمْ عَلَيْكَ

“Өмнө нь Чамд тухайн ярьсан пайгамбарчууд болон яриагүй бусад пайгамбарчуудад ч (вахий илгээв)**...”** (эн-Ниса, 164)

وَلَقَدْ اَرْسَلْنَا مِنْ قَبْلِكَ رُسُلًا اِلٰى قَوْمِهِمْ فَجَآؤُهُمْ بِالْبَيِّنَاتِ

“Тангараг өргөе, Бид Чамаас өмнө өөрийнхөө улсад хэдэн олон пайгамбар илгээж тэд улсынхандаа ил гэрчилгээ авчрав...” (эр-Рум, 47)

Аллах Таала анхны хүнээс эхлээд эрин бүрт пайгамбарчуудаа “нэбий” эсвэл “расул” бэлгээр хүмүүст энэрэл болгож илгээсэн байдаг.

Нүбүввэт нь ухаантай боолчууд дэлхий болон ахиратын үйлсийг зохицуулдаг Аллах болон боолчуудын хооронд үйлчилдэг элчийн ажил юм.

Расул нь өөрт нь вахий илгээсэн ба авсан вахийг бусдад мэдээлэх хариуцлагатай хүн мөн. **Нэбий** бол мэдээлэх хариуцлагатай эсэх нь хамаагүй, өөрт нь вахий илгээсэн хүн мөн. Ерөнхийдөө нэбийчүүд тэдний өмнө “расул” бэлгээр томилог-

дсон пайгамбарын шэрийтыг нь мэдээлэх ба гүйцэтгэх хариуцлагаар илгээсэн байдаг. Тэгэхээр расул бүр нь нэбий мөн, гэтэл нэбий бүр нь расул биш. Нэбийгийн расулаас ба тэр чигээр нь нүбүввэтийн рисалэтээс өргөн түгээмэл байсныг илэрхийлсэн зарим хадиснууд дамжуулсан байдаг. Гэтэл, Кур'ан-и Кэримд эдгээр үгсийг нэг нэгийнх нь оронд хэрэглэдэг.

"Аллах Таала нь боолчууддаа яагаад шууд биш харин пайгамбарчуудыг хэрэглэн хандаж байдаг вэ?" гэсэн нэгэн асуулт аяндаа төрөх болбол, ингэж хариу өгч болно:

Аллах Таалагийн хүмүүст шууд хандах буюу вахий илгээж тушаал ба хоригоо нээлттэй мэдээлэх нь дэлхийг туурвисан "нууц"ын эсрэг юм. Тийм болбол иманы нууцтай хамаатай байснаас үүссэн үнэ ба хүнд нь учир утгагүй үлдэхсэн. Тушаал ба хоригийг Аллах Таалагийн өөрөөс авсан хүмүүс үнэнийг иж бүрэн ухаарсан болох тул уг тушаал ба хоригийг аргагүй дагахсан. Энэ бол хүний оюун ухаан ба үйл ажиллагаандаа буян эсвэл муугийн чигээр сонголт хийхэд саад болж, шагнал болон ялыг учиргүй болгох байсан.

Нөгөө талаас хүмүүсийн оюун ухааны төвшин, хүч чадал нь өөр өөр байдаг. Учир нь энэ амьдралд хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь нэг нэгээсээ ялгаатай байдаг. Хэрэв хамаг хүмүүс маш авьяастай байсансан бол, зарим ажлыг хэн ч хиймээргүй байхсан. Хамгийн энгийнээс хамгийн хүндэт нь хүртэл хамаг далд ба дэлхийн ажлыг хэрэгжүүлэх нь хүмүүсийн чадвараараа ялгаатай туурвихыг шаардсан байдаг.

Хүн төрөлхтний түүхийн хамгийн том дарга, сургагч ба хүмүүжүүлэгчид нь пайгамбарчууд мөн. Учир нь олныг авралд хүргэж гийгүүлэх, тэдэнд зөв зам заах, хүмүүсээс үүсэх муу муухай болон зовлонг дийлэх хүмүүсийн агуу чадвар ба эцэсгүй тэсэх хүчтэй төрсөн байх хэрэгтэй. Түүнийг дагах

олныг хүндэтгэх шинж ба агуу бэлгэ тэмдэг нь болохгүй бол, нэгэн пайгамбарын хүмүүсийн нөлөөлж тэднийг залахын арга үгүй байдаг.

Энгийн нэгэн тэргүүн ч удирдах хариуцлагатай хүмүүсээс давуу шинжтэй болохгүй бол тэргүүний байранд хүрч чадахгүй. Хүрсэн ч амжилттай байж чадахгүй. Учир нь хэн ч хүчгүй байсан нь тодорхой хэн нэгийг тэргүүнээр хүлээн зөвшөөрөхгүй.

Ийм л учраас пайгамбарчуудын туурвигдсанаасаа давуу олон шинж эзэмшсэн нь үзэгдэнэ. Гэтэл тэд уг туурвилаас ирсэн авъяасаа хэрэглэж гагц өөрийнхөө мэдлээрээ пайгамбар болж чадахгүй. Пайгамбарын цол нь ийм л хангалттай хүмүүсийн хоорондоос тэнгэрлэг томилолтоор сонгогдон томилогдох хүмүүст зориулсан байдаг. Өөрөөр хэлбэл нүбүввэт ба рисалэт нар мэргэжил биш юм. Өөрөөр хэлбэл хичээж зүтгээд олддоггүй. Аллах Таалагийн хүслээр боолчуудынхаа хэн нэгэнд олгосон үүрэг юм. .

Ает-и кэримэ нь ингэж айлдана:

اَللّٰهُ اَعْلَمُ حَيْثُ يَجْعَلُ رِسَالَتَهُ

“...Аллах нь рисалэтаа хэнд олгохоо хамгийн сайн мэдэгч мөн...” (эл-Эн’ам, 124)

Нөгөө талаас тэнгэрлэг вахийг энгийн нэгэн хүн эсвэл хамаагүй хэн нэгэнд илгээх ч зохимжтой биш юм. Учир нь хүмүүсийн бүгд нь тэнгэрлэг мэдээллийг ухаарах ба гүйцэтгэх талаар авъяас ба чадвараараа ижил биш юм. Ийм л учраас пайгамбарчууд бүх талаараа агуу шинжтэй хүмүүсийн дундаас сонгогдсон байдаг. Эзэмшсэн туурвилтын хүч чадлын ачаар ч нүбүввэт болон рисалэтийн хүнд ачааг зөөх, даах хариуцлагатай болгосон байдаг.

Пайгамбарчуудын Бэлгэ Тэмдэг

Хамаг пайгамбарчуудын дундын зарим бэлгэ тэмдэг байдаг. Энгээр сидк, эманэт, фэтанэт, исмэт ба тэблиг мөн. Пайгамбарчуудад итгэл үнэмшил нь эдгээр шинжүүдийн хүрээнд л тайлбарладаг:

Сидк: Пайгамбарчуудын тэнгэрлэг шийдвэр, тушаал ба хоригийг хүмүүст мэдээлэхэд ба хэлсэн хамаг мэдээ үнэнч байдаг. Тэд үг ба үйлсээрээ байнга зөв зам дээр байдаг. Үг ба үйлс нь нэг нэгийнхээ толь тусгал мэт ижил юм. Тэд худал хэлэхийн арга үгүй юм. Аллах -жэллэ жэлалүхү- нь пайгамбарчуудаа үнэнч байсны улмаас магтсан байдаг:

وَاذْكُرْ فِي الْكِتَابِ اِبْرٰهِيمَ اِنَّهُ كَانَ صِدّٖيقًا نَبِيًّا

“Сударт Ибрахимтай хамаатай бидний ярьсан юмыг ч сана! Гарцаагүй Тэр сиддийк (зөв яриатай, үнэнч) **нэгэн пайгамбар байв.”** (Мэрьем, 41)[124]

Аллах Таала пайгамбарчуудын нэгэн мөч гэсэн ч сидкаас салахын арга үгүйг ингэж мэдээлнэ:

وَلَوْ تَقَوَّلَ عَلَيْنَا بَعْضَ الْاَقَاوِيلِ لَاَخَذْنَا مِنْهُ بِالْيَمٖينِ
ثُمَّ لَقَطَعْنَا مِنْهُ الْوَتٖينَ

“Хэрэв (Пайгамбар) **Бидний хамаатай зарим үгс зохиосонсон бол, Бид Түүнийг заавал хүчээр барихсан. Дараа нь мэдээж Түүний гол судсыг таслахсан.”** (эл-Хакка, 44-46)

124. Мөн хар.: Мэрьем, 54, 56; Юүсүф, 46.

Тэдний үнэнч зан нь тэдэнд итгээгүй хүмүүс ч батлах агуу төвшинд байдаг. Үүний тоолшгүй жишээнээс зарим нь:

Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- урилгаа анх зарласан өдрүүдэд Сафа Даваан дээрх өндөр нэгэн хад дээрээс Курайшчуудад ингэж дуудав:

“–Аяа Курайшийн нийгэм ээ! Би танд тэр уулын бэлчээрт эсвэл тэр хөндийд дайсны морьтод бий; шууд танд дайраад, барааг тань булааж авна гэвэл надад итгэнэ үү?”

Тэд ч огт сандралгүй:

“–Тийм, итгэнэ! Чамайг одоо хүртэл байнга үнэнчээр оллоо. Чиний худал хэлснийг огт сонсоогүй!” гэцгээв. (Бухарий, Тэфсир, 26)

Бизансын Импэратор Ираклий нь Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм- Эзний маань тухай мэдээ авах тулд, арай итгэж үнэмшээгүй байсан Эбү Сүфьянаас асуусан асуултаас нэгэнд:

“–Хэзээ ч амалснаа зөрсөн удаатай юу?” гэж асуусан байв.

Тэр үеээр Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн эсрэг тал байсан боловч Эбү Сүфьян:

“–Үгүй! Тэр нь амласан үгээ заавал хэрэгжүүлнэ!” гэж хариулав. (Бухарий, Бэд’ү’л-Вахй, 1, 5-6; Мүслим, Жихад, 74)

Маккагийн мүшрикчүүдээс Үбэй бин Халэф ч Исламын хамгийн догшин байснаас нэг байв. Хижрэтээс өмнө Орчлонгуудын Эзэнд:

“–Нэг морь тэжээж байна; түүнд хамгийн сайныг идүүлнэ. Нэгэн өдөр тэрийг унаад Чамайг ална!” гэдэг байв.

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- ч нэгэн удаа түүнд:

“–Иншааллах би чамайг ална!” хэмээн хариу өгөв.

Ухуд Дайны өдөр уг ухаангүй мүшрик нь Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийг хайж ингэж хэлж байв:

“–Хэрэв өнөөдөр Тэр аврагдвал миний ажил дууссан гэсэн үг!”

Ийнхүү бодлоороо Пайгамбар Эзэнд маань довтлохоор ойрт нь дөхөв. Сахаба-и кирам ч арай хол байхад түүнийг толгойг таслах юмсан. Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-:

“–Ирэг, салаад орхи!” хэмээв.

Үбэй бин Халэфыг дөхөхөд Орчлонгийн Хүндэт Эзэн маань сахабагаас нэгний гараас жадыг нь авав. Энэ удаа Үбэй зугтаж эхлэв. Харин Пайгамбарчуудын Хаан нь:

“–Хаашаа зугтах гэж байгаа вэ, худалч чи?” гээд жадаар харвав. Жад нь Үбэйгийн хүзүүг хальт шүргэв. Гэтэл тэр нь ийм чинээгээр ч мориноос унав; айж сандран гүйж зугтав. Нэг талаас гүйж, нэг талаас ч нүд нь илд гарснаараа хашхирч байв:

“–Тангараг өргөе, Мухаммед намайг аллаа!..”

Хажууд нь ирээд шархыг нь харсан мүшрикчүүд:

“–Энэ нь нэгэн шалбархай төдий!” гэцгээв.

Харин тэр сэтгэл ханаагүй ингэж хэлэв:

“–Мухаммед надад Маккад байхдаа: *«Би чамайг заавал ална!»* гэсэн байв. Тангараг өргөе, хэрэв Тэр надад нэг шүлс хаясан ч би үхнэ!..”

Дараа нь үргэлж бархирав. Чимээ нь бараг нэгэн шар үхрийн орилоон шиг гарч байв.

Эбү Сүфьян:

“–Энэ жижигхэн шалбархайд ийм том бархирах гэж байдаг юм уу?” гэж түүнийг зэмлэхэд Үбэй түүнд ч ингэж хэлэв:

“–Чи мэдэж байна уу, энийг хэн шалбалсан гээч? Энэ нь Мухаммедын шарх юм. Лат ба Уззагийн нэрээр тангараг өргөе, уг шархнаас мэдэрсэн өвчнийг хамаг Хижазынханд тараавал, бүгд нь ч үгүй болно. Мухаммед надад Маккад: *«Би чамайг заавал ална!»* гэсэн байв. Би бүр тэр мөчид Түүний гарт үхэхээ, Түүний гараас өөрийгөө аварч чадахгүйгээ ойлгосон байв.”

Пайгамбарын догшин нэгэн өстөн асан Үбэй нь эцэст нь Маккад хүрэхээс нэгэн хоногийн өмнө замдаа үхэв. (Ибн-и Исхак, х. 89; Ибн-и Са’д, II, 46; Хаким, II, 357)

Уг явдлын ч зааснаар, Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийг ойроос таньсан догшин нэгэн мүшрик ч Түүний үгийн хэр их хүчтэй ба зөв байсанд нь итгэж байв.

Эбү Мэйсэрэгийн хэлснээр:

“Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- нэгэн өдөр Эбү Жэхил ба найз нарынх нь дэргэд очив. Тэд Хазрат-и Пайгамбарыг харахлаараа:

«–Еэ Мухаммед аа! Валлахи бид Чамайг үгүйсгэхгүй; Чи бидний хувьд үнэнч нэгэн хүн мөн. Гэтэл бид Чиний авчирсан юмыг л үгүйсгэнэ,» гэцгээв. Тэгэхлээр нь ает-и кэримэ нь буув:

قَدْ نَعْلَمُ اِنَّهُ لَيَحْزُنُكَ الَّذِي يَقُولُونَ فَاِنَّهُمْ لَا يُكَذِّبُونَكَ وَلٰكِنَّ الظَّالِمِينَ بِاٰيَاتِ اللّٰهِ يَجْحَدُونَ

«Тэдний хэлсэн нь Чамайг зовохыг Бид заавал мэддэг; үнэндээ тэд Чамайг худалч гэж тоолдоггүй, гэтэл харгисчууд нь Аллахын аетуудыг мэдсээр байгаад үгүйсгэж байдаг.» (эл-Эн'ам, 33) (Вахидий, х. 219)

Хазрат-и Мухаммед Мустафа -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн үсэг яриагүйгээр зөвхөн царайны байдал ч үнэнчийнх нь бодит нэгэн илэрхийлэл байв. Жишээлбэл еврейчүүдийн шилдэг эрдэмтдээс Абдуллах бин Салам Түүний сарнай адил царайг харахлаараа:

"–Энэ царай нь худалчийн царай байж болохгүй!" гээд иман хийсэн байв. (Тирмизий, Киямa, 42; Ахмад, V, 451)

Өөрт нь пайгамбарын үүрэг олгохоос өмнө ч хүмүүс тоглох зорилгоор ч худал хэлээгүй хэн нэгний Аллахын тухай худал хэлэх нь боломжгүй юм. Угаасаа Пайгамбар Эзэн маань худал ярихыг нифак буюу замбараагүй зангийн тэмдгээр тоолсон бөгөөд үммэтдээ ч худал хэлэхийг хатуу хориглосон байдаг[125]

Эзэн маань -алэйхиссалатү вэссэлам- нэгэн хадис-и шариф-даа ингэж айлдсан байдаг:

"Боол нь худал хэлсээр ба худал хэлэх зорилгоо зөөсөөр байхад зүрхэнд нь хар нэгэн цэг тавьдаг. Дараа нь энэ цэг өсч зүрх нь бүрэн хав хар байх болно. Эцэст нь энэ хүн Аллахын онгонд «худалчдын» хооронд бүртгэгдэнэ." (Муватта', Кэлам, 18)

Нүфэй бин Харис -радъяллаху анх- үүнийг дамжуулна:

Нэгэн өдөр Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-:

125. Бухарий, Иман, 24; Мүслим, Иман, 107.

“–Том нүгэлийн хамгийн хүндийг танд мэдүүлэх үү?” хэмээн гурван удаа асуув. Бид ч:

“–Тийм Расулаллах!” гэцгээв.

Хүндэт Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- Эзэн маань:

“–Аллахад ширк олгох, аав ээжийгээ үл тоох,” хэмээсний дараа өндийж суугаад:

“–Сайхан сонсч аугаа, бас худал хэлээд худлын гэрч хийх!” хэмээн айлдав. Энэ үгийг маш олон удаа дахиж хэлсэнд нь бид түүнийг илүү ядраад санаа зовохгүйн тулд тайвшрахыг нь хүсцгээлээ. (Бухарий, Эдэб, 6; Муслим, Иман, 143)

Кур’ан-и Кэрим ч үнэнч байхын чухал талыг ингэж зарладаг:

قَالَ اللّٰهُ هٰذَا يَوْمُ يَنْفَعُ الصَّادِقِينَ صِدْقُهُمْ لَهُمْ جَنَّاتٌ تَجْرِي مِنْ تَحْتِهَا الْاَنْهَارُ خَالِدِينَ فِيهَآ اَبَدًا رَضِيَ اللّٰهُ عَنْهُمْ وَرَضُوا عَنْهُ ذٰلِكَ الْفَوْزُ الْعَظِيمُ

“Аллах Таала ингэж айлдана: Энэ нь үнэнч байсных нь ашиг олгох өдөр мөн. Тэдэнд үүрд мөнх орших, доороос нь гол мөрөн урсдаг диваажин байдаг. Аллах тэднээс таатай болсон, тэд ч таатай болсон байдаг. Том аврал ба ашиг нь энэ мөн.” (эл-Маида, 119)

Эманэт: Хамаг пайгамбарчууд хэтэрхий эмин, итгэмжтэй, шударга, шулуун ба шилдэг хүмүүс мөн. Итгэлийн бус хүмүүс ч тэдэнд дуусашгүй итгэнэ. Пайгамбарчуудын эманэт хэмээсэн бэлгэ нь тэдний хамаг хэрэгт итгэмжтэй байснаас үл барам, ихэнхдээ вахий талаар итгэмжтэй байхыг, Аллахын тушаал ба

хоригийг хүмүүст өөрчлөлгүй, нэмж хасалгүй мэдээлэхийг нь илэрхийлнэ.

Аллах Таала нь пайгамбарын үүрэг болон алдрын урвагчдад биш, зөвхөн бүх талаараа итгэмжтэй ба үнэнч боолчууддаа гардуулж өгнө. Ает-и кэримэчүүд пайгамбарчуудын үммэт нартаа:

أُبَلِّغُكُمْ رِسَالَاتِ رَبِّي وَاَنَا لَكُمْ نَاصِحٌ اَمِينٌ

“Танд Раббынх минь вахий хийснийг мэдээлж бөгөөд би таны төлөө итгэмжтэй нэгэн сануулагч мөн.” (эл-А’раф, 68)

اِنِّي لَكُمْ رَسُولٌ اَمِينٌ

“Андашгүй нь би танд илгээсэн итгэмжтэй нэгэн пайгамбар мөн.” (эш-Шуара, 107) хэмээснийг мэдээлнэ.[126]

- Энэ үүднээс Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн төлөө хэлсэн “Мухаммеду’л-Эмин” нэр нь мүшрикчүүдийн хэлнээс ч салдаггүй байв. Жишээлбэл тэд бараагаа өөрсдийн талынхандаа биш Хүндэт Элч Эзэнд маань итгэж үлдээдэг байв. Мадинад нүүхээр болсондоо ч Хазрат-и Пайгамбарын дэргэд мүшрикчүүдийн хадгалсан зарим бараа байв. Пайгамбар Эзэн маань үхэх аюул байсан ч Хазрат-и Алиг Маккад орхиж тэднийг эзэн болгонд нь хүргүүлсэн байв.

- Эл-Эмин бэлгэ нь Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм- Эзний маань бараг хоёр дахь нэр болсон байв. Жишээлбэл Орчлонгийн Хүндэт Эзэн маань 25 нас хүрээд

126. Мөн хар. эш-Шуара, 125, 143, 162, 178; эд-Духан, 18.

Маккад зөвхөн **эл-Эмин** (хамгийн итгэмжтэй хүн) гэсэн нэрээр дууддаг болсон байв.[127]

Кабад шүүгч хийсэнд нь Түүний ирж буйг харагсад “эл-Эмин игж байна!” гээд баяссан ба хамаг хэрэгт Түүнд итгэж Түүнтэй зөвлөлцсөн байв. Учирт нь амиа, бараагаа, хамаг юмаа зориулсан асхаб-и кирамтай зэрэг, Түүний амийг хороохыг хүсдэг өстөн ч Пайгамбар Эзний маань итгэмжтэй байсны эсрэг нэг үг ч хэлж чадаагүй байдаг.

Пайгамбарчуудын эмин байсны шигээ тэдэнд вахийг авчирсан Жэбраил -алэйхиссэлам- ч эмин мөн. Аугаа Эрх энэ тухай:

اِنَّهُ لَقَوْلُ رَسُولٍ كَرِيمٍ ذِي قُوَّةٍ عِنْدَ
ذِي الْعَرْشِ مَكِينٍ مُطَاعٍ ثَمَّ اَمِينٍ

“Тэр (Кур’ан-и Кэрим), **үнэт, хүчит ба Огторгуйн эзэн** (Аллахын) **онгонд нэр хүндтэй нэгэн элчийн** (Жэбраилын) **авчирсан нэгэн үг мөн. Тэр нь үгэнд ордог, эмин нэгэн элч мөн,”** (эт-Тэквир, 19-21) хэмээн айлдана. Тэгэхлээр вахий нь тэнгэр дэх эминий аргаар дэлхий дэх Эминд буулгаж байдаг.

Фэтанэт: Пайгамбарчууд хүмүүсийн хооронд ялангуяа оюун, ухаан ба фирасатаараа хамаг талаараа давуу төвшинд байдаг. Тэд хүчтэй санах ойтой, өндөр зэргийн ухаантай, хүчтэй нэгэн логик ба ятгах авъяастай байдаг.

Фэтанэт нь хуурай оюун ухаан биш, суутны цаад ухаарахын төвшин мөн. Зүрхэнд холбоотой ухаан, фирасат (ирээдүйг таах) ба басиратын (тухайн байдлын нууц учрыг харах) илэрхийлэл юм. Хамаг пайгамбарын үүргээ дутуугүй ба төгс төгөлдөр

127. Ибн-и Са’д, I, 121, 156.

гүйцэтгэхийн тулд ийм өндөр ухаантай байх нь шаардана. Эс тэгвэл илгээсэн хүмүүстээ хүчтэй баталгаа үзүүлж чадахгүй, тэднийг ятгаж ба хэрэглэж чадахгүй.

Пайгамбарчууд хамгийн балархай ба хэцүү асуудлыг ч хялбар шийдэцгээнэ. Сэдвийг тайлбарлахдаа ятгагч хамгийн ойлгомжтой үгээр ярьцгаадаг тул, ойлгох ухаан нь нэг нэгээсээ тустай буй сонсогчид нь тэднийг амархан ойлгож чадна.

Энэ бэлгэ пайгамбар бүрт тус тус өөр өөр илэрсэн, Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн бол хамаг амьдрал нь ийм шинжийн илэрснээр өнгөрсөн байдаг. Өмнө ч өгүүлснээр, Кабаг засвар хийж байхад Хажар-и Эсвэдийг байранд нь тавих үед гарсан маргааныг Харамын үүдэнд харагдсан Орчлонгуудын Эзэн басират ба фирасатын ижилгүй нэгэн жишээг толилуулж маш амархан шийдээд, аймгуудын хооронд гарч мэдэх дайн байлдааныг зогсоосон байдаг.

Түүний Исламын учирт хийсэн байлдаануудад ч үзүүлсэн мэдэл, энх тайвны гэрээнүүдэд, ялангуяа Худэйбиед тлрүүлсэн фирасат, Маккаг цус асгалгүй эзэлсэн ба авралд хүргэсэн нь, Хүнэйн ба Таифад хэрэгжүүлсэн ер бусын тактик ба үзүүлсэн хууль зүй, хэн нэгэн хүний нарийн учрыг нь ухаарч чадахааргүй фэтанэтын үр дүн мөн.

Нэгэн мусульман ч пайгамбарчууд дахь фэтанэт бэлгээс хувь аваад, ухааны шимийг хамгийн ашигтай эдлэх хэрэгтэй. Хэнд, юуг, хэзээ, хаана ба яаж хэлэхээ ба яаж хандахаа сайн мэдэх хэрэгтэй.

Жишээлбэл Жафар-и Тайяр -радъяллаху анх-ын Абиссинийн Нэжашид нь Исламын тухай мэдээлэл өгч байхдаа мөрдсөн нарийн арга нь нэгэн мусульманы фирасатыг үзүүлсний талаар маш чухал байдаг:

Христийн шашинтай байсан Нэжаши нь Жафар-и Тайяр Тауyâr -радъяллаху анх-аас Кур'ан-и Кэримийн хэдэн аетыг уншихыг нэхэхлээр нь тэр эхлээд үгүйсгэгчдийг сүрдүүлсэн Кафигун Сураг биш, дотроо Хазрат-и Есүс ба эхийг нь магтаад дурдсан Мэрьем Сураг уншив. Хазрат-и Жафарын уншсан ает-и жэлилэнүүдийг дуртай сонссон Нэжаши:

"–Яг миний сонссонтой Есүсийн авчирсан нь туяаны ижил булгаас оргилж байна!" гээд хэсэг хугацааны дараа Исламд орох алдарт хүртэв. (Ибн-и Хишам, I, 358-360)

Тэблиг: Пайгамбарчууд тэнгэрлэг тушаалыг зөв авч, тушаал авснаараа хүмүүст мэдүүлнэ. Тэблиг буюу мэдүүлэх ажилдаа нэмэлт ч хийхгүй, хасалт ч хийхгүй. Тэблиг нь пайгамбарчуудын дундын бэлгээс ба хамгийн чухал үүргээс нэгэн байдаг. Ает-и кэримэ ингэж айлдана:

يَا أَيُّهَا الرَّسُولُ بَلِّغْ مَا أُنزِلَ إِلَيْكَ مِن رَّبِّكَ
وَإِن لَّمْ تَفْعَلْ فَمَا بَلَّغْتَ رِسَالَتَهُ

"Аяа Расул! Раббаас чинь Чамд буусныг мэдүүл. Хэрэв үүнийг хийхгүй бол рисалат үүргийг нь гүйцээгүйд тооцогдоно..." (эл-Маида, 67)

Пайгамбарчууд тэблиг үүргээ биелүүлж байхдаа янз янзын төвөгтэй тааралдсан байдаг. Гэтэл хэзээ ч үзэл санаагаа болиогүй юм. Тэдний амьдралууд энэ тухай сургаалтай явдлаар дүүрэн байдаг.

Пайгамбар Эзэн маань Исламд урьж байхдаа хамгийн ойр дотноос эхэлсэн, цаг ба орны дагуу хандсан, харилцагчийнхаа сэтгэлийн байдал ба оюун ухааны төвшнийг анхаарсан, олсон

хамаг завшааныг үнэлсэн, хэзээ ч албадаагүй, байнга хялбаршуулсан, байнга сайхыг мэдээлж, хэзээ ч хилэгнүүлэгүй юм.

Хамаг амьдралаа Исламыг мэдүүлэхэд зориулсан Хүндэт Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- Эзэн маань Вэда буюу Салах Ёсны Яриандаа асхабдаа хандан:

"Тэблиг үүргээ хийв үү?" хэмээн асууж, тэднээс эерэг хариу авахлаараа ч:

"Аллах минь, гэрчил!.." хэмээж, үүргээ биелүүлж буйн тааламжийг авав.

Бүх итгэгчид ч Аллахын Элчийн уг тэблиг аргуудыг, чадлаараа эзэмшсэн байх ёстой. Учир нь тэблиг нь мусульманчуудад фарз болсон шиг хүчинтэй байдаг.[128]

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- Эзэн маань ингэж айлдана:

"Танаас хэн ч нэгэн муу муухайг харвал тэрийг гараараа засаг, хүч нь хүрэхгүй бол хэлээрээ засаг, үүнд ч хүч нь хүрэхгүй бол зүрхээрээ голог! Энэ бол итгэл үнэмшлийн хамгийн хүчгүй төвшин юм." (Мүслим, Иман, 78)

Нэгэн нийгэмд маруфыг (сайн сайхан ба шударгыг) тушааж мүнкэрийг (муу муухайг) хориглосон хүмүүс болохгүй бол, муухай үйлс цаг хугацааны туршид заншил болж амьдралд хэвийн шиг тооцохоор байх болно. Саад болоогүй муу муухай нь хэсэг хугацааны дараа хүссэн ч саад болохооргүй төвшинд хүрнэ. Үнэн худал хоёр нь холилдож үнэн нь алга болоод хүмүүс Аллахыг мартах болно. Үүний үр дүнд ч тухайн нийгэм бүтнээрээ мөхнө. Ийм аймшгийн төгсгөлөөс сэргийлэх тулд тэблигийн үйл ажиллагааг чухалчилж авах хэрэгтэй юм.

128. Хар. Ал-и Имран, 104, 110.

Исмэт: Пайгамбарчууд далд ба ил бүх төрлийн масиет ба нүгэл хийхээс хол байдаг. Ийм бэлгийнхээ улмаас тэд номлохоос өмнө ч дараа ч ширкийн намагт унахаас хамгаалсан байдаг. Мөн Аллахаас амсан вахийг хүмүүст мэдээлэхэд мартах эсвэл алдаа хийх магадлал үгүй.

Пайгамбарчууд **исмэт** бэлгэ эзэмшээгүйсэн бол хүргэсэн мэдээллийн үнэн байхад итгэж болохгүй болохсон. Энэ бол тэдний Аллахын дэлхий даяарх гэрч болох шинж дээр сүүдэр тусгах байхсан.

Эхл-и сүннэтийн үзлээр пайгамбарчууд том нүгэл огт хийдэггүй. Алдаагаар ба зарим нууц учиртай буйгаар “зэллэ” хийсэн нь боломжтой байсан ч алдаатайгаар орхидоггүй, шууд аетаар сануулаад зөвлөнө.

Энэ “зэллэ” гэгч санаандгүй хүний алдаанууд нь пайгамбарчуудын ч хүчгүйг амсах ба хүн байснаа санаж тэднийг бурхан шиг үзэхэд саад болох мэтийн нууц учир агуулна.

Пайгамбарчууд жишээ авахад боломжтой үйлс толилуулах хэрэгтэй байдаг. Эс тэгвээс хүмүүс, “Пайгамбарчуудын тушаасан нь бидний хүчнээс дээш” гээд тэнгэрлэг тушаал ба хоригийг хэрэгжүүлэх талаар маш олон шалтгаан зохиох байхсан. Энэ үнэнийг анзааралгүй пайгамбарчуудын мэлэк болох хэрэгтэйг бодсон хайхрамжгүйчүүд ч илэрч Кур’ан-и Кэрим тэдэнд ингэж хариулав:

قُل لَّوْ كَانَ فِي الأَرْضِ مَلآئِكَةٌ يَمْشُونَ مُطْمَئِنِّينَ لَنَزَّلْنَا عَلَيْهِم
مِّنَ السَّمَاءِ مَلَكاً رَّسُولاً

“(Еэ Расул минь! Тэдэнд) **ингэж хэл: Хэрэв дэлхий дээр энх тайвнаар суурьшигчдыг** (хүн биш) **мэлэкчүүд байсансан бол, мэдэ-**

эж Бид ч тэдэнд тэнгэрээс пайгамбар болгож нэгэн мэлэк илгээхсэн.” (эл-Исра, 95)

وَمَا جَعَلْنَاهُمْ جَسَداً لَّا يَأْكُلُونَ الطَّعَامَ وَمَا كَانُوا خَالِدِينَ

“Бид тэднийг (пайгамбарчуудыг), **хоол иддэггүй нэгэн бие** (мэлэк) **шиг туурвиагүй. Тэд** (энэ хорвоод) **мөнхы ч биш.”** (эл-Энбия, 8)

Нөгөө талаас пайгамбарчууд үммэтйинхээ ижил алдаа хийхгүй эсвэл алдаа хийвэл яаж хандахаа сурах тулд ч тэдэнд жишээ болох хэрэгтэй юм.

Жишээлбэл Нух -алэйхиссэлам- 950 жилийн тэвчээрээр дүүрэн тэблиг үйл ажиллагааны дараа улсынхан хидаятад хүрэхгүй байхад:

فَدَعَا رَبَّهُ أَنِّي مَغْلُوبٌ فَانتَصِرْ

“Рабдаа: «(Аяа Раббий) **би хожигдлоо; одоо надад тусал!» гээд хорогдов.”** (эл-Камэр, 10)

Энэ залбирлынх нь үр дүнд улсынхан нь усанд уйж байхад үгүйсгэгч хүүгийнхээ төлөө ч аавын энэрэлт сэтгэлээр:

رَبِّ إِنَّ ابُنِي مِنْ أَهْلِي

“...Аяа Раб минь! Андашгүй нь миний хүү ч манай гэр бүлийнх мөн...” (Хүд, 45) гэв.

Аугаа Эрх хүүгийнхээ төлөө залбирсан учраас:

إِنِّي أَعِظُكَ أَن تَكُونَ مِنَ الْجَاهِلِينَ

“...(Еэ Нух!) Би чамд мунхаг үл болохыг санал болгоё!” (Худ, 46) хэмээн айлдав.

Нух -алэйхиссэлам-ын энэ зэллэ нь киямат хүртэл ирэх хамаг үммэтчүүдэд нэгэн жишээ болсон байдаг.

“Ла юхтий: алдаа хийхгүй” бэлгэ нь зөвхөн Аугаа Эрхэд харъяалагдана. Боолчуудын талаар алдаанаас хол болохын арга байдаггүй. Гэтэл мусульман алдаагаа хамгийн бага байхаар буулгахыг хичээх ёстой юм. Ийм учраас Кур’ан-и Кэрим маш олон газарт зикир буюу зүрхний Аугаа Эрхтэй хамт байхыг тушааж байдаг. Учир нь зүрхийн “Аллах” гэж байхад эрхгүйгээр хандаж, буруу үйл хийж чадахгүй.

Аллах Таала ингэж айлдана:

وَلَا تَكُونُوا كَالَّذِينَ نَسُوا اللَّهَ فَأَنسَاهُمْ
أَنفُسَهُمْ أُوْلَئِكَ هُمُ الْفَاسِقُونَ

“Аллахыг мартаад Аллахын ч өөрийгөө мартуулсан хүмүүс шиг байгуузай; тэд замаа төөрсөн фасик хүмүүс мөн.” (эл-Хашр, 19)

Дахиад энэ сэдвээр хайхрамжгүй хүмүүсийн тухай Аллах Таала:

فَوَيْلٌ لِّلْقَاسِيَةِ قُلُوبُهُم مِّن ذِكْرِ اللَّهِ أُوْلَئِكَ فِي ضَلَالٍ مُبِينٍ

“...Зүрх нь Аллахыг дурдах талаар хатуужсан хүмүүст даанч дээ; тэд төөрсөн нь тодорхой юм,” (ээ-Зүмэр, 22) хэмээн айлдана.

❀

Пайгамбарчуудын уг таван бэлгэнээс (сидк, эманэт, фэтанэт, тэблиг, исмэт) гадна зөвхөн Хазрат-и Пайгамбар -саллал-

лаху алэйхи вэ сэллэм-д тусгай гурван өөр бэлгэ байдаг нь эдгээр:

1. Расул-и Мүжтэба -алэйхи экмэлү'т-тэхаяа- Эзэн маань Хабибуллах мөн, хамаг пайгамбарчуудаас агуу бөгөөд Тэр хүн төрөлхтний хамгийн нэр хүндтэй нь мөн.

Шүлэгч Нэжип Фазил Түүнийг түвчоор ингэж тайлбарлана:

Мөнх нь үнэрийг нь шүүсэн,
Зөгийн бал Чи мөн, оршигчийн ховд...

2. Хүндэт Расул -саллаллаху алэйхи вэ сэллэм- Эзэн маань хамаг хүмүүс ба жинчдэд томилогдов. Өөрөөр хэлбэл Расулү'с-сэкалэйн буюу хоёр талын элч юм. Авчирсан шашин киямат хүртэл хүчинтэй юм. Бусад пайгамбарчууд бол түр зуурын ба зарим нь ч ялангуяа тусгай нэгэн улсад томилогдсон байдаг. Үүнээс үзвэл хамаг пайгамбарын гайхамшиг өөрийнх үетэй хамаатай байхад, Хазрат-и Пайгмбар -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн гайхамшгууд нь хамаг эринд хандана. Ялангуяа Кур'ан-и Кэрим нь Түүнд өгсөн хамгийн том гайхамшиг буйгаараа киямат хүртэл эвдэхээс хамгаалагдана.

3. Хатэмү'л-энбияа буюу пайгамбарчуудын сүүлийнх юм.

Эдгээрээс тустайгаар мөн Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм-д киямат өдрийн хувьд макам-и махмуд ба шафаат-и узса хайрласан байдаг. Ийм учраас тэр энэрлийн пайгамбар агуу цуглалтад үммэтийнхээ нүгэлтдэд шафаат хийх буюу өршөөхийг нь гуйж, уг шафаат нь ч хүчинтэй байх болно.[129]

❀

129. Хар. Бухарий, Тэвхид, 36. Энэ тухай мөн хар. х. 248.

Хэн нэгийг хайрлаж түүний ааш занг хүндэтгэх ба түүнийг дуурайхыг хичээх нь хүний байгалийн эрмэлзэл мөн нь үгүйсгэшгүй нэгэн үнэн мөн. Энэ талаар хүний хувьд хамгийн төгс жишээнүүдийг олж тэдний мөрөөр явах нь маш чухал хэрэг юм. Ийм л учраас Аугаа Эрх нь хүн төрөлхтөнд зөвхөн ном биш, мөн тэдгээр номуудын амьд илэрхийлэл гэсэн утгаар мянга мянган давуу шинж эзэмшсэн пайгамбарчууд буюу үлгэр жишээ хүмүүс илгээсэн байдаг. Тэд шашны, шинжлэх ухааны ба ёс суртахууны үйлсийн талаар бүх талаасаа төгсийг толилуулах чинээ үлгэр жишээ хүмүүс мөн. Тэгэхээр тэд пайгамбарчуудын аль нэгэн ч хүний түүхийн турш тодорхой жишээ үйлийн оргил болж хүн төрөлхтөнд тусгай үйлчилгээ бэлэглэсэн байдаг.

Жишээлбэл пайгамбарчуудын дунд **Хазрат-и Нух** -алэйхиссэлам-ын амьдралыг харвал, нэгдүгээрт иманы урилга, тэсвэр, тэвчээр ба эцэст нь күфүр болон күфрийн хүмүүст ширүүн голсныг анзаарна.

Хазрат-и Ибрахим -алэйхиссэлам-ын амьдрал нь ширкийн эсрэг өршөөлгүй тэмцээн ба баримал шүтлэгийг үгүй болгох зорилгоор өнгөрсөн, мөн Нэмрүдийн галыг сарнайн цэцэрлэгэ-эр эргүүлсэн Эрхэд бууж өгөх, найдах ба итгэх талаар ч тусгай нэгэн жишээ болсон байдаг.

Хазрат-и Муса -алэйхиссэлам-ын амьдрал нь харгис Фарон ба хамт олныхтой нь тэмцэж өнгөрсөн бөгөөд тэр нь дараа нь авчирсан шэриатаар итгэгчдэд нийгмийн эмх цэгцийг зохион байгуулсан байдаг.

Хазрат-и Есүс -алэйхиссэлам-ын тэблиг аргын ялгаатай шинж нь хүмүүст халамж ба энэрлээр дүүрэн уяхан нэгэн зүрх мөн. Түүнд хүмүүст өршөөлөөр хандах ба даруу зан мэтийн агуу байдлын шинж анхаарал татна.

Хазрат-и Сүлэйман -алэйхиссэлам-ын ам дамжин яригдсан тэр нүд гялбуулам хааны цолоос байтугай, даруу зан ба шүкүрээр зүрхээ хадгалан Эрхдээ боолчлоход дэвшсэн нь гайхмаар үйл юм.

Хазрат-и Эйюүб -алэйхиссэлам-ын амьдралд зовлонг тэвчих ба яасан ч Аллахад шүкүр хийхийн агуу илрэхийлэл байдаг.

Хазрат-и Юүнүч -алэйхиссэлам-ын амьдрал нь Аллахад чиглэж холбогдох ба алдаанаасаа болж гэмшиж тавбаг хатуу барихын төгөлдөр нэгэн жишээ юм.

Хазрат-и Юүсүф -алэйхиссэлам- нь олз байхдаа ч Эрхэд үнэнч байх ба урилгын оргилд хүрсэн юм. Тэр нь хөрөнгө ба нэр алдартай гоо сайхан нэгэн эмэгтэйн **"За, надад ирээч"** гээд хүний сэтгэл татам санал болгосонд ч агуу нэгэн ариун зан толилуулсан байдаг. Түүний өндөр такватайгаар чимэглэсэн зүрх нь төгс хандах аргын гайхамшигт булагтай адил.

Хазрат-и Давуд -алэйхиссэлам-ыг амьдрал нь тэнгэрлэг содон өмнөх сургаалаар дүүрэн байдаг. Түүний хашетуллахаар дүүрэн, нулимсаа гоожуулан хамд сэнаагаар Аллахын дурдсан бөгөөд хүслээ ерөөж Аллахад чиглэсэн нь их сургаалтай юм.

Хазрат-и Я'куб -алэйхиссэлам-ын амьдрал бол хүний нүдэнд дэлхийг бүүдийсэн ч гунихгүйгээр сайхан тэвчээрээр Аллахад холбогдох ба Түүний рахматаас найдвар таслахгүй байх хэрэгтэйн том нэгэн жишээ мөн.

Пайгамбарчуудын тэргүүн асан **Хазрат-и Мухаммед Мустафа** -саллаллаху алэйхи вэ сэллэм- Эзний маань амьдрал бол Түүнээс өмнө ирсэн, -дамжуулан мэдээлснээр- 124 мянга гаруй пайгамбарын мэдэгдсэн ба мэдэгдээгүй хамаг тусгай шинжийн бүр цаашийг нь эзэмшсэн, сайхан ёс суртахуун ба ааш зангийн оргил бүрдсэн байдаг. Түүнийг ариун амьдрал бараг уужим

нэгэн далай, бусад пайгамбарчуудын амьдрал бол түүнд зутгах мөрөнтэй адил.

❁

Хазрат-и Адам -алэйхиссэлам- ба Хавва эхтэйгээ эхэлсэн хүний гэр бүл нь шашны энх тайван ба жаргалын уур амьсгалд амьдарсаар өнөөдөр Макка дахь Кабаг оршсон газрыг анхны залбирал үйлчилгээний орон болгов. Аж ахуй ба нийгмийн хэрэгцээнээс болж дэлхийд тарсан Адамынхан, заримдаа пайгамбарчуудаар заалгаад шашны амьдралыг үргэлжлүүлсэн ба ингээд тэнгэрлэг үнэнийг дамжуулсан байдаг. Угаасаа тэнгэрлэг үнэн нь Хазрат-и Адам -алэйхиссэлам-аас эхлээд заримдаа хэн нэгэн шашны дайсан ба мунхаг хүмүүсийн гарт эвдэрсэн, гэтэл Аугаа Эрх нь үе үеэр пайгамбар илгээх аргаар уг алдааг арилгаж шашны амьдралыг дахиад сэргээсэн байдаг. Ингээд хүний хорвоог бие болон нийгмийн бухимдлаас аварсан байдаг.

Эцэст нь дэлхийн өдрийн оройтой төсөөтэй жаргалын үе ирж Пайгамбар Эзэн маань **Хазрат-и Мухаммед Мустафа** -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн хамт шашны амьдрал анх эхэлсэн оронд сүүлийн удаа төгс оргилд хүрэв. Одоо оргилыг бүрдсэн Мухаммедын дараа шинэ нэгэн төгсийг төсөөлөх арга үгүй. Учир нь пайгамбарчууд илгээх аргаар шашныг дахин сэргээх нь Түүгээр цэглэсэн, Аллахын таатай зөвшөөрсөн шашин Ислам болсон байдаг.

Пайгмбар Эзэн маань Хүн Байсан нь

Аллах Таала нь хүмүүст өөрсдийнх төрлөөс, тэдний хооронд амьдарсан ба амьдралыг нь хамаг жижиг зүйлсээр нь мэддэг пайгамбарчууд илгээв. Аугаа Раб маань мүшрикчүүдийг

гайхамшиг нэхэхлээр нь Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм-д ингэж хэлэхийг нь вахий хийв:

قُلْ سُبْحَانَ رَبِّي هَلْ كُنتُ إَلاَّ بَشَراً رَّسُولاً. وَمَا مَنَعَ النَّاسَ أَن يُؤْمِنُواْ إِذْ جَاءهُمُ الْهُدَى إِلاَّ أَن قَالُواْ أَبَعَثَ اللّهُ بَشَراً رَّسُولاً. قُل لَّوْ كَانَ فِي الأَرْضِ مَلآئِكَةٌ يَمْشُونَ مُطْمَئِنِّينَ لَنَزَّلْنَا عَلَيْهِم مِّنَ السَّمَاءِ مَلَكاً رَّسُولاً

“…Ингэж хэл: «Раббыгаа дээшлүүлье. Би хүн буй элчээс өөр юм биш.» Хүмүүст аврал ирэхэд, итгэхийг саад хийгсэд зөвхөн: «Аллах нь пайгамбар болгож нэгэн хүнийг илгээв үү?» гэцгээдэг. Ингэж хэл: «Дэлхийд амар тайван оршигчид явагчид нь (хүмүүс биш) **мэлэк байсансан бол, Бид ч тэдэнд тэнгэрээс пайгамбар болгож мэлэк илгээхсэн.»”** (эл-Исра, 93-95)

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- нь Аллах Таалагийн зөвшөөрөлгүйгээр өөрийнх мэдлээрээ гайхамшигт үйл илрүүлж чадахгүйгээ, өөрийнхөө ч тэдэн шиг хүн буйгаа илэрхийлэв.

Аугаа Эрх маш олон aет-и кэримэд:

قُلْ إِنَّمَا أَنَا بَشَرٌ مِّثْلُكُمْ يُوحَى إِلَيَّ أَنَّمَا إِلَهُكُمْ إِلَهٌ وَاحِدٌ

“Ингэж хэл: «Би ч тан шиг нэгэн хүн л мөн; гэтэл надад таны бурхан цорын ганц бурхан буй нь вахий болдог...»” (эл-Кэхф, 110) хэмээн айлдаж уг үнэнийг зарлав.[130]

130. Энэ тухай бусад aет-и кэримэчүүдийн төлөө хар. Фүссилэт, 6; эл-Мү’минүн, 24, 33; эл-Энбияа, 2-3; Ибрахим, 11.

Орчлонгийн Хүндэт -саллаллаху алэйхи вэ сэллэм- Эзний маань уг хадис-и шариф нь Түүний ч нэгэн хүн буйг ил далангүй зарладаг:

"Би ч тан шиг нэгэн хүн. Та асуудлаа шийдүүлэхээр надад ирдэг. Зарим тань хүчтэй буй, өөр зарим нь бол ятгагч буй тул би сонссоныхоо дагуу түүний талаар шийдвэр гаргаж мэднэ. Хэний талаар дүүгийнх нь эрхээс юм шийдсэн бол (үүнийг мэдээсэй), түүний төлөө тамаас галын хэсгийг зориулсан байх болно." (Бухарий, Шэхадат 27, Мэзалим 16; Муслим, Акдие 5)

Пайгамбарчууд зөвхөн вахийг тэблиг хийх төлөө биш, мөн түүнийг зохимжтой орчинд аж ахуйн арга болгож хэрэгжүүлэх, хамаг явдалд үлгэр жишээ нэгэн зан толилуулах ба идэвхтэй хэмжүүр болохоор томилогдов. Энэ бол хүний нийгэм дотуур хэрэгжиж мэдэх тул энэ үүргийг нэгэн хүн л хийж мэдэхсэн. Хэрэв хүмүүст элч болохоор нэгэн мэлэк илгээгдсэсэн бол тэр мэлэкийн хийж чадах ганцхан үйл вахийг хүмүүст ярьж өгөх байхсан. Учир нь мэлэк хүмүүсийн хамт амьдарч тэдний бодол, үйл ба хуулийг засахаар тэдний амьдрал ба хэрэгт тунш болж чадахгүйсэн. Хүмүүс ч энэ удаа өөрсдийнхөө мэлэк байгаагүйг илэрхийлэн ирсэн тушаал ба хоригт хүчээ хүргэхгүйн талаар шалтгаан санал болгохсон.

Үүнээс үзвэл Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- нь үммэтдээ үлгэр жишээ болох гэсэн үүрэгтэй байсан улмаас, амьдралаа үнэндээ нүбүввэтийн эрхээр хийж чадахаар байсан ер бусын аргаар авч яваагүй, ийнхүү ер бусын байдлыг ховор ба өөртөө л үзсэн байдаг. Амьдралыг нь дүүргэсэн үйл ажиллагааны жинхэнэ том хэсгийг хүний хүч чадлын хүрээнд хэрэгжүүлэв. Ийм учраас идеалын наймаачин, гэр бүлийн төгс тэргүүн, цэрэг эсвэл удирдлагын ер бусын дарга болох юмсан

хүн бүр нь Түүний амьралаас өөртөө удирдамж болгох зарим зарчим олж авч мэднэ.

Түүхийн турш хүмүүст, хүний Аллахын элч байж болохгүй гэсэн буруу нэгэн санаа байсаар байдаг. Пайгамбарууд өөрсдөө хүн байсан, хоол идсэн, эхнэр ба хүүхэдтэй болсныг нь бараг нэгэн дутагдал шиг ухаарсан, ингээд Аллахын хүсэлд буруу байсныг санал болгох зорилго үзүүлсэн байдаг. Маш олон пайгамбар, дундаас томилогдсон хүмүүсээс ийм нэгэн зарга сонссон байдаг.

Үүний эсрэгээр, зарим пайгамбарчуудын дагагчид ч пайгамбарчууддаа мэдэрсэн хайр ба холбоог хэтрүүлж, цаг хугацаа өнгөрөхөд түүнийг хүн байгаагүйд итгэхээр эхлэв. Пайгамбараа хэрэггүй хэт дээшлүүлж тэднийг бурхан шиг үзссэн, ингэж ширкэд унасан байдаг. Зарим нь пайгамбарчуудаа бурхан болгож, карим нь ч түүнийг Аллахын хүү, зарим нь ч Аллахын бодит дүрс гэж бодсон, тэвхидээс салж антропоморф нэгэн шүтлэг бий болгосон байдаг. Христийн шашинд ийм л болсон байдаг...

Кур’ан-и Кэрим болон хадис-и шарифуудад Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн хүн байсны тухай чухалчилж дурдсаны нэгдүгээрт учир нь өмнөх үммэтүүдийн унасан уг алдаанаас Мухаммедын үммэтийг хамгаалах юм.

Хазрат-и Умар -радъяллаху анх- нь Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн ингэж айлдсаныг дамжуулав:

“Минйи тухай, христчүүдийн Мэрьемийн хүү Есүст хийсэн хэтэрхий магтаал хэлүүзэй. Андашгүй нэг юм байвал би нь Аллахын нэгэн боол мөн. Миний тухай: «Аллахын боол ба элч » гэцгээ.” (Бухарий, Энбияа, 48)

Пайгамбар Эзэн маань -саллаллаху алэйхи вэ сэллэм- өөр нэгэн хадис-и шарифдаа, өөрийг нь хэтэрхий хүндэтгэл үзүүлсэн хүмүүсийн ингэж сануулсан байдаг:

"Та намайг миний эрх буй төвшнөөс дээш гаргуузай! Учир нь, Аллах Таала намайг пайгамбар болгохоос өмнө боол болгосон байв." (Хаким, III, 197/4825; Хэйсэмий, IX, 21)

Пайгамбар Эзний маань өөрийнхөө нэгэн хүн ба боол байсныг олон удаа дурдсаны өөр нэгэн учир бол, Түүний ухаан даруу зан мөн.

Жишээлбэл Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм- маш олон удаа Аугаа Эрхийн өөрт нь хайрласан шимүүдийг шимийн илэрхийллээр тоолсны дараа : *Бахархах үгүй"* хэмээн айлдав.[131]

Абдуллах бин Жүбэйр -радъяллаху анх- ярина:

"Нэгэн өдөр Эзэн маань -саллаллаху алэйхи вэ сэллэм- хэсэг сахабигийн хамт замдаа явж байхад, тэдний нэгэн дэвсгэр даавуутайгаар Аллахын Элчийг нарнаас хамгаалах юмсан. Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- нь хэн нэгний өөрийг нь сүүдэрлэснийг анзаараад түүнд шууд болихыг хэлж, дэвсгэрийг газар дээр тавив. Дараа ч:

«–Би ч тан шиг нэгэн хүн юм!» хэмээв." (Хэйсэмий, IX, 21)

Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- нэгэн хүн байсан ч ердийн хүн шиг биш байсныг ч мартаж болохгүй. Шүлэгчийн илэрхийлснээр:

"Хазрат-и Мухаммед -саллаллаху алэйхи вэ сэллэм- Эзэн маань нэгэн хүн, гэтэл бусад хүмүүс шиг биш юм. Чулуудын

131. Хар. Тирмизий, Мэнакиб, 1/3615.

дунд маргад ямар байдаг , хүмүүсийн хооронд Аллахын Элч ч тийм байдаг.”

Өөр нэгэн шүлэг уг үнэнийг бүтээлдээ ингэж дуулна:

Хүний түүхэнд ижил нь үгүй
Хэл болгонд түүний мөрөөдөл буй
Төгс мираж нь мэлэкчүүд
Гоо сайханд нь мэлэкчүүд
Бэлэг болгож үгийг нь ав
Хүн боловч мэлэкээс давуу

Пайгамбар Эзний Үммий Байсны Олон Учир

Үммий гэсэн үг нь эхээс төрсөн шигээ ариун, цэвэр үлдсэн, уншиж, бичиж мэддэггүй, хүний нөлөөгөөр хүмүүжил аваагүй, гэсэн утга агуулдаг.

Кур’ан-и Кэримийн илэрхийлснээр Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- үммий байсан, өөрөөр хэлбэл уншиж, бичиж мэддэггүй байв.

Ает-и кэримэ нь ингэж айлдана:

الَّذِينَ يَتَّبِعُونَ الرَّسُولَ النَّبِيَّ الأُمِّيَّ الَّذِي
يَجِدُونَهُ مَكْتُوباً عِندَهُمْ فِي التَّوْرَاةِ وَالإِنْجِيلِ

“Тэд хажуудах Тэврат ба Инжилд (бэлгэ тэмдгийг нь) **бичсэнээр олсон Тэр үммий Расулыг дагаж Түүний мөрөөр явна …”** (эл-А’раф, 157)

Орчлонгуудын Эзний үммий байсныг тэр үеийн мүшрикчүүд ч хүлээн зөвшөөрдөг байв. Жишээлбэл ает-и кэримэгийн мэдээлснээр тэд:

وَقَالُوا أَسَاطِيرُ الْأَوَّلِينَ اكْتَتَبَهَا فَهِيَ تُمْلَى عَلَيْهِ بُكْرَةً وَأَصِيلاً

“«Кур’ан нь эртний туульс юм; бусдад бичүүлсэн бөгөөд өдөр шөнөгүй түүнд уншуулдаг,» гэцгээв.” (эл-Фуркан, 5)

Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн үммий хэмээн нэрлэсний учрыг ингэж жагсааж болно:

1. Эхээсээ төрсөн шигээ цэв-цэвэр үлдсэн, гаднаас ирсэн мэдлэгтэйгээр жинхэнэ туурвил ба ариун шинж нь эвдрээгүй, Аллах Таала өөрөө хүмүүжсэн байдаг.

Ает-и кэримэ ингэж айлдав:

وَقَالُوا أَسَاطِيرُ الْأَوَّلِينَ اكْتَتَبَهَا فَهِيَ تُمْلَى عَلَيْهِ بُكْرَةً وَأَصِيلاً

“Чамд Кур’аныг Бид уншуулах ба Чи огт мартахгүй.” (эл-А’ла, 6)

Хадис-и шариф ч:

“Намайг Раб минь хүмүүжүүлээд, хүмүүжлийг минь маш сайхан болгов,” (Сүюүтий, I, 12) хэмээдэг.

Аллах Таала нь Хазрат-и Пайгамбар -алэйхиссалатү вэссэлам-ын цээжийг гурван удаа сүнсний мэс засал хийж (шэрх-и садр), зүрхэн дэх сөргүүдийн хаяж, оронд нь амар амгалан, энх тайван, энэрэл, халамж, итгэл үнэмшил ба гүн ухаан мэтийн агуу мэдрэмжийг байрлуулав.

2. Пайгамбар Эзэн маань Эхл-и китабт биш, Араб үндэстэнд харьяалагдана.

3. Эзэн маань -алэйхиссалатү вэссэлам- Маккад төрөв. Учир нь Маккагийн хэдэн нэрийн нэг ч Үммү’л-Кура юм. Карйэ нь Араб хэлэнд тосгон эсвэл жижиг суурьшмал газар

гэсэн утгатай. Үүний олон тоо нь “Кура” юм. Үммү’л-Кура нь эх буюу анхан суурьшсан газар гэсэн үг мөн.

Арабчууд ердөө үммий байв. Соёлоос хол, унших бичихийг мэддэггүй улс байв. Аллах Таала тэдэнд өөрийнх дотроос, ариун нь эвдрээгүй зүрхтэй оргилын пайгамбар илгээв.

Ает-и кэримэ нь ингэж айлдана:

هُوَ الَّذِي بَعَثَ فِي الْأُمِّيِّينَ رَسُولاً مِّنْهُمْ يَتْلُو
عَلَيْهِمْ آيَاتِهِ وَيُزَكِّيهِمْ وَيُعَلِّمُهُمُ الْكِتَابَ وَالْحِكْمَةَ وَإِن
كَانُوا مِن قَبْلُ لَفِي ضَلَالٍ مُّبِينٍ

“Үммийчүүдэд тэндий дундаас өөрсдөд (Аллахын) **аетуудыг уншигч, тэндийг ариутгаж цэвэрлэгч, Судар ба эрдмийг сургагч нэгэн пайгамбарыг Тэрээр илгээв. Мэдээж тэд өмнө нь лав төөрсөн хүмүүс байв.”** (эл-Жум’а, 2)

Хүндэт Нэбий -саллаллаху алэйхи вэ сэллэм- уг үнэнийг ингэж илэрхийлнэ:

“Бид үммий нэгэн нийгэм мөн. Бичиг ч бичихгүй, тооцоо ч мэдэхгүй!” (Мүслим, Съям, 15)

Үммий шинж нь эгэл хүмүүсийн хувьд ердөө шинжлэх ухааны талаар дутагдал илэрхийлж байхад, Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн хувьд бол яг эсрэгээр нь идэр ба давуу талыг илэрхийлнэ. Шинжлэх ухаан ба үйлийн идэр шинж нь уншиж бичигчдийг ч чадваргүй орхисон нэгэн пайгамбарын мөн үммий байсан нь Түүний шууд Аллахын илгээснийг баталсан ер бусын нэгэн гэрч мөн.

Эрх Таала Хазрат нь ингэж айлдана:

وَمَا كُنتَ تَتْلُو مِن قَبْلِهِ مِن كِتَابٍ
وَلَا تَخُطُّهُ بِيَمِينِكَ إِذاً لَّارْتَابَ الْمُبْطِلُونَ

“Чи үүнээс өмнө бичиг ч уншдаггүй, бичдэггүй байв. Тийм байсансан бол мухар сүсгийг дагагчид сэжигт автахсан.” (эл-Анкэбут, 48)

Үммий хэн нэгний тэнгэрлэг баталгаа буюу вахий болохгүйгээр, зүрхний нээлтээр хамаг хүн ба дуганыг аргагүй үлдээсэн илэрхийллийн гайхамшиг Кур’ан-и Кэримийг бий болгох нь; Фароны туульс, Хазрат-и Мусагийн ээжийн туульс, Юүсүф -алэйхиссэлам-ын туульс мэтийн түүхийн явлыг мэдэх нь боломж үгүй юм.

Кур’ан-и Кэрим нь өнгөрсөн үммэтчүүдийн туульсуудыг, өнөөгийн түүхийн ухаан ба түүхийн гүн ухааны дагуу хамгийн сургамжтай буйгаар нь хүн төрөлхтөнд дайлна.[132]

Нөгөө талаас үммий байх нь Кур’аны дүрмийн түгээмэл болохын хамгийн бага шаардлага мөн. Жингийн тэргүүн нь хамгийн хүчгүй ба удаан нь юм,” гэсэн жишээгээр, Кур’ан-и Кэрим авчирсан буй хариуцлагыг хамаг хүн төрөлхтөнд хүргэх ба хэрэгжүүлэх боломжтой болохын тулд, гэсэн үүднээс үммийг хүний төвшний дунджаар авсан юм. Өөрөөр хэлбэл Исламыг ойлгож амьдарч чадахын тулд эгэл ба дундын хүн болох ч хүрэмжтэй юм. Дахиад ийм л учраас, Ислам нь өдөр тутмын залбирал үйлчилгээний цаг үеийг тогтоохдоо Нарны, сар ба

132. Тэврат ба Инжилд дурдсан зарим явдал нь өнөөгийн түүх ба модерн шинжлэх ухааны тогтмолтой зөрөлцдөг. Орчлонгийн туурвил ба эрин нь, хүний дэлхийд буусны түүх, Туфан буюу том үерийн туульс гэх мэт... (Хар. Maurice Bucaille, *Эерэг Ухааны Талаар Тэврат, Инжил ба Кур’ан,* х. 53-82, 157-175)

жилийн залбирал үйлчилгээний цаг үеийг тогтооход бол Сарны хөдөлгөөнийг голлон авав.

Кур'ан-и Кэрим нь үммий хүмүүсийн төвшинд буусан боловч хэзээ ч тэр байдлаар хэвээрээ байхыг нь ч хүсээгүй, тэднийг үммий байдлаас гаргаж номтой нэгэн үммэт болгохыг зорилго болгов. Жишээлбэл Ислам нь шив шинэ нэгэн иргэншил байгуулж, үүний голыг ч "эл-Китаб" буюу ном л хэмээн нэрлэсэн Кур'ан-и Кэрим бүрдэж тавив.

Хилье-и Саадэт

Хилье нь толь бичигт гоёл чимэглэл, нүүр царай ба далдын гоо сайхан гэсэн утга агуулна. Фикихэд бол Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм- Эзний маань хүний хэлний боломжийн хүрээнд үгээр хийсэн зураг нь юм.

Нахифий ингэж хэлнэ:

"Гарцаагүй, хэн нэгэн хилье-и шарифыг бичиж түүнийг их харвал, Аллах Таала тэр хүнийг өвчин, төвөг ба гэнэтийн үхлээс хамгаална. Хэрэв нэг тийш зорчихдоо хамтдаа авч явбал, тэр замдаа байнга Аллах -жэллэ жэлалүхү-гийн хамгаалалтад байх болно."

Исламын олон зохиолч нь хилье-и шарифын тоолшгүй эрдмийнхээ тухай үзэл бодлоо илэрхийлсэн байдаг. Түүнчлэн Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийг зүүдлэхийн тулд ч хилье-и шарифыг цээжлэх заншил нь Исламын олон оронд өнөөдөр ч хүчинтэй юм.

Мөн, Хүндэт Хайр -саллаллаху алэйхи вэ сэллэм- Эзний маань "нурун ала нур" буюу туяан дээр туяа хэмээн тайлбарласан ариун царайг үгээр тайлбарлахад үгсийн хүрэмжгүй , хүн, Түүний үнэнийг гэрчлэх ба ухаарахад чадвар хүрэхгүйг

тооцох хэрэгтэйг бодох учиртай. Учир нь Аугаа Эрхийн хүн төрөлхтөнд хайрлаж өгсөн хамаг гоо сайхныг биендээ цуглуулсан тэр ижил ханьгүй оршигчийг, төгс утгаар нь тайлбарлах арга үгүй. Жишээлбэл Хаканийгийн хэлснээр:

"Хамаг оршигчид Түүний үнэн пайгамбар буйг мэддэг. Учир нь туурвигдагсдын хооронд Түүний ижил хань нь хэзээ ч бий болоогүй юм."

Хамгийн гоо сайхан Эзний маань зургийг үгээр зурахыг хичээсэн уг тайлбарууд, жаргалын үед хүрээгүй ба хагацлаар түлсэн сэтгэлүүдийг өчүүхэн ч гэсэн тайвширч тайтгаруулж байдаг. Эзнийг маань ярьдаг үнэт яриаг дамжуулсан хүмүүс бидэнд бараг далайгаас нэгэн дуслаар дайлна. Тус дусал дахь далайг харахыг хичээдэг итгэгчид нь Орчлонгуудын Эзэнд хайраа улам нэмж Түүний үсвэ-и хасэнэгээс ашиглаж, дүрс ба ёс суртахуунаар нь хамт байхыг хичээдэг.

Үнэхээр хүний сэтгэл, зүрх байнга гоо сайхан руу тэмүүлж, түүнтэй хамт байхыг хүснэ. Ийм хүслээс болж ухаан нь байнга түүнтэй орооцолдоно. Сэтгэлд нь сүнс ба ёс суртахуунаараа түүнийг дуурайх хүсэл төрнө. Эцэст нь дуртай хүнийг үлгэр жишээ болгож аваад түүнийг дуурайж эхэлнэ. Туурвилаас ирсэн ийнхүү эрмэлзэлээс болж Түүний төрхийг Пайгамбар Эзний маань эрмэлзэл, хайр ба хорхойг нэмэх шалтгаан болох нь андашгүй мөн.

Жишээлбэл Хазрат-и Хасан -радъяллаху анх- нь хойт нагац нь Хинд бин Эбий Халэгаас Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн төрхийг асууж байхад, түүний автсан мэдрэмжийн байдлыг ингэж илэрхилэв:

"Нагац Хинд бин Эбий Халэ нь Аллахын Элчийн хильег маш сайхан ярьдаг байв. Миний зүрхний Түүнд холбоотой

байх ба өөрөө Түүнийг дагаж явахын тулд нагацынхаа Аллахын Элчийн тухай ярих нь надад маш их таалагддаг байв.” (Тирмизий, *Шэмаил,* х. 10)

Сарнайн царайтай Эзний маань төрхийг сонсоод ханадаггүй Хазрат-и Хасан ба Хазрат-и Хүсэйн -радъяллаху анхүма- нар Түүний ариун царайг, аав Хазрат-и Али -радъяллаху анх-аас ч олон удаа сонссон ба бидэнд дамжуулсан байдаг.

Бичсэн тус шэмаил-и шарифууд нь Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн үнэний хэдэн хувийг илэрхийлж чаддаг вэ?!. Мэдээж шэмаил-и шарифыг хүн бүр нь сэтгэл дэх хайрын харьцаагаар ба үгээр хязгаарласан агуулах хүрээнд л ухаарч чадна.

Бид ч энэ тухай хүч чадалгүй буйгаа илчилж, бидэнд хүрч ирсэн яриануудаас сэтгэлд маань туссан шүүдэр шигээ, хилье-и шарифыг ойлгож дамжуулахыг хүсэв. Янз бүрээр дамжуулсан үгсэнд ингэж хэлдэг:

Хүндэт Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- нь өндөрт ойрхон дундаж нуруутай байв.

Бищ тэнхээ нь ер бусын тэгш болж, аятайхан биетэй байв.

Цээж өргөн, хоёр мөр нь завсартай байв. Хоёр далынхаа хооронд пайгамбарын тамгатай байв.

Яс ба үе нь нүсэрдүү байв.

Арьс нь сарнай шиг ягаавтар цагаан, туяат ба гялтагар, торгоноос зөөлхөн байв. Ариун бие нь байнга цэвэр бөгөөд анхилуун үнэртэй байв. Үнэр түрхсэн ч түрхээгүй ч арьс ба хөлс нь хамгийн гоё үнэрээс таатай байв. Хэн нэгэн Түүнтэй гар баривал өдөр жингөө Түүний таатай үнэр ханхална. Бараг сарнай нь үнэрээ Түүнээс авсан юм шиг байв. Ариун гараар

нэгэн хүүхдийн толгойг илбэл, тэр хүүхэд сайхан үнэрээрээ бусад хүүхдүүдээс ялгардаг байв.

Хөлрөхдөө хөлс нь сарнайн навч дээрх шүүдрийг санагдуулна.

Өтгөн сахалтай байв. Сахлаа тавивал нэг атгаснаас илүү уртасгахгүй байв. Өөд болоход нь гэзэг ба сахалд нь хорь орчим буурал үс байв.

Хавирган хөмсөгтэй бөгөөд, хоёр хөмсөгийн хооронд нэг нэгээсээ завсартай байв.

Хоёр хөмсөгийн хооронд нэгэн судас байсан бөгөөд Эрхийн төлөө хилэгнэхэд нь хөөрдөг байв.

Сувд шиг шүдтэй бөгөөд байнга мисвак гэдэг сойз хэрэглэдэг, ихэнхэд хэрэглэхийг санал болгодог байв.

Сормуус нь урт ба хар байв. Нүд нь томоохон, хар нь тас хар, цагаан нь цав цагаан байв. Сорвинд нь урьд дээр цагт хүчтэй гараар татсан хар зурвастай юм шиг байв.

Шилмэл сүнсний байдынх нь төгс төгөлдөр шигээ, биеийн төрх нь ч ижилгүй байв.[133]

Царай нь шөнө тэргэл сар шиг гялалздаг байв. Хазрат-и Аиша -радъяллаху анхаа- ингэж ярина:

“Расулаллахын царай нь маш их туяат байсан чинь, шөнийн харанхуйд зүү сүвлэхээр гэрэлтүүлнэ. .”

Хоёр далны хооронд пайгамбарыг батлах тэнгэрлэг нэгэн тэмдэг байв. Олон сахаби тэрийг үгсч чадах хүслээр шатдаг

133. Хар. Хаким, III, 10; Ахмад, I, 89, 96, 117, 127; IV, 309; Ибн-и Са’д, I, 376, 412, 420-423; II, 272; Ибн-и Кэсир, *эл-Бидая,* VI, 31-33; Тирмизий, *Шэмаил*, х. 15.

байв. Өөд болоход нь тус тамга алга болсон нь, Түүний харьсны баталгаа болов.[134]

Ариун ба туяат бие нь өөд болсны дараа ямар өөрчлөлт ороогүй. Жишээлбэл Хазрат-и Эбү Бэкир -радъяллаху анх- нь гунигтай, нүд ба сэтгэл нь нулимстай буйгаараа “Оршигчийн Туяа”нд хараад:

“Амьдрал шиг өөд болох чинь ч маш гоё, аяа Расулаллах аа!..” гээд, ариун магнайд нь уруулаа хүргэв.

Аллахын Элчийн зүрх ямар уяхан байсныг тайлбарлахын аргагүй байв.

Хэрэггүй үг хэлдэггүй бөгөөн үг бүр нь эрдэм ба сургаал байв. Толь бичигт нь хов ба хоосон яриа огт ороогүй. Хүн бүрт оюун ухааных нь дагуу үг хэлдэг байв.

Уяхан ба даруу зантай байв. Инээхдээ чанга дуугаар хэтрүүлдэггүй байв. Байнга мишээдэг байв.

Түүнийг гэнэт харсан хүн цочих мэдрэмжид автдаг байв. Түүнтэй уулзаж ярилцсан хүн нь Түүнд чин сэтгэлийн хайртай болдог байв.

Эрдэмтэй хүмүүсийг тэдний төвшний дагуу хүндэлдэг байв. Садан хамаатнаа их хүндэлдэг,их дайлдаг байв. Гэр бүлийнхэндээ болон асхабдаа сайнаар хандсанаас үл баран, бусдад ч эелдэг ханддаг ба:

“Таны хэн нэгэн өөрийнх тухай хүссэнээ итгэгч дүүгийнхээ тухай ч хүсэхгүй байхдаа төгс итгэгч байж чадахгүй,” хэмээн айлддаг байв. (Бухарий, Иман, 7; Мүслим, Иман, 71-72)

134. Тирмизий, *Шэмаил*, х. 15; Ибн-и Са’д, II, 272.

Үйлчлэгчиддээ сайнаар ханддаг байв. Өөрөө юу идэж өмсвөл, тэдэнд ч тэрийг идүүлж өмсгөдөг байв. Өгөөмөр, халамж ба энэрэлтэй, хэрэгтэй байвал зоригт ба хэрэгтэй байвал уяхан байв.

Амласан үгэндээ бат, хэлсэндээ үнэнч байв. Ёс суртахууны гоо сайхан, оюун ухааны талаараа хамаг хүмүүсээс давуу ба хамаг магтаалыг хүлээдэг байв. Төрх нь сайхан, амьдрал нь төгс, ижил нь туурвиагүй нэгэн ариун бие байв.

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- байнга гунигтай, таслалтгүй бодолтой байв. Шаардлагагүй байхад ярьдаггүй байв. Чимээгүй удаан байдаг байв. Үг хэлж эхэлбэл , заавал дуусгадаг байв. Бага үгээр олон утга илэрхийлдэг байв. Үг нь нэг нэгээр байв. Хэрэгтэй хэмжээнээс ч ихгүй ч багагүй ч байв. Туурвигдсанаасаа уяхан сэтгэлтэй байсан ч хүдэр чийрэг биетэй байв.

Хилэгнэвэл суусан газраасаа босдоггүй байв. Эрхэд эсэргүүцэх эсвэл эрхийг зөрчих тохиолдлоос гадна хилэгнэдэггүй байв. Хэн нэгний анзаараагүй нэгэн эрх зөрчсөн байхад хилэгнэж, эрх нь эзнээ олтол хилэн нь үргэлжилдэг байв. Гэтэл эрхийг эзэнд нь олгосны дараа тайвширдаг байв. Өөрийнхөө төлөө огт хилэгнэдэггүй байв. Өөртөө хамаатай байдалд хамгаалдаггүй, хэнтэй ч маргалддаггүй байв.

Тэр нь хэний ч гэрт зөвшөөрөл авахгүйгээр ордоггүй байв. Гэртээ байхдаа ч, тэнд байх хугацаагаа гурав хуваадаг байв; нэгийг Аллахад залбиран үйлчлэхдээ, нөгөөг гэр бүлийнхэндээ, гурав дахийг ч өөртөө зориулдаг байв. Өөртөө зориулсан цагаа хүмүүст зориулдаг, тэднээс хэнийг ч буцаадаггүй байв. Ингээд бүгдийн сэтгэлийг ээлдэг байв.

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн байдал ба үйл бүр нь Аллахыг дурддаг байв.

Тодорхой нэгэн хэсэгт нь суух нь хэвшил болохыг саатуулж, мэсжидийн бүх талд нь суусан удаатай байв. Газар орнуудыг ариун гэж үзэх ба цуглалтад томчуудыг дээшлүүлэх мэтээр хандахыг хүсдэггүй байв. Нэгэн цуглалтад орохдоо, хаана нь сул байвал тэнд сууж, хүн бүрийн ингэхийг хүсдэг байв.

Хэн нэгэн Түүнээс ямар нэгэн хэрэгцээтэй юм гуйвал, тухайн юм чухал эсвэл энгийн байсан ч, түүнийг өгөхгүйгээр ерөөсөө санаа амрахгүй, хэрэгцээг хангах нь боломжгүй байхад, ядаж сайхан нэгэн үгээр тухайн хүний сэтгэлийг хангахыг боддог байв. Тэр, хүн бүрийн бэрхшээлийг хуваалцагч байв. Хүмүүс нь ямар ч үүрэг ба суудалд байсан ч, баян-ядуу, эрдэмтэн-мунхаг хамаагүй, Түүний дэргэд хүн байх хүндээрээ эрх тэгш хандлагад хүртдэг байв. Хамаг цуглалт нь шинжлэх ухаан, хүмүүжил, итгэл, тэвчээр, хүндэт, бууж өгөх ба итгэмж мэтийн эрдмээр эзэлсэн орон байв.

Дутагдлаас нь болж хэнийг ч буруушаадаггүй, сануулах нь шаардлагатай болбол үүнийг, тухайн хүнийг гомдоохгүй эелдэг нэгэн байдлаар хэлдэг байв.

“Мусульман дүүгийнхээ автсан төвгийг хуваалцаж! Аллах Таала түүнийг рахматаараа тус төвгөөс аварч чамайг шалгана,” хэмээдэг байв. (Тирмизий, Киямат, 54)

Хэний ч ил гараагүй дутагдалтай оролдоогүйгээр үл барам, ийнхүү байдлыг эрэхийг ч хатуу хориглодог байв. Учир нь, бусдын тухай муугаар бодох ба тагнах нь тэнгэрлэг тушаалаар хориглосон байв.

Буяныг нь найдсан сэдвээс гадна ярьдаггүй байв. Яриа, цуглаанд гүн бодолтой байв. Түүнийг ярихад эргэн тойрныхон

чин сонороор сонсдог байсан нь, Хазрат-и Умар -радъяллаху анх-ын хэлснээр, толгой дээр нь шувуу буусан ч, нисэлгүй олон цаг байж чадах байв. Түүнээс асхабт нь дамжсан хүмүүжил ба ичэмхий зан нь Түүниээс юм асуухад ч -ихэнхдээ- зориг гэж үзээд, цөлөөс нэгэн бадавий ирээд Хазрат-и Пайгамбартай юм ярилцах болоод, Түүний эрдэм ба сүнснээс ашиглах болъё гэж найдвартай хүлээдэг байв.[135]

Түүнчлэн, Түүний хүдэр биеэс нь эмээдэг тул хоёр жил юм асуухгүйгээр хүлээгсэд нь байв. Хайраас нь ариун царай өөд нь харж чаддаггүй байв.

Амр бин Ас -радъяллаху анх- ингэж хэлсэн байв:

“Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-тэй удаан хугацаагаар хамт байлаа. Гэтэл Түүний онгонд мэдэрсэн ичгүүр ба Түүнийг хүндэтгэж байснаас болж, толгойгоо өндийлгөж ханатлаа ариун, туяат царайг нь ширтэж чадсангүй. Хэрэв өнөөдөр надад «Бидэнд Расулаллахыг тайлбарлаад, Түүний тухай ярь» гэвэл, надад итгээрэй, ярьж чадахгүй.” (Мүслим, Иман, 192; Ахмад, IV, 199)

Түүний агуу шинж ба чадварыг ярих юмсан хүн нь, “Би үүнээс өмнө ч дараа ч Түүний нэгэн ижлийг ерөөсөө хараагүй!” гэхээс өөр аргагүй болдог байв.[136]

Нэгэн өдөр Халид бин Вэлид -радъяллаху анх- нь Араб аймгуудын нэгэн дээр очоод, аймгийн тэргүүн нь түүнд:

“–Халид аа! Бидэнд Аллахын Элчийг, Түүний төрх ба амьдралыг тайлбарла,” гэсэн байв.

Халид -радъяллаху анх- бол:

135. Ибн-и Са’д, I, 121, 365, 422-425; Хэйсэмий, IX, 13.
136. Ахмад, I, 96.

“–Энэ нь боломжгүй, үүнд хэлэх үг яриа нь хүрэхгүй,” гэхлээр нь аймгийн тэргүүн:

“–Тэгэхээр ядаж мөрөөдөл ба ухааныхаа хэрээр товчил,” гэв.

Тэгэхлээр нь Халид -радъяллаху анх- ийм гайхамшигт хариултыг өгөв:

“–Чамд үүнийг л хэлж чадна, илгээгдсэн нь илгээсний хэрээр л байдаг. Илгээсэн нь Орчлонгийн Туурвигч байхад, илгээгдсэний алдрыг чи өөрөө бодож мөрөөд!..” (Мүнавий, V, 92; Касталаний, *Мэвахиб-и Лэдүнние Орчуулсан нь,* х. 417)

Түүний гоо сайхан, хүдэр бие, туяа ба эелдэг байдал нь тийм агуу байсан нь, Аллахын Элч байсны тухай өөр тусгай нэгэн гайхамшиг эсвэл баталгаа хэрэггүй байв.

Товчоор нь Түүний ёс суртахуун нь Кур’ан байв. Үүнийг Муаллим Нажи маг сайхан илэрхийлсэн байдаг:

Кур’аны гоо сайхныг харсан нь Чамд дурлана
Кур’ан нь чиний төлөө хүчний гараар бичсэн нэгэн хилье мөн

Мавлана Халид-и Багдадий Хазрат ч, Аллахын Элчийн магтам ёс суртахууны хамаг оршигчдыг хөөрүүлснийг ингэж илэрхийлнэ:

“Тэр нь маш гоё нэгэн өгөөмөр байсан бөгөөд, Түүний гоо сайхан оргилсон биеийн ачаар тэнгисээс сувд, хатуу чулуунаас маргад, өргөснөөс сарнай гардаг. Хэрэв цэцэрлэгт Түүний сайхан ёс суртахууныг яривал, баяр хөөрөөс болж амаа нээж инээсэнгүй, өөрөөр хэлбэл дэлгэрээгүй нэгэн нахиа харж чадахгүй юм.” (*Диван,* х. 65-66)

Хамаг гоо сайхан нь Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-д цугларсан байв. Биеэс нь бараг туяа цацардаг байв.

Тэгсэн ч Аллахын Элчийг хамаг гоо сайхнаар нь хэн ч харсан биш юм. Жишээлбэл Имам Куртубий ингэж хэлнэ:

“Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн сайхан царай нь бүрэн ил болоогүй юм. Хэрэв биеийнх хамаг гоо сайхан нь хамаг буйгаар нь харагдсансан бол, асхабынхан Түүнд харахдаа хүч хүргэж чаддаггүй байв.” (Али Ярдым, *Манай Пайгамбарын Төрх*, х. 49)

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн шүлэгч Хассан бин Сабит -радъяллаху анх- нь Түүний туурвилтын гоо сайхны ижилгүйг ингэж бичив:

وأحسن منك لم تر قد عين   وأجمل منك لم تلد النساء

خلقت مبرء من كل عيب   كأنك خلقت كما تشاء

(Аяа Расулаллах аа! Ямар ч нүд нь Чамаас гоёыг хараагүй юм. Хэн нэгэн эмэгтэй ч Чамаас гоёыг төрөөгүй юм. Чи хамаг дутагдлаас хол буйгаар туурвигдав. Бараг туурвигч нь Чамайг Чиний хүссэн шигээ туурвив…)

Вахий Дахиад Эхэлсэн нь

Вахийн фэтрэт буюу тасралт зургаан сар үргэлжлэв.

Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- вахийн дахи-ад эхэлснийг ингэж ярина:

“Би (нэгэн өдөр) алхаж байхдаа гэнэтхэн тэнгэрээс дуу сонсов. Толгойгоо өндийлгөв. Нэг харвал Хирад надад ирсэн мэлэк (Жэбраил) тэнгэр газар хоёрын хооронд нэгэн оронд суув. Би ихээр цочлоо. (Гэртээ) хариад:

«Намайг нөмөргө, намайг нөмөргө!» гэлээ.

(*Намайг нөмөргөсөн байхад, Жэбраил -алэйхиссэлам- ирэв.) Аллах Таала, (түүний аргаар надад):*

يَا أَيُّهَا الْمُدَّثِّرُ. قُمْ فَأَنذِرْ. وَرَبَّكَ فَكَبِّرْ.
وَثِيَابَكَ فَطَهِّرْ. وَالرُّجْزَ فَاهْجُرْ

“Аяа нөмөргөн бүрдсэн (Пайгамбар)**! Босоод,** (зовлонг) **сануул! Раббаа дээшлүүл!** (Өөрөөр хэлбэл түүний агуу байдлыг яриад хүн бүрт мэдүүл!) **Хувцсаа цэвэрлэ!** (Өөрөөр хэлбэл ил, далд бүх талаа цэвэр байлга; сайхан ёс суртахуун эзэмш!) **Муухайгаас хол бай!”** (эл-Мүддэссир, 1-5) *аетуудыг буулгаж өгөв.*

Вахий нь (түүнээс хойш) дахиад тасраагүй.” (Бухарий, Тэфсир, 74/4, 5; Мүслим, Иман, 255-258)

Аллах Таала ингэж айлдана:

وَلَقَدْ وَصَّلْنَا لَهُمُ الْقَوْلَ لَعَلَّهُمْ يَتَذَكَّرُونَ

“Тангараг өргөе, Бид бодоод сурч авцгаааг гэж вахийг нэг нэгийг дагуулан хүргүүлэв (вахийг таслалтгүй илгээв)**.”** (эл-Касас, 51)

Вахийн таслалтгүй үргэлжилсэн нь ч Кур’ан-и Кэримийн гайхамшгаас юм. Учир нь хамаг хүн төрөлхтнийг хамтран ба тусламжид гуйх хүн бүрийг ч дуудаад хэрэгжүүлж чадахааргүй агуу аетуудыг Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-д дараалалтай буусан нь Кур’ан-и Кэримийн вахийн бүтээл байсныг лав баталж байдаг. Энэ нь түүнд ямар ч хүний оруулалт байгаагүйн хамгийн тодорхой баталгааны нэг юм.

Нөгөө талаас хамгийн жижиг нэгэн шүлгийн ном ч удаан хугацааны хүнд ажлын үр дүнд бүтсэн нь тодорхой юм. Мөн хэр их анхаарал үзүүлсэн ч хүний бүтээл гэж хэлэх ч аргагүй

юм. Гэтэл тэнгэрлэг вахийд ийм нэгэн шинж яриад байдаггүй бөгөөд, тэр нь анхны байдлаараа мөнх, тоолшгүй гайхамшгийг агуулсан ба хүний хамаг дутагдлаас хол нэгэн үг буйгаараа хүн төрөлхтөнд дайлсан байдаг. Энэ ч Кур'ан-и Кэримийн үнэн ба өндөр шинжтэй буйг илэрхийлэхэд хүрэмжтэй юм.

Мүддэссир Сураг буухлаар нь Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- амрахаар хэвтсэн орноос шууд босов. Хазрат-и Хатижа -радъяллаху анхаа- эх маань, юу болсныг мэдээгүй тул андууран:

"–Яагаад босоо вэ, амрахгүй ?" гэв.

Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- бол:

"–Одоо амралтын цаг өнгөрөв!" хэмээж, шинээр ирсэн вахийг мэдээлэв.

Жэбраил -алэйхиссэлам- вахий ирсэн анхны өдрүүдэд Пайгамбар Эзэнд маань абдэст авч мөргөл үйлдэхийг сургав. Аллах Таала нь Элчдээ таалагдах нэгэн залбирал үйлчилгээ тушаагаад Түүний баясгаж, царайг нь инээлгэсэн байв.

Орчлонгуудын Эзэн нь том баяр хөөртэй гэртээ харив. Аллахын өөрт нь хамгийн том дайлсан бэлгийг эхнэртээ мэдүүлж түүнд ч абдэст аваад мөргөл үйлдэхийг сургав.[137]

Анхны Мусульманчууд

Анх итгэж үнэмшсэн хүн нь Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- Эзэн маань мөн. Үүнийг ает-и кэримэ нь ингэж мэдүүлнэ:

137. Ибн-и Исхак, х. 117; Ибн-и Хишам, I, 262-263.

آمَنَ الرَّسُولُ بِمَا أُنزِلَ إِلَيْهِ مِن رَّبِّهِ وَالْمُؤْمِنُونَ

“Пайгамбар нь Раббынхаа өөрт нь буулгасанд итгэж үнэмшив…” (эл-Бакара, 285)

قُلْ إِنِّي أُمِرْتُ أَنْ أَعْبُدَ اللَّهَ مُخْلِصاً لَّهُ الدِّينَ.
وَأُمِرْتُ لِأَنْ أَكُونَ أَوَّلَ الْمُسْلِمِينَ

“Ингэж хэл: Надад Аллахад зориулан Тэрээрт боолчлогдохыг тушаагдав. Надад мусульманчуудын анхан болохыг тушаав.” (эз-Зүмэр, 11-12)

Орчлонгийн Хүндэт Эзний маань дараах анхны мусульман, хүндэт эхнэр нь **Хазрат-и Хатижа** -радъяллаху анх- байв.

Орчлонгуудын Эзэн нь аймгийнхаа доромжлол, шог ба зовлон мэтийн хатуу давралтыг үзээд гэртээ гунигтай харихад, Аллах Таала Түүний гунигийг Хазрат-и Хатижа эхийн маань тайтгаруулан урамшуулагч үгсээр нь хөнгөлүүлсэн, тэнгэрлэг үүргийг нь хялбаршуулсан байв.[138]

Хазрат-и Хатижа -радъяллаху анхаа-г итгэн үнэмшихээр нь Эзний маань охид **Хазрат-и Рукайя, Үммү Гүлсүм** ба **Фатима** ч мусульман болсон байв.[139]

Хазрат-и Али -кэррэмаллахү вэжхэх- ч Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- ба Хазрат-и Хатижаг мөргөл үйлдэхэд хараад:

“–Энэ юу вэ?” гэж асуусан байв.

138. Ибн-и Хишам, I, 259.
139. Ибн-и Са’д, VIII, 36.

Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-:

“–Энэ нь Аллахын өөрийнхөө төлөө сонгосон шашин мөн. би чамайг цорын ганц буй Аллахад итгэж үнэмшиж ба залбиран үйлчлэхэд, ямар ч ашиг ба аюул үгүй Лат ба Уззаг ч үгүйсгэхэд урьж байна!” хэмээв.

Хазрат-и Али -радъяллаху анх-:

“–Би уг шашныг одоо хүртэл хэзээ ч сонсоогүй! Аав Эбү Талибаас харилгүй яаж ч чадахгүй!” гэв.

Орчлонгийн Хүндэт Эзэн маань тэр үеэр мэдээлэх үйлээ нууцаар хэрэгжүүлээд байсан тул:

“–Еэ Али! Хэрэв мусульман болохгүй бол миний ярьсан энэ сэдвийг хадгал, битгий илрүүл!” хэмээв.

Хазрат-и Али тэр шөнө хүлээв. Аллах Таала түүний зүрхэнд Исламын хайрыг хайрлаж өгөв. Өглөөгүүр Пайгамбар Эзэн маань -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн дэргэд очоод Ислам шашны тухай зүйлс асуув. Авсан хариултын дагуу Аллахын Элчийн тушаалыг шууд гүйцэтгэн мусульман болов. Аавaасаа эмээж, мусульман болсноо хэсэг хугацаанд нууц байлгав. Хазрат-и Али тэр хооронд арван настай байв. (Ибн-и Исхак, х. 118; Ибн-и Са’д, III, 21)

Пайгамбар Эзэн маань -саллаллаху алэйхи вэ сэллэм-мөргөл үйлдмээр байхдаа Хазрат-и Али -радъяллаху анх-ын хамт Маккагийн хөндий рүү одоод хүмүүсээс нууцаар мөргөлөө тэнд үйлдэж, орой харьдаг байв. Энэ нь Аллахын хүссэн цаг болтол ингэж үргэлжлэв.

Эбү Талибыг хөвүүн ба хайрт ачийнхаа нууцаар мөргөл үйлдэж буйг мэдэхлээр нь Пайгамбар Эзэн маань их хайртай

авга ахыгаа ч Исламд урив. Эбү Талиб бол уг урилгыг ингэж хариулав:

"–Миний дүүгийн хүү! Овог дээдсийнхээ шашнаас салахад миний хүч хүрэхгүй! Гэтэл Чи томилогдсон юм дээрээ үргэлж яв! Валлахи намайг амьд байхад Чамд хэн ч аюул учруулж чадахгүй!"

Хазрат-и Алид ч:

"–Миний хүү! Тэр нь чамайг зөвхөн буян ба сайнд л урина. Чи Түүний замыг бат барь. Түүнээс огт битгий сал!" гэв. (Ибн-и Хишам, I, 265)

Абдуллах бин Мэс'үд[140] -радъяллаху анх- Маккад наймаа хийхээр ирсэндээ Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийг Хазрат-и Хатижа ба Хазрат-и Алигийн хамт Кабаг тойрч байхад харсныг ба тэр хооронд Хазрат-и Хатижагийн биеэ нөмрөхдөө маш их анхаарсныг хэлээд байдаг. (Зэхэбий, *Сиер,* I, 463)

Үфэйф эл-Киндий ч наймаа хийхээр Маккад ирээд Аббас -радъяллаху анх-ын гэрт зочин болсон байв. Үфэйф

140. **Абдуллах бин Мэс'үд** -радъяллаху анх- анхны мусульманчуудаас юм. Хоч нь Эбү Абдуррахман юм. Мусульман болсон өдрөөс эхлэн Хазрат-и Пайгамбараас салаагүй бөгөөд Түүнд үйлчлэхэд сэтгэл ханамжтай байв. Ибн-и Мэс'үд нь туранхай, нарийхан хүн байв. Зөөлхөн дуутай, энхрий царайтай байв. Мусульман болоход нь мусульманчуудын тоо нь маш цөөн байв. Мүшрикчүүд түүнд Маккад амар заяа үзүүлээгүй. Тэр Мадинад нүүж Муаз бин Жэбэлийн дэргэд хоргодов. Хазрат-и Пайгамбарыг нүүсний дараа Мадинад суурьшив. Дайн бүрт оролцов. Хазрат-и Пайгамбар нь түүний Кур'ан уншихыг сонсох дуртай байв.
Тэфсир, хадис ба фиких талбайд уудам мэдлэгээрээ маш олон эрдэмтэн боловсруулав. Ялангуяа Куфагийн эрдэмтэд түүний дамжуулсан үг ба бодлын дагуу үзэл саналаа илэрхийлсэн байдаг. Өөрөө 848 үг дамжуулсан байдаг. Хазрат-и Усманы эринд Куфагийн кадий буюу шүүгч ажлаас Мадинад буцаж их удахгүй, жаран хэдэн насандаа нас барсан байв.

нь Пайгамбар Эзнийг маань, Хазрат-и Хатижаг ба Хазрат-и Алиг Кабад мөргөл үйлдэж байхад харсан, Аббас -радъяллаху анх-аас тэдний талаар мэдээлэл нэхсэн байв. Хазрат-и Аббас ч тэдний тухай ярьсны дараа:

“–Валлахи ыи дэлхий даяар энэ шашныг шүтсэн уг гурваас гадна хэнийг ч мэдэхгүй!” гэсэн байв.

Үфэйф -радъяллаху анх- авралаар хүндэлсний дараа байн-га ингэж санаа зовдог байв:

“–Тэр үеэр би итгэн үнэмшигч хоёр дахь эрэгтэй итгэгч нь болоогүй яасан бэ! Тэдний дөрөв дэх болохыг маш их хүснэ шүү!” (Ибн-и Са’д, VIII, 18; Ибн-и Хажар, *эл-Исабэ,* II, 487)

Пайгамбар Эзний маань чөлөөлсөн боол нь **Зэйд бин Хариса** -радъяллаху анх- нь Хазрат-и Алигийн дараа мусульман болж, мөргөл үйлдэж, Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн харъяа болон үйлчилгээнээс хэзээ ч салаагүй байв. Таифын таг-найчуудын Пайгамбар Эзэнд маань хаясан чулуудад өөрийнх биеэрээ халхавч хийгээд цусаар булах чинээ жинхэнэ хай-раар өөрийгөө Аллахын Элчид зориулсан, үүний хариугаар Орчлонгуудын Эзний тусгай хайр ба магтаалд хүртсэн байв.

Хүндэт Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн Хазрат-и Зэйдэд мэдэрсэн хайрын тухай Хазрат-и Умар -радъяллаху анх-ын энэ гэрчилгээ нь маш их утгатай юм:

Хазрат-и Умар -радъяллаху анх- нь Зэйдийн хүү Үсамэд гурван мянга дирхэм цалин тусгайлсан, хүү Абдуллахдаа бол түүнээс таван зуун дирхэм бага өгсөн байв. Абдуллах аав Умараасаа үүний учрыг асуун:

“–Үсамэг яагаад надаас давуу үзээ вэ? Тэр надаас илүү дайнд оролдоогүй юм аа!” гэв.

Хазрат-и Умар -радъяллаху анх- нь ижилгүй эрх тэгшийнхээ хамт сэтгэлийн баялаг болон агуу даруу занг нь илэрхийлдэг энэ гайхамшигт хариуг өгөв:

"–Миний хүү! Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- түүний аавд чиний ааваас илүү хайртай байв. Үсамэд ч чамаас илүү дуртай байв. Ийм л учраас Расулаллахын хайрласныг өөрийнхөө хайрласнаас илүүд үзэв." (Тирмизий, Мэнакиб, 39)

Энэ ба төсөөт маш олон жишээнд илэрснээр, асхаб-и кирам Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн хайрласныг өөрийнхөө хайрласнаас илүүд үздэг байв.[141]

Хазрат-и Эбү Бэзир -радъяллаху анх- нь номлох үүргээс өмнө ч Пайгамбар Эзний маань анд байв. Бага наснаас нь хойш Түүний сайхан ёс суртахуун, үнэнч ба итгэмжтэй занг нь гэрчилсээр байв. Сайхан ёс суртахуунаас нь болж ерөөсөө худал хэлдэггүй хүний Аугаа Эрхэд ч худал хэлэхийн ч аргагүй буйг боддог байв. Ийм учраас Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- түүнийг Исламд урихлаар, огт сандралгүй хүлээн зөвшөөрөв.[142]

Орчлонгийн Хүндэт Эзэн маань энэ тухай хадис-и шарифдаа:

"Аллах намайг танд Пайгамбар болгож илгээхэд эхлээд та надад «Чи худалч!» гэцгээв. Гэтэл Эбү Бэкир бол «Тэр зөв хэлж байна,» гээд амь ба бараагаараа надад хэтэрхий тусламжтай болов," хэмээн айлдсан байв. (Бухарий, Асхабу'н-Нэбий, 5)

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийг юу ч Хазрат-и Эбү Бэкирийн мусульман болсон шиг баясаагүй байв. Хазрат-и

141. Хэйсэмий, VI, 174; Ибн-и Са'д, IV, 30.
142. Ибн-и Кэсир, *эл-Бидая*, III, 78.

Эбү Бэкир -радъяллаху анх- мусульман болсондоо огт андалгүй мусульман болсноо илэрхийлсэн бөгөөд бусдыг ч Аллах Таала болон Элчид нь итгэн үнэмшихэд урьж эхлэв.[143]

Пайгамбар Эзний маань амьдралд Хазрат-и Эбү Бэкирийн тусгай ба чухал нэгэн байр суурь байдаг. Учир нь, нэгэн зорилгыг хэрэгжүүлэхийн гурван шалтгаан байдаг:

1. Нэгэн бат бодол.

2. Тус бодлын эргэн тойрны бие бүрэлдэхүүн хүмүүс.

3. Эдийн засгийн боломж.

Бат бодол нь Исламын хүрээ байсан бөгөөд, вахийгаар тогтсон байдаг. Хазрат-и Эбү Бэкир -радъяллаху анх- бусад хоёр шалтгаанд маш чухал үүрэг даасан байв. Өөрөөр хэлбэл бие бүрэлдэхүүн түүгээр эхэлсэн бөгөөд, тэр ариун сахабигийн гайхамшигт хөрөнгө нь Исламын янз янзын үйлчилгээний зэрэг мусульман болсон боолчуудыг худалдаж авах чөлөөлөх мэтийн бодол хэргийн эдийн засагт ч хэрэглэсэн байдаг.

Уг хоёр сэдвийг жаахан тайлбарлах юм бол; Хазрат-и Эбү Бэкиртэй Пайгамбар Эзний маань залуу үед хүрсэн анд ба хамтлагын харьцаа нь номлох үүрэг олгосны дараа сүнсний хүрээний найрамдлаар эргэв.

Хазрат-и Эбү Бэкир -радъяллаху анх- анх итгэн үнэмшигчдээс байснаас үл барам итгэлдээ сэжгийн тоосыг ч буулгалгүй **“Сиддийк”** буюу үнэнч гэсэн нэрийг хүртсэн байдаг. Дараахь үед ч Исламыг хөгжүүлэх ба тараах төлөө сүнсний ба эд барааны хамаг юмаа андалгүй зориулсан бөгөөд хамаг бараанаа Аллахын замд тараасан байв.

143. Ибн-и Кэсир, *эл-Бидая*, III, 80-81.

Хайрын шаардлага буюу хууль нь хайрласан хүний дуртай юмд дурлах, түүний хүслийг өөрийнхөө хүслээс илүүд үзэх ба хайрынхаа төлөө хамаг юмаа зарцуулж чадахаар болох юм. Хазрат-и Эбү Бэкир -радъяллаху анх-ын амьдрал нь Аллахын Элчид хайр, холбогдол ба түүний хүрэх оргил болох жишээгээр дүүрэн байдаг:

Нэгэн өдөр сэтгэлийн хаан Эзний маань өвдсөнийг сонссон Хазрат-и Сиддийк нь санаа зовсноосоо өөрөө ч өвдөөд унасан байв.

Энэ хоёр андын хоорондын агуу хайрын үр дүн болсон нэг ба ижил болох улмаас Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-:

“Эбү Бэкир нь надаас, би ч түүнээс хамааралтай. Эбү Бэкир дэлхий ба ахиратад миний дүү мөн,” (Дэйлэмий, I, 437) хэмээн айлдаж , зүрхнээс зүрхэнд урсдаг байдлыг дамжуулалтыг баталж өгөв.

Эзэн маань -алэйхиссалатү вэссэлам-ын хэрэг болох гудсандаа байхдаа:

“Хамаг хаалгад хааг; зөвхөн Эбү Бэкирийнх л үлдэг!” (Бухарий, Асхабү’н-Нэбий, 3) хэмээсэн магтаал нь Хазрат-и Эбү Бэкиртэй хоорондох сэтгэлийн холбоо ба тусгай дотно харилцааны хамгийн сайхан илэрхийллийн нэг мөн.

Билал-и Хабэший ба **ээж нь** ч, Аллахын Элчийн хүмүүсийн Исламд нууцаар урьж эхэлсэн анхны өдрүүдэд мусульман болцгоов. Хазрат-и Билал -радъяллаху анх- нь мусульман болсноо зарласан анхны долоон хүний нэг байв. Шашнаасаа буцахын тулд хийсэн харгислалыг тэвчдэг байв. Үгүйсгэхэд албадах тусам: “Аллах нэг мөн! Аллах нэг мөн!” гэдэг байв.

Хазрат-и Эбү Бэкир -радъяллаху анх- нь Хазрат-и Билал ба ээжийд төлөөс төлж тэднийг чөлөөлөв.[144]

Эбү Бэкир -радъяллаху анх- нь уг үйлээрээ Пайгамбарын магтаалыг хүртсэн, энэрэл ба өгөөмөр зангаараа хөшөө болсон байв.

Хазрат-и Мавлана -куддисэ сиррух- нь уг байдлыг сэтгэлийн хэлээр тайлбарлаж ингэж дамжуулна:

"Билал-и Хабэшийг мусульман болсон учраас ширүүн тамлалтад оруулсныг сонссон Хазрат-и Сиддийк нь Хазрат-и Мустафагийн онгонд гарч үнэнч санаатай Билалын байдлыг мэдээлэв."

"Ингэж хэлэв: Тэр аз заяаг хэмжих ариун биетэн Чиний хайрт автсан, сэтгэлээ Чамтай холбосон байдаг. Ийм учраас харгисчууд тэр мэлэк зантай хүнийг тамлана. Гэмгүй байсан ч жигүүрийг нь зулгааж авна. Тэр том эрдэнийг ширк ба босолгоны хөрсөнд булмаар байцгаана."

"Шатаагч наранд халуун элсэнд хэвтүүлж, нүцгэн биеийг нь өргөстэй мөчөөр зодоцгооно."

"Гэтэл тэр арьснаас нь гоожуур шиг цус оргилсон ч: «Аллах нэг мөн, Аллах нэг мөн!» гээд Эрхэд мөргөхөө болихгүй."

"Хазрат-и Ebû Bekr'in merhamet ve şefkatinden dolayı vücûdunun her zerresi mahzûn ve gamla dolu bir dil hâline gelmiş, Bilâl'in hâlini Хазрат-и Пайгамбар'е büyük bir üzüntü içinde uzun uzun anlatmaktaydı."

"Эцэст нь сэтгэл дэх зорилтоо зарлан: «Аяа Расулаллах аа! Би түүнийг худалдаж авмаар байна. Хамаг хөрөнгөө зар-

144. Ибн-и Са'д, III, 232; Хаким, III, 319.

цуулахаар бэлэн байна. Аугаа Эрхэнд сэтгэл өгсөн, Тэрээр болон Элчийнх нь боол болсон, ийм учраас ч Аллахын дайсдын харгислалд автсан, тамласан тэр ариун хүнийг тэр байдлаас нь авралгүй энэ аминд минь энэ хорвоонд амар үгүй,» гэв."

"Хазрат-и Мустафа -саллаллаху алэйхи вэ сэллэм- нь үүнд сэтгэл таатай болж: «Еэ Аллах болон Элчийнх нь энэрэлт анд аа! Энэ наймаанд би ч чамд түнш юм...» хэмээн айлдав."

"Хазрат-и Эбү Бэкир нь шууд Билалын эзний гэр лүү чиглэв. Билал нь хийсэн тамлалтаас болж ухаан балартсан байдалтай байв. Хазрат-и Билалын эзэн асан тэр энэрлийн ядуу хүнд гашуун үгс зарцуулав."

"Ингэж хэлэв: Еэ мухар! Еэ хилэнгээс нүд нь харлаган болсон, энэрлийн хувьгүй! Энэ Аллахын андыг яаж зодох нь энэ вэ? Еэ мөсгүй! Энэ нь юуны өшөө, юуны өс вэ?"

"Еэ энэрлийн ядуу! Өөрийгөө хүн гэж бодож байна уу? Еэ хүмүүнлэгийн ядуу, өшсөн хүн! Чи хүний төрхөнд мөн, гэтэл хүмүүнлэгийн гутамшиг юм!.."

"эдгээр үгсийн дараа Эбү Бэкир Эбү Бэкир -радъяллаху анх- нь тэр хүний шуналт нүдийг дэлхийн баялагаар дүүргэ. Тэгээд Билалын эзэн үүнд нэлээд гайхан, Эбү Бэкирийн байдлыг сонирхолтой үзэв."

"Түүний уг сонирхлыг анзаарсан Сиддийк-и Экбэр Хазрат нь тэр хувьгүйд ингэж хэлэв: Еэ тэнэг! Чи хүүхэд шиг, нэгэн чаагийн хариугаар надад үнийг нь тооцошгүй нэгэн сувд өгсөн, гэтэл мэдэхгүй байна! Билалын хоёр хорвоод үнэтэй байхыг мэдэхгүй. Би түүний сүнс рүү харна, чи бол арьсны өнгө рүү..."

"Хэрэв зарахдаа чи арай илүү дарсансан бол, түүнийг худалдаж авахаар бүр илүүг нь төлөх байв. Илүү дарсансан

бол, хамаг эд бараагаа төлж, түүнчлэн өрөнд ч орох байв. Тэгсэн ч энэ худалдаанаас би ашиг олох байв. Еэ хувьгүй хүн! Энийг сайн сур, эрдэнийн үнийг зөвхөн үнэт эдлэл нь мэднэ.”

Хазрат-и Мавлана -күддисэ сиррух- нь энэ туульсанд энэрэл ба халамжийн төгс нэгэн илрэлтийг толилуулснаар үл барам, төгс хүнд үнэ тооцох аргагүйг, өөрөө хэлбэл дэлхийн үнэт хүний сүнсний үнийн өмнө ямар ч утга үгүй буйг илэрхийлэн сэтгэлд маань агуу нэгэн үнэнийг илэрхийлнэ.

Хазрат-и Эбү Бэкир -радъяллаху анх- нь энэ баялаг сэтгэлийн хөдөлмөрөөр Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-д мэдэрсэн оргилын хайраа дахин нэг удаа толилуулсан байдаг.

Хазрат-и Эбү Бэкир -радъяллаху анх-ын Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-д мэдэрсэн хил хязгааргүй хайрын бэлгэ тэмдгээс зарим нь ийм байв:

-Түүний авчирсан Кур’ан-и Кэрим ба Исламын дүрэм журамд чин сэтгэлээрээ дурлаж, тэдний дагуу хандах.

-Түүний үммэтэд энэрэл ба халамж үзүүлж, тэдний ашгийн үйлсэд хичээх.

-Дэлхийг үл тоож, хэрэг болбол ядууралд бэлэн болох.

-Тэрээрт хүрэхийг хүсэх.

-Тэрээрийг ихээр дурдах.

Халид бин Саид -радъяллаху анх-ын авралыг бол үзсэн аймшгийн зүүд учир болсон байв. Нэгэн шөнө нойрондоо том нэгэн галын нүхний дэргэд сонссон бөгөөд аавыгаа түүнийг түлхээд галын дотор унагаамаар буй юм шиг хандсаныг, Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн бол түүнийг шууд нуруугаар нь бариад галын дотор унахаас аварсныг харав. Айсандаа сэрээд өөртөө:

“Аллахад тангараг өргөе, энэ нь зөв нэгэн зүүд мөн!” гээд Хазрат-и Эбү Бэкирийн удирдамжаар Пайгамбар Эзний дэргэд очоод Исламын хүндэд оров.

Аав нь хүү Халидынхаа мусульман болсныг сонсохлоороо түүнийг тамлаж:

“–Еэ дорой! Зайлаад од! Валлахи чиний хүнсийг ч тасална!” гэв.

Халид:

“–Чи миний хувийг саатуулахыг хичээсэн ч Аллах заавал намайг тэтгэх болно!” гэв.

Хазрат-и Халид нь Абиссинид нүүтлээ Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн хажуугаас огт салаагүй. (Хаким, III, 277-280)

Дараа нь Халидын эхнэр **Үмэйнэ Хатан**, дүү **Амр** ба түүний эхнэр **Фатима Хатан** ч Исламын хүндэд орцгоов.

Мэдээлэх үйл нь нууцаар явж байсан өдрүүдэд Эбү Бэкир -радъяллаху анх-ын урамшуулах ба тусламжаар **Эбү Фүкэйхэ, Хазрат-и Усман, Зүбэйр бин Аввам, Абдуррахман бин Авф, Са’д бин Эбий Ваккас, Талха бин Үбэйдуллах** -радъяллаху анхүм эжмаин- итгэн үнэмшлийн шимд хүртэв.[145]

Хазрат-и Усман -радъяллаху анх- нь Пайгамбар Эзэнд маань тааралдсан нэгэн байдлаа ингэж ярив:

“Аяа Аллахын Элч ээ! Дамаскад байхдаа, нойр сэрүүн хоёрын хооронд байсан үед гэнэтхэн:

145. Ибн-и Хишам, I, 268.

«Аяа унтагчид аа! Сэрцгээ! Учир нь Ахмад Маккад илрэв,» гэж нэгэн дуу сонсцгоов. Маккад эргэхлээрээ таны пайгамбар болсны мэдээг авцгаав.” (Ибн-и Са’д, III, 255)

Талха бин Үбэйдуллах -радъяллаху анх- ч ингэж ярив:

“Бусра Яармагт байсанд нэгэн лам нь хүмүүст:

«–Таны хооронд Харамын ардаас хэн нэгэн бий юү?» гэж асууж байв.

«–Тийм! Би байна» гэлээ.

Лам:

«–Ахмад илрэв үү?» гэж асуув.

Би:

«–Ямар Ахмад?» гэлээ.

Лам:

«–Ахмад бин Абдуллах бин Абдүлмутталиб! Тэр Маккад илрэх юм, сүүлчийн пайгамбар мөн. Харамаас гараад, хасарвааньт, чулуут ба цоглог нэгэн газар нүүнэ. Чамд Түүн рүү гүйхийг санал болгоё!» гэв.

Ламын хэлсэн нь зүрхэнд минь нөлөөлөв. Шууд тэндээс салж Маккад ирлээ:

«–Сонин сайхан юу байна?» гэж асуулаа.

«–Тийм, бий! Абдуллахын хөвүүн Мухаммедү’л-Эмин пайгамбар болсон байна. Эбү Бэкир ч түүнийг дагана,» гэцгээв. (Ибн-и Са’д, III, 215)

Эбү Үбэйдэ бин Жэррах, Эбү Сэлэмэ, Эркам бин Эби’л-Эркам, Усман бин Маз’ун, Эсма бинт-и Эбү Бэкир, Хаббаб бин Эрэт, Абдуллах бин Мас’уд, Абдуллах бин Жахш, Жафар бин

Эбий Талиб, эхнэр нь Эсма бинт-и Үмэйс, Эбү Хүзэйфэ, Амир бин Фүхэйрэ -радъяллаху анхүм эжмаин- анх мусульман болсон хүндтэй хүмүүс мөн.

Дару'л-Эркам: Анхны Мусульманчуудын Боловсрол ба Сургаалын Төв

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- анхны гурван жил Исламыг нууцаар мэдээлсэн, урилгыг нь хүлээж аваагүй хүмүүсээс энэ тухай хэнд ч эс ярихыг хүссэн байв.

Номлолын анхны жилд Эркам бин Эби'л-Эрзам -радъяллаху анх- мусульман болсны дараа асхаб-и кирам түүний гэрт нууцаар цуглаж эхлэв.

"Дару'л-Ислам" хэмээн ч мэдсэн "Дару'л-Эркам" нь Маккад Сафа Даваaны дэргэд оршдог байв. Пайгамбар Эзэн маань -алэйхиссалатү вэссэлам- Курайшийн мүшрикчүүдээс болгоомжилж энэ ариун гэрт орж, хажууд нь ирэгсдэд тэнд Исламыг ярьж, Кур'ан-и Кэрим уншиж сургадаг байв. Тэнд хамт мөргөл үйлддэг байв. Маш олон хүн Исламтай энд л танилцав.

Хазрат-и Умар -радъяллаху анх-ыг номлохын зургаа дахь жилд мусульман болтол, уг гэр Исламыг мэдээлж сургахад том үйлчилгээ хэрэгжүүлэв.

Эркам -радъяллаху анх- Дару'л-Эркамыг дараа нь сан болгов. Бичээс нь ийм байв:

"Бисмиллахиррахманиррахим. Энэ нь Эрзамын Сафагаас жаахан цаанахь гэрийнхээ тухай хийсэн гэрээслэл нь болоод, түүний газар хөрөнгө нь Харам-и Шарифаас тоолсон тул, тэр ч харам болсон, дархалсан байдаг: Зарж болон өвлүүлж үл болно.

Хишам бин Ас ба түүний чөлөөлсөн боол нь үүнийг гэрчилнэ.” (Ибн-и Са’д, III, 242-244; Хаким, III, 574-575/6129)

Дару’л-Эркамыг нь манай үед Саудын Арабын Вант Улс нурааж Харам-и Шарифын газар хөрөнгөнд нэмсэн буюу эхэнд нь буцаасан байдаг.

❁

Пайгамбар Эзэн маань -саллаллаху алэйхи вэ сэллэм- нь номлохын анхны гурван жилээ нууц урилгаар өнгөрөөв. Урилга нууц байсан нь Орчлонгийн Туяагийн ямар нэгэн тамлалт буюу төвөгтэй тааралдах айдсаас биш, шашны арга жамыг хадгалахын төлөө байв. Учир нь мэдээлэхийг ил хийх тухай ямар нэгэн тэнгэрлэг тушаал арай илрээгүй байв. Хэрэв энэ үед Исламыг илээр зарласансан бол, дөнгөж итгэн үнэмшсэн ихэнх нь ядуу ба хүчгүй мусульманчууд аюулд автаж, тэдний мөхсөн нь бол шашны эхлэхгүйгээр үгүй болохыг учруулж мэдэх байв.

Дару’л-Эркамын байдлаас Исламын аргын тухай эдгээр үр дүнг гаргаж болно:

1. Хэрэгтэй байхад нууцаар хандах нь нэгэн үзэл бодлын гол байх ёстой юм.

2. Боловсрол ба сургаал нь нийгэм, шашин ба улс төрийн ямар нэгэн явдлыг хэрэгжүүлэхийн анхны ба шаардлагатай алхам мөн. Бие хүмүүсийн чанар олохын тулд үзэл бодлын диалэктик ба ёс суртахуунаар төхөөрөх хэрэгтэй юм.

Үүнээс үзвэл Исламын үйл ажиллагаанд киямат хүртэл барих зам ба дагах аргыг нь Пайгамбар Эзэн маань -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн уг дадлагын гэрэл доор хэрэгжүүлэх хэрэгтэй юм. Исламын дахиад соёолох эсвэл огт хүрээгүй газруудад тараахын тулд хичээхдээ, боловсрол ба сургаалын уг үйл ажиллагаанд нэн тэргүүнд анхаарал тавих шаардлагатай.

Номлолын Дөрөв Дэх Жил

Зарлигийг Илэрхийл:
Хамгийн Ойртоо Үзүүл

Гурван жил явсан нууц хугацааны дараа буюу номлохын дөрөв дэх жилд Аллах Таала ингэж айлдав:

فَاصْدَعْ بِمَا تُؤْمَرُ وَاَعْرِضْ عَنِ الْمُشْرِكِينَ
اِنَّا كَفَيْنَاكَ الْمُسْتَهْزِءِينَ

"(Аяа Расул минь! Одоо) **Чамд тушаасан юмыг илэрхийл! Мүшрикчүүдээс нүүрээ эргүүл. Шоглогсдын эсрэг Бид Чамд хүрэмжтэй байх болно!"** (эл-Хижр, 94-95)

Эдгээр аетууд тэблиг ажлыг одоогоос хойш илээр хийхийг тушаасан байв.

Өөр нэгэн ает-и кэримэ ч энэ хэргийг дэлгэрэнгүй, түүнчлэн сануулах аргаар ингэж илэрхийлэв:

يَا اَيُّهَا الرَّسُولُ بَلِّغْ مَآ اُنْزِلَ اِلَيْكَ مِنْ رَبِّكَ
وَاِنْ لَمْ تَفْعَلْ فَمَا بَلَّغْتَ رِسَالَتَهُ وَاللّٰهُ يَعْصِمُكَ مِنَ النَّاسِ
اِنَّ اللّٰهَ لَا يَهْدِي الْقَوْمَ الْكَافِرِينَ

“Аяа Расул! Чамд буулгасныг мэдээл! Хэрэв тэгэхгүй бол, Тэрээрийн элчийн үүргээ гүйцэтгэхгүй байна гэж тооцогдоно! Аллах Чамайг хүмүүсээс хамгаалах болно. Мэдээж Аллах кафирчуудын нийгмийг авралд хүргэхгүй.” (эл-Маида, 67)

Одоо Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- нь Аугаа Эрхийн тушааснаар:

قُلْ يَآ اَيُّهَا النَّاسُ اِنّ۪ي رَسُولُ اللّٰهِ اِلَيْكُمْ جَم۪يعًا الَّذ۪ي لَهُ
مُلْكُ السَّمٰوَاتِ وَالْاَرْضِ لَٓا اِلٰهَ اِلَّا هُوَ يُحْي۪ وَيُم۪يتُ فَاٰمِنُوا
بِاللّٰهِ وَرَسُولِهِ النَّبِيِّ الْاُمِّيِّ الَّذ۪ي يُؤْمِنُ بِاللّٰهِ
وَكَلِمَاتِه۪ وَاتَّبِعُوهُ لَعَلَّكُمْ تَهْتَدُونَ

“Ингэж хэл: Аяа хүмүүс ээ! Андашгүй нь би Аллахын та бүхэнд илгээсэн Расул нь мөн. Аллах хамаг тэнгэрүүд ба газрын эзэн мөн. Түүнээс гадна бурхан үгүй. Тэрээр амилуулна, мөн ална! Тийм байвал Аллах болон (Тэрээрийн) **үммий Расулд нь –Тэр ч Аллах болон Тэрээрийн хэлсэнд итгэнэ- итгэж үнэмшээд, Түүний үгэнд орцгоогоорой, ингэж зөв замаа олж чадна!”** (эл-А’раф, 158) хэмээж хүмүүсийг илээр Исламд урьж эхлэх болов.

Гэтэл үүнд хаана ба яаж эхлэхээ мэддэггүй байхад, тэр хооронд өөр нэгэн вахий ирэв:

وَاَنْذِرْ عَش۪يرَتَكَ الْاَقْرَب۪ينَ وَاخْفِضْ جَنَاحَكَ لِمَنِ اتَّبَعَكَ
مِنَ الْمُؤْمِن۪ينَ فَاِنْ عَصَوْكَ فَقُلْ اِنّ۪ي بَر۪يٓءٌ مِمَّا تَعْمَلُونَ
وَتَوَكَّلْ عَلَى الْعَز۪يزِ الرَّح۪يمِ اَلَّذ۪ي يَر۪يكَ ح۪ينَ تَقُومُ

“Эхлээд хамгийн ойр садан хамаатандаа үзүүл! (Ахиратын тамлалаар болгоомжлуул.) **Чамайг дагах итгэгчийн дээр** энэрлийн **жигүүрээ буулга! Хэрэв Чамайг эсэргүүцэх болбол: би таны хийснээс хол юм!» гэ! Чи, Тэр лав ялагч ба энэрэлтэд итгэ! Тэрээр нь босоход Чамайг харна!”** (эш-Шуара, 214-218)

Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм- нь илээр урилж эхлэхдээ тэнгэрлэг тушаалын дагуу нэг дүгээрт ойр садан хамаатнаа урив. Тэднийг хоол ундаар дайлав. Дараа нь ингэж хандав:

“–Аяа Абдүлмутталибынхан аа! Би ялангуяа танд, ерөнхийдөө бол хамаг хүн төрөлхтөнд пайгамбар болж томилогдов. Та надад зарим гайхамшиг ч харцгаав. Таны аль нь надад дүү ба анд болохоор амлах вэ?”

Эдгээр үгсийг хэнч чухалчилж аваагүй. Бүгд дуугүй суув. Тэднээс арай залуу байсан, гэхдээ хамт олныхоо анхдагч алдарт хүрсэн Хазрат-и Али босч:

“–Аяа Аллахын Элч ээ! Чамд би тусална!” гэв.

Тэнд байсан хүмүүсийн басамжилсан,итгэлгүй,дорд үзсэн харцан дор, Аллахын Элчийн хорвоог гийгүүлсэн хараа нь Хазрат-и Али рүү чиглэж, хайртуудын ганцхан удаа ч үнсэхээр хүсдэг тэр ариун гараараа түүний толгойг илэв.[146]

Садан хамаатан нь анхны мөчид хүлээн аваагүй ч Аллахын Элчийн шийдвэр нь эвдрээгүй. Учир нь Түүнд Аллах Таала ингэж тушааж байв:

يٰسٓ وَالْقُرْاٰنِ الْحَكِيمِ اِنَّكَ لَمِنَ الْمُرْسَلِينَ عَلٰى صِرَاطٍ مُسْتَقِيمٍ

146. Ахмад, I, 111, 159; Хэйсэмий, VIII, 302-303.

“Яа-син. Эрдмээр дүүрэн Кур’аны эрхээр, андашгүй нь Чи пайгамбарчуудын нэг мөн! Зөв зам дээр мөн!” (Яа-син, 1-4)

وَاَرْسَلْنَاكَ لِلنَّاسِ رَسُولًا وَكَفٰى بِاللّٰهِ شَهٖيدًا

“...Чамд пайгамбар болгож хүмүүст илгээв. Гэрч болохоор ч Аллах хангалттай!” (эн-Ниса, 79)

وَمَٓا اَرْسَلْنَاكَ اِلَّا كَٓافَّةً لِلنَّاسِ بَشٖيرًا وَنَذٖيرًا
وَلٰكِنَّ اَكْثَرَ النَّاسِ لَا يَعْلَمُونَ

“Бид Чамайг хамаг хүн төрөлхтөнд, сайхныг мэдээлэгч ба сануулагч болгож л илгээв; гэтэл хүмүүсийн ихэнх нь үүнийг мэдэхгүй.” (Сэбэ’, 28)

قُلْ يَٓا اَيُّهَا النَّاسُ اِنّٖي رَسُولُ اللّٰهِ اِلَيْكُمْ
جَمٖيعًا الَّذٖي لَهُ مُلْكُ السَّمٰوَاتِ وَالْاَرْضِ

“Ингэж хэл: «Аяа хүмүүс ээ! Гарцаагүй би, тэнгэрүүд ба газрын эзэн буй Аллахын та бүхэнд илгээсэн пайгамбар нь мөн!..” (эл-А’раф, 158)

Ает-и кэримэчүүдийн илрүүлснээр, Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- нь бусад пайгамбарчуудаас ялгаатай болж, хамаг хүн төрөлхтөнд томилогдсон байв. Үүнийг нэгэн хадис-и шарифдаа өөрөө ингэж илэрхийлнэ:

“Надад, надаас өмнөх пайгамбарчуудаас хэнд ч өгөөгүй таван шинж олгов:

1. Алс холоос дайсны зүрхэнд айдас төрүүлэх боломж олгов.

2. Надад дэлхий даяар мэсжид ба цэвэр байлгав. Тэгэхээр нь үммэтээс минь хэн нэгэн итгэгч мөргөлийн үед орвол шууд байгаа газраа мөргөл үйлдэг!

3. Надаас өмнөх пайгамбарчуудад халал болгоогүй байсан дайны олз нь надад халал болгов.

4. Шэфаатын зөвшөөрөл олгов.

5. Надаас өмнөх пайгамбарчууд зөвхөн улстаа томилогдож байв. Би бол хамаг хүн төрөлхтөнд пайгамбар болж томилогдлоо." (Бухарий, Тэеммүм, 1)[147]

Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- илээр хийсэн анхны урилгандаа, тэр үед хүүхэд байсан Хазрат-и Алигаас гадна садан хамаатныхаа тулгуурыг олж чадаагүй.

Хэсэг хугацааны дараа садан хамаатнаа дахиад гэртээ урив. Хоол унд дайлсны дараа ингэж айлдав:

"...Аяа Абдүлмутталибынхан аа! Валлахи Арабчуудын дотор таны дэлхий ба ахиратын төлөө, миний танд авчирсан юмаас илүү буянтыг улстаа авчирсан нэгэн залуу танихгүй.

Аая Абдүлмутталибынхан аа! Би ялангуяа танд, ерөнхийдөө бол хамаг хүн төрөлхтөнд пайгамбар болж томилогдлоо. Та энэ тухай өмнө нь үзээгүй гайхамшгийн заримыг ч надад үзсэн байна. Энэ үүрэгт надад туслах ба дүү болохыг,

147. Өөр нэгэн ярианд Аллахын Элч гурван зүйлд анхаарал татав:
"1. Надад цөөн үгээр их утга илэрхийлэх авъяас хайрлав.
2. Пайгамбарын үүрэг надаар дуусч цэглэв. Надаас хойш пайгамбар ирэхгүй.
3. Намайг унтаж байхад дэлхийн сангийн түлхүүрийг надад авчраад миний дэргэд тавьцгаав." (Мүслим, Мэсажид, 5, 6)

ингэж диваажинд орорхыг аль тань хүлээн авах вэ? Таны аль тань энэ замд миний дүү ба анд болохоор надад амлах вэ?”

Орчлонгийн Тэргүүн Эзний маань уг урилганд ч мадан хамаатнаас хэн ч хариулаагүйгээс байтугай, түүнчлэн инээлдэж шоглоцгоов. Мөн удахгүй тараад явцгаав. (Ахмад, I, 159; Ибн-и Са’д, I, 187; Хэйсэмий, VIII, 302; Ибн-и Эсир, *эл-Камил*, II, 63; Бэлазурий, I, 119; Халэбий, I, 283)

Хүний дотор буй садан хамаатны хүрээ нь түүний ярьсан юмыг холын хүмүүстэй харьцуулбал илүү амархан хүлээн зөвшөөрнө. Бас урилгыг хүлээн зөвшөөрөгсдийн садан хамаатныг тооцвол, Исламын нийгэмд ийм аргаар илүү богино хугацаанд хүрч чадах нь тодорхой юм. Хэрэв уригчийн садан хамаатан нь түүнд итгэж түшихгүй бол хандсан бусад хүмүүсийн итгэж найдсан нь илүү хэцүү байх болно. Ийм л учраас Орчлонгийн Хүндэт -саллаллаху алэйхи вэ сэллэм- Эзэн маань тэнгэрлэг тушаалын ч дагуу тэблиг үйл ажиллагаагаа ойр садан хамаатнаасаа эхлэв.

Нөгөө талаас, пайгамбарчуудын тэблиг үүрэгтээ амжилттай болох тухай ойрын хүмүүсээс авч мэдэх түшиг ба тусламж нь агуу чухал байдаг. Жишээлбэл энэ үнэнийг, Кур’ан-и Кэрим өнгөрсний пайгамбарчуудын жишээгээр ингэж илэрхийлдэг:

قَالُوا يَا شُعَيْبُ مَا نَفْقَهُ كَثِيرًا مِمَّا تَقُولُ وَاِنَّا لَنَرٰيكَ فِينَا ضَعِيفًا
وَلَوْلَا رَهْطُكَ لَرَجَمْنَاكَ وَمَٓا اَنْتَ عَلَيْنَا بِعَزِيزٍ

“Ингэж хэлцгээв: Еэ Шуайб аа! Чиний хэлсний ихэнхийг бид ойлгохгүй ба үнэндээ Чамайг бид хүчгүй гэж үзнэ. Хэрэв садан хамаатан чинь байгаагүйсэн бол Чамайг цохих байв!..” (Худ, 91)

Хазрат-и Лут -алэйхиссэлам- ч улсынхаа төөрөгсдийн өмнөөс аргагүй үлдэхдээ, өөртөө түшиг болох садан хамаатангүй байснаасаа гуньж ингэж хэлсэн байв:

قَالَ لَوْ اَنَّ لِي بِكُمْ قُوَّةً اَوْ اٰوِيٓ اِلٰى رُكْنٍ شَدِيدٍ

“…Би ч таны эсрэг (босох) **хүчтэй байгаасай эсвэл хүчтэй нэгэн газар хорогдож чадаасай.”** (Худ, 80)

Ислам нь ялангуяа садан хамаатнаа хамгаалж хадгалахыг чухалчилсан байдаг. Ийм учраас хүн нь хүмүүсийн итгэлийн шимээр алдаршихыг хүсч байвал, хэнээс ч өмнө өөрийнхөө гэр бүл ба садан хамаатнаа бодох ёстой юм.

Жшээлбэл Аллах -аззэ вэ жэллэ- ингэж айлдав:

اَلنَّبِيُّ اَوْلٰى بِالْمُؤْمِنِينَ مِنْ اَنْفُسِهِمْ وَاَزْوَاجُهُٓ اُمَّهَاتُهُمْ
وَاُو۬لُوا الْاَرْحَامِ بَعْضُهُمْ اَوْلٰى بِبَعْضٍ
فِي كِتَابِ اللّٰهِ مِنَ الْمُؤْمِنِينَ وَالْمُهَاجِرِينَ

“…Садан хамаатан ч Аллахын шийдвэрийн дагуу нэг нэгэндээ, бусад итгэгчид ба Мухажиочуудаас илүү ойр байдаг...” (эл-Ахзаб, 6)

Пайгамбар Эзний маань Сафа Даваанд Курайшчуудыг Исламд Урьсан нь

Урихад хамгийн ойроос эхлэх нь тушаасан Оршигчийн Туяа -алэйхиссалатү вэссэлам- нь нэгэн өдөр Сафа Даваан дээр гараад Курайш аймагт дуудав. Тэд ч уг урилгыг дагаж Сафа Даваанд очицгоов. Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- нь өндөр нэгэн хадан дээрээс тэдэнд ингэж хандав:

“–Еэ Курайшийн нийгэм! Би танд энэ уулыны хормойд эсвэл тэр хөндийд дайсны морьтод бий; шууд танд довтолж, барааг тань булааж авна гэвэл, надад итгэх нь үү?”

Тэд ч огт бодолгүй:

“–Тийм, итгэнэ! Учир нь одоо хүртэл Чамайг байнга зөв буйгаар олов. Чиний худал хэлснийг огт сонсоогүй!” гэцгээв.[148]

Тэнд ирсэн буй хүн бүрээс гажилтгүй энэ баталгааг авсан Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- нь тэдэнд тэнгэрлэг уг үнэнийг мэдүүлэв:

“–Тийм байвал одоо би танд, маны өмнө ширүүн нэгэн зовлонгийн өдөр буйг, Аллахад итгэж үнэмшээгүй хүмүүсийн тэр ширүүн зовлонд автахыг мэдээлье. Би таныг тэр ширүүн өдрөөс болгоомжлуулахаар илгээгдлээ.

Еэ Курайшчууд аа! Таны өмнөх миний байдал минь, дайсныг харсан ба гэр бүлийнхэнд аюул хүргэхээс нь айгаад шууд мэдээлэхээр гүйсэн хүний байдал шиг юм.

Курайшийн нийгэм ээ! Та нойронд автах шиг үхнэ. Унтсанаасаа сэрэх шиг амилна. Булшаасаа босоод Аллахын онгонд хүрээд дэлхий дэх хамаг үйлийнхээ тухай тооцоо өгөх

148. Энд Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- тэблигийн төлөө эхлээд нэгэн зан тогтоодог. Учир нь хүмүүс занд дурлаж, дараа нь үгэнд ордог. Манай эринд Исламыг тэблиг хийгчид ч зангаа тэр чигээр тогтох, “Итгэмжтэй” ба “Үнэнч” байх нь, үнэнч буйгаа нийгмээр батлуулах шаардлагатай байдаг. Яа-син Сурад дурдсан Хабиб эн-Нэжжар нь тэблиг хийдэг хүмүүсийн занг ингэж тогтдог:

اتَّبِعُوا مَن لاَّ يَسْأَلُكُمْ أَجْراً وَهُم مُّهْتَدُونَ

“(Ард минь ээ!) **Танаас ямар нэгэн төлбөр нэхээгүй энэ салих хүмүүсийн үгэнд орцгоо! Учир нь тэд авралд хүрсэн хүмүүс байдаг.”** (Яа-син, 21) Aет-и кэримэд тэблигийг зөвхөн Аллахын тааламжийн төлөө хийх ба эхлээд өөрсдөө зөв зам дээр байх шаардлагыг илэрхийлсэн байдаг.

тань андашгүй юм. Эцэст нь буян ба залбирал үйлчилгээнийхээ шагналыг, муухай үйлсийнхээ бол ял ба ширүүн зовлонг үзэх болно! Шагнал нь мөнхийн нэгэн диваажин; ял нь бол үүрдийн нэгэн там юм." (Бухарий, Тэфсир, 26; Мүслим, Иман, 348-355; Ахмад, I, 281-307; Ибн-и Са'д, I, 74, 200; Бэлазурий, I, 119; Сэмира эз-Зайид, I, 357-359)

Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн уг ярианд, тэнд байгсдаас ерөнхий эсэргүүцэх хариу ирээгүй. Зөвхөн авга ах нь Эбү Лэхэб:

"–Оо, гар чинь хувхайраасай! Бидэнд энд үүний тухай дуудав уу?" гээд хамаагүй ба зохимжгүй үгс хэлэв. Доромжлох үгсээрээ Пайгамбар Эзний маань -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн зүрхийг хатгав.

Эбү Лэхэб ингэсний улмаас "Тэббэт Сура" нь буув:

تَبَّتْ يَدَٓا اَبِي لَهَبٍ وَتَبَّ مَٓا اَغْنٰى عَنْهُ مَالُهُ وَمَا كَسَبَ

سَيَصْلٰى نَارًا ذَاتَ لَهَبٍ وَامْرَاَتُهُ حَمَّالَةَ الْحَطَبِ

فِي جِيدِهَا حَبْلٌ مِنْ مَسَدٍ

"Эбү Лэхэбийн хоёр гар хувхайраг! Бас хувхайрав... Эд бараа болон олсон нь түүнд ашиг болоогүй. Тэр дөлтэй галд шатна. Галын модыг зөөгчөөр хүзүүндээ мушгисан олстой эхнэр нь ч, (галд орно)." (Тэббэт, 1-5) (Бухарий, Тэфсир 26/2, 34/2, 111/1-2; Мүслим, Иман 355)

Ает нь Эбү Лэхэбийн эхнэрийг ч дурдана. Учир нь, тэр ч нөхөр шигээ Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-д олон харгислал хийж, явж өнгөрөх зам дээр нь өргөс цацдаг байв.

Тус сура нь мөн ураг болон угсааг ойр байсны тодорхой учиртай нэгэн үнэ цэнэ байгаагүйг ч далдаар илэрхийлнэ.

Гол нь сүнсний дотно харьцаа болон таква мөн. Сүнсний ураг байдаггүй. Ураг нь шарилтай хамаатай нэгэн чанар юм. Шарил бол хөрсөнд үгүй болно. Хүний үнэ цэнэ нь сүнснийхээ боловсролтой харилцаатай байдаг. Түүний хүндтэй шинж энэ л юм. Хүний эдийн тал буй бие нь, сүнс орсон эсвэл өмссөн нэгэн хувцастай адил юм. Хүн бол тустай даавуугаар хувцас өмсөөд үнэ цэнэ олдоггүй!

❁

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн хичээснээр авга эгч нар нь **Хазрат-и Сафийе** ба **Хазрат-и Атикэ**, Хазрат-и Аббасын чөлөөлсөн **Эбү Рафий**, **Эбү Зэрр** ба **Амр бин Абэсэ** нар мусульман болцгоов.

Эбү Зэрр -радъяллаху анх- мунхаглалын үед баримтыг шүтдэггүй байв. Өөрөө авралыг хүртээд ингэж ярина:

Би Гяфар аймгийн хүн. “Маккад нэгэн илэрч, өөрийгөө пайгамбар буйгаа хэлж гэнэ,” гэсэн мэдээ авахлаар, Аллах Таала нь бүр тэр үед сэтгэлд минь Исамын хайрыг өгөв. Дүү Үнэйстээ:

“–Маккад очоод, өөрийгөө тэнгэрээс мэдээлэл авчирснаа хэлсэн Тэр хүнтэй уулз, Түүний тухай надад мэдээ авчир!” гэлээ.

Миний дүү Үнэйс Маккад очиж, Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-тэй уулзаж хэлснийг сонссоны дараа миний дэргэд ирэв. Түүнээс:

“–Юу хийсэн? Ямар мэдээлэл авчраа вэ?” гэж асуулаа.

“–Маккад чиний шашны нэгэнтэй таарaлдаад, өөрийгөө Аллахын илгээснийг хэлж байна,” гэв.

“–Тэгвэл, хүмүүс түүний тухай юу хэлдэг вэ?” гэж асуулаа.

“–Шүлэгч, мэргэ харагч, шившлэгтэн мэтийн юм хэлнэ!” гэв.

Миний дүү өөрөө шүлэгч бөгөөд шүлгээ ч сайн ойлгодог байв. Тэр бол Хазрат-и Пайгамбарын тухай ингэж хэлэв:

“–Би мэргэ харагчдын үгсийг мэднэ. Түүний үгс нь тэднийхтэй огт төсөөгүй. Түүний үгсийг шүлгийн хамаг төрөлтэй зүйрлэлээ. Валлахи түүнийг хэний хэл ч шүлэг гэж чадахгүй. Тэр заавал үнэнийг хэлдэг. Түүнийг гүтгэдэг хүмүүс бол худалч мөн! Тэр нь зөвхөн буяныг, сайн сайхныг ба ёс суртахууны эрдмийг л тушааж, муу муухайгаас болгоомжлуулдаг.”

Дүүгийн минь ярьснаас сэтгэл ханаагүй байв. Шууд хоол ундаагаа авч замд гарлаа. Маккад ирлээ. Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийг таньдаггүй, бусдаас ч асуумааргүй байлаа. Мэсжид-и Харамд хүлээж, Зэмзэм уугаад өлсгөлөн ба цангаснаа тайлж байв. Тэр хооронд миний дэргэд Хазрат-и Али ирээд:

“–Та энэ хавьд танилгүй хүн байх?” гэв.

Түүнд:

“–Тийм!” гэлээ.

“–Тэгвэл бидэнд зочин бол!” гэв.

Али -радъяллаху анх-ыг дагаж явлаа. Маккагийнхны дэгдээсэн шуурганы нөлөөгөөр миний ирэх учрыг ч асуугаагүй. Өглөө болохлоор Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийг олохоор дахиад Мэсжид-и Харамд очлоо. Үдэш болтол хүлээсэн ч сураг чимээ авч чадаагүй. Али -радъяллаху анх- дахиж ирээд:

“–Та очих газраа мэдээгүй л байна уу?” гэв.

Би:

“–Үгүй,” гэлээ.

Али -радъяллаху анх-:

“–Тэгвэл дахиад манайд очоорой ” гэлээ.

Тэднийд очиход:

“–Энэ чинь хэн бэ? Энд яагаад ирээ вэ?” гэж асуув.

Намайг нууж байгаад зам зааж өгнө гэж амласны дараа би:

“–Бидэнд хүрсэн мэдээллээр, энд хэн нэгэн өөрийгөө пайгамбар болсныг хэлж гэнэ! Түүнтэй уулзаж яриуахаар ирсэн,” гэлээ.

“Зөв юмны төлөө иржээ! Тэр хүн Аллахын Расул, үнэн пайгамбар мөн. Өглөөгүүр намайг дагаад яв, миний орсон гэрт чи ч ор! Би чиний хувьд аюултай юм харвал, гутлаа засах юм шиг хандан хананд эргэнэ, чи өнгөрч яв,” гэв.

Эцэст нь Пайгамбар -алэйхиссалату вэссэлам-ын онгонд хүрлээ.

“–Эс-Сэламу алэйкэ аяа Расулаллах!” гээд Түүнийг Исламын мэндээр анх би мэндлэв.

“–Аяа Мухаммед! Чи хүмүүсийг юунд урьдаг вэ?” гэж асуулаа.

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-:

“–Цорын ганц бөгөөд ямар ч ижилгүй Аллахад итгэхэд, баримлыг орхиход ба намайг ч Аллахын Элч буйг гэрчлэхэд урина,” хэмээв.

Надад Исламын тухай ярихлаар нь би шууд мусульман боллоо. Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- намайг мусульман болсонд маш их баясч, баяр хөөртэй царайгаар мишээв.

“–Эбү Зэрр ээ! Одоо энэ ажлыг Маккачуудаас нууц байлгаж нутагтаа харь!” хэмээв.

“–Аяа Расулаллах аа! Би шашнаа зарламаар байна,” гэлээ.

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-:

“–Би Маккагийнхан чамд аюул авчирна гэж зовниж байна!” хэмээв.

“–Аяа Расулаллах аа! Намайг алсан ч үүнийг заавал хийнэ,” гэлээ.

Хүндэт Элч Эзэн маань дуугүй байв.

Курайшчуудын Мэсжид-и Харамд цугласан үед тэнд очоод чанга дуугаар:

“–Аяа Курайшийн нийгэм! Эшхэдү эн ла илахэ иллаллах вэ эшхэдү эннэ Мухаммедэн абдүхү вэ расулүх!” гээд хашхирлаа.

Мүшрикчүүд:

“–Нөхөр төөрчээ! Нөхөр төөрчээ! За, яваад энэ сабий[149] руу дайрья!” гээд босч намайг алахаар зодоцгоов. Тэр хооронд Аллахын Элчийн авга ах Аббас амжиж намайг халхавчлан тэдэнд:

“–Танд хайран юм шүү! Курайшийн нийгэм! Та нар наймаачин хүмүүс. Наймааны зам тань ч Гяфар аймгийн тэндээс

149. Маккачууд тэр үеэр мусульман бологсдод “шашнаас халсан” гэсэн утгаар “сабии” гэдэг байв.

өнгөрнө. Эсвэл наймааны замаа таслуулмаар байна уу?" гээд загнавал тэд тарав.

Дараах өдөр намайг өглөөгүүр Мэсжид-и Харамд ороход дахиад ижил юм болов. Намайг ухсэн гэж бодоод орхицгоов. Босоод Аллахын Элчийнд очлоо. Эзэн маань миний байдлыг харангаа:

"–Би чамайг хориглосон биз дээ?" хэмээв.

Би:

"–Аяа Расулаллах аа! Энэ нь миний сэтгэлийн хүсэлт байв, би ч хэрэгжүүллээ," гэлээ.

Хэсэг хугацаагаар Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн дэргэд байж байлаа. Дараа нь:

"–Аяа Аллахын Элч ээ! Надад юу хийхийг тушаана уу?" гэлээ.

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-:

"–Чамд миний тушаал хүрэхлээр Исламыг аймагтаа мэдээл! Илэрснийг мэдэнгүүтээ миний дэргэд хүрээд ир!" хэмээв. (Бухарий, Мэнакибү'л-Энсар 33, Мэнакиб 10; Ахмад, V, 174; Хаким, III, 382-385; Ибн-и Са'д, IV, 220-225)

Орчлонгийн Хүндэт Эзэн маань хүмүүсийг Исламд урьсаар байв. Хажжийн улиралд Указ, Мэжэннэ, Зүлмэжаз мэтийн яармагуудад хүмүүсийн хамт байсан газаруудаар яваад, таарaлдсан хүн бүрт, чөлөөт-боол, туранхай-хүчит, баян-ядуу гэлгүй Исламыг мэдээлж, тэднийг Аллах цорын ганц гэдэгт итгэж үнэмшихээр дууддаг байв.[150]

150. Хар. Ибн-и Са'д, I, 216-217.

Номлолын энэ шатад буусан аетууд ерөнхийдөө кияматын аймшгийг мэдээлж байв:

إِنَّ عَذَابَ رَبِّكَ لَوَاقِعٌ مَا لَهُ مِنْ دَافِعٍ يَوْمَ تَمُورُ السَّمَآءُ مَوْرًا وَتَسِيرُ الْجِبَالُ سَيْرًا فَوَيْلٌ يَوْمَئِذٍ لِلْمُكَذِّبِينَ
اَلَّذِينَ هُمْ فِي خَوْضٍ يَلْعَبُونَ يَوْمَ يُدَعُّونَ اِلٰى نَارِ جَهَنَّمَ دَعًّا هٰذِهِ النَّارُ الَّتِي كُنْتُمْ بِهَا تُكَذِّبُونَ

“Раббын чинь тамлал заавал хэрэгжинэ. Түүнд саад хийх ямар ч юм байдаггүй. Тэр өдөр тэнгэр доргисоор байдаг. Уулнууд нь явсаар байна. Тэр өдөр (пайгамбарчуудаа) **үгүйсгэгчдэд хайран юм! Тэд мухар сүсэгт живж дэмий цаг нөгцөөж байна. Тэр өдөр тамын галд унахдаа: «бидний үгүйсгэсээр байсан гал энэ мөн!» гэцгээнэ.”** (эт-Тур, 7-14)

Хүндэт Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- Эзний маань пайгамбар болсноо зарлаж илээр урьж эхэлсний дараа мүшрикчүүд болон тэдний баримлын эсрэг ает-и кэримэчүүд бууж эхлэв:

اِنَّكُمْ وَمَا تَعْبُدُونَ مِنْ دُونِ اللّٰهِ حَصَبُ جَهَنَّمَ اَنْتُمْ لَهَا وَارِدُونَ

“(Еэ Мүшрикчүүд ээ!) **Та болон таны Аллахаас гадна шүтэж буй зүйлс, бүгд тамын мод болох мөн. Та тэнд л орцгооно.”** (эл-Энбияа, 98)

قُلْ اِنَّمَآ اَنَا بَشَرٌ مِثْلُكُمْ يُوحٰىٓ اِلَيَّ اَنَّمَآ اِلٰهُكُمْ اِلٰهٌ وَاحِدٌ فَاسْتَقِيمُوٓا اِلَيْهِ وَاسْتَغْفِرُوهُ وَوَيْلٌ لِلْمُشْرِكِينَ

“Аяа Расул минь ээ! **Ингэж хэл: Би ч зөвхөн тан шиг нэгэн хүн юм. Миний бурхан цорын ганц вахий илгээдэг. Одооноос түүнд хандаарай. Түүний өршөөлд багтаарай. Түүнтэй адилтгах түнш хайгчид өрөвдөлтэй еэ!”** (Фүссилэт, 6)

Аллахын Элч-саллаллаху алэйхи вэсэллэм-мүшрикчүүдийн залбирсаар байсан баримлуудыг шүүмжилж эхлээд, күфүр ба мэдлэггүй буйгаараа үхэж явсан буй өвөг дээдэс нь тамд буйг хэлэхлээр нь, Курайшийн мүшрикчүүд Пайгамбар Эзний маань үгүйсгэн татгалзав. Түүний эсрэг нэгдэв. Гэтэл Эбү Талиб нь Аллахын Элчийг хамгаалж байсан тул яаж ч чадаагүй.[151]

Эбү Жэхил, Эбү Лэхэб, Вэлид бин Мугира, Үмэйе бин Халэф, Ас бин Ваил, Надр бин Харис, Үкбэ бин Эбий Муайт, Үтбэ бин Рэбиа мэтийн догшин мүшрикчүүд Хүндэт Элч Эзний маань эсрэг дайсан болохоор мөнхийн мөхөлд автсан азгүйчүүд байв.

Тэблигийн Чухал Тал ба Хэв Маяг нь

Тэблиг нь Ислам шашин болон түүний үндсүүдийг яриад, хүмүүсийг тус тушаалуудын чигээр амьдрахад хичээх юм. Хамгийн алдаршсан үгээр хэлбэл тэблиг нь “эмр-и би’л-ма’руф, нэхй-и ани’л-мүнкэр: сайн сайхныг тушааж, муу муухайг хориглох” хэмээн ойлгож болно.

Аллах Таала нь аег-и зэримэчүүдэд тэблигийг хамаг итгэгчдэд нэгэн үүрэг болгож тушаадаг:

وَلْتَكُنْ مِنْكُمْ اُمَّةٌ يَدْعُونَ اِلَى الْخَيْرِ وَيَاْمُرُونَ بِالْمَعْرُوفِ
وَيَنْهَوْنَ عَنِ الْمُنْكَرِ وَاُولٰٓئِكَ هُمُ الْمُفْلِحُونَ

151. Ибн-и Са’д, I, 199.

“Танаас буянд уриад, сайныг тушааж муухайгаас болгоомжлуулах хэсэг хүмүүс байг! Тэд л жинхэнэ аврал хүрэгчид мөн.” (Ал-и Имран, 104)

كُنْتُمْ خَيْرَ اُمَّةٍ اُخْرِجَتْ لِلنَّاسِ تَاْمُرُونَ بِالْمَعْرُوفِ وَتَنْهَوْنَ عَنِ الْمُنْكَرِ وَتُؤْمِنُونَ بِاللّٰهِ وَلَوْ اٰمَنَ اَهْلُ الْكِتَابِ لَكَانَ خَيْرًا لَهُمْ مِنْهُمُ الْمُؤْمِنُونَ وَاَكْثَرُهُمُ الْفَاسِقُونَ

“Та, хүн төрөлхтний сайн сайхны **төлөө гаргасан хамгийн буянтай нэгэн үммэт мөн. Сайныг тушааж, муухайгаас болгоомжлуулна...”** (Ал-и Имран, 110)

Пайгамбар Эзэн маань ч хадис-и шарифдаа тэблигийн чухал талын тухай ингэж айлдав:

“Биднээс юм сонсч, түүнийг яг тэр чигээр бусдад хүргэсэн хүний царайг Аллах цайвар байлга! Өөрт нь мэдээ хүргэсэн олон хүмүүс байдаг, тэр мэдээг шууд сонссон хүнээс ч сайн ойлгож хэрэгжүүлнэ.” (Тирмизий, Илим, 7)

“Аллахад тангараг өргөе, Аугаа Эрхийн нэгэн хүнийг аврал хүргэсэн нь, дэлхийн хамгийн үнэт шимээр тооцогдож байсан улаан тэмээтэй болохоос ч буянтай юм.” (Бухарий, Асхабу’н-Нэбий, 9)

“Аврал урьсан хүнд, түүнийг дагагчдын ач буян чинээ ач буян болно. Гэхдээ тэдний ач буянаас ч хасахгүй.” (Мүслим, Илим, 16)

Асхабаас Энэс -радъяллаху анх- Исламын тэблигчдийн ахиратад хүрэх өндөр төвшнийг илэрхийлсэн ийм нэгэн хадис-и шарифыг дамжуулна:

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- нэгэн өдөр ингэж айлдав:

"–Танд зарим хүмүүсийн тухай яриад өгөх үү? Тэд пайгамбар ч, шэхид ч биш. Гэтэл киямат өдөрт пайгамбарчууд ба шэхидчүүд тэдний Аллахын онгон дахь орныг хүснэ.[152] *Тэд туяан дэрэн дээр суугаад хүн бүр тэднийг танина."*

Асхаб-и кирам:

"–Тэд нь хэн бэ аяа Расулаллах аа?" гэж асууцгаав.

Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-:

"–Тэд нь боолчуудыг нь Аллахад, Аллахыг ч боолчуудад нь хайрлуулсан хүмүүс юм. Дэлхий дээр сургаж тэблигчин болоод явна," хэмээв.

Би:

"–Аяа Аллахын Элч ээ! Аллахыг боолчуудад хайрлуулахыг ойлголоо. Харин боолчуудыг нь Аллахад хайрлуулах яаж байдаг вэ?" гэж асуулаа.

Ингэж айлдав:

"–Хүмүүст Аллахын дуртай юмыг тушааж, дургүй юмаас ч болгоомжлуулна. Хүмүүс үүнийг дагавал, Аллах -аззэ вэ жэллэ- тэднийг хайрлана." (Али эл-Муттакий, III, 685-686; Бэйхакий, *Шуабу'л-Иман,* I, 367)

Шүлэгч нь Эрхэд хайртай сэтгэлийг ингэж илэрхийлнэ:

---

152. Энэ үгийн зорилго нь тэблигтэй оролцсон хүмүүсийн үнэ цэнийг мэдүүлэх юм. Харин тэдний Пайгамбар эсвэл шэхидчүүдээс давуу буйг үзүүлдэггүй. Учир нь Пайгамбарчууд ба шэхидчүүд ч угаасаа амьдралаа тэблигийн төлөө золиосолсон хүмүүс юм. Тэдний тэблигчдийн үйлсэд дурласан нь бол тухайн үүргийн үнэ цэнэ ба ариуныг мэдсэнээс үүсэлтэй байдаг юм.

Хамаг дэлхийн ард түмэн миний "амрагийг" хайрлахыг хүсье,

Хан Хорвоод миний " хааныг" хайрлаагүй хэн ч үлдэхгүйг хүсье.

Өөр нэгэн шүлэгч ч энэ тухай мэдрэмжээ ингэж дуулна:

Хамаг дэлхийн ард түмэн минйи "амрагийг" хайрлаасай,

Хонон өнждөг бидний үг яриа амрагийн туульс болоосой...

Тэблиг үүргээ ёсоор нь гүйцэтгэсэн хүний орлого нь дэлхийн хамгийн үнэт сангуудаас ч давуу байхад, уг үүргээ хойш тавих нь хамаг нийгмийг хөнөөлд чирэх чинээ хэцүү үр дүнд хүргэж мэднэ.

Аллахын Элчийн энэ тухай сануулга үг нь үнэхээр анхаарал татам юм:

"Надад амь хайрлаж өгсөн Аллахад тангараг өргөе, танд сайныг тушааж муугаас болгоомжлуулна эс дагавал, Аллах танд зовлон илгээж, тэгээд та залбирна, гэтэл таны залбирлыг хүлээн зөвшөөрөхгүй." (Тирмизий, Фитэн, 9)

Сахаба-и кирамаас Эбза эл-Хузаи -радъяллаху анх- ярина:

"Нэгэн өдөр Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- индэр дээр гараад үг хэлэв. Мусульманчуудаас зарим нийгмийг буянаар дурдсаны дараа эдгээрийг хэлэв:

"–Зарим нь юу болсон ч, хөршдөө юм ярихгүй, мэдээгүйд нь сургахгүй, тэднийг ухааруулахгүй. Тэдэнд ухааныг заахгүй, мухар сүсгээс болгоомжлуулахгүй байна?

Зарим хүмүүс юу болж байгааг мэдэхгүй, тэдээгүй юмыг хөршөөсөө асууж мэдэхгүй, ойлголттой болохыг хичээхгүй байна вэ?

Аллахад тангараг өргөе, оюун ухаантай хүмүүс эсвэл хөршдөө сургана, тэднийг ойлголттой болгоно, ухааныг тушааж мухар сүсгээс болгоомжлуулна; нөгөө талаас тэдээгүйчүүд ч хөршөөсөө асуугаад мэдэж авна, шашны хэргийг ухаарахыг хичээнэ эс тэгвэл тэдний аль аль нь ял хүлээнэ.

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- үүнийг хэлсний дараа индэрээс бууж гэртээ харив. Зарим нь:

“–Манай бодлоор (Йемений) Эш’арийчуудыг хэлэх гэсэн юм, учир нь тэд факих хүмүүс юм, тэдний хөршүүд бол бүдүүлэг, хатуу зантай, ус өвс даган нүүдэллэн амьдардаг хүмүүс мөн,” гэцгээв.

Эш’арийчууд үүнийг мэдээд, Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-д хүрч ирээд:

“–Аяа Расулаллах аа! Чи нэгэн аймгийг буянтай, биднийг бол муугаар дурджээ. Бидний ямар байдлаас ингэж болоо вэ?” гэцгээв.

Орчлонгуудын Эзэн юу ч хэлээгүй, зөвхөн түрүүний үгсээ давтав. Эш’арийчууд заасан нь тэд өөрсдөө мөн эсэхийг ойлгож чадаагүй. Яг нарийн ойлгох тулд үүнийг Хүндэт Нэбий Эзнээс маань хэдэн дахин асууцгаав. Расулаллах -алэйхиссалатү вэссэлам- бол удаа бүрт ижил юмыг дахиж байв. Тэгэхлээр нь Эш’арийчууд:

“–Тэгвэд бидэнд жилийн хугацаа өг!” гэцгээв.

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- ч хөршүүдээ боловсруулж тэдэнд шашны хэргийг сургахын төлөө тэдэнд жилийн хугацаа өгөөд, дараа нь тэдэнд уг аетуудын уншив:

لُعِنَ الَّذِينَ كَفَرُواْ مِن بَنِي إِسْرَائِيلَ عَلَى لِسَانِ دَاوُودَ وَعِيسَى ابْنِ مَرْيَمَ ذَلِكَ بِمَا عَصَوا وَّكَانُواْ يَعْتَدُونَ كَانُواْ لاَ يَتَنَاهَوْنَ عَن مُّنكَرٍ فَعَلُوهُ لَبِئْسَ مَا كَانُواْ يَفْعَلُونَ

“Исраилынхнаас куфүр хийгсдийг Давуд болон Мэрьемийн Есүсийн хэлээр хараасан байдаг. Энэ нь тэдний бослого хийж хэтэрсний улмаас юм. Тэд бие биедээ хийсэн муу муухайгаа болиулахыг хичээдэггүй байв. Үнэхээр, тэдний хийсэн нь маш муу юм!” (эл-Маида, 78-79) (Хэйсэмий, I, 164; Али эл-Муттакий, III, 684/8457)

Оршигчдын Туяа -саллаллаху алэйхи вэ сэллэм- нь Аллахын соёорхсоноор хүртсэн зүрхний өтгөн ба төгсөөр, хүмүүсийг авралтад хүргэх зорилгоор шашныг тэблиг болгоод байсаар, өөрт нь олгосон уг тэнгэрлэг үүргийг хэрэгжүүлэх мэдэл нь Түүнийг оргилын оргил болгов. Үүргийг нь саатуулах дэлхийтэй хамаатай хамаг саналыг андууралгүй татгалзаж, Эрхэд боолчлохыг бүгдээс дээр үзсэн байв.

-Саллаллаху алэйхи вэ сэллэм- Эзэн маань Исламыг хүн бүрийн оюун ухааны төвшний дагуу, тухайн хүний ойлгохоор тайлбарлаж, ганцхан хүнд ч Түүнийг тайлбарлан аргагүй баяр хөөр болдог байв. Жишээлбэл Хайбарыг эзэлсний өдөр мэтийн том нэгэн явдал болоход ч нэгэн боолд Иалсмын тухай урт удаан ярихад дуртай, түүний авралд багтана гэж байв. (Ибн-и Хишам, III, 398)

Арван өдрийн бэрхшээлтэй Таифын зорчилд зөвхөн Христийн шашинтай нэгэн боол асан Аддасын авралын учир олсон байв. Тэгэхлээрээ Таифад үзсэн хамаг гашуун явдлыг мартчихсан гэдэг.

Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- нь хамаг хүмүүсийн Исламын туяагаар гийгүүлсний төлөө хамаг хүчээ зарцуулж, тэблиг талаар огт мэддэггүй байв. Түүний тэблиг талаар ийнхүү мэдрэмжийг харуулсан нэгэн байдлыг сахабага-ас Эбү Рифаа -радъяллаху анх- ингэж ярина:

“Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийг хутба унши-хад хажууд нь хүрээд:

«–Аяа Расулаллах аа! Шашнаа мэдээгүй харийн нэгэн хүн ирэв, асууж мэдмээр байна,» гэлээ.

Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- эргээд над руу харав. Хутбагаа орхиж миний дэргэд ирэв. Шууд суу-хад нь Түүнд нэгэн төмөр суудал авчрав. Дээр нь суугаад Аллах Таалагийн өөрт нь сургасан зарим юмыг надад ярьж өгөв. Дараа нь дахиад хутбадаа эргэж яриагаа бүтэн дуусгав.” (Мүслим, Жум’а, 60)

Амхаб-и кирам ч үнэнийг тэблиг ба харсан бурууг засах талаар маш нямбай ханддаг байв. Тэдний хооронд Аллахын Элчийн сүннэтийн эсрэгээр хандагсдын сануулах үүрэг нь тодорхой хүмүүсээр хязгаарлаагүй байв. Аль нэгэн ч цаг ба орон таарвал даалгасан үүргээ гүйцэтгэж, юу болсон ч үнэнийг илэрхийлэхээс огт татгалзахгүй, Орчлонгийн Хүндэт Эзний маань сүннэтийн эсрэг байдалд огт тэсч чаддаггүй байв. Түүний хадисуудад эсэргүүцэгчдэд, тэдэнтэй нэг дээвэр доор

ерөөсөө сууж болохгүйгээ хэлж,[153] хадис-и шарифын хариунд өөрийнхөө бодлыг хэлэгсдэд, түүнээс хойш дахиад түүнтэй нэг газар сууж болохгүйгээ илэрхийлэн тэр газраас салдаг байв.[154]

Сүфьяан-и Сэврий -күддисэ сиррух- тэблигийн чухал талын тухай ингэж хэлэв:

“Хорасанд очоод тэблиг хийх чинь; чиний хувьд Маккад сууснаас илүү ашигтай юм.”

Тэблиг нь ийм чухал зүйл болоход, уг үүргийг ёсоор нь хийдэг хүний боловсрол ч үүнтэй хамаатай чухал болдог. Тус байдал нь сэтгэлийн хүн нэгэн тэблигчийн үнийг илээр илэрхийлнэ:

Хазрат-и Умар -радъяллаху анх- нэгэн өдөр андуудын хамт сууж байв. Тэдэнд (Аллахаас) зарим юм хүсэж ерөөхийг хэлэв. Тэдний зарим нь:

“–Бидний суусан энэ гэрээр дүүрэн мөнгөтэй болоод Аллахын замд зарцуулахаар болъё!..” гэсэн зорилгоо хэлэв.

Зарим нь:

“–Бидний суусан энэ гэр дүүрэн алттай болоод Аллахын төлөө зарцуулъя!..” гэв.

Зарим нь ч:

“–Бидний суусан энэ гэрийн дүүрэн эрдэнэтэй болоод тэднийг Аллахын замд зарцуулъя!..” гэж ерөөв.

Гэтэл Хазрат-и Умар -радъяллаху анх-:

“–Илүү, бүр илүүг хүсцгээ!” гэхлээр нь тэд:

---

153. Хар. Шафии, *Рисалэ*, х. 193, Истанбул, 1985; Сүюүтий, *Мифтах*, х. 48, Бейрут 1987.

154. Хар. *Муватта'*, Бүюү', 33; Ибн-и Мажэ, Мукаддима, 2.

“–Аллах Таалагаас өөр юу ерөөж чадах вэ?!” гэцгээв.

Тэгэхлээр нь Хазрат-и Умар -радъяллаху анх-:

“–Би, бидний суусан энэ гэрийн Эбү Үбэйдэ бин Жэррах, Муаз бин Жэбэл ба Хүзэйфэтү’л-Еманий мэтийн (шилмэл бөгөөд бүх талаасаа төгс) хүмүүсээр дүүрэн болох ба тэдний г Аллахад бууж өгөх замд буюу тэблиг ба боловсруулах үйлчилгээнд тохирохыг хүсэн ерөөнө...” гэв. (Бухарий, *Тарихуʼс-Сагийр,* I, 54)

❁

Энэрэл ба халамжийн эх булаг асан Аугаа Раб маань, боолчуудыг нь үнэн шашинд дуудахад мөрдөх хэрэгтэй хамгийн нөлөөтэй аргыг ингэж зарладаг:

اُدْعُ اِلٰى سَبِيلِ رَبِّكَ بِالْحِكْمَةِ وَالْمَوْعِظَةِ الْحَسَنَةِ
وَجَادِلْهُمْ بِالَّتِي هِيَ اَحْسَنُ اِنَّ رَبَّكَ هُوَ اَعْلَمُ بِمَنْ ضَلَّ
عَنْ سَبِيلِهِ وَهُوَ اَعْلَمُ بِالْمُهْتَدِينَ

Аяа Расул минь! Хүмүүсийг **Раббынхаа замд эрдэм ба сайхан сургаалаар уриад** хэрэгтэй болбол **тэдэнтэй хамгийн сайхан аргаар өрсөлд...”** (эн-Нахл, 125)

وَلَا تُجَادِلُوٓا اَهْلَ الْكِتَابِ اِلَّا بِالَّتِي هِيَ اَحْسَنُ
اِلَّا الَّذِينَ ظَلَمُوا مِنْهُمْ وَقُولُوٓا اٰمَنَّا بِالَّذِيٓ اُنْزِلَ اِلَيْنَا
وَاُنْزِلَ اِلَيْكُمْ وَاِلٰهُنَا وَاِلٰهُكُمْ وَاحِدٌ وَنَحْنُ لَهُ مُسْلِمُونَ

“Тэдний дундаас тамлагсдаас нь байтугай, эхл-и китабаар зөвхөн хамгийн сайхан аргаар өрсөлдөж: «Бидэнд буулгасанд ч танд буулгасанд ч итгэлээ. Бидний бурхан ч таны бурхан ч нэг бөгөөд бид Тэрээрт бууж өгсөн байдаг,» гэцгээ.” (эл-Анкэбүт, 46)

وَمَنْ اَحْسَنُ قَوْلًا مِمَّنْ دَعَٓا اِلَى اللّٰهِ وَعَمِلَ صَالِحًا وَقَالَ اِنَّن۪ي مِنَ الْمُسْلِم۪ينَ وَلَا تَسْتَوِي الْحَسَنَةُ وَلَا السَّيِّئَةُ اِدْفَعْ بِالَّت۪ي هِيَ اَحْسَنُ فَاِذَا الَّذ۪ي بَيْنَكَ وَبَيْنَهُ عَدَاوَةٌ كَاَنَّهُ وَلِيٌّ حَم۪يمٌ

“Салих сайхан **үйлс хийгээд: «Би Аллахад бууж өгөгсдөөс юм,» гээд хүмүүсийг Аллахад урьсан хүнээс сайхан яриатай хэн нь байж болох вэ! Сайн ба муу нь тэгш биш юм. Чи мууг хамгийн сайн аргаар саатуулахыг хичээ.[155]** Тэгээд нэг харвал **Чамд өстөн болсон хүн нь Чиний дотно нэгэн анд болчихсон.”** (Фүссилэт, 33-34)

قُلْ هٰذِه۪ سَب۪يل۪ٓي اَدْعُٓوا اِلَى اللّٰهِ عَلٰى بَص۪يرَةٍ اَنَا۠ وَمَنِ اتَّبَعَن۪ي وَسُبْحَانَ اللّٰهِ وَمَٓا اَنَا۠ مِنَ الْمُشْرِك۪ينَ

“Ингэж хэл: Энэ нь миний зам; үнэнийг харахаар Аллахад урьж байна. Би болон намайг дагагчид ийм л байдаг. **Би Аллахыг тэсбих хийдэг ба би мүшрикчүүд биш.”** (Юүсүф, 108)

155. Юүсүф -алэйхиссэлам-ын байдал энэ аетад гоё нэгэн жишээ юм. Тэр түүнд харгисласан дүү нарынхаа гэмт хэргийг царайндаа илэрхийлээгүй, өөрийгөө далдалж тэдэнд хэвээрээ үйлчилсэн байдаг. Эцэст нь дүү нар нь түүнийг тахиж: تَاللّٰهِ لَقَدْ اٰثَرَكَ اللّٰهُ عَلَيْنَا **“...Аллахад тангараглая үнэхээр Аллах чамайг биднээс давуу болгосон юм...”** (Юүсүф, 91) гээд Түүний давуу буйг хүлээн зөвшөөрч илчлээд уучлал гуйцгаав. Энэ байдлаараа тэблигийн хэдий нөлөөтэй нэгэн арга буйн ил нэгэн жишээ юм. Дэлгэрэнгүй мэдээллийн төлөө хар. Осман Нури Топбаш, *Нэбийчүүдийн Дараалал 2,* х. 129-130, Истанбул, 2004.

Санал болгосон энэ тэнгэрлэг аргыг хэрэгжүүлэхийн үр дүнд түүхэнд хэдэн олон өргөст сарнайгаар хатгуулж, олон цээж туяанд автсан байдаг.

Аугаа Эрх нь Муса ба Hârûn -алэйхимэссэлам-ыг Фарон шиг үнэхээр догширсон ба төөрсөн хүнд илгээхдээ ч зөөлөн арга хэрэглэхийг санал болгоод ингэж тушаав:

فَقُولَا لَهُ قَوْلًا لَيِّنًا لَعَلَّهُ يَتَذَكَّرُ اَوْ يَخْشٰى

“Түүнд зөөлөн үг хэлцгээ. Магадгүй сургаалыг сонсч эсвэл Аллахаас айдаг байж болно.” (Та-ха, 44)

Энэ аят-и тэблигийн хоёр гол зүйлийг үзүүлнэ :

1. Үнэнийг тухайн хүнд мэдүүлэхдээ, түүнийг занг эвдэхгүйгээр, зөөлөн арга хэрэглэх:

Жишээлбэл Фарон нь Муса -алэйхиссэлам-ын гайхамшгийг харахлаараа олон удаа итгэхээр болсон ч, Хаман ба эргэн тойрныхон түүнд саад хийв. Өөрөө ч их зан гаргаж итгэн үнэмшээгүй.

Аугаа Эрх нь Муса -алэйхиссэлам-д “кавл-и лэйин буюу зөөлөн хэл” хэрэглэхийг тушаал болгож бидэнд ч тэблигийн аргыг сургаж байдаг. Үүнээс үзвэл эхлээд зүрхнүүдийг зөөлрүүлнэ, тараа нь тэблиг хийнэ.[156] Пайгамбарчууд ба Аллахын

156. Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- хижрэтийн тооллын 7 онд Хайбарыг Эзэлсний дараа ган ба өлсгөлөнд автсан Маккад алт, арвай ба хасарвааны үр илгээж тусалсан байв. Эбү Сүфьян энэ бүхнийг авч Курайшийн ядуучуудад тарааж:
“–Аллах дүүгийн минь хүүг буянаар шагнах болтугай! Учир нь Тэр садан хамаатны эрхийг хамгаалав!” гээд мэдэрсэн талархлаа илэрхийлэв. (Я’кубий, II, 56)
Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн ийм өгөөмөр хандлага нь Маккачуудын зүрхийг зөөлрүүлж хэсэг хугацааны дараа Маккагийн

андуудын амьдралд маргалдаанд ямар ч газар байдаггүй. Ятгаж тэблиг хийх нь чухал гол арга юм.

Аллах Таалагийн тэблигээр томилсон пайгамбарчууд нь сэтгэл засахаар ирсэн тул, хүмүүст байнга сэтгэлийн үүдээр ойртсон, эргэн тойрондоо эгнэгт хайр ба халамж тарааж олны авралын учир болсон байдаг. Хэрэв тэд ийм сайхан, буянтай үйлсийн эсрэг хандсансан бол, эцэст нь хоорондоо хагаралтай хүмүүстэй холбоогоо бүр тасалж, сүүлд нь ийм хүмүүст тэблиг болгох боломжоо ч алдах байв. Энэ бол тэнгэрлэг хүслэнтэй зөрчилдөнө. Учир нь Аугаа Эрх нь боолчуудын унасан намагтай газраас аврагдахыг нь хүснэ. Үүний төлөө Эрх Таала нь хүн төрөлхтний турш хэдэн мянган пайгамбар илгээсэн ба хамгийн сайхан аргаар сэтгэлийг засахыг тэдэнд тушаасан байдаг. Дахиад ижил зорилгоор хүмүүст хайрласан эхлуллах буюу Аллахын андаар хүлээж авсан хүмүүс ч хүн төрөлхтний сүнсний боловсролд ийм номлох аргыг үргэлжлүүэв.

Сайхан ёс суртахуунтай нийцэшгүй бүдүүлэг, ширүүн, хатуу аргаар хийсэн үйлчилгээнээс үр дүн олох найдваргүй. Ялангуяа хүний сэтгэлд хандсан боловсрол, хүмүүжил ба тэблиг мэтийн үйлчилгээнд, энэ хэрэг бүр илүү анхаарал шаарддаг. Энэ тухай ает-и кэримэ нь Орчлонгийн Хүндэт Эзэн маань болон Түүний өмнөөс хамаг үммэтэд нь хандан:

فَبِمَا رَحْمَةٍ مِنَ اللهِ لِنْتَ لَهُمْ وَلَوْ كُنْتَ فَظًّا غَلِيظَ الْقَلْبِ لَانْفَضُّوا مِنْ حَوْلِكَ فَاعْفُ عَنْهُمْ وَاسْتَغْفِرْ لَهُمْ وَشَاوِرْهُمْ فِي الْاَمْرِ فَاِذَا عَزَمْتَ فَتَوَكَّلْ عَلَى اللهِ اِنَّ اللهَ يُحِبُّ الْمُتَوَكِّلِينَ

Ялалтад ийнхүү хандлагаас болоод амархан мусульман болсон байцгаав.

“Аяа Хабиб минь! **Аллахаас** Чамд ирсэн **энэрлийн улмаас Чи тэдэнд зөөлөн хандав! Хэрэв бүдүүлэг ба хатуу зүрхтэй байсансан бол, мэдээж тэд Чамаас холдож явах байв...”** хэмээн айлдав. (Ал-и Имран, 159)

2. Ямар ч байдалд буйг нь харалгүй, тэблигийг хамаг хүн төрөлхтөнд хандуулах:

Фарон нь итгэх үнэмшихэд ойртдоггүй харгис ба азгүй байснаар үл барам, мөн Муса -алэйхиссэлам-ыг үгүй болгох учиртай хэдэн мянган гэмгүй үрийг алсан нэгэн яргачин байв. Ийм байсан боловч тэнггэрлэг тэблиг түүнд хандав.

Пайгамбар Эзэн маань -саллаллаху алэйхи вэ сэллэм- ч Эбү Жэхилд хэдэн олон удаа тэблиг хийв. Эбү Жэхил бол Пайгамбар Эзний маань ил далангүй номлохыг нь дотроо хүлээж зөвшөөрсөн ч ихэмсэг зангаасаа болж үүнийг хэлээрээ илэрхийлж чадаагүй байв. Гэтэл Аллахын Элчийн уг агуу хандлага нь Умар бин Хаттаб, Эбү Сүфьян, Хинд ба Вахши мэтийн, эхэнд Исламын дайсан байсан олон хүний аврալд хүрэхийн учир болов.

Энэ нь Исламын үйлчилгээнд ч, хүн төрөлхтний хамаг харилцаанд ч хандсан хүмүүсийн ил байдал шиг, магадтай байдалд ч анхаарал хандуулснаас төрөх нэгэн гоо сайхан, уяхан сэтгэл ба элдэг занг хэрэгжүүлэх боломж олгоно. Тухайлбал суфийчуудын үйл ажиллагаандаа хамгийн идэр ба эрдэмт нөлөө олж гэрчилдэг харааны гол арга энэ л юм.

Оршигчдын Туяаны сургаалаа дүүрэн хорин гурван жилийн тэблигийн амьдралыг шинжилбэл, тэблигчийн замыг гийгүүлэх тус зарчмуудыг гэрчилнэ:

1. Аллахын Элч тэблигт хамгийн ойр дотноос эхэлсэн байв. Учир нь Аугаа Эрх ингэж айлдана:

وَأَنذِرْ عَشِيرَتَكَ الْأَقْرَبِينَ

“Эхлээд **дотно садан хамаатандаа ойлгуул,** ахиратын зовлонгоор болгоомжлуул!” (эш-Шуара, 214)

يَا اَيُّهَا الَّذٖينَ اٰمَنُوا قُوا اَنْفُسَكُمْ وَاَهْلٖيكُمْ نَارًا وَقُودُهَا النَّاسُ وَالْحِجَارَةُ عَلَيْهَا مَلٰٓئِكَةٌ غِلَاظٌ شِدَادٌ لَا يَعْصُونَ اللّٰهَ مَٓا اَمَرَهُمْ وَيَفْعَلُونَ مَا يُؤْمَرُونَ

“Аяа итгэгчид ээ! Өөрсдийгөө болон гэр бүлийнхнээ хүн байтугай хад чулуу хайлах ТИЙМ **нэгэн галаас хамгаалцгаа. Түүний дээгүүр нэлээд хатуу ширүүн мэлэкчүүд байдаг, тэд Аллахыг эсэргүүцдэггүй ба тушаасан бүхнийг хийдэг.”** (эт-Тахрим, 6)

2. Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- Исламд урихдаа шат шатны өөр өөр аргыг сонгосон, хялбараас хэцүү рүү төвшин бүрээр урагшилдаг замыг мөрдөв.

Аллах Таалагийн анхны тушаал нь اِقْرَأْ **“Унш!”** (эл-Алак, 1) хэмээх ает байв.

Ингээд Эзэнд маань номлох үүрэг олгож, قُمْ فَأَنذِرْ **“Босоод болгоомжлуул!”** (эл-Мүддэссир, 2) хэмээн тушааж, түүний дараа бол:

وَاَنْذِرْ عَشٖيرَتَكَ الْاَقْرَبٖينَ

“Эхлээд **ойр садан хамаатантайгаа ярь,** ахиратын зовлонг сануул!” (эш-Шуара, 214) гэсэн тэнгэрлэг тушаал нь ирэв.

Үүний араас үүргийн хязгаар хамаг хотыг хүрээлэхээр өргөтгөж ингэж айлдав:

وَمَا كَانَ رَبُّكَ مُهْلِكَ الْقُرٰى حَتّٰى يَبْعَثَ فٖٓي اُمِّهَا رَسُولًا يَتْلُوا عَلَيْهِمْ اٰيَاتِنَا وَمَا كُنَّا مُهْلِكِي الْقُرٰٓى اِلَّا وَاَهْلُهَا ظَالِمُونَ

“Раб чинь тэдэнд бидний аетуудыг уншсан пайгамбарыг нутгийн төвд илгээгээгүй байхдаа, тухайн орны хүмүүсийг сөнөөгч биш юм. Угаасаа Бид зөвхөн буруу номтон орнуудыг мөхөөсөн байдаг.” (эл-Касас, 59)

Дараагийн төвшинд, урилгын хил хязгаар нь эргэн тойрны аймгуудыг ч багтаахаар өргөдөв:

وَهٰذَا كِتَابٌ اَنْزَلْنَاهُ مُبَارَكٌ مُصَدِّقُ الَّذ۪ي بَيْنَ يَدَيْهِ وَلِتُنْذِرَ اُمَّ الْقُرٰى وَمَنْ حَوْلَهَا وَالَّذ۪ينَ يُؤْمِنُونَ بِالْاٰخِرَةِ يُؤْمِنُونَ بِه۪ وَهُمْ عَلٰى صَلَاتِهِمْ يُحَافِظُونَ

“Энэ Ном (Кур’ан)**, өөрөөсөө өмнөх Номнуудыг баталсан, хотуудын эх (** Маккагийн**) ард ба эргэн тойрны хамаг хүн төрөлхтнийг болгоомжлуулахаар Чамд буулгасан нэгэн Судар мөн...”** (эл-Эн’ам, 92)

Эцэст нь тэблиг үүргийн хил хязгаарын хамаг хүн төрөлхтнийг агуулах чинээ өргөн буйг нь зарлав:

وَمَٓا اَرْسَلْنَاكَ اِلَّا رَحْمَةً لِلْعَالَم۪ينَ

“Аяа Мухаммед аа! **Бид Чамайг орчлонгуудад энэрэл болгож л илгээв.”** (эл-Энбияа, 107)

وَمَٓا اَرْسَلْنَاكَ اِلَّا كَٓافَّةً لِلنَّاسِ بَش۪يرًا وَنَذ۪يرًا وَلٰكِنَّ اَكْثَرَ النَّاسِ لَا يَعْلَمُونَ

“Бид Чамайг хамаг хүмүүст сайхныг мэдээлэгч ба болгоомжлуулагчаар л илгээв; гэтэл хүмүүсийн ихэнх нь үүнийг мэддэггүй.” (Сэбэ’, 28)

Орчлонгийн Хүндэт -алэйхи экмэлү’т-тахийят- Эзэн маань хандсан хүмүүсийн тухай төвшний харьцааг дагасан шигээ тэблиг хийх дүрэм журмыгярихдаа ч ижил аргыг хэрэглэв. согтууруулах ундаа уух ба мөнгөний хүүг хориглох мэтийн олон хэрэг үүний нэг жишээ юм.

Оршигчийн Туяа нь итгэл, залбирал үйлчилгээ болон ёс суртахуунаараа төгс төвшинд хүрсэн асхабаа, гэнэтийн өөрчлөлтөөр биш, мэдрэгдэшгүй, удаан ба шат шатаар агуу нэгэн төвшин гаргав. Жишээлбэл Муаз бин Жэбэлийг Йеменд илгээхдээ түүнд хэлсэн зарим сургаал нь үүнийг илээр заадаг:

“ чи. Тэднийг Аллахаас өөр бурхан үгүй ба намайг Аллахыг Расул буйд гэрчлэхэд урь. Хэрэв үүнийг чадвал, Аллах тэдэнд өдөрт таван удаа мөргөхийг фарз болгосныг мэдүүл. Үүнийг зөвшөөрч дагавал, баядаас аваад ядууд өгөхөөр тэдэнд зэкат фарз болгосныг мэдээл. Үүнийг ч дагасан тохиолдолд, эд барааных нь хамгийн үнэтэйг авахаар бүү оролд! Аргагүй хүний хараалыг авахаас болгоомжил, учир нь түүний хараал ба Аллахын хооронд хөшиг байдаггүй.” (Бухарий, Зэкат 41, 63; Мүслим, Иман 29-31)

3. Аллахын Элч -алэйхиссалатү вэссэлам- Эзэн маань тэблиг ба боловсруулах талаар хүний цаг, орон ба сүнсний хамгийн боломжтой үеийг хүлээдэг байв.

Сахабагаас Ибн-и Мэс’үд -радъяллаху анх- хүмүүст Пүрэв гариг болгонд сургаал ярьдаг байв.

Хэн нэгэн түүнд:

“–Эбү Абдуррахман аа! Бидэнд өдөр бүр сургаал ярьдаггүй яагаад вэ!” гэв.

Ибн-и Мэс’үд -радъяллаху анх- түүнд эдгээрийг хэлэв:

“–Таныг залхаахгүйн тулд өдөр бүр сургаал ярихгүй байна. Угаасаа Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- ч биднийг залхахгүй гэж бидний сонсоход сонирхолтой байх өдрүүдийг хүлээдэг гэв.” (Бухарий, Илим, 11, 12)

Маккагийн Ялалтад Аббас -радъяллаху анх- нь мусульман болохыг хүлээн зөвшөөрсөн Эбү Сүфьяныг авчирч Аллахын Элчид ингэж хэлэв:

“–Аяа Расулаллах аа! Эбү Сүфьян магтаалд дуртай хүн. Түүнийг хүндэтгэх нэг юм хийхгүй юү!”

Тэгэхлээр нь Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-:

“–Чиний зөв! Хотод орохдоо ингэж зарлаарай: Хэн нь Эбү Сүфьяны гэрт орвол аюулгүйд юм, хэн нь хаалгаа хааж гэрээсээ гарахгүй бол аюулгүйд юм,” хэмээн айлдав. (Эбү Давуд, Хараж, 24-25/3021)

Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- заримдаа Түүнээс юм асуусан хүмүүст, тухайн хүний байдалтай хамаатай хариу өгч, тухайн хүнд тохирох арга замыг дагасан байдаг.

“Хамгийн эрдэмтэй үйл аль вэ?” гэж асуусан өөр өөр хүмүүст, тэдний байдалд тохируулан ийм тустай хариу өгсөн байдаг:

“Үйлсийн хамгийн эрдэмтэй нь Аллахад итгэж үнэмших, Аллахын замд жихад хийх ба цагт нь ёсоор нь хийсэн хаж-мөргөл нь буян мөн!” (Бухарий, Хажж, 4)

“Цагт нь үйлдсэн мөргөл юм!” (Бухарий, Мэвакит, 5)

“Зикруллах буюу Аллахыг дурдах юм!” (Муватаа’, Кур’ан, 24)

“Аллахын төлөө хайрлах!” (Эбү Давуд, Сүннэт, 2)

“Хижрэт буюу нүүх юм!” (Нэсаи, Бэй’ат, 14)

“Ээж ба аавдаа үйлчлэх юм!” (Ибн-и Эсир, *Үсдү’л-Габэ,* IV, 330)

4. Пайгамбар Эзэн маань ямар ч хэрэгт хялбаршуулах ба сайхныг хэлэхийг амьдралын чухалд үзэж, тэблигт онцгой анхаарал хандуулав.

Хадис-и шарифад ингэж айлдана:

“Хялбаршуул, битгий албад. Сайныг хэл, битгий өс сана.” (Бухарий, Илим 11, Эдэб 80)

Жишээлбэл Аугаа Эрх ч:

يُرِيدُ اللّٰهُ بِكُمُ الْيُسْرَ وَلَا يُرِيدُ بِكُمُ الْعُسْرَ

“…Аллах танд амрыг хүсч байгаа, хэцүүд тэр ч дургүй...” (эл-Бакара, 185)

وَرَحْمَتِي وَسِعَتْ كُلَّ شَيْءٍ

“…Рахмат минь бүгдийг агуулж бүсэлсэн…” (эл-А’раф, 156) хэмээн айлдав.

Орчлонгийн Хүндэт -саллаллаху алэйхи вэ сэллэм- нь энэ аетыг тэфсирийн учирт ингэж айлдав:

“Аллах Таала нь оршигчдыг туурвисандаа, өөрийнх онгонд Огторгуйн дээр буй номдоо: «Энэрэл минь үнэхээр .... минь дагав!» хэмээн бичсэн мөн.” (Бухарий, Тэвхид, 15, 22, 28, 55; Мүслим, Тавба, 14-16)

Асхабаас Эбү Хүрэйрэ -радъяллаху анх- ийм нэгэн хадис дамжуулна:

Нэгэн бадавий нь Мэсжид-и Нэбэвийд бие засжээ. Сахабийчууд түүнийг загнаж эхэллээ. Тэгэхлээр нь Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм-:

"–Тэр хүнийг чөлөөл, хөөрхий. Бие зассан газар дээр нэгэн ховоогоор ус асгаад цэвэрлэ. Та бид хялбарыг үзүүлэхээр илгээгдсэн, хэцүүг биш," хэмээв. (Бухарий, Вуду' 58, Эдэб 80)

5. Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- тэблиг хийж байхдаа хүмүүсийг тэнгэрлэг гэсгээлт байгааг сануулж, тэднийг ахиратад бэлдэхэд урамшуулав.

Орчлонгуудын Эзэн нь анх урьж ахалсанд, Хашимынханд ингэж хандсан байв:

"Би таныг «Ла илахэ иллаллахү вахдэхү ла шэризэ лэх: Аллахаас өөр нэг ч бурхан үгүй! Тэрээр цорын ганц! Тэрээр ижилгүй!» гээд гэрчлэхээр урьж байна. Би ч Тэрээрийн боол бөгөөд Расул мөн. Үүнийг ингээд хүлээн зөвшөөрсөн тохиолдолд, таны диваажинд орохын баталгаа нь би байна.

Та киямат өдөр сайхан үйлстэйгээрээ ирэхгүй, энэ насны зовлонгоосоо хүзүүндээ үүрсээр ирвэл, би танаас нүүр буруулна! Тэгэхээр та надад: «Аяа Мухаммед!» гэцгээнэ. Би бол ингэж хэлнэ."

Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- *"ингэж хэлнэ"* хэмээн айлдахдаа нүүрээ тэднээс өөр тийш эргүүлж, үүнийг хоёр дахиа давтав. (Ибн-и İshâk, х. 128; Я'кубий, II, 27)

6. Пайгамбар Эзэн маань тэблиг хийсэн сэдвийг зөвхөн үгээрээ биш, өөрөө өөрийнхөө амьдралд хэрэгжүүлэн, биерээ ч хүмүүст үлгэрлэдэг байв.

Исламыг хэрэгжүүлэн тэблиг хийх нь боловсролын хамгийн гоё арга юм. Асхаб-и кирам нь дэлхийн хамгийн мухар булан хүртэл итгэлийн авиаг сонсгож хүмүүст авралд хүргэхийн тулд өөрсдийгөө Исламд зориулав. Өнөөдөр ижил бишрэлээр Исламын гоо сайхныг дэлхийд толилуулах нь тэблигийн хамгийн гоё нэгэн арга мөн.

Исламтай амьдарч тайлбарлаад тэблиг хийдэг итгэгч бүрд тэнгэрлэг нэгэн үүрэг бий. Манай үед боломж хөгжсөн бөгөөд холбох арга багаж нь арвижсны улмаас, энэ үүргийн хариуцлага ч нэлээд хүндрэв. Дэлхийн хол нэгэн буланд амьдарч Исламыг мэдээгүй хүмүүст, бидний ойрт байсан ч, сануулах ба боловсроход хойш тавьсан олон хүмүүс ахиратад бидний захыг мушгиж, тооцоог нь асуух юм.

Үүний тухай Эбү Хүрэйрэ -радъяллаху анх- ингэж хэлнэ:

“Бид үүнийг сонсдог байлаа:

Киямат өдөрт нэгэн хүн, нэгэн хүнтэй зарга ярина. Хоёр дахь нь:

«–Надаас юу нэхээд байгаа юм бэ? Бие биеэ таних ч үгүй юм!» гэнэ.

Нөгөөх нь бол:

«–Чи дэлхийд намайг алдаа ба муухай үйл дээр хараад саад хийдэггүй, сануулдаггүй байлаа,» одоо чамд хариуг өгнө.” (Руданий, *Жэм’ү’л-Фэваид,* V, 384)

Исламын Тэблиг ба Шашин Номлох

Исламд тэблиг болон боловсролын гол зорилго нь үнэн шашныг хүн төрөлхтөнд хүргэх юм.[157] Зорилт нь хүмүүсийг

157. Хар. эл-Маидэ, 67.

албадан бүх төрлийн аргыг хэрэглэн мусульман болгох биш юм.[158]

Христийн шашныг дэлгэрүүлэх үйлд хандсан хүмүүсийг ямар ч байсан христжүүлэх ба вафтиз хийлгэхийг чухалд тавьсан байдаг.[159] Христийн шашин дэлгэрүүлэгчдийн жишээ авсан Павел нь нэгэн захиандаа яаж хандахаа ингэж илэрхийлдэг:

“Би чөлөөтэй, хэний ч боол биш юм. Харин илүү хүн олох тулд хүн бүрийн боол ч байх болно. Еврейчүүдийг олохын тулд еврейчүүдэд еврей шиг хандлаа. Өөрөө шэриатыг дагадаггүй боловч, шэриатчдыг олохын тулд тэдэнд шэриатад холбоотой юм шиг хандлаа. Есүсийн хуульд харьяалсан боловч хуульгүйчүүдийг олохын тулд хуульгүйчүүд шиг хандлаа. Хүчгүйчүүдийг олохын тулд тэдэнтэй адил хүчгүй боллоо. Яасан ч гэсэн аргалаад заримыг аврахын тулд хүн бүртэй адил боллоо.”[160]

Үүнээс харвал Павел зорилгодоо учрах тулдаа ямар ч дүрэм ба хил хязгаар ч тавилгүй бүх төрлийн аргыг хэрэглэх ёстой гэж үздэг. Гэтэл Исламд шэриатын зорилгод хууль бус аргаар хүрэх нь хориглосон байдаг. Бүр эхнээс нь эвдсэн Христийн шашны хүлээн зөвшөөрсөн энэ буруу арга олон хүмүүст месежийг хүргэхийн оронд тэднийг ямарч аргаар хамаагүй христжүүлэх ажиллагаа нь шашны цөм эвдэрч алга болсны, месежийг газар бүрт өөрчилж шашныг дагагчдыг цаг хугацааны явцад эвдсэний учир болсон байдаг.

Христийг дэлгэрүүлэгчдийн үйл нь, нийгмийн ба улс төрийн талаар хэцүү байдалд орсон хүмүүст, ядуу, нүүдэлчид,

158. Хар. эл-Бакара, 256; Яа-син, 17.
159. Хар. *Матайгийн Инжил* 28:19-20.
160. Хар. Коринфчуддад Захидал I, 9:19-22.

бага ястан, дайн ба байгалийн гамшгийн хохирогчдод , тухайн хүмүүсийн эд барааны ба хүнсний бухимдлыг буруугаар ашиглаж бараг тэдний итгэл үнэмшлийг худалдаж авахыг хичээсэн нь харагдана.

Нөгөө талаас Христийн шашны дэлгэрүүлэх ажиллагааны империалзмтай ойр дотны харьцаатай байж, зорилго нь гагнаас байтугай улс төрийн бодлоготой хамаатай буй нь мэдээгддэг юм. Христийн шашны дэлгэрүүлэгчид гол, төв нутагт суурьшаад сургууль гадаад хэлний курс гэх мэтийн боловсролын үйл ажиллагааны нэрийн доор хүмүүсийг христжүүлэхийг хичээдэг.

Павелын аргыг барин дагагч манай эриний дэлгэрүүлэгчид нь "такийя" хийдэг, өөрөөр хэлбэл жинхэнэ үнэмлэхээ далдлан хандсан хүнд таалагдахаар харагдахыг чухалчилдаг. Жишээлбэл мусульманчуудад энхрий харагдахын тулд Кур'анаас аетууд унших, мусульманы хувцас өмсөх, "педер", "лам" гэсний оронд "хожа"; "чиркэв" гэсний оронд "жамий" мэтийн Исламын ойлголтыг ашиглах мэтийн аргыг мөрдөж байдаг. Дахиад хүмүүсийг шашнаас нь эргүүлэх ба өөрсдөө дөхүүлэх тулд Христийн шашнаас маш олон буулт хийхийг заншил болгосон байдаг.[161]

Христийн шашны дэлгэрүүлэгчид ийм бишрэлтэй ажилласаны хариунд мусульманчууд ч өөрсдийн болон хүүхдийнхээ хүмүүжилд анхаарал үзүүлэх, Исламыг хамгийн сайнаар сурч хэрэгжүүлэхийг ба бусад хүмүүст хүргэхийг хичээх хэрэгтэй юм. Мусульманчууд хамгийн багаар нь эвдэрсэн шашнаа тараахад ийм ихээр хичээсэн христчүүдээс жишээ авч, жинхэнэ буй Ислам шашныг амьдарч тэблиг хийхийг хичээх ёстой юм. Учир

161. Хар. Шинаси Гүндүз, х. 5-28.

нь шүкүр буюу талархлыг нь төлөхийн аргагүй Ислам шашныг тэблиг хариуцлагаа мартахгүй байх нь хэрэгтэй юм.

Өөд болсон шүлэгч маань Мэхмэд Акиф мусульманчуудын энэ тухай дутагдлыг зааж ингэж хэлдэг:

Мисъёнерчууд өдөр шөнөгүй дэлхийг дамжуулна;
Эрдэмтэд бол магадгүй тэнгэрлэг вахийг хүлээнэ!

Эбү Лэхэб ба Эхнэр нь Даварсан нь

Орчлонгийн Хүндэт Эзний маань жаргалын гэр нь мөнхийн хоёр ядуу Эбү Лэхэб ба Үкбэ бин Эбий Муайтын гэрийн хооронд байв. Эд нар, хамаг төрлийн бохирыг авчирч Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн үүдэн дээр хаядаг байв. Орчлонгийн Эзний маань уяхан ба цэвэр сэтгэл нь хөрш нарын ингэж даварснаас гомдож:

“–Эе Абди Мэнафынхан! Энэ нь ямар хөршийн харьцаа вэ?!” гэж зэмлэж, бохирдлыг үүднээсээ нумаараа холдуулдаг байв. (Ибн-и Са’д, I, 201)

Эбү Лэхэбийг нэгэн өдөр дахиад ижил муухай үйлээ хийх гэж байхад Хазрат-и Хамза түүнийг харав. Бохирдлыг гараас нь авч толгойн дээр нь асгав. Эбү Лэхэб нь нэг талаас бохирыг цэвэрлэж байхдаа нөгөө талаас ч Хазрат-и Хамзаг доромжилж байв.[162]

Эбү Лэхэбийн эхнэр Үммү Жэмил ч Аллахын Элчид зовлон хүртээхэд нөхрөөсөө хойно үлддэггүй, шөнө бүр модны өргөстэй мөчрүүдийг том нэгэн баглаа болгож, хүзүүндээ өлгөж, шөнө хөлд нь хатгах гэж Хүндэт Элч Эзний маань яваад өнгөрөх замд хаядаг байв. Расулаллах -саллаллаху алэйхи вэ

162. Хар. Ибн-и Эсир, *эл-Камил,* II, 70.

сэллэм- бол тэдэн дээр торгон дээр гишгэхтэй адил гишгэж явдаг байв.[163]

Тэдний ийм харгислалаас болж, тэдний тухай Тэббэт Сура нь буусан байв. Үммү Жэмил үүнийг сонсохлоороо гартаа том нэгэн чулуу аваад Пайгамбар Эзнийг маань хайж гадаа гарав. Аллахын Элч тэр хооронд Хазрат-и Эбү Бэкирийн хамт Кабад байв.

Эбү Бэкир -радъяллаху анх- нь түүнийг ирж буйг харахлаараа Оршигчийн Туяанд:

"–Аяа Расулаллах аа! Энэ нь Үммү Жэмил мөн. Зэвүүрхэм нэгэн эмэгтэй юм. Таныг хараад даварч мэднэ гэж би санаа зовно. Энэ эмэгтэйг чамд ямар нэгэн аюул хүргэхээс өмнө босоод явсан чинь дээр байв!" гэлээ.

Орчлонгийн Хүндэт Эзэн маань:

"–Тэр намайг харж чадахгүй!" хэмээв.

Үнэхээр Үммү Жэмил тэдний дэргэд хүрсэн ч Аллахын Элчийг харж чадаагүй. Эбү Бэкир -радъяллаху анх-ын хажууд зарим үгээр орилсоны дараа буцаад явав.[164]

❀

Номлохоос өмнө Пайгамбар Эзний маань охид Хазрат-и Үммү Гүлсүм нь Эбү Лэхэбийг хөвүүн Үтэйбэтэй, Хазрат-и Рукайя бол нөгөө хөвүүн Үтбэтэй сүй тавьсан боловч, арай гэрлээгүй байв. Тэббэт Сураг буухлаар нь Үммү Жэмил хөвүүддээ:

163. Хар. Ибн-и Хишам, I, 376; Куртубий, XX, 240.
164. Хар. Ибн-и Хишам, I, 378-379; Куртубий, XX, 234.

“–Рукайя ба Үммү Гүлсүм нар шашнаас халагдав. Тэднээс салцгаа!” гэв.

Эбү Лэхэб ч:

“–Мухаммедын охидоос салахгүй бол, миний толгой харам болог!” хэмээн тангараг өргөв.

Тэгэхлээр нь Аллахын Элчийн дэргэд очсон Үтэйбэ:

“–Би Чиний шашныг танихгүй. Чиний охиноос ч саллаа. Одоогоос хойш Чи ч надад бүү ир, би ч Чамд ирэхгүй!” гэсний дараа Орчлонгуудын Эзний цамцыг урав!

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- Үтэйбэгийн хийсэн ийм соёлгүй үйлийн хариунд:

“–Аллах минь! Нохойноосоо нэгэн нохойг түүний араас дагуул!” гээд хараав.

Хэсэг хугацааны дараа Үтэйбэ наймаачидтай замд гарав. Зэрка хэмээн мэддэг нэгэн газар хоноцгоов. Тэр шөнө нэгэн арслан ирээд тэднийг тойрч эхлэхлээр Үтэйбэ:

“–Ижий! Валлахи Мухаммедын хэлснээр энэ нь намайг иднэ! Өөрөө Маккад, би Дамаскад байсан ч миний алуурч Ибн-и Эбий Кэшбэ юм!”[165] гэв.

Арслан тэр шөнө тэднийг тойрсны дараа эргэж явав. Найзууд нь Үтэйбэг дундаа авч унтав. Арслан нь буцаад ирэв. Тэдний дундуур алхаж өнгөрөв. Аажил аажмаар ба үнэртээд

165. Өмнө нь Хузаа аймгаас Эбү Кэбшэ гэсэн нэртэй нэгэн баримлад залбирах тухай аймгийнтайгаа маргалдсан байв. Мүшрикчүүд Пайгамбар Эзнийг маань түүгээр төсөөлж, Түүнд Ибн-и Эбий Кэбшэ гэдэг байцгаав. Эбү Кэбшэг Аллахын Элчийн эх буюу эцгийн талаар өвөөгөөс нэг нэг буюу сүүний аавын хоч буйг ч хэлсэн байдаг.

Үтэйбэгийн дэргэд очоод, толгойг нь зууж хатуу нэг хазахад Аллахын өстөн үхэлтэй таарав.

Үтэйбэ:

"–Би танд «Мухаммед хүмүүсийн хамгийн үнэн яриатай нь мөн,» гээгүй юу?" гээд үхэв.

Эбү Лэхэб хүү Үтэйбэгийн гашуун заяаг мэдэнгээ:

"–Би танд «Мухаммед миний хүүгийн тухай хараалаас нь айна,» гээгүй билүү?" гэв.[166]

Оршигчийн Туяа -алэйхиссалатү вэссэлам- Эзэн маань тэр үеэр Эбү Лэхэб мэтийн хэд олон мүшрикийн харгислалтай учрав. Тэд бүхэнд тэсвэр болон тэвчээртэйгээр хариулж тэблигээ үргэлжлүүлэв.

Маккачуудын Тохиролцох Оролдлого

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн юуг ч тоохгүйгээр Исламыг тэблигээ үргэлжлүүлсэн нь мүшрикчүүдийн уурыг хүргэж байв. Мусульманчуудад уур хилэн бадарч эхлэцгээв. Учир нь шинээр ирсэн шашин тэдний ашгийг эвддэг байв. Тэд шууд Эбү Талиб дээр гүйж очив. Байдлыг ярьж саад болохгүйг шаардав. Эбү Талиб нь тэднээс элдэг үгсээр зайлсхийв. Хазрат-и Пайгамбарт ч юу ч хэлээгүй.

Ингээд юу ч өөрлөгдөөгүйг харсан мүшрикчүүд нь дахиад Эбү Талиб дээр ирээд:

"–Аяа Эбү Талиб аа! Бидэнд өөр тэвчээр үлдээгүй! Чиний ч мэдсэнээр чиний дүүгийн хүү нь бидний шашин ба бурхадыг

166. Хар. Ибн-и Са'д, VIII, 36-37; Бэйхакий, *Дэлаил,* II, 338-339; Хэйсэмий, VI, 19.

муулдаг. Биднийг ч ухаангүй хэмээн буруушаадаг. Хэрэв ач дүүгээ болиулахгүй бол, чамайгч Түүнийг ч эсэргүүцнэ. Эсвэл Түүнийг ингэснээс болиул, эсвэл Түүнийг хамгаалалтаасаа хал! Бид Түүний дийлж чадна...” гэцгээв.

Эбү Талиб ийм үгсийг сонсохлоороо Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-д мүшрикчүүдийн үйлийг зэлдэг аргаар ярьж өгөв. Түүнийг хамгаалахаа болихгүй ч мүшрикчүүдийг эсэргүүцэхгүйгээ ч мэдрүүлэн:

“–Намайг ч өөрийгөө ч хамгаал!” гэв.

Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- маш их гунив. Учир нь авга ахынхаа үгс нь хэрэг гарвал Түүнийг хамгаалахаа болино гэсэн утгатай байв. Ариун нүд нь чийгшив. Учир нь мусульманчууд арай л хүчгүй байв. Хөрөнгө ба хүч эзэмшсэн Курайшийн догшин мүшрикчүүдийг эсэргүүцэх хүч үгүй байв.

Энэ хооронд Расулынхаа автсан бэрхшээлийг давж чадахаар Аугаа Эрх ингэж айлдав:

وَاذْكُرِ اسْمَ رَبِّكَ وَتَبَتَّلْ إِلَيْهِ تَبْتِيلاً. رَبُّ الْمَشْرِقِ وَالْمَغْرِبِ لَا إِلَهَ إِلَّا هُوَ فَاتَّخِذْهُ وَكِيلاً

“Раббынхаа нэрийг дурд! Бүгдийг орхиж хамаг буйгаараа Түүнд л чиглэ! Тэрээр дорнодын ч өрнөдийн ч Раб мөн. Түүнээс өөр бурхан үгүй. Тэгвэл зөвхөн Түүний хамгаалалтад хоргод!” (эл-Мүззэммил, 8-9)

Тэгэхлээр нь Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн гуниг арилав. Эргэлзээгүй итгэл үнэмшилтэй ба агуу зоригтойгоор авга ах Эбү Талибдаа алдартай үгээ хэлэв:

“–Аяа ах аа! Аллахад тангараглая, энэ хүмүүс минйи нэгэн гарт Нарыг, нөгөө гарт Сарыг тавьсан ч би энэ урилгаа болихгүй!”

Үүнийг хэлсний дараа нулимстай нүдтэй тэндээс гарав.

Ингэж хариулна гэж бодоогүй Эбү Талиб бараг ухаан алдах шахав. Тэр итгэж үнэмшээгүй байсан, харин Хазрат-и Пайгамбарыг өөрийнх хүү шигээ хайрладаг байв. Мөн өөд болохоос түр өмнө хөвүүдээ цуглуулж Хазрат-и Пайгамбарыг хэн хамгаалахыг асуусан аав Абдүлмутталибдаа:

“–Аав аа! Чиний ч мэдсэнээр би баян биш, гэтэл уяхан сэтгэлтэй ба халамжтай мөн. Дүүгийнхээ хүүг сахихыг аминаасаа илүүд үзнэ. Энэ тухай чамд ам өгье; Түүнийг надад хадгалуул!..” гэж баталгаа өгсөн байв.

Ийм учраас Орчлонгуудын Эзний хажуугаас нь ийм гунигтэй салж гарсанд нь Эбү Талибын энэрэлт зүрх тэсэлгүй, араас нь хашхирав:

“–Дүүгийн минь хүү! Нааш ир, хүссэнээ хэл! Тангараг өргөе, юу болсон ч Чамайг тэдэнд яасан ч дарлуулахгүй !” (Ибн-и Хишам, I, 276-278; Ибн-и Кэсир, *эл-Бидая,* III, 96-97)

Мүшрикчүүд хүссэндээ хүрч чадаагүйдээ Вэлид бин Мугирагийн хүү Умараг Эбү Талиб дээр аваачаад:

“–Энэ Умара, Курайшийн залуучуудын хамгийн хүчтэй ба аятай нь мөн. Чи үүнийг аваад, түүний ухаан ба хүчийг нь ашигла! Чиний хүү байг. Чиний овог дээдсийн шашныг эсэргүүцсэн, аймгийг чинь хуваасан, бодол үзлийг нь тоохгүй энэ ач хүүгээ бидэнд гардуулж өг, Түүнийг бид ална!” гээд ухаангүй, гутамшиг нэгэн санал илэрхийлэв.

Эбү Талиб:

“–Валлахи та надад ямар муухай юм санал болгож байна! Та надад хүүгээ өгөөд, би түүнийг таны төлөө тэжээнэ. Би ч танд хүүгээ өгөөд, та бол түүнийг ална, тийм үү? Ийм юм хэзээ ч байж болохгүй!” хариуг өгөв. (Ибн-и Хишам, I, 279; Ибн-и Са’д, I, 202)

Мүшрикчүүд Эбү Талибд:

“–Мухаммедад мэдээ хүргэ, Тэр ирээд Түүнд нигүүлсэнгүй сонголт санал болгоё,” гэцгээв.

Авга ах нь мэдээ салгангаа Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- шууд хүрээд ирэв. Ахнас бин Шэрик:

“–Чи бидний бурхадыг шүүмжлэхээ боль, бид ч Чамайг ба Бурханыг чинь үймүүлэхгүй!?” гэв.

Расулаллах Эзэн маань толгойгоо өндийлгөж тэнгэр өөд хараад:

“–Тэр Нарыг харж байцгаана уу?” хэмээн асуув.

“–Тийм, харж байна,” гэсэнд нь Аллахын Элч Ислам шашны агуу талыг ба ирээдүй дэх байдлыг хамгийн сайнаар илэрхийлсэн ийм гүнзгий хариуг өгөв:

“–Тэгвэл, Би таныг агуу нарны гэрлээс ашиглахад саад болж чадах уу?”

Эбү Талиб:

“–Аллахад тангараг өргөе, миний дүүгийн хүү бидэнд хэзээ ч худал хэлсэн удаагүй юм!” гэв.

Хувьгүй мүшрикчүүд хилэнтэйгээр босч Орчлонгуудын Эзнийхээс гарав. (Ибн-и Исхак, х. 136; Ибн-и Кэсир, *эл-Бидая,* III, 92; Ибн-и Са’д, I, 202-203)

Ибн-и Аббас -радъяллаху анх-ын дамжуулснаар, үүнээс хойш Курайшийн агуу хүмүүс Кабагийн Хижр хэмээн хэсэгт цуглаж, Пайгамбар Эзнийг маань харангуутаа бүгдээр дайрч алахаар Лат, Мэнат, Узза, Наила ба Исаф гэсэн нэртэй баримлын нэрээр тангараг өргөв. Бүгдээрээ өөрийнх хувийн цусны мөнгийг төлөхөөр ч баталгаа өгөв.

Үүнийг мэдсэн охин нь Фатима -радъяллаху анхаа- уйлаад Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн дэргэд очив. Аймгийнхаа хийсэн муухай гэрээг аавдаа мэдээлэв.

Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- ус авчируулж абдэст авав. Дараа нь шууд Мэсжид-и Харамд очив.

Мүшрикчүүд Пайгмбар Эзнийг маань харангаа бишрэлтэйгээр:

“–Энэ нь тэр мөн!” гэцгээв.

Гэтэл Орчлонгийн Эзэн эрс шийдэмгий харж, хараагаа доош эргүүлэн толгойгоо бөхийлгөв. Тэдний хэн нь ч босч чадаагүй. Нүдээ дээшлүүлэн Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн царайг ч харж чадаагүй. Эзэн маань алхаж тэдний дэргэд зогсов. Дараа нь газраас шороо атган авч :

“–Та нарын царай харболог!” хэмээн тэдэн рүү цацав.

Тэр өдөр өөрт нь шорооны ширхэг оносон мүшрик тус бүр нь Бэдир Дайны өдөр алагдаж тамын нүх шиг нэгэн худагт унав. (Ахмад, I, 303)

Эдгээр явлуудын араас Эбү Талиб нь Хишамынхан болон Мутталибынхныг дуудав. Тэднээс гэр голомтын нэр алдрын улмаас Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм-

ийг Курайшаас хамгаалахыг нэхэв. Эбү Лэхэбээс бусдыг нь зөвшөөрөв.[167]

Эбү Талибд хэлсэн саналынхаа ашиг олоогүйг мэдсэн мүшрикчүүд энэ удаа шууд Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- Эзэнд маань очоод:

"–Чи удмаараа цэвэр, орноороо өндөр мөн! Одоо хүртэл Арабчуудын хооронд хэний ч хийгээгүйг хийж, хэлээгүйг хэлж байна. Бидний хооронд цав суулгав. Биднийг дайсан болгов. Ингэж хандсаны учир чинь юу вэ?

Баян болохын тулд ингэж байвал Чамд хүссэн чинээ бараа өгцгөөе. Аймгуудын хооронд Чамаас баян хэн ч болохгүй!

Тэргүүн болохыг хүсч байвал Чамайг даруй өөрсдийн тэргүүн болгоё; Маккагийн эзэн бол!

Хэрэв язгууртай эмэгтэйтэй гэрлэх санаатай байвал, Чамд Курайшийн хамгийн гоё эмэгтэйчүүдээс алийг хүсвэл өгье!

Хэрэв буг, чөтгөрийн дарамтад автсан юм бол, Чамайг анагаагчдад аваачъя. Чамайг аврахаар хамаг бэрхшээлийг даацгаая.

Чамайг юу хүссэн ч бид тэгж хийхэд бэлэн. Гагцхүү энэ зорилгоо боль!" гэцгээв.

Хайран мүшрикчүүд хүний хамгийн том эргэлзээ буй эд-бараа, орон ба эмэгтэйгээр Хазрат-и Пайшамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийг хэргээс нь болиулахыг боддог байв.

Тэд, байнга хүн агнах аргаар хэрэглэсэн уг гурван санаалд Пайгамбар Эзний маань "үгүй" гэж чадахгүйг боддог байв.

167. Хар. Ибн-и Хишам, I, 281; Ибн-и Эсир, *эл-Камил,* II, 65.

Хөрөнгө-баялаг, нэр алдар ба тачаал нь ердөө хүн хайлдаг нэфсийн том гурван хавх юм. Гэтэл мүшрикчүүд Аллахын Элчийн туяат амьдралд үүнтэй төсөөт зйүлсийн байр хэзээ ч болоогүй яасан ч ухаарч чадаагүй байв..

Жишээлбэл Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн нэлээд ойлгомжтой хариу ч энэ үнэнийг өгүүлж байв:

"–Би танаас юу ч шаардаагүй байна. Эд , бараа ч, хааны суудал ч, тэргүүний орон ч! Миний ганцхан хүсэл минь: Баримлыг шүтэхээ боль, цорын ганц буй Аллахад л залбирцгаа!" (Ибн-и Кэсир, *эл-Бидая,* III, 99-100)

Мүшрикчүүд нэфсийнхээ тушаалд орсон учраас Түүний агуу чармайлтыг яасан ч ойлгодоггүй, Түүнээс баримлыг шүтэхийг шаардах зэргээр хэтэрч байцгаав. Тэгэхлээр нь Пайгамбар Эзэн маань -саллаллаху алэйхи вэ сэллэм- нь ает-и кэримэд тушааснаар тэдэнд өөрийгөө ингэж таниулав:

قُلْ إِنِّي نُهِيتُ أَنْ أَعْبُدَ الَّذِينَ تَدْعُونَ مِن دُونِ اللّٰهِ لَمَّا جَاءَنِيَ الْبَيِّنَاتُ مِن رَّبِّي وَأُمِرْتُ أَنْ أُسْلِمَ لِرَبِّ الْعَالَمِينَ

"Ингэж хэл: Надад Раббаас минь ил нээлттэй нотолгоо ирсэн байхад, надад таны Аллахыг орхиж тэд залбирсанд залбирахаас хатуу хориглосон ба Орчлонгуудын Раббад бууж өгөхийг тушаасан." (эл-Мү'мин, 66)

قُلْ إِنَّمَا أُمِرْتُ أَنْ أَعْبُدَ اللّٰهَ وَلا أُشْرِكَ بِهِ إِلَيْهِ أَدْعُو وَإِلَيْهِ مَآبِ

"...Ингэж хэл: Надад Аллахын боол бөгөөд Түүнийг ижилгүй гэдгийг л тушаав. Би Тэрээрт л дуудах ба Тэрээрт л харина." (эр-Ра'д, 36)

إِنَّمَا أُمِرْتُ أَنْ أَعْبُدَ رَبَّ هَذِهِ الْبَلْدَةِ الَّذِي حَرَّمَهَا وَلَهُ كُلُّ شَيْءٍ
وَأُمِرْتُ أَنْ أَكُونَ مِنَ الْمُسْلِمِينَ. وَأَنْ أَتْلُوَ الْقُرْآنَ فَمَنِ اهْتَدَى
فَإِنَّمَا يَهْتَدِي لِنَفْسِهِ وَمَن ضَلَّ فَقُلْ إِنَّمَا أَنَا مِنَ الْمُنذِرِينَ

“Надад тус хотын (Маккагийн) **Раббад -Тэрээр эндэхийн дархан болгов- боолчлохыг тушаав. Хамаг юм ч угаасаа Түүнд л харьяаылдаг. Надад мусульман болох бөгөөд Кур’ан уншихыг тушаав.**

Одоогоос хэн ч зөв замд орвол, өөрийнхөө төлөө л орсон байх болно; хэн ч төөрвөл ингэж хэл: Би зөвхөн сануулга хэлнэ!” (эн-Нэмл, 91-92)

قُلْ إِنَّنِي هَدَانِي رَبِّي إِلَى صِرَاطٍ مُّسْتَقِيمٍ دِيناً قِيَماً مِّلَّةَ إِبْرَاهِيمَ
حَنِيفاً وَمَا كَانَ مِنَ الْمُشْرِكِينَ. قُلْ إِنَّ صَلاَتِي وَنُسُكِي وَمَحْيَايَ
وَمَمَاتِي لِلّهِ رَبِّ الْعَالَمِينَ. لاَ شَرِيكَ لَهُ وَبِذَلِكَ أُمِرْتُ وَأَنَاْ
أَوَّلُ الْمُسْلِمِينَ. قُلْ أَغَيْرَ اللّهِ أَبْغِي رَبّاً وَهُوَ رَبُّ كُلِّ شَيْءٍ وَلاَ
تَكْسِبُ كُلُّ نَفْسٍ إِلاَّ عَلَيْهَا وَلاَ تَزِرُ وَازِرَةٌ وِزْرَ أُخْرَى ثُمَّ إِلَى
رَبِّكُم مَّرْجِعُكُمْ فَيُنَبِّئُكُم بِمَا كُنتُمْ فِيهِ تَخْتَلِفُونَ

“Ингэж хэл: Мэдээж Раб минь намайг зөв зам, үнэн шашин руу авчрав. Тэр ерөөсөө мүшрикчүүдээс болоогүй.

Ингэж хэл: Мэдээж миний мөргөл, тахил, амьдрал ба үхэл бүхэн Орчлонгуудын Раб болон Аллахын төлөө юм. Тэрээр огт ижилгүй. Надад зөвхөн үүнийг л тушаасан ба би ахндагч мусульман мөн.

Ингэж хэл: Аллах бүгдийн Раб байхад, би Түүнээс гадна Раб хайх юм уу?..” (эл-Эн’ам, 161-164)

قُلْ هَذِهِ سَبِيلِي أَدْعُو إِلَى اللهِ عَلَى بَصِيرَةٍ

“Ингэж хэл: Миний зам энэ мөн! Би ухаанаараа Аллахад урьж байна...” (Юүсүф, 108)

قُلْ مَا أَسْأَلُكُمْ عَلَيْهِ مِنْ أَجْرٍ وَمَا أَنَا مِنَ الْمُتَكَلِّفِينَ

“Ингэж хэл: Үүний хариуд би танаас төлбөр нэхэхгүй. Өөрийнх дурааараа юм зохиосон бөгөөд байснаасаа өөрөөр харагдах хүмүүс ч биш юм.” (Сад, 86)

❀

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн ийм тод хандлагын хариунд мүшрикчүүд ядаж баримлыг өөрчлөх тухайд шийдвэр олохыг хүсэв. Хазрат-и Пайгамбараас баримлуудыг буруушаахаа болихыг нь шаардацгаав. Тэгэхлээр нь Аугаа Эрх нь ингэж айлдав:

فَلَا تُطِعِ الْمُكَذِّبِينَ. وَدُّوا لَوْ تُدْهِنُ فَيُدْهِنُونَ

“Үнэнийг худал гэж тооцогчдод ерөөсөө толгойгоо бөхийж болохгүй! Чи тэдэнд зөөлөн хандаад тэд ч Чамд зөөлөн хандахыг хүснэ.” (эл-Калэм, 8-9)

Өөрөөр хэлбэл Исламын үнэнийг хүлээн зөвшөөрсөнгүй мүшрикчүүд нь ашигтай нь зөрөлцсөн аетуудыг орхих нөхцөлөөр Пайгамбар Эзэнтэй маань нэгэн тохиролцооны төвшинд уулзаж чадахЫ бөгөөд, ийм тохиолдолд Түүнтэй

нэлээд сайхан хамт байж болохоо илэрхийлж байв. Гэтэл ает-и кэримэ дэх шийдвэр нэлээд ил байв:

إِذاً لَّأَذَقْنَاكَ ضِعْفَ الْحَيَاةِ وَضِعْفَ الْمَمَاتِ
ثُمَّ لاَ تَجِدُ لَكَ عَلَيْنَا نَصِيراً

“Хэрэв Чи тэгсэн бол **мэдээж** Бид ч **Чамд амьдрал болон үхлийн уйтгар** зовлонг **хэдэн дахин нэмэх байв. Дараа нь Бидний эсрэг өөртөө туслагч хэнийг ч олж чадахгүй байв.”** (эл-Исра, 75)

Өөрөөр хэлбэл тэвхидээс буулт хийх нь тийм хэцүү байдалд ч хориглосон байдаг. Учир нь, энэ нь шашныг арай бүрэн байгуулахаас өмнө эвдэрсний утга илэрхийлэх болох байсан бөгөөд, мүшрикчүүдийн муухай зорилго ч угаасаа ийм л байв. Гэтэл хүссэндээ хүрч чадахгүй байх тусам ухаангүйгээр зууж , баримлынхаа байдлыг аврахыг хичээж байцгаав. Үүний төлөө ийм инээдтэй санал болгоод цааш явцгаав:

“–Чи бидний баримлуудад залбир; бид ч Чиний Аллахад залбирья. Ингэхдээ бидний хоорондын зөрчил арилна!” гэцгээв.

Исламын сүнс ба логикт шал эсрэг буй ийм саналд ч Аугаа Эрх нь Кур’ан-и Кэримд ингэж хариулав:

قُلْ يَا أَيُّهَا الْكَافِرُونَ. لَا أَعْبُدُ مَا تَعْبُدُونَ.
وَلَا أَنتُمْ عَابِدُونَ مَا أَعْبُدُ. وَلَا أَنَا عَابِدٌ مَّا عَبَدتُّمْ.
وَلَا أَنتُمْ عَابِدُونَ مَا أَعْبُدُ. لَكُمْ دِينُكُمْ وَلِيَ دِينِ

“Ингэж хэл: «Еэ мунхаг тэнэг **кафирчууд! Би таны залбирдагт залбирахгүй! Та ч миний залбирдагт минь залбирахгүй! Би таны залбирдагт залбирч болохгүй! Тэгээд та ч миний залбирдагт залбирч болохгүй! Таны шашин танд, миний шашин надад!»”** (эл-Кафирун, 1-6)[168]

Хүндэт Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- Эзний маань агуу урилганд эхлээд ядуу, боол ба хүчгүй хүмүүс итгэж үнэмшив. Тэгэхдээ Хазрат-и Эбү Бэкир -радъяллаху анх-мэтийн баячуудаас итгэж үнэмшигсэд болсон ч тэдний тоо нэлээд бага байв.

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- Эзний маань мүшрикчүүдийн тохиролцох учиртай авчирсан эд бараа, орон мэтийн хамаг саналыг үгүйсгэсэн нь Түүний -заримын хэлсний эсрэгээр- баян эсвэл тэргүүн болох зорилт байгаагүйг нь ил далангүй илрүүлэв. Угаасаа Орчлонгуудын Эзний өдөр тутмын амьдрал, бүх төрлийн боломж байсан ч ядуучуудын байдлаас ялгаагүй байв. Энэ нь мэдээж Түүний зүхд, даруу зан болон сэтгэл ханамж мэтийн номлогчийн ёс суртахууны нэгэн илрэл байв.

Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- хүссэнсэн бол Курайшчуудын тэргүүн эсвэл ноён болох саналыг зөвшөөрч ийнхүү боломж ба хүчийг ирээдүйд Исламыг тэблигийн арга болгож хэрэглэж чадахсан. Гэтэл Оршигчинй Туяа Эзэн маань ийм төрийн бодлогод орж, үүнийг чармайлтаа болгохыг ерөөсөө зөвшөөрөөгүй. Учир нь Ислам нь бүх төрлийн зорилго ба шашны мэдрэмж нэр алдарт үнэнч байх дүрмийг байнга хадгалсан байдаг. Ийм л учраас мусульманчууд олон байдалд өгөөмрөөр хандаж жихад хийхээс аргагүй болдог. Учир нь, тэд-

168. Хар. Ибн-и Хишам, I, 386.

ний дагаж явсан зам нь ямар ч тахир муруй биш шулуун дардан сират-и мүттаким юм.

Кур’ан-и Кэримийн Ижаз ба Сонсогчид Дээрх Нөлөө нь

Ижаз нь толь бичигт хэн нэгийг аргагүй үлдээх эсвэл хэдэн дахин давах гэсэн утга илэрхийлдэг. Өдөр тутмын хэрэглээнд бол Кур’ан-и Кэримийн, хамгийн өндөр төвшинд буйгаасаа уран хэллэг талаараа ч, утга зохиолын талаараа ч, эсвэл нууц мэдээллийг мэдээлсний улмаас, түүнтэй төсөөт номыг хамаг хүн төрөлхтөн бүтээж чадахгүй буйг илэрхийлнэ.

Аллах Таала нь хүн төрөлхтөнд хайрласан сүүлийн Номоо хамгийн төгсөөр ба Араб хэлээр буулгахыг хүссэн тул, тус хэлээр ярьдаг хүмүүст Кур’ан бууж эхлэхээс хэдэн олон зууны өмнө сайхан яриа, сайхан үг ба уран зохиолын эрмэлзээ өгсөн байв. Арабчууд зарим тэмцээнээр уг авьяасын талаар хичээсэн байхдаа хэлээ бүр илүү дэвшүүлж бөгөөд, ингээд уг хэл нь тэнгэрлэг яриаг илэрхийлэхэд хүрэмжтэй баялаг байдаг.

Хэдэн олон зуун үргэлжилсэн ийм үйл ажиллагааны үр дүнгээр Арабчуудын хооронд ижазтай үг хэлэх хамгийн хүчинтэй мэргэжил болов. Шүлэгчид ба үг хэлэгчид нь нийгэмд шагшдаг, нүд гялбуулам дээд байранд дээшлэв. Ийм л учраас Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм-ээс гарсан гайхамшгийн хамгийн том нь үгсийн оргил буй тэнгэрлэг үг буюу Кур’ан-и Кэрим болов.

Хүнийг бусад амьтдаас ялгах хамгийн чухал шинж нь оюун, ухаан, шийдвэр ба илэрхийлэх байсан тул, хамгийн сүүлийн ба хамгийн төгс төгөлдөр нлм буй Кур’ан-и Кэримийн ижаз нь оюун, илэрхийлэх ба шинжлэх ухааны талд хэрэгжсэн байдаг. Жишээлбэл Аугаа Эрх нь ингэж айлдана:

الرَّحْمَنُ. عَلَّمَ الْقُرْآنَ. خَلَقَ الْإِنسَانَ. عَلَّمَهُ الْبَيَانَ

“Рахман нь Кур’аныг сургав. Хүнийг туурвиж түүнд илэрхийлэхийг (ярихыг) сургав.” (эр-Рахман, 1-4)

Кур’ан-и Кэримийн учрыг нь ойлгохын аргагүй ижазын хэлний эрдэмтэд тоогүй бүтээл гаргасан бөгөөд эдгээрээр маш чухал санал илрүүлсэн байдаг. Бид энд эдгээрээс заримыг товчоор дурдмаар байна.

Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- пайгамбар болсноо зарлахад нь кафирчууд:

وَقَالُوا لَوْلَا أُنزِلَ عَلَيْهِ آيَاتٌ مِّن رَّبِّهِ

“Раббаас Түүнд зарим гайхамшиг буух хэрэгтэй биш билүү?..” гээд эсэргүүцэв.

Аллах Таала тэдэнд ингэж хариулав:

قُلْ إِنَّمَا الْآيَاتُ عِندَ اللَّهِ وَإِنَّمَا أَنَا نَذِيرٌ مُّبِينٌ.
أَوَلَمْ يَكْفِهِمْ أَنَّا أَنزَلْنَا عَلَيْكَ الْكِتَابَ يُتْلَى عَلَيْهِمْ
إِنَّ فِي ذَلِكَ لَرَحْمَةً وَذِكْرَى لِقَوْمٍ يُؤْمِنُونَ

“…Тэдэнд: «Гайхамшиг нь Аллахын онгонд л байдаг. Би бол ил тод нэгэн сануулагч л мөн,» гэ! Тэдэнд уншдаг Номыг Чамд буулгасан маань тэдэнд (гайхамшиг буйгаар) **хүрэмжтэйгүй юү? Андашгүй нь түүнд итгэж үнэмшсэн нийгэмд рахмат ба сургаал байдаг.”** (эл-Анкэбут, 50-51)

Кур’аны ижаз нь уран үг нь, найруулга нь, агуулагын баялаг нь, агуулсан гол шинжүүд хүн төрөлхтөнд хандаж буй нь, нууцаас мэдээлэл өгсөн нь, байнга хүчинтэй буй нь, хуулийн талаарх давуу тал нь мэтийн олон шинжээрээ илэрсэн байдаг.

Кур’аны гайхамшиг буйн хамгийн чухал талыг уран хэллэг ба найруулга нь бүрддэг. Уран хэллэг нь агуулга, зорилго ба хандсан хүнтэй хамаатай, өөрөөр хэлбэл тухайн байдлын шаардсан хамгийн зохимжтой үгийг хэлэх мөн. Кур’ан-и Кэрим нь дурдсан сэдвүүдэд үүнийг хамгийн сайхан аргаар хэрэгжив.

Кур’ан-и Кэрим нь өгүүллэг талаараа ч сод бүтээл юм. Сонгосон үгсэд, бүтээсэн өгүүлбэрт ба эдгээрийн илэрхийлсэн утгад хамгийн жижиг дутагдал олох нь ч аргагүй юм.

Кур’анд утгын шигээ дикци буюу хэв маяг[169] ч Аугаа Эрхийн юм. Түүнийг хадис-и кудсий буюу Аллахын Пайгамбараараа дамжуулсан үгээс гол ялгаа нь энэ юм. Ийм л учраас Кур’аны тэкстээс нэгэн үгийг дахиад Араб өөр нэгэн үгтэй солих нь, зорилготой хийвэл хүнийг күфүрт автуулна; алдаатай хийвэл, утгыг тодорхой хэмжээнд өөрчилдэг тул, ихэнхдээ мөргөл залбирлыг хүчингүй болгоно. Ийнхүү андуурсан буруу хэллэг эсвэл үгийг солих нь шашны талаарх үр дүнгийн тухай эрдэмтэд фикхийн номууддаа “зэллэтү’л-карий” гарчиг доор маш олон шийдвэр илэрхийлсэн байдаг.

Ийм байхад, Кур’аны хэн нэгний ойлгох төвшинд гаргасан нэгэн орчуулгаар хийсэн мөргөл үйлчилгээний хүчинтэй байх

169. Дикци: Ярьдаг хэлдэг үгээ сонгох, хэлэх (аялга) ба бодлоо амархан илэрхийлэх юм. Фэсахат, бэлагат, талакат ба натика гэсэн үгсийн илэрхийлсэн утгын нийлц юм.

тухай худал нь итгэл үнэмшлийн талаар маш гунигтэй тааруу байдал юм.

Кур'аны найруулгад утга ба үгийн тэгш байдаг. Тэр нь ойлгуулах гэж байгаа утга бүрийг хамгийн сайхан ба хүчтэй аргаар илэрхийлэх үгийг, хамгийн оновчтой хэрэглэсэн гэсэн үг. Ингээд үг ба утгын хоорондын зохицлыг тэмдэг нэрийн тусгай найруулгаар бүтээнэ. Ингэж найруулахад хамгийн хүчтэй уран зохиолчийн авьяас ур чадал хүрэхэд хэцүү юм.

Энэ тухай Ибн-и Атийе -рахматуллахи алэйх- ингэж хэлэв:

"Кур'аны дотроос нь нэгэн үг аваад, түүний оронд оруулахаар хамаг Араб хэлийг уудалсан ч түүнээс зохимжтой өөр нэгэн үг олох арга үгүй юм."[170]

Кур'ан-и Кэрим нь кисса (цадиг), мэв'иза (сэдэв), жэдэл (маргалдаан), мүназара (ярилцлага), тарих (түүх), тэшрий (дүрэм), ахират, жэннэт (диваажин) ба жэхэннэм (там) мэтийн сэдвийг айлгах ба баясгах аетуудыг, утгын хүрээнд тус тус найруулгаар яруу сайхан илэрхийлжээ. Энэ бол түүний тэнгэрлэг яриа байнаас л үүссэн хэрэг.

Кур'ан-и Кэрим нэг доор, өөр өөр цаг ба орнуудад амьдарч буй, шинжлэх ухааны төвшин нь нэг нэгээсээ ялгаатай хамаг хүн төрөлхтөнд хандана. Гэтэл тэр Ялгаат төвшний олон хүн нэгэн цуглаанд Кур'аны аетуудыг уншихад, өөр өөрийнхөө ухаарах төвшингөөр ойлгож ухаарна. Энэ ч хүний чадлаас давамгай нэгэн шинж мөн.

170. Ибн-и Атийя, эл-Мухарраруʼл-Вэжиз, I, 52, Бейрут 1413; Зэрканий, *Мэнахилүʼл-Ирфан,* II, 325; Дяраз, *эн-Нэбэүʼл-Азим,* х. 112; Абдүлкадир Ата, *Азамэтүʼл-Курʼан,* х. 85.

Эцэст нь пайгамбар бүрийн гайхамшиг өөрийнх нь эринтэй хамаатай байдаг. Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм- бол хамаг хүн төрөлхтний пайгамбар болж илгээгдсэн тул Түүний хамгийн том гайхамшиг буй Кур'ан-и Кэрим нь хамаг цаг ба орныг багтааж киямат хүртэл үргэлжилнэ.

Кур'ан-и Кэримд Аугаа Эрхийн буй ба хүчийг батлах эшлэл болохоор олон удаа байгалийн ухааны үнэнийг ч дурдсан байдаг. Мянга дөрвөн зуун жилийн турш байгалийн ухааны талбайд илэрсэн дэвшил ба нээлтүүдийн Түүний ямар ч шийдвэрийг үгүйсгэж чадаагүй, эсрэгээр нь байнга баталсаар гайхамшгийг илрүүлж байдаг.

Өнөөдөр дэлхийн улсууд хамгийн гавьяат эрдэмтдээ цуглууж нэгэн нэвтэрхий толь хэрэгжиж бөгөөд үүнтэйгээрээ өөрсдийгөө магтана. Англичуудын Бриттаника, Францчуудын Ларус нь үүнд багтана. Гэтэл уг улсууд жил бүр хэвтэрхий толио засах ба нэмэх хэрэгтэйгээр шинэ бөгөөд нэмэлт нэгэн боть л гаргана. Үүнд өнгөрсөн хугацаанд хийсэн шинжилгээний дүнгээр илэрсэн шинэ мэдээллээс болж илэрсэн шинэ мэдлэгийн улмаас хуучны мэдлэгийг засч эсвэл тэнд нэмэлт хийдэг. Байгалийн ухааны нээлтийн ухаанд багтахааргүй төвшинд хүрсэн манай эринд ч, хамгийн шилмэл эрдэмтдээс бүрдсэн шинжлэх ухааны хамт олон хэрэгжүүлсэн эдгээр алдартай хэвтэрхий толиуд ч жилээс жилд засах хэрэгтэй болж байхад, Кур'аны дурдсан байгалийн ухааны тоолшгүй үнэн дээр хэдэн олон зууны турш ийм засвар хэрэгтэй огт болоогүй нь, түүний тэнгэрлэг эх буюу Аллахын яриа буйн хамгийн том баталгааны нэг юм.

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- Кур'аны гайхамшиг буй бөгөөд тус шинжийнх нь үүрд мөнх үргэлжлэхийг мэдээлсэн нэгэн хадис-и шарифдаа ингэж айлдана:

“Кур’ан-и Кэрим нь хэрэгжих бүх төрлийн замбараагүй байдлын эсрэг хүнийг эсэн мэндэд хүргэж, өмнөх нийгмүүдийн мэдээллийг, дараах нийгмүүдийг байдлыг, хүмүүсийн хооронд илрэх явдлуудыг шийдвэрийг агуулсан, үнэн худал хоёрыг ялгаж, хов үгүй, түүнийг орхисон догшныг Аугаа Эрхийн мөхөөсөн, түүний гаднаас аврал хайгчдыг Аллахын төөрүүлсэн, Эрх Таалагийн бат аргамж нь, шийдэгч үг нь ба зөв зам нь буй, түүнд холбогдогсод нь хэзээ ч төөрдөггүй, түүний өгүүлсэн хэлнүүд хэзээ ч андуураагүй, эрдэмтдийн ханаагүй, олон удаа давтсан учраас шинэ шинжээ алддаггүй, хүмүүсийг андууруулдаг гайхамшигт олон шинж нь огт дуусдаггүй, жин буюу буг чөтгөр түүнийг сонсохдоо:

إِنَّا سَمِعْنَا قُرْآناً عَجَباً

«…Үнэхээр бид, гайхалтай нэгэн Кур’ан сонсов» (эл-Жин, 1) *гэхээс аргагүй болсон, түүгээр яригчдын үнэнийг хэлсэн, түүнтэй шийдвэр гаргагчдын оновчтой болж эрх тэгш хандсан, түүнийг дагагчид буян авсан, түүнд уригчдын зөв замыг олсон тэнгэрлэг нэгэн үг яриа мөн.”* (Тирмизий, Фэдаилү’l-Кур’ан, 14; Даримий, Фэдаилү’l-Кур’ан, 1)

Кур’ан-и Кэрим бүх талаараа том нэгэн гайхамшиг юм. Үүнээс үзвэл Кур’ан-и Кэрим тэр өдрийн өгүүллэг ба уран ярианд оргилд хүрсэн Арабчуудаас ба киямат хүртэл ирэх хүн ба буг чөтгөрүүдээс өөртэй нь төсөөтэй нэгэн ном бүтээхийг нэгээд хэдэн олон зууны турш сүрдүүлж байдаг. Энэ тухай Кур’ан-и Кэримд нэгдүгээрт Тур Сурагийн 34-р ает-и кэримэд:

فَلْيَأْتُوا بِحَدِيثٍ مِّثْلِهِ إِن كَانُوا صَادِقِينَ

“Мүшрикчүүд Кур’аны Аллахын үг биш гэсэн саналдаа **итгэлтэй байвал, түүн шиг нэгэн бүтээл аваад ирцгээ!”** хэмээн айлддаг.

Аугаа Эрх нь Исра Сурагийн 88-р ает-и кэримэд ч ингэж айлдав:

فَاسْتَجَبْنَا لَهُ وَنَجَّيْنَاهُ مِنَ الْغَمِّ وَكَذٰلِكَ نُنْجِي الْمُؤْمِنِينَ

“Ингэж хэл: Хүмүүс ба чөтгөрүүд, бие биедээ тусалж энэ Кур’ан шиг, ядаж төсөөтийг хийхээр хамтарсан ч, хийж чадахгүй, гэдгээр тангараглая”

Мүшрикчүүд энэ тэнгэрлэг үгийн хариуд хүрэхгүй гэдгийг, Аугаа Эрх тэдний энэ тухай лав авъяасгүйг тод илрүүлэхийн тулд энэ ает-и кэримэг буулгаж өгөв:

أَمْ يَقُولُونَ افْتَرَاهُ قُلْ فَأْتُواْ بِعَشْرِ سُوَرٍ مِّثْلِهِ مُفْتَرَيَاتٍ وَادْعُواْ مَنِ
اسْتَطَعْتُم مِّن دُونِ اللّهِ إِن كُنتُمْ صَادِقِينَ

“Эсвэл түүнийг өөрөө зохиов гэл үү? Ингэж хэл: Тийм бол та ч түүнтэй төсөөтэй, зохиосон арван сура авчирцгаа! Хэрэв итгэж бай-вал, Аллахаас өөрийг дуудаж чадахаа харуул !” (Худ, 13)

Гуравдугаарт арай багасгаж зөвхөн нэгэн сурагийн төсөөтэйг авчрахыг нэхэв. (хар. Юүнүс, 38) ҮҮнийг дийлэхгүй байхлаар нь, дөрөвдүгээрт аль нэгэн сурагийн учигтай нэгэн хэсэг буюу талыг байсан ч авчрахын тушаав:

وَإِن كُنتُمْ فِي رَيْبٍ مِّمَّا نَزَّلْنَا عَلَى عَبْدِنَا فَأْتُواْ بِسُورَةٍ مِّن مِّثْلِهِ
وَادْعُواْ شُهَدَاءكُم مِّن دُونِ اللّهِ إِنْ كُنْتُمْ صَادِقِينَ

“Боолдоо буулгасан Кур’ан маань сэжигтэй байвал, та ч түүнтэй төсөөтэй нэгэн сура бүтээгээрэй; хэрэв Аллахаас өөр юманд итгэдэг бол, түүнийгээ дуудаад туслуулаарай.” (эл-Бакара, 23)[171]

Энэ аетууд мүшрикчүүдийн авъяасгүйг хязгаараас хязгаар хүртэл зөөж, хүчгүй буйг нь баталж, амыг нь таглав. Ийм тэнгэрлэг сүрдүүлэгт хариу өгч чадаагүй тул, үгүйсгэх, өдөөх, буруушаах мэтийн довтлогч үйлээ нь эхлэв:

إِنْ هَذَا إِلَّا سِحْرٌ يُؤْثَرُ

“…Энэ нь дамжуулсан нэгэн шившлэг л юм.” (эл-Мүддэссир, 24),

سِحْرٌ مُّسْتَمِرٌّ

“…Үргэлжилсээр нэгэн шившлэг л юм.” (эл-Камэр, 2),

إِنْ هَذَا إِلَّا إِفْكٌ افْتَرَاهُ

“…Энэ нь түүний өөрийнх зохиосон нэгэн худал л юм…” (эл-Фуркан, 4),

إِنْ هَذَا إِلاَّ أَسَاطِيرُ الأَوَّلِينَ

“…Энэ нь эртний үлгэр л юм,” (эл-Эн’ам, 25) мэтийн үнэнд талгүй, мөн түүнчлэн тэдний шийдвэргүй ба тогтворгүйг ч үзүүлсэн зарим утгагүй санал гаргадаг.

Кур’ан-и Кэримийн нэгэн сурагийн төсөөтийг илрүүлэх талаар хамаг өрсөлдөгчидөө ингэж сүрдүүлсэн нь манай эрин

171. Түүнчлэн хар. эл-Касас, 49-50.

хүртэл хамаг үгүйсгэгчдийн мөхөөснөөр дуусав. Кияамат хүртэл энэ бүхэн үргэлжлэх болно.

Христчүүд нь Арабчуудад Араб хэл сургах чинээ хэлний ухаантай лам боловсруулав. Гэтэл тэдний хэн нэгэн ч Кур'аны уг саналын хариуд ямар нэгэн үйлд оролдохоор зориг үзүүлж чадсангүй. Хэдэн олон зууны турш Исламын туяаг унтраахын төлөө амь болон эд бараагаараа хичээж хамаг төвгийг дийлсэн күфүр ба илхад хорвоо нь тийм олон зүтгэсний оронд -боломж байвал- үүнийг хийх нь хэрэггүй биш үү? Түүхийн уг үнэн ч Кур'аны гайхалтай талыг ба өстний хүч авъяасгүйг, үгүйсгэхийн аргагүйгээр илээр үзүүлдэг биш үү?

Энэ талаар өөрийгөө нэгэн өрөөнд хааж хэдэн олон сар ажилласан алдартай ба авьяастай зохиолчид ч тархиа гашилган хичээгээд нэг ч ает бичиж чадсангүй.

Жишээлбэл Кур'ан-и Кэримийн сурануудын тухай шог бичсэн Мүсэйлэмэтү'л-Кэззаб болон төсөөтэйг бичсэн нь инээд хөөрөөс цааш давалгүй, зөвхөн тэдний ухаан дутахыг илрүүлсэн байдаг. Учир нь Кур'ан зөвхөн уран гоё хэллэгийн гайхамшиг биш, мөн хамаг эринүүдийг, доторх үнэний хамт багтаасан гайхамшгийн ном юм. Ийм байхад, хэзээ ба хаана үхэхээ ч мэддэггүй, эгэл нэгэн хүний ижилгүй ба агуу олон үнэнийг агуулсан гайхамшигтай нэгэн ает зохиох нь мэдээж аргагүй байдаг юм. Жишээлбэл, хүний оролдлогоор бичсэн манай эриний Тэврат болон Инжил нарын байдал ил юм. Тус хоёр ном ч үндсэнээсээ холдсон, бараг зөрчлийн үлгэр болсон байдаг.

Кур'аны өнөөдөр хүртэл нөлөөгөө алдалгүй ирсэн өгүүлэхийн гайхамшигт нэгэн ном буйн хамгийн том ба үгүйсгэшгүй баталгаа нь туршлага ба гэрчилгээ мөн. Анх бууж эхэлсэн өдрөөс манай эрин хүртэл арван таван зууны турш

Кур'анд дутагдал олж хожигч хэн ч байгаагүй. Сорьж үзэгсэд хамаг хүн төрөлхтний өмнөөс гутамшигт унаж киямат хүртэл балрахгүй нэгэн муу нэрийг зүүжээ.[172]

❁

Кур'ан-и Кэрим нь дан яруу найраг ч биш. Шүлэг үргэлжилсэн үг хосолсон найруулгатай бөгөөд ийм найруулгыг удирдах гайхалтай нэгэн яруу байдал ба зүрхэнд шингэсэн аялгуутай байдаг. Кур'аныг уншсан хүн тэр өвөрмөц аялгууг зөвхөн хамгийн дотор сүнснийхээ хамгийн гүнзгий хэсэгт мэдэрнэ.

Кур'аны үг үсгийг өчүүхэн өөрчилбэл аяыг болон утгыг нь шууд эвдэнэ.

Кур'ан-и Кэрим энэ шинжээрээ хүмүүсийн сэтгэлд ер бусын хүчтэй нөлөө төрүүлж, Арабчууд түүнийг Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн жаргалтай дуугаар сонсч олноороо итгэсэн байв. Хамаг мүшрикчүүд нэгэн төсөөтийг илрүүлж чадаагүй болохоор уг чанартаа Кур'аны уран ба гоё хэллэгийг хүлээн зөвшөөрөв. Тэд Кур'аныг зөвхөн дэлхийн ашигтаа таараагүй ба өнчин шигээ түүнийг дагах нь тэдэнд хүнд санагдсан учраас л татгалзав.

Ибн-и Аббасаас дамжуулснаар, мүшрикчүүдийн суутнаас Вэлид бин Мугира нь нэгэн өдөр Пайгамбар Эзэн маань -алэйхиссалатү вэссэлам-ын дэргэд очоод өөрт нь Кур'ан уншихыг шаарджээ. Аллахын Элч түүнд:

إِنَّ اللهَ يَأْمُرُ بِالْعَدْلِ وَالإِحْسَانِ وَإِيتَاء ذِي الْقُرْبَى وَيَنْهَى عَنِ
الْفَحْشَاء وَالْمُنكَرِ وَالْبَغْيِ يَعِظُكُمْ لَعَلَّكُمْ تَذَكَّرُونَ

172. Бутий, *Мин Рэваии'л-Кур'ан,* х. 126, 129, 130.

“Гарцаагүй Аллах танд тэгш эрхийг, дайлахыг, садан хамаатандаа туслахыг; , муу муухайг ба харгислалыг бол хориглоно. Сонсоод дагах гэж танд сургаал хэлээд өгч байна,” (эн-Нахл, 90) аетыг уншив.

Вэлид:

“–Үүнийг дахиад унш!” гэв.

Пайгамбарыг маань аетыг дахин уншихлаар, Вэлид:

“–Валлахи, энэ үгэнд маш сайхан ая, гоо сайхан ба гялбаа байна, мөчир нь элбэг жимстэй, язгуур нь услаг, нов-ногоон модтой төсөөтэй. Үүнийг нэгэн хүний хэлсэн нь огт боломжгүй. Андашгүй нь эдгээр үгс бүхнийг давна. Түүнийг юу ч хожиж чадахгүй, эсэргүүцэгчдээ заавал ялна,” гэхээс аргагүй болов.

Гайхан хөшсөн Вэлид босч Хазрат-и Эбү Бэкирийн гэрт очоод Кур’ан-и Кэримийн тухай зарим юм асуув. Дараа нь Курайшчуудын дэргэд хүрээд:

“–Эбү Кэбшэгийн хүүгийн хэлсэн нь үнэхээр гайхмаар юм аа! Валлахи тэр нь шүлэг ч шившлэг ч тэр! Түүний хэлсэн нь яг Аллахын үг мөн,” гэв.

Түүний эдгээр үгс нь Эбү Жэхилд хүрэхлээр:

“–Валлахи Вэлид шашнаасаа боливол хамаг Курайш ч шашнаас буцна,” гээд шууд түүн дээр очиж:

“–Авга ах аа! Улс чинь чамд өгөхөөр бараа цуглуулж байна. Чи Мухаммед дээр очоод Түүнээс зарим зүйл гуйжээ,” гэв.

Вэлид:

“–Курайш намайг сайн таньдаг, тэдний хамгийн баян нь би байна,” гэв.

Эбү Жэхил:

“–Тэгвэл Мухаммедын тухай чамайг Түүнийг үгүйсгэсэн ба Түүнд дургүйг хамаг улсыг чинь мэдэхээр ярь,” гэв.

Вэлид:

“–Юу гэх вэ? Валлахи таны дунд шүлгийг, рэжэзийг[173] надаас сайн хэн ч мэддэггүй. Түүний хэлсэн нь эдгээрээс аль нэгэнтэй ч төсөөгүй. Валлахи, Мухаммедаас өмнөхөн нэг үг сонссон, хүний үгтэй ч чөтгөрийн үгтэй ч төсөөгүй. Агуу аятай санагдсан,” гэв.

Эбү Жэхил албадаад:

“–Улс чинь Түүний эсрэг юм хэлэхгүй байхад чамд огт дургүй байх болно,” гэв.

Тэр ч:

“–Намайг орхи, жаахан бодъё,” гэв.

Дараа ч:

“–Энэ дамжуулсан нь нэгэн шившлэг юм,” гэж хашхирав. (Хаким, II, 550/3872; Табэрий, *Тэфсир*, XXIX, 195-196; Вахидий, х. 468)

Түүний уг байдлыг Кур’ан-и Кэрим хамаг амьд өнгөөр нь ингэж тайлбарладаг:

---

173. **Рэжэз**: Арабын аруз гэдэг шүлгийн аргад нэгэн “бахир”ын нэр. Үүнд хурд ба удаан байдал цохилттой учирсан тул найрал хөгжим хөгжимдөх боломжтой бөгөөд; ийм учраас утгыг ухаанд төрүүлдэг; гуниг , баярыг илэрхийлэх боломжтой бахр-и рэжэзийн 15 орчим фүрүүтэй буйг илэрхийлдэг. (Тахирү’л-Мэвлэвий, *Уран Зохиолын Толь,* х. 120, “рэжэз” зүйл.)

إِنَّهُ فَكَّرَ وَقَدَّرَ. فَقُتِلَ كَيْفَ قَدَّرَ. ثُمَّ قُتِلَ كَيْفَ قَدَّرَ
ثُمَّ نَظَرَ. ثُمَّ عَبَسَ وَبَسَرَ. ثُمَّ أَدْبَرَ وَاسْتَكْبَرَ. فَقَالَ
إِنْ هَذَا إِلَّا سِحْرٌ يُؤْثَرُ. إِنْ هَذَا إِلَّا قَوْلُ الْبَشَرِ

Тэр бодоод хэмжив. Хараамаар нь ямар муухай хэмжив! Хараамаар нь ямар муухай хэмжив!.. Дараа нь нэг харж, царайгаа ярвайж, хөмсгөө зангидав. Дараа нь хойшоо эргэн их зан гаргаж: «Энэ Кур'ан **өөр юм биш, дамжуулан ирсэн нэгэн шившлэг мөн. Энэ нь хүний ярианаас өөр юм биш!» гэв."** (эл-Мүддэссир, 18-25)

Ард түмнийг Кур'аныг сонсохоос татгалзсан догшин мүшгирчүүдээс Эбү Сүфьян, Эбү Жэхил ба Ахнэс бин Шэрик нь шөнө Кабад Кур'ан уншиж байсан Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийг гурван шөнө нэг нэгээ мэдэлгүй, нууцаар, өөрийнх тааламжийн дураараа сонсч, тохиолдлоороо тааралдахдаа ч өөрсдийгөө буруушааж нэг нэгэндээ:

"–Хэн нэгэн биднийг битгий анзаараасай!.. Ард түмэн бидний ийм байдлыг мэдвэл, нэр алдраа хэт алдана. Үүнээс хойш хэнд ч Кур'аныг сонсохгүйн талаар үг оруулж чадахгүй!.." гээд гэмшиж дараа, дахиад ийм үйл хийхгүйнхээ төлөө ам өгөв. (Ибн-и Хишам, I, 337-338)

Олон хүн нь Кур'аны цөмд буй ийм нөлөөний ачаар мусульман болсон байв. Эд нарын нэг Хазрат-и Умар хадам ахынхаа үүдэнд хамаг хилэнтэйгээ очсон боловч Кур'аны уншлагыг сонсонгуутаа зүрх нь зөөлөрч бодол нь бүр өөрчилсөн нь ихээр мэдсэн нэгэн үнэн юм. Түүнчлэн, Хазрат-и Умар хатуу зангаараа алдаршсан нэгэн байв.

Кур'ан-и Кэримийн нөлөөнд автаж Исламаар алдар олсон өөр нэгэн ч Жүбэйр бин Мут'им -радъяллаху анх- юм. Тэр ч

Хүндэт Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- Эзнээс маань Тур Сураг сонсохлоороо зүрх нь цочиж мэдрэмжээ:

"–Бараг миний зүрх хагарна гэж бодсон," гээд илэрхийлэв. (Ахмад, IV, 83, 85)

Өөрөө тухайн өдрийг ингэж ярина:

"Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийг, үдшийн мөргөлд Тур Сураг уншиж байхад сонссон байлаа.

أَمْ خُلِقُوا مِنْ غَيْرِ شَيْءٍ أَمْ هُمُ الْخَالِقُونَ. أَمْ
خَلَقُوا السَّمَاوَاتِ وَالْأَرْضَ بَل لَّا يُوقِنُونَ.
أَمْ عِندَهُمْ خَزَائِنُ رَبِّكَ أَمْ هُمُ الْمُصَيْطِرُونَ

«Тэд нэгэн туурвигч байхгүйгээр туурвигдав уу, эсвэл өөрсдөө туурвив уу? Эсвэл тэнгэрүүд ба газрыг тэд өөрсдөө туурвив уу? Үгүй, тэд Аллахад үнэхээр итгэхгүй юм. Эсвэл Раббынх чинь баялагийн сан тэдний дэргэд байдаг уу? Эсвэл бүхнийг өөрсдөө эзэншсэн байдаг уу?» (эт-Тур, 35-37) аетад хүрэхлээр зүрх минь бишрэлтээрээ бараг нисэх юм шиг болов." (Бухарий, Тэфсир, 52)

Рисалэт-и Мухаммедийе буюу Мухаммедын номлол эхлэх үед, шүлгийн тэмцээнд түрүүлж бүтээл нь Кабагийн хананд өлгөсөн Имрү'л-Кайсын охин дүү нь амьд байв. Түүнд Кур'ан-и Кэримээс хэдэн аетыг уншив. Уран ба ойлгомжтой ярианы утгыг сайн мэдсэн энэ эмэгтэй Кур'аны аетуудыг сонсонгуутаа:

"–Энэ нь хүний үг байж болохгүй. Хэрэв дэлхий дээр ийм үг байвал, миний дүүгийн шүлэг Кабагийн хананд өлгөөтэй байх зохимжгүй. Тэрийг буулгаж байранд нь энэ үгийг өлгөх хэрэгтэй," гэхээс аргагүй болж дүүгийнхээ шүлгийг өөрийнх

гараараа Кабагийн хананаас буулгав. Төвшнөөрөө түүний доор байсан бусад өлгөөт шүлгийн тухай хэлэх юм үлдээгүй тул тэднийг ч нэг нэгээр буулгав.[174]

Эрүүл ухаантай хүн Кур’аныг зөвхөн сонсоод л түүнийг Аллахын үг буйг ойлгоход хүрэмжтэй юм. Ийм учраас Эзэн маань -алэйхиссалатү вэссэлам- Кур’ан-и Кэримийг хүмүүст сонсгохоор томилогдсон байв.

Жишээлбэл ает-и кэримэ ингэж айлдана:

وَإِنْ أَحَدٌ مِّنَ الْمُشْرِكِينَ اسْتَجَارَكَ فَأَجِرْهُ
حَتَّى يَسْمَعَ كَلاَمَ اللّهِ ثُمَّ أَبْلِغْهُ مَأْمَنَهُ

“Хэрэв мүшрикчүүдээс хэн нэгэн Чамаас тусламж гуйвал түүнийг хамгаал. Аллахын үгийг сонсож чадтал Дараа нь түүнийг аюулгүй байх газар хүргэж өг…” (эт-Тавба, 6)

Үүнээс үзвэл Аллахын яриа дууг хүний чихэнд хүргэх нь итгэл үнэмшлийн туяаг зүрхэнд байлгах учир болдог.

Кур’аны аяд сүнсийг татдаг хөгжим ч түүн дэх дууны эмх цэгцээс, өөрөөр хэлбэл үг, үсэг, чимээгүй ба авианы, урт ба богино үенүүдийн хамгийн зохимжтой дараалснаас л үүсдэг. Ердөө нэг авианаас нөгөөд нь ороход илэрсэн тусгай аяараа зүрхийг догдлуулна. Утгыг нь ойлгоогүйчүүд ч, дүрэм журмынхаа дагуу уншвал, түүний ижилгүй дуу хөгжмийн тааламжид автана.[175]

174. Хар. Ахмад Жэвдэт Паша, I, 83.
175. Ийм л учраас Кур’ан-и Кэримийг унших тусгай ухаан болгож байгуулсан байдаг. Кур’аныг тусгай арван аргаар уншдаг бөгөөд, эдгээрийг “Кираат-и Ашэрэ” гэдэг. Кираатын арга бүрийг, яг мэзхэбийн имам шиг “кираатын

Мүшрикчүүдийг Кур'аны Эсрэг Хандлага нь

Ислам нь мүшрикчүүдийн нэфсний амьдралыг цэглэж, эрх тэгш, хууль зүй, киямат, дахин амилж тооцоо өгөх, хийсэн муухай ба ёсгүй үйлсийн ялгүй үлдэхгүй мэтийг дурдаж байв. Кафирчууд үүнд маш их дургүйцэв. Түүнчлэн Ислам нь мүшрикчүүдийн бурхадыг хуурамч гэдгийг зарлаж байв. Дээр нэмэх нь Аллахын Элчийн авчирсан "Агуу Мэдээлэл"ээр Макка доргиж эхэлсэн байв. Нэбэ Сурагийн анхны аетууд нь энэ аймшигт үзэгдлийг ингэж байлбарлана:

عَمَّ يَتَسَاءلُونَ. عَنِ النَّبَإِ الْعَظِيمِ. الَّذِي هُمْ فِيهِ مُخْتَلِفُونَ

"Тэд бие биеэсээ юуг асуудаг вэ? Тухайн маргалдаж буй тэр том ба аймшигт мэдээллийг (үү?)" (эн-Нэбэ, 1-3)

Хүн үнэнийг эрмэлзэж туурвигдсан учраас зүрхэндээ мэдэгдээгүйг зөвшөөрөхгүй. Байнга мэдэгдсэн рүү гүйнэ. Энэ талаараа мэдээгүй ба мэдэж чадаагүй зүйлс түүнийг зовоо-но. Дээр үеэс эхлээд -пайгамбарчуудаа боловсруулсан ч- хүн төрөлхтнийг үхэх гэдэг ихээр завгүйдүүлсэн байдаг. Хүний ухаанд хортой могой шиг тунсан ба заримдаа зовлонтой айхтар чагтаараа хөдөлдөг тус асуултыг зарим ойлголт ба үгсээр дуугүй байлгах, дарах эсвэл хороохыг хүссэн байдаг. Гэтэл хүн бүрийг амьдралын хэргээс ч илүү үхэл гэсэн үнэн -гажилтгүй- хүн бүрт онох андашгүй нэгэн үнэн байхаар, түүнийг мэдэх нь хүний хамгийн чухал чармайлт байх болно.

Хүний бодлоор ухаарах арга үгүй энэ ирээдүйн зангиаг зөвхөн вахийн хүч л тайлж мэднэ. Хамаг пайгамбарчуудын ялангуяа Хүндэт Расул -саллаллаху алэйхи вэ сэллэм- Эзний

имам" хэмээн мэддэг байгуулагчтай байдаг. Манай нутагт тараагдсан нь "Асимын Кираат" мөн.

маань өгсөн ирээдүйн тухай энэ мэдээлэл, хүмүүсийн талархлыг хүртэх хэрэгтэй байтал -даанч- хүний хүндээс холдсон зарим хүмүүсийн улмаас шог, дооромжлол, зовлонтой хариу авсан байв. Туурдигдсаныхаа учир ба зорилгын амьдарч байсан мүшрик ба мүнкирчүүд нь Хүндэт Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн вахийгаар мэдээлсэн ахиратын үнэнд сандраад л хариулсан, нэфснийхээ амьдралтай зөрчсөн мөнхийн уг авралын урилгад хэт зөрүүд зан ба царай улаймаар сөрөг байдлаар хойноо эргүүлсэн байв.

Кур'ан-и Кэрим нь ахиратыг **"нэбэ-и азим: том мэдээ"** гэж дурдав. Үүний ил ба нууц учир нь нэлээд нээлттэй юм. Учир нь хүмүүс -ямар ч аж ахуйтай болсон ч- үхэлийн өмнө дундын гашуудал мэдэрнэ. Амьдралын хамаг замын эргэж тойрч үхэлийн хязгаарт алга болох нь, ялангуяа итгэл үнэмшилгүй сэтгэлийг гүнзгий хатгана. Амьдын төлөө үхэхээс чухал өөр юм байдаггүй тул үүний тухай мэдээллийг ухаарахыг шаардана. Жишээлбэл үүнийг ёсоор нь ухаарч чадагсад нь түр зуурын шимийг орхиж, үнэн ба мөнхийн ирээдүй рүү хандсан байдаг. Үхлээс сургаал авахгүйгээр өнгөрөөсөн амьдрал нь харанхуй бэрхшээлийн хорвоогоос ялгаагүй юм. Жаргалын од нь сайхан өнгөрөөсөн амьдралын төгсгөлд хүрээд ирсэн үхэлтэй мандана. Ийм л учраас Ислам шашин нь үхлийг байнга санаж түүнд бэлэн байхыг зөвлөсөн байдаг.

Кур'аны ахират ба үхэл мэтийн, тэдний дурын эсрэг зарлал үймүүлсэн асан кафирчууд нь Пайгамбар Эзнээс маань түүнийг тэдний дурын дагуу өөрчлүүлэхийг нэхэв. Аллахын Элчид хүрээд:

"–Бидэнд, дотроо Лат ба Уззад залбирахаа болихыг тушаасангүй нэгэн Кур'ан авчир. Хэрэв Аллах Чамд ийм Кур'ан буулгахгүй юм бол Чи ийм нэгэн Кур'ан хэл эсвэл Аллахаасаа

Чамд ирснийг ингэж соль; зовлонгийн оронд энэрлийн ает тавь, харамын оронд халалыг, халалын оронд харамыг тавь!" гэцгээв.

Ийм хүмүүсийн тухай энэ ает-и кэримэ нь буув:

وَإِذَا تُتْلَى عَلَيْهِمْ آيَاتُنَا بَيِّنَاتٍ قَالَ الَّذِينَ لاَ يَرْجُونَ
لِقَاءنَا ائْتِ بِقُرْآنٍ غَيْرِ هَذَا أَوْ بَدِّلْهُ قُلْ مَا يَكُونُ لِي
أَنْ أُبَدِّلَهُ مِن تِلْقَاء نَفْسِي إِنْ أَتَّبِعُ إِلاَّ مَا يُوحَى إِلَيَّ إِنِّي
أَخَافُ إِنْ عَصَيْتُ رَبِّي عَذَابَ يَوْمٍ عَظِيمٍ

"Аетууд маань тэдэнд ил нээлттэй уншихад, (үхсэний дараа) **Бидэнтэй уулзахыг найдахгүйчүүд: «ҮҮнээс гадна нэгэн Кур'ан авчир эсвэл үүнийг өөрчлөл,» гэцгээв. Ингэж хэл: «Түүнийг би өөрөө өөрчлүүлж чадахгүй, би надад вахий босныг л дагна. Би Рабдаа эсэргүүцвэл, тэр өдрийн зовлонтой учрахаас айна.»"** (Юүнүс, 15) (Вахидий, х. 270; Алусий, XI, 85)

Мүшрикчүүд яахаа андуурсан байв. Тэдний мусульманчуудад зохистой гэж үзсэн харгислал, тамлал, дарамт ба зовлон өдөр тутам ихэсч, амьдрал Маккад дийлшгүй болоод байв. Тэгэхээр бусад мусульманчууд шиг Хазрат-и Эбү Бэкир ч нүүхээр Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- Эзнээс маань зөвшөөрөл эрсэн, зөвшөөрөл олохоор Абиссини руу замд гарсан байв.

Нэг-хоёр хоногийн дараа Каарэ аймгийн тэргүүн Ибн-и Дэгинэтэй тааралдав.

Ибн-и Дэгинэ:

“–Еэ Эбү Бэкир! Чам шиг хүнийг нутгаасаа гаргах боломжгүй. Валлахи, улс аймгийнхаа эрдэнэ мөн! Сайныг хийж, садан хамаатнаа хадгалж хамгаална. Ажлаа дийлж чаддаггүйчүүдийн ачааг тээвэрлэнэ! Харь, чи миний хамгаалалт доор юм,” гэв.

Хазрат-и Эбү Бэкир ч Ибн-и Дэгинэгийн хамт Маккад буцав. Маккад орохдоо, Ибн-и Дэгинэ хамгаалалтаа хамаг Курайшчуудад зарлав.

Үүний хариунд Курайшчууд Ибн-и Дэгинэд зарим нөхцөл тавив:

“–Эбү бэкирт хэл, Рабдаа залбирлаа гэрийнхээ дотор хийг! Тэнд дураараа мөргөл үйлдэг, Кур’ан уншиг, гэтэл гэрээсээ өөр газар нээлтттэй мөргөл үйлдэж Кур’ан уншаад биднийг бүү үймүүлэг! Учир нь бид бидний эмэгтэй ба хүүхдүүдийг хуурахаас нь санаа зовдог,” гэцгээв.

Ибн-и Дэгинэ мүшрикчүүдийн эдгээр шаардлагыг Хазрат-и Эбү Бэкирт дамжуулан хэлэв. Тэр ч зөвшөөрөв. Гэрийнхээ дэргэд мөргөлийн газар хийв. Тэнд мөргөл үйлдэж Кур’ан уншиж эхлэв. Уяхан сэтгэлтэй хүн байсан болохоороо Кур’ан-и Кэримийг уншихдаа гуньж, нулимсаа барьж чаддаггүй байв. Түүнийг Кур’ан-и Кэрим уншихад мүшрикчүүдийн хүүхдүүд ба эмэгтэйчүүд тойрч, дуртай сонсч эхэлцгээв. Энэ байдал нь Курайш мүшрикчүүдийн айлгав. Тэгэхээр нь Ибн-и Пэгинэд лавлаж, түүнээс Хазрат-и Эбү Бэкирт саад болохыг эсвэл түүн дээрх хамгаалалтаа өргөхийг нэхэцгээв.

Тэр ч:

“–Эбү Бэкир ээ! Эсвэл гэртээ суугаад дуу битгий гарга, эсвэл миний хамгаалалтаас гарснаа зарла,” гэв.

Тэгэхлээр нь Эбү Бэкир Сиддийк -радъяллаху анх- нь Аллахад итгэж бууж өгөхийн ийм хариуг өгөв:

“–Хамгаалалтыг чинь чамд буцааж байна. Надад Аллахын хамгаалалт нь хүрэмжтэй юм.” (Бухарий, Мэнакибу’л-Энсар, 45; Ибн-и Хишам, I, 395-396)

❁

араб нийгэм нь уран зохиолд хэтэрхий сонирхолтой байсан тул, уран сайхан үгэнд их дуртай бөгөөд ер бусын анхаарал хандуулдаг байв. Заримдаа хоёр мөр ч заримыг тэнгэрт өлгөхөд, заримыг ч хөрстөд булахад хангалттай болж байв. Мүшрикчүүд заримдаа тэднийг ч нөлөөлсөн Кур’аны хэв маягийн хэтэрхий нөлөөтэй буйг анхааран өөрсдийнхөө бодлоор зарим арга хэмжээ авдаг байв. Кур’аныг унших ба сонсохыг хориглосон мүшрикчүүд, тохиолдлоор нь Кур’ан уншихад бол хүмүүсийн тэр тэнгэрлэг үгийг сонсч сэтгэл хөдлөхөд нь саад болохоор шуугиан гаргадаг байв. Аунаа Эрх нь үүнийг ает-и кэримэд ингэж мэдээлнэ:

وَقَالَ الَّذِينَ كَفَرُوا لَا تَسْمَعُوا لِهَذَا الْقُرْآنِ
وَالْغَوْا فِيهِ لَعَلَّكُمْ تَغْلِبُونَ

“Үгүйсгэгчид нь: «Энэ Кур’аныг битгий сонсоцгоо; уншихад нь шуугиан гаргацгаа; та давуу гарч магадгүй!» гэцгээв.” (Фүссилэт, 26)

Орчлонгуудын Эзэн -алэйхиссалатү вэссэлам- нь аймгийнхаа Түүнд зохимжтой гэж үзсэн бүх төрлийн харгислал ба тамлалд тэсч, тэгсэн ч тэдэнд Исламыг мэдээлэхээс, тэднийг мөнхийн авралд урихаас ухардаггүй байв. Мүшрикчүүд бол Арабчуудаас хаж, үмрэ эсвэл өөр зорилгоор Маккад ирэгсдэд хотын гадаа угтаж, Пайгамбар Эзэнд маань үл дөхөх ба Түүний

хэлснийг үл сонсох тухай сануулж, түүнчлэн сүрдүүлдэг байв. Аллахын Элчийн тухай галзуу, шившлэгтэн, мэргэ харагч мэтийн тэмдэг нэр олгож, өөрсдийнхөө ч итгээгүй ийм худлаар Маккад ирэгсдийг Түүнээс холдуулахыг хичээдэг байв.

Түфэйл бмн Амр[176] Маккад ирэхэд Курайшийн томчуудаас зарим нь дөхөж:

“–Түфэйл ээ! Чи шүлэгч хүн ба аймгийнхаа дунд нэр хүндтэй нэгэн хүн мөн. Манай нутагт ирсэн, гэвч, бидний дундаас гарсан энэ хүнээс болгоомжил! Түүний байдал бидэнд төвөг болов. Манай нийгэм ба үйлсийг тааруу болгов. Үг нь шившлэг шиг нөлөөтэй бөгөөд хүний аавтайгаа, дүүтэйгээ, эхнэртэйгээ харилцааг эвдэнэ. Бидэнд тохиолдсон энэ байдлыг чи болон танай аймагт ч тохиолдохоос бид айна. Түүнтэй ерөөсөө битгий ярь, битгий сонс !” гээд тайтгаруулав.

Эдгээр үгсийн нөлөөнд автсан Түфэйл нь Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ээс юу ч сонсохгүй ба Түүнтэй огт ярихгүйгээр шиидэв. Түүнчлэн Мэсжид-и Харамд хүрэхдээ Аллахын Элчийн хэлснийг сонсохгүйн тулд чихэндээ хөвөн чихэв. Дараа нь ийм байдлаа өөртөө зохимжгүй:

“–Чамд хайран юм аа! Би ухаантай шүлэгч хүн. Үгийн сайхыг ч муухайг ч сайн мэднэ. Тэгвэл тэр хүний хэлснийг сонсоход ямар харш болж мэдэх вэ? Сайхан байвал хүлээн зөвшөөрч, муухай байвал татгалзана,” гэж бодоод тэнд хүлээв. Расулаллах

176. **Түфэйл бин Амр эд-Дэвсий** -радъяллаху анх-; алдартай, ухаантай, шүлэгч ба зочломтгой хүн байв. Хаалга нь ирсэн хүн бүрт нээлттэй байв. Өлссөнийг цатгадаг, өөрт нь хорогдсон хүнийг хамгаалдаг ба тусламж гуйгсдад тусалдаг байв. Номлохын 10 дахь жилд мусульман болсны дараа Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийг Мадинад нүүтэл Дэвс аймгийг Исламд урьсан байв. Емамэ дайнд баатарлагаа үзүүлсний дараа тэнд шэхид болов.

-саллаллаху алэйхи вэ сэллэм-ийг салж гэртээ харихад нь тэр ч дагаж яваад:

“–Аяа Мухаммед аа! Чиний аймаг надад Чиний тухай тийм тийм үг хэлэв. Намайг маш их айлгасны тулд, чиний үгсийг сонсохгүй гэж чихэндээ хөвөн ч чихлээ. Дараа нь Аллахын тусламжтайгаар чиний үгийг сонсч чадлаа. Чи энэ үүргээ надад нэг яриад өгнө үү?” гэв.

Түфэйл үргэлжлүүэн ингэж хэлэв:

“–Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- надад Исламыг ярьж, Кур’ан уншиж өгөв. Валлахи би хэзээ ч Кур’анаас гоё үг, Исламаас гоё шашин дуулаагүй байв! Шууд мусульман болж Аллахаас өөр бурхан үгүйд гэрчилгээ хийв.”

Түфэйл -радъяллаху анх- нь Пайгамбар Эзний маань дэргэд хэд хоносны дараа зөвшөөрөл авч тэблиг зорилттойгоороо аймагтаа харив. Хүмүүст баталгаа болгож эдлэх нэгэн тэмдэгтэй болох тулдаа Хүндэт Расул Эзнээс маань Аллахад залбирахыг гуйв. Аллахын Элчийн залбирлынх элбэгээр эхлээд хоёр нүдний хооронд нь зул шиг нэгэн туяа гарч илрэв. Дараа ч өөрийнх нэхэмжээр тус туяа нь царайнаас нь салж, санааны үзүүрт нь оров. Ингэж аймгийнхаа дэргэд харьж шэхид болтлоо тэблиг ба жихадаар оролцов.[177]

Түфэйл -радъяллаху анх-ын урилганд анх орсон нь, хамгаас олон хадис дамжуулсан алдартай сахаба Эбү Хүрэйрэ -радъяллаху анх- болов.[178]

177. Ибн-и Хишам, I, 407-408; Ибн-и Са’д, IV, 237-238.
178. Ибн-и Насеr, *эл-Исабэ,* II, 226.

Кур’ан-и Кэримийн эсрэг ийм сөрөг хандсан ч мүшрикчүүд үнэндээ ганц үлдэхдээ үнэнийг баталж, Кур’ан-и Кэримийн нууцаар сонсохоо байж чаддаггүй байв. Энэ удаа ч өөр нэгэн шалтгаан олж:

وَقَالُوا لَوْلَا نُزِّلَ هَذَا الْقُرْآنُ عَلَى رَجُلٍ مِّنَ الْقَرْيَتَيْنِ عَظِيمٍ

“«Энэ Кур’аныг энэ хотоос том газар өөр нэгэн хүнд буусан нь дээр байгаагүй юү?» гэцгээж байв.” (эз-Зүхрүф, 31)

Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн үнэн пайгамбар ба Кур’ан-и Кэримийг ч үнэн ном буйг нь угтаа хүлээн зөвшөөрсөн ч нэфис нь батлахад саад болж байв. Кур’аныг Аллахын ном болохыг хүлээн зөвшөөрч, харин -хаша-Аллахын шийдвэр буруу болсныг илэрхийлж байв. Тэднийхээр бол , Кур’ан баян биш, өнчин хэн нэгэнд биш; эсвэл Маккагийн баячуудаас Вэлид бин Мугирад эсвэл Таифын баячуудаас Амр бин Үмэйрт буусан байх ёстой байв.

Жишээлбэл Вэлид бин Мугира ингэж хэлсэн байв:

“–Курайшийн том ба эзэн буй би, эсвэл Сазифын ахмад Амр бин Түфэйл байж байхад, Кур’ан Мухаммедад буух юм уу?!.” (Ибн-и Хишам, I, 385)

Гэтэл Исламын шашны үнэ цэнэ нь баялаг эсвэл язгуу-раар биш; зөвхөн таквагаар болдог. Нөгөө талаас нь Хазрат-и Мухаммед Мустафа -саллаллаху алэйхи вэ сэллэм- Эзэн маань угсаагаараа тэдний хамгийн хүндтэй нь байв.

Расулаллах ба Кур’аны Эсрэг

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн эсрэг юу хийсэн ч чадалгүй болсон мүшрикчүүд энэ удаа Түүний үммий

байсныг мэдсэн ч Кур'аныг Христийн шашинтай нэгэн боолоос сурсан гэх ухаангүй нэгэн санааг гаргав. Ийм агуу нэгэн шашны суурийг тавьж чадах нэгэн боолын тухай яаж бодож олсныг мэдэхгүй.

Энэ зохимжгүй буруутгалын хариуг Кур'ан-и Кэрим ингэж өгөв:

وَلَقَدْ نَعْلَمُ اَنَّهُمْ يَقُولُونَ اِنَّمَا يُعَلِّمُهُ بَشَرٌ لِسَانُ الَّذِي
يُلْحِدُونَ اِلَيْهِ اَعْجَمِيٌّ وَهٰذَا لِسَانٌ عَرَبِيٌّ مُبِينٌ

"Мэдээж тэд: «Кур'аныг Түүнд нэгэн хүн л сургана!» гэснийг бид мэддэг. Тэдний бодлоор санал болгосон хүн гадаадын хэлтэй. Харин энэ (Кур'ан) **бол цэвэр Араб хэлтэй юм."** (эн-Нахл, 103)

وَمَا كُنْتَ تَتْلُوا مِنْ قَبْلِهِ مِنْ كِتَابٍ وَلَا
تَخُطُّهُ بِيَمِينِكَ اِذًا لَارْتَابَ الْمُبْطِلُونَ

"Аяа Расул аа! Тэдний мэддэгээр **Чи энэ Кур'аныг ирэхээс өмнө нэгэн ном уншаагүй; бичиг бичээгүй! Хэрэв уншиж-бичдэг байсансан бол,** тэд **худлыг дагагсад нь сэжиглэх байв** (Чамайг бусдаас сурсан гэж чадах байв)**."** (эл-Анкэбут, 48)

Түүнчлэн Аллах Таала нь мүшрикчүүдийн буруутгалд санаа зовохгүй гэж Расулдаа ингэж айлдаж байв:

فَذَكِّرْ فَمَآ اَنْتَ بِنِعْمَتِ رَبِّكَ بِكَاهِنٍ وَلَا مَجْنُونٍ
اَمْ يَقُولُونَ شَاعِرٌ نَتَرَبَّصُ بِهِ رَيْبَ الْمَنُونِ
قُلْ تَرَبَّصُوا فَاِنِّي مَعَكُمْ مِنَ الْمُتَرَبِّصِينَ

“ Расул минь ээ! **Чи зөвийг ярь! Раббынхаа соёорхсоноор Чи мэргэч, төлөгч, үзмэрч биш, галзуу ч биш! Эсвэл тэд: «Тэр нэгэн шүлэгч; манай эриний хохиролд автахыг найдан хүлээж байцгаана!» гээд байна уу? Ингэж хэл: Хүлээцгээ, би ч таны хамт хүлээж байна.”** (эт-Тур, 29-31)

وَاِذَا تُتْلٰى عَلَيْهِمْ اٰيَاتُنَا بَيِّنَاتٍ قَالَ الَّذٖينَ كَفَرُوا لِلْحَقِّ لَمَّا جَٓاءَهُمْ هٰذَا سِحْرٌ مُبٖينٌ اَمْ يَقُولُونَ افْتَرٰيهُ قُلْ اِنِ افْتَرَيْتُهُ فَلَا تَمْلِكُونَ لٖي مِنَ اللّٰهِ شَيْـًٔا هُوَ اَعْلَمُ بِمَا تُفٖيضُونَ فٖيهِ كَفٰى بِهٖ شَهٖيدًا بَيْنٖي وَبَيْنَكُمْ وَهُوَ الْغَفُورُ الرَّحٖيمُ

“...Үгүйсгэгчид өөрсдөд хүрсэн үнэний тухай: «Энэ нь ил далангүй нэгэн шившлэг мөн!» гэцгээв. Эсвэл түүнийг зохиосон гэж байцгаана уу? Ингэж хэл: Хэрэв би түүнийг зохиосон бол, та намайг Аллахаас аврах юу ч хийж чадахгүй. Тэрээр таны Кур’аны тухай андуурлыг маш сайн мэддэг. Та бид хоёрын хооронд гэрч болно! Тэрээр маш өршөөлтэй, маш энэрэлтэй юм.” (эл-Ахкаф, 7-8)

Мүшрикчүүд зөв замд орох хүсэлтэй байгаагүй тул, Аллахын Элч болон Кур’аны эсрэг буруутгахаас татгалздаггүй байцгаав. Гэтэл үнэнийг ч мэддэг байв. Жишээлбэл Курайшийн алдартнууд нь Исламын Маккаг цалгиж тарахаас нь санаа зовч Вэлид бин Мугирагийн дэргэд цугласан байв. Хоорондоо:

“–Маккад ирсэн аймгуудад Мухаммедын тухай юу хэлэх вэ?” гэцгээв.

Вэлид нь Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм-тэй уулзсан, шууд Түүнээс Кур’ан-и Кэрим сонссон байв. Ингэж хэлэв:

“–Би шүлгийн хамаг төрлийг мэднэ. Миний Түүнээс сонссон нь шүлэг биш юм. Шүлгээс давуу талтай үг байв. Тэр үгс нь хүүрнэл ч байгаагүй. Учир нь, тийм уран ба сайхан хэллэгээр дүүрэн аятай хөгжмийг би өмнө нь хэзээ ч сонссон биш. Мэргэ харагчийн үгтэй ч огт төсөөгүй байв. Галзуугийн үгс ч биш. Би ТүүнэЭС галзуутай холбоотой ямар нэгэн шинж тэмдэг огт хараагүй. Бид Түүнийг шившлэгч ч гэж чадахгүй. Учир нь уншаад үлээхгүй, зангиа уяхгүй, тэгэхлээр нь шившигчидтэй төсөөтэй биш!”

Эдгээр үгсийн дараа Вэлид н мүшрикчүүдийн буруу зорилтод заавал нэгэн гарц арга олохоор өөрийгөө албадаад ийм тайлбар хийв:

“– Тэр ахан дүүсийг салгаж байна. Садан хамаатны хооронд салалцах үр тарьж байна. Ийм учраас шившлэгээс өөр юм байж болохгүй!” (Ибнү’л-Жэвзий, VIII, 403-404; Хаким, II, 550; Вахидий, х. 468)

❁

Кур’ан-и Кэримийн талаар буруутгалаар амжилт олоогүй мүшрикчүүд энэ удаа Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн ариун биеийг зорилго болгов.

Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн хөвүүн Касимын хоёр ойтой байхдаа өөд болсныг ашиглан, Ас бин Ваилын амаар Түүнд “эбтэр мөн” гэцгээв. Өөрөөр хэлбэл үр угсаагүй, удам нь дууссан, барсан мэтээр ярьцгаав. Ингэхдээ Аллахын Элчийг хүмүүсийн нүдэн дээр доромжилж, Түүний сэтгэл дэх нөлөөг үгүй болгохыг хүсч байцгаав.

Гэтэл энэ ч амжилттай болж чадаагүй. Кэвсэр Сура нь тэдний муухай санааг нам цохив:

اِنَّٓا اَعْطَيْنَاكَ الْكَوْثَرَ فَصَلِّ لِرَبِّكَ وَانْحَرْ اِنَّ شَانِئَكَ هُوَ الْاَبْتَرُ

Элч минь битгий санаа зов. Бид чамд Кэвсэрийг өгөв! Тэгвэл Раббынхаа төлөө мөргөл үйлдэж тахил барь! Санаа битгий зов! **жинхэнэ эбтэр, үр удамгүй үлдсэн нь чамд өшиж байгаа тэд мөн!”** (эл-Кэвсэр, 1-3)

Уг сурагийн ойлгуулснаар, ямар ч цаг ба оронд байсан ч Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-ээг хаясан зөвшөөрөөгүй бөгөөд өшсөн хүмүүсийн шинж тэмдэг нь “эбтэр” болох юм. Орчлонгуудын Эзнийг бадавий гэхийг хичээсэн соёлгүйчүүд, Орчлонгийн Мөнхийн Хүндэт хүнд өөрийнхөө дутагдлыг ачих зориг гаргасан мангарууд, авчирсан жинхэнэ шашинд тэнцэхгүй аз жаргалгүйчүүд, эд-бараа ба сүнсний талаараа ч хувь заяагүй, удамгүй, эбтэр хүмүүс мөн.

Шүлэгч нь маш гоё хэлнэ:

......
Гоё царайгаар чинь хоёр хорвоо ч гийгүүлсэн;
......
Чиний хүүг энэ талд хэн ч хайрлахгүй бол,
Тэдгээр хараалтууд кияматад чөтгөрөөс ч эбтэр юм!..

❁

Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-д тэсч чадахгүйчүүд нь яг өмнөх пайгамбарчуудыг үгүйсгсэд шиг ихэнхдээ ихэмсэг зантай удирдагчид болон задарсан баячууд байв.

Аллах Таала айлдана:

وَمَآ اَرْسَلْنَا فٖي قَرْيَةٍ مِنْ نَذٖيرٍ اِلَّا قَالَ مُتْرَفُوهَآ اِنَّا بِمَآ اُرْسِلْتُمْ بِهٖ كَافِرُونَ وَقَالُوا نَحْنُ اَكْثَرُ اَمْوَالًا وَاَوْلَادًا وَمَا نَحْنُ بِمُعَذَّبٖينَ

“Бид аль ч нутагт нэгэн сануулагч илгээсэн ч, тэндэхийн баян ба ихэмсэг хүмүүс заавал: «Бидний тэблиг хийсэн зүйлсийг үгүйсгэнэ, » гэцгээв. Мөн: «Бид бараагаараа ч хүүхдүүдээрээ ч арвин байна; ямар нэгэн осолтой ч тааралдахгүй!» гэцгээв.” (Сэбэ’, 34-35)

وَلَا تُطِعْ كُلَّ حَلَّافٍ مَهِينٍ هَمَّازٍ مَشَّآءٍ بِنَم۪يمٍ مَنَّاعٍ لِلْخَيْرِ مُعْتَدٍ اَث۪يمٍ عُتُلٍّ بَعْدَ ذٰلِكَ زَن۪يمٍ اَنْ كَانَ ذَا مَالٍ وَبَن۪ينَ اِذَا تُتْلٰى عَلَيْهِ اٰيَاتُنَا قَالَ اَسَاط۪يرُ الْاَوَّل۪ينَ

“ Расул минь! **байнга хүмүүсийн дутагдлын хайгч, зогсолгүй хүний яриаг зөөгч, сайнд бүр садаа бологч, довтлогч, нүгэлд автсан, бүдүүлэг ширүүн, муугаар алдаршсан хүмүүсээс хэнд ч баян ба хүүхэдтэй гэж битгий бөхий!** (Тэдний аль нэгэн ч) **түүнд манай аетуудыг уншихад: «Эртний үлгэр!» гэнэ.”** (эл-Калэм, 10-15)

Жишээлбэл, тухайн Тэббэт Сура буусан Эбү Лэхэб:

“–Намайг бусадтай ижил үздэг шашин үгүй болог!..” гэж байв.

Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм- болон Ислам шашны хамгийн догшин өстнүүдийг тэргүүлсэн Эбү Жэхил ч ингэж хэлж байв:

“–Мухаммедийн хэлсний зөв буйг бид мэднэ! Харин одоо хүртэл тэдний аймаг юу хийсэн ч бид ч хийсэн, тэднээс дутаагүй байв. Одоо бол тэд: «Манай дунд нэгэн пайгамбар бий!» гэж бахархана. Бид дундаасаа Түүн шиг пайгамбар яаж гаргах вэ? Энэ нь боломжгүй юм! Тийм учраас би, Мухаммедийн номлолыг огт хүлээн зөвшөөрч чадахгүй!..” (Ибн-и Кэсир, *эл-Бидая,* III, 113)

Ингэж хэлсэн Эбү Жэхил хилэн, атаархал ба өшөөнөөсөө болж нэгэн удаа ч ингэж хэлэв:

"–Хэрэв Түүнийг мөргөл үйлдэхэд харвал, толгой дээр нь гишгэнэ!"

Дараа нь Харам-и Шарифад Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийг мөргөл үйлдэж байхад тааралдав. Хэлснээ хийхээр даруй хөдөлсөн ч, гэнэтхэн царай нь шарлаж, ихэд айдаст автаад, гартаа авсан чулуугаа ч барьж чадахгүй болов. Эргээд зугтаж эхлэв. Эргэн тойрныхон сонирхож Эбү Жэхилээс юу болсныг асууцгаав. Эбү Жэхил бол сандран айснаар:

"–Намайг Түүнд дөхөхөд миний өмнөөс гэнэтхэн догшин тэмээ гарч илрэв. Үгүй! Валлахи тэрэн шиг айхтар тэмээг одоо хүртэл ерөөсөө хараагүй! Бараг намайг залгих гэж байлаа!" гэв. (Ибн-и Хишам, I, 318; Ибн-и Кэсир, *эл-Бидая,* III, 92-93)

Учир нь Аллах Таала, боол ба Расул Хазрат-и Мухаммед Мустафа -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийг ба Түүгээр дамжуулан илгээсэн шашнаа хамгаалж, Тэднийг байнга давуу байдалд байлгаж байв.

Ийм байхад мүшрикчүүд хэвээрээ Аллахын Элчийг хүлээн зөвшөөрөхгүй, Кур'аны үнэнээс хол зөрөөтэй зогсч байв. Бараг тэнгэрлэг үнэнээс зугтаж байв.

Аллах Таала айлдана:

فَمَا لَهُمْ عَنِ التَّذْكِرَةِ مُعْرِضِينَ
كَاَنَّهُمْ حُمُرٌ مُسْتَنْفِرَةٌ فَرَّتْ مِنْ قَسْوَرَةٍ

"Үнэн ийм байхад тэд юу болоод, арслангаас айж зугтсан хулан шиг царайгаа сургаалаас цааш эргүүлнэ вэ?!" (эл-Мүддэссир, 49-51)

Шүлэгч нь кафирчууд үнэнийг мэдсэн ч итгэл үнэмшилд дөхөөгүй бөгөөд авралт нь хувь заяатай хамаатайг маш сайхан илэрхийлэв:

Чи авралт олгохгүй бол, шийдвэр яах билээ, аяа Раб!
Араб хэл мэдсэн ч Эбү Жэхилд ает яах билээ, аяа Раб!

Гэтэл кафирчуудын зөрж нүүр буруулсан нь, цаг болж тэнгэрлэг шалгалттай хамаатай Аллахын Элч болон итгэгчдэд тэвчишгүй харгислал ба тамлал болоод илэрч байв.

Тамлалын Эрин

Эбү Талибд хүргэсэн саналаас нэгэн үр дүн олж чадаагүй бөгөөд Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-ээс ч ямар нэгэн буулт олж чадаагүй мүшрикчүүд, бослого хөдөлгөөнөөр дарамтлах арга хайв. Анхны ээлжээр өнөр аймаг ба гэр бүлтэй хүмүүст гар хүргэж чадаагүй. Тэр үеэр мусульманчуудад хийсэн ийм харгислал арай түгээмэл болоогүй байв.

Тэр хооронд мүшрикчүүдийн харгислалд орогсод нь ихэнхдээ хэн хүнгүй ядуучууд болон боолчууд байв. Бараг тэдэнд хийгээгүй зовлон үлдээгүй байв...

Хазрат-и Хаббаб -радъяллаху анх-ыг[179] улаан гал дээр хэвтүүлж, галыг биеэс нь хайлсан өөхөөр унтартал цээжинд нь дараад хүлээлгэв.

179. **Хаббаб бин Эрэт** -радъяллаху анх- нь зургаа дахь мусульман юм. Мүшрикчүүдийн хүнд тамлал амссан мусульманчуудаас нэгэн юм. Тамлалын ул мөрийг бие сэтгэлдээ тээсээр байсан юм. Өөрөө Мадинад нүүсний дараа Бэдирээс эхлээд хамаг дайнд оролцов. Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ээс 32 хадис-и шариф дамжуулав. Дал гаруй настай байхдаа хижрэтийн тооллын 37 / билгийн тооллын 657 онд Кжфад нас барав.

Хаббаб -радъяллаху анх- нь төмрийн дархан бөгөөд зарим мүшрикчүүдээс ч авлагатай байв. Авлагаа нэхсэнд нь түүнд:

“–Эхлээд Мухаммедыг үгүйсгэ, дараа нь чиний авлагыг өгнө!” гэдэг байв.

Тэр ч дэлхийн түр зуурын ашгийг хаян:

“–Би Түүнийг ерөөсөө үгүйсгэхгүй! Би Түүнтэй хамт!..” гэж, мөнхийн жаргалыг сонгож байв.

Туршигдсан эдгээр харгислалаас нэгийг өөрөө ингэж ярина:

“Нэгэн өдөр авлагаа нэхэхээр Ас бин Ваил дээр очсон байв:

«–Мухаммедыг үгүйсгэхгүй байхад мөнгийг чинь өгөхгүй,» гэв.

Би ч:

«–Чамайг үхтэл, түүнчлэн дахиж сэртэл Мухаммедыг ерөөсөө үгүйсгэхгүй,» гэв.

«–Тэгвэл би одоо үхээд, дараа нь дахиад амьд орно, тийм байна уу?» гэв.

Би:

«–Тийм» гэсэн хариу өглөө.

Ас бин Ваил:

«–Тийм байвал дахиж сэрэхдээ бараа олон байг, тэгээд л би ч чамд өрөө төлнө,» гэв.

Тэгэхлээр нь эдгээр аетууд буув:

أَفَرَأَيْتَ الَّذِي كَفَرَ بِآيَاتِنَا وَقَالَ لَأُوتَيَنَّ مَالاً وَوَلَداً. أَاطَّلَعَ الْغَيْبَ أَمِ اتَّخَذَ عِندَ الرَّحْمَنِ عَهْداً. كَلَّا سَنَكْتُبُ مَا يَقُولُ وَنَمُدُّ لَهُ مِنَ الْعَذَابِ مَدّاً. وَنَرِثُهُ مَا يَقُولُ وَيَأْتِينَا فَرْداً

«Манай аетуудыг үгүйсгэж “Надад мэдээж эд баялаг бараа болон хүү өгнө,” гэснийг харав уу? Тэр (кафир) **нууцыг мэдээ юү? Эсвэл Рахман** (буй Аллахын) **онгоноос нэгэн ам авав уу? Үгүй, огт тийм биш! Бид түүний хэлснийг бичээд тамлалыг нь нэмсээр байх болно! Бид түүний тухайн ярьж байсан** (бараа болон хүү)**г нь авч, тэр Бидэнд ганц биеэрээ л ирнэ!»** (Мэрьем, 77-80)” (Бухарий, Тэфсир, 19/3; Муслим, Мунафикийн, 35-36; Тирмизий, Тэфсир, 19/3162)

Хаббаб -радъяллаху анх-ын эзэн Үммү Энмар ч түүнд тамлал хийхэд бусдаас ухралгүй, галд улайлгасан төмрөөр Хазрат-и Хаббабын толгойг хайрдаг байв. Хаббаб -радъяллаху анх- нь Пайгамбар Эзэн дээр очоод Үммү Энмарын тухай зарга мэдүүлэв. Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-:

“Аллах минь! Хаббабт тусал!” хэмээн залбирахлаар нь Үммү Энмар толгой нэгэн өвчинд баригдаж нохой шиг ульж эхлэв. Түүний толгойг тамгалахыг зөвлөв. Тэгэхлээр нь Хабааба -радъяллаху анх- төмрийг авч, галд улайлгаж, Үммү Энмарын толгойг тамгалав.[180]

Хазрат-и Билал -радъяллаху анх-[181] ч энэрэлгүй тамлалд орогсдын нэгэн байв. Эзэн Үмэйе бин Халэф нь Билалыг уха-

180. Хар. Ибн-и Эсир, *Усдү’л-Габэ,* II, 115.

181. **Билал бин Рубах** -радъяллаху анх- Абиссинийн хүн байсан тул Билал-и Хабэший гэсэн нэрээр алдаршсан байдаг. Маккад мусульман болсноо ил зарласан анхны долоон хүнээс нэгэн байв. Ээж нь Хамамэ ч мусульман байв. Ийм учраас хоёулаа ч Исламын анхны жилүүдэд мүшрикчүүдийн хүнд тамлалыг үзэв. Хижрэтийн тооллын нэгэн онд анхны эзаныг

анд төрөхөөргүй хэрцгийгээр тамладаг байв. Түүнийг халуун элсэнд хэвтүүлж, дээр нь том чулуу тавьж, заримдаа ч Маккагийн гудамжаар чирдэг байв. Билал-и Хабэший -радъяллаху анх-ыг нэгэн өдөр нэгэн шөнө усгүй үлдээсний дараа төмөр цамц өмсгөж, ширүүн халуун доор халуун элсэн дээр байлгаж, өөхийг нь хайлтал хүлээлгэдэг байв.

Мүшрикчүүд Билал -радъяллаху анх-ад бүх төрлийн тамлал хийсэн ч хүссэн юмаа хэлүүлж чадахгүй, тэр байнга:

“–Ахад, Ахад, Ахад (Аллах нэг мөн, Аллах нэг мөн, Аллах нэг мөн)!” гэдэг байв.[182]

Мусульманчуудад зохимжтой гэж үзсэн үйлс зөвхөн тамлалаад зогссонгүй. Аммар -радъяллаху анх-ын аав Хазрат-и

уншсанаараа алдаршсан Билал-и Хабэший -радъяллаху анх- энх тайванд ч дайнд ч байнга Пайгамбар Эзний маань мүэззиний үүргийг гүйцэтгэв. Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн хамт бүх дайнд оролцов. Маккаг эзэлсний өдөр Кабагийн дээвэр дээр гараад ялалтын эзаныг уншив. Аллахын Элчийн абдэстийн усыг бэлтгэж, хувийн үйлчилгээг хийдэг, дайнд шөнө Түүнийг хамгаалдаг, улс төрийн бусад ажлыг хийхэд тусалдаг байв. Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийг өөд болсны дараа дахиад эзан уншаагүй. Хазрат-и Умарын калиф байсан эринд Мадинагаас салж Сирид зарим дайнд оролцов. Тэнд мусульманчууд Билал -радъяллаху анх-ад эзан уншуулах төлөө калифаас тусламж нэхэв. Хазрат-и Умар гуйсанд Билал нэгэн удаа эзан уншив. (Зэхэбий, *Сиер*, I, 357) Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн эринийг үгүйлсэн мусульманчууд нулимсанд автав. Билал-и Хабэший -радъяллаху анх- Пайгамбар Эзнээс маань дөчин дөрвөн хадис-и шариф дамжуулав. Расулаллахын уг хайрт нь жаран гаруй настайдаа Дамаскад нас барав.
Нас барахдаа:
“–Маргааш хайртай андууддаа; Хазрат-и Мухаммед -алэйхиссалатү вэссэлам- болон найз нартай учирна,” гэв.
Тэгэхлээр нь эхнэр нь:
“–Надад хайран юм аа!” гэж уйлж эхлэв.
Сэтгэл нь үгүйлж Пайгамбарын хайрт Билал -радъяллаху анх- ч:
“–Ямар гоё, ямар таатай юм бэ!” гэж байв. (Зэхэбий, *Сиер*, I, 359)

182. Хар. Ахмад, I, 404; Ибн-и Са’д, III, 233; Бэлазурий, I, 186.

Яасир[183] нь мүшрикчүүдийн хэлүүлмээр байсан зүйлсийг хэлээгүй бөгөөд тэдний хүнд харгислал амь насаа алдав.

Ээж нь Хазрат-и Сүмэйе -радъяллаху анхаа- ч зэрлэгээр тамлуулж хоёр хөлийг нь нэг нэг тэмээнд уяж, энэрэлгүйгээр тасчин алсан гэдэг.

Ингээд Яасир гэсэн гал голомт -радъяллаху анх- нь Исламын анхны шэхидүүд болцгоов.[184]

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- нэгэн өдөр, тамлагдаж байсанд энэ ариун гэр бүлд таарч:

“–Яасирын гэр бүл ээ, тэвчээрэй! Яасирын гэр бүл ээ, баяссаарай! Гарцаагүй таны орон диваажин мөн!” хэмээсэн байв. (Хаким, III, 432, 438)

Хазрат-и Аммар -радъяллаху анх-[185] ч хэд олон тамлал ба зовлонд орсон байв.

Курайшийн мүшрикчүүд нэгэн өдөр Хазрат-и Аммарыг барьж, толгойг нь худагт живүүлж:

“–Мухаммедыг дооромжилж Лат ба Уззаг магттал чамайг салгахгүй!” гэцгээж, хүссэнээ хэлүүлэв.

Аллахын Элчид:

183. **Яасир бин Амир** -радъяллаху анх- нь Йеменээс ирээд Маккад суурьшиж Эбү Хүзэйфэгийн боол Сүмэйе Хатантай сууж түүнээс Аммар ба Абдуллах нэртэй хоёр хөвүүнтэй болов. (Ибн-и Са’д, IV,136, VIII, 264) Яасирын гэр бүлийнхэн бүгдээрээ мусульман болсныхоо төлөө хамтдаа тамлуулсан байв.

184. Хар. Ибн-и Насер, *эл-Исабэ*, III, 648; Зэмахшэрий, III, 164.

185. Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-: *“Диваажин гурван хүнд; Али, Аммар ба Сэлманд хүрэхийг хүсдэг.” “Аммар түүнд дайлсан юмаас хамгийн зөвийг л сонгоно,”* хэмээн айлдаж энэ шилмэл сахабийгийн эрдмийг зарлав. (Тирмизий, Мэнакиб, 32, 34; Ибн-и Мажэ, Мукаддима, 11)

“–Аяа Расулаллах аа! Аммар кафир болжээ!” гэсэн мэдээлэл хүрэв.

Орчлонгийн Хүндэт -саллаллаху алэйхи вэ сэллэм- Эзэн маань бол:

“–Үгүй! Аммар нь бие сэтгэлээрээ итгэл үнэмшлээр дүүрэн юм! Итгэл үнэмшил нь түүний мах болон цус хүртэл нэвтэрсэн байдаг!” хэмээв.

Тэр хооронд Аммар -радъяллаху анх- нь Пайгамбар Эзний маань дэргэд оров. Ариуи сахабий уйлж байв...

Орчлонгуудын Эзэн түүний нулимсыг гараараа арчихдаа:

“–Чамд юу болоо вэ?” хэмээн асуув.

Аммар -радъяллаху анх-:

“–Аяа Расулаллах аа! Чамайг дооромжлуулахгүй бөгөөд баримал ч Чиний шашнаас дээр буйг хэлүүлэхгүйгээр надаас салахгүй!” гэв.

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-:

“–Чи эдгээрийг хэлж байхад, чиний зүрх ямар байв?” хэмээн асуув.

Аммар:

“–Зүрх минь Аллах болон Расулд нь итгэсний амар амгаланд, миний шашинтайгаа холбоо ч төмрөөс бат байлаа!” гэв.

Тэгэхлээр нь Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- нэг талаас түүний нулимсыг арчиж байхдаа нөгөө талаас:

“–Аммар аа! Хэрэв тэд чамайг энэ хэлснийг чинь дахихаар албадвал, дахиад хэлээд өгчих!” хэмээв.

Энэ явдлын дараа уг ает-и кэримэ нь буув:

مَن كَفَرَ بِاللّهِ مِن بَعْدِ إيمَانِهِ إِلاَّ مَنْ أُكْرِهَ وَقَلْبُهُ مُطْمَئِنٌّ بِالإِيمَانِ وَلَكِن مَّن شَرَحَ بِالْكُفْرِ صَدْراً فَعَلَيْهِمْ غَضَبٌ مِّنَ اللّهِ وَلَهُمْ عَذَابٌ عَظِيمٌ

“Зүрх нь итгэл үнэмшлээр дүүрэн байхад албадвал, хэн ч итгэлийнхээ дараа зүрхээ күфүрт нээвэл, тэдэн дээр заавал Аллахаас нэгэн зовлон ирээд тэдэнд том нэгэн тамлал ч байдаг.” (эн-Нахл, 106) (Ибн-и Са’д, III, 249; Ибн-и Эсир, *эл-Камил,* II, 67; Хэйсэмий, IX, 295; Вахидий, х. 288-289)

Энэ байдал, итгэл үнэмшлийн эсрэг ийм үгсийг зөвхөн үхлийн аюул байсан тохиолдолд хэлж болохыг, бусад тохиолдолд бол жаиз биш буйн хуулийн баталгаа юм.

❁

Исламын дайсан мүшрикчүүд нь Хазрат-и Сүхэйб[186] -радъяллаху анх-ыг ч ухаан баларттал нь зоддог байв.

---

186. **Сүхэйб бин Синан** -радъяллаху анх- нь Сүхэйб-и Румий гэж алдаршсан байдаг. Бага насандаа эхлээд Римчүүдэд, дараа нь Арабчуудад олзлогдов. Маккад Ибн-и Жэд’аны холбоотон байхдаа Аммар бин Яасир -радъяллаху анх-аас Исламыг мэдэж аваад шууд мусульман болов. Хамаг бараагаа мүшрикчүүдэд өгөөд олон мянгаараа зүтгэж Мадинад нүүж одов. Түүний тухай:

وَمِنَ النَّاسِ مَن يَشْرِي نَفْسَهُ ابْتِغَاء مَرْضَاتِ اللّهِ وَاللّهُ رَؤُوفٌ بِالْعِبَادِ

“Хүмүүсийн хооронд Аллахын тааламжийн төлөө өөрийгөө зардаг зарим нь байдаг. Аллах боолчуудаа их энэрэлтэй байдаг,” (эл-Бакара, 207) ает нь буув.

Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- түүнийг харахлаараа:

“–Эбү Яхяа! Чи их ашигтай ба элбэгтэй худалдаа хийсэн шүү!” хэмээв. (Хаким, III, 450-452)

Сум харвахдаа их авьяастай байсан Сүхэйб -радъяллаху анх- Хазрат-и Пайгамбарын харъяанд хамаг дайнуудад оролцов. Дунд хуруутай, улаан арьстай, маш өгөөмөр хүн байв. Хамаг амьдралаа Исламын төлөө

Зиннира Хатан бол мүшрикчүүдийн элдэв тамлал харгислалд орсон нэгэн эмэгтэй боол байв. Эбү Жэхилийн хийсэн тамлалаас болж сохор болсон байв.

Эбү Жэхил:

“–Хараа юу? Лат ба Узза чиний нүдийг сохлов!” гэв.

Зиннира Хатан:

“–Үгүй! Валлахи миний нүдийг сохолсон ч Миний Раб нүдийг минь буцааж өгөхөд чадалтай юм!” гэв.

Өглөө болоход, Аллах Таалаг Зиниира Хатаны хоёр нүдийг буцаасныг харцгаав. (Ибн-и Хишам, I, 340-341; Ибн-и Эсир, *эл-Камил*, II, 69; *Усдү’л-Габэ*, VII, 123)

Мусульманчуудаас өөр хэчнээн олон нь ийм төвөг ба зовлонд автсан байв. Амир бин Фүхэйрэ, Эбү Фүкэйхэ, Микдад бин Амр, Үммү Үбэйс, Лүбэйнэ Хатан, Нэхдие Хатан ба охин нь мэтийн манай Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм- Эзний шилмэл асхаб нь, хүний ухаанд, оршгүй тамлалд орсон байв. Мүшрикчүүд тэднийг хувцасгүй байхад хөлөөр нь гинжээс уяж чирээд, халууны хамгийн ширүүн байсан цагт цөлд гаргадаг, дээр нь том хадаа тавьдаг, ухаан балартаж юу хэлснээ мэдэхгүй болтол бүх төрлийн зовлон хийдэг байв. Багалзуурыг нь шахаж үхснийг нь бодтолоо орхидоггүй байв.[187]

Энэ байдалд, Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм-ээс эхлээд хамаг итгэгчид санаа зовдог байв. Гэтэл тэр

өөрийгөө зориулан өнгөрөөсөн Сүхэйб-и Румий -радъяллаху анх- нь хижрэтийн тооллын 38 онд 73 насандаа байхдаа нас бараад Мадина дахь Бакий’ Булшад булсан байдаг.

187. Хар. Ибн-и Мажэ, Мукаддима, 11; Ахмад, I, 404.

үед чадах юм байгаагүй байв.[188] Зөвхөн эд бараагаараа арай дажгүй байсан итгэлийн хөшөө Хазрат-и Эбү Бэкир -радъяллаху анх- нь Хазрат-и Билалыг ч агуулсан долоон мусульман боолыг эздээс нь худалдаж аваад чөлөөлсөн, тэднийг таслалтгүй тамлалаас ингэж нэг аварч чадсан байв.

Харин мүшрикчүүдийн тамлал нь өдөр бүр улам ихэсч, хүчгүй ба хэн хүнгүй итгэгчдийн дараа Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- ба хажууд нь буй Хазрат-и Эбү Бэкир, Хазрат-и Усман, Зүбэйр бин Аввам, Мус'аб бин Үмэйр мэтийн баян хүмүүс ч тамлал ба харгислалаас хувиа авдаг байв.

Мүшрикчүүд Маккагийн хар ардаас тааруу хүмүүсийг өдөөж Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм- Эзэнд маань довтлуулдаг байв. Шүлэгч, шившлэгч, мэргэ харагч ба галзуу мэтийн өөрсдийнхөө ч итгээгүй худал ба гүтгэлгээр Түүнийг зовоодог байв.[189]

Абдуллах бин Амр -радъяллаху анх-ын өөрөө хараад ярьснаар, нэгэн өдөр Хүндэт Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- Кабагийн Хижр хэмээсэн хэсэгт мөргөл үйлдэж байхад, Үкбэ бин Эбий Муайт ирэв. Орчлонгийн Туяа Эзнийг маань боохоор нөмрөгийг нь хүзүүнд нь эргүүлж угз татав. Хазрат-и Эбү Бэкир амжиж мөрөөр нь бариад түүнийг зайлуулан:

---

188. Мэхмэд Акиф нь Пайгамбар Эзний маань мусульманчуудад харгислал учруулагсдаас мэдэрсэн том зовлонг илэрхийлэхээр ингэж хэлнэ:
Хазрат-и Пайгамбараас та нар огт ичдэггүй юу
Хол газар нэгэн итгэгчид нэгэн өргөс хатгавал
Ариун зүрхэндээ түүний зовлонг мэдэрдэг гэнэ
Андашгүй нь Нэбийгин сүнс та нарын тухай зарга гаргана…
Ийм учраас нэгэн итгэгчийг ямар нэгэн учраар зовоохын Расулаллахыг ч зовоосныг бодож хандах хэрэгтэй. Тийм учраас эрх бусын үйл, хов яриа, сэтгэл гомдоох мэтийн бүх төрлийн муухай үйлээс холд байх хэрэгтэй байдаг.

189. Хар. Ибн-и Хишам, I, 309-310.

“–Раббаас маань ил баталгаагаар ирсэн хэн нэгийг *«Миний Раб Аллах мөн!»* гэсэн учраас нь алах юм уу?” гэв. (Бухарий, Тэфсир, 40)

Дахиад ижил нэгэн байдлыг Ибн-и Мэс’үд -радъяллаху анх- ч ингэж дамжуулна:

“Нэгэн өдөр Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- Кабагийн дэргэд мөргөл үйлдэж байв. Эбү Жэхил ба найзууд нь ч тэнд байцгаав. Өмнөх өдөр нэгэн тэмээ төхөөрсөн байв. Эбү Жэхил найзууддаа:

«–Тус гэрийн төхөөрсөн тэмээний гүзээг хэн авчраад, мөргөж байхад нь Мухаммедын мөрөн дээр тавих вэ?» гэв.

Тэндэхийн хамгийн жаргалгүй нь ухасхийн гүзээг барингуутаа, Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн мөргөж байхад Түүний ариун мөрөн дээр орхив. Үүнд бүгдээрээ инээж, нэг нэгнийхээ дээр хэвтээд эхлэв. Би жаахан цаана нь зогсоод тэднийг харж байлаа. Хэрэв намайг хамгаалах хэн нэгэн байсансан бол, гүзээг шууд мөрнөөс нь хаяхсан. Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- мөргөсөн, толгойгоо өндийлгөхгүй байв. Гэхэд нэгэн очоод Хазрат-и Фатимад мэдээлэв. Тэр нь арай жижигхэн охин байв. Ирээд гүзээг эрхэм аавынхаа сээрээс нь аваад хаяв. Дараа нь тэдэн рүү эргэж хүнд үгс хэлэв. Мүшрикчүүд Фатима -радъяллаху анхаа-д ямар ч хариу өгч чадаагүй. Оршигчийн Туяа мөргөлөө бүтээхлээрээ дуугаа чагнаж:

“–Аллах минь! Курайшийг чамд л илгээлээ!” хэмээж үүийг гурван дахин хэлэв.

Мүшрикчүүд Хүндэт Элчийн маань энэ залбирлыг сонсонгуутаа гэнэтхэн инээж чадахгүй болов. Түүний залбирлаас болж тэд аймшигт автав. Учир нь тэд Аллахын Элчийн зал-

бирал ёсоороо хэрэгжсэнийг олон удаа үзсэн байв. Дараа нь Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-:

«–Аяа Аллах минь! Эбү Жэхилийг, Үтбэг, Шэйбэг, Вэлидийг, Үмэйе бин Халэфыг, Үкбэ бин Эбий Муайтыг Чамд л илгээж байна,» гээд Исламыг дайсдыг нэрээр нь нэг нэгээр тоолов.

Мухаммедыг үнэн дээр илгээсэн Зат-и Зү'л-Жэлалд тангарлая, Расулаллахын тоолсон энэ хүмүүсийг Бэдирийн өдөр бүгд газар дэвсэлсэнд харлаа. Дараа ч тэднийг Бэдирийн чирээд Бэдирийн худагт хаяв." (Бухарий, Салат 109, Жихад 98, Жизье 21; Мүслим, Жихад 107)

Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- ийм харгис хандлагатай тааралдсан боловч тэвхидийн учирт мүшрикчүүдэд ерөөсөө дөхөөгүй; шашнаасаа огт бууж өгөөгүй. Мөн асхаб-и заримаас асууж байв:

"–Таны дундаас хэн нь очоод Кабад мүшрикчүүдэд Кур'ан унших вэ?"

Ийм саналд чин сэтгэлээрээ «Би, аяа Расулаллах аа!» гэсэн Абдуллах бин Мэс'үд нь Кабад мүшрикчүүдэд Кур'ан-и Кэрим уншаад, ийм учраас тэр хувигүй харгисчууд түүнийг маш муухай зодсон байв.

Найзууд нь:

"–Бид угаасаа чиний учирсан юмтай тааралдахаас айж байлаа!" гэцгээв.

Абдуллах бин Мэс'үд бол:

"–Одоо ч би тэднээс айхгүй байна! Та хүсвэл би маргааш очоод тэдэнд дахиад Кур'ан сонсгож чадна!" гэв.

Найзууд нь:

“–Үгүй! Тэдэнд дургүй юмыг хэрэггүй. Чамд энэ нь хүрэмжтэй!” гэцгээв. (Ибн-и Хишам, I 336-337)

❁

Эбү Жэхил хэзээ ч баян хэн нэгний мусульман болсныг сонсвол шууд очоод түүнийг дооромжилж:

“–Чи аавынхаа шашныг орхио юу! Харин тэр чамаас илүү байв. Тэгэхээр чи түүний бодлыг тоогоогүй, алдрыг уруудуулав биз?! Үнэхээр бид чиний бодлыг хэлэлзэж авахгүй ба буруу буйг нь илрүүлнэ. Чиний нэр хүндийг үгүй болгоно,” гээд сүрдүүлдэг байв.

Хэрэв мусульман болсон нь худалдаатай оролдсон хүн байвал түүнд:

“–Валлахи чиний наймааг тасалж, хөрөнгийг чинь хохируулна,” гэдэг байв. Мусульман байсан нь хүчгүй ба ядуу хүн байвал түүнийг зодно, хуурамч үгээрээ түүнийг хангаж Исламаас эргүүлэхийг хичээдэг байв.

Нэгэн удаа хэн нэгэн Ибн-и Аббас -радъяллаху анх-аас:

“–Мүшрикчүүд нь Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- ба асхабд нь шашнаас халахын шаалтгаан болох зэрэг чинээ тамлал хийдэг байв уу?” гэж асуусан байв.

“–Тийм, валлахи мүшрикчүүд тэднээс барьсныг маш хатуу зодож, өлөн ба усгүй үлдээж, хэт тамлал хийдэг байсан тул, зодооны ширүүнээс сууж чадахааргүй болж, тэндий хүссэн хамаг юмыг хэлдэг байв. Түүнээс:

«–Аллахаас өөр Лат ба Узза ч бурхан мөн үү?» гэж асууж, тэр ч:

«–Тийм!» гэдэг байв.

Түүнчлэн хажууд нь яваад өнгөрч буй Жуал ялааг зааж:

«–Тэр Жуал ч Аллахаас өөр бурхан мөн үү?» гэж асууж, тэр ч ийм хүнд тамлалаас аврах тулд:

«–Тийм!» гэдэг байв.

Сэрээд ухаан орсны дараа бол буцдаг байв,” гэв. (Ибн-и Хишам, I, 339-343; Ибн-и Са’д, III, 233; Ибн-и Кэсир, *эл-Бидая*, III, 108)

Ийм олон харгислалыг давж -бидний дамжуулсан “Ислам” хэмээх шим бидэнд олон мянган хүний ийм зовлонд тэсвэрээр хүрч чадсныг ба энэ замд бууж өгч ерөөсөө болохгүйг ухаарах, үнэ цэнийг нь сайн тогтоох хэрэгтэй.

❁

Аллах Таала хүссэнсэн бол Исламын хөгжлийг амархан болгож чадахсан бөгөөд ийм учиртай мусульманчуудад ямар ч төвөг үзүүлдэггүй байж мэдэхсэн. Гэтэл тйим тохиолдолд энэ замд амиа зориулсан хүмүүсийн сэтгэлийн дотно харьцаа нь илрэхгүй, энэ тухай чармайлт нь тогтохгүй байв. Мэдээж тийм тохиолдолд итгэгч ба мүхафиз, үнэнч ба худалчийг бие биеэс нь ялгаж боломжгүй байхсан.

Аллах Таала нь ает-и кэримэд ингэж айлдана:

الٓمٓ اَحَسِبَ النَّاسُ اَنْ يُتْرَكُوٓا اَنْ يَقُولُوٓا اٰمَنَّا وَهُمْ لَا يُفْتَنُونَ وَلَقَدْ فَتَنَّا الَّذٖينَ مِنْ قَبْلِهِمْ فَلَيَعْلَمَنَّ اللّٰهُ الَّذٖينَ صَدَقُوا وَلَيَعْلَمَنَّ الْكَاذِبٖينَ

“Элиф. Лам. Мим. Хүмүүс шалгалт өгөлгүй, зөвхөн «Бид итгэлээ» гээд чөлөөт болохоо бодов уу? Тангараг өргөе, Бид тэдний

өмнөх хүмүүсийг ч шалгав. Мэдээж Аллах үнэнчийг ч худалчийг ч илрүүлнэ.” (эл-Анкэбут, 1-3)

اَمْ حَسِبْتُمْ اَنْ تَدْخُلُوا الْجَنَّةَ وَلَمَّا يَعْلَمِ اللّٰهُ الَّذ۪ينَ
جَاهَدُوا مِنْكُمْ وَيَعْلَمَ الصَّابِر۪ينَ

“Эсвэл Аллахыг таны дундаас жихад хийж тэвчигчдийг илрүүлэлгүйгээр диваажинд орохоо бодож байв уу?” (Ал-и Имран, 142)

اَمْ حَسِبْتُمْ اَنْ تَدْخُلُوا الْجَنَّةَ وَلَمَّا يَأْتِكُمْ مَثَلُ الَّذ۪ينَ خَلَوْا مِنْ
قَبْلِكُمْ مَسَّتْهُمُ الْبَأْسَٓاءُ وَالضَّرَّٓاءُ وَزُلْزِلُوا حَتّٰى يَقُولَ الرَّسُولُ
وَالَّذ۪ينَ اٰمَنُوا مَعَهُ مَتٰى نَصْرُ اللّٰهِ اَلَٓا اِنَّ نَصْرَ اللّٰهِ قَر۪يبٌ

“Эсвэл та, танаас өмнөх яваад өнгөрөгсдийн байдал (учирсан төвгүүд) **танд тохиолдолгүйгээр диваажинд орчихоо бодов уу? Тэдэнд ядуу зүдүү байдал, маш хатуу төвөг хүрсэн ч ба маг ширүүн донсолсон, түүнчлэн пайгамбарчууд ба тэдний хамт байгсад нь: «Аллахын тусламж хэзээ вэ?» гэдэг байв. Одоо хар! Үнэхээр Аллахын тусламж ойр юм.”** (эл-Бакара, 214)

Тэвхидийн оролдлогын үр дүнд ширүүн шалгалтаар учрах нь сүннэтуллахын шаардлага мөн. Хамаг пайгамбарчууд ба үнэнч боолчууд бүгд төвөгт автсан, зовлонтой тааралдсан, түүнчлэн зарим нь ийм учиртай шэхид болсон байв. Ийм учраас нэгэн мусульман зовлон ба төвөгтэй тааралдахдаа найдвараа алдах нь зөв биш юм. Эсрэгээр нь итгэгчид Аллахын тушаалыг хэрэгжүүлэх тухай аюул ба төвгүүдэд хэдий их тэсвэл, Аллахын тааламж ба амжилтад төдий том зэргээр хүрэхээ мэдэх хэрэгтэй юм.

Мусульманчуудад Тэсвэр ба Тэвчээрийг Санал Болгох нь

Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- ч нэгэн хүн байв. Заримдаа Түүнд хийсэн сөрөг үйлс Түүнийг зовоож, авралынх нь төлөө хамаг хүчээрээ чармайсан хүмүүсийн муухай үйлс нь сэтгэлийг нь зовоодог байв. Заримдаа заавал нэгэн тайгаруулагчийн хэрэгцээг мэдэрмээр хэцүү байдалд ордог байв.

Түүний тайтгаруулах үг нь Раббаасаа ирдэг байв. Аллах Таала нь Элчийнхээ гунихыг хүсдэггүй, Түүнийг ает-и кэримэчүүдээрээ сүнсний талаар дэмждэг байв:

اِلَّا رَحْمَةً مِنْ رَبِّكَ اِنَّ فَضْلَهُ كَانَ عَلَيْكَ كَبِيرًا

“...(Аяа Расул минь!) **Аллахын чамд туслах тусламж нь агуу том юм.”** (эл-Исра, 87)

وَمَنْ كَفَرَ فَلَا يَحْزُنْكَ كُفْرُهُ اِلَيْنَا مَرْجِعُهُمْ فَنُنَبِّئُهُمْ بِمَا عَمِلُوا اِنَّ اللّٰهَ عَلِيمٌ بِذَاتِ الصُّدُورِ نُمَتِّعُهُمْ قَلِيلًا ثُمَّ نَضْطَرُّهُمْ اِلٰى عَذَابٍ غَلِيظٍ

“Хэн үгүйсгэвэл, тэр үгүйсгэл нь Чамайг бүү зовоогоосой. Бүгд л буцна. Тэр үед тэдний юу хийснийг тэдэнд мэдүүлнэ. Аллах зүрхэнд буйг андашгүй сайн мэднэ. Тэдэнд түр зуур ашиглуулна, дараа нь хүнд тамлал ирнэ!” (Лукман, 23-24)

وَلَا تَحْزَنْ عَلَيْهِمْ وَلَا تَكُنْ فِي ضَيْقٍ مِمَّا يَمْكُرُونَ

“(Хабиб минь!) **Тэдний төлөө бүү гунигла, тэдний барьж буй хавхнаас болж ч санаа зовуузай!”** (эн-Нэмл, 70)

Аугаа Эрх нь Хайртыгаа ингэж тайтгаруулж Түүнд тэвчээрийг зөвлөж байв:

فَاصْبِرْ عَلٰى مَا يَقُولُونَ وَسَبِّحْ بِحَمْدِ
رَبِّكَ قَبْلَ طُلُوعِ الشَّمْسِ وَقَبْلَ الْغُرُوبِ

“(Расул минь!) **Тэдний хэлсэнд нь тэвч! Нарны мандахаас өмнө ч, жаргахаас өмнө ч Раббаа хамд ба тэсбих хий!”** (Каф, 39)

Энэ ает-и кэримэчүүдэд хичээх ба чармайхыг зорилт нь дэмжсэн Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- ч асхабынхаа зовлонг гийлгэж, тэдний сэтгэлийн шархыг ороож байв.

Хаббаб -радъяллаху анх- ингэж хэлнэ:

Нэгэн өдөр Аллахын Элч нь Кабагийн сүүдэрт байхад, хажууд нь очоод Түүнд мүшрикчүүдийн үзүүлсэн тамлалыг зарга маягаар ярив.

Тэр ч бидэнд ингэж айлдав:

“Танаас өмнөх удмуудын хооронд, баригдаж нэгэн нүхэнд хийсэн, тэгээд хөрөөгөөр толгойгоос нь доош хоёр хуваасан, төмөр самаар мах нь самнасан бөгөөд тэгсэн ч шашнаасаа буцаагүй итгэгчид болов. Аллахад хамд болог, Аллах Таала энэ шашнаа бүтээж, эзэмшүүлнэ. Үүний жишээ өгвөл, хэн нэгэн Аллахаас ба хоньдоо чоно дайрах эмээлээс өөр айлт мэдрэхгүйгээр Сан’агаас Хадрамуут хүртэл яваад ирж чадахаар болно. Гэтэл та нар тэвчихгүй байна!..” (Бухарий, Мэнакибу’л-Энсар, 29)

Үүний дараа Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- уг ает-и кэримэг уншаад өгөв:

لَا يَغُرَّنَّكَ تَقَلُّبُ الَّذِينَ كَفَرُوا فِي الْبِلَادِ مَتَاعٌ قَلِيلٌ
ثُمَّ مَأْوٰيهُمْ جَهَنَّمُ وَبِئْسَ الْمِهَادُ لٰكِنِ الَّذِينَ اتَّقَوْا
رَبَّهُمْ لَهُمْ جَنَّاتٌ تَجْرِي مِنْ تَحْتِهَا الْاَنْهَارُ خَالِدِينَ
فِيهَا نُزُلًا مِنْ عِنْدِ اللّٰهِ وَمَا عِنْدَ اللّٰهِ خَيْرٌ لِلْاَبْرَارِ

“Үгүйсгэгчдийн (амар тайван) **нутаг нутгаар яваад одсон нь Чамайг битгий хуураг! Тэдний түр ашиглахын дараа очих газар нь там юм. Тэр нь маш муу очих газар шүү! Гэтэл Раббыгаа эсэргүүцэхээс бологоомжлогчдод бол, Аллахаас нэгэн шагналаар доороос нь мөрөн урсдаг, үүрд мөнх байх диваажин байдаг. Зөв хүмүүсийн төлөө Аллахын онгон дахь** (шимүүд) **илүү буянтай юм.”** (Ал-и Имран, 196-198)

Мүшрикчүүдийн харгислал ба тамлал нь үргэлжлээд, зовлон ихсээд байхад, энэ тухай ает-и кэримэнүүдээр Аллах Таала итгэгч сэтгэлүүдийг боловсруулж байв. Нэг талаас нь зовлон ба төвөг нь боолчуудыг Рабдаа дөхөх нөлөө болохын зэрэг, итгэгчдийн Аллахад бууж өгөх төвшнийг ч хэмжих тэнгэрлэг нэгэн тэгш болж байв. Ийм цагуудад мусульманы хувьд хамгийн гоё хандлагыг Кур’ан-и Кэрим ингэж мэдүүлнэ:

فَاصْبِرْ لِحُكْمِ رَبِّكَ وَلَا تُطِعْ مِنْهُمْ اٰثِمًا اَوْ كَفُورًا وَاذْكُرِ اسْمَ
رَبِّكَ بُكْرَةً وَاَصِيلًا وَمِنَ الَّيْلِ فَاسْجُدْ لَهُ وَسَبِّحْهُ لَيْلًا طَوِيلًا

“**Раббынхаа шийдвэрт тэвч**! (Өөрөөр хэлбэл Аллахын шийдвэрийг иртэл хүлээхээ мэд! Энэ шийдвэрийг хүлээхдээ ч ерөөсөө) тэднээс хэн нэгэн үгүйсгэгчид битгий бөхий! Өглөө-оройгүй Раббынхаа нэрийг дурд! Шөнө түүнд мөргө; шөнийн урт нэгэн хэсэгт Түүнд тэсбих хий!” (эл-Инсан, 24-26)

Эдгээр тушаалуудыг дагасан итгэгчийн сэтгэл ханамжид хүрэх тул, түүний төвөг ба тэвчээрийн гашууныг дийлэх хүчтэй болох нь андашгүй байв. Ялангуяа шөнө үйлддэг тэхэжжүд мөргөл нь, боолыг Аллахад дөхүүлж сүнсэнд ер бусын хүч олгож байсан, ингээд сэтгэл нь итгэлтэйгээр батжиж байв. Жишээлбэл Аугаа Эрх нь ингэж айлдана:

اِنَّ نَاشِئَةَ الَّيْلِ هِيَ اَشَدُّ وَطْئًا وَاَقْوَمُ قِيلًا

“ **Мэдээж шөнө босох нь илүү нөлөөтэй, мөн үгийн хэрээр ч илүү баталгаатай юм.”** (эл-Мүззэммил, 6)

Тэхэжжүд тушаал нь шууд Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийг хамаардаг байсан ч, үммэтэд нь ч -хүч чадалынх хэрээр- хүсэлд нь санал болгосонтой адил хэмжээнд байдаг юм. Фарз үйлчилгээний гадаа бөгөөд сүнсийг боловсруулдаг тул такват хүмүүст зөвлөсөн хамаг үйлчилгээ нь үүнд багтдаг.

❀

Итгэгчдэд жаргалын хамаг замыг хайрласан Аугаа Эрх нь Элчдээ мөн ингэж айлдсан байв:

وَقُلْ جَٓاءَ الْحَقُّ وَزَهَقَ الْبَاطِلُ اِنَّ الْبَاطِلَ كَانَ زَهُوقًا

“(Аяа Расул минь!) **Ингэж хэл: Үнэн ирээд төөрөг нь нурж явав. Угаасаа төөрөг нь нурахаас өөр аргагүй юм!”** (эл-Исра, 81)

Харин үнэнийг дээшлүүлэхээр томилогдогсод нь энэ талаар чадах юмаа хийх үүрэгтэй байдаг. Учир нь, хүн боолчлолын шалгалтын улмаас хэчнээн олон бэрхшээлтэй учрах ёстой байдаг. Ийм учраас тэр нь оролдохгүйгээр хэзээ ч хүссэн үр дүнд хүрч чадахгүй.

Аугаа Эрх нь энэ үнэнийн пайгамбарчуудын тухай ч хүчинтэй буйг ает-и кэримэд ингэж зарлав:

حَتّٰى اِذَا اسْتَيْئَسَ الرُّسُلُ وَظَنُّوا اَنَّهُمْ قَدْ كُذِبُوا جَاۤءَهُمْ نَصْرُنَا فَنُجِّيَ مَنْ نَشَاۤءُ وَلَا يُرَدُّ بَأْسُنَا عَنِ الْقَوْمِ الْمُجْرِمِينَ

“Хэзээ ч пайгамбарчууд найдвараа баруулж өөрсдийгөө худал буйг баталсныг бодвол, тэр мөчид л бидний тусламж тэдэнд хүрнэ. Бид хүссэн хүмүүсээ аврална хүргэнэ. Гэмт хэрэгтнүүдийн нийгмээс бол тамлалаа ерөөсөө буцаахгүй!” (Юүсүф, 110)

Эдгээр аетуудын сонссон итгэгчдийн сэтгэл нь хэдий их амарч, чармайлт нь ихэссэн бол, мүшрикчүүдийн хилэн ба өшөөг төдий их билүүдэж байв. Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-д хийсэн харгислалаа байхаас байтугай, өдөр бүр тамлалын шинэ нэгэн төрлийг олоод байцгаав. Итгэгчдэд төвөг саад тасрахгүй, өдөр тутам бүр тэвчихээргүй байдалд орж байв.

Мүшрикчүүд энэ үйлээ, вахийн булгийг хатаах мэтийн дорой бодлыг ч ухаандаа оруулах чинээ хэтрүүлэв. Орчлонгийн Хүндэт Эзэн маань бол тэвчээрийн оргил Аугаа Аллахад хоргодож, түүний хамгаалалтад орж байв. Гэтэл тэнгэрлэг үг нь арай хэрэгжихгүй байв.

Расулынхаа автсан гуниг ба төвгөөр дүүрэн байдалд хожигдохгүйг хүссэн Раб нь, Түүнд ингэж сануулдаг бай:

فَلَا تَحْسَبَنَّ اللّٰهَ مُخْلِفَ وَعْدِهٖ رُسُلَهُ اِنَّ اللّٰهَ عَزِيزٌ ذُو انْتِقَامٍ

“(Хайрт минь ээ!) **Аллахын пайгамбарчуудаа өгсөн амнаасаа болихыг нь бодуузай! Учир нь Аллах , өшөөгөө авдаг!”** (Ибрахим, 47)

فَاصْبِرْ كَمَا صَبَرَ اُولُوا الْعَزْمِ مِنَ الرُّسُلِ وَلَا تَسْتَعْجِلْ لَهُمْ
كَاَنَّهُمْ يَوْمَ يَرَوْنَ مَا يُوعَدُونَ لَمْ يَلْبَثُوا اِلَّا سَاعَةً مِنْ نَهَارٍ بَلَاغٌ
فَهَلْ يُهْلَكُ اِلَّا الْقَوْمُ الْفَاسِقُونَ

“(Аяа Расул минь ээ!) **Хичээнгүй пайгамбарчуудын тэссэн шиг Чи ч тэвч! Тэдний талаар** (тамлалын тухай) **битгий яар. Тэд өөрсдөд нь амласан тамлалыг харсан өдөр, дэлхий зөвхөн өдрийн нэг цаг чинээ үлдсэнээ л бодох болно …”** (эл-Ахкаф, 35)

Номлолын Тав Дахь Жил

Абиссинид Нүүдэл

Хүндэт Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- Эзэн маань Курайшчуудын тасралтгүй тамлалаас болж мусульманчуудад нүүхийг тушаав. Учир нь, тэд шашны үүргээ чөлөөтэй хийж чаддаггүй байв. Мөн шашнаа тараах ч тэдний үүрэг байв.

Асхаб-и кирам хааш нүүхээ асуухлаар нь Хүндэт Элч Эзэн маань:

"–Абиссинид! Тэнд ард түмэндээ тамладаггүй нэгэн эзэн хаан бий. Мөн тэд нь үнэн шударгын улс юм. Аллах Таала нь автсан төвгөөс нэгэн гарц зааж өгтөл тэнд байж байцгаа!" хэмээв. (Ибн-и Хишам, I, 343; Ибн-и Са'д, I, 203-204)

Энэ анхны нүүдэл Маккагийн эриний 5-р жилийн Рэжэб сард болов.

Анхны хамт олон арван хоёр эр, таван эм, нийт арван долоон хүнээс бүрдэв. Тэдний дунд Усман бин Аффан, эхнэр нь Хазрат-и Рукайя, Зүбэйр бин Аввам, Мус'аб бин Үмэйр, Абдуррахман бин Авф, Эбү Сэлэмэ, Үммү Сэлэмэ, Усман бин Маз'ун, Ибн-и Мэс'үд -радъяллаху анхүм- мэтийн асхабын тэргүүлэгчид ч байв.

Маккагаас нууцаар гарсан Мухажир буюу нүүдэлчдийг Шуайба боомтод хүрэхэд, Аллах Таалагин нэгэн бэлгээр най-

мааны хоёр онгоц ирэв. Мухажирчууд тэдэнтэй хагас алтаар зохицуулан Абиссинид гатлав. Курайшчууд Мухажирчуудыг барихаар дагаж явсан ч амжаагүй. Тэнгисийн эрэгт хүрэхэд нь онгоцнууд аль хэдийн тэнгист гарсан байв. (Ибн-и Са'д, I, 204)

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-нь Абиссинид нүүсэн Хазрат-и Усман ба охин Рукайягаас хэсэг хугацаагаар мэдээ авч чадаагүй. Орчлонгийн Хүндэт Эзэн маань заримдаа гадаа гарч, тэр чигээс ирсэн хүмүүсээс хүүхдүүдийнхээ тухай мэдээлэл асуудаг байв. Курайшийн нэгэн эмэгтэй Абиссинийн нутгаас ирэв. Хүндэт Элч Эзэн маань охин ба хүргэнийхээ тухай түүнээс ч асуув. Тэр ч:



“–Эбү’л-Касим аа, би тэднийг харлаа,” гэв.

Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-:

“–Ямар байв, сайн байцгаав уу?” хэмээн асуув.

Эмэгтэй:

“–Усман нь Рукайяаг илжиг унуулан явж, өөрөө ч араас нь алхаж байв,” гэв.

Тэгэхлээр нь Орчлонгийн Хүндэт Эзэн маань:

“–Аллах анд ба туслагч болоосой! Андашгүй нь Усман бин Аффан нь, Лут -алэйхиссэлам-ын дараа гэр бүлийнхээ хамт Аллахын төлөө нүүсэн анхны хүн болов,” хэмээв. (Али эл-Мүттаккий, XIII, 63/36259)

Анхны Мухажирчууд Абиссинид гурван сар сууж чадав. Учир нь Маккагийн мүшрикчүүдийн ч итгэж үнэмшсэний тухай нэгэн мэдээ тараасан байв. Тэгэхлээр нь нүүдлийн хамт олон буцав. Гучин гурван эр, зургаан эмээс бүрдсэн гучин есөн хүний хамт олон, номлохын тав дахь жилийн Шаввал сараар Абиссиниас замд гарав. Маккад дөхөхдөө бол мүшрикчүүдийн мусульман болсны тухай мэдээлэл үндэсгүй болсныг мэдэж авцгаав. Дахиад Абиссинийн нутаг руу эргэх нь тэдэнд маш хэцүү санагдав. Нөгөө талаас хамгаалалтгүйгээр Маккад орохоос ч айцгаав. Гэтэл мүшрик байсан хамаатан андуудынхаа хамгаалалтаар эсвэл нууцаар Маккад орж чадав. (Ибн-и Хишам, II, 3-8; Ибн-и Са’д, I, 206; Хэйсэмий, VI, 33)

Гараник Асуудал

Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- саяхан буусан “Нэжм Сура”г Харам-и Шарифад ирэгсдэд чанга дуугаараа уншиж байв. Сурагийн төгсгөлд мөргөх ает ирэхлээр, Хазрат-и

Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм- нь Аугаа Эрхэд мөргөж өгөв. Түүний хамт байсан итгэгч-үгүйсгэгч хүн бүр нь мөргөв. (Бухарий, Тэфсир, 53/4)

Гэтэл мүшрикчүүд нь сурад дурдсан баримлын нэрээс болж Аллахад биш, өөрсдийнхөө баримлуудад мөргөж байв.

Дараа нь зохиосон ба "Гараник Асуудал" гэж нэрлэсэн дорой саналын үүсвэр болгомоор байсан явдал нь энэ юм.

Маккагийн мүшрикчүүдийн Ислам шашинд орсны тухай худал мэдээллийн учир нь мусульман ба мүшрикчүүдтэй хамаатай энэ хоёр тус тустай мөргөлийн зэрэгцээ хийсэн нь байв.

Үнэндээ хамаг үйл ийм л байсан ч дараа нь "Гараник Асуудал" гэсэн нэгэн буруутгал илрүүлсэн байдаг. Тэдний хэлснээр чөтгөр нь, аетуудын дунд "баримлаас ч шафаат найдаж болох" гэсэн утгаар нэгэн шившээ нэмж, мүшрикчүүд ч үүнд дурлаж мөргөжээ, гэтэл алдаа нь дараа ил гэрчээ!..

Энэ туульсад зөвхөн зарим мүсшрикчүүдийн шиг Исламын өстөн зарим хүмүүс үнэн байж мэдэхийг тоолсон байдаг. Гэтэл хамгийн том тэфсир, хадис, сиер болон Исламын түүхийн эрдэмтэд нь, дамжуулах талаар ч саналын Исламын дүрэм журамтай холбооны талаар ч уг зохиомол байдлыг шинжилж, нэгэн дуугаар худал гэж зарласан байдаг.

Нэгдүгээрт нь, Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- тэнгэрлэг вахийг хүмүүст тэблиг хийх үүрэгтээ буруу болон алдаанаас хамгаалсан байв. Чөтгөрийн пайгамбарчуудын номлох үүрэгт оролдох нь ерөөсөө боломжтой биш. Аллах Таала нь чөтгөрийн итгэгч боолчууд дээр ямар нэгэн мэдэл

үгүйг зарласан байхад,[190] түүний Хүндэт Расул Эзний маань тэблигт оролцсныг бодохын ч арга үгүй.

Пайгамбар Эзэн маань -саллаллаху алэйхи вэ сэллэм- нь номлохдоо бүх төрлийн дутагдал, алдаа, буруу ба нүглээс гэмгүй байсан шигээ, Түүний авчирсан Кур’ан-и Кэрим ч тэнгэрлэг хамгаалалт доор байдаг.

Ает-и кэримэ айлдана:

لَا يَأْتِيهِ الْبَاطِلُ مِنْ بَيْنِ يَدَيْهِ وَلَا مِنْ خَلْفِهِ تَنْزِيلٌ مِنْ حَكِيمٍ حَمِيدٍ

“Түүнд (Кур’ан-и Кэримд) **өмнөөс нь ч хойноос ч худал дөхөж чадахгүй. Тэр хамаг орчлонгийн магтсан эрдмийн нэгэн эзнээр хэсэг хэсгээр буулгасан байдаг.”** (Фүссилэт, 42)

اِنَّا نَحْنُ نَزَّلْنَا الذِّكْرَ وَاِنَّا لَهُ لَحَافِظُونَ

“ Гарцаагүй, Кур’аныг Бид буулгав, мэдээж түүнийг Бид л хамгаална.” (эл-Хижр, 9)

Гараник саналыг агуулсан дамжуулсан үг нь баримт талаараа дутуу юм. Энэ тухай Ибн-и Хүзэймэ:

“Гараник тууль нь зиндик (худалчд)ийн үг юм,” гэсэн байв.[191]

Бат хадиснуудыг дамжуулсан ямар ч ном үүнийг агуулаагүй нь, хэн нэгэн дасгалжуулагчийн бат гэж тоогоогүй түүний дутуутай адил юм.[192]

---

190. Хар. эл-Хижр, 42.
191. Исмаил Жэррахоглу, *ДИА,* “Гаранийк” зүйл, XIII, 363.
192. Кадий Ияад, II, 132.

Гараник санал нь ухаанаараа ч боломжтой харагдахгүй. Учир нь Гараникад ширк санал байдаг. Гэтэл Ислам шашин нь анхны мөчөөс эхлээд кэлимэ-и тэвхидийг тэблиг хий-сэн байдаг. Исламын гол шавар байсан тэвхид шүтлэгийн эсрэг ийм саналууд ямар ч оюун ухааны тал агуулдаггүй. Тухайлсан Нэжм Сура нь эхээс дуустал нь ширкийг дооромжилж, баримлуудын зөвхөн хуурай нэр буйг, мүшрикчүүдийг зөвхөн санаа ба дураа дагасныг мэдээлнэ. Ийм сурагийн дотор, мүшрикчүүдийн нотлож мөргөхөөр нэгэн үг холих нь, хэрэв хольсон ч түүний мүшрикчүүдийг ятгасан нь боломжийн үйл биш. Дахиад, Маккагийн мүшрикчүүдийн, тэднийг дооромжилсон ийм олон аетын дунд -хаша- чөтгөрийн нэмсэн хоёр үгээр зөөлөрч мөргөсөн нь ч ухааны хэрэг биш юм.

Энэ саналд хамгийн гоё хариуг энэ сура өөрөө шууд өгдөг:

مَا ضَلَّ صَاحِبُكُمْ وَمَا غَوٰى وَمَا يَنْطِقُ عَنِ الْهَوٰى

اِنْ هُوَ اِلَّا وَحْيٌ يُوحٰى

“Таны нөхөр (Мухаммед) **андуураагүй ба төөрөөгүй. Тэр дурааараа ярихгүй. Түүний ярьсан нь Түүнд вахий болохоос өөр зүйл биш юм.”** (эн-Нэжм 2-4)

Үүнд Исламын өстөнгүүд хилэнгээрээ илрүүлсэн нь, Исламын эрдэмтдээр маш олон талаас батласан байдаг. Арван гурван жилийн Маккагийн эрин ширкийг хожих ба зүрхэд дэх тэвхидийн итгэл үнэмшлийг батлуулах үйл ажиллагаагаар өнгөрөв. Учир нь тэвхидийн итгэл үнэмшил нь Аллахтай ямар ч оршигчийг адил үзэхийг ерөөсөө зөвшөөрдөггүй.

Абиссинийн Хоёр дахь Нүүдэл

Маккагийн мүшрикчүүд ирсэн Нүүдэлчдийн Абиссинид сайнаар угтсаныг мэдээд, өөрсдийн байдалд санаа зовоод хийж байсан тамлалаа улам бүр ширүүдүүлэв.

Вэлид бин Мугирагийн хамгаалалтад амар амьдарч байсан Усман бин Маз’ун -радъяллаху анх- нь Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- ба асхабынхыг ухаанд багташгүй харгислал ба тамлалд орсныг, заримын галд тамгаласныг, ташуураар зодогдсоныг харахлаараа бодолд автав:

“Валлахи, манай найзууд ба тэдний гэр бүлийнхнийг Аллахын учирт тааралдсан төрөл бүрийн зовлонг өөрөө тааралдаагүй байсан минь, нэгэн мүшрикийг хамгаалалт доор амар тайван амьдрах минь том нэгэн дутагдал байв! Аллахын хамгаалалт нь илүү алдартай ба баталгаат мөн!” гэж бодоод хамгаалагч Вэлидийнхээ дэргэд очоод түүнд:

“–Авга ахын хүү! Чи намайг хамгаалалтдаа авлаа! Сайхан ч хамгааллаа ба амалснаа хэрэгжүүллээ! Би одоо чиний хамгаалалтаас гарч Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн дэргэд очмоор байна. Тэр ба асхба нь миний төлөө хамгийн сайхан жишээ юм. Намайг Курайшчуудын дэргэд аваачаад миний дээрх хамгаалалтаа больсноо мэдүүл!” гэв. (Ибн-и Исхак, х. 158; Хэйсэмий, VI, 34)

Мүшрикчүүдийн харгислал ба тамлалыг улам бүр ихэссэнээс болж мусульманчууд тухайн жилд хоёр дахь удаа Абиссинид нүүхээс аргагүй болцгоов. Энэ удаа тэд ерүүлээ байв. Далан долоо нь эр, арван гурав нь эм байв. Тэдний тэргүүлэгчээр

Хазрат-и Алигийн том дүү Жафар-и Тайяр -радъяллаху анх-[193] байв.

Лайла Хатан ингэж ярина:

“Биднийг мусульман болсны тул Умар бидэнд маш их уурлаж байв. Абиссинид нүүхээр замд гарахад бэлдэхэд, намайг тэмээн дээр байхад ирээд:

«–Хааш явах гэж байна вэ ээ Үммү Абдуллах?» гэж асуув.

«–Шашны талаар та биднийг зовоосон, бид ч тамлал үзэхгүй газар явж байна,» гэлээ.

«–Аллах таны хамт байг!» гэв.

Манай нөхөр Амирыг ирэхээр, Умар бин Хаттабын зөөлөн байдлыг түүнд ч ярьж өгөв.

---

193. **Жафар бин Эбий Талиб** -радъяллаху анх- Хазрат-и Пайгамбарын авга ахын хөвүүн юм. Хазрат-и Жафар нь Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийг арай Эркамын гэрт ороод Исламыг тарааж эхлэхээс өмнө мусульман болсон; эхнэр Эсма бинт-и Үмэйсийн хамт Абиссинийн Хоёр дахь Нүүдэлд оролцсон байв. (Ибн-и Са’д, IV, 34)
Жафар бин Эбий Талиб ба найз нар нь Хижрэтийн тооллын долоон онд Абиссиниас Мадинад буцав. Тэр хооронд Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- нь Хайбарын Дайнд байв. Хайбарын олзоос Абисcниас ирэгсдэд ч хувь өгөв. (Бухарий, Мэгазий, 38)
Хазрат-и Жафар хижриэтйин тооллын найман онд хэрэгжсэн Мүтэгийн Дайнд оролцов, тэнд шэхид болов.
Ибн-и Умар ингэж хэлэв:
“Жафар -радъяллаху анх-ыг шэхидчүүдийн дундаас олов. Биенд нь ер гаруй жад, сум ба сэлмийн шарх харцгаав.” (Бухарий, Мэгазий, 44)
Хазрат-и Жафарын дайнд хоёр гар нь ч цавчигдсан учраас Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- түүнд диваажинд хоёр жигүүр бэлэглэснийг мэдээлж:
“Жафарыг диваажинд мэлэкчүүдийн хамт нисч байхыг харлаа,” хэмээв. (Тирмизий, Мэнакиб, 29/3763)
Түүний дараа Жафар -радъяллаху анх- нь “нисэгч” гэсэн утгаар “Тайяар” гэсэн хочоор алдаршив.

Тэр:

«–Магадгүй чи түүний мусульман болохыг хүсч байна. Валлахи Хаттабын илжиг ч мусульман болно, харин тэгсэн ч тэр мусульман болохгүй,» гэв.

Тэр үе хүртэл Умар байнга маш хатуу хандаж байсан тул, бүгд түүнийг итгэх үнэмшихийг найдахаа байсан байв.” (Хэйсэмий, VI, 23-24)

Орчлонгийн Хүндэт -саллаллаху алэйхи вэ сэллэм- Эзний маань эхнэр Хазрат-и Үммү Сэлэмэ -радъяллаху анхаа- ингэж хэлсэн байв:

“Биднийг Абиссинид хөл гишгэснээс эхлэн Нэжаший бидэнд маш сайхан үгээр хандаж дайлав. Биднийг байнга хадгалж хамгаалав. Амар тайвнаар Аллах Таалад залбирч үйлчилцгээв.” (Ахмад, I, 201-202)

Абиссинийн Нүүдэлчдээс Үммү Хабиба -радъяллаху анхаа- эхийн маань тэр үеийн тухай ярьсан уг дурсамж ч мусульманчуудын Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-д Түүнийг хараагүй байхдаа ч хэр их хайртай байсныг заадаг:

“Нэжашийд Эбрэхэ гэсэн нэртэй нэгэн шивэгчин байв. Намайг Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-тэй гэрлэх минь Абиссинид хийлгээд Мадинад очих бэлтгэлээ хийж байхад надад:

«–Чамаас Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-д миний мэндийг хүргэж, Түүнд шашинд нь ирснийг минь мэдээлэхийг гуйя,» гэв.

Эбрэхэ надад маш эелдэг хандаж, замын бэлтгэлийг минь хийв. Миний дэргэд ирэх бүртээ:

«–Миний хүслийг минь огт мартуузай! Аллахын Элчид мэндийг минь заавал дамжуул!» гэж байв.

Мадинад Расулаллахын дэргэд очингоо гэрлэлтийн үед Эбрэхэгийн надад хийснийг Түүнд ярьж өгөөд мэндийг нь дамжууллаа. Аллахын Элч мишээж:

“–Вэ алэйхэссэлам вэ рахматуллахи вэ баракатүх” хэмээн мэндийг нь хариулав. (Ибн-и Са’д, VIII, 98)

Номлолын Зургаа Дахь Жил

Курайшийн Нэжашийнаас Нүүдэлчдийг Нэхсэн нь

Абиссинийн анхны нүүдлийг нэг их тоогоогүй Курайш мүшрикчүүд нь, тэнд Нүүдэлчдэд үзүүлсэн сайхан хандлагаас болж сандрав. Исламын эргэн тойронд тарсны тохиолдолд энэ үйлийг зогсоохын арга үгүй гэж бодож байцгаав. Абиссинийн эзнээс мусульманчуудыг хойноос нь нэхэхээр шийдвэр гаргаж, шууд Абдуллах бин Рабиа ба Амр бин Асыг, Нэжаший болон дарга нарт нь өгөх янз бүрийн бэлгээр илгээцгээв.

Эбү Талиб нь Курайшчуудын Нэжашийд элч ба бэлэг илгээснийг мэдэнгээ, Нүүдэлчдийг мүшрикчүүдийн худлаас хамгаалахаар Нэжашийд хандаж, түүнийг магтсан нэгэн яру найраг бичээд илгээв. (Ибн-и Хишам, I, 356)

Амр ба анд нь, Нэжашийтай уулзахаас өмнө дарга нарт нь зарим бэлэг өгөөд тэднийг өөрийнх талдаа татахыг амжив. Мүшрик хамт олон дараа Нэжашийд бэлгээ өргөөд ингэж хэлэв:

“–Аяа Эзэн ээ! Биднээс зарим ухаан хүрэмжгүй залуус чиний нутагт ирээд хорогодов. Тэд овог дээдсийнхээ шашнаас халсан шигээ чиний шашинд ч ороогүй. Тэд шинэ нэгэн шашин бүтээв. Садан хамаатан нь тэднийг буцаах тулд биднийг чамд

илгээв. Учир нь аймаг нь эднийг хэнээс ч сайн мэддэг ба бурууг нь хэнээс ч сайн ойлгоно.”

Тэд нь Нэжашийг Жафар ба найзуудыг нь сонсч нөлөөнд орохоос айж байцгаав. Иймл учраас Нэжашийгийн Нүүдэлчдийг огт сонсолгүй өөрсдөө өгөхийг шаардаж байв.

Нэжашийгийн дарга нар ч:

“–Эзэн ээ! Энэ хүмүүс зөв хэлж байна. Аймаг нь тэднийг илүү сайн мэднэ. Чи эднийг энэ хүмүүст буулгаж өгөөд, тэд нутагтаа аваачиг!” гэцгээв.

Нэжаший нь уурлаад:

“–Болохгүй! Би тэднийг сонсолгүй шууд бууж өгөх биш юм! Намайг бусдаас илүүд үзээд нутагт минь ирсэн хүмүүст би муугаар хандаж болохгүй,” гээд, зарлагч илгээж нүүдэлчдийг дуудав.

Нэжаший нь өөрийн шашны зөвлөгчдийг ч дуудав. Тэд Нэжашийгийн эргэн тойронд номоо дэлгэрсэн буйгаараа сууцгаав.

Нүүдэлчдийг ирэхэд Нэжаший хоёр талыг шүтээндээ уулзуулав. Түүхийн нэгэн бишрэлт төрөв. Мусульманчуудын үг хэлэгч нь Хазрат-и Жафар -радъяллаху анх- байв.

Нэжаший нь Нүүдэлчдийн тэргүүй Жафар-и Тайяр луу эргэв:

“–Курайшчууд элч илгээжээ, таныг Маккад буцахыг шаардаж,” гэв.

Жафар нь эзэнд:

“–Аяа Эзэн ээ! Тэднээс асуугаарай; бид боол юм уу, яагаад биднийг нэхэж байгаа вэ?” гэв.

Нэжаший нь Амр бин Ас руу харав. Тэр хариулав:

“–Үгүй, бүгд чөлөөт!”

Яриа нь ингэж үргэлжлэв:

“–Тэднээс асуугаарай! Бид өртэй байна уу, биднийг юунд нэхэж байгаа вэ?”

“–Үгүй, хэн ч бидэнд өртэй биш!”

“–Тэднээс асуугаарай! Бид алуурч хүмүүс үү, биднийг юунд дуудаж байгаа вэ?”

“–Үгүй, ийм нэхэмж ч үгүй!”

“–Тэгвэл биднийг юу гэж нэхдэг вэ?”

Тэгэхээр Амр ингэж хэлэв:

“–Эд нар манай овог дээдсийн шашнаас халав. Бурхадыг маань доромжилно. Манай залуусын итгэлийг эвдэв. Ард түмэнд салалцаа орруулав. Хамаг Маккагийнхан хоёрт хуваагдав.”

Тэгэхлээр нь Нэжаший:

“–Та миний шашинд ч, улсынхаа шашинд ч ордоггүй байхаар, таны зөвшөөрсөн нь ямар шашин бэ? Гэж асуув.

Жафар-и Тайяар ярьж эхлэв:

“–Аяа эзэн ээ! Бид мунхаг нэгэн ард байв. Чулуугаар, модоор хийсэн баримлыг бурхан гэж шүтдэг байв. Үхсэн амьтдын махыг идэж, охидыг амьд байхад нь булдаг байв. Мөрий тоглож, мөнгө хүүлэх ажил хийдэг байв. Шалиг болон нэгэн эмэгтэйг нэгээс илүү эртэй харьцсан мухар байдлыг тоодоггүй байв. Садан хамаатандаа ямар үүрэгтэй буйгаа мэддэггүй байв. Хөршийнхөө эрхийг таньдаггүй байв. Хүчтэйчүүд

хүчгүйчүүдийг дарж, баяд нь ядуучуудаас олдог байв. Бидний хоорондо хэн ч эрх гэдгийн утгыг мэддэггүй байв.

Аллах Таала бидэнд энэрэл буулгаж биднийг боловсруулахыг хүсээд, манай дундаас бидэнд нэгэн Пайгамбар илгээв. Тэр Пайгамбар язгуурт нэгэн удам ба цэвэр нэгэн аймгаас мөн. Түүнийг өмнө нь «эл-Эмин» хэмээн нэрлэсэн байлаа. Тэр биднийг Аллахын шашинд урив. Тэрээрт залбирахыг сургав. Овог дээдсийнхээ баримлаас аврав. Ёс суртахуунгүй хамаг байдлыг холдуулав. Цус асгахыг, мөрий тоглохыг, архийг, мөнгөний хүүг, худлыг, өнчдийн өмчид гар хүргэхийг хориглов. Бидэнд байнга сайн сайхныг сургаж өгөв. Үнэнч байхыг, амласнаа хийхийг, хөрш ба садан хамаатандаа сайнаар хандахыг, эмэгтэйчүүдийн нэр хүндийг, охидын амийг аврахыг тушаав. Биднийг зэрлэг байдлаас аврав. Иргэншилд хүргэв. Сайн хүн болохыг хангав. Бид ч Түүнд итгэлээ. Түүний замаар л явна. Ийм л учраас Курайшчууд бидэнд дайсан болов. Бидэнд төрөл бүрийн тамлал хийцгээв. Гэтэл тамлал нь тэвчихээргүй болохлоор, бид ч шашнаасаа буцмааргүй буй тул, Пайгамбараасаа зөвшөөрөл авч эздийн дундаас таныг сонгож таны нутагт ирлээ. Таны нутагт харгислалтай тааралдахгүйгээ найдан таны хамгаалалтад орлоо!..”

Жафар -радъяллаху анх-ын хэлснийг чимээгүй сонссон Нэжаший:

“Аллахын онгоноос танай Пайгамбарт илгээсэн вахийгаас цээжилсэн хэсэг бий юу?” гэж асуув.

Жафар -радъяллаху анх-:

“–Тийм,” гээд Мэрьем Сурагийн анхны хэсгээс, Яхяа ба Есүс -алэйхимэссэлам-ын хорвоод мэндэлсний тухай аетуудыг

уншихлаар нь Нэжаший болон хамт олон нь нөлөөнд автаж уйлав.

Нэжаший:

“–Аллахад тагараглая, энэ үгс нь Хазрат-и Муса болон Хазрат-и Есүст буусан вахийн булгаас мөн,” гээд Курайшийн элч нарт эргэж:

“–Би энэ Нүүдэлчдийг танд буулгаж өгч болохгүй!” гээд тэдний саналыг татгалзав.

Элч нар Нэжашийгин хажуугаас салахдаа Амр:

“–Аллахад тангараг өргөе, Нэжашийд эдний Иса бин Мэрьемийн боол буйд итгэж үнэмшсэнийг хэлээд тэднийг гаргуулна!” гэв.

Дараа өдөр Нэжашийгийн онгонд гараад:

“–Аяа эзэн ээ! Тэд Иса бин Мэрьемийн тухай маш хэцүү үг хэлж байдаг! Хүсвэл хажуудаа дуудаад, Түүний төлөө юу хэлэхийг нь асуу,” гэв.

Нэжаший нь мусульманчуудыг дахиж дуудаад:

“–Мэрьемийн хөвүүн Есүсийн тухай юу бодож байгаа вэ, хэлээд үз,” гэв.

Жафар-и Тайяар Хазрат:

“–Бид Түүнийг манай Пайгамбарын сургасан шиг мэддэг. Аллахын Элч Түүний тухай ингэж айлдав:

«Иса нь Аллахын боол, Расул, Сүнс ба бүгдийг хаяж өөрийгөө Аллахад зориулсан Мэрьемд илгээсэн Үг мөн,»” гэхлээр нь Нэжаший гараас нэгэн өргөс авч:

“–Аллахад тангараг өргөе, Иса бин Мэрьем ч чиний хэлснээс өөр биш юм! Таны хэлсэнтэй Хазрат-и Есүсийн хэлсний хооронд энэ өргөсний чинээ ч ялгаа үгүй!” гэв.

Нэжашийн ингэж хэлэхлээр нь эргэн тойрны дарга нар бөвтнөж эхлэв. Нэжаший тэдэнд:

“–Валлахи та бөвтнөсөн ч үнэн ийм юм!” гэв.

Нүүдэлчдэд ч:

“–Сууцгаа! Та нар миний нутагт бүрэн аюулгүй юм! Танд хэлээ уртгасан хүнийг ялламуй. Улан чинээ алт ч өгсөн ч би танаас хэн нэгэнд зовлон учруулахыг хүсэхгүй. Авчирсан бэлгээ ч энэ хоёрт буцааж өгцгөө! Тэд надад хэрэггүй! Хэрэв би Хазрат-и Пайгамбарын дэргэд байсансан бол, Түүний хөлд ус асгаж, өөрт нь үйлчилдэгсэн!..” гэв. (Ибн-и Хишам, I, 356-361; Ахмад, I, 202-203, V, 290-291; Хэйсэмий, VI, 25-27)

Өөр нэгэн ярианд мэдүүлснээр Нэжаший ингэж хэлэв:

“Би Мухаммедыг Аллахын Элч гэдгийг гэрчилнэ. Тэр нь Хазрат-и Есүсийн мэдээлсэн хүн мөн. Хэрэв би энэ хаант гүрний тэргүүн ба хүмүүсийн хариуцлагыг ачсан болоогүйсэн бол Түүний гутлыг зөөхөөр дэргэд нь очиж байсан.” (Эбү Давуд, Жэнаиз, 55-57/3205)

❁

Хазрат-и Жафар -радъяллаху анх- нь Нэжашийд өгсөн хариугаараа Исламын тэблигчдэд, хаана яаж ярих хэрэгтэйн тухай сайхан нэгэн жишээ болсон ба байнга энэ аргыг дагах хэрэгтэй:

Түүнээс Кур’ан-и Кэрим уншихыг нэхэхлээр нь хамаагүй хэсгийг биш, тухайн байдалд хамгийн зохимжтой аетууд буюу Мэрьем Сурагийн Хазрат-и Есүстэй хамаатай хэсгийг уншаад

хариулсан нь магтмаар ухаан юм. Тэр чигээр нь мүшрикчүүдийн Нүүдэлчдийг буцааж авахаар илэрхийлсэн шалтгаанд оюун ухааны хариу өгөөд өөрсдөө ирсэн шашны үнэн, хууль ба сайхан ёс суртахууныг тушаасныг хэлсэн нь ч анхаарал татам юм.

Пайгамбар Эзний маань Нүүдэлчдийн хамт олонд тэргүүн болохоор Жафар -радъяллаху анх-ыг сонгосонд олон том учир байдаг. Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- ингэсэндээ удирдагчаар томилох хүмүүсийн, болох газар ба гавъяагаараа томилогдох хэрэгтэйг сургасан байдаг.

Абиссинийн хоёр дахь нүүдэлд оролцсон хэсэг Нүүдэлчид нь Пайгамбар Эзний маань Мадинад нүүсний дараа, нөгөө хэсэг нь ч Хүдэйбие Гэрээг болоход буцав.

Хазрат-и Жафар -радъяллаху анх-ын тэргүүлсэн сүүлийн хамт олон бол Хайбарын Ялалтаар Мадинад ирээд Хүндэт Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийг баясгав.

Хазрат-и Хамза Мусульман Болсон нь

Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- нь мүшрикчүүдэд Кабад Кур’ан-и Кэрим уншихаар зөвхөн асхабаа илгээдэггүй байв. Заримдаа өөрөө очоод Аллахын аетуудыг уншиж байв. Энэ удаа очиход нь Эбү Жэхил Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм-д дооромжлох маш их хэтрэв. Эргэн тойронд нь цугласан бусад мүшрикчүүд ч хүчээ үзүүлсээр байх юм шиг бүр догшрох гэж байхад, нэгэн эмэгтэй гүйгээд байдлыг ангаас буцаж буй Хазрат-и Хамзаад мэдээлэв:

“–Аяа зоригтуудыг зоригт! Кабад чиний ачид дооромжилж байцгаана; би Түүнийг тамлахаас нь айна!..” гэв.

Хазрат-и Хамза нь шууд Каба руу гүйж даруй хараалт Эбү Жэхилд саад болов. Барьсан нумаараа тэр толгой дээр нэг цохиод Эбү Жэхилийн толгойноос цус гоожиж эхлэв. Ийм нэгэн оролдлого болохыг таасангүй шашны дайсан нь андуураад амиа аврах сандралаар тэндээс зугтмаар холдов. Үүнийг харсан бусад мүшрикчүүд ч нэг хоёр гээд тарав. Учир нь бүгдээрээ Хамзагийн хүчийн маш сайн мэддэг байв. Курайшийн хамаг бөхчүүд түүнээс түдгэлзэж, өмнөөс нь гарах зорилго үзүүлж чаддаггүй байв.

Үүний дараа Хазрат-и Хамза нь Орчлонгуудын Эзэн буй ач Хазрат-и Мухаммед Мустафа -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн дэргэд очоод:

“–Чиний өшөөг авсан Мухаммед аа; одоо санаа амар бай!” гэв.

Хүндэт Расул бол авга ахынхаа ингэсэнд хариугаар:

“–Ахаа! Би бол чиний мусульман болоход санаа амарна!” гэхлээр нь Хазрат-и Хамзагийн сэтгэлийн мунхагийн хөшиг нь завсарлав. Тэр зоригт хүн, үнэнийг анзаарч ариун дүүдээ мишээж хараад Түүний агуу туяаг харсаар байж:

أَشْهَدُ أَنْ لاٰ إِلٰهَ إِلاَّ اللهُ وَأَشْهَدُ أَنَّ مُحَمَّدًا عَبْدُهُ وَ رَسُولُهُ

гээд кэлимэ-и шахадэт авчрав.

Хазрат-и Хамза -радъяллаху анх- нь Пайгамбараас маань хоёр ах бөгөөд Түүний авга ах ба сүүний дүү байв.[194]

Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-:

194. Хар. Ибн-и Хишам, I, 312-313; Хаким, III, 213; Ибн-и Кэсир, *эл-Бидая,* III, 84.

“Ахаа! Би бол чиний мусульман болоход санаа амарна!” хэмээж, өөрийнх өшөөг авахаар биш, түүний авралтайгаар хөөрөхөө хэлж, түр зуурын дэлхийн амьдрал биш, мөнхийн амьдрал чухал буйг илэрхийлэв.

Энэ явдал нь Исламыг дээшлүүлсэн үйлчилгээг биеийнхээ ашгаас байнга илүү үзэх хэрэгтэйг бөгөөд хувийн хэргээс шашны үйлчилгээний амжилттайгаар санаа амрах хэрэгтэйг бидэнд зааж өгдөг.

❀

Хазрат-и Хамза -радъяллаху анх-ын мусульман болсон өдөр Хазрат-и Эбү Бэкир -радъяллаху анх- Расулаллах Эзэнд маань бүгдээрээ Мэсжид-и Харам дээр очоод тэндэн хүмүүсийн Исламд урих тухай дахин дахин санаа оруулав. Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- бол:

“–Эбү Бэкир ээ! Арай бидний тоо маш цөөн,” хэмээв.

Хазрат-и Эбү Бэкир -радъяллаху анх-ыг цаашид албадахлаар, Пайгамбар Эзэн маань асхабнхаа хамт Дару’л-Эркамаас гарч Мэсжид-и Харамд очив. Кабад очиход Эбү Бэкир -радъяллаху анх- хүмүүсийг Аллах болон Элчид нь итгэж үнэмшихэд урьж эхлэхлээр нь мүшрикчүүд Хазрат-и Эбү Бэкир ба мусульманчууд дээр алхаж тэдний ширүүн зодож эхлэв. Ялангуяа фасик худалч Үтбэ нь Эбү Бэкир -радъяллаху анх-ын дээр гарч гишгээд, царайг нь төмөр ултай гутлаараа өшиглөв. Хазрат-и Эбү Бэкир -радъяллаху анх- цусаар булагдав. Аймаг нь Тэйтийнхэн Хазрат-и Эбү Бэкирээ мүшрикчүүдээс арай л аварч чадав.

Тэйтийнхэн түүнийг ухаан балартсан байхад гэрт нь аваачив. Үхэхийг нь бодоод, бүгдээрээ шууд буцаж Мэсжид-и Харамд ороод:

“–Хэрэв Эбү Бэкир үхэх юм бол, валлахи бид ч Үтбэг ална!” гэцгээв.

Хазрат-и Эбү Бэкир -радъяллаху анх- нь үдэш болох гэж байхад л ухаан оронгуут хамгийн түрүүнд үүнийг л асуув:

“–Расулаллах нь сайн уу?”

Ээж нь Үммү’л-Хайр байнга:

“–Юм хум идэж уугаарай!” гээд албадаад байв.

Хазрат-и Эбү Бэкир -радъяллаху анх- бол бараг түүнийг огт сонсохгүй юм шиг:

“–Расулаллах юу хийж байна, ямар байдалтай вэ?” гэж асуугаад байв.

Үммү’л-Хайр:

“–Миний хүү! Найзын чинь тухай би юм мэдэхгүй,” гэв.

Хазрат-и Эбү Бэкир -радъяллаху анх- ээжийгээ Расулаллахын тухай мэдээ авахаар мусульман нэгэн эмэгтэй байсан Үммү Жэмил[195] дээр илгээв. Үммү Жэмил -радъяллаху анхаа- ирээд Хазрат-и Эбү Бэкирийг ийм байдалтайг хараад бие барьж ядан хашхирав:

“–Аллахад тангараг өргөе, чамд үүнийг хийгсэд нь андашгүй ховчид ба кафирчууд мөн! Тэдний чамайг яасныг Аллах авах болтугай!” гэв.

Дараа нь Эбү Бэкирийг асуусны хариугаар Аллахын Элчийн мэнд сайхан ба Дару’л-Эркамд буйг мэдүүлэв.

Хазрат-и Эбү Бэкир -радъяллаху анх-:

195. Энэ эмэгтэй нь Үммү Жэмил бинт-и Хаттаб бөгөөд, мусульман байв. Түүнийг Эбү Лэхэбийн эхнэр Үммү Жэмилтэй андуурч болохгүй.

“–Аллахдаа тангараглая, Расулаллахыг харахгүй бол юу ч идээд уухгүй!” гэв.

Орчин тайвширч хүн бүр гэртээ очихлоор нь ээж нь ба Үммү Жэмил нь хоёр талаар нь дэмжиж Эбү Бэкир -радъяллаху анх-ыг Оршигчийн Туяаны дэргэв аваачив. Хазрат-и Эбү Бэкир -радъяллаху анх- нь Орчлонгийн Хүндэт -алэйхиссалатү вэссэлам- Эзнийг маань харангуутаа өвдгийг нь тэврэв. Үнэт андынхаа ийм байдал нь Орчлонгуудын Хаан Эзний маань уяхан зүрхийг хэт мэгшүүлэв. Хазрат-и Эбү Бэкир -радъяллаху анх-:

“–Аав ээж минь Чамд золиос болог, аяа Расулаллах! Надад ямар ч зовлон үгүй. Тэр бузар фасик нь манайг жаахан найгуулав!” гээд Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-ээс ээжийнхээ авралын төлөө залбирахыг нь гуйв.

Оршигчийн Туяаны залбирлын элбэгээр, Эбү Бэкир -радъяллаху анх-ын хүндэт эх ч итгэл үнэмшлийн чагтад оров.[196]

❀

Мусульманчуудын тоо хурдан өсч байсан ба Хазрат-и Хамза -радъяллаху анх- мэтийн баатруудын Исламд орсноор бүр сандарсан мүшрикчүүд уулзалт хийгээд энэ явдлын зогсоох тулд арга бодоцгоов:

“–Мухаммедын байдал бүрэн чухал болов, ажлыг эвдэв. Шившлэгт, мэргэ харахад, шүлэгт хамгийн эрдэмтээ Түүнд илгээж яриулъя!” гэцгээв.

Энэ ажилд Үтбэ бин Рабиаг зохимжтой гэж үзээд Хүндэт Нэбий -саллаллаху алэйхи вэ сэллэм- Эзэнд маань илгээцгээв. Үтбэ нь мүшрикчүүдийн өмнө нь оруулсан санааг илүү ихээр

196. Хар. Ибн-и Эсир, *Усдү'л-Габэ*, VII, 326; Ибн-и Кэсир, *эл-Бидая*, III, 81.

нь дахиж урт удаан ярив. Үгийг нь дуустал Аллахын Элч түүнийг чимээгүй сонсов. Дараа нь:

“–Эбү’л-Вэлид ээ! Хэлэх юм нь дуусав уу?” хэмээн асуув.

Үтбэ:

“–Тийм!” гэхлээр нь Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-:

“–Одоо чи ч намайг сонс!” хэмээв.

Бэсмэлэ татаж Фүссилэт Сураг уншиж эхлэв. Мөргөлийн ает буй 37-р аетыг уншиж мөргөсний дараа:

“–Эбү’л-Вэлид ээ! Миний уншсан юмыг сонслоо. Одоо чи энд, тэр тэнд!” хэмээв.

Үтбэг босоод найзуудынхаа дэргэд харьж байхад түүнийг харсан мүшрикчүүд:

“–Валлахи Эбү’л-Вэлид явснаасаа ялгаатай царайгаар ирж байна. Байдал нь бүх өөрчилжээ!” гэцгээв.

Хажуудаа хүрэнгүүт бишрэлттэйгээр Үтбэгээс:

“–Яриач, юу болсон бэ?” гэж асууцгаав.

Үтбэ:

“–Валлахи, би өнөөдөр хүртэл нэг ижлийг ерөөсөө дуудаагүй нэгэн үг сонслоо. Тэр нь шүлэг ч үгүй, шившнэг ч үгүй, мэргэ ч үгүй! Мухаммедыг:

فَاِنْ اَعْرَضُوا فَقُلْ اَنْذَرْتُكُمْ صَاعِقَةً مِثْلَ صَاعِقَةِ عَادٍ وَثَمُودَ

«Хэрэв нүүрээ буруулбал тэдэнд ингэж хэл: Би таныг Аад ба Сэмүдэд тохиолдсон цахилгааны төсөөт цахилгаанаар сануулав,»

(Фүссилэт, 13) гэсэнд, өөр уншихгүйн тулд гараараа амыг нь барьж, садан хамаатны эрхээр тангараглалаа. Мухаммедын хэлсэн үг бүр нь яг ёсоороо хэрэгжсэнийг мэддэг учраас бидэн дээр тамлал буухаас айлаа.

Курайшийн нийгэм ээ! Намайг сонсоорой! Түүнийг өөрийнх ажилтайгаар хамт үлдээж, битгий оролдоорой! Хэрэв Түүнийг Арабчууд албал, бусдын аргаар Түүнээс аврагдана. Хэрэв Тэр Арабчуудыг ээзлбэл, Түүний эзлэл таны ч эзлэл, Түүний хүч ба алдар нь таны хүч ба алдар гэсэн үг юм. Ингээд Мухаммедын ачаар хүмүүсийн хамгийн аз жаргалтай нь та л байх болно!" гэв.

Курайшчууд:

"–Эбү'л-Вэлид ээ! Тэр чамайг хэлээрээ илбэджээ!" гэхлээр нь Үтбэ:

"–Би ийм л бодолтой. Та яамаар байвал тэгж байцгаагаарай!" гэсэн хариуг өгөв. (Ибн-и Хишам, I, 313-314; Ибн-и Кэсир, *эл-Бидая,* III, 111-112)

Хазрат-и Умар Мусульман Болсон нь

Хазрат-и Умар -радъяллаху анх- нь Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-ээс арван гурав дүү юм. Угсаа нь есдүгээр аавд Пайгамбар Эзэнтэй маань нийлнэ.

Мүшрикчүүд зөвлөлцөх хурал байсан Дару'н-Хэдвэд цуглаж Хүндэт Элч Эзнийг маань алахаар шийдсэн байв. Үүнд дундаасаа зоригт, баатар ба хатуу зантай нэгэн байсан Умар бин Хаттабыг сонгож илгээсэн байв. Умар нь Орчлонгуудын Эзнийг алах зорилгоор мэдэлгүй замдаа гарав. Замдаа Нуайм бин Абдуллах -радъяллаху анх-тай тааралдав.

Нуайм нь Умарын байдлаас сэжиглэн:

“–Умар аа! Хааш явах гэж байна вэ?” гэж асуув.

Умар:

“–Овог дээдсийнхээ шашныг орхиж шинэ нэгэн шашин авчирсан Мухаммедыг алахаар явж байна!” гэв.

Нэвтэрхий ухаантай Нуайм -радъяллаху анх- нь цаг олох зорилгоор:

“–Умар аа! Валлахи нэфис чинь чамайгаа хуурчээ! Чи Түүнийг албал Абди Мэнафын удам чамайг амьд үлдээнэ гэж бодож байна уу?! Чи эхлээд өөрийнхөө гэр бүлд харсан нь дээр?” гэв.

Умар хилэгнэж:

“–Чи хэнийг гэж байгаа юм бэ!?” гэв.

Нуайм -радъяллаху анх-:

“–Хэн болох юм бэ? Чиний дүү Фатима хүргэн ах Сайд бин Зэйдийг хэлж байна! Валлахи хоёулаа ч мусульман болцгоов!” хариултыг өгөв.

Нуайм -радъяллаху анх- нь Умарын уг муухай хүслийг мэдэхлээрээ түүнийг дүү хүргэн ах хоёрын гэр лүү нь чиглүүлж байдлыг Аллахын Элчид мэдээлэхээр цаг олсон байв.

Нуаймаас эдгээрийг сонссон Умарын хилэн бүр хөөрч хэт их ууртайгаараа шууд охин дүүгийнхээ гэр лүү чиглэв.

Тэр хооронд охин дүү болон хүргэний нь хажууд Хаббаб -радъяллаху анх- байсан бөгөөд Кур’ан-и Кэрим зааж байв. Умарын уууртай тэдэнд рүү ирснийг харангаа, Хаббабыг гэрт

нэгэн өрөөнд нууцгаав. Фатима Хатан я шууд Кур’ан-и Кэрим хуудсыг далдлав.

Умар гэрт ормогцоо:

“–Тэр миний сонссон нь юу билээ?!” гэж хүрхрэв.

Дүү ба хүргэн нь:

“–Чи буруу сонссон бололтой, энд тийм юм үгүй!” гэцгээв.

Умар:

“–Үгүй! Валлахи та хоёрын ч Мухаммедын шашинд орсныг би мэдлээ!” гээд уууртайгаар хүргэн дээрээ алхав. Түүнийг занчиж эхлэв. Хооронд орсон дүү Фатимаг алгадав. Тэгсэнд нь Фатима:

“–Умар аа! Чи юу хүссэн ч хий! Хүсвэл биднийг ал! Бид Ислам шашнаасаа хэзээ ч болихгүй!..” гэв.

Фмтима -радъяллаху анхаа- нь итгэлийн зоригоор ийм үгсийг хашхирч байхад, ариун царайнаас нь торгомсог цус шүүрч байв.

Дүүгээсээ ийм хариу хүлээж байсангүй Умар цочив. Охин дүүгийнхээ царайн дахь цусыг ч харахлаараа дотроо нэгэн зовлон мэдрэв. Хийсэндээ гэмшиж:

“–Тэр уншиж байсан юмаа нэг аваад ир дээ!” гэв.

Охин дүү нь:

“–Бид чамайг хуудсыг яах бол гэж айж байна!” гэв.

Умар:

“–Битгий ай!” гээд түүнийг уншсаныхаа дараа буцаахаар бурхадын нэрээр тангараг өргөв.

Тэгэхлээр нь Фатима Хатан түүний мусульман болохыг найдан:

“–Миний дүү! Чи баримлыг шүтэж байхдаа цэвэр биш юм! Гэтэл Кур’ан бичсэн хуудсанд ариун бус нь гар хүрч болохгүй!” гэв.

Умар босоод биеэ угаасны дараа Фатима Хатан түүнд хуудсыг гардуулав. Тэгээд шинээр ирсэн ает-и кэримэнээдийг[197] уншиж эрлэв:

طه. مَا أَنزَلْنَا عَلَيْكَ الْقُرْآنَ لِتَشْقَى. إِلَّا تَذْكِرَةً لِّمَن يَخْشَى. تَنزِيلاً مِّمَّنْ خَلَقَ الْأَرْضَ وَالسَّمَاوَاتِ الْعُلَى. الرَّحْمَنُ عَلَى الْعَرْشِ اسْتَوَى. لَهُ مَا فِي السَّمَاوَاتِ وَمَا فِي الْأَرْضِ وَمَا بَيْنَهُمَا وَمَا تَحْتَ الثَّرَى. وَإِن تَجْهَرْ بِالْقَوْلِ فَإِنَّهُ يَعْلَمُ السِّرَّ وَأَخْفَى. اللَّهُ لَا إِلَهَ إِلَّا هُوَ لَهُ الْأَسْمَاء الْحُسْنَى. وَهَلْ أَتَاكَ حَدِيثُ مُوسَى. إِذْ رَأَى نَاراً فَقَالَ لِأَهْلِهِ امْكُثُوا إِنِّي آنَسْتُ نَاراً لَّعَلِّي آتِيكُم مِّنْهَا بِقَبَسٍ أَوْ أَجِدُ عَلَى النَّارِ هُدًى. فَلَمَّا أَتَاهَا نُودِي يَا مُوسَى. إِنِّي أَنَا رَبُّكَ فَاخْلَعْ نَعْلَيْكَ إِنَّكَ بِالْوَادِ الْمُقَدَّسِ طُوًى. وَأَنَا اخْتَرْتُكَ فَاسْتَمِعْ لِمَا يُوحَى. إِنَّنِي أَنَا اللَّهُ لَا إِلَهَ إِلَّا أَنَا فَاعْبُدْنِي وَأَقِمِ الصَّلَاةَ لِذِكْرِي. إِنَّ السَّاعَةَ ءاَتِيَةٌ أَكَادُ أُخْفِيهَا لِتُجْزَى كُلُّ نَفْسٍ بِمَا تَسْعَى. فَلاَ يَصُدَّنَّكَ عَنْهَا مَنْ لاَ يُؤْمِنُ بِهَا وَاتَّبَعَ هَوَاهُ فَتَرْدَى

197. Хазрат-и Умарын уншсан аетуудын Хадид Сурагийн анхны аетууд байсныг илэрхийлсэн байдаг. (Бэйхакий, *Дэлаил*, II, 217)

“Та-ха. (Аяа Мухаммед аа!) **Бид Кур’аныг Чамд төвөгт орох тулд буулгаагүй. Харин Аллахаас айсан хүний төлөө нэгэн сургаал болгож л** (буулгалаа.)

(Кур’ан нь) **дэлхий газар ба аугаа тэнгэрийг туурвисан Аллахын онгоноос хэсэг хэсгээр буулгав. Тэр Рахман нь** (хүч мэдлээрээ) **огторгуйд суурьшив. Тэнгэрийн, газрын, энэ хоёрын хоорондын ба хөрсний доорх ардууд бүгд Түүнийх мөн.**

Чи үгийг илрүүлсэн ч илрүүлээгүй ч ялгаагүй **Тэр нууцыг ч илүү нууцыг ч мэддэг.**

Аллах ижил хань өөр бурхангүй нэгэн мөн. Хамгийн гоё нэрс нь Түүнийх юм.

(Хабиб минь!) **Мусагийн туульс Чамд ирэв үү? Тэр нь нэгэн гал хараад гэр бүлийнхэндээ: «Эндээ байж бай, миний нүдэнд нэгэн гал тусав. Магадгүй танд цог авчирж эсвэл галын дэргэд нэгэн газарч л олж мэднэ,» гэсэн байв. Тэнд хүрэхлээр нь Түүнд** (манай талаас): **«Аяа Муса!» хэмээн дуудав: «Би андашгүй нь чиний Раб мөн. Шууд гутлаа тайл, одоо чи арриун хөндий Тувад орсон. Би чамайг сонгов, одоо** (чамд) **вахий болгох юмыг сонс.»**

Гарцаагүй Би Аллах мөн, Надаас өөр ямар ч бурхан үгүй. Тийм учраас Надад л боолчлогдож, Намайг дурдан мөргөл үйлд. Учир нь киямат нь заавал ирэх юм. Би түүний цагийг нууц байлгана, тэгээд хүн бүр хийсний хариуг үзэж аваг. Кияматад итгэлгүй өөрийнхөө дурыг дагасан хүн, чамайг түүнд итгэхээс битгий холдуулаг; эсвэл чи мөхнө.” (Та-ха, 1-16)

Эдгээр аетуудыг уншсан Умар бараг хөшиж үлдэв:

“–Энэ үгс нь ямар гоё вэ!” гэхээс аргагүй болов.

Кур’аны уран ба гоё хэллэг нь түүний хэт автсан байв. Эдгээр үгч хэн нэгэн хүний хэзээ ч хэлж чадахааргүй үнэн ба учраар дүүрэн байв. Хэсэг хугацаа гүн бодолд автав.

Хазрат-и Умарын үгсийг сонссон Хаббаб -радъяллаху анх- нуусан газраасаа гараад:

“–Умар аа! Валлахи Расулаллахын залбирал чамд л хүрнэ. Аллахын Элч өчигдөр:

«Аяа Раббий! Исламыг Эбү’л-Хазэм бин Хишам эсвэл Умар бин Хаттабтайгаар батлах болтугай!» хамаан залбирсан байв. Умар аа! Одоо Аллахаас ай!” гэв.

Хазрат-и Умар Хаттабт:

“–Хаббаб аа! Чи намайг Мухаммедийн буй газар аваачаад би мусульман болъё!” гэв.

Хоёулаа шууд замдаа гарав. Энэ удаагийн алхмууд итгэлийн хайр ба бишрэлтээр бүрдсэн, Расулаллахын үнэнийг ухаарч чадсаны дураар дүүрэн байв.

Хазрат-и Умарыг Эркамын гэрт очиход түүнийг Хазрат-и Хамза угтав. Нуруундаа сэлэмтэйгээрээ бэлэн байв. Учир нь Нуайм -радъяллаху анх- тэдэнд өмнөөс нь мэдээг хүргэсэн байв. Дараа юу болсныг бол хэн ч мэдээгүй байв.

Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- ч босоод Умарын тийш алхав. Түүнийг хашаан дотор уггаж юунд ирснийг асуув. Хазрат-и Умар учраа ийм баярын өгүүлбэрээр илэрхийлэв:

“–Мусульман болохоор ирлээ, аяа Расулаллах аа!”

Тэгэхлээр нь Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- нь Аугаа Эрхийн юуны хүч чадалтай буйг илэрхийлэх ба талархах учраар;

اَللّٰهُ اَكْبَرُ

тэкбир авчрав. Үүнийг сонссон хамаг асхаб чанга дуугаараа тэкбир авч эхлэв. Ингээд Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн өөр нэгэн залбирал хэрэгжсэн байв.

Хазрат-и Умар -радъяллаху анх- ярьж эхлэхдээ, сэтгэл ханамжтай анх хэлсэн нь кэлимэ-и шэхадэт болов:

أَشْهَدُ أَنْ لاٰ إِلٰهَ إِلاَّ اللّٰهُ وَأَشْهَدُ أَنَّ مُحَمَّدًا عَبْدُهُ وَ رَسُولُهُ

Пайгамбар Эзний маань залбирал Умар бин Хаттабт оносон байв. Эбү'л-Хакэм бин Хишам, алдаршсан нэрээрээ Эбү Жэхил бол унасан жаргалгүйн нүхэнд мөхөх байв.[198]

Хазрат-и Умарын Аллахын Элчийн өмнө кэлимэ-и шэхадэт хэлээд мусульман болсны араас, түүний санал болгосноор хамаг мусульманчууд хамтдаа Эркамын гэрээс гарцгаав. Тэкбир авчраад Каба руу алхаж эхлэв.

Энэ нь мүшрикчүүдийг нэлээд зовоов. Тэгээд Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- Хазрат-и Умарт үнэн худал хоёрыг ялгасан учраас "Фарук" цол олгов.[199]

Хазрат-и Умар тэдгээр өдрүүдийг дараа нь ингэж ярина:

198. Хар. Ибн-и Хишам, I, 365-368.
199. Хар. Диярбэкрий, I, 296.

“Мусульман болж харгислалтай тааралдаагүй хэн ч байгаагүй. Гэтэл надад хэн ч гараа хүргэж чадаагүй байв. Өөртөө яриад:

«Мусульманчуудыг янз бүрийн гайтай тааралдаж байхад би эсэн мэнд баймааргүй байна!»

Исламд орсон шөнөдөө бодоод, Маккагийн мүшрикчүүдээс Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн эсрэг өшөөндөө хамгийн их хэтэрч догширсон нь хэн байвал очоод түүнд мусульман болсноо хэлэхээр шийдэв. Өглөө болохлоор нь Эбү Жэхилийн хаалгыг тогшлоо. Үүдэнд ирээд:

«–Сайн явав уу, Умар аа! Ямар сонинтой вэ?» гэв.

Намайг:

«–Аллах болон Расулд нь итгэж Түүний авчирсан хамаг юмыг батласнаа чамд мэдээлэхээр л ирлээ!» гэхлээр, хараагаад хаалгаараа нүүрийг нь цохих шахан хаав.” (Ибн-и Хишам, I, 371)

Дараа нь Хазрат-и Умар -радъяллаху анх- нь Курайшийн догшин мүшрикчүүдээс нагац ах Вэлид бин Мугира болон үнэний дайсан өөр хоёр мүшрикэд ч очоод энэ сайхан мэдээг хүргэж, гэтэл тэднээс хэн ч түүнд юу ч хийж чадалгүй хаалгыг царайнд нь цохиж, гунигтайгаараа гэртээ орсон байв.

Абдуллах бин Мэс’үд -радъяллаху анх- ингэж хэлнэ:

“Хазрат-и Умарын мусульман болсон нь нэгэн ялалт, нүүсэн нь нэгэн тусламж, калиф болсон нь нэгэн рахмат байв! Умар -радъяллаху анх-ыг мусульман болтол нь бид Кабагийн дэргэд илээр мөргөж чадаагүй. Тэр мусульман болохлоороо Курайшийн мүшрикчүүдтэй байлдав, тэд ч бидэнд гар хүргэж чадаагүй. Ингээд тэнд мөргөл үйлдэж чадахаар болцгоов.” (Хэйсэмий, IX, 62-63)

Хазрат-и Ömer -радъяллаху анх- нь Хижрэт хүртэл Маккад Исламын төлөө хамаг хүчээрээ чармайж итгэгчдийн хамт маш олон төвгийг даав.

Номлохын Долоо-Ес Дэх Жил: Дарамт

Мүшрикчүүдийн Мусульманчуудыг Гадуурхах Бодлого:

Ислам нь саад болохоор бүх юмыг хичээсэн боловч өдөр тутам дэвшиж бөгөөд, энэ нь мүшрикчүүдийн өшөө ба хилэнг ихэсгэж байв. Үүнийг тэсч чадсангүй мүшрикчүүд нь Оршигчийн Туяаны эрхэм биеийг арилгаж орчлонг харанхуй-гаар даруулахаар амлалцав:

“–Түүнийг далдуур эсвэл илээр заавал ална!” гэж тангараг өргөцгөөв.

Эбү Талиб нь Курайшийн мүшрикчүүдийн ийм хэргийг хийхэд шийдвэртэй буйг харахлаараа, Аллахын Элчийн амь насанд санаа зовж эхлэв. Хашимынхан ба Мутталибынхныг цуглуулж, Орчлонгийн Хүндэт -саллаллаху алэйхи вэ сэллэм-Эзний маань дэргэд байх бөгөөд Түүнийг бүх төрлийн аюулаас хамгаалахыг тушаав.

Мухаррам сарын шинийн нэгний шөнө, Эбү Талиб тэргүүлснээр, Аллахын Элч, хамаг Хашимынхан ба Мутталибынхан нь Эбү Талибын хороололд цуглав. Зөвхөн Эбү Лэхэб тэдэнд оролцоогүй, мүшрикчүүдийн талд байсаар хандав.

Тэгэхлээр нь мүшрикчүүд Исламыг илүү тарагдаж хүч олоход нь завшаан олголгүй үгүй болгохын төлөө урвагч нэгэн төлөвлөгөө хийцгээв:

Эдийн засаг ба нийгмийн дарамт бий болгож шашны шинэ гишүүдийн бухимдуулаад чиглэсэн туяат зүгээс - буцаах!..

Ийм зорилгоор Эбү Жэхилд тэргүүлэн Хайф-и Бэний Кинанэд цугласан харанхуй зүрхнүүд нь мусульсанчууд ба тэднийг хамгаалсан Хаүимынхантай бүх төрлийн худалдаанаас охин авч-өгөх мэтийн хүмүүнлэгийн харьцуунууд хүртэл хамаг харьцаагаа тасалцгаав. Үүнийг нэгэн гэрээгээр батлан Кабагийн ханaнд өлгөцгөөв.

Гэрээний энэ хуудсыг Мансур бин Икримэ бичсэн байв. Хуудсыг бичсэн өдөр Аллахын Элчийн залбирлын нөлөөгөөр гар нь хувхайрав. Тэгэхлээр нь мүшрикчүүд хоорондоо:

"–Биднийг Хашимынханд харгисласан тул Мансурт гай тохиов!" гээд эхлэв. (Ибн-и Хишам, I, 372-373; Ибн-и Са'д, I, 208-209; Бухарий, Хаж, 45)

Энэ бойкотын дүнгээр, өмнө нь Маккагийн тустай хороололд нь тараамал суурьшиж байсан мусульманчууд, хоорондын харьцааг илүү амраар хийх тулдаа Ши'б-и Эбий Талиб хэмээн, Хазрат-и Пайгамбарын авга ахын хороололд нүүцгээв. Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- ч Эркамын гэрээс гарч уг хороололд суурьшив.

Эбү Талиб нь ямар нэгэн муухай үйл эсвэл халдлагын эсрэг чадах хамаг арга хэмжээгээ авч байв. Пайгамбар Эзэн маань орой хэвээрээ орондоо хэвтэж, шөнө хүмүүс нойрондоо орсны дараа Эбү Талиб нь хөвүүдээс, дүү нараас эсвэл садан

дүү нараас нэгийг Аллахын Элчийн оронд илгээж, Эзнийг маань ч түүний оронд илгээж байв.[200]

Мусульманчуудын хувьд маш том гачигдлын эрин эхэлсэн байв. Эбү Жэхил ба түүний догшин андууд нь өдөр шөнөгүй мусульманчуудын хорооллыг манаж, тэнд нууцаар хүнс ороход саад болохы хичээж байв.

Зах зээлийн мусульманчуудын тийш явсан хамаг замыг нь хаав. Зарахаар ирсэн хүнсний барааг мусульманчуудад үлдээлгүй өөрсдөө худалдаж авдаг байв. Мусульманчууд зөвхөн хажжийн улиралд Эбү Талиб хорооллоос гарч чаддаг байв. Итгэгчдээс нэгэн гэрийнхэндээ жаахан идээ авахаар хэн нэгэн худалдагчид очвол, Эбү Лэхэв шууд бараан дээр зогсч:

"–Наймаачид аа! Үүнийг Мухаммедын найзуудад хэт ихэсгээд, тэд танаас юм авч эс чадаг! Та намайг баян ба амласнаа хэрэгжүүлдэг хүн буйг мэднэ. Ингэсэн тохиолдолд танд ямар нэгэн аюул тусахгүйг нь би батлан даана!" гэдэг байв.

Мусульманчууд өлссөнөөсөө уйлдаг хүүхдүүдээ идэх юм авч чадалгүй харьдаг байв. Наймаачид нь дараа өглөө Эбү Лэхэбийн дэргэд очоод, тэр ч үлдсэн барааг өндөр үнээр өөрөө авдаг байв.[201]

Ийм хэцүү байдалд Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- ба Хазрат-и Хатижа эх маань хамаг хөрөнгөө мусульманчуудын төлөө зарцуулав.[202]

Мүшрикчүүд хорооллын замыг хаахад дээд зэргийн анхаарал үзүүлсэн ч зарим Маккагийнхан садан хамаатандаа нууцаар тусламж илгээдэг байв. Хаким бин Хизам нь нэгэн жингээр

200. Ибн-и Кэсир, *эл-Бидая,* III, 132.
201. Сүхэйлий, II, 127-128.
202. Я'кубий, II, 31.

Дамаскаас буудай авчирсан байв. Нэгэн тэмээнд буудай ачиж нууцаар хорооллын замд авчраад мусульманчуудад илгээв. Тэд ч тэмээн дээрх буудайг буулгаж авав. Өөр нэгэн шөнө ч тэмээнд гурил ачиж хороололд хүргэв.

Хишам бин Амр ч тэр чигээр мусульманчуудын нэгэн байв. Хишамын хэдэн тэмээний ачаагаар хүнс илгээснийг мэдсэн хүн чанараар ядуу мүшрикчүүд түүнийг маш хатуу үгсээр сүрдүүлэв. Сануулга өгсөн ч Хишам садан хамаатандаа тусалсаар байхад, мүшрикчүүд муухай үгс хэлээд түүнийг түлхэж үймүүлж эхлэв. Эбү Сүфьян хооронд нь орж алахад саад болж:

“–Эрийг тавь! Садан хамаатандаа тусалжээ! Бид ч түүн шиг хийж чадсансан бол сайхан болохсон!..” гээд Хишамыг хадгалав.

Уг эринд мусульманчууд маш том зүдүүр ба гачигдлыг тэсээд өнгөрөөв. Заримдаа гэдсээ модны навчаар цатгах ёстой болов. Хүүхдүүд нь өлсгөлөнгөөр үхэж байв.. Тэдний орилоон нь хорооллын гаднаас ч сонсогдохоор болсон байв.

Мүшрикчүүдийн ийм бүслэлт хийхдээ зорилго нь Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийг тэдэнд бууж өгтөл мусульманчуудыг өлөн үлдээж, ингэхдээ Аллахыг Элчийг алж чадах завшаан олох байв. Гэтэл Эбү Талибаар захирагдсан Хашимынхантай нэгдсэн мусульманчууд Оршигчдын Туяаг хамгаалахаар, шаардвал цусаа сүүлийн дусал хүртлээ зориулахад шийдвэртэй байв.

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- Эзэн маань Маккачуудын тамлал ба харгислал нь хэт хязгаарт хүрэхлээр ариун гараа тэнгэр өөд дэлгэж Курайшийн мүшрикчүүдийн тухай ингэж хараав:

"–Аяа Раббий! Уг харгис ардад, Юүсүф -алэйхиссэлам-ын эринийх шиг долоон жилийн гандах тамлал өгөөд надад туслах болтугай!"

Тэгээд бороо тасрав; Курайшийн мүшрикчүүд маш хатуу ширүүн ганд нэрвэгдэж , бүх юмыг хатаав ! Ихэнх нь өлсөж үхэв! Идэх юм олохгүй тохиолдолд үхсэн амьтдын махыг, арьсыг идэж эхлэв. Тэднээс хэн нэгэн толгойгоо тэнгэр өөд өндийлгөвөл, өлссөнөөсөө орчныг утаа бүрдсэн шиг хардаг байв!

Аллах Таала Кур'ан-и Кэримд үүнийг ингэж дурдана:

فَارْتَقِبْ يَوْمَ تَاْتِي السَّمَآءُ بِدُخَانٍ مُبِينٍ
يَغْشَى النَّاسَ هٰذَا عَذَابٌ اَلِيمٌ

"Одоо чи тэнгэрийн хүмүүсийг бүрдэх утаа гаргах өдрийг манаад бай. Энэ нь санаа зовохоор нэгэн тамлал мөн." (эд-Духан, 10-11)

Энэ ганг нь хэт ширүүдэхлээр нь Эбү Сүфьян нь Орчлонгуудын Эзэнтэй зөвлөлцөөд:

"–Аяа Мухаммед аа! Чи энэрлээр илгээгдсэнээ хэлж, Аллахад бууж өгөх ба садан хамаатандаа туслахыг тушаана. Чиний ард бол үгүй болох гэж байна! Тэднээс уг гамшгийг холдуулаач Аллахад залбираад өгөөч! Хэрэв Чиний залбирлын ачаар Аллах энэ гамшгийг биднээс холдуулах бол, бид Аллахад итгэнэ!" гэв. Дараа ч тангараг өргөж амлав.

Тэгсэн, Орчлонгийн Хүндэт -саллаллаху алэйхи вэ сэллэм- Эзэн маань залбирав. Бороо оров. Ган тайлагдав. Амарт хүрсэн мүшрикчүүд бол дахиад ширкдээ харив.[203]

---

203. Бухарий, Тэфсир, 30, 44; Мүслим, Мүнафикийн, 40; Ахмад, I, 431, 441.

Аугаа Эрх нь күфүрийн хүмүүсийн сэтгэлийн ийм байдлын тухай ингэж айлдана:

وَاِذَا مَسَّ الْاِنْسَانَ الضُّرُّ دَعَانَا لِجَنْبِهٖٓ اَوْ قَاعِدًا اَوْ قَآئِمًا فَلَمَّا كَشَفْنَا عَنْهُ ضُرَّهُ مَرَّ كَاَنْ لَمْ يَدْعُنَآ اِلٰى ضُرٍّ مَسَّهُ كَذٰلِكَ زُيِّنَ لِلْمُسْرِفِينَ مَا كَانُوا يَعْمَلُونَ

“Хүн үнэхээр хэцүүдэхдээ хэвтэж байхдаа, эсвэл сууж байхдаа, зогсож байхдаа ч Бурханд залбирна; харин саад бэрхшээл арилангуут, бараг тэр хэцүү байдлаас болж огт залбираагүй юм шиг аашилна. Хэтрэгсдэд хийсэн үйлийг нь ингэж чимэгтэй үзүүлсэн байдаг.” (Юүнүс, 12)

Дарамт Дууссан нь

Арвин гашуудлаар өнгөрсөн гурван жилийн эцэст, Аллах Таала мүшрикчүүдийн Кабад өлгөсөн гэрээний хуудсанд модны хорхойг дайруулав. Хорхой нь хуудсан дахь “Бисмикаллахүммэ: Аяа Аллах минь, Чиний нэрээр эхлэе” гэсэн өгүүлбэрээс гадна, харгислал илэрхийлсэн хамаг юмыг идэв. Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- Түүнд вахийгаар мэдээлсэн энэ байдлыг авга ах Эбү Талибдаа хэлэв. Эбү Талиб энэ мэдээг дүү нартаа дамжуулан:

“–Хамгийн гоё хувцсаа өмсч Курайшчуудын дэргэд очицгоо! Өөрсдөө анзаарахаас өмнө хуудсанд юу болсныг тэдэнд мэдүүл!” гэв.

Эбү Талиб ба дүү нар нь энэ мэдээг мүшрикчүүдэд хүрэхэд яаралтай нэг хүн илгээж хуудсыг авчруулаад, түүнийг Аллахын

Элчийн хэлснээр л олов. Курайшчууд аргагүй бууж өгөв! Эбү Талиб үүнээс хүч ба зориг олоод:

“–Одоо тамласнаа, садан хамаатантайгаа харьцаагаа тасалж муухай хандсанаа та ч ойлгоо биз дээ?!” гэв.

Мүшрикчүүдээс хэн ч Эбү Талибд хариу өгөөгүй. Зөвхөн:

“–Энэ нь илбэнээс өөр юм биш!” гээд нүүр буруулан харгислалаа үргэлжлүүлэв.

Курайшийн чухал хүмүүсээс зарим нь бол Хашимынханд хийс зүйлсээс болж нэг нэгээ буруушаав:

“–Дүү нартаа бидний энэ хийсэн нь харгислалаас өөр юм биш!” гэцгээв.

Номлохын арав дахь жил болсонд, Курайшчуудаас хэдэн хүн бойкотыг өлгөхөөр хөдлөв. Хишам бин Амр нь Зүхэйр бин Үмэйед:

“–Зүхэйр ээ! Нагац нар чинь юм худалдахаас, гэрлэх мэтээс гачаад оруулаад хоосон шамлаж байхад, өөрөө дураараа идэж ууж, өмсөөд явахдаа сэтгэл чинь яаж ханамжтай болж байна вэ? Валлахи Эбү Жэхилийг өөрийн нагац нарынх нь эсрэг ийм нэгэн гэрээнд урьсансан бол, тэр ерөөсөө зөвшөөрөхгүй байсан,” гэв.

Хишам нь Зүхэйрийг ятгасны дараа Мут’им бин Адийй, Эбү’л-Бахтэрий ба Зэм’а бин Эсвэлийг ч нэг нэгээр өөрийнх талдаа татав. Энэ таван хүн Маккагаас дээш Хажун гэсэн газар шөнө цуглаж юу хийх хэрэгтэй тухайгаа ярилцав. Гэрээг эвдэртэл хичээхээр амлалцав.

Өглөө болохлоор Мэсжид-и Харам очицгоов. Зүхэйр үнэтэй хувцас өмссөн буйдаа Кабаг эргэж:

“–Маккагийнхан! Биднийг дураараа идэж ууя, хувцас өмсөе, Хашимынхан болон Мутталибынхан худалдаанаас гачигдаж мөхөг гэвэл, энэ нь болох үйл юм уу?! Аллахад тангараглая, садан хамаатны холбоог тасалсан уг хуудсыг уртал нь би суухгүй!” гэв.

Эбү Жэхил эсэргүүцсэн ч бусад дөрвөн найз нь өмнө тохиролдсоноор Зүхэйрийг дэмжихлээр гэнэтхэн зэрэг нэгэн агаар биелэв. Мут’им босч Забагийн хананд өлгөсөн хуудсыг урав. Тэгэхлээр нь Адийй бин Кайс, Зэм’а, Эбү’л-Махтэрий ба Зүхэйр нь зэвсэглэн Хашимынхан ба Мутталибынханы дэргэд очоод, тэднийг Эбү Талиб хорооллоос гаргаж гэртээ харихыг нь хангав. Ингээд мусульманчууд нь гурван жилийн хэцүү бүслэлтээс Аллахын соёорхлоор аврагдав. Эбү Талиб нь дарамт цуцлагсдыг шүлгээрээ шагшив. Мүшрикчүүд ч Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн Исламыг тэблиг хийхэд саад болж чадахгүйгээ ухаарч найдвараа алдав.[204]

Ийм давсан зовлон ба төвөг нь мусульманчуудын итгэлийг нэмж харьцааг бүр батлуулав. Кафирчууд ч хэвээрээ алдагдлаас өөр юм олж чадаагүй.

❁

тэблиг эхэлсний найм дахь жилд Иранчууд Римийг (Бизанти) ялсан байв. Римийн хотуудыг шатааж нураасан, Истанбул хүртэл ороод Бизантын Императорыг хүнд нөхөн төлөхөд албадсан байв.

Иранчууд баримал шүтэгч байсан тул мүшрикчүүд тэдний ялалтанды маш их баясав. Номын улсаас буй Римчүүдийн ялагдсан нь Орчлонгийн Хүндэт Эзнийг маань маш их зовоов. Тэгэхлээр нь Аллах Таала энэ тухай уг аетуудын буулгав:

204. Хар. Ибн-и Хишам, I, 397-406; Ибн-и Са’д, I, 210-211.

الم. غُلِبَتِ الرُّومُ. فِي أَدْنَى الْأَرْضِ وَهُم مِّن بَعْدِ غَلَبِهِمْ سَيَغْلِبُونَ. فِي بِضْعِ سِنِينَ لِلَّهِ الْأَمْرُ مِن قَبْلُ وَمِن بَعْدُ وَيَوْمَئِذٍ يَفْرَحُ الْمُؤْمِنُونَ. بِنَصْرِ اللَّهِ يَنصُرُ مَن يَشَاءُ وَهُوَ الْعَزِيزُ الرَّحِيمُ

“Элиф. Лам. Мим. Римчүүд хамгийн ойр нэгэн газар ялагдав. Гэтэл тэд нь энэ цөөн хэдэн жилийн дараа ялах болно. Эцэст нь тушаал Аллахын мөн. Тэр өдөр итгэгчид ч Аллахын тусламжаар баясана. Аллах хүссэндээ тусална. Тэрээр Азиз, энэрлээрээ итгэгчдийг хамгаалагч **Рахим мөн.”** (эр-Рум, 1-5)

Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-:

“–Пэрсчүүд заавал хожигдоно!” хэмээн айлдав. (Ахмад, I, 276)

Энэ тэнгэрлэг мэдээллийг мэдсэн Эбү Бэкир -радъяллаху анх- нь мүшрикчүүдээс Үбэй бин Халэфтэй Римийн гурван жилийн хугацаанд Пэрсийг хожихоор арван тэмээгээр мөрий тавив.[205]

Хазрат-и Эбү Бэкир -радъяллаху анх- энэ мөрийг Аллахын Элчид мэдээлэхээр Тэр:

“–Ает дахь «бид’» гэсэн үг нь гурваас есний хоорондын тоог илэрхийлнэ. Чи яаралтай яв, тэмээний тоог нэмж, хугацааг нь сунга!” хэмээв.

Хазрат-и Эбү Бэкир -радъяллаху анх- очоод хугацааг арван жилд, тэмээний тоог ч зуу гаргав.

Римчүүд гэнэтхэн хөгжиж Иранчуудыг хүнд дарав. Үүнийг мэдэнгээ Эбү Бэкир -радъяллаху анх- нь Үбэйгийн өвөөс зуун

205. Энэ байдал нь мөрий тоглох хориглосноос өмнө болсон байв.

тэмээг аваад Пайгамбар Эзэнд маань хүргэж өгөв. Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-:

“–Эдгээрийг ядуучуудад тараа!” хэмээн айлдав.

Тэр ч ядуучуудад тараав.

Кур’ан-и Кэримийн уг гайхамшгийг харсан Маккагийн мүшрикчүүдээс ихэнх нь мусульман болов.[206]

Шакк-и Камэр: Саран Хоёр Хагалсны Гайхамшиг

Аугаа Эрх нь зөв замд урихаар томилсон пайгамбарыгаа, олон нийтийг нөлөөлж тэднийг итгэл үнэмшилд татах ер бусын мэдэлтэйгээр бэлтгэсэн байв. Энэ нь тэдний тааралдах зөрүүд күфүрийг дийлэхийн төлөө байдаг. Түүнчлэн пайгамбарчуудад олон нийтийг дагуулах тулд зарим ер бусыг гайхамшиг ч хайрласан ба эдгээрийг “мүжизэ” гэж нэрлэдэг.

Мүжизэчүүд нь пайгамбар бүрт, тус бүрийн эринд хүний гайхлыг татсан хүчээр толилуулсан авъяасны дагуу хайрласан байдаг. Жишээлбэл, Хазрат-и Муса -алэйхиссэлам-ын эринд илбэ нь оргилд байв. Ийм учраас Түүнд энэ гайхамшгийг хайрлав: Таяг ба Ед-и Бэйза.[207]

Хазрат-и Есүсийн эринд анагаах ухаан хөгжсөн бөгөөд эмч нар ардын хараанд агуу өндөр байр олсон байв. Ийм л учраас Түүнд ч хамгийн авъяастай эмч нарыг ч аргагүй болгох нэгэн гайхамшгийг хайрлав: Шарилыг амьд оруулах.

206. Хар. Тирмизий, Тэфсир, 30/3194; Куртубий, XIV, 3.
207. Ед-и Бэйза буюу цагаан гар нь Хазрат-и Мусад хайрласан есөн гайхамшгийн нэгэн юм. (Хар. эл-А’раф, 108; эл-Исра, 101; Та-ха, 22; эш-Шуара, 33; эн-Нэмл, 12; эл-Касас, 32) Тэр нь гараа гаргангуут бүх талыг гийгүүлдэг, бараг нар туссан шиг харагддаг байв.

Пайгамбар -алэйхиссалатү вэссэлам-ын номлох нь бол киямат хүртлийн хамаг цаг ба орнуудад хандсан тул Тэр нь өмнөх пайгамбарчуудын бүгдийн эрх, мэдэл ба гайхамшгийг эзэмшсэн бөгөөд энэ бүхнээс ч дээш байдаг. Үүнээс үзвэл Түүний гайхамшиг нь эриний хамгийн нөлөөт мэргэжил асан уран ба гоё хэллэгтэй хязгаарласангүй бөгөөд янз бүрийн орон газар хандсан байдалтай хэрэгжсэн байдаг. Эдгээрээс нэгэн ч дээр тайлбарласан харгис мүшрикчүүдийн дарамтын улмаас ядарч туйлдсан итгэгчдийн сэтгэлд нь нэгэн ариун агаар, хүч ба найдварын ундаа дайлах ба мүшрикчүүдэд бол эсэргүүцсэн энэ шинэ байгууллагын хүчний хил хязгаарын тухай сануулга олгох учиртай хэрэгжсэн “Шакк-и Камэр” буюу “Сар хоёр хагарсны” гайхамшиг мөн.

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн энэ агуу гайхамшиг нь дарамтын хугацаанд, Маккагийн эриний ес дэх жилд хэрэгжсэн байв.

Тэргэл сартай нэгэн шөнө Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- нь Рабдаа залбирсан ба Сарыг хоёр хувааж энэ гайхамшиг нь бүх талаас харагдсан байв. Сарыг хоёр хагалаады тал нь Эбү Күбэйс Уулны тийш, нөгөө тал нь Куайкъян Уулны тийш харагдав. Мүшрикчүүд энэ гайхамшгийг нүдээрээ ил далангүй харсан ч итгэх үнэмшихээс татгалзав. Түүнчлэн Эбү Жэхил нь «Энэ нь нэгэн илбэ мөн!» гээд энэ гайхамшгийг ч үгүйсгэ.

Энэ гайхамшгийг харсан мүшрикчүүд Хазрат-и Пайшамбарын -саллаллаху алэйхи вэ сэллэм- тухай:

“–Биднийг илбэдсэн, гэтэл хүн бүрийг илбэдэж чадахгүй!” гэцгээв.

Иэгэхлээр нь Маккагийн гаднаас хол газраас ирсэн жингүүдээс ч ийм байдал харсан эсэхийг асууцгаав. Тэд ч сарны хагарсныг харснаа мэдэгдэв.

Энэ байдлын дараа энэ ает-и кэримэ буув:

اِقْتَرَبَتِ السَّاعَةُ وَانْشَقَّ الْقَمَرُ

وَاِنْ يَرَوْا اٰيَةً يُعْرِضُوا وَيَقُولُوا سِحْرٌ مُسْتَمِرٌّ

“Киямат дөхөөд Саран хагарав. Тэд нэгэн гайхамшиг харвал, шууд царайгаа эргүүлэн: «Дээр үеэс үргэлжилсээр буй нэгэн илбэ юм,» гэцгээнэ.” (эл-Камэр, 1-2) (Вахидий, х. 418; Тирмизий, Тэфсир, 54/3286)

Хамаг Маккагийнхан Сарны хоёрт хагарсныг зөвшөөрөв. Зүрхэндээ авралын гэрэл байгсад нь Хүндэт Элч Эзнийг маань батлав; цоожтой зүрхнүүд бол “Ямар агуу илбэчин бэ!” гэцгээв.

Үүнтэй хамаатай Францын алдартай огторгуйн эрдэмтэн Лөфрансуа дө Лаланд нь Сарны өнгөрсөн хөдөлгөөнийг шинжлэхдээ “Шакк-и Камэр” гайхамшиг болсон нь үнэн гэдгийг хүлээн зөвшөөрөхөөс аргагүй болов.[208]

❁

Аугаа Эрхийн пайгамбачууддаа хайрлаж өгсөн гайхамшгийн учрыг хэдэн зүйлээр товчлох гэсэн юм бол эдгээрийг хэлж мэднэ:

1. Олон нийтийг нөлөөлж хүмүүсийг итгэл үнэмшилд татах.

208. Хар. Зэкаи Конрапа, х. 110.

2. Итгэгчдийн итгэл үнэмшлийг нэмэн, сэтгэлийг нь тайтгаруулах.

3. Пайгамбарчуудын нүбүввэт болон рисалатыг нь батлах.

4. Тэнгэрлэг хүчээр үгүйсгэгчдийг хожиж, итгэгчдийг гайхуулах.

Кур'ан-и Кэримийн тус бүр ает нь итгэгчдийн итгэлийг, үгүйсгэгчдийн үгүйсгэл ихэссэн шигээ гайхамшиг ч тухайн "ла ехдий" хэмээн айлдсан, өөрөөр хэлбэл Раббын аврал хайрлахгүй хүмүүсийн үгүйсгэлийг ихэсгэнэ.[209]

"Шакк-и Камэр" байдал нь Пайгамбар Эзний маань том гайхамшиг мөн. Пайгамбар Эзэн маань "Төгсгөл Үеийн Нэбий" байсан тул Түүний дэлхийд илэрсэн нь, мөн кияматын шинж тэмдгээс нэгэн мөн. Энэ тухай ает-и кэримэ:

اِقْتَرَبَتِ السَّاعَةُ وَانْشَقَّ الْقَمَرُ

"Киямат дөхөөд Саран хагарав," (эл-Камэр, 1) хэмээн айлдаж энэ үнэнийг илэрхийлдэг.

---

209. لاَ يَهْدِى: **Аллах аврал хайрлахгүй.** Энэ үг Кур'ан-и Кэримд нийт 26 аетад дурддаг. Жишээлбэл:

وَاللّٰهُ لاَ يَهْدِي الْقَوْمَ الظَّالِمِينَ

"…Аллах, харгис хүмүүсийг авралд хүргэхгүй," (эл-Бакара, 258)

وَاللّٰهُ لاَ يَهْدِي الْقَوْمَ الْكَافِرِينَ

"…Аллах, кафирчуудыг авралд хүргэхгүй," (эл-Бакара, 264)

وَاللّٰهُ لاَ يَهْدِي الْقَوْمَ الْفَاسِقِينَ

"…Аллах, фасикчуудын нийгэмд аврал хайрлахгүй," (эл-Маидэ, 108) ает нь үүний жишээ мөн.

Пайнамбар Эзэн маань Ямар ч Тохиолдолд Тэблигээ Үргэлжлүүлсэн нь

Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- нь ардынхаа хамаг төвөг ба харгислалыг тэсч өнгөрөөсөн ч үнэнд урихаа хоромхон болихгүй байв. Завшаан бүрт хүмүүсийг авралтад дуудаж, тухайн хүний байдлын дагуу тустай аргаар хандаж байв.

Курайшчуудын хамгийн хүчтэн босоо бөхчүүд асан Рүканэ нь нэгэн өдөр Маккагийн нэгэн хөндийд Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-тэй таарaлдсан байв. Пайгамбар Эзэн маань түүнд:

"–Рүканэ! Чи одоо ч Аллахаас айхгүй, Исламыг зөвшөөрөхгүй эсэргүүцээд байгаа юу? Ирээд мусульман бол!" гээд Исламд урив.

Рүканэ:

"–Аяа Мухаммед аа! Чи надтай барилдаад давбал Чамд итгэнэ!" гэв.

Хүндэт Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-:

"–Би давбал үнэхээр итгэж үнэмших үү?" хэмээн асуув.

Рүканэ:

"–Тийм, Чи намайг хожвол би Исламд орно, эсвэл тэд хонь минь Чиний байх болно! Би Чамайг хожих болбол Чи энэ пайгамбар ажлаа боль!" гэв.

Тэр хоёр барилдав. Орчлонгийн Хүндэт -саллаллаху алэйхи вэ сэллэм- түүнийг давлаа. Рүканэ өөрийгөө хамгаалж чадаагүй.

"–Аяа Мухаммед! Дахиад нэг барилдая!" гэв.

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- дахиад барилдад дахиад түүнийг давав.

Рүканэ:

“–Авга ахын хүү! Дахиад нэг барилдая?” гэв.

Гурав дахь удаа унасан Рүканэ дахиад итгэж үнэмшээгүй.

Оршигчдын Туяа нь Рүканэг итгэж үнэмшээгүй бөгөөд тэр хооронд хэлсэн зарим үгсэнд их санаа зовов. Түүнд:

“–Талаа аваад яв!” хэмээв.

Тэгэхлээр нь Рүканэ:

“–Валлахи Чи надаас илүү буянтай, илүү алдартай!” гэв.

Рүканэ -радъяллаху анх- олон жилийн дараа Маккагийн ялалтын өдөр мусульман болж, Мадинад очоод тэнд суурьшсан байв. (Ибн-и Хишам, I, 418; Ибн-и Эсир, *Усдү’л-Габэ,* II, 236)

Нэг удаа ч Эзд-и Шэнүэ аймгаас Дямад бин Са’лэбэ нь үмрэ хийхээр Маккад ирсэн байв. Дямад эмч болохыг хүссэн, сэтгэл мэдрэлийн өвчнийг эмчилдэг ба шинжлэх ухаанд хүрэхийг хичээсэн нэгэн байв. Мүшррикчүүдийн “Мухаммед зүгээргүй юм!” гэснийг сонсоод өөртөө:

“–Би очоод энэ хүнийг нэг харъя. Магадгүй Аллах Түүнд миний ачаар эрүүл мэнд өгнө,” гээд мүшрикчүүдийн хурлаас босов. Пайгамбар Эзэнд маань очоод:

“–Аяа Мухаммед! Би сэтгэл мэдрэлийн өвчнийг анагаана. Хүсвэл Чамайг ч анагаая. Магадгүй Аллах Чамд эрүүл мэнд өгнө!” гэв.

Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- Дямадад ийм хариу өгөв:

"–Хамд нь Аллахын юм. Бид Тэрээрт хамд хийж, тусламж ба өршөөлийг ч Түүнээс гуйна. Нэфсүүдийнхээ муу муухайнаас Аллахад хоргодоно. Аллахын авралд хүргэснийг төөрүүлэх нь үгүй. Төөрүүлснийг нь ч аврах нь үгүй. Би Аллахаас өөр бурхан үгүйг гэрчилнэ. Тэрээр цорын ганц мөн. Ижилгүй юм. Мөн Мухаммед Түүний боол ба Расул мөн гэдгийг ч гэрчилнэ."

Хүндэт Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн үгс нь Дямадад маш их таалагдав:

"–Би хэзээ ч үүнээс гоё үг сонсоогүй! Чи энэ үгээ дахиад хэлээд өгнө үү?" гэв.

Орчлонгийн Хүндэт Эзэн маань үгээ дахив. Дямад нь энэ сувд шиг үгсийг өөр хоёр удаа дахиулсны дараа:

"–Валлахи би мэргэ харагчдын, илбэчдийн, шүлэгчдийн, төрөл бүрээс хүний үгийг дуулав. Гэтэл Чиний энэ хэлсэн шиг ямар ч үг сонсоогүй. Эдгээр гоё ба уран хэллэг далайн хамгийн үнэт сувднууд мөн. Гараа өг, Чамд ам өгье!" гээд мусульман болов.

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-:

"–Ардынхаа нэрээр ч ам өгнө үү?" хэмээн асуув.

Дямад:

"–Ардынхаа нэрээр ч ам өгье!" гэв. (Мүслим, Жум'а, 46; Ахмад, I, 302; Ибн-и Са'д, IV, 241)

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- Дямадыг мусульман болсны дараа шууд ардынхаа нэрээр ч түүнд ам өгүүлж авав. Ингээд түүнийг арддаа Исламыг тэблиг хийх ба сургахаар элч ба сургагч болгож томилов.

Номлохын Арав Дахь Жил

Гунигт Жил: Хазрат-и Хатижа ба Эбү Талиб Өөд Болсон нь

Мүшрикчүүдийн бүслэлтээс мэнд сайханд гарсан Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- ба мусульманчуудын баяр хөөр их удаагүй. Түүний ба мусульманчуудын хамгаалагч асан, тэднийг бүх чадлаараа хадгалсан авга ах нь Эбү Талиб нас барав.

Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм- түүний итгэх үнэмшихийн тулд заримдаа ихээр шахсан байв. Эбү Талиб ч энэ шахалтын хариунд дүүдээ:

"–Би Чиний үнэнийг мэддэг. Гэтэл Чамд итгэж үнэмшвэл Курайгийн эмэгтэйчүүд намайг буруушаана!" гэдэг байв.

Хазрат-и Пайгамбарын нүбүввэтийг уг чанартаа хүлээн зөвшөөрдөг, харин нэфис нь үүнийг үгүйсгэдэг байв.

Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- түүний сүнсээ Рабдаа итгэл үнэмшилтэй буйгаар буулгаж өгөхийн тулд нас барсан байхад нь ч:

"–Агаа! Би гуйж байна, нэг үг хэл дээ, Аллах чамд мөнхийн жаргалыг хайрлаж өгөг!" хэмээн шахав.

Тэр хооронд тэнд ирсэн буй Эбү Жэхил үүнд саад болов. Учир нь Эбү Талибт эгнэгт кэлимэ-и шэхадэтийг санал болгосон Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн эсрэгээр Эбү Жэхил:

“–Чи овог дээдсийнхээ шашинд юм!” гээд сануулдаг байв.

Эцэст нь Эбү Талибын Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-д сүүлийн үг нь:

“–Би хуучин шашинтайгаа үхэж байна. Курайш нь намайг “Үхэхээс айгаад шашнаа солив” гэхгүйсэн бол, би ч Чиний үгсийг хүлээн зөвшөөрөхсөн!..” болов. (Бухарий, Жэнаиз 81, Мэнакибу’л-Энсар 40; Ибн-и Са’д, I, 122-123)

Тэгэхлээр нь Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм-:

“–Би ч чиний төлөө эгнэгт өршөөл гуйна!” хэмээсэн, гэтэл авга ахынхаа гэрээс гунигтай салсан байв.

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн ихээр гуньж авга ахынхаа төлөө “Чиний төлөө эгнэгт өршөөл гуйна!” гэхлээр нь ает-и зэримэ ингэж айлдав:

اِنَّكَ لَا تَهْدِي مَنْ اَحْبَبْتَ وَلٰكِنَّ اللّٰهَ يَهْدِي مَنْ يَشَآءُ
وَهُوَ اَعْلَمُ بِالْمُهْتَدِينَ

“ Расул минь! **Чи хайрласнаа авралд хүргэж чадахгүй! Гэтэл Аллах хүссэнээ зөв замд хүргэнэ...”** (эл-Касас, 56) (Мүслим, Иман, 41-42)

Хидаят нь боолыг зөв замд хүргэдэг тэнгэрлэг туяа мөн. Хэний сэтгэлд түүнд сонирхолтой ба Эрхэд эрмэлзэлтэй байвал, зөвхөн түүнд л ононо.

Аят-и дэримэ ингэж айлдана:

وَيَهْدِيٓ اِلَيْهِ مَنْ اَنَابَ

“...(Аллах) **өөрт нь чиглэсэн хүнд авралтыг өгнө!”** (эр-Ра’д, 27)

Энэ тухай бусдын хичээсэн нь зөвхөн учир буюу арга болох юм. Эсрэгээр нь өрр нэгний -пайгамбар байсан ч- хичээснээр аврaлт хүрсэн нь байнга боломжтой биш юм. Жишээлбэл -Хазрат-и Пайгамбар ихээр хичээсэн ч, Эбү Талиб үнэнийг мэдсэн боловч нэфистээ хожигдож Эрхэд чиглээгүйн дүнгээр түүнд амралт хувь болоогүй юм.

❁

Пайгамбар Эзнийг маань гүн нэгэн гунигт дарсан Эбү Талибын нас барсны дараа гурав ч хонолгүй, Аллахын Элчийн зовлонг нь хуваалцагч, том түшиг, амьдралын хань, Эмэгтэйчүүдийн Тэргүүн, Хатижатү’л-Күбра -радъяллаху анхаа- эх маань өөд болов. Хүндэт Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- болон итгэгчдийн сэтгэлийн гашуун дээр дахиад том нэгэн гашуун нэмэгдэв. Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- их хайртай ариун эхнэрээ булшид нь өөрийнх гараараа буулгав. Орчлонгуудын Эзний сэтгэл гунигаар, нүд нь нулимсаар дүүрсэн байв.

Хазрат-и Хатижа эх маань Оршигчдын Туяа -алэйхиссалатү вэссэлам-д Исламын үйл ажиллагаанд үнэнч нэгэн зөвлөх, зовлонг хуваалцагч, тайтгарал ба тайвны булаг болж байв. Түүний өөд болсон нь Аллахын Элчид:

“–Энэ үммэтэд таарсан хоёр том гамшгаас алинд илүү санаа зовоохоо мэдэхгүй байна,” (Я’кубий, II, 35; Табэрий, *Тарих*, II, 229) хэмээн хэлүүлэх чинээ хүнд санагдсан байв.

Гунигтай явдлаас болж Маккагийн эриний арав дахь жилийг “Гунигт Жил” гэж нэрлэдэг.

Авга ах ба эхнэрийнхээ өнгөрснөөр Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм- Эзэнд маань ямар ч ил, бодит, эсвэл түр зуурын хамгаалалт үлдээгүй болов. Ингэж Түүний сэтгэлийн хорвоо нь Аллах Таалад зориулсан болов. Учир нь бууж өгөх ба хоргодох гагцхуу орон Аугаа Эрх байв. Угаасаа багадаа ч ээж, аав ба өвөөгийнхөө хүмүүжлийг алдаж Аллахын хүмүүжилд боловсруулсан байв.

❁

Хатижа эх маань их эрдэмтэй хүн байв. Вахийн мэлэк нэгэн өдөр Хүндэт Элч Эзэнд маань ирээд:

“–Аяа Расулаллах аа! Хатижа нь нэгэн аяга хоол барьж Чамд ирж байна. Хатижаг ирэхээр түүнд Раббаас нь ба надаас мэнд дамжуул! Түүнд шуугиан үймээнгүй диваажинд сувдаар хийсэн нэгэн ордонтой болохын сайхан мэдээллийг хүргэ!” хэмээв. (Бухарий, Мэнакибу’л-Энсар, 20)

Хазрат-и Хатижа -радъяллаху анхаа- уг тэнгэрлэг мэндчилгээг ингэж хариулав:

“–агуу алдарын Аллах нь өөрөө Салам мөн, салам Тэрээрээс мөн, Жэбраилд ч мэнд өргөе! Аяа Аллахын Элч ээ! Аллахын салам, энэрэл ба элбэг Чиний дээр ч байх болтугай.”

Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- амьдралынхаа турш энэ ариун эхнэрээ мартаагүй. Түүнд үнэнч сэтгэлийн хамгийн сайхан олон жишээг толилуулав.

Аиша -радъяллаху анхаа- ингэж ярина:

“Пайгамбар -алэйхиссалатү вэссэлам-ын эхнэрүүдээс хэнийг ч Хатижа шиг нь үгүй. Түүнчлэн би түүнийг хэзээ ч

хараагүй байв. Гэтэл Хүндэт Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- түүнийг ихээр дурддаг байв. Хонь төхөөрч махаа хуваахдаа, ихэнхдээ Хатижагийн андуудад илгээдэг байв. Нэгэн удаа тэсэлгүй Аллахын Элчид:

«–Орчлонд Хатижагаас өөр эмэгтэй үлдээгүй юм шиг!» гэлээ.

Хүндэт Нэбий -саллаллаху алэйхи вэ сэллэм-:

«–Тэр нь тийм тийм байв,» хэмээн түүний сайхан талуудыг тоолж:

«–Миний хүүхдүүд ч түүнээс төрөв,» хэмээв.

Үнэн голоосоо:

«–Дахиад Хатижагийн тухай муу үг хэлэхгүй,» гэлээ.” (Бухарий, Мэнакибу’л-Энсар 20; Эдэб 73; Мүслим, Фэдаилү’с-Сахаба 74-76)

Нэгэн өдөр Хатижагийн охин дүү Халэ бинт-и Хүдэйлид нь Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ээс орох зөвшөөрөл эрсэн байв. Хүндэт Расул -саллаллаху алэйхи вэ сэллэм- нь Хатижагийн дууг санаж:

“–Аллах минь, энэ нь (Хатижагийн дүү) Халэ бинт-и Хүвэйлид!” сэтгэл хөөрөв.

Энэ байдлыг харсан Аиша -радъяллаху анхаа- тэсч чадалгүй:

“–Хөгширч амандаа шүд нь үлдээгүй, дээр үед үгүй болсон Курайшаас нэгэн чавганцын юуг нь санаад байна вэ? Аллах Чамд түүний оронд илүү буянтыг нь хайрлаж өгөв,” гэв. (Бухарий, Мэнакибу’л-Энсар, 20)

Хазрат-и Аиша “илүү буянт” гээд өөрийгөө л хэлмээр байв. Түүний энэ үг нь таалагдаагүй Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- энэ хариуг өгөв:

“–Үгүй, Аллах Таала надад түүнээс илүү буянтыг өгөөгүй. Ардыг надад итгэхгүй байхад тэр итгэв. Хүн бүрийг надад худалч гэж байхад тэр үнэн буйг минь батлав. Хэн ч надад юу ч өгөхгүй байхад тэр бараагаараа түшиг олгож надад хүүхдүүд хайрлаж өгөв.” (Ибн-и Ханбал, VI, 118)

Таифын Аялал

Авга ах болон эхнэрийнх нь нас барсны дараа Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм-д даралт нь улам бүр ихсэв. Тэр Номлошчдын Хааны эсрэг хийсэн өстөн шиг довтлого нь зэрлэгшлийн төвшинд хүрэв. Тэгээд Хүнвэл Расул -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн хүчийг туйлдуулж эхлэв. Тэгэхлээр нь Аллахын Элч хажуудаа Зэйд -радъяллаху анх-ыг ч аваад Маккагаас ойролцоогоор 120 км. цаанах Таиф хотод очив. Тэнд арав хонов.

Таифчуудад Исламыг ярьж өгөв. Тэднийг тэвхидэд урив. Хотын хүндэт хүмүүстэй уулзаад баримлыг шүтэхээс болиулж цорын ганц буй Аллахад итгэхийг сургав. Таифын хүндэтчүүдээс хажууд нь ороод ярилцаагүй хэн ч үлдээгүй.

Гэтэл энэ урилга нь Курайшчууд шиг баримал шүтэгч асан Таифчуудын хооронд аймшигт бодлын шуурга тэсрүүлэв. Нэфсийн амьдралын давалгаанд амьдарч байсан тул аль нэгэн ч авралд хүрч чадаагүй. Түүнчлэн Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм-д хийгээгүй харгислал ч үлдээгээгүй:

Эхлээд шоглоцгоов. Дараа нь доромжилж эхлэцгээв. Араас нь боолчуудаа Аллахын Элчийн явж өнгөрсөн замын хоёр талд

жагсааж Түүнийг доромжилж чулуудуулав. Ингээд хотоос гартал нь Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийг тамлахаа үргэлжлүүлэв. Түүнчлэн боолчуудыг араас нь явуулж хэсэг хугацаагаар илүү чулууны бороо оруулав. Орчлонгуудын туурвигдсаны учир болсон Тэр Пайгамбар Хааны ариун хөл нь цусаар бүрдсэн, гутал нь цусаар дүүрсэн байв. Түүнийг хаясан чулуудаас хамгаалахыг хичээсэн үнэнч сэтгэлт сахабий Зэйд -радъяллаху анх- ч шархадсан байв. Тэр нь Аллахын Элчид хаясан чулуунд өөрийнх биеэ халхавч болгож:

"–Аяа Таифын ард аа! Чулуудсан хүн нэгэн пайгамбар буйг мэдэж байна уу?!." гэсээр байв.

Өөрсдийгөө арайхий л Маккачуудаас нэгний цэцэрлэгт, нэгэн хасарвааны модон доор хаяж чадав. Газрууд ч гунигтай, тэнгэрүүд ч гунигтай байв. Мэлэкчүүд гунигтай байв. Жэбраил гунигтай байв. Микаил, Исрафил, Азраил гунигтай байв.

Эхэнд Жэбраил -алэйхиссэлам- буйгаар хамаг мэлэкчүүд Аллах Таалагаас зөвшөөрөл аваад Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн дэргэд гүйсхийв:

"–Аяа Расулаллах аа! Тушаавал энэ ардыг мөхөөцгөөе!" гэцгээв.

Тэр рахматын булаг ба энэрлийн пайгамбар, учирсан ийм муухай хандлагын хариунд ч хараалгүй гараа тэнгэр өөд дэлгэн:

"Аллах минь! Хүчээ алдсан, аргагүй болсон, ардын хараанд доромжлогдсоноо Чамд өргөж байна.

Аяа энэрэлтдийн хамгин энэрэлт ээ! Хэрэв надад хилэнгээрээ харвал, дийлсэн тамлалыг огт тоохгүй!

Илахий! Чи ардад минь авралт хайрлаж өгчих; тэд мэддэггүй.

Илахий! Чамайг таалтал одоо өршөөлийг чинь гуйя...” гэээд залбирав. (Ибн-и Хишам, II, 29-30; Хэйсэмий, VI, 35; Бухарий, Бэд’ү’л-Халк, 7)

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- Эзний маань амарсан усан үзмийн багийн эзэн асан Рэбиагийнхан нь Орчлонгуудын Эзний ийм байдалд өрөвдөж Түүнд боол Аддасаар нэгэн таваг усан үзэм илгээв. Аддас тавгийг барив:

“–Авч идээрэй!” гэв.

Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм- ч:

Хазрат-и Ali -радъяллаху анх- ярина:

“بِسْمِ اللّٰهِ” гэээд идэж эхлэв.

Энэ үг Аддасын анхаарлыг татав. Одоо хүртэл хэнээс ч ийм үг сонсоогүй байв. Сонирхолт ба гайхсаар:

“–Энэ үгийг энэ газрын хүмүүс мэдэх ч үгүй, хэлэх ч үгүй!..” гэээд бувтнав.

Дараа нь дахиад гайхалтайгаараа:

“–Чи ялгаатай хүн мөн! Энэ газрын хүмүүстэй төсөөгүй! Чи хэн бэ?” гэв.

Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- ч:

“–Чи хаанахын, ямар шашных вэ?” хэмээн асуув.

Аддас:

“–Ниновагаас, Христийн шашинтай юм!” гэв.

Хүндэт Расул Эзэн маань:

“–Тэгэхээр сайхан боол Юүнүс бин Мэттагийн нутгаас юм!” хэмээв.

Аддасын гайхах нь бүр ихсэв:

“–Чи Юүнүсийн хаанаас мэддэг вэ?” гэв.

Оршигчдын Туяа:

“–Юүнүс миний дүү мөн. Тэр нэгэн пайгамбар байв. Би ч пайгамбар мөн!” хэмээв.

Эдгээр үгсийг сонссон Аддасын сэтгэл хөөрч, суусан газраасаа баяртай босоод Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн гарыг барьж кэлимэ-и гэхадэт авчрав. (Ибн-и Хишам, II, 30; Я’кубий, II, 36)

Эзэд нь Аддасыг тэглээ гэж эзэд нь зэмлэхэд нь тэр энэ хариуг өгөв:

“Би өөрийгөө мэдсэнээс хойш дэлхий даяар Түүнээс буянтай хүн хараагүй! Түүний надад хэлсэн үгийг зөвхөн нэгэн пайгамбар л мэдэж чадна.” (Ибн-и Хишам, II, 31)

Азаар нь Аддас -радъяллаху анх- нь Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн амьдралын хамгийн сөрөг байдал дор итгэж үнэмшээд Түүнийг тайтгаруулсан итгэгч болох нэр алдарт хүртсэн байв. Орчлонгуудын Эзэн нь түүний мусульман болсонд нь, мэдэрч буй зовлонгоо ч мартах чинээ баяссан байв.

Өнөөдөр Аддасын мусульман болсон газар түүний нэрэмжит нэгэн мэсжид байдаг бөгөөд Орчлонгуудын Эзэнд үзэм дайлсныг ч хадгалсаар байдаг.

Ижилгүй Энэрэл ба Рахманы Тайтгарлууд

Хазрат-и Аиша -радъяллаху анхаа- эх маань айлдана:

“–Ухуд Дайнаас илүү давчитсан өдөр болов уу аяа Расулаллах?” гээд Хазрат-и Пайгамбараас асуулаа.

Ингэж айлдав:

“–Тийм, чиний ардаас маш олон муухай үйл дийлсэн. Эдгээрээс хамгийн муу нь тэдний надад Акабагийн Өдөр[210] хийсэн нь мөн. Түүнчлэн Таифын Абдүкүлалын хөвүүн Ибн-и Абдиялийлд хоргодмоор байхад, тэр намайг оруулж аваагүй. (Эсрэгээр нь намайг дорой хүмүүст чулуудуулж бүх биеийг минь цусаар булуулж, хийгээгүй харгислал үлдээгээгүй байв.) би ч буцсан гүнзгий гунигаар дүүрэн яваад байв. Карнү’с-Сэалиб гэдэг газар хүртлээ ухаан орж чадаагүй. Тэнд толгойгоо өндийлгөхдөө нэгэн үүл намайг сүүдэрлэж буйг харав. Анхааралтай харвал тэр үүлний дотроос Жэбраил -алэйхиссэлам-ыг анзаарав. Надад:

«–Аллах Таала ардынхаа Чамд юу хэлснийг ба Чамайг хамгаалахыг яаж татгалзсаныг сонсов. Тэдэнд Чиний хүссэнийг хийхээр ч Уулнуудын мэлэкийг илгээв,» гээд дуудав.

Тэгэхлээр нь Уулнуудын мэлэк нь надад мэнд хүргэв. Дараа нь:

«–Аяа Мухаммед! Ардынхаа Чамд юу гэснийг Аугаа Эрх сонсов. Би Уулнуудын мэлэк. Юу тушаасныг чинь хийхээр Аллах Таала намайг Чамд илгээв. Юу хийхийг хүсэх вэ?хэрэв хүсвэл энэ хоёр уулыг тэдэн дээр нураая,» гэв.

Тэгсэнд би:

210. **Акабагийн Өдөр:** Аллахын Элчийн Минад Акаба гэсэн газар зогсоод хүмүүсийг Исламд урьсан өдөр юм. Тэр үеэр хэсэг хүмүүс Исламыг зөвшөөрөхөд, хэсэг нь ч Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийг зовоосон байв. Тэр л өдөр “Акабагийн Өдөр” хэмээн алдаршсан байдаг.

«–Үгүй, би Аугаа Эрхийн тэдний удмаас зөвхөн Аллахад боолчлох бөгөөд Тэрээрээс өр бурхан танихгүй хүмүүс гаргахыг ерөөнө,» гэв.” (Бухарий, Бэд’ү’л-Халк, 7; Мүслим, Жихад, 111)

Шүлэгч нь Аллах Таалагийн Хабибаа яаж хайрласныг маш сайхан илэрхийлнэ:

“Аяа Расулаллах! Аугаа Эрх дэлхий болох түүн доторх хамаг юмыг Чиний төлөө золиослох чинээ Чамд хайртай юм.”

❀

таифын аялал маш олон сургаал агуулдаг:

1. Эхлээд, тэблиг маш чухал гэдгийг заадаг. Пайгамбар маань гунигт жил байсан ч тэблигээ таслаагүй, ажлаа тэвчээрээр үргэлжлүүлсэн байдаг.

2. Таифчууд Түүнийг чулуудуулсан ч Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- тэдний тухай хараагаагүй юм. Энэ нь Аллахын Элчийн энэрлийг үзүүлдэг бөгөөд, тэблигч хүний ч энэрэлтэй байх хэрэгтэйг тэсвэрлэдэг.

3. Тэблигч нь алдааг өөртөө хайж, хүмүүсийн авралын төлөө залбираад найдвараа алдах ёсгүй юм. Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- нэгэн алдаа харвал өөрөө гэмшиж:

“–би юу болоод таныг ингэж харж байна вэ!”[211] хэмээдэг байв. Жишээлбэл Хазрат-и Сүлэйман -алэйхиссэлам-ын өвөөлж шувууг хуралд алга буйг анзаарахдаа:

مَا لِيَ لَٓا اَرَى الْهُدْهُدَ

211. Хар. Мүслим, Салат 119; Эбү Давуд, Хатэм 4, Эдэб 14.

"…би юу болоод өвөөлжийг харж чадахгүй байна вэ?.." (эн-Нэмл, 20) гэсэн нь ч тэблигийн ийм аргаар юм.

4. Таифын аялалын дараа Аддасын итгэсэн нь маш чухал юм. Учир нь Расулаллах -алэйхиссалатү вэссэлам- хамгийн давчидсан үед ч үүнийг санан тайвшрав. Энэ байдлын зааснаар хамгийн давчуу байдалд байхдаа ч нэгэн хүний итгэл ч биднийг тайтгаруулах хэрэгтэй.

5. Тэблигч нь байдлаараа үлгэр жишээ байх ёстой.

6. Исламыг тэблиг хийгч хүн нь хүмүүст хандах аргыг мэдэж соёлтой байх ёстой, Пайгамбар Эзний маань Аддаст хандсан шиг хаана, хэнд юу хэлэхээ мэдэх ёстой юм.

Оршигчдын Туяанаас Кур'ан Сонсч Итгэж Үнэмшсэн нь

Аддасаас өөр хэний ч итгэж үнэмшээгүй Таифаас буцахдаа Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- хоносон нэгэн газар Кур'ан уншихад хэсэг жин буюу сүг сүнснүүд Түүнийг сонсчээ. Бүгд ч үнэнийг ухаарч Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-д итгэж үнэмшив. Ардынхаа дэргэд тэблиг үүргээр харив. (Ибн-и Са'д, I, 212)

Ибн-и Аббас -радъяллаху анхүма- ингэж хэлэв:

"Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- хэсэг асхабынхаа хамт Указ Яармагт очих зорилгоор замд гарсан байв.

Тэр үед, чөтгөрүүдийн тэнгэрээс ирсэн мэдээллийг авахад саад болсон байв.[212] (Ийм л учраас тэнгэрээс мэдээ авчирсан)

212. "Жинүүд өгсөж тэнд вахийг сонсдог байв. Нэгэн үг дуулбал өөрсдөө дээр нь ерэн ес нэмдэг байв. Тэр нэгэн үг нь үнэн, тэдний нэмсэн ерэн есөн бол худал байв. Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- Пайгамбар болоод томилогдсонд, шихаб хэмээн галаар тэдний тэнгэрт өгсөхийг саад хийв.

сүнс сүгнүүд дээр байнга шихаб[213] илгээгдэв. Ингээд тэд арддаа (гар хоосон ба мэдээлэлгүй) харив.

Ард нь:

«–Яасан бэ, яагаад хоосон харив?» гэж асууцгаав.

Тэд:

«–Бид тэнгэрлэг мэдээлэл хоёрын хооронд саад тавилаа. Бидэн дээр шихаб илгээлээ. Бид ч зугтаад ирэв,» гэцгээв.

Ард нь:

«–Энэ нь шинээр гарсан нэгэн зүйлийн учиртай байх ёстой. Дэлхий өрнөд дорнодоор яваад, энэ саадны тухай мэдээ авчирцгаа,» гэцгээв.

Сүг сүнснүүд дэлхийг самнахаар багаараа хөдлөв. Эд нараас Тихамэгийн тийш явсан бага нь (Указ яармагийн дам дахь Нахлэ гэсэн газар) асхабынхаа хамт өглөөний мөргөл үйлдэж буй Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм-тэй тааралдав. Кур'ан-и Кэримийг сонсоод зогсч сонороо дэлдийлгэв:

«–Бидний тэнгэрээс мэдээлэл авахад саад болсон нь энэ юм!» гээд буцацгаав.

Арддаа ингэж хэлцгээв:

«–Манай ардынхан, үнэхээр бид зөв замд хүргэгч, ер бусын гоё нэгэн Кур'ан сонсоод түүнд итгэж үнэмшив. Одоогоос хойш хэнийг ч Рабдаа адил болгож үзэхгүй.»

Түүнээс өмнө тэнгэр дэх жинүүдэд шихаб харвадаггүй байв." (Тирмизий, Тэфсир, 72/3324)

213. Шихаб нь толь бичигт галын дөл л гэсэн утгатай. Ялангуяа тэнгэрт од харвасан шиг харагдсан дөлийг л хэлдэг. Манай эриний тэфсирчин хүмүүс шихабыг солир байж болохыг бичсэн байдаг.

Тэгэхлээр нь Аугаа Эрх нь Хүндэт Нэбийдээ Сураг буулгаж буг чөтгөрүүд Кур’ан сонссон ба арддаа мэдээ авчирсныг мэдүүлэв:

قُلْ أُوحِيَ إِلَيَّ أَنَّهُ اسْتَمَعَ نَفَرٌ مِّنَ الْجِنِّ فَقَالُوا إِنَّا سَمِعْنَا قُرْآناً عَجَباً. يَهْدِي إِلَى الرُّشْدِ فَآمَنَّا بِهِ وَلَن نُّشْرِكَ بِرَبِّنَا أَحَداً

«Аяа Расул минь ээ! **Ингэж хэл: Жинүүд хэсэг ардын** унш- сан Кур’аныг **сонсоод ингэж хэлсэн нь надад вахий болов: Үнэхээр бид зөв замд хүрэгч, ер бусын гоё нэгэн Кур’ан сонсоод түүнд итгэж үнэмшив.** Үүнээс хойш **хэнийг ч Рабтайгаа адилтгаж үзэхгүй.»** (эл-Жин, 1-2)” (Бухарий, Тэфсир 72, Эзан 105; Мүслим, Салат 149; Тирмизий, Тэфсир 72/3324)

Аллах Таала нь Ахкаф Сурад үүнийг ингэж дурдана:

وَاِذْ صَرَفْنَآ اِلَيْكَ نَفَرًا مِنَ الْجِنِّ يَسْتَمِعُونَ الْقُرْاٰنَ فَلَمَّا حَضَرُوهُ قَالُوٓا اَنْصِتُوا فَلَمَّا قُضِيَ وَلَّوْا اِلٰى قَوْمِهِمْ مُنْذِرِينَ ﴿٢٩﴾ قَالُوا يَا قَوْمَنَآ اِنَّا سَمِعْنَا كِتَابًا اُنْزِلَ مِنْ بَعْدِ مُوسٰى مُصَدِّقًا لِمَا بَيْنَ يَدَيْهِ يَهْدٖيٓ اِلَى الْحَقِّ وَاِلٰى طَرٖيقٍ مُسْتَقٖيمٍ يَا قَوْمَنَآ اَجٖيبُوا دَاعِيَ اللّٰهِ وَاٰمِنُوا بِهٖ يَغْفِرْ لَكُمْ مِنْ ذُنُوبِكُمْ وَيُجِرْكُمْ مِنْ عَذَابٍ اَلٖيمٍ وَمَنْ لَا يُجِبْ دَاعِيَ اللّٰهِ فَلَيْسَ بِمُعْجِزٍ فِي الْاَرْضِ وَلَيْسَ لَهُ مِنْ دُونِهٖٓ اَوْلِيَآءُ اُولٰٓئِكَ فٖي ضَلَالٍ مُبٖينٍ

“ Хэсэг ардад Кур’аныг сонсгохоор Чамд илгээлээ. Кур’аныг сонсоход бэлэн болохдоо нэг нэгэндээ **«Чимээгүй!» гээд, Кур’аны**

уншлага нь дуусаад буцсан байв. Тэд арддаа ингэж хэлэв: «Манай ардынхан! Үнэхээр бид Мусагийн дараа буулгасан бөгөөд өөрөөс өмнөх юмыг баталсан нэгэн ном сонсов. Тэр ном нь үнэн болон зөв замыг заадаг. Манай ардынхан! Аллахын урилгачийг дагацгаа! Та Түүнд итгээд, Аллах ч таны нүглээс өршөөж таны гашуун тамлалаас хагаслаг. Хэн ч Аллахын урилгачийг дагахгүй бол, дэлхий даяар Аллахыг хүч чадалгүй үлдээж чадахгүйгээ мэдэг. Түүнд Аллахаас өөр найз үгүй. Тэд ил далдгүй төөрсөн байдаг.” (эл-Ахкаф, 29-32)

Ает-и кэримэд жинүүдийг тэнгэрийн мэдээллийг сонсохыг хориглосны тухай ингэж айлдав:

وَاَنَّا لَمَسْنَا السَّمَآءَ فَوَجَدْنَاهَا مُلِئَتْ حَرَسًا شَدِيدًا وَشُهُبًا
وَاَنَّا كُنَّا نَقْعُدُ مِنْهَا مَقَاعِدَ لِلسَّمْعِ فَمَنْ يَسْتَمِعِ الْاٰنَ يَجِدْ لَهُ
شِهَابًا رَصَدًا وَاَنَّا لَا نَدْرٖٓي اَشَرٌّ اُرٖيدَ بِمَنْ
فِي الْاَرْضِ اَمْ اَرَادَ بِهِمْ رَبُّهُمْ رَشَدًا

“Сүг сүнснүүд: **«Бид тэнгэрт хүрээд түүнийг хүчтэй мануул ба дөлөөр дүүрэн олов. Үнэхээр бид тэнгэрийн зарим хэсэгт сонсохоор суудаг байв. Гэтэл одоо хэн ч сонсох болбол түүнийг манадаг гялтаг нэгэн дөл олно. Үнэхээр бид дэлхийг ардуудад нэгэн муухай үйл хүрсэн эсвэл Раб нь тэдэнд нэгэн буян хүссэн эсэхийг мэдэхгүй юм.»”** (эл-Эин, 8-10) [214]

214. Мэвлана Хазрат нь ийм явдлыг төсөөлөн ингэж илэрхийлнэ:
“Чөтгөрүүд тэнгэрт өгсөөд тэнгэрийн нууцыг сонорлодог байцгаав.”
“Тийм нууцаас заримыг хулгайлж байхад, тэнгэрээс шууд шихаб ирээд тэднийг тэнгэрээс цөллөдөг байв.”
“Тэгээд ингэж хэлнэ: Нэгэн Пайгамбар илгээгдлээ. Түүнийг буй газар очоод юу хүсвэл Түүнээс олж авцгаа.”
“Хэрэв үнэлшгүй сувд хайж байвал ***«Гэрүүдэд хаалгаар нь орцгоо!»*****”*

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн Таиф аялалын ил харагдсан орлого нь зөвхөн Аддас -радъяллаху анх- байв. Гэтэл үнэндээ Аллах Таала Түүнд маш олон юм хайрласан байв. Энэ бүхнээс жишээлбэл Түүнд хоёр ертөнцийн хааны цол олгосон байв. Анх удаа, Маккад харихаас ч өмнө сүнснүүд Түүнээс Кур'ан сонсч өөрсдийн хорвоод тэблигт эхлэв. Үүний богино хугацааны дараа ч Аллах Таала тэнгэрийн орны хаан болгож Миражийг хайрлав.

❁

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- Эзэн маань Маккагаас өөрийнх дураараа гарсан учраас, Арабын ёсоор тэнд буцахдаа заавал Маккагийн нэгэн хүний хамгаалалтад орох шаардлагатай байв. Ийм учраас Таифаас буцахдаа Нахлэгаас Макка руу ирээд Хира Ууланд хүрэхдээ Маккагийнхнаас тааралдсан нэгийг эхлээд Ахнэс бин Шэрикэд, дараа ч Сүхэйл бин Амр ба Мут'им бин Адийд илгээв. Тэдэнд:

"Тэр хаалганы хонхыг дар ба өмнө нь байж бай. Чи болон чиний төсөөтдөд хувь заяа өөд зам үгүй."
"Бас та тийм хол зам явах ч хэрэггүй. Бид нууцын нууцыг хөрсөөр туурвисан боолдоо хайрлаж өгөв."
"Хэрэв та урвагч биш бол Тэнгэрлэг Калиф буюу тэр Хүний онгонд хүрцгээ. Хоосон зэгс шиг байсан ч Түүний эрдэм ба яриагаад чихрийн нишингэ шиг байх болно."

* **"Гэрүүдэд хаалгаар орцгоо"** (эл-Бакара, 189)**:** Мунхаглалын үеэр ба Исламын анхны жилүүдэд хүн хаж эсвэл үмрэд явахаар ихрам өмсөхлөөрөө хашаа болон гэрт хаалгаар нь ордоггүй байв. Хотын хүн байвал дээвэт нэгэн хүн нээж түүгээр орж гардаг байв. Бадавий бол майхны үүдээр ордоггүй, майхныг хойноос нь сэтэлж, түүгээр ордог байв. Ихрамаа тайлтлаа ингэдэг байж үүнийг сайн ба дүрмийн дагуу гэж боддог байцгаав. Аллах Таала Бакара Сурагийн 189-р аетыг буулгаж гэрүүдэд хойгуур нь орох нь сайн биш уламжлалаас гажиж буйг мэдүүлэв. (Вахидий, х. 56-57)
Дараа нь энэ аетыг "ажлыг ёсоор нь хийх" гэсэн утгаар ямар ч хэрэгт хэрэглэж эхэлцгээв. Хазрат-и Мевлана энд: "Аллахыг олохоор Тэрээрийн хаалгыг дуурайсан эхлуллахад хандацгаа" хэмээн тасаввуфын нэгэн тэфсир хийжээ.

“–Мухаммед *«Раббынхаа надад хайрласан номлох үүргээ тэблиг хийж гүйцэтгэтэл намайг хамгаалалтдаа авна уу?»* хэмээн асууна,” гэхийг нь гуйв.

Бусад хоёр нь зөвшөөрөөгүй, харин Мут’им эерэг хариу өгөв. Оршигчдын Туяа -алэйхиссалатү вэссэлам- тэр шөнө Мут’имынд хонов. Өглөө болоход Мут’им хөвүүд болон ардаа дуудаж:

“–Зэвсгээ бүсэлж Бэйтуллахын дэргэд очицгоо!” гэв.

Кабад хүрэхдээ арддаа хандаж:

“–Курайшийн нийгэм ээ! Мухаммедыг хамгаалалтдаа оруулсан! Түүнд хэн ч гараа битгий хүргээрэй!” гэж дуудав.

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- Кабаг тавах хийх буюу долоон удаа тойрч хоёр рэдат мөргөл үйлдэж гэртээ харьтал нь Мут’им болон хөвүүд нь Түүнийг хамгаалав. (Ибн-и Са’д, I, 212; Ибн-и Кэсир, *эл-Бидая,* III, 182)

олон жил өнгөрөв. Итгэлийн хүндийг хүртэж чадаагүй Мут’им нь Бэдирт мусульманчуудын эсшэр байлдаж алагдав. Дайсны олзонд юу хийхийг маргалдаж буйд Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- нь Мум’имын хөвүүн Жүбэйрт:

“–Хэрэв Мут’им амьд болж надаас олз бүхнийг өршөөхийг нэхсэнсэн бол барьцааны мөнгө авалгүй бүгдийг нь чөлөөлөх байсан,” хэмээж түүнд үнэнч сэтгэлээ үзүүлэв. (Бухарий, Хумус, 16; Ибн-и Хишам, I, 404-406)

Исламыг тэблиг хийхдээ өөрт нь хялбаршил үзүүлсэн нэгэн мүшрикэд ч хүрсэн чин сэтгэлийн энэ мэдрэмж нь агуу том ёс суртахууны илрэл мөн!..

Зарим Аймгуудтай Уулзаад Тэднийг Исламд Урьсан нь

Таифаас буцахдаа Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- хэсэг хугацаагаар ардаас хол амьдрав. Дараа нь дахиад урьж үргэлжлүүлэв. Мүшрикчүүд бүр хатуу хандаж эхлэхлээр нь, Аллах Таала нь Пайгамбар Эзэнд маань Араб аймгуудтай уулзаад тэблиг хийхийг тушаав.

Тэгэхлээр нь Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- нь хажжийн үеэр Маккад игэрсд ба Указ, Мэжэннэ, Зүлмэжаз мэтийн яармагт оролцогсдод хандан Кур'ан-и Кэримийн аетуудыг уншиж тэднийг Исламд урьж байв.

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- ийм том яармагт ирсэн Бэий Амир, Мухариб, Фэзара, Гассан, Мүррэ, Ханифа, Сүлэйм, Абс, Бэний Наср, Бэний Бэкка', Киндэ, Кэлб, Хариса, Үзрэ, Хударима мэтийн аймгуудын буусан газар очоод, тэднийг Исламд урьж байв. Номлох үүргийг нь баталж, Раббынхаа өөрт нь өгсөн номлох үүргийг хэрэгжүүлэхэд өөрт нь туслахыг нь тэднээс гуйдаг байв.[215]

Жабир -радъяллаху анх-[216] ингэж ярина:

215. Хар. Ибн-и Са'д, I, 216-217; Ахмад, III, 322, 492; Ибн-и Кэсир, III, 183-190.

216. **Жабир бин Абдуллах** -радъяллаху анх- хижрэтээс 16 жилийн өмнө Мадинад төрөв. Аав нь Абдуллах бин Амр нь Ухуд Дайнд шэхид болсон анхны сахабий юм. Аавыг амьд байхад 9 охин дүүгээ сахин хамгаалаад дайнд оролцож чадаагүй байв. Аавыг нь өөд болсны дараа Аллахын Элчийн хамт 19 дайнд оролцов. Жабир -радъяллаху анх- нь Акабагийн Хоёр дахь Бий'атад оролцсон хамт олны хамгийн залуу гишүүн байв. Пайгамбар Эзэн маань Жабирт их хайртай байв. Заримдаа түүнийг тэмээ унуулан, бие өвдвөл зочилдог байв. Аав нь нэлээд их өр үлдээж шэхид болсон тул Жабир уг өрийг төлөхдөө их бэрхшээлтэй тааралдав. Ихэнх нь еврей авлагатангууд өрийг нь яаралтай төлөхийг нэхдэг байв. Түүнчлэн тэр жил ургамал ногоо ч гандуу байв. Расулаллах -саллаллаху алэйхи

“Аллахын Элч хажжийн улиралд кабагийн оронд өөрийгөө хажийчуудад таниулан:

«Намайг аймагтаа аваачих хүн бий юү? Курайш нь намайг Раббынхаа үгийг тэблиг хийхэд саад болов,» гээд байв.” (Эбү Давуд, Сүннэт, 19-20/4734)

Гэтэл тэднээс урилгыг нь хүлээн зөвшөөрөх, Түүнийг хамгаалж туслах хэн ч гарахгүй байв. Эсрэгээр нь зарим нь ярвайсан царайгаар, бүдүүлэг ба хатуу хандаад; зарим нь ч “Чамайг аймаг чинь сайн мэднэ! Тэд яагаад Чамайг дагадаггүй вэ?” гээд Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-тэй маргалдаж байв. Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- бол хэрэгтэй хариултыг өгөөд тэднийг зөв замд уриад байв.[217]

Мудар эсвэл Йеменээс хэн нэгэн хаж эсвэл яармагт ирэхээр замд гарвал аймгийнхан түүнд:

“–Болгоомжил! Курайшийн залуу чамайг шашнаас битгий эргүүлэг!” гээд сануулдаг байв.[218]

вэ сэллэм- түүсэн хасарвааныг хэсэг хэсгээр овоолуулав. Ариун гартаа хэмжүүрийг аваад хүн бүрт авлагыг нь тарааж эхлэв. Аллахын Элчийн нэгэн гайхамшгаар Жабирын хамаг өрийг төлснөөс үл барам хасарваан огт дутаагүй юм.

“Мүксирүн” гэсэн хамгийн олон хадис дамжуулсан долоон сахабийгаас нэгэн асан Хазрат-и Жабир -радъяллаху анх- нь 1540 хадис дамжуулсан байдаг. Асхаб-и кирамаас Абдуллах бин Үнэйсийн, дээрээ зовлонтой хүний эрх буй хэн нэгний диваажинд орж чадахгүйн тухай нэгэн хадис дамжуулсныг дуулав. Жабир -радъяллаху анх- энэ хадисыг өөрөө Пайгамбар Эзнээс маань сонссон хүний амнаас өөрөө сонсох юмсан. Харин уг сахабий нь Дамаскад суурьшсан байв. Жабир нэгэн тэмээ худалдаж аваад Мадинагаас замд гарав. Сар явсан зорчлын дараа Дамаскад хүрч, хадисыг Абдуллах бин Үнэйсээс асуугаад мэдэж авав. Амьдралынхаа сүүлийн жилүүдэд сохроод хижрэтийн тооллын 78 / билгийн тооллын 697 онд 94 настай байхдаа Мадинад нас барав. Мадинад хамгийн сүүлийг нас барсан сахабий болов.

217. Ахмад, III, 322; Ибн-и Са’д, I, 216.

218. Хаким, II, 681/4251.

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- нэгэн өдөр Мина дээр, Шийбан бин Са'лэбэгийнхны дэргэд очив. Өөрийгөө Аллахын Элч хэмээн таниулахлаар нь аймгийн ахмадаас Мэфрүк бин Амр:

"–Аяа Курайш дүү! Чи хүмүүсийг юунд урьдаг вэ?" гэж асуув.

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- ороод дэргэд нь суув. Эбү Бэкир -радъяллаху анх- ч босоо байж, Оршигчдын Туяаг хувцастайгаараа сүүдэрлэв. Аллахын Элч нь Мэфрүкэд:

"–Би таныг Аллахаас өөр ямар ч бурхан үгүйд, Аллах ижилгүй ба цорын ганц буйд, намайг ч Аллахын Элч буйг гэрчилж, Аллахын надад тушаасан зүйлсийг хэрэгжүүлж чадтал намайг хамгаалж надад туслахад урьж байна. Учир нь Курайш Аллахын тушаалыг эсэргүүцэж, Аллахын Элчийг үгүйсгэж, худлыг барьж, үнэнээс царайгаа эргүүлэв. Аллах хамгаас дээш ба хамаг хамдыг харъяалдаг!" хэмээв.

Мэфрүк:

"–Аяа Курайш дүү! Чи өөр юунд урьдаг вэ?" гэж асуув.

Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- Эн'ам Сурагийн эдгээр аетуудыг уншив:

قُلْ تَعَالَوْا اَتْلُ مَا حَرَّمَ رَبُّكُمْ عَلَيْكُمْ اَلَّا تُشْرِكُوا بِهٖ شَيْـًٔا وَبِالْوَالِدَيْنِ اِحْسَانًا وَلَا تَقْتُلُوٓا اَوْلَادَكُمْ مِنْ اِمْلَاقٍ نَحْنُ نَرْزُقُكُمْ وَاِيَّاهُمْ وَلَا تَقْرَبُوا الْفَوَاحِشَ مَا ظَهَرَ مِنْهَا وَمَا بَطَنَ وَلَا تَقْتُلُوا النَّفْسَ الَّت۪ي حَرَّمَ اللّٰهُ اِلَّا بِالْحَقِّ ذٰلِكُمْ وَصّٰيكُمْ بِهٖ لَعَلَّكُمْ تَعْقِلُونَ

وَلَا تَقْرَبُوا مَالَ الْيَت۪يمِ اِلَّا بِالَّت۪ي هِيَ اَحْسَنُ حَتّٰى يَبْلُغَ اَشُدَّهُ
وَاَوْفُوا الْكَيْلَ وَالْم۪يزَانَ بِالْقِسْطِ لَا نُكَلِّفُ نَفْسًا اِلَّا وُسْعَهَا وَاِذَا
قُلْتُمْ فَاعْدِلُوا وَلَوْ كَانَ ذَا قُرْبٰى وَبِعَهْدِ اللّٰهِ اَوْفُوا ذٰلِكُمْ وَصّٰيكُمْ
بِه۪ لَعَلَّكُمْ تَذَكَّرُونَ وَاَنَّ هٰذَا صِرَاط۪ي مُسْتَق۪يمًا فَاتَّبِعُوهُ وَلَا تَتَّبِعُوا
السُّبُلَ فَتَفَرَّقَ بِكُمْ عَنْ سَب۪يلِه۪ ذٰلِكُمْ وَصّٰيكُمْ بِه۪ لَعَلَّكُمْ تَتَّقُونَ

“Ингэж хэл: Би танд Раббынхаа танд юуг харам болгосныг уншъя: Түүнд юуг ч тунш гэж үзүүзэй, аав-ээждээ сайн хандаарай, ядуурлаас айж хүүхдүүдээ алуузай! Учир нь таны ч тэдний ч ризкийг Бид өгнө. Муу муухайн илд нь ч далд нь ч дөхүүзэй ба Аллахын хүндэт (дархан) **болгосон амийг эрхгүйгээр хядуузай! Эдгээр нь Аллахын танд тушаал мөн. Бодоод ойлгох тань найдвартай.**

Идэр үед нь хүртэл өнчний барааг хамгийн сайнаар хадгал. Хэмжүүрийг ёсоор нь хий. Бид хүн бүрт хүч хүрэхээр чинээ л ачаална.

Үг хэлэхдээ, (тухай нь хэлсэн хүн) **таны садан хамаатан байсан ч эрх тэгш хандаад Аллахад ам өгсөн үгэндээ үнэнч бай. Аллах танд сайхан бодоорой гэж эдгээрийг тушаав.**

Мэдээж энэ нь Миний шув-шулуун зав мөн. Үүнийг дагаад, (бусад) **гамыг дагуузай. Учир нь бусад зам таныг Аллахын замаас салгана. Аллах болгоомжилж такватай болоорой гэж танд эдгээрийг тушаав.”** (эл-Эн’ам, 151-153)

Мэфрүк:

“–Аяа Курайш дүү! Чи өөр юунд урьдаг вэ? Валлахи эдгээр хүний яриа биш! Хэрэв хүмүүсийн ярианаас байсансан бол бид түүнийг маш сайхан мэддэгсэн,” гэв.

Энэ удаа Орчлонгийн Хүндэт -саллаллаху алэйхи вэ сэллэм-:

إِنَّ اللّٰهَ يَاْمُرُ بِالْعَدْلِ وَالْاِحْسَانِ وَاِيتَآئِ ذِي الْقُرْبٰى وَيَنْهٰى عَنِ الْفَحْشَآءِ وَالْمُنْكَرِ وَالْبَغْيِ يَعِظُكُمْ لَعَلَّكُمْ تَذَكَّرُونَ

“Андашгүй нь Аллах эрх тэгшийг, сайхан үйлсийг, садан хамаатнаа туслахыг тушаана, бузар үйлсийг, муухай ба догшин үйлсийг бол хориглоно. Түүнийг бодоод дагаарай гэж танд сургаал өгч байна,” (эн-Нахл, 90) аетыг уншив.

Мэфрүк:

“–Аяа Курайш дүү! Валлахи Чи намайг агуу ёс суртахуун ба хамгийн сайхан үйлсэд урив! Чамд худалч гэсэн ард нь гүтгэсэн л гэсэн үг шүү!” гэв.

Аймгийн ахмадаас Хани ба Мүсэнна ч ижил хариуг өгөв. Гэтэл аймгийнхтайгаа уулзаад ярилцахгүйгээр энэ саналыг зөвшөөрч чадахгүйгээ, түүнчлэн Пэрсийн Хосровтой гэрээ хийсэн тул энэ нь тэдэнд огт таалагдахгүйг хэлцгээв.

Эцэст нь уг чанартаа хүлээн зөвшөөрсөн боловч ашгаа алдах ба ямар нэгэн аюултай тааралдахаас айсан тул Аллахын Элчийн саналыг татгалзацгаав.[219]

Тарик бин Абдуллах -радъяллаху анх- ингэж ярина:

“Расулаллах -алэйхиссалату вэссэлам-ыг Зүлмэжаз Яармагт улаан хувцастайгаар нь харсан байлаа:

219. Ибн-и Эсир, *Усдү’л-Габэ,* V, 250-251; Ибн-и Кэсир, *эл-Бидая,* III, 187-189.

«–Аяа хүмүүс ээ! Ла илахэ иллаллах, гээд аврагдаарай!» гээд чанга дуугаараа ярьж байв.

Нэгэн чулуу атгасан эр Түүнийг дагаж яваад:

«–Хүмүүс ээ! Түүнийг ерөөсөө дагуузай, Тэр нь худалч юм,» гэж бархираад байв.

Чулуугаа шидэж Хүндэт Нэбий Эзний маань хөлийг шархдуулсан байв.

Би тэнд буй хүмүүсээс:

«–Энэ хүн хэн бэ?» гэж асуулаа.

«–Абдүлмутталибынхнаас нэгэн залуу,» гэцгээв.

«–Тэгвэл араас нь яваад чулуу хаясан нь хэн бэ?» гэлээ.

«–Тэр ч авга ах нь Эбү Лэхэб юм,» гэцгээв.” (Хаким, II, 668; Ибн-и Эсир, *Усдү’л-Габэ,* III, 71)

Орчлонгийн Хүндэт Эзний маань Исламыг тэблигийн төлөө дийлсэн төвгийн тухай нэгэн байдлыг ч Мүдрик эл-Эздий -радъяллаху анх- ингэж дамжуулна:

“Аавынхаа хамт хаж хийж байлаа. Минад хонохдоо хэсэг хүмүүстэй тааралдлаа. Аавaасаа:

«–Энэ хүмүүс юунд цуглаа вэ?» гэж асуулаа.

Аав:

«–Ардынхаа шашныг орхисон энэ хүний төлөө!» гэв.

Заасан тийш ширтвэл Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийг харлаа:

«–Аяа хүмүүс ээ! Ла илахэ иллаллах, гээд аврагдаарай!» гэж дуудаж байв.

Зарим нь Түүний нүүр лүү нулимж, зарим нь толгойд нь шороо цацаж, зарим нь ч дооромжилж байв. Үд болтол энэ нь ингэж явав. Тэр хооронд задгай захтай нэгэн охин, дүүрэн устай нэгэн сав ба алчуур бариад ирэв. Охин нь уйлж байв. Аллахын Элч нь савыг бариад ус уув, гар нүүрээ угаав. Толгойгоо өндийлгөн:

«–Миний охин, захаа алчуураараа далдал! Аваасаа болж баригдаад алагдана эсвэл хохирогдоно гэж санаа зовуузай!» хэмээв.

Энэ ирсэн нь хэн буйг асуулаа:

«–Охин нь Зэйнэб!» гэцгээв." (Ибн-и Эсир, *Усдү'л-Габэ,* V, 130; Хэйсэмий, VI, 21)

Хазрат-и Зэйнэб, Хазрат-и Цатима ба Оршигчдын Туяаны бусад охид нь бага ба залуу насаа Исламын хамгийн хүчгүй, мусульманчуудын хамгийн их дарагдсан эринд өнгөрөөсөн байв. Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- болон мусульманчуудын дийлсэн төвөгт доод зах нь тэдэн чинээ Хазрат-и Зэйнб ба дүү нэр нь ч хуваалцдаг байв. Аав нь гэрээсээ гарч Исламыг тэблиг хийж байхад тэд санаа зовоод шохоорхон үүдэн дээр хүлээж эсвэл хүндэт аавыгаа алхам алхмаар нь дагаж Түүнийг хамгаалахын хичээдэг байцгаав.

Пайгамбар Эзний маань энэ хүндэт охид нь ээж Хазрат-и Хатижаг өөд болоход ч аавдаа тусалсан, Түүний төвгийг хуваалцсан байв. Дийлсэн төвгөөр гуньж нулимс гоожуулсан байв. Фатима нь цусыг нь арчсан, Зэйнэб араас нь ус зөөж гар нүүрийг нь угаасан, олон жил санаа амаргүй амьдарсан байцгаав.

Аллахын Элчийн Указ яармагт Исламд урьсан олон аймгаас нэгэн бол Амир бин Са'Саагийнхан байв. Тэдэнд:

"–Би Аллахын Элч мөн! Таны дэргэд очвол, Раббынхаа тушаалыг ардад хүргэтэл, элчийн үүргийг гүйцэтгэтэл намайг хамгаална уу? Таны дундаас хэнийг ч албадахгүй!" хэмээв.

"–Бид Чамайг хажуугаасаа ч хөөхгүй, Чамд ч итгэхгүй. Зөвхөн тэблийг үүргээ хийтэл хамгаална!" гэцгээв.

Тэр хооронд Бийхара гэсэн нэртэй, тус аймгаас нэгэн хүн гарч илрэв. Эзний маань хэн болсныг мэдсэн Бийхара нь өөртөө:

"–Валлахи энэ хүнийг Курайшаас нэг авч чадвал, Түүний ачаар хамаг Арабыг дийлнэ!" гэж бувтнэв. Дараа нь Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ээс:

"–Хэрэв бид Чамд ам өгөөд, Аллах ч Чамайг эсрэг ялагч болговол, Чиний дараа тэргүүний орон бидэнд залгамжлана уу?" гэж асуув.

Оршигчдын Туяа:

"–Үйлс Аллахад харъяалагдана! Аллах түүнийг хүссэндээ л өгнө!" хэмээв.

Бийхара:

"–Тэгвэл манай цээж Чиний төлөө хамаг Арабчуудын зорилго байх болно, Аллах Чамайг ялагч болохлоор ч тэргүүний орныг бусдад өгөх , биз?! Энэ нь бидэнд ашигггүй!" гэсний дараа аймгийнхандаа хандаж:

"–Энэ яармагаас танайхаас муу юмтай харьсан хэнийг ч би мэдэхгүй. Арабын хамаг аймгуудыг өмнөөс авах юм уу? Түүнийг өөрийнх аймаг нь танаас сайн мэднэ. Хэрэв аймгийнхан Түүнд нэгэн буян харсансан бол хэнээс ч илүү хамгаалахсан…" гээд орилов. Дараа нь Пайгамбар Эзэнд маань хандан:

“–Шууд эндээс босоод яв!” гэв.

Аллахын Элчийг тэдний дэргэдээс босч тэмээндээ унахад, Бийхара бузар нь тэмээний цээжийг гэнэтхэн хатгав. Тэмээг нь үсэрч босохдоо хайрт Пайгамбарыг маань унагаав.

Дубаа бинт-и Амир гэсэн нэртэй мусульман нэгэн эмэгтэй нь Эзэнд маань яаж хандсаныг нь харангуутаа:

“–Аяа Амирын удмынхан! Нүндий өмнөө Аллахын Элчид хүргэсэн энэ зовлонг хараад дотроос чинь Түүний миний нэрэ-эр хамгаалах хэн ч үгүй юү?” гэв.

Авга ахынхнаас гурав нь шууд ирээд хараалт Бийхара дээр алхав.

Энэ байдлын дараа Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэл-лэм- тэдний тухай:

“Аяа Аллах минь ээ! Эдэнд элбэгээ хайрлаад өг!” хэмээн залбирав.

Уг залбирлын элбэгээр Аллах Таала тэдэнд итгэл үнэмшил хайрлаж эцэст нь шэхидийн цолд хүртэцгээв.

Энэ аймгийн, хэт настай байсан тул хажжийн улиралд оролдож чаддаггүй нэгэн тэргүүн байв. Нутагтаа харихдаа бол-сон үйлсийг түүнд яриад өгцгөөв. Буурал хүн гараа яаралтай толгой дээрээ тавиад:

“–Аяа Амирынхан! Алдсан ийм завшаанаа яаж нөхөх вэ? Нэфсийг минь хүчит гараараа барьсан Аллахад тангараг өргөе, Исмаилын удмаас хэн ч өнөөдөр хүртэл худлаар пайгамбар болсноо хэлээгүй байдаг! Андашгүй нь Түүний хэлсэн нь үнэн

байв! Таны тэр оновчтой бодол тэр хооронд хаана байна вэ?" гээд тэднийг буруугаав.[220]

Эзэн маань -саллаллаху алэйхи вэ сэллэм- ийм олон сөрөг хандлагатай тааралдсан ч, ил шашныг хүмүүст тэблиг хийхээс ерөөсөө хойшлоогүй бөгөөд яармагт ирсэн хамаг аймгуудад үнэнийг илрүүлж өгөв.

Пайгамбар маань Хазрат-и Сэвдэтэй Гэрлэсэн нь

Сэвдэ эх маань Сэкран бин Амртай гэрлэсэн байв. Мусульманчуудыг тамлалтай учрахлаар Абиссинид нүүцгээв. Сэкран нь удалгүй тэнд нас барав. Хазрат-и Сэвдэ нь Исламын талаар үнэнч ба өгөөмөр зан толилуулж Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн магтаалыг олов. Пайгамбар Эзэн маань түүнийг, орсон гачаалаас аврах санаагаар түүнтэй гэрлэв.

Аллахын Элчийн Хазрат-и Сэвдэ эхтэй маань гэрлэлтэд Усман бин Маз'уны эхнэр Хавлэ Хатан учир болсон байв.

Хавлэ Хатан нь гэрлэлт санаагаа Хазрат-и Сэвдэгийн аавд мэдүүлэхэд тэр:

"–Үнэхээр Мухаммед маш цуутай нэгэн нөхөр байх болно!" гээд тэдний гэрлэхийг зөвшөөрөв.

Гэтэл Сэвдэ Хатан нь өнгөрсөн нөхрөөс тав юм уу зургаа хүүхэдтэй байсан тул Пайгамбар Эзэнтэй маань гэрлэхэд зорилгогүй байв.

Оршигчдын Туяаа -саллаллаху алэйхи вэ сэллэм- нь түүний эргэлзэж буйг харахлаараа:

220. Ибн-и Хишам, II, 33-34; Ибн-и Кэсир, *эл-Бидая*, III, 184; Ибн-и Насег, *эл-Исабэ*, IV, 353.

“–Чиний надтай гэрлэхэд саад болсон юм юу вэ?” хэмээн асуув.

Хазрат-и Сэвдэ:

“–Валлахи, аяа Расулаллах! Надад Чамаас хайртай хэн ч санагдахгүй байхад намайг Чамтай гэрлэхэд юу саад болж мэдэх вэ? Харин энэ бага хүүхдүүдийн өглөө оройгүй Чиний толгой дээр хашхираад үймүүлэхээс нь айж байна. Эсвэл би энэ ажлыг чамайг баяртай ба таатай болгохоор дуртай зөвшөөрнө,” гэв. (Ибн-и Са’д, VIII, 53-57; Ахмад, I, 318-319; VI, 211; Хэйсэмий, IV, 270)

Энэ гэрлэлт нь номлохын арав дахь жилийн Рамазан сард хэрэгжив.

Сэвдэ эх маань Оршигчдын Туянд анхаарал үзүүлдэг, үйлчлэхдээ дутагдал үлдээхгүй байв. Тэр нь Эзнийг маань ган-цаараа үлдсэн байхад Түүнд амьдралын хань болсон, Аллахын Элчийн сахил ба ээжийн халамжийн хэрэгцээтэй байсан бага охидод нь ч том халамж ба энэрлээх харж, тэднийг хайраараа өсгөсөн байдаг.

Номлохын Арван Нэг Дэх Жил

Акабагийн Уулзалт

Шөнийн цаг…

Кабаг зочлохоор ирсэн буй Мадинагийн зургуулын хамт олон нь Акаба хэмээн газар Орчлонгуудын Эзэн, Нэбийчүүдийн Тэргүүн Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-тэй таарал-дав. Түүний хорвоог гийгүүлдэг туяаг нь хараад:

“Энэ нь ямар гоё хүн юм бэ!” гэж хоорондоо ярилцав. Сэтгэлдээ тэр мөчөөр тайлбарлахын аргагүй тааламжтай ба дотуур хайрын соёолжийг ургуулах энэрлийн дусал урсч эхлэв. Тэр хооронд тэдэнд дөхсөн Оршигчдын Туяа ч номлох үүргийнхээ ёсоор тэднийг ч Исламд урихаар дуудав:

“–Жаахан суугаад ярилцах уу!” гэв.

Мадинагаас ирсэн зургуудын энэ азтай хамт олон нь ийм дурласан хүнтэй ярилцах завшаанд маш их баясав. Шууд Пайгамбар Эзний маань эргэн тойронд, гэрлийг тойрсон удган эрвээхий шигээ цугларчхав.

Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- тэдэнд Кур’ан-и Кэримээс ает уншиж Исламыг тэблиг хийв. Хоёр ертөнцийн жаргалыг хүсдэг юм бол, итгэл үнэмшлийн энэ урилгад орох хэрэгтэйг нь хэлэв.

Мадиначууд ойрдоо нэгэн пайгамбар ирж мэдэхийг овог дээдсээсээ сонссон, мөн хөрш еврейчүүдээс ч олон удаа дуудсан байв. Пайгамбар Эзний маань урилгыг сонсоод бие биедээ:

"–Андууд аа! Валлахи энэ нь еврейчүүдийн ирэх тухайн биднийг сүрдүүлсээр байсан пайгамбар мөн! Еврейчүүд Түүнд итгэхэд биднийг бүү даваг," гэцгээв.

Хүндэт Расулийн анх харснаасаа дурласан туяат царайнд нь дахиад нэг хараад, Түүний ярьсан нь үнэн буйг ухаарч тэнгэрлэг урилгад таатай "тийм" гэж хариулав. Бүгдээрээ кэлимэ-и гэхадэт авчирцгаав:

أَشْهَدُ أَنْ لاٰ إِلٰهَ إِلاَّ اللّٰهُ وَأَشْهَدُ أَنَّ مُحَمَّدًا عَبْدُهُ وَ رَسُولُهُ

Пайгамбар Эзэн маань тэднээс мусульманчуудын хамт Мадина очвол өөрсөд нь тусалж чадах эсэхийг асуув.

Мадинагийн энэ анхны мусульманчууд бол Эвс болох Хазрэж аймгуудын хооронд маш ширүүн дайнууд болсныг, тэдний хоорондын өстний харьцааг хэтэрснийг, энэ жил ирэх болбол тусалж чадахгүйгээ хэлээд жилийн хугацаа гуйв. Мадиначуудын Исламд урихаар ам өгөөд ирэх жил хажжийн улиралд тахиад ирэхээр зохицуулав.

Итгэл үнэмшлийн энэ жижиг дөл нь нутагтаа ижилгүй жаргал ба тайвнаар харив. Мунхаглалын хирээс арилсан, дээрх харанхуйн ачаа нь одоод шувуу шиг хөнгөлсөн байцгаав. Мадинад хүрэхдээ Орчлонгийн Эзэн Хоёр Хорвооны Сарны тухай яриад хүмүүсийн Исламд урьж эхлэцгээв. Мадинад

Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн тухай яриагүй ганцхан гэр ч үлдээгүй.[221]

Гурав дахь Шэрх-и Садр: Миражийн Бэлтгэл

Исра болон Мираж Шөнө Орчлонгийн Хүндэт -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн Аллах Таалатай учрахаас өмнө пайгамбарын ариун зүрхийг нь гурав дахь удаа тэнгэрлэг үзвэрт бэлтгээд цээжийг нь итгэл ба нууц учраар дүүргэв.[222]

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- үүнийг ингэж ярина:

"Би Кабагийн Хатийм хэмээн хэсэгт хэвтэж байлаа. Нойр ба сэрүүний хооронд хэн нэгэн над дээр ирээд цээжийг минь эндээс энд хүртэл ярав. (Энэ үгээ хэлж байхдаа төвөнхнөөсөө үс ургасан газар хүртэлх хэсгийг зааж байв.) *Зүрхийг минь гаргаж авав. Дараа нь итгэл үнэмшил ба нууц учраар дүүрэн алтан нэгэн сав авчрав. Зүрхийг минь (ус ба Зэмзэмээр) угаав. Дараа нь дотрыг нь итгэл үнэмшил ба нууц учраар дүүргэж дахиад байранд нь хийв…"* (Бухарий, Бэд'ү'л-Халк 6, Энбияа 22, 43; Мүслим, Итгэл 264)

Ижилгүй Бэлэг нь: Мираж

Исра байдал нь хижрээтээс 18 сарын өмнө хэрэгжив.

Исра ба Мираж хэмээн илэрхийлдэг энэ тэнгэрлэг бэлэг нь, хүмүүсийн хамаг хөшгийг өргөж ухааны цаана ба иж бүрэн тэнгэрлэг хэмжээнд хэрэгжсэн нэгэн шагнал мөн. Жишээлбэл, хүний хэмжээнд цаг ба орон гэсэн ойлголт үгүй болж, олон

221. Хар. Ибн-и Хишам, II, 38; Ибн-и Са'д, I, 219; Хэйсэмий, VI, 40.
222. Хар. Бухарий, Салат, 1; Мүслим, Иман, 263.

тэрбум хүний насанд багтахааргүй нэгэн зорчил ба тоолшгүй үзвэр нь хормоос богино хугацаанд хэрэгжсэн байдаг.

Аллах Таала айлдана:

سُبْحَانَ الَّذِيٓ اَسْرٰى بِعَبْدِهٖ لَيْلًا مِنَ الْمَسْجِدِ الْحَرَامِ اِلَى الْمَسْجِدِ الْاَقْصَا الَّذِي بَارَكْنَا حَوْلَهُ لِنُرِيَهُ مِنْ اٰيَاتِنَا اِنَّهُ هُوَالسَّمِيعُ الْبَصِيرُ

“Боол (Мухаммед-ыг) **нэгэн шөнө, Мэсжид-и Харамаас, Түүнд зарим аетуудаа үзүүлэхээр, эргэн тойргийг нь ариун болгосон Мэсжид-и Аксад аваачсан Аллахад ямар ч дутагдал байдаггүй. Гарцаагүй тэр бүгдийг ёсоор нь мэдэгч, ёсоор нь харагч мөн.”** (эл-Исра, 1)

Ает-и кэримэ нь илэрхийлсэн чухал ба гайхалтай зүйлсийн анхаарал татахаар Аллахыг магтаад эхлэв. Тэфсирч хүмүүсийн хэлснээр Аллахын гинжээс иж бүрэн хол буйг илэрхийлнэ. Түүнчлэн Эрхийн ер бусын урлагийн өмнө гайхалтаа илэрхийлэхээр ч хэрэглэдэг. Мөн түүнчлэн чухал тэсбих хийх үгсээс мөн.

Товчоор хэлбэл энэ үг;

1. Ухаан багташгүй Исра явдлыг магтах ба батлах; зүрхнүүдийг цэвэрлэгээний бэлтгэл мөн. Хүмүүсийг тэр туурвисандаа төсөөлөх ба Түүнийг махбодиор бодох алдаанаас ч хамгаална.

2. Миражийг болшгүй гэж үзэгчдийн эсрэг түүнийг хүч чадалгүй ба төсөөт хамаг дутагдлаас ариун буй үнэнийг илэрхийлнэ.

Ает-и кэримэгийн үргэлжлэлд шөнөд анхаарал татдаг. Учир нь Исра нь шөнийн зорчил гэсэн утгатай юм. Вахий нь ихэнхдээ шөнө ирдэг байв. Ээрэг-сөрөг хамаг биелэх ба оргил явдлууд ч ердөө шөнө илэрсэн байдаг. Жишээлбэл нафила залбирал үйлчилгээнээс үүрээс өмнө үйлддэг тэхэжжүд мөргөл нь оргил үйлчилгээ мөн.

Мэсжид-и Акса ба эргэн тойрны ариун болохыг ингэж тайлбарладаг:

1. Шашин ба дэлхийн элбэгээр баяжуулсан юм. Эргэн тойронд нь уул ус үргэлжилж, ургамал ногоо жигдэрсэн байдаг.

2. Маш олон пайгамбар тэнд амьдарсан ба ийм учраас ч вахий буусан орон юм.

3. Исрагийн явдлаас ч бас элбэг болгосон байдаг.

Энэ зорчилд Аллах боол ба Расул Мухаммед Мустафа -саллаллаху алэйхи вэ сэллэм-дээ сонин содон олон юм үзүүлэв.

❁

Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- тэр шөнө Мэсжид-и Аксад хамаг пайгамбаруудад имам болж мөргөл үйлдүүлэв.[223]

Эбү Хүрэйрэ -радъяллаху анх-ын дамжуулснаар, Исра шөнөд Хүндэт Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-д нэгэнд дарс, нэгэнд сүү байсан хоёр аяга авчрав. Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм- ингэж нэг гүйлгэсний дараа сүүний аягыг сонгов. Тэгэхлээр нь Жэбраил:

“–Чамайг хүний туурвисан зорилгод зохимжтойд чиглүүлсэн Аллахад хамд болог. Хэрэв дарсаар дүүрэн аягыг

223. Ибн-и Са’д, I, 214.

авсансан бол, чиний үммэт замаасаа төөрөхсөн,” гэв. (Мүслим, Иман 272, Эшрибэ 92)[224]

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- ингээд хамаг үммэтээ төлөөлж тэдний эрдмийн булаг болж байв. Энд сүү нь туурвилыг; дарс бол дэлхийг чухалчлахыг төлөөлж байв.

Аугаа Эрх нь ает-и кэримэд:

وَمَا يَنْطِقُ عَنِ الْهَوٰى

“Тэр нь дурынхаа дагуу ярьдаггүй,” (эн-Нэжм, 3) хэмээн айлдан Оршигчдын Туяа Эзний маань дураараа ярьдаггүй ба өөрөө юм хийгээгүйг мэдүүлэв.

Фаио-и Мутлак буюу Үнэн Үйлч нь Аугаа Эрх мөн бөгөөд Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- ч Тэрээрт чин үнэнээрээ бууж өгсөн байдаг. Энд Аллах Таала сүү сонгуулж Хайртыгаа хамгийн эрдэмтэд чиглүүлэв.

Исра явдлаар Мэсжид-и Харамаас Мэсжид-и Аксад хүргэсэн Пайгамбар -алэйхиссалатү вэссэлам-д, эндээс тэнгэрүүдэд үрүж хийх (өгсөх) буюу Миражийн алдрыг хайрлав. Үнэхээр нь Мэсжид-и Аксад хүрсэн Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм- эндээс Хазрат-и Жэбраил удирдсанаар “Сидрэ-и Мүнтэха” хүртэл өгсөв.

Орчлонгийн Эзэн Номлогчдын Титэм -алэйхиссалатү вэссэлам- Эзэн маань энэ явдлыг ингэж ярина:

---

224. Түүнчлэн хар. Бухарий, Тэфсир 17/3, Эүрибэ 1, 12; Нэсаи, Эшрибэ 41. Исра болон Миражаар Исламын хүний сэтгэлийн дагуу буйг зарласан; сэтгэл муут хүмүүст тэнгэрийн үүдийг онгойлгохгүйг илэрхийлсэн байв.

“–Би Кабагийн Хатийм хавьд унтаа ба сэрүүний хооронд байв... Дэргэд минь илжгээс том, лууснаас жижиг нэгэн амьтан авчрав. Энэ нь Бурак байв. Өмнөх хөлөө нүднийхээ харсан хамгийн хол цэгт тавиад урагшилж байв. Намайг түүн дээр унуулав. Ингээд Жибрийл -алэйхиссэлам- намайг аваачив. Дэлхийн сансарт хүрч одов. Хаалга нээв.

«– Хэн ирсэн бэ?» гэцгээв.

«–Жибрийл!» гэв.

«–Хажууд нь хэн бэ?» гэцгээв.

«–Мухаммед -алэйхиссалату вэссэлам-» гэв.

«–Түүнд Миражийн урилга илгээв үү?» гэцгээв.

«–Тийм!» гэв.

«–Тавтай морилог! Ирсэн нь маш сайн болов!» гээд хаалгыг нээцгээв.

Хаалгаар оронгуут Хазрат-и Адам -алэйхиссэлам-ыг харлаа.

«–Энэ нь танай эцэг Адам мөн! Түүнд мэнд хүргэ!» гэцгээв.

Би ч мэнд хүргэлээ. Тэр миний мэндийг хариулав. Дараа нь надад:

«–Салих хүү тавтай морил, салих пайгамбар тавтай морил!” гэв.

Дараа нь Хазрат-и Жэбраил намайг дээшлүүлж хоёр дахь сансарт хүргэв. Энд Хазрат-и Яхяа ба Хазрат-и Иса -алэйхимэссэлам-тай тааралдлаа. Тэд нагац эгчийн хүүхдүүд байв.

Дараа нь Жэбраил намайг гурав дахь сансарт гаргаж тэнд Хазрат-и Юүсүф -алэйхиссэлам-тай тааралдлаа. Дөрөв дэх давхарын сансарт Хазрат-и Идрис -алэйхиссэлам-тай, тав дахь давхар сансарт Харун -алэйхиссэлам-тай, зургаа дахь давхар сансарт бол Хазрат-и Муса -алэйхиссэлам-тай тааралдлаа.

«–Салих дүү тавтай морил, салих пайгамбар тавтай морил!» гэв.

Намайг тэндээс өнгөрөхөд тэр уйлав. Түүнээс:

«–Яагаад уйлаа вэ?» хэмээн асууцгаав.

«–Учир нь миний дараа нэгэн залуу пайгамбар болов. Түүний үммэтээс диваажинд орогчид, миний үммэтээс диваажинд орогчдоос олон!» гэв.[225]

Дараа нь Жэбраил намайг долоо дахь сансарт гаргаж Ибрахим -алэйхиссэлам-тай тааралдлаа.

Жэбраил -алэйхиссэлам-:

«–Энэ нь чиний аав Ибрахим мөн; Түүнд мэнд хүргэ!» гэв.

Би мэнд хүргэж, Тэр ч мэндийг минь хариулав. Дараа нь:

«–Салих хүү тавтай морил, салих пайгамбар тавтай морил!» гэв.

Дараа нь надад:

«–Аяа Мухаммед аа! Үммэтдээ надаас мэнд дамжуулаад тэдэнд диваажингийн хрөс маш сайхан, ус маш амттай, газар хөрөнгө нь уужим өргөн ба шув шулуун буйг мэдүүл.

225. Хазрат-и Муса -алэйхиссэлам- атаанаасаа болж уйлаагүй юм. Гардаж чадаагүй эрдэмд санаа зовсноос учиртай уйлжээ.

Тэдэнд диваажинд олор мод тарихыг хэл. Диваажингийн мод нь "Сүбханаллахи вэ'л-хамдү лиллахи вэ ла илахэ иллаллахү валлахү экбэр!" гэхээр бүрддэг,» гэв.

Дараа нь намайг Сидрэ-и Мүнтэхад гаргав. Үүний жимс нь (Йемений) Хэжэрийн ваар шиг том, навч нь ч зааны чих шиг байцгаав.

Жэбраил -алэйхиссэлам- надад:

«–Энэ нь Сидрэ-и Мүнтэха юм!» гэв."

Энд дөрвөн мөрөн байв: Хоёр нь далдын мөрөн, хоёр нь ил мөрөн.

«–Эдгээр юу вэ, аяа Жибрийл?» хэмээн асуулаа.

Жэбраил -алэйхиссэлам-:

«–Далдын энэ хоёр мөрөн диваажингийн хоёр мөрөн мөн. Илчүүдийн нэгэн Нил, нөгөөх нь ч Евфрат мөн!»[226] гэв..." (Бухарий, Бэд'ү'л-Халк, 6; Энбияа, 22, 43; Мэнакибу'л-Энсар, 42; Мүслим, Иман, 264; Тирмизий, Тэфсир 94, Дэават 58; Нэсаи, Салат, 1; Ахмад, V, 418)

Сидрэ-и Мүнтэхад Жэбраил -алэйхиссэлам-:

"–Аяа Аллахын Расул аа! Эндээс цааш ганцаараа явна!" гэв.

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-:

"–Яагаад, аяа Жибрийл ээ?" хэмээн асуув.

---

226. Нэгэн үзлээр Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн Нил ба Евфрат мөрнийг диваажинд үзсэн нь ийм л утгатай байдаг:
Исламын туяа нь дэлхий даяар тараагдана; Ислам нь Нил болон Евфратын бассен дахь элбгтэй орон нутгыг эзэлж, тухайн хэсгийг Ираны галын шүтлэг ба Бизансын гуравт шүтлээгээс аврах болно. Энэ хөндийн хүмүүс олон удмаар Тэвхидийн тугийг барьж Исламд үйлчлэх болно.

Тэр ч хариулан:

"–Аллах надад энд хүртэл гарах зөвшөөрөл олгов. Хэрэв эндээс цааш нэг алхвал шатаад үнс болно!.." гэв. (Разий, XXVIII, 251)

Эндээс хойшхи замд Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- ганцаараа явав. Түүнд гайхамшигт үзвэр үзүүлэв. Аугаа Эрхийн гоо сайхантай уулзах нэр алдарт хүртэв.

Энэ зорчил дахь ер бусын үзвэрийг ёсоор нь илэрхийлэх нь, мөрөөдлөөс цааш нэгэн үнэнийг хүний ухааны хүрээнд багтаахтай адил хэцүү нэгэн ажил юм. Үнэндээ юу болсон нь Аллах ба түүний Хабибынхаа хооронд мөнхийн нууц болсон гайхамшигт үзвэрүүд иж бүрэн "далдын ертөнцийн" нөхцөлд хэрэгжсэн байдаг.

Гэтэл, Аллах ба Тэрээрийн агуу Пайгамбарын хоорондох энэ шайхамшигт нууц хэрэг нь вахий хандсан хүмүүст Раббынхаа эцэсгүй хүч, чадал ба ноёрхлыг толилуулна.

Мөн Мираж хэрэг нь Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм- Эзний маань сүүлдээ Таифад тааралдсан харгислалын дүнгээр зүрхийг нь дүүргэсэн гунигийг баяр хөөрөөр эргүүлэх тэнгэрлэг зорилго агуулна.

Үнэндээ цаг ба орны гадна хэрэгжсэн энэ тэнгэрлэг явдлыг хүний ухаанаар бүрэн ойлгох нь боломжгүй юм. Хүний ухааныг хол давсан ийм мэдрэмжтэй ба тусгай сэдэвт ухааныг албадах манай шашинд хориглосон байдаг.

Эцэст нь Пайгамбар Эзэн маань -саллаллаху алэйхи вэ сэллэм- хамаг пайгамбарчуудын тухай хэрэгжсэн тэнгэрлэг шагналыг давсан тусгай тэнгэрлэг бэлгээр Миражид Аллахын Биед зориулсан цаг ба оронгүй нэгэн хорвоод:

فَكَانَ قَابَ قَوْسَيْنِ اَوْ اَدْنٰى

“(Мухаммед Мустафа ба Раббынхаа) **хооронд хоёр нумын чинээ, эсвэл түүнээс ч ойр болов,”** (эн-Нэжм, 9) гээд мэдэгдсэн нэгэн байдалтай учрав.

Энэ үзвэрийн хамгийн жижиг өөдөстэй нь учрахдаа, агуу пайгамбарчуудаас болсон ч Хазрат-и Муса -алэйхиссэлам-ын ухаан балартсаныг санавал, Пайгамбар Эзэн маань -алэйхиссалатү вэссэлам-ын Аллахын онгон дахь агуу орон ба Түүнд хайрласан тусгай шинжийг бага-сага ч ойлгож болно.

Нөгөө талаас Муса -алэйхиссэлам-д ариун газар орохдоо улавчаа тайлахыг тушаасан бөгөөд хөлийнх тэндийн алдраар алдар олохын санал болгосон байв. Гэтэл Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- Эзэнд маань Мираж Шөнөд ухаандаа:

“Аяа Амраг минь! Чи Огторгуйн дэвсгэрт гуталтайгаараа яваад, Огторгуй нь Чиний гутлын тоосоор нэр алдарт олж, Огторгуйн туяа Чамтай учрах шимд хүртэг!..” хэмээсэн байв. (Бурсэвий, V, 370)

Хоёр ертөнцийн Тэргүүнийг Миражид өгсөнөөр тэнгэрүүдийн автсан бишрэлийг шүлэгч Кэмал Эдиб Күркчүоглу маш сайхан илэрхийлэв:

Мираж Шөнөд царайг нь ширтсэндээ,
Талархлын мөргөл болохоор тэнгэр газар дээр бөхийнө!

❀

Аллах Таала нь Миражийг Кур’ан-и Кэримд ингэж зарлана:

وَالنَّجْمِ اِذَا هَوٰى

“Бууж буй одоор[227] тангараг өргөе.” (эн-Нэжм, 1)

Сура нь агуулсан үнэнийг үгүйсгэгчид эсэргүүцэж мэдэх учраас Миражийн үнэн хэргийг батлуулах тулд ийм нэгэн тангаргаар эхэлсэн байдаг. Жишээлбэл энэ байдал нь тангаргийн араас ирсэн ает-и кэримэнүүдэд ингэж батлсан байдаг:

مَا ضَلَّ صَاحِبُكُمْ وَمَا غَوٰى وَمَا يَنْطِقُ عَنِ الْهَوٰى
اِنْ هُوَ اِلَّا وَحْيٌ يُوحٰى عَلَّمَهُ شَدِيدُ الْقُوٰى
ذُو مِرَّةٍ فَاسْتَوٰى وَهُوَ بِالْاُفُقِ الْاَعْلٰى

“Таны анд (Мухаммед Мустафа) **төөрөөгүй ба худалд итгээгүй. Тэр дурынхаа дагуу ч ярьдаггүй. Түүний яриа нь вахийгаас өөр юм биш. Учир нь Түүнд хүчтэй ба агуу туурвилтай нэгэн** (буй Жэбраил, Раббынхаа тушаалаар) **сургав. Дараа нь хамгийн өндөр хязгаарт** (Сидрэ-и Мүнтэхад) **байхдаа жинхэнэ төрхөөрөө босч харагдав.”** (эн-Нэжм, 2-7)

Аетад буй “истива” хэмээн үг бүрдэх, бүслэх ба өндийх гэсэн утга агуулна. Тэфсирчдийн ихэнх нь истива гэсэн үгийн үйлдэгчийг Жэбраил -алэйхиссэлам- буйг зарласан боловч, Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм-д ч томилохыг илүүд үзсэн нь ч байдаг. Ийм тохиолдолд истива нь Аллахын Элчийн үнэ цэнийг, цол ба орны өндрийг илэрхийлнэ.

227. Аугаа Элрийн тангарагласан од гэсэн үгтэй хамаатай тэфсирчид зарим тайлбар хийсэн байдаг. Эдгээрээс хамгийн чухлаар нь “од”ыг Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм- эсвэл Кур’ан-и Кэримээс хэсэг хэсгээр буусан аетууд буйг илэрхийлцгээв. Ийм тохиолдолд одонд тангараглахын утгыг ингэж тайлбарлав:
1. Миражид өгссөн ба буусан Мухаммед Мустафагаар тангараглая!
2. Кур’аныг буухад ирсэн вахийн буух цагаар тангараглая!

Өөрөөр хэлбэл Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- нь эхлээд хамгийн өндөр хязгаарт босов:

ثُمَّ دَنَا فَتَدَلّٰى

“Дараа нь ойртож сээтэгнэв.” (эн-Нэжм, 8) Өөрөөр хэлбэл Оршигчдын Туяа нь тэнгэрлэг татмын нөлөөгөөр дээш явав. Байсан орон ба байрнаас дээш өгсөв.

Ингээд Агуу Пайгамбар нь Миражид хамгаас өндөр хязгаарт зөвхөн боссоноор үл барам Аллах өөд ойртов. Араас нь тэнгэрийг татмын нөлөө ихэсч ихэсч ихэсч, Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм- гэнэтхэн хамгаас өндөр хязгаарын цаана гаталчхав:

فَكَانَ قَابَ قَوْسَيْنِ اَوْ اَدْنٰى

“(Мухаммед Мустафа ба Раббынхаа) **хооронд хоёр нумын чинээ эсвэл түүнээс ч ойр болов.”** (эн-Нэжм, 9)

Ает-и кэримэ дэх قَابَ قَوْسَيْنِ اَوْ اَدْنٰى **“Хоёр нумын чинээ эсвэл түүнээс ч бага зай**” гэсэн үг нь хүний ухаанаас давуу үнэнийг хүний ухаанд багтаахаар хэрэглэсэн нэгэн төсөөлөх үг юм. Тайлбарлавал:

Исламаас өмнө Арабчууд, холбоо тогтоохоор гэрээ хийхдээ хоёр нум гаргаж, нэгийг нөгөөн дээр тавиад хоёрын хоёр үзүүрийг нэгдүүлж, дараа ч хоёрыг зэрэг татаж нэг сум харвадаг байв. Энэ нь тэднээс нэгний зөвшөөрөх юмыг нөгөө нь зөвшөөрч, нэгийг хилгэнэх юмыг нөгөөг нь ч хилэгнэхийг илэрхийлсэн хамтлаг нэгдлийн гэрээ байв.

Үүний дагуу “кабэ кавсэйн” нь эд барааны ч сүнсний ч ойр харьцааг агуулсан бөнөөд хүний ухааныг хол давсан агуу нэгэн

үнэн мөн. Өөрөөр хэлбэл Хазрат-и Мухаммед Мустафа -саллаллаху алэйхи вэ сэллэм- нь энэ цэгт Рабдаа хамаг хэрэгсэл нь үгүй болох чинээ дөхөөд шууд:

فَاَوْحٰىٓ اِلٰى عَبْدِهٖ مَآ اَوْحٰى

"Аллах тэр мөчид боолдоо вахийгаа мэдүүлэв." (эн-Нэжм, 10)

Энэ вахийн агуулга нь ингэж тайлбарласан байдаг:

1. Мөргөл: Мираж дахь хамгийн чухал хэргээс нэгэн өдөрт таван удаа мөргөл фарз болгосон нь юм. Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм- нь Муса -алэйхиссэлам-ын зөвлөлтөөр Аллахаас лавлан, эхлээд тавин удаа байсан фарз мөргөлийг тавд буулгав. Гэтэл Аллах таван удаа мөргөл үйлдсэнд тавин удаагийн буяныг хайрлахаа мэдүүлэв. Дараа нь Аугаа Аллах ингэж байлдав:

"Хэн нэгэн буян хиймээр байгаад хэрэгжүүлж чадахгүй бол, тэр хүнд (ийм сайн зорилтоос нь болж) нэгэн буян бичнэ, хэрэгжүүлсэн тохиолдолд бол арван буян бичнэ.

Хэн нэгэн ч муу юм хиймээр байгаад, харин хэрэгжүүлэхгүй бол, түүнд нүгэл бичихгүй. Хэрэв тэр муу юмыг хийвэл нэгэн нүгэл бичнэ!" (Мүслим, Иман, 259)

Энэ тухайх урт хадис-и шарифад илэрхийлснээр Аллах Таала нь эхлээд тавин удаагаар тушаасан мөргөлийг, Хүндэт Элч Эзний маань олон дахин лавласнаар таван удаад буулгав. Энэ бол хүмүүсийн дээрх Аллахын хуулийн ёсоор мөргөлийг тавин удаа үйлдэх нь зүйтэй бөгөөд, гэтэл Аугаа Эрхийн хайрласнаар тус хариуцлага аравны нэгэн харьцаанд багасгасан гэсэн утгатай юм. Үнэндээ Аугаа Эрхийн:

وَمَا خَلَقْتُ الْجِنَّ وَالْاِنْسَ اِلَّا لِيَعْبُدُونِ

“Би сүнс ба хүмүүсийг Надад боолчлохын төлөө л туурвив,” (эз-Зарият, 56) хэмээн зарлал нь хүний талаар гол үйлийн мөргөл буйг, гэтэл тэнгэрлэг энэрлийн ёсоор хамгийн хүчгүй бие хүнийг ч анзааран энэ тухай хөнгөлөлт хийсэн утгатай байсан шиг, албагүй байсан ч таваас илүү удааг зөвшөөрсөн ба хэрэгтэй буйг илэрхийлнэ.

Төгс итгэн үнэмшигчид нь фарз буй энэ таван удаагийн дээр нэмээд, духа, ишрак, эввабин мэтийн нафила мөргөл ч үйлддэг ба ялангуяа шөнө тэхэжжүдэд босно. Энэ бүх нь тус явдлын энгийн үр дүн юм. Гэтэл ийм залбирал үйлчилгээг, хүмүүсээс хүчээ хүргэж ба тэр тааламжид хүртэж чадахаар хэсэгт хамаарсны төлөө мөргөлийн тушаал нь тавин удаагаас эхлэн дараа нь Хазрат-и Пайгамбар -алэйхиссалатү вэссэламын лавласнаар таван удаад буулгав.

2. Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-д хандан:

“Пайгамбарчуудаас аль нь ч Чамаас өмнө, үммэтүүдээс ч аль нь Чиний үммэтээс өмнө диваажинд орохгүй!” хэмээн айлдав. (Разий, XXVIII, 248)

3. Бакара Сурагийн сүүлийн хоёр ает-и зэримэг нь вахий болгов.

Мүслимд дамжуулсан нэгэн хадис-и шариф ингэж айлдана:

“Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-д (Миражид) гурван юм өгөв: Таван удаагийн мөргөл, Бакара Сурагийн сүүлийг хоёр ает ба үммэтээс нь ширкэд автаагүйчүүдэд том нүглийн өршөөгдсөний мэдээ...” (Мүслим, Иман, 279)

Гэхдээ Мираж дахь вахийг яаж болсныг дэлгэрэнгүй зөвхөн Аллах ба Пайгамбар л мэддэг.

Энд ил байсан нь, Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн Мираж дахь үзвэрийн мөрөөдөл шиг биш, зүрх ба сэтгэл баталснаар үнэн хэргээр харсан нь юм. Өөрөөр хэлбэл:

مَا كَذَبَ الْفُؤَادُ مَا رَاٰى اَفَتُمَارُونَهُ عَلٰى مَا يَرٰى

"Мухаммед Мустафагийн **нүдээрээ харсныг зүрх нь үгүйсгээгүй.** Үгүйсгэгчид ээ! **Түүний харсан тухай одоо Түүнтэй маргалдах юм уу?"** (эн-Нэжм, 11-12)

Аллахын Элч нь Мираж Шөнөд Рабтайгаа учирч тоолшгүй үзвэр ба сургаалын байдал харсны дараа, хэн нэгэн боолын хүрч чадахааргүй тэр тусгай орноос буцахдаа Жэбраил -алэйхиссэлам-ыг орхисон газар (Сидрэ-и Мүнтэхад) дахиад нэг удаа жинхэнэ төрхөөр нь харав.

Ает-и кэримэ айлдана:

وَلَقَدْ رَاٰهُ نَزْلَةً اُخْرٰى عِنْدَ سِدْرَةِ الْمُنْتَهٰى

"Тангараглая (Мухаммед Мустафа), **түүнийг** (Жэбраилыг) **Сидрэ-и Мүнтэхад дахиад нэг удаа харав."** (эн-Нэжм, 13-14)

Аетад Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн цолоороо Жэбраил -алэйхиссэлам-аас урд байхыг заасан байдаг. Жишээлбэл Жэбраил -алэйхиссэлам- нь Мираж Шөнөд өөрийгөө: "Өчүүхэн дөхвөл яг шатна!" гэсэн байранд зогссон ба Пайгамбар Эзэн маань тэндээс цааш ч явав. Энэ үнэнийг, Аллахын Элчийг харихдаа дахиад Жэбраилтай тааралдсанаар улам бүр ойлгомжтой болдог.

عِنْدَهَا جَنَّةُ الْمَاْوٰى اِذْ يَغْشَى السِّدْرَةَ مَا يَغْشٰى

“Тэнд Мэ’ва диваажин байдаг. Тэр Сидрэг нь бүрдсэн байв.” (эн-Нэжм, 15-16)

Орчлонгийн Хүндэт -алэйхи экмэлү’т-тахийят- Эзнээс маань асуув:

“–Аяа Расулаллах аа! Сидрэг юу бүрдсэнийг хараа вэ?”

Ингэж айлдав:

“–Олон алтан сэнс түүнийг тойрох бөгөөд навч бүрт нь нэгэн мэлэк сууж Аллахыг тэсбих хийснийг харав.” (Табэрий, XXVII, 75; Мүслим, Иман, 279)

Ибн-и Аббас -радъяллаху анхүмаа-гийн дамжуулснаар:

Аллах Таала нь Мусаг яриа, Ибрахимыг найрамдал ба Мухаммед Мустафаг ч рү’етуллах (Аугаа Эрхийг аргыг нь бидний мэдэхгүй төрхөөр нь харах) шагналаар хүндэлсэн байдаг. (Табэрий, XXVII, 64)

Нүд Түүнээс өөр тийш хандахгүй нь хүмүүжлийн хамгийн оргил цэг юм. Үнэхээр:

مَا زَاغَ الْبَصَرُ وَمَا طَغٰى لَقَدْ رَاٰى مِنْ اٰيَاتِ رَبِّهِ الْكُبْرٰى

“(Мухаммед Мустафагийн) **нүд нь тэндээс өөр тийш хандаагүй ба хил хязгаараа ч даваагүй. Үнэхээр Тэр Раббынхаа хамгийн том аетуудаас** (бэлгэ тэмдгээс) **заримыг ч харав.”** (эн-Нэжм, 17-18)

Эдгээр аетуудаас ч ойлгосноор, Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм- нь Жэбраил -алэйхиссэлам-ыг агуулсан хэн нэгэн оршигчийн хилийг нь даваагүй “Сидрэ-и Мүнтэха”гаас цааш туулав. Аетад, хүний ухаанд “ хоёр нум

нийлүүлсэн эсвэл түүнээс богино" зай гэж мэдээлснээр, боолчуудын ухаарах нь балархай ба хувийн буй нэгэн учралт хэрэгжив.

Энэ учралтад Пайгамбарчуудын Хаан нь үг илэрхийлэх хүрээнд багтаашгүй агуу том үнэнийг буюу Раббын Раб болох аетуудаас, ноёрхлынх нь содноос зөвхөн ширтээд л хүрэмжтэй том бэлгэ тэмдгийн харж үзэв.

Энд тэфсирчид "Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм- зүрхний нүдээрээ Аллахыг харав," гэж илэрхийлэв. (Табэрий, XXVII, 63)

Ибн-и Аббас -радъяллаху анх-аас дамжуулснаар Хүндэт Расул -саллаллаху алэйхи вэ сэллэм-:

"Би аугаа Раббыгаа харсан!" хэмээв. (Ахмад, I, 285; Хэйсэмий, I, 78)

Өөр нэгэн дамжуулсан үгэнд Пайгамбар Эзэн маань "Раббыгаа харав уу?" асуултыг хариулан:

"Нэгэн туяа л харав!" хэмээв. (Мүслим, Иман, 292)

Хамгийн зөвийг нь Аллах л мэддэг…[228]

❁

Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм-ээс Исра ба Миражтай хамаатай олон мэдээ дамжуулсан байдаг. Тэдний зарим нь ийм байдаг:

Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- Миражид нэгэн учралаар хэсэг хүнийг харвал уруул нь тэмээний уруул

228. Миражтай хамаатай ает-и кэримэчүүдийг тайлбарлахдаа Элмалыгийн Хамди Языр Гуайн *"Үнэн Шашны Кур'аны Хэл"* хэмээн тэфсирийг нь ашиглав.

шиг юм. Элчүүд тэдний уруулыг хэрчиж аманд нь чулуу хийнэ.

"–Аяа Жибрийл ээ! Эд нар хэн бэ?" хэмээн асуув.

Жэбраил -алэйхиссэлам-:

"–Эд нар өнчдийн эд хөрөнгийг булааж идэгсэд юм!" гэв. (Табэрий, XV, 18-19)

Дараа нь Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- өөр нэгэн хэсэгтэй учрав. Тэд ч зэсэн хумсаараа царай ба цээжээ маажилзаж байв:

"–Аяа Жэбраил! Эд нар хэн бэ?" хэмээн асуув.

Жэбраил -алэйхиссэлам-:

"–Эд нар далдуур хүмүүсийн нэр алдрыг муулагсад юм," хариултыг өгөв. (Эбү Давуд, Эдэб, 35/4878)

Дараа нь Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм- Эзэн маань тэнд; зина хийгсдийг цогцос идэгч азгүйчүүд шиг; мөнгөний хүү идэгсдийг хэвлий нь бүр цүрдийсэн ба чөтгөр цохисон дорой нэгэн байдалд; санаатайгаар үрээ алсан эмэгтэйчүүдийг цээжээр нь таслан толгой нь доош өлгөөтэй байхыг харав.[229]

Ийм учраас Оршигчдын Туяа Эзэн маань:

"Хэрэв миний мэдснийг та нар ч мэдсэнсэн бол, андашгүй нь маш бага инээж ба ихээр уйлах байсан!" хэмээн айлдав. (Бухарий, Тэфсир, 5/12)

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- дахиад Миражид харсан үзвэрийн тухай нэгэн хадис-и шарифдаа ингэж айлдав:

229. Хар. Табэрий, XV, 18-19.

“Мираж Шөнөд диваажингийн үүдэн дээр ийм үг бичсэнийг харлаа:

«Садака буюу хандивыг арван дахин, зээл өгөхийг бол арван найман дахин шагнана.»

Би:

«–Аяа Жибрийл ээ! Зээлдэж өгсөн нь яагаад хандиваас илүү байна вэ?» хэмээн асуув.

«–Учир нь гуйгч нь өөртөө мөнгө байсан ч хандив гуйна. Зээл гуйгч бол хэрэгцээний улмаас юм гэсэн,» хариуг өгөв.” (Ибн-и Мажэ, Садакат, 19)

Оршигчдын Туяа -алэйхиссалатү вэссэлам- өөр нэгэн хадис-и шарифдаа ингэж айлдав:

“(Миражийн үеэр) диваажингийн үүдэнд зогсоод дотогш нь харлаа. Тэнд орогсод нь ихэнхдээ ядуучууд байв. Баячууд ч тооцоогоо өгөхөөр хорьсон байв. Эд нээс тамынханыг галд хаях тушаасан байв. Тамын үүдэнд ч зогсов. Тэнд орогсдын ихэнх нь эмэгтэй байв.” (Бухарий, Рикак, 51; Мүслим, Зүхд, 93)

Пайгамбар Эзэн маань -саллаллаху алэйхи вэ сэллэм- энэ хадис-и шарифтайгаараа ялангуяа эмэгтэйчүүдэд өөрсдийгөө хамгаалах талаар тусгай нэгэн сануулга мөн.

❀

Миражийн хэргээр дурдах хэрэгтэй өөр нэгэн үнэн ч, хүмүүс цагийн хэрээр зөвхөн өнгөрсний үзвэр ба сэтгэгдлээр дүүрэн байсан боловч, Пайгамбарчууд бол -Аугаа Эрхийн зөвшөөрсөн хэрээр- эртийн ч, эдүгээгийн ч, ирээдүйн ч мэдээллээр бэлдсэн байдаг. Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн нөгөө талын байдлыг мэдээлсэн ба энэ мэдээллийг “харав,

сонсов" мэтээр хэрэгжсэн шигээ илэрхийлсэн нь ийм үнэний илрэл юм.

Жишээлбэл Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- нь эрт, эдүгээ ба ирээдүйн хэмжээснээс гарсан Мираж Шөнөд ирээдүйтэй хамаатай зарим сургамжтай байдал үзсэн бөгөөд эдгээрийг өнгөрсөн цагаар буюу болсныг дамжуулав. Үүнтэй хамаатай нэгэн жишээ ч Ашэрэ-и Мүбэшшэрэ буюу амьд байхдаа диваажинд орох нь мэдээлсэн арван хүнээс Абдуррахман бин Авф Хазратын тухай юм.

Хадис-и фарифад ингэж айлдана:

"Тэр шөнө (Мираж Шөнөд) Абдуррахман бин Авфыг харлаа. . Түүнээс асууж:

«–Яагаад ийм удаан ирж байна вэ?»

Ингэж хэлэв:

«–Аяа Расулаллах аа! Эд хөрөнгөнийхөө тооцооноос болж, хүүхдүүдийг ч хөгшрүүлэхүйц хүнд бэрхшээлийг давлаа. Нэг дор таныг дахиад харж чадахгүй гэж бодлоо...»" (Мухаммед Парса, *Фаслу'л-Хятаб,* х. 403)

Абдуррахман бин Авф -радъяллаху анх- Мадинад нүүж баян болсон байв. Нэгэн өдөр чихэнд нь энэ мэдээ тусав. Шууд Хазрат-и Аиша -радъяллаху анхаа-гийн дэргэд очоод, Хазрат-и Пайгамбараас ийм нэгэн хадис-и шариф дуулсан эсэхийг асуув. Аиша -радъяллаху анхаа- энэ хадисыг дуулсныг хэлэхлээр нь, бассанаасаа сэтгэл хөөрсөн Абдуррахман бин Авф Хазрат нь, тэр хооронд Дамаскаас саяхан ирсэн буй жингээ буйгаар нь даруй Аллахын замд тараав.

Үнэхээр Миражид Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- тоолшгүй олон ает харсан мөн.

Жишээлбэл нэгэн хадис-и шарифдаа ингэж айлдана:

“Тэр шөнө би тэнгэр өөд өгслөө. Үзэгний шарчигнуулах дууг сонссоор нэгэн оронд гарав.” (Бухарий, Салат, 1)

Өөрөөр хэлбэл Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- нь орчлонгийн хувь заяаг бичдэг үзэгнүүдийн дууг сонсож, ухаанаас цааш үнэнтэй тааралдсан нэгэн төвшинд хүрсэн байв.

Дээрх Хадис-и шарифуудаас ил ойлгосноор, Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- Миражид эрт, эдүгээ ба ирээдүйг, нэг доор үзэж байв.

Миражаас Зарим Тэмдгүүд

1. Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- Эзэн маань энэ аялалд гарахаас өмнө “шакк-и садр” хэрэгжсэн байв. Үүний зааснаар сүнсний дээшлэх нь зүрхний ариун байснаар л боломжтой юм. Дотуур нь тэнгэрлэг туяанаас өөр юм үгүй нэгэн зүрх. Зүрхний хир арилахад, тэнгэрлэг нууцын үзвэрүүд зүрхийг эргэж эхлэнэ.

2. Исра явдал нь, боолоо шилмэл аргаар явуулсан Аллахын эцэсгүй хүч ба эрхийг толилууна.

3. Өөр нэгэн тэмдэг нь, Миражийн төвөг, гуниг ба тамлалаар дүүрэн Тасф аялалын дараа хайрласан нь ба төвгийн хооронд жаргалын мэдээлэгч байсан нь байв.

4. Кур’ан-и Кэримд бидэнд мэдэгдсэн фарзууд, Жэбраил -алэйхиссэлам-ын аргаар хэрэгжив. Мөргөлийг бол Миражид шууд Аугаа Эрх өөрөө тушаав. Энэ ч мөргөлийн тустай нэгэн нууц агуулдаг ба түүний бусад залбирал үйлчилгээний дунд тусгай чухалчлал багтаасныг заадаг.

Үнэхээр мөргөл нь шашны багана юм. Түүгээр олох төгс төгөлдөр шинж нь өөр ямар ч залбирал үйлчилгээгээр олддоггүй. Исламын залбирал үйлчилгээний дунд мөргөлийн цол нь ахиратын шимийн дунд оргил бүрдсэн рү'етуллах буюу Аугаа Аллахыг харах орон шиг байдаг. Учир нь мөргөл итгэж үнэмшигчдийн мираж мөн. Дэлхийд боолчуудын Эрхэд хамгийн ойр буй мөч нь, амар амгалан үйлдсэн мөргөлийн мөч мөн. Мөргөл нь боолын дэлхийд байхдаа Рабдаа учирсан нь мөн. Ийм учраас Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-Эзэн маань *"Мөргөл нь миний нүдний туяа юм,"*[230] хэмээж сүүлийн амьсгалаа үммэтдээ "мөргөлд анхаарал тавихыг"[231] гэрээсэлсэн байдаг.

5. Миражид Оршигчдын Туяа -саллаллаху алэйхи вэ сэллэм-Эзэнд маань тэнгэрийн үүд, хаалга нээгдсэн нь Түүний номлох зөвхөн Макка, Курайш ба Сакифаар хиллээгүйг, Түүнийг хамаг Орчлонгийн Нэбий ба Хорвоогийн Эзэн буйг үзүүлнэ.

6. Миражид хүний боловсролын хүрч чадах хамгийн сүүлийн цэгийг үзүүлсэн, өөрөөр хэлбэл хүний сүнсний дээшлэх хязгаар зарласан байдаг.

7. Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн Мэсжид-и Харамаас Мэсжид-и Аксад хүргэсэн нь түүхийн турш олон пайгамбар илгээсэн шашны энэ хоёр төвийн хоорондын бат холбоосыг бүх хүчтэй үзүүлсэн байдаг. Түүнчлэн энэ байдал нь Исламын хамаг тэнгэрлэг шашнуудыг агуулах, Аллахын онгон дахь ганцхан шашин буйг илэрхийлнэ. Жишээлбэл Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн Мэсжид-и Аксад хамаг нэбийчүүдэд имам хийсэн нь үүний өөр нэгэн заалт мөн.

230. Нэсаи, Ишрэтү'н-Ниса, 1.
231. Хар. Эбү Давуд, Эдэб, 123-124.

Миражийн Ойлтууд

Оршигчдын Туяа, Орчлонгийн Жаргал Эзэн маань Исра ба Миражийг Курайшийн мүшрикчүүдэд мэдээлэх болохдоо:

“–Аяа Жэбраил аа, ард минь намайг батлахгүй!” гэв.

Жэбраил -алэйхиссэлам-:

“–Эбү Бэкир Чамайг батална. Тэр нь үнэнч юм,” гэв. (Ибн-и Са’д, I, 215)

Мүшрикчүүд Миражийг сонсмогцоо шууд үгүйсгэж эхлэв. Орчныг хов яриа нь эзлэв. Үүнийг завшаан болгож итгэгчдийг ч энэ тухай худал яриагаар замаас нь буцаахын хичээцгээв. Түүнчлэн Хазрат-и Эбү бэкир дээр ч очицгоов. Гэтэл тэр нь Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм-д домог шиг үнэнчээрээ:

“–Тэр юу хэлсэн ч зөв юм! Түүний худал хэлснийг магадлах хэрэггүй! Би Түүний хамаг хэлсэнд бэлнээр итгэнэ...” гэв.

Мүшрикчүүд:

“–ЧиТүүнийг батлан, нэгэд шөнөд Бэйтү’л-Макдист очоод ирсэнд нь итгэж байна уу?” гэцгээв.

Хазрат-и Эбү Бэкир -радъяллаху анх-:

“–Тийм! Үүнд гайхах юу байна вэ? Валлахи Тэр надад шөнө эсвэл өдрийн ямар нэгэн үед өөрт нь Аллахаас мэдээ ирснийг хэлээд, би Түүнийг дахиад баталж байна,” гэв.

Дараа нь Эбү Бэкир -радъяллаху анх- нь тэр хооронд Кабад байсан Пайгамбар Эзний маань дэргэд очив. Юу болсныг шууд Түүний үгсээр сонсоод:

“–Зөв хэллээ, аяа Расулаллах!..” гэв.

Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- ч түүний баталсанд нь дурлаж, хорвоог гийгүүлсэн мишээлтэйгээр Хазрат-и Эбү Бэкирт:

"–Аяа Эба Бэкир ээ, чи «Үнэнч» мөн!.." хэмээв. (Ибн-и Хишам, II, 5)

Тэр өдрөөс хойш Эбү Бэкир -радъяллаху анх- "Сиддийк" нэрээр алдаршив.

Асхаб-и кирам хазрат ч Эбү Бэкир -радъяллаху анх- шиг Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийг баталцгаав.

Итгэж үнэмшигчдийн хуурч чадсангүй сүшрикчүүд, энэ удаа Пайгамбар Эзний маань онгонд гараад, ухаандаа Түүнийг шалгахыг хичээцгээв. Бэйт-и Макдисыг асууцгаав. Аугаа Эрх нь Бэйт-и Макдисыг Расулынхаа нүдний өмнө авчрав. Аллахын Элч -алэйхиссалату вэссэлам- ч, асуусныг Бэйт-и Макдисыг ширтэн хариулав. (Бухарий, Мэнакибу'л-Энсар, 41; Тэфсир, 17/3; Мүслим, Иман, 276)

Мүшрикчүүд энэ удаа ч зам дахь нэгэн сүг чөтгөр ба тэдний зарим шинжийг асууцгаав:

"–Аяа Мухаммед аа! Чи бидэнд, бидний хувьд Бэйтү'л-Макдисаас чухал буй чөтгөрийн тухай мэдээлэл өгчих!" гэцгээв.

Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-:

"–Тэр хөндийд олонтой таарaлдлаа.Бидний тэмээг нэгэн амьтны дуу үргээсэн, нэгэн тэмээ нь зугтсан байв. Би тэдэнд алга болсон тэмээний сургийг өгөв!" хэмээв.

Дараа нь ингэж үргэлжлүүлэв:

“–Дажнаана гэдэг газар сүг чөтгөртэй таарaлдлаа. Хүмүүс унтаж байв. Усаар дүүрэн нэгэн сав байж, дээр нь юм дэвссэн байв. Дэвсгэрийг нь нээж усыг уулаа.[*232] *Дараа нь дээр нь хэвээр нь хаалаа. Тэдний хамт олон одоо Бэйзагаас, Тэн'им налуугаар бууж байх ёстой. Хамт олны урдуур саарал нэгэн ат, атан дээр ч нэгэн хар, нэгэн цагаах хоёр шуудай бий!”*

Авсан хариунд андуурсан мүшрикчүүд:

“–Лат ба Уззад тангараг өргөе, энэ нь яг нэгэн тэмдэг юм,” гэцгээв. “Магадгүй сүүлдээ хэлсэн нь үнэн биш болов ,” гэсэн санаагаар Тэд налуу тийш гүйгээд очицгоов. Сүг чөтгөрийг хайцгаав. Сүг харагдахлаар:

232. * Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-:
“Мусульманчууд гурван зүйлд туншюм: Өвс, ус ба гал,” хэмээн айлдав. (Эбү Давуд, Бүюү', 60/3477)
Гэтэл хэн нэгэн усыг савандаа авсан байвал түүнийг эзэлсэн болж, зөвгөөрөлгүйгээр түүнийг ашиглах нь зөв биш юм. Ийм тохиолдолд Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн битүү савнаас ус уусныг яаж тайлбарлаж чадах вэ? Манай эрдэмтэд ингэж хариулав: Мунхаглалын үед Арабын зан каншлаар зорчигчдод хамаг малын сүүг нь ашиглахад зохимжтой гэж үздэг байв. Малчиддаа үүнийг бат сургаж, шинээр ажилд авсан малчиндаа, хажууд нь ирсэн хэн нэгэн зорчигчид ч сүү өгөхөд саад болохгүйг шаарддаг байв. Сүүг ийм байхад, уух ус ч зорчигчдод чөлөөтэй болох нь илүү үохимжтой юм. Исламд заншлын дагуу шийдвэр гаргах арга хүчинтэй байдаг. (Сүхэйлий, *Равду'л-Үнуф,* Бейрут 1978, II, 152)
Тийм болохоор Хазрат-и Пайгамбар Эзний маань Миражаас буцахдаа жингийн усыг уусан нь цаг ба орны талаар энгийн байдаг. Нөгөө талаас Аллахын Элч үүнийг Миражин талаар нэгэн тэмдэг ба баталгаа болгомоор байв. Үнэхээр ус уусныг нь сонссон мүшрикчүүд, “За, энэ нь андашгүй нэгэн тэмдэг юм. Очоод шалгаад үзье, хэлсэн нь үнэн үү?” гээд хариулан хандав.
Өөр нэгэн хадис-и шарифад ч ингэж айлдав:
“Гурван анги байдаг бөгөөд, Аллах Таала киямат өдөрт тэдэнтэй ярилцахгүй. Тэд: Хажуу дахь усын илүүг зорчигчид өгөөгүй хүн, оройгоос хойш бараагаа зарахаар -худал- тангараг өргөсөн хүн ба калифад бийат хийж, калиф нь түүнд (бараа) өгөхөд амласнаа хэрэгжиж, өгөхгүйд нь хэрэгжүүлдэггүй хүн юм.” (Эбү Давуд, Бүюү', 60/3474)

"–Валлахи жин нь ирж буй! Саарал атыг хамгийн урдуур явуулсан байна!?" гэцгээв.

Анх тааралдсан тэмээ нь тэдэнд тайлбарласан шиг байв. Хамт олноос усны савыг асууцгаав. Тэд ч савыг дүүрэн үлдээж, дээр нь хаасныг, гэтэл дараа нь ус байгаагүйг хэлцгээв.

Аллахын Элчийн ус уусны тухай энэ мэдээлэл нь, түүнчлэн Мираж бие ба сүнсээрээ нэг дор хэрэгжсэний заасан шинжийн нэг юм.

Курайш мүшрикчүүд бусад хамт олонуудаас ч асуух юмаа асууцгаав:

"–Үнэн! Түүний хэлсэн хөндийд нэгэн дуунаас үргэж манай нэгэн тэмээ ч зугтлаа. Нэгэн хүн биднийг тэмээнд маань дуудаж байв! Тэмээг түүний дуудсан газар олоод барьцгаалаа!" гэцгээв.

Түүнчлэн зарим нь уг дууны эзнийг ч таньж "Энэ нь Мухаммедын дуу мөн," гэцгээсэн байв.

Курайш мүшрикчүүдээс сүгнүүд тэмээ болон мэл хариулагчийн тоо хүртэл асуугаагүй юм үлдээгээгүй. Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- ч бүгдийн хариуг зөв өгөв. Учир нь сүг ч тэр мөчид яа Мэсжид-и Акса шиг Расулаллахын өмнө авчирсан байв. Гэтэл зүрх нь цоожтой байгсад зөрсөөр:

"–Энэ нь ил далангүй илбэ мөн!" гэцгээв. (Ибн-и Хишам, II, 10; Ибн-и Сэййид, I, 243; Хэйсэмий, I, 75; Бэйхакий, *Дэлаил*, II, 356)

Аллах Таала:

اَفَعَيِينَا بِالْخَلْقِ الْاَوَّلِ بَلْ هُمْ فِي لَبْسٍ مِنْ خَلْقٍ جَدِيدٍ

“Бид анх туурвахдаа хүчгүйдэл үзүүлэв үү? Үгүй, тэд л шинэ нэгэн туурвилын тухай сэжигт автсан байдаг,” (Каф, 15) хэмээн айлдана. Бүхнийг үгүй байхад бий болгосон Аллахын боолоо Миражид дээшлүүлснээс амар юу байх вэ? Үүнийг зөвшөөрөхгүй нь эрүүл ухааны дутагдлыг л заана.

Аргагүй, ухаангүй ба азгүй мүшрикчүүд Миражид ч итгээгүй, дахиад Аллахын Расулыг шоглосон байв. Одоо Орчлонгуудын Эзний тэдний хооронд байх шимийг хийсэн зохимжгүй үйлээрээ иж бүрэн алдсан байцгаав. Одоо энэ шимийг үнийг нь мэдээгүй Маккачуудын гараас татаж авах цаг болсон байв. Учир нь тэд, нэр алдраар нь туурвигдсан нэгэн Пайгамбарын эсрэг ухаанд багтаашгүй эрхгүйгээр хандсан, хил хязгаарыг бүр давсан байцгаав.

Үнэхээр хийх ганцхан юм үлдсэн байв: “Аллахын Оршигчдын Туяаг тэдний дундаас татаж аваад, Түүнийг үнэ цэнийг нь тэдэх өөр хүмүүст хайрлах нь!..”

Угаасаа Аугаа Эрх нь Таифын аяллын дараа их удахгүй Кур’ан болон Расулд итгэж ам өгөх шилмэл хамт олны анхны мэдээлэгчдийг хамт олноор нь Хайрт Элчдээ илгээсэн байв…

Номлохын Арван Хоёр Ба Арван Гурав Дахь Он

Акабагийн Нэг дэх Бий'ат

Зургуулаа Маккад ирж, Акабад итгэлийн туяагаар алдар олсон Мадиначууд нь дараа жил арван хоёулаа ирцгээв. Уулзах газар нь дахиад Акаба болов.

Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- шинээр ирэгчдийг ч тэвхидэд урив. Найзуудаасаа Исламын агуу ба сайхан талуудыг дуудаж Пайгамбар Эзний маань магтаалыг сонссон бусад зургаан хүн ч итгэн үнэмшив.

Түрүүний уулзалтаас ялгаатай тал нь, энэ удаагийн уулзалтад Оршигчдын Туяад бий'ат хийх буюу байнга дагахаар ам өгцгөөв. Мадиначууд Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн гарыг бариад анхны бий'атаа хийж ам өгцгөөв. Энэ бий'атаас болж Акабагийн хоёр дахь уулалтын "Акабагийн Нэг дэх Бий'ат" гэсэн байдаг.

Тус бий'атад Мадиначууд Аллахын Элчид эдгээрийг амлав:

1. Аллахад яасан ч түнш олгохгүй.
2. Хулгайлахгүй.
3. Зинад дөхөхгүй.

4. Охидоо амьд байхад нь булахгүй.

5. Хэнийг ч гүтгэхгүй.

6. Аллах болон Пайгамбарын үгнээс гарахгүй. (Бухарий, Мэнакибу'л-Энсар, 43)

Мадиначуудын энэ анхны баталгаа нь Исламын түүхэнд эргэлтйн цэг болов. Үүнтэйгээр хамаг Хижаз болон Арабын хойгт эзэлсэн буй ширк, харгислал ба муухай заншлуудыг үгүй болгох тухай ам өгсөн байцгаав.

Мус'аб аин Үмэйрийн Багшаар Томилогдсон ба Мадинаг Кур'анаар Ялсан нь (Номлохын 12-р Жил)

Мадинагийн шинэ мусульманчууд нэгэн захиа бичээд Исламыг сурах тулдаа Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ээс тэдэнд Кур'ан-и Кэрим унших, Исламыг ярих ба мөргөл үйлдүүлэх нэгэн багш илгээхийг гуйв. Пайгамбар Эзэн маань -алэйхиссалатү вэссэлам- ч Мус'аб -радъяллаху анх-ыг илгээв.[233]

Хүндэт Расул Эзэн маань Мус'аб -радъяллаху анх-ын хамт анх итгэн үнэмшигчдээс байсан Абдуллах бин Үмм-и Мэктүтийг ч Мадинад Кур'ан сургахаар илгээсэн байв.[234]

Мус'аб аин Үмэйр -радъяллаху анх- маш залуудаа авралд хүрсэн, гэр бүлийнхэн түүнд хүнд тамлал үзүүлсэн ба, түүнчлэн өв хөрөнгөний хувиараас хассан ч шашнаасаа буцаагүй байв. Учир нь тэр илээр ядуу ба хэн хүнгүй үлдсэн ч, дотроо итгэ-

233. Ибн-и Са'д, I, 220.
234. Бухарий, Мэнакибу'л-Энсар, 46.

лийн хайр ба бишрэлтээр дүүрэн баян сэтгэлтэй байв. Исламыг дэвшүүлэх төлөө бараг бишрэлтийн хөшөө шиг байв.[235]

Тэгэхлээр нь Мус'аб -радъяллаху анх-ын Мадинад очсоноор Ислам нь тэнд сайхан дэлгэрэв. Пайгамбар Эзний маань тэблигээр томилсон энэ залуу сахабий нь хүмүүст Аллахын шашныг ярихаар өдөр шөнөгүй ажиллаж эхлэв. Мус'аб -радъяллаху анх-ын хичээсний элбэгээр авралд хүртсэн анхны жаргалтдаас Эс'ад бин Зүрара -радъяллаху анх- түүнийг гэртээ хүндэлж, хамаг үйл ажиллагаанд нь түүнд тусалж байв.

Тэр нь нэгэн өдөр Мус'абыг хажуудаа аваад Зафарынхны цэцэрлэг дэх худаг дээр суув. Абдүлэшхэлийнхний тэргүүлэгчдээс Са'д бин Муаз үүнийг сонсонгоо Үсэйд бин Худайрт:

"–Чи ажлаа сайн мэддэг ба хэнийх ч тусламжийн хэрэгцээгүй нэгэн хүн юм. Манай хүчгүйчүүдийн шүтлэгийг эвдэхээр манай хороололлд ирсэн тэр хүмүүсийн дэргэд очоод тэднийг сануул, дахиад манай хороололд бүү ирэг! Эс'ад миний хамаатай байгаагүйсэн бол энэ ажлыг би өөрөө хийх байсан," гэв.

---

235. "Бид Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн хамт мэсжидэд сууж байв. Мус'аб орж ирэв. Дээрээ олон хэсэг дахаар нөхсөн нэгэн цамцнаас өөр юм байгаагүй. Аллахын Элч түүнийг харангуутаа Макка дахь шимээр дүүрэн амьдарч байсан байдалтай одоогийн байдлыг нь зүйрлэн уйлав. Дараа ч ингэж айлдав:
«–Таны нэгэн өглөө өөр, үдээс хойш сайхан хувцас өмссөн, өмнөө нэгэн таваг тавьж нөгөөг хураасан, гэрээ Кабаг бүрдсэн дэвсгэрээр бүрсэн тохиолдолд таны байдал хэр байх вэ!»
«–Аяа Аллахын Элч ээ, мэдээж бидний байдал тийм тохиолдолд өнөөгөөс сайн байх болно. Учир нь тийм тохиолдолд бидэнд аж ахуйн асуудал болохгүй, өөрсдөө өүр залбираллд зориулах болно,» гэцгээв.
Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- ингэж айлдав:
«–Эсрэгээр нь өнөөдөр та тэр өдрөөс илүү буянтай байдалд байна.»"
(Тирмизий, Киямат, 35/2476)

Үсэйд жадаа барингуутаа тийш яваад, нэлээд хилэнтэй дуугаараа:

“–Та энд юунд ирээ вэ? Энэ чиний дэргэд гадны хүнийг бидний хүчгүйчүүдийн шүтлэгийг эвдэхээр авчраа юу?! Дахиад ийм юм бүү хий! Хэрвээ аминдаа хайртай бол үтэр түргэн эндээс холд!” гэв.

Фирасатын ухаантай нэгэн сахабий байсан Мус’аб -радъяллаху анх- түүнд:

“–Жаахан суугаад миний хэлэх юмыг сонсоно уу? Чи ухаантай хүн юм, миний үгэнд дурлавал хүлээж авна, дурлахгүй бол хүлээж авахгүй,” гэв.

Үсэйд:

“–Ухаантай үг хэлцгээ!” гэсний дараа жадаа газар хатгаж тэдний дэргэд суув. Мус’аб нь Исламыг яриад Кур’ан-и Кэрим уншив.

Үсэйд Кур’ан-и Кэримийн соносхдоо, арай ярьж л эхлэлгүй царайнд нь Исламын туяа гялалзаж эхлээд, зүрх нь Исламаар зөөлрөв. Кур’ан-и Кэримийн тухай ч:

“–Энэ нь ямар гоё, ямар агуу нэгэн үг![236] Та энэ шашинд ормоор байвал юу хийх вэ?” гэв.

---

236. Үсэйд -радъяллаху анх- гоо сайхныг нь анхны тааралдахдаа анзаарсан Аллахын Үгийг амьдралынхаа турш том нэгэн хайр ба бишрэлттэйгээр уншсан байв. Өөрөө ингэж ярина:
“Нэгэн шөнө Бакара Сураг уншиж байлаа. Миний морь ч яг дэргэд уясан байж байв. Гэнэтхэн морь нь цоройж эхлэв. Уншихаа байвал морь тайвшрав. Дахиад уншиж эхлэбэл морь нь дахиад цоройв. Түүнчлэн хүү Яхняагаа морь гишгэж мэдэн эж айснаасаа дэрдэгээ татав. Тэр хооронд дээш харвал над дээр туяатай төсөөтэй зүйлс буйг харлаа. Дараа нь тэд тэнгэр өөд өгсөж алга болцгоов. Өглөө юу болсныг Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-д ярихлаар надад:

Үсэйд -радъяллаху анх- босоод Хазрат-и Мус’аб ба Эс’ад -радъяллаху анхүмаа- нарын зааснаар гусул авч, хувцсаа цэвэрлэж шэхадэт авчрав. Дараа ч хоёр рэкат мөргөл үйлдэж:

“–Би хойноо нэгэн хүн үлдээсэн, тэр таны үгэнд орвол ардаас нь хэн ч түүнийг эсэргүүцэж чадахгүй. Тэр нь Са’д бин Муаз юм! Би одоо түүнийг танд илгээнэ!” гэв.

Са’д ууртай буйгаар тэдний дэргэд ирэв. Харин эцэст нь тэр ч Хазрат-и Үсэйд шиг Мус’аб -радъяллаху анх-ыг сонсоод мусульман болов. Дараа нь аймгийнхныхаа дэргэд очоод:

“–Аяа Абдүлэшхэлийнхэн! Намайшг яаж таньдаг вэ?” гэж асуув. Тэд:

“–Чи бидний эзэн, бодлоороо хамгийн давуу ба тэргүүн мөн,” гэцгээв.

Тэгэхлээр нь Са’д -радъяллаху анх-:

«–Унш Үсэйд ээ, унш!» хэмээв... ==>
Тэгээд:
«–Үсэйд ээ! Тэр харсныгаа юу гэдгийг мэднэ үү?» хэмээн асуув.
«–Үгүй,» гэлээ.
Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-:
«–Тэд чамайг Кур’ан уншихад сонсохоор ирсэн мэлэкчүүд байв. Хэрэв чи угшсаад байсансан бол өглөө болтол чамайг сонсох байцгаав. Тэд мэлэкчүүд хүмүүст нууц болохгүй, хүмүүс ч тэднийг харж чадах байцгаав,» хэмээв.” (Бухарий, Фэдаилу’л-Кур’ан, 15)
Аиша -радъяллаху анхаа- ярина:
“Үсэйд бин Худайр -радъяллаху анх- хамгийн эрдэмтэй сахабийчуудаас байв. Байнга ингэж хэлдэг байв:
«Хэрвэ би байнга уг гурван байдлаас нэгэнд байсансан бол, андашгүй нь диваажингийнхаас болохсон: Кур’ан-и Кэримийг уншсан эсвэл сонссон байхад, Пайгамбарын маань хутбаг сонссон байхад ба нэгэн шарил харсан байхад. Тийм ээ, хэзээ ч нэгэн шарилтай тааралдвал түүнд болох юмуг надад болох юм шиг, түүний очх гакар би өөрөө очих юм шиг бодно.»”
(Хаким, III, 326/5260)

“–Таныг Аллах болон Расулд нь итгэтэл, эр ба эмчүүдтэй тань ярих нь надад харам байх болтугай,” гэв.

Тэр өдөр үдэш хүртэл тус аймгаас мусульман болоогүй хэн ч үлдээгүй. (Ибн-и Хишам, II, 43-46; Ибн-и Са’д, III, 604-605; Ибн-и Эсир, *Үсдү’л-Габэ,* I, 112-113)

Хазрат-и Мус’аб -радъяллаху анх- нь Сэлимийнхний алдартдаас Амр бин Жэмүхийг ч Исламд урив. Түүнд Юүсүф Сурагийн анхны найман аетыг уншив. Амр бодохооор жаахан хугацаа нэхсэн ч яасан ч шийдэж чадаагүй. Тэгэхлээр нь Амрын өмнө нь мусульман болсон хөвүүн Муаз аймгийнхнаас мусульман залуучуудтай тохиролдуулж нэгэн шөнө аавынхаа баримлыг нууцаар ойрын бохирын нүхэнд хаяв. Өглөө үүнийг харсан Амр нь хэт айгаад баримлаа нүхнээс гаргаж, цэвэрлээд сайхан үнэр түрхсэний дараа байранд нь тавив.

Ижил юм хэдэн хоног дахихлаар нь, баримлыг өөрийгөө хамгаалах тул хүзүүнд нь сэлмээ зүүв. Дараа өдөр баримлаа дахиад нүхэнд харахлаараа, залбирч үйлчилж байсан амьгүй юмын яаж ч чаддаггүйг, биеэ хамгаалж ч чадаагтүйг ухаарч ширкийн харанхуйнаас гарч Исламын туяат өглөөтэй золгов. өөрийгөө Пайгамбар -алэйхиссалатү вэссэлам-ын адилаар зөв замд оруулсан Аллахад талархлаа илэрхийлэн шүкүр хийв. Дараа ч ардаа Исламд урамшуулав.[237]

Исламыг Мадинад ингэж сайхнаар хүлээн авсан тухай мэдээллийг авсан Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- болон Маккагийн мусульманчууд хэт баясцгаав. Тэгээд тэр жилийг “Баясах Жил” нэрийг өгөв. Учир нь одоо Мадина нь Исламын өлгий болоход бэлэн болж байв.

237. Ибн-и Хишам, II, 61-63; Зэхэбий, *Сиер,* I, 182.

Аугаа Пайгамбар -алэйхиссалатү вэссэлам- Эзэн маань ингэж айлдав:

“Орнуудыг сэлэмтэйгээр эзлэв, гэтэл Мадинаг Кур’антайгаар л эзэллээ.” (Бэззар, *Мүснэд*, №: 1180; Руданий, №: 3774)

Акабагийн Хоёр дахь Бий’ат (Номлхын 13-р Жил)

Акабагийн хоёр дахь уулзалтаас жилийн дараа Мадиначууд, дахиад хажжийн улиралд Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-тэй уулзав. Энэ удаа хоёр нь эмэгтэй, далан тавуулаа байцгаав.

Пахиап Аллахын Элчип бий’ат хийцгээв. Үүнийг ч “Акабагийн Хоёр дахь Бий’ат” гэцгээв.

Хамт олны тэргүүнээр ирсэн Мус’аб -радъяллаху анх-өөрийн гэртээ ойртохоос өмнө Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн дэргэд очив. Энсарын Исламын хурдан хүлээж авсны мэдээллийг хүргэж өгөв. Орчлонгуудын Эзэн -саллал-лаху алэйхи вэ сэллэм- нь Мус’абын авчирсан мэдээллээр баясав.

Хазрат-и Мус’абын эхлээд Аллахын Элч -саллаллаху алэй-хи вэ сэллэм-ийн дэргэд очсон нь мүшрик эхийнх нь чихэнд хүрэхлээр маш их уурлав.

Тэр бол:

“–Би Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ээс өмнө хэний дэргэд ч очихгүй, Түүнийг байхад хэн ч түрүүлэхгүй,” гэв.

Эзнээс маань зөвшөөрөл амсны дараа ээжийнхээ дэргэд очоод түүнийг Исламд урив. (Ибн-и Са’д, III, 119)

Асхабын Расулаллах хайр нь ийм л байв.

Жабир -радъяллаху анх- ингэж хэлнэ:

“Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм- Эзний маань өөрийгөө болон мусульманчуудыг хамгаалах нэгэн аймаг хайж хэний ч Түүнд үүдээ нээгээгүй өдрүүдэд, Аллах Таала биднийг Есриб (Мадина)гаас Түүнд илгээж, бид ч итгэж үнэмшиж биеийг нь хамгаалав. Биднээс нэгэн очоод Аллахын Элчид итгэдэг, Эзэн маань ч түүнд Кур’ан уншдаг байв. Гэртээ харихлаараа хамаг гэрийнхэн түүнийг дагаж мусульман болдог байв. Энсарын гэрүүдээс Ислам тайлбарлаагүй ганц гэр үлдээгүй. Дараа нь цугларч ярилцаад:

«–Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийг хэр удаан Маккагийн уулнуудад харгислал ба төвөг дотор үлдээх вэ?!» гэцгээв.

Тэгэхлээр нь хажжийн улиралд бий’ат хийхээр Түүний дэргэд очицгоов.” (Ахмад, III, 322; Хаким, II, 681-682)

Энэ аз жаргалтай хүмүүс Пайгамбар Эзэнтэй маань хамтрах өдрүүдэд Акаба гэсэн газар уулзахаар тохиролдов. Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- Мадиначуудад:

“–Унтсаныг сэрээгүүзэй, цагт нь уулзах газар ирээгүйг ч хүлээгүүзэй!” хэмээв.

Шөнийн гуравны нэг нь өнгөрөхлөөр нь Орчлонгийн Хүндэт Эзэнтэй маань тохиролцсон ёсоор Акабад очоод Түүнийг хүлээж эхэлцгээв. Эцэст нь Расулаллах Эзэн маань авга ах Аббасынхаа хамт ирэв. Аббас арай мусульман болоогүй ч Эбү Талибын дараа ачийгаа хамгаалалтдаа авсан байв. Мадиначуудын Аллахын Элчийг өөрийнх нутагт урьснаар Аббас тэдэнд ингэж хэлэв:

“–Мадиначууд аа! Бид нар Түүнийг дайсдаас хамгаалав. Бас хамнаалах болно. Түүний бидний хоорондох орон өндөр юм. Гэтэл та хайр ба хүндэтгэлээрээ илүү аюулгүйд болохын тулд Түүнийг Мадинад урьж байна. Тэр ч ийм л хүсэлтэй. Харин Түүнийг дайснаас нь хамгаалж чадах бол нутагтаа аваачаарай. Би танаас Түүнийг орхихгүй , хуурахгүй гэсэн бат нэгэн ам авмаар байна. Учир нь таны хөрш буй еврейчүүд миний ачийн дайсан юм. Би тэдний хавх тавихгүй гэдэгт итгэлтэй биш байна. Араб аймгуудын ч дайсны харьцаанд дийлж чадах чинээ дайны хүчтэй байвал ийм ажил оролдоорой. Хоорондоо сайн бодолцож, дараа энэ тухай тунгаа! Хэрэв таны дэргэд очсоны дараа айж Түүнд тусалж чадахгүй, Түүнийг эсрэг талд гардуулж өгөх юм бол, өөрсдөө итгэлтэй биш юм бол, одоогоос боль! Таны хооронд ярих юмсан хүн байвал яриарай, харин яриагаа их битгий удаагаарай. Учир нь бүх талд мүшрикчүүдийн мануул тагнуулууд бий! Эндээс тарахлаараа ч энэ уулзалтыг нууц байлгаарай!”

Эс’өд бин Зүрара -радъяллаху анх- босоод Пайгамбар Эзний маань авга ах Аббасын илэрхийлсэн санааны хариугаар ийм үг хэлэв:

“–Аяа Расулаллах аа! Чи биднийг дээр үеэс шүтэж байсан шашнаа орхиж өөрийнхөө шашинд оруулахаар урив. Энэ нь маш хэцүү ба хүнд байсан ч бид Чиний уг саналыг хүлээн авлаа. Чи биднийг хол-ойргүй мүшрик хамаг садан хамаатан ба хөршчүүдтэйгээ харьцаагаа тасал гэж урив! Энэ ч маш хэцүү ба хүнд байсан ч бид Чиний энэ саналыг ч хүлээн зөвшөөрлөө! Бид нар, зөвхөн аймгийнхан биш, өөрийнх авга ах нар ч алмаар буй хүнийг хамгаалах болсноо мэддэг. Гэтэл бид Чиний энэ тухай саналыг ч хүлээн зөвшөөрлөө. Аяа Аллахын Элч ээ! Бид өөрсдийгөө, хөвүүдээ ба эмэгтэйчүүдээ хамгаалах шигээ Чамайг ч хамгаална. Хэрвээ энэ амалснаа эвдвэл, Аллахын

гэрээг эвдсэн азгүй хүмүүс байх болтугай! Аяа Расулаллах аа! Энэ нь бидний Чамд өгсөн үнэнчийн ам мөн! Тусламжид нь хоргодох буй нь зөвхөн Аллах Таала мөн!"

Хазрат-и Эс'адын дараа Абдуллах бин Раваха -радъяллаху анх- босоод Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-д:

"–Аяа Расулаллах аа! Раббын ба өөрийнхөө төлөө биднээс хүссэнээ шаардаж болно," гэв.

Аллахын Хайрт -алэйхи экмэлү'т-тэхаяа- Эзэн маань ингэж айлдав:

"–Раббынхаа төлөө шаардлага минь, Түүний боол Аллахад түнш байхгүй гэж үзэх юм. Өөрийнхөө төлөө , амь ба бараагаа яаж хамгаалдаг билээ , намайг ч тэгж хамгаал."

Мадинагаас ирсэн сахабагийн ариун хамт олон асууцгаав:

"–Ингэвэл хариуд нь бидэнд юу байдаг вэ?"

Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм- хариулан:

"–Диваажин байдаг!" гэхлээр нь тэндэх хүмүүс:

"–Ямар ашигтай худалдаа юм аа! Үүнээс буцах ч үгүй, буцахыг хүсэх ч үгүй!" гэцгээв. (Ибн-и Кэсир, *Тэфсир,* II, 406)

Абдуллах бин Раваха -радъяллаху анх- нь Мүтэ дайнд энэ ашигт худалдаагаа бүтээсэн, Оршигчдын Туяанаас шэхид болох мэдээллээ аваад, дайнд амь алдахаа мэдсэн ч өөрийн хүслээр дайнд оролцсон, бараагаа төрийн санд, амиа ч Аугаа Аллахад зориулаад Аугаа Диваажинд ниссэн байв. Бусад сахабийчууд ч тустай газруудад, Аллахын замд хичээсээр байгаад энэ бий'атдаа үнэнч хандсан, сүнсний худалдаагаа элбэгшүүлсэн байв.

Мадинагийн мусульманчуудын хийсэн энэ бий’аттай хамаатай энэ ает-и кэримэ буув:

اِنَّ اللّٰهَ اشْتَرٰى مِنَ الْمُؤْمِنِينَ اَنْفُسَهُمْ وَاَمْوَالَهُمْ بِاَنَّ لَهُمُ الْجَنَّةَ يُقَاتِلُونَ فِي سَبِيلِ اللّٰهِ فَيَقْتُلُونَ وَيُقْتَلُونَ وَعْدًا عَلَيْهِ حَقًّا فِي التَّوْرٰيةِ وَالْاِنْجِيلِ وَالْقُرْاٰنِ وَمَنْ اَوْفٰى بِعَهْدِهٖ مِنَ اللّٰهِ فَاسْتَبْشِرُوا بِبَيْعِكُمُ الَّذِي بَايَعْتُمْ بِهٖ وَذٰلِكَ هُوَ الْفَوْزُ الْعَظِيمُ

“Аллах итгэгчдийн бараа ба амийг тэдэнд диваажингийн хариугаар худалдаж авсан мөн. Тэд Аллахын замд байлдаж, алах ба алагдах болно. (Энэ нь), **Тэвратад, Инжийлд ба Кур’анд Аллахын эрх буй нэгэн амласан үг мөн. Амласнаа Аллахаас илүү хэрэгжүүлсэн нь хэн байдаг вэ? Тэгэхээр хийсэн буй энэ худалдаанаас болж баясцгаагаарай! Энэ нь** (үнэхээр) **том аврал мөн.”** (эт-Тавба, 111)

Үүний дараа цөөн хэдэн хүн ч үг хэлэв. Тэдний дараа Пайгамбар Эзэн маань Мадиначуудад хандаж тэдэнд Кур’ан-и Кэрим уншаад Исламыг ярив. Дараа ч ямар нөхцөлд бий’ат хийхийг нь тайлбарлав. Түрүүний зүйлсэд нэмж эдгээрийг ч энэ бий’атад дурдав:

1. Удирдлага нь итгэгчдээс хэнд байсан ч түүнийг үл эсэргүүцэх.

2. Аллахын замаар алхсанаас болж мүшрикчүүд ба бусад үгүйсгэгчид буруушаана гэж үл айх.

3. Элбэгт эсвэл бариуд, баярт эсвэл гунигт Аллахын Элчийг дуулгаварлах ба Түүнийг өөрийнх аминаас дээд үзэх; Түүнийг ямар ч тохиолдолд үл эсэргүүцэх.

Пайгамбар Эзэн маань:

“–Дундаасаа надад арван хоёр накиб[238] *гаргаад тэд аймгийнхаа төлөөлөгч байх болог!”* хэмээв.

Мадинагийн мусульманчууд ес нь Хазраж гурав нь Эвс аймгаас болоод арван хоёр накиб гарцгаав.

Оршигчдын Туяа нь төлөөлөгчид:

“–Хаварийчууд нь Иса бин Мэрьемийн төлөө батлан даасан шиг, та нар ч ардынхаа батлан даагч мөн. Би ч мусульман болсон ардынхаа батлан даагч юм!” хэмээв.

Накибчууд:

“–Тийм!” гэцгээв.

Оршигчдын Туяаны авга ах Аббас нэгэн модон доор Пайгамбарын маань гарыг барьж Мадинагийн мусульманчуудад нэг нэгээр нь бий’ат хийлгэв.

Энэ бий’атад Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийг урьж Мадинаг нүүхийг зохицуулав. Учир нь тэр үеэр Есриб гэсэн нэртэй асан Мадина нь бүх талаараа Исламыг тэврэхээр бэлэн болсон байв.

Бий’ат нь шөнө хэрэгжсэн учраас Маккагийн мүшрикчүүд тэр тухай мэдээ аваагүй. Бий’ат хэрэгжиж төгс болсны дараа Акабагийн дээрээс чөтгөр:

“–Аяа Минагийн ард! Аяа Курайшийн нийгэм! Мухаммедтай дэргэд нь буй ба шашнаа сольсон хүмүүсийн тантай байлдахаар цугларч гэрээ хийснийг мэдээгүй байна уу?!” гээд ширүүн ба урт дуугаар орилов.

Хүндэт Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-:

238. Накиб: Төлөөлөгч. Улс эсвэл аймгийн тэргүүн эсвэл төлөөлөгч нь.

“–Энэ дуунаас битгий айг! Тэр нь Аллахын дайсан Иблийсийн дуу юм! Аяа Аллахын дайсан, сонс! Чамайг би ч хожно!” хэмээсний дараа мусульманчуудад:

“–Одоо шууд тараад хонох газартаа очоорой!” хэмээн айлдав.

Аббас бин Убадэ -радъяллаху анх-:

“–Чамайг үнэн шашин ба номоор илгээсэн Аллахад тангараглая, хүсвэл Мадинагийн ардыг ч сэлмээр цавчия!” гэв.

Пайгамбар Эзэн маань:

“–Бидэнд үүнийг тушаагаагүй! Та нар одоо байрандаа харьцгаа!” хэмээв.

Мусульманчууд байрандаа харьж өглөө болтол унтав. Өглөөгүүр Курайшийн мүшрикчүүдээс зарим нь мусульманчуудыг ч агуулсан хамт олонд хүрээд Оршигчдын Туяатай гэрээ хийсэн эсэхийг асууцгаав. Юу ч мэдсэнгүй хамт олны мүшрикчүүдд, тангараг өргөж ийм юм болоогүйг илэрхийлэв. Харин Курайшийн мүшрикчүүд Азабагийн Бий’атыг сураглаад явав. Бий’атын мэдээ зөв байсан нь ил болохлоор ч, Мадинагийн замуудыг хааж, мусульманчуудыг олохоор бүх тийш зэвсэгтэй хүмүүс илгээцгээв. Мүшрикчүүдийн дагагчид замд Са’д бин Убада -радъяллаху анх-ыг барьцгаав:

“–Чи Мухаммедын шашинд оров уу?” гэж асууцгаав.

“–Тийм!” гэхлээр нь хоёр гарыг нь хүзүүнээс нь бат уяцгаав. Зодоод урт гэзгийнх хөхлөөр нь чирж Маккад аваачицгаав. Түүнийг тамлаж эхлэв. Өмнө нь тусалж эрхийг нь хамгаалсан

Жүбэйр бин Мут’им[239] ба Харис бин Харб нар шууд ирээд Са’д -радъяллаху анх-ыг мүшрикчүүдийн гараас аварцгаав.

Мадинагийн итгэгчид цуглаж түүнийг аврахыг ярьж байсанд Са’д -радъяллаху анх- тэдний дэргэд гарч ирэв. (Ибн-и Хишам, II, 47-57; Ибн-и Са’д, I, 221-223; III, 602-603; Ахмад, III, 322, 461, 462; Хэйсэмий, VI, 42-44)

Ибн-и Аббас -радъяллаху анх- ингэж хэлэв:

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-, Хазрат-и Эбү Бэкир ба Хазрат-и Умар нь Мухажирчуудаас мөн. Учир нь тэд мүшрикчүүдээс зугтаж Мадинад нүүсэн байдаг. Тэр чигээр нь Энсараас ч Мухажирчууд байдаг. Тэд ч Акабагийн шөнө, ширкийн нутаг байсан Мадинагаас Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-д ирцгээсэн мөн. (Нэсаи, Бий’ат, 13)

❁

Акабагийн Бий’атууд, зөвхөн арван хоёр эсвэл далан таван хүний биш, хамаг мусульманчуудын Аугаа Аллахтай хийсэн нэгэн гэрээ мөн.

Энэ дэлхий нь ахиратыг худалдаж авах зах юм. Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-тэй хийсэн уг бий’атад бидний ч хамаг зүрхээрээ оролцох ба асхаб-и кирам шиг “ямар ашигтай худалдаа юм бэ” гэж чадах маань хэрэгтэй.

239. **Жүбэйр бин Мут’им** -радъяллаху анх- нь Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн хамаатнаас юм. Удаах хугацаагаар Исламыг хүлээн зөвшөөрөөгүй. Оршигчдын Туяаг алахаар шийдсэн хамтлагад тэр ч оролцов. Бэдир Дайнд мүшрикчүүдийн хооронд байв. Ухуд Дайнд боол Вахшийнаар Хазрат-и Хамзаг шэхид болгов. Хүдэйбиегийн Бүслэлийн яг араас (628 онд) итгэж үнэмшээд маш дотно сэтгэлийн мусульман болов. Уяхан сэтгэлтэй, ирээдүйн сэхээтэй сахабий байсан Жүбэйр нь жаран хадис дамжуулав. Хижрэтийн тооллын 58 / билгийн тооллын 678 онд Мадинад Рахманы энэрэлд хүрэв.

Мус’аб -радъяллаху анх- нь Мадинад Исламын суурь болов. Бид ч сэтгэлүүдэд Исламын суурийг хэрэгжүүлэх ёстой. Тэблигч хүн шаардвал гэрээс гэрт алхаж, хамаг байдлаараа үлгэр жишээ байх ёстой юм. Тэблигчийн зүрх нь Аллах болох Элчийнх нь хайраар дүүрвэл, Мус’аб -радъяллаху анх- шиг дэлхийн тааламжийг Исламын төлөө зориулж чадна.

Маккагийн Эриний Тайлан

Арван гурван жил Маккагийн эриний турш Маккагийн мүшрикчүүд мусульманчуудад хийсэн харгислалыг ийм таван зүйлд хуваах болно:

1. Шоглох.

2. Доромжлох.

3. Тамлах.

4. Бүх төрлийн худалдаа ба хүний харилцааг таслах (гадуурхах).

5. Мусульманчуудыг нүү гэж албадан туйлдуулах харгислах, алах.

Тэдний ийм байдлыг Аугаа Аллах ает-и кэримэнүүдэд ингэж мэдээлнэ:

اِنَّ الَّذِينَ اَجْرَمُوا كَانُوا مِنَ الَّذِينَ اٰمَنُوا يَضْحَكُونَ

وَاِذَا مَرُّوا بِهِمْ يَتَغَامَزُونَ وَاِذَا انْقَلَبُوٓا اِلٰٓى اَهْلِهِمُ انْقَلَبُوا فَكِهِينَ

وَاِذَا رَاَوْهُمْ قَالُوٓا اِنَّ هٰٓؤُلَٓاءِ لَضَٓالُّونَ

“Нүгэлтнүүд мусульманчуудыг шоолон инээдэг байцгаав. Урдуур нь өнгөрөхдөө бие биедээ нүдээрээ дохилцон тэднийг шоглодог байв. Мусульманыг шоолсондоо их л таатай харьдаг байв. Итгэгчдийг хараад: «Тд нар төөрчээ!» гэдэг байцгаав.” (эл-Мутаффифийн, 29-32)

Үүний хариугаар байнга вахийгаар дэмжээд яаж хандах нь мэдүүлсэн Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн мөрдсөн арга нь ийм болов:

1. Итгэгч сэтгэлүүдийн сүнсний байдлыг сэргээхийг хичээх.

2. Төвөг ба тамлалд тэвчих.

3. Сайхан жишээгээр сургаалын үг хэлэх.

4. Эсэргүүцлийг таслалтгүй үргэлжлүүлэх.

5. Аугаа Аллахад бууж өгөх.

Ийм аргуудын үр дүнд Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- хамаг байдал нь сөрөг байсан ч амжилттай болоод тааралдсан саадуудыг давсан байдаг. Ийм урт ба төвөгтэй шатын дүгнэлтээр Мадина шиг бүх талаас стратегик нэгэн нутгийн хүмүүс баг багаар итгэж үнэмшсэн байв. Том найдвараар очсон Таифаас чулуудуулан хөөгдсөн Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- нь урихаар Мадинад огт очоогүй байсан ч Ислам шашин нь тэнд тэнгэрлэг баталгаагаар хурдан өсч, богино хугацаанд ч Хазрат-и Пайгамбараас эхлээд хамаг итгэгчдэд алгаа дэлгэсэн байв.

Нэгэн гүн ухаантан Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн учир дахь амжилтаас хөдлөн, Түүний ямар суут хүн буйг ингэж тогтоно:

“Зорилт нь том, арга нь жижиг ба дүн нь агуу байх нь хүний гавъяаны гурван том хэмжүүр байвал, шинэ түүхийн

хамгийн том хүмүүсийг (Хазрат-и) Мухаммедтай зүйрлэж хэн чадах вэ?” (А. дө Ламартэн, *L'histore de la Turquie*)

Аугаа Таала итгэгчдийн нүүхийг, тамлал харгислалаар өнгөрсөн арван гурван жилийн дараа л зөвшөөрөв. Арван гурван жилийн ийм харгислалын араас итгэгчдийн итгэл үнэмшил төгс төгөлдөрт хүрч, зүрхнүүд нь эрдэм ба сүнсний боловсролоор дүүрэв. Өөрөөр хэлбэл итгэгчид нь итгэл үнэмшлийнхээ хөлсийг төлцгөөв.

Тэр эринд Мадинад байгуулах ба хамаг хүн төрөлхтөнд жишээ болох Исламын улс төр ба иргэншлийн суурь тавьсан, итгэлийн эрдэм ба бишрэлтээр тааралдах бэршээлд хүч алдахгүй, бат зантай хүмүүс боловсруулсан байдаг. Энэ хүмүүс хамаг үммэтэд удирдамж болох одон хүмүүсээр эргэсэн байдаг.

Маккий Аетуудын Шинжүүд

Мэдэгдсэнээр нь анх буусан аетууд тэвхидэд урих, үхсэний дараа сэрэхдээ итгэх, итгэгчдэд диваажингийн сайн мэдээг олгох, кафир ба босогчдыг тамаар айлгах тухай байв. Энэ тухай тус тусдаа баримтаар ятгах аргаар хүмүүсийн итгэл үнэмшлийг батжуулсны дараа хуультай хамаатай дүрэм журам бууж эхлэв. Учир нь хүмүүс мухар сүсэг ба хэвшилдээ хатуу холбоотой байсан тул, эдгээрийг болих нь их амар байгаагүй. Шат шатын харьцааг анхааралгүй, хүмүүсийг муухай заншлаас арилгахыг хичээх нь өших ба голохын учир болж мэдэх байв.

Хазрат-и Аиша эх маань ингэж хэлдэг:

"Анх буусан сура нь жижиг сугануудаас[240] нэгэн байв. Үүнд диваажин ба тамыг дурдсан байв. Халал ба харамтай хамаатай дүрэм бол хүмүүс Исламд бүрэх дассаны дараа л бууж эхлэв. Хэрэв анх удаад:

«–Архи бүү уу!» сургаал ирсэнсэн бол хүмүүс:

«–Бид уухаа ерөөсөө болихгүй!» гэх байцгаав.

Дахиад анхны ээлжээр:

«–Зина битгий хий!» тушаал нь ирсэнсэн бол хүмүүс тэр чигээр нь:

«–Бид зинаг ерөөсөө орхихгүй!» гэх байцгаав.

Намайг Маккад тоглоом тоглодог хүүдэх байхад Хазрат-и Мухаммед -алэйхиссалатү вэссэлам-д:

بَلِ السَّاعَةُ مَوْعِدُهُمْ وَالسَّاعَةُ اَدْهٰى وَاَمَرُّ

"Үгүй, тэдэнд амласан (жинхэнэ тамлалын) **цаг нь киямат мөн. Тэр цагт үнэхээр маш айхтар ба хэцүү байдаг,"** (эл-Камэр, 46) (мэтийн итгэл ба кияматтай хамаатай) аетууд буусан байв. (Хуультай хамаатай дүрэм журам агуулсан) Бакара ба Ниса суганууд бол намайг Түүний дэргэд байхад (Мадинад) бууцгаав." (Бухарий, Фэдаилү'л-Кур'ан, 6)

Маккий суганууд зохиох аргаараа богино ба гүн бөгөөд ширк болон баримал шүтээний эсрэг лав хандана. Учир нь Маккагийн мүшрикчүүд уран зохиолын тэмцээн хийдэг уран хэллэгтэй хүмүүс байв. Тэдэнд нөлөөтэй болох үг нь уран ба гоё хэллэгийн талаар төгс төгөлдөр болох ёстой байв.

---

240. Богино Суранууд нь Судрын адагт бөгөөд, илүүд үзсэн бодлоор 50 дахь сура буй Кафаас эхлэн Нас хүртлийн хэсэг юм.

Жишээлбэл Аллах Таала мүшрикчүүдийн уран зохиол дахь төвшнийг цэг гэж тоож, тэдний оюун ухааныг хутгахаар үг хэлж эхлэхдээ, тэдний дассан аргаас ялгаатай Хуруф-и Мукаттаа гэдэг тустай үсгүүдийг хэрэглэсэн байдаг. Эхэндээ Хуруф-и Муракаттаатай суганууд, Бакара ба Ал-и Имранаас багна бүгд Маккий юм.

Ийнхүү шинжээсээ болж анхны аетуудын уран зохиолын арга нь маш их нөлөөтэй бөгөөд хандсаны шууд зүрхэнд хүрч; сайхан ба урсгалтай бүцрээрээ сонсогчдыг бараг дур булааж байв.

Маккад буусан ает-и кэримэчүүдийн шинжээс нэгэн ч, тусгай тохиолол байсан ч ердөө “Аяа хүмүүс ээ” хэмээн хандсан байдаг.

Маккий суранаудад мүшрикчүүдийн саналын эсрэг маш олон зүйлийг, тэдний анхаарлыг татахаар тэдний ихээр хүндэлсэн Нар, Сар, одод, шөнө-өдөр мэтийн бодит зүйлс дээр тангараг өргөсөн байдаг. Мөн тангараг өргөсөн эдгээр зүйлсээр Аллахын хүч ба орчлон дахь хүчдэлийн урсгалын ч толилуулж байв.

Нөгөө талаас Кур’аны туульсын ихэнх нь Маккагийн эринд буусан байв. Учир нь “өнгөрснөөс сургаал авах” нь Маккий аетуудын ихээр дурдсан нэгэн арга байв. Дотроо Пайгамбарчууд болон эртний улсуудын туульсыг ярьсан, ялангуяа Адам -алэйхиссэлам- болон чөтгөрийн дурдсан суранууд, ердөө Маккий байдаг юм. Үүний ганцхан гажилт бол Мадинад буусан Бакара сура мөн.

Өнгөрсний улсуудад тохиолдсон сургаалтай туульсыг ярих нь Маккагийн мүшрикчүүдэд үнэнийг тэблиг хийх ба тэднийг шат шатаах боловсруулахад чухал ажил хийсэн байдаг.

Туульсыг ярьсан эдгээр аетуудад "тэвхидийн итгэл үнэмшлийг" байнга баталгаат илэрхийлсэн байдаг.

Маккий аетууд тэблигч хүний яаж хандах хэрэгтэйг ч үзүүлдэг. Тэр энэ урилгыг дэлхийн ашгийн төлөө биш, зөвхөн Аугаа Таалагийн тааламжид хүрэх зорилгоор хийх, шагналыг нь ч зөвхөн Аллахаас найдах хэрэгтэйг ярьдаг. Жишээлбэл Шуара Сурад Нух, Хүд, Салих, Лут ба Шуайб -алэйхимүссэлам-ын ардынхандаа байнга Аллахын үгэнд орж такваг тушааж, өөрсдийгөө итгэмжтэй нэгэн элч буйг хэлээд:

وَمَا أَسْأَلُكُمْ عَلَيْهِ مِنْ أَجْرٍ إِنْ أَجْرِيَ إِلَّا عَلَى رَبِّ الْعَالَمِينَ

"Би үүний хариуд танаас ямар ч төлбөр нэхэхгүй байна. Миний төлбөр зөвхөн Орчлонгуудын Рабд л байдаг," гэснийг дамжуулна. (эш-Шуара, 109, 127, 145, 164, 180)

Кур'аны хоёр дахь тал нь ердөө Маккад буусан байдаг. Маккачуудын ихэнх нь их зантай хүмүүс байсан тул **"кэлла: үгүй, тийм биш"** гэдгийг олон дахин хэлж тэдний байдлын үгүйсгэсэн ба энэ их зантай хүмүүсийг сүрдүүлсэн байдаг. Ийм учраас **"кэлла"** гэсэн үг дурдсан суранууд бүгд Маккий бөгөөд **"кэлла"** гэсэн үг бүх нь Кур'ан-и Кэримийн хоёр дахь хагас талд байдаг.

Тэр чигээр нь мөргөх аетуудыг агуулсан суранууд ч Маккад бууцгаав. Ингэхдээ Аллахаас өөр зүйлсийн өмнө мөргөсөн хүмүүсийн Аугаа Аллахад мөргөхөд чиглэсэн бөгөөд тэдний энэ талаар төгс болохыг хангав.

Маккад буусан эдгээр анхны аетууд нь хуучны зан заншлын мунхаглалаас үүссэн ба иж бүрэн мухар сүсэг буйг зарладаг. Түүнчлэн ёс суртахууны түгээмэл зарчмын гол зүйлсийг илэрхийлдэг.

Маккий аетууд итгэл үнэмшил, ёс суртахуун ба бодлын талаар эрүүл нийгмийн суурийг тавив. Эдгээр аетуудад ёс суртахууны тугаал ба дүрэм журам агуулдаг. Ингээд итгэгчдийг хүчтэй итгэл үнэмшилтэй болгох, тэсвэр, тэвчээр, чармайлт мэтийн шинжээр төхөөрөх ба мухар сүсгээс арилгахыг зорилго тавив.

Маккий аетуудад хуулийн зүйлс байгаагүй бөгөөд, мөргөлөөс гадна залбирал үйлчилгээний тухай дүрэс журам ч байдаггүй. Жишээлбэл Юүнүс, Ра'д, Фуркан, Яа-син, Хадид суранууд Маккий бөгөөд, эдгээрт дүрэм журмын ает байдаггүй. Эдгээр сурануудад ерөнхийдөө итгэл үнэмшлийн үндэснүүд, туурвил, Аллахын бэлгэ тэмдгүүд, Пайгамбарчуудын сургалтай туульс ба кияматын үзвэрүүдийн ярьдаг.

Пайгамбарчуудын Сүүлийн Арга: ХИЖРЭТ
(Номлохын 13-р Жил) **Хижрэтэд Зөвшөөрөл Олсон ба Мадинад Нүүсэн нь**

Акабагийн Хоёр дахь Бий'атын дараа мүшрикчүүд нь мусульманчуудын хоргодож өөрсдийгөө хамгаалах нэгэн газар нүүхийг нь мэдэхлээрээ хийсэн тамлалыг бүр ихэсгэв. Мусульманчууд ч ийм тэвчиж дийлшгүй тамлалын улмаас Макка сууж чадахааргүй болоод, байдлаа Пайгамбар Эзэнд маань илэрхийлж нүүх тухай зөвшөөрөл эрэв.

Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- нь Аллахын зөвшөөрлөөр мусульманчуудад Мадинагийн замыг заагаад ингэж айлдав:

"Одоогоос хойш таны нүүх хот нь хоёр хар чулуутын дунд хасарваант нэгэн газар буйг надад үзүүлэв." (Бухарий, Кэфалэт, 4)

Тэдэнд Энсар буюу Мадинагийн мусульман дүү нартайгаа тэврэлдэхийг тушааж:

"Аллах Таала танд дүү нар ба энх амгалан олох нэгэн нутаг хайрлав!" хэмээв.

Үүний дараа мусульманчууд мүшрикчүүдэд мэдэгдэлгүй бэлтгээд, нэг нэгэндээ тусалж нууцаар нүүж эхлэв.[241]

Мусульманчуудын өмнө нь нүүж сайнаар хүлээн авагдсан Абиссини нь шашны түгээмэл төв болох нөхцөл агуулдаггүй байв. Мадина бол улс төрийн ч, худалдааны ч талаараа болон өөр маш олон талаараа Исламын төв болох шинжтэй хот байв. Ийм учраас нэгмөсөн нүүдэт тэр ариун нутгийн хувь болох байв.

Ингээд Мадина нь мусульманчуудад нэгэн хорогдох газар болов. Ингэж Маккагийн мүшрикчүүдийн айсан нь хэрэгжсэн болов. Ислам нь Маккагийн гадаа гарсан ба Мадинад их нэр хүнд олсон байв. Энэ нь мүшрикчүүдийн Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн нутгаас нь хаях тулд үймүүлсээр байсны, өөрсдийнхөө төлөө ямар их алдагдал буйг яасан ч ойлгож чадаагүйгээс үүсч байв. Үнэхээр энэ нь тэдний төлөө том нэгэн алдагдал байв. Гэтэл тэд харж, сонсч, мэдэрч, ухаарч чадахгүй байцгаав.

Аллах Таала нь Элчдээ айлдав:

وَإِذاً لاَّ يَلْبَثُونَ خِلافَكَ إِلاَّ قَلِيلاً

"...Тэд Чиний дараа нутагтаа их удаж чадахгүй!" (эл-Исра, 76)

241. Хар. Ибн-и Хишам, II, 76; Ибн-и Са'д, I, 226.

Аргагүй мүшрикчүүд нь тэр үеийн хүч ба нэфсийнхээ ноёрхлоор хандаж мусульманчуудыг тоглоом шоглоом хийх, сүрдүүлэх, эмбарго, хүчирхийлэл ба тамлалаар туйлдуулснаа бодож, ингээд Макка дахь нэр алдраа хамгаалсандаа итгэж байв. Гэтэл Тэднийг андашгүй ба холдошгүй нэгэн ялагдал ба хохирол хүлээж байв...

Учир нь олноороо Мадинад очсон мусульманчууд нь тэднээс айснаасаа биш, Исламын суурийг хамгийн баталгаатай тавихаар нүүснийг ухаарцгаав.

❀

Нүүдлийг хэзээ ч хохирсон буюу аргагүй болоод зугтсан гэж ойлгож болохгүй. Мадина нь Мухажирчуудын төлөө нүүдлийн орон, бусад итгэгч дүү нартайгаа хамтарч цуглараад, хөөгдсөн нутагт Аллахын шашныг дэлгэрүүлэх нэгэн орон мөн.

Мэрхүм шүлэгч Нэжип Фазыл нь энэ үнэнийг ингэж илэрхийлдэг:

Хижрэт нь гадаадад хайсан түшиг
Хэрэгт хүнд өөрийнх нутагт гашуун
Зорилго нь төвийг гаднаас нь бүслэх
Хүсэл нь төвийг хүрээгээр нь эзлэх
Хижрэт нь гадаадад хайсан түшиг...

Мухажирчууд үүний төлөө хөрөнгө бараа, садан хамаатай хамаг юмаа Маккад үлдээж байцгаав. Зарим нь нууц, зарим нь ил Мадинагийн замаар явж байцгаав.

Хазрат-и Али -радъяллаху анх- ингэж хэлдэг:

“Би мухажирчуудаас нууцаар нүүгээгүй хэнийг ч мэддэггүй. Зөвхөн Умар бин Хаттаб өөр юм. Тэр нүүх болсон-

доо сэлмээ бүсэлж, нумаа мөртөө өлгөж, сум ба жадаа гардаж Кабад очив. Курайш мүшрикчүүдийн тэргүүлэгч хүмүүс тэр хооронд Кабагийн дэргэд байцгаав. Умар -радъяллаху анх-нь Кабаг долоон удаа тойрсны дараа тэдний дэргэд очоод, одоогоос ирээдүйн ялалтын анхны хандлагыг заах юм шигээ мүшрикчүүдэд хашхирав:

«–Зэ, би ч Мадина руу явж байна! Ээжийгээ уйлуулмаар, эхнэрээ бэлбэсэн, хүүхдүүдээ өнчин үлдээмээр буй нь миний араас ирээд тэр хөндийн ард миний өмнө гараг!»

Харин хэн ч түүнийг дагаж явж чадаагүй.” (Ибн-и Эсир, *Үсдү’л-Габэ*, IV, 152-153)

Мадиначууд нь Маккагаас ирсэн дүү нараа тэврэлдээд угтаж, тэдэнд чин сэтгэлээрээ тусалж байцгаав. Ийм л учраас Маккагийн мусульманчуудыг “Мухажир”, Мадинагийн мусульманчуудыг бол туслагчид гэсэн утгаар “Энсар” гэсэн нэр өгцгөөв.

Аллах Таала ингэж айлдана:

وَالسَّابِقُونَ الْاَوَّلُونَ مِنَ الْمُهَاجِرِينَ وَالْاَنْصَارِ وَالَّذِينَ اتَّبَعُوهُمْ
بِاِحْسَانٍ رَضِيَ اللّٰهُ عَنْهُمْ وَرَضُوا عَنْهُ وَاَعَدَّ لَهُمْ جَنَّاتٍ تَجْرِي
تَحْتَهَا الْاَنْهَارُ خَالِدِينَ فِيهَٓا اَبَدًا ذٰلِكَ الْفَوْزُ الْعَظِيمُ

“ Мухажирчууд ба Энсар болон тэдэнд тусалцаа үзүүлээд дагагсад нь бий биз, Аллах тэднээс таатай болоод, тэд ч Аллахаас таатай болцгоов. Аллах тэдэнд үүрд мөнх байхаар, доороос нь мөрөн урсдаг диваажин бэлтгэв. Энэ нь том аврал мөн.” (эт-Тавба, 100)

❁

ислам эрдэмтэд нь мусульманчуудад нүүх зөвшөөрөл олгосноос нь ийм дүрмийг хураацгаав:

Хижрэт нь Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн эринд фарз байв. Энэ фарз нь киямат хүртэл хүчинтэй байдаг. Маккаг ялалтаар барсан хижрэт бол зөвхөн Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн эринтэй хамаатай юм.

Нэгэн мусульманы эзан, чуулга, мацаг, мөргөл болон Исламын бусад дүрмийг хэрэгжүүлж чадаагүй газар суугаад байсан нь боломжтой биш юм. Аллахын ает нь энэ тухай баталгаа мөн:

اِنَّ الَّذِينَ تَوَفّٰيهُمُ الْمَلٰٓئِكَةُ ظَالِمٖيٓ اَنْفُسِهِمْ قَالُوا فٖيمَ كُنْتُمْ قَالُوا كُنَّا مُسْتَضْعَفٖينَ فِي الْاَرْضِ قَالُوٓا اَلَمْ تَكُنْ اَرْضُ اللّٰهِ وَاسِعَةً فَتُهَاجِرُوا فٖيهَا فَاُولٰٓئِكَ مَاْوٰيهُمْ جَهَنَّمُ وَسَٓاءَتْ مَصٖيرًا اِلَّا الْمُسْتَضْعَفٖينَ مِنَ الرِّجَالِ وَالنِّسَٓاءِ وَالْوِلْدَانِ لَا يَسْتَطٖيعُونَ حٖيلَةً وَلَا يَهْتَدُونَ سَبٖيلًا

“Мэлэкчүүд өөртөө тамлаж байсан хүмүүсийн амийг авахдаа тэдэнд «Ямар ажилтай байсан бэ?» гэцгээнэ. Тэд ч: «Бид дэлхийд хүчгүй хүмүүс байцгаав,» гэцгээнэ. Мэлэкчүүд: «Аллахын газар өргөн байгаагүй юү, та ч нүүгээгүй яасан!» гэцгээнэ. Эдний очих газар нь там юм. Тэр нь очоод суух газар. Гэтэл үнэхээр аргагүй ба хүчгүй байсан бөгөөд нүүх зам олж чадаагүй эрчүүд, эмчүүд ба хүүхдүүд үүнд багтахгүй.” (эн-Ниса, 97-98)

Энэ ает нь Мадинад нүүлгүй мүшрик нийгэм дотор үлдэгсдийн өөрсдөө тамласныг мэдээлнэ. Эд нар тав тух, зан-

шлаа, гэр бүлээ, хөрөнгө ба ашгаа шашнаас илүүд үзэж байв. Ийм учраас **“Бид дэлхийд хүчгүй хүмүүс байцгаав,”** гэж илэрхийлсэн шалтгааныг нь хүлээн зөвшөөрөхгүй байна. Гэхдээ нүүхэд үнэхээр хүч хүргэж чадаагүй настай, хүчгүй эр, эм ба хүүхдүүдийг шалтгааныг нь хүлээн зөвшөөрч байв.

Хижрэтээс гаргасан өөр нэгэн дүрэм бол мусульманчуудын орон нутаг хэдий тустай байсан ч бусад мусульманчуудад чадах чинээгээрээ туслах нь фарз байдаг юм. Ислам эрдэмтэд нь мусульманчуудын дэлхийд ямар нэгэн харгислалд автсан, баригдсан эсвэл дарагдсан итгэгч дүүдээ туслах чадалтай боловч тусалсангүй тохиолдолд том нүгэл болох тухай санаа нийлсэн байдаг.

Оршигчдын Туяа -алэйхиссалатү вэссэлам- нь Хижрэтийг ихээр чухалчилсан, Маккаг ялж автлаа хамаг мусульманчуудын Мадинад нүүхийг нэхсэн байдаг. Учир нь Мадинагаас бусад газар нь күфүрийн орон байсан бөгөөд мусульманчуудын тэр хэсэгт шашнаа сураад амьдрах нь маш хэцүү байв.

Мүшрикчүүдийн Халдах Төлөвлөгөө

Маккагийн өдөр тутам хоосорсныг харсан мүшрикчүүд нь аажим аажмаар явдлын өөрсдийнхөө талаарх сургийг ухаарч эхэлцгээв. Яаралтай муу муухайн голомт байсан Дару’н-Нэдвэд цугларав. Уулзалтад Нэждээс ирсэн нэгэн буурал ч оролцсон байв. Энэ хөгшин нь хүний төрхөд орсон чөтгөр гэмээр.

Яах тухай урт удаан маргалдцгаав. Пайгамбар Эзнийг маань бариад шоронд оруулах эсвэл Маккагаам цөлөх мэтийн олон санал илэрхийлэв. Санал бүрийг чөтгөр эсэргүүцэв. Эцэст нь дорой нэгэн шийдвэрт санаа нийлцгээв:

Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийг алах!..

Уг саналын үеийн Фарон асан Эбү Жэхил ингэж илэрхийлсэн байв:

"–Айл бүрээс зэвсэгтэй нэгэн залуу олцгооё. Залуус Түүн рүү зэрэг дайраг. Бүгдээрээ цохиод алцгааг. Ингэж Түүнээс аврагдад амар заяад хүрцгээе! Залуучуудыг ингэхэд Түүний цус хамаг аймгуудад тараагдсан байх болно! Абди Мэнафынхан бол хамаг аймгуудтай байлдахаар хүч хүргэж чадахгүй, төлбөрийг нь авахаас аргагүй болно. Бид ч Абди Мэнафынханд Түүний мөнгийг төлнө!" гэв.

Нэждээс ирсэн хөгшин хүний дүрсэнд орсон чөтгөр -ланэтуллахи алэйх-:

"–Хамгийн зохимжтой нь энэ эрийн үг юм! Үүнээс ухаантай санал байж болохгүй!" гэв. (Ибн-и Хишам, II, 93-95)

Энэ шийдвэрийг гаргасан үед Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- Маккад бараг гав ганцаараа үлдсэн байв. Тэр нь үммэтдээ дуртай нэгэн Пайгамбар болохоороо тэднийг урдуур илгээсэн, өөрөө ч Мухажирчуудыг хамгаалахыг сонгосон байв. Угаасаа тэнгэрлэг хүсэл ч ийм байв. Түүнчлэн ариун зорчих замын гагцхуу анд болох Эбү Бэкир -радъяллаху анх- нүүхээр Түүнээс зөвшөөрөл эрэхэд:

"–Тэвч!" хэмээсэн ба нэмсэн байв:

"–Магадгүй Аллах чамд замын буянтай нэгэн анд хайрлаж өгнө!" (Ибн-и Хишам, II, 92)

Үүнд маш их баяссан Хазрат-и Эбү Бэкир -радъяллаху анх- нь нүүдлийн бэлтгэлээр найман зуун дирхэмээр худалдаж авсан хоёр тэмээг гэртээ дөрвөн сарын турш анхааран тэжээв. (Бухарий, Мэнакибу'л-Энсар, 45)

Мүшрикчүүд гаргасан шийдвэрээ хэрэгжүүлэхээр хөдөлсөнд, Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- ч нүүхээр тэнгэрлэг зарлигийг авсан байв:

وَقُل رَّبِّ أَدْخِلْنِي مُدْخَلَ صِدْقٍ وَأَخْرِجْنِي مُخْرَجَ صِدْقٍ
وَاجْعَل لِّي مِن لَّدُنكَ سُلْطَاناً نَّصِيراً

“Расул минь! **Ингэж хэл: Аяа Раб минь ээ! Орох газар минь шударгаар орохыг хайрлаад өгөх болтугай! Гарах газраас минь шударгаар гарахыг хайрлаад өгөх болтугай! Надад онгоноосоо ёсоор нь туслагч нэгэн хүч хайрлах болтугай!”** (эл-Исра, 80)

Уг ает-и кэримэгээс гадна Жэбраил -алэйхиссэлам- ч мүшрикчүүдийн тогтсон мэхийг Хазрат-и Пайгамбарт мэдээлж:

“–Өнөө шөнө орондоо хэвтэхгүй!” гэсэн байв. (Ибн-и Хишам, II, 95)

Тэгэхлээр нь Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм- өдөр хүн бүр амарч буй үдийн халуунд Эбү Бэкир -радъяллаху анх-ын дэргэд очоод нүүх зарлиг авснаа мэдүүлэв.

Хазрат-и Эбү Бэкир -радъяллаху анх- асуув:

“–Хамтдаа байх уу аяа Аллахын Элч ээ!”

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-:

“–Тийм, хамтдаа байна!” хэмээв.

Хазрат-и Эбү Бэкир энэ хариугаар маш их хөөрч, нүднээс нь цацарсан баясгалангийн гэрэл нь Түүний сэтгэлийн хорвоог хамгийн сайхнаар ойлгож байв.[242]

242. Хар. Ибн-и Хишам, II, 97-98.

Дараа нь Пайгамбар Эзэн маань -саллаллаху алэйхи вэ сэллэм- Хазрат-и Алиг дуудан хижрэтийг мэдээлсэн ба дээрээ байсан хүмүүсийг хамгаалуулсан барааг эзэн болгонд нь хүргэхээр түүнийг төлөөлөгчөөр үлдээв. Учир нь Маккад үнэт эдлэлтэй бөгөөд итгэмжтэй буйг мэдсэн учраас бараагаа Расулаллахад хамгаалаагүй хэн ч байгаагүй.

Мүшрикчүүдийн төлөвлөгөөнд арга хэмжээ болохоор ингэж айлдав:

"–Аяа Али! Өнөө шөнө миний оронд чи хэвт! Энэ хувцсыг минь ч нөмрөг. Битгий ай! Чамд дургүй нь онохгүй!" (Ибн-и Хишам, II, 95, 98)

Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн хувцсаа Хазрат-и Алигийн дээр нөмрөгсөн нь бас бараагаар дэмжихийн нэгэн жишээ юм. Үүнд олон жишээ байдаг.

Жишээлбэл Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм- Вэйсэл Каранийд ч хувцсаа илгээж:

"Үүнийг өмсөөд миний үммэтийн төлөө залбираг!" хэмээн айлдсан байв. (Фэридүддин Аттар, *Тэзкирэтү'л-Эвлияа*, х. 21)[243]

Энд анхаарал татам өөр нэгэн зүйл ч Хазрат-и Али -радъяллаху анх-ын Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-д бууж өгсөн нь юм. Угаасаа сахаба-и кирам хазрат нь Аллахын Элчийн тушаалд бууж өгөхдөө ерөөсөө андуурдаггүй, Түүний үг ба үйлсийг дагахад огт хоцордоггүй байв. Хэзээ ч яагаад гэж асуудаггүй, авсан тушаалаа шууд хэрэгжүүлдэг байв. Түүний сүннэтээс аль нэгийг ч орхихгүйд, бүгдээр нь боолчлохыг хичээдэг, Түүний замыг орхивол төөрөхөө мэддэг бөгөөд тэгэхээс

243. Мөн хар. Мүслим, Фэдаилу'с-Сахаба, 223-225.

айдаг байв. Асхабын Кур'ан-и Кэрим ба Сүннэт-и Сэнийетэй харьцаа нь сүүдрийн эзэнтэй адил харилцаатай байв.[244]

❁

Хазрат-и Али -кэррэмаллаху вэжхэх- ингэж ярина:

"Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- Маккагаас нүүх болоход хоёулаа Кабад очлоо. Орчлонгийн Эзэн надад:

«–Суу!» хэмээв.

Мөр дээр минь гишгэж Кабад гарахыг хүсэв. Гэнэтхэн би хүчээ алдлаа! Орчлонгийн Хүндэт Эзэн маань намайг хүчээ алдсаныг харахлаар шууд мөрнөөс минь буув. Өөрөө явган суугаад:

«–Мөрөн дээр минь гишгэ!» хэмээв.

Би мөр дээр нь гишгэлээ. Надад гэнэтхэн маш их хүч ирээд, хүсвэл тэнгэрт хүрэхээ мэдэрлээ! Эцэст нь Бэйтуллах дээр гарлаа. Тэнд хүрэл буюу зэсэн нэгэн баримал байв. Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- надад:

«–Али, түүнийг доош хая!» хэмээв.

Хаянгуут тэр шилэн аяга шиг хагарчхав!

Шууд Каба дээрээс буулаа. Хэн нэгэнтэй тааралдалгүй даруй тэндээс холдлоо." (Ахмад, I, 84; Хаким, III, 6/4265)

❁

нүүдлийн шөнө Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- арай жаргалтай гэрээсээ гаралгүй мүшрикчүүд эргэн тойрныг нь бүсэлсэн байв. Гэтэл Аллахад хязгааргүй итгэлтэй буй Хазрат-и

244. Хар. Бухарий, Хумус, 1; Мүслим, Жихад, 52; Эбү Давуд, Хараж, 18; Ахмад, I, 10.

Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм-д ямар ч эмээх эсвэл сандралын шинж харагдахгүй байв. Хүндэт Элч Эзэн маань ариун гартаа нэгэн атга шороо аваад мүшрикчүүдийн дээгүүр цацаж Яа-син Сурагийн уг ает-и кэримэг нь уншаад тэдний дундуур шүүрч гарав:

إِنَّا جَعَلْنَا فِي أَعْنَاقِهِمْ أَغْلاَلاً فَهِيَ إِلَى الأَذْقَانِ فَهُم مُّقْمَحُونَ. وَجَعَلْنَا مِن بَيْنِ أَيْدِيهِمْ سَدّاً وَمِنْ خَلْفِهِمْ سَدّاً فَأَغْشَيْنَاهُمْ فَهُمْ لاَ يُبْصِرُونَ

“Бид тэдний хүзүүнд гинж зүүв. Тэр гинж эрүүнд нь тулаад, хамар нь доош, нүд нь дээш хандан царай нь ярвайна. (Мөн) **бид тэдний урд ба араас нь хана босгов; одоогоос хойш тэд харж чадахгүй!”** (Яа-син, 8-9)

Мэдээж харж чадахгүй байв! Учир нь тэдний зүрхний сохор байсан нь нүдээ сохолсон байв. Тэдний дундуур явж өнгөрсөн нь бол Хорвооны Хүндэт, Орчлонгуудын Эзэн, Оршигчдын Туяа -алэйхиссалатү вэссэлам- байв. Мэдээж сохор зүрх ба нүдний Туяаг харах арга үгүй байв. Тэгээд тэд харж ч чадаагүй!..

Хэн нэгэн мүшрикчүүдийн дэргэд ирээд тэднээс:

“–Та энд юуг хүлээж байна вэ?” гэж асуув.

Тэд:

“–Мухаммедыг хүлээж байна!” гэцгээв.

Тэгсэнд нь нөгөө хүн:

“–Аллах таныг хүссэнд тань бүү хүргэг! Валлахи Мухаммед гарч, таны толгойд шороо цацаад явжээ!” гэв.

Мүшрикчүүд гараа толгой дээрээ хүргэж шороонд булагдсанаа анзаарав. Шууд дотогш ороод харцгаав. Пайгамбар Эзний маань гудас дэвсгэр дээр хүн унтаж буйг олов:

“–Энэ нь Мухаммед! Дэвсгэрээ нөмөрч унтаж байна!” гэцгээв.

Яараад орны тийш алхацгаав. Орон дахь хүн өндийж тэдэн рүү харвал мүшрикчүүд хөшиж, нүдэндээ итгэж чадаагүй! Тэр нь Аллахын Элч биш, Хазрат-и Али байв!

Хоорондоо:

“–Валлахи, тэр хүний бидэнд хэлсэн нь үнэн юм байна!” гэж ярилцав.

Зурайшийн сүшрикчүүд нь Хазрат-и Али -радъяллаху анхад хилэнтэйгээр:

“–Авга ахын хүү чинь хаана вэ, Али!?” гэж орилцгоов.

Хазрат-и Али -радъяллаху анх-:

“–Мэдэхгүй, энэ тухай мэдэхгүй! Бас би Түүний мануул ч биш! Та Түүнд Маккагаас гарч яв гэцгээв! «Биднээс салаад яв!» гэцгээв. Тэр ч гараад явлаа,” гэв.

Тэгэхлээр нь мүшрикчүүд Хазрат-и Алиг загнаж нудчицгаав; түүнчлэн Мэсжид-и Харамд аваачаад түр шороонд хорьсны дараа салгав. (Ибн-и Хишам, II, 96; Ахмад, I, 348; Я’кубий, II, 39)

Зүрх нь цоожтой ба үнэнд сохор буй жаргалгүйчүүд нь жаргалын гэрийн эргэн тойронд муухай зорилготойгоор хүлээж байхад, Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- тэнгэрлэг аюулгүйдэлд аль хэдийнэ Эбү Бэкир -радъяллаху анх-ын гэрт хүрсэн байв. Мүшрикчүүдийн нэгэн төлөвлөгөө байсан, гэтэл Аллахын ч нэгэн төлөвлөгөө байсан бөгөөд түүнээс гадна

хүчинтэй болох өөр ямар ч шийдвэр байдаггүй. Энэ тухай Аугаа Аллах ингэж мэдээлнэ:

وَاِذْ يَمْكُرُ بِكَ الَّذٖينَ كَفَرُوا لِيُثْبِتُوكَ اَوْ يَقْتُلُوكَ اَوْ يُخْرِجُوكَ وَيَمْكُرُونَ وَيَمْكُرُ اللّٰهُ وَاللّٰهُ خَيْرُ الْمَاكِرٖينَ

“(Аяа Расул минь!) **Кафирчууд Чамайг уях эсвэл алах эсвэл Чамайг** (нутгаас) **гаргахаар Чамд хавх тавьж байв. Тэднийг** (Чамд) **хавх тавьж байхад, Аллах ч** (тэдэнд) **мэх** (хавх) **бэлтгэж байв. Учир нь Аллах мэх** (хавх) **бэлтгэгчдийн хамгийн буянтай нь мөн.”** (эл-Энфал, 30)

Бэрхшээлт Аялал

Гэрээсээ гараад Хазрат-и Эбү Бэкирийнхэд ирсэн Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- нь, түүнийг хүлээн зөвшөөрөөгүй ч, өөртөө зориулан бэлтгэсэн тэмээ-ний мөнгийг төлөв. Түр өмнө мүшрикчүүдийн дундаас тэдэнд харагдалгүй өнгөрсөн Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- үммэтдээ жишээ болох тул энэ удаа учиртай хандав. Хазрат-и Эбү Бэкирийн хамт нэгийн ард талаас гарцгаав. Тэмээ нь энд өөр хэд хонох байв.

Дахиад нарийн нэгэн арга хэмжээ болохоор Мадинагийн эсрэг чигээр замд гарцгаав.

Хазрат-и Эбү Бэкир -радъяллаху анх-ын нэг урдуур, нэг араас алхаж байв. Аллахын Элч түүний энэ явдлыг анзааран-гаа:

“–Эбү Бэкир ээ, яагаад ингэж байна вэ?” хэмээн асуув.

Хазрат-и Эбү Бэкир -радъяллаху анх-:

"–Аяа Расулаллах аа! Таны тухай санаа зовсондоо ингэж явж байна!" гэв.

Эцэст нь Сэвр Агуйд хүрцгээв.

Эбү Бэкир Хазрат:

"–Аяа Расулаллах аа! Намайг агуйг цэвэрлэтэл та энд байж байгтун!" гээд агуйд оров. Агуйн дотрыг цэвэрлээд газрын нүхнүүдийг бөглөсний дараа:

"–Одоо ирж болно, аяа Аллахын Элч ээ!" гэв. (Ибн-и Кэсир, *эл-Бидая,* III, 222-223)

Тэр хооронд мүшрикчүүд Эбү Жэхилээр тэргүүлсэнд Хазрат-и Эбү Бэкирийн гэрт ирээд, охин нь Эсмагаас аавыг нь асууж, түүнээс "мэдэхгүй" гэсэн хариу аваад хилэнгээ хөөрхөн охиныг алгадаж гаргасан байв.

Оршигчдын Туяа болон Түүний Яар-и Гар нь[245] агуйд түр хүлээх байцгаав. Ингээд өөрсдийгөө Мадинагийн замд хайх мүшрикчүүдээс илүү амархан хамгаалж чадах байв. Угаасаа Аллахын хайр ба хамгаалалт тэдэн дээр байсан бөгөөд боолын арга хэмжээг барахад тэнгэрлэг тусламж хүрээд ирж байв. Зарим мүшрикчүүд мөр дагаж Сэвр Агуй аманд хүрээд ирсэн байв. Гэтэл нэг харвад агуйн ам нь гар огт хүрээгүй аалзны тороор бүрдсэн бөгөөд, мөн түүнчлэн тагтааны үүр байв. Аллах Таалагийн тушаалаар агуйн өмнө Пайгамбар Эзний маань царайг хааж үзүүлэхгүй газар нэгэн мод ч ургав![246]

---

245. **Яар-и Гар:** Агуйд анд гэсэн утгатай бөгөөд Оршигчдын Туяа Эзэнтэй маань Хазрат-и Эбү Бэкирийн Сэвр агуй дахь андлахыг илэрхийлнэ. Цаг хугацааны тусан дотно андын харьцааны төлөө ч хэрэглэдэг болов.

246. Ибн-и Са'д, I, 229; Ибн-и Кэсир, *эл-Бидая,* III, 223-224.

Мүшрикчүүд нь Орчлонгуудын Эзнийг энд байж магадлалгүй гэж үзээд буцав.

Энэ хоёр үнэт зорчигчийн туслагч, түшиг, ба хоргодох газар нь Эрх Таала байв. Ийм учраас агуйн өмнө ирсэн жаргалгүйчүүд нь тагтааны үүр ба аалзны тороос өөр юм харж чадаагүй. Шүлэгч Ариф Нихат Асъягин хэлснээр:

Аалз нь агаарт ч,
Усанд ч хөрсөнд ч байгаагүй…
Тэр нь үнэнийг харж ядсан
Нүдэнд байв!

Харин энэ бүхнийг болж байхад, агуйн дотор Хазрат-и Эбү Бэкир -радъяллаху анх- нарийн хугацаа өнгөрөөв. Айсан байв; өөрийнхөө төлөө биш, Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- Эзний маань төлөө...

Учир нь мүшрикчүүд жаахан бөхийж харвал тэндийг шууд олж мэдэх байв. Тэд агуй эргэн тойронд алхаж:

"–Хэрэв тэд агуйд орсонсон бол, тагтааны өндөг хагарч, аалзны тор ч эвдрэх байлаа," гэж байв.

Зарим нь:

"–Агуйн дотор ороод харцгаая!" гэхлээр нь Үмэйе бин Халэф:

"–Танд ухаан байна уу? Агуйд ямар ажилтай вэ?! Дээрээ хэдэн давхар аалзны тортой уг агуйд орох юм уу?! Валлахи миний бодлоор аалзны энэ тор нь Мухаммедыг төрөхөөс өмнө байсан байх ёстой!" гэв.

Эбү Жэхил бол:

“–Валлахи, миний бодлоор Тэр бидэнд ойрхон! Харин илбээрээ бидний нүдийг уяж, хардаггүй болгов!” гэв.[247]

Тэр хооронд санаа зовсон Хазрат-и Эбү Бэкир Сиддийк нь Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-д хандан:

“–Би үхвэл, эцэст нь би ганц бие хүн, алга болно. Харин Чамд ямар нэгэн юм болбол үммэт л мөхнө,” гэж байв.

Пайгамбар маань босоод мөргөл үйлдэж, Хазрат-и Эбү Бэкир ч манаад байв. Эзэнд маань:

“–Тэр ард чинь Чамайг хайгаад байна. Валлахи өөрийгөө бодохгүй. Харин Чамд аюул хүргэхээс нь айна,” гэв.

Хүндэт Расул Эзэн маань Яар-и Гардаа:

“–Эбү Бэкир ээ, битгий ай! Андашгүй нь Аллах бидний хамт!” хэмээв. (Ибн-и Кэсир, *эл-Бидая,* III, 223-224; Диярбэкрий, I, 328-329)

Кур’ан-и Кэрим уг байдлыг ингэж ярина:

اِلَّا تَنْصُرُوهُ فَقَدْ نَصَرَهُ اللّٰهُ اِذْ اَخْرَجَهُ الَّذٖينَ كَفَرُوا ثَانِيَ اثْنَيْنِ اِذْ
هُمَا فِي الْغَارِ اِذْ يَقُولُ لِصَاحِبِهٖ لَا تَحْزَنْ اِنَّ اللّٰهَ مَعَنَا فَاَنْزَلَ اللّٰهُ
سَكٖينَتَهُ عَلَيْهِ وَاَيَّدَهُ بِجُنُودٍ لَمْ تَرَوْهَا وَجَعَلَ كَلِمَةَ الَّذٖينَ كَفَرُوا
السُّفْلٰى وَكَلِمَةُ اللّٰهِ هِيَ الْعُلْيَا وَاللّٰهُ عَزٖيزٌ حَكٖيمٌ

“Түүнд (Мухаммедад) **туслахгүй бол, үгүйсгэгчид Түүнийг Маккагаас гаргахад байсан хоёр хүнээс нэг нь байхад Аллахын Түүнд тусалсныг мэдэцгээ. Найздаа «Санаа битгий зов, Аллах бид-**

247. Ибн-и Са’д, I, 228; Халэбий, II, 209.

ний хамт!» гэж байв; Аллах ч Түүнд амар тайвнаа буулгасан, танд харагдахгүй цэргээр Түүнийг дэмжсэн, үгүйсгэгчдийн үгийг доошлуулсан байв. Аллахын үг бол хамгаас өндөр юм. Аллах нь Азиз юм, Хаким юм.” (эн-Тавба, 40)

Эбү Бэкир -радъяллаху анх- ингэж хэлнэ:

“Бид агуйд байхдаа би мүшрикчүүдийн хөлийг харж байсан:

«–Аяа Аллахын Элч ээ, тэд хөлийн доор нэг харах болбол биднийг заавал олно!» гэлээ.

Тэгэхлээр минь:

«–Эбү Бэкир ээ! Гурав дахь нь Аллах буй хоёр хүний тухай юунд санаа зовоо вэ?» хэмээв. (Бухарий, Фэдаилү’л-Асхаб 2, Мэнакиб 45; Мүслим, Фэдаилү’с-Сахаба 1)

❁

Макка дахь арван гурван жилийн тэблиг ба боловсролын чармайлтаас дараа Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-д хоёр дахь нэгэн буйгаар заасан Сэвр нь Хирагаас тустай нэгэн сүнсний боловсролын орон байв.[248] Тэнд нь нууц ба хүчдэлийн урсгалын үзэх, хүн ба орчлонгийн ном дахь үнэнийг унших төлөө байв. Тэнгэрлэг нууцад автах ба зүрхийг хөгжүүлэх хичээлийн тэнхим байв.

Энд гурван өдөр, гурван шөнө байцгаав. Ганцаараа байгаагүй. Анд нь Пайгамбарчуудын дараа хүмүүсийн хамгийн агуу ба үнэт нь буй Хазрат-и Эбү Бэкир -радъяллаху анх-

248. Сэвр нь Хирагаас тустай нэгэн боловсролын орон байв. Хирад итгэл үнэмшлийг үр тарисан, Сэврэд бол хүчидсэн итгэл үнэмшлийг дараа ихсан ба тасаввуфын үр тарисан байв. Үүний заачнааг зүрх нт эхлээд шэриатын мэдэрч, дараа нь тасаввуфыг эзэмшир хэрэгтэй юм.

байв. Хазрат-и Эбү Бэкир нь Түүнтэй агуйд болж гурван хонох нэр хүнд ба эрдэмд хүрсэн, “хоёрын хоёр дахь” болсон байв. Оршигчдын Туяа энэ эрхэм анддаа:

لاَ تَحْزَنْ إِنَّ اللّٰهَ مَعَنَا

“…Санаа битгий зов; Аллах бидний хамт юм!..” (эт-Тавба, 40) айлдаад, бас Аллахын хамт байх (маийет) нууцыг тайтгарч байв. Энэ нь нууц зикир боловсролын эхлэл ба сэтгэлээ Аллахад нээсэн байв.

Өөрөөр хэлбэл Сэвр Агуй нь боолыг дуусашгүй нууцын хорвоонoос Аллахад хүргэх зүрхний үндсэн боловсролын эхлэх орон ба уг тэнгэрлэг зорчдын анхны шат болсон байв.

Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн туяаны үүсвэр байсан зүрхний нууцыг үммэтдээ зарласан нь анх удаа Хазрат-и Эбү Бэкир -радъяллаху анх-ын хамт уг агуйд эхэлсэн ба киямат хүртэл удах Алтан Гинжийн анхны чагт болсон байв.

Итгэл нь хүчээ Хазрат-и Пайгамбарын хайраас л авдаг. Сүнсний хамаг төрлийн зорчлын гол арга нь Түүний хайр бөгөөд Аллахад хүрэх ганцхан арга нь Түүнийг хайрлах байдаг. Учир нь дурлалын шаардлага, хайрын хууль нь амрагтаа мэдэрсэн хайр ба тэр хайраас болж тухайн хүний дуртай юмд ч дурлах юм. Хайрыг шинээр хадгалах нь ч сүнсний холбоотойгоор л боломжтой байдаг.[249] Тэнгэрлэг хайрыг түүхий ба гүехэн ухаанаар ухаарах нь боломжтой байдаггүй.

249. Рабитагийн тухай дэлгэрэнгүй мэдээлэл авахаар хар. Усман Нури Топбаш, *Итгэл Үнэмшлийг Дара ТАСАВВУФ,* х. 249-257, Истанбул 2002.

Хазрат-и Эбү Бэкирийн Пайгамбар Эзэнтэй маань зүрхний холбоог илэхрийлсэн уг явдлын сэтгэл бүрт өөрийнх хязгаар ба багтаамжтай хамаатай нөлөө хийхийг бодож байна:

Хазрат-и Эбү Бэкир -радъяллаху анх- нь Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-тэй ярилцлага бүрт тустай амт авдаг, номлогчийн хамгийн хамгийн дотно анд нь байсан тул, шилмэл үзвэрт хүртээд хажууд нь байхдаа ч Аллахын Элчийг үгүйлдэг байв.

Үүнтэй хамаатай Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн:

"–Эбү Бэкирийн эд барааг ашигласан чинээ өөр хэний ч эд барааг ашиглаагүй..." хэмээсний хариугаар Эбү Бэкир -радъяллаху анх- нулимс гоожуулан:

"– миний бараа зөвхөн Чиний төлөө биш үү, аяа Расулаллах?!." (Ибн-и Мажэ, Мукаддима, 11) гэхээр өөрийгөө хамаг юмынхаа хамт Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм-д зориулсан ба Түүнд байнга алга болохоо илрүүлсэн байдаг. (Сүнсний уг орныг тасаввуфад "Фэна фи'р-Расул" хэмээн илэрхийлдэг.)

❀

Сэвр Агуйд Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- хэсэг хугацаанд ариун толгойгоо Хазрат-и Эбү Бэкир -радъяллаху анх-ын өвдгөнд тавиад зүүрмэглэсэн байв. Тэр хооронд Эбү Бэкир -радъяллаху анх- агуйд тэдэнд ойрхон жижиг нэгэн нүх харав. Ямар нэгэн аюултай амьтан гараад Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийг үймүүлэхгүйн тулд хөлөө шууд Аллахын Элчийг сэрээхгүйгээр нөгөө нүхэн дээр тавив.

Тэнгэрлэг шалгалтаар, үнэхээр удахгүй чиний санаа нь зөв гарав. Нэгэн могой нь Хазрат-и Эбү Бэкирийн хөлийг ширүүн хатгаж хороо урсгав. Тэр агуу сахабийн амь нь маш их өвдсөн тул, Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийг сэрээхгүйн төлөө огт хөдлөөгүй байсан ч, нүднээс унасан хэдэн дусалд саад болж чадаагүй. Энэ дуслаас нэг нь Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн ариун царайнд унав. Тэгэхлээр нь сэрсэн Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм-:

“–Юу байна вэ Эбү Бэкир ээ? Яасан?” хэмээн асуув.

Хазрат-и Эбү Бэкир -радъяллаху анх-:

“–Яагаа ч үгүй, аяа Расулаллах!” гэсэн ч, Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийг давтсанаар юу болсныг ярихаас аргагүй болов. (Бэйхакий, *Дэлаил*, II, 477; Ибн-и Кэсир, *эл-Бидая*, III, 223)

Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- шууд ариун шүлсээ могой хатгасан газар дээр хуруугаараа түрхэв. Аллахын тусламжаар тэр мөчид Эбү Бэкир -радъяллаху анх-ын өвчин ба зовлон дуусаад, шарх нь сэхэв.

Хүчгүй нэгэн туульсаар иим учиртай Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- могойноос асуув:

“–Үүнийг яагаад ингэсэн бэ?”

Могой ч ингэж хэлэв:

“–Аяа Расулаллах аа! Би олон жил Чамайг харах санаагаар энэ жижиг нүхэнд хүлээсээр байна. Яг хүссэндээ хүрэх болохдоо, Таныг харах зам хаагдсан буйг харлаа. Харин хайрын минь ялалтыг дийлэлгүй түүнийг хаасан саадыг хатгахаас аргагүй боллоо.”

Иим л учиртай шүлэгч Фузулий нь Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн махболь ба сүнсний анагаах булаг

байсныг ба Түүнд анд бологсдын үүнийг ашиглахыг зарлахаар ингэж хэлнэ:

(Хэрэв Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн анд буй хүмүүс могойн хор уусан ч тэр хор нь түүнд амины ус байх болно. Гэтэл Тэр Пайгамбарчуудын Хаанд өстөн болсон нь ус уусан ч тэр ус түүнд могойн хор болно.)

Энэ үнэнийг ойлгосон өөр нэгэн жишээ ч Хазрат-и Умар -радъяллаху анх-ын калиф байсан хугацаанд илрэв:

Мэдэгдсэнээр нь Бизансын Император сайхан санааны тэмдгээр Хазрат-и Умарт дайсдаа хожиход ашигтай болохуйц маш хүчтэй нэгэн хор илгээжээ. Амьдрал нь Римийн далд хөнөөлөөр бүрдсэн Бизансын императорын хувьд хэвийн бол ийм ажлыг Хазрат-и Умар -радъяллаху анх- огт тоохгүй. Түүнийг авчирсан элчийн өмнө хорын шилийг бариад зөвхөн бэсмэлэ хэлж буйгаар нь ууна. Хорын ямар ч нөлөө болохгүй.[250]

Ийм байдлууд буюу Аллахын зөвшөөрлөөр хорын хөнөөлөөс хамгаалсан болох нь зөвхөн Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн зүрхний хорвоонoос хувь аваад Түүнтэй нэг болсон шилмэл боолчуудын харъяалсан нэгэн шинж мөн.

Хазрат-и Умар -радъяллаху анх- калиф хийсэн үедээ заримыг түүнийг Хазрат-и Эбү Бэкирээс давуу үзүүлэн ярьсныг сонсохлоороо:

"–Валлахи Эбү Бэкирийн тэр шөнө Умарын хамаг удмаас ч буянтай юм! Мөн Эбү Бэкирийн тэр өдөр Умарын хамаг удмаас илүү буянтай юм! Расулаллах -алэйхиссалатү вэссэлам- агуйд

250. Мустафа бин Халил эз-Загравий, *Рисалэтү'л-Бэсмэлэ, х.* 42. Энд бол хорыг уусныг Халид бин Вэлид -радъяллаху анх- гэж дурддаг.

очихоор гэрээсээ гарахад Эбү Бэкир Түүний дэргэд байлаа,” гэв. (Хаким, III, 7/4268)

❁

Сэвр Агуйд зочин болсон хугацаанд Хазрат-и Эбү Бэкирийн охин Эсма хоол авчирж; хүү Абдуллах бол аавынхаа тушаалаар шөнө бүр агуй тэдний дэргэд хонож, үүрээр салаад, Маккад хоносон шигээ өглөө Курайшийн мүшрикчүүдтэй хамт босдог байв. Хэт ухаантай ба авъяастай залуу байсан Абдуллах нь өглөө ч Курайшийн мүшрикчүүдийн хооронд байж, Пайгамбар Эзэн маань -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн тухай хэлсэн юмыг сонсч, бэлтгэсэн мэх залийг Оршигчдын Туянд мэдээлдэг байв.

Хазрат-и Эбү Бэкирийн чөлөөлсөн Амир бин Фүхэйрэ ч Эбү Бэкирийн малыг Маккачуудын малчдын хамт малладаг байв. Өглөө тэдний хамт гардаг, орой харихдаа малын явдалын удаан болгож бусдаас хоцорч, шөнийн харанхуйнаар малынхаа хамт Сэвр Агуйд буцдаг байв. Манай Пайгамбар ба эрхэм анд нь хэрэгцээний сүүг энэ хонийг сааж авдаг байв. Өглөө эртээр Маккад харьсан Абдуллахын хөлийн мөрийг малын мөрөөр арчдаг, балархай болгодог байв.[251]

Гурван хоногийн турш Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийг хайсан мүшрикчүүд нь одоо Түүнийг олох найдвараа алдсан байв. Абдуллахаас мүшрикчүүдийн найдвар барсныг мэдэж авсан Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- нь дөрөв дэх өдөр газарчийн авчирсан тэмээнд унаж замд орцгоов. Эцэст нь энэ аялал төрж өссөн нутгаас нэгэн салах буй тул Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн гунихад учир болов. Учир нь өөрөө Макка-и Мүкэрээмэд их хайртай

251. Ибн-и Хишам, II, 99; Бухарий, Мэнакибу’л-Энсар, 45; Хэйсэмий, VI, 53.

байв. Энэ тухай нэг удаа Хазвэрэ гэсэн тойрогт зогсон Каба ба харамд нь чиглэж, Маккад хандан ингэж айлдсан байв:

"Валлахи чи Аллахын онгонд хамгийн буянтай ба хамгийн хайртай нь мөн. Намайг гаргаагүйсэн бол би чамаас огт гарахгүйсэн." (Ахмад, IV, 305; Тирмизий, Мэнакиб, 68/3925)

Дахиад нэг удаа Маккад хандан:

"Чи маш гоё нутаг бөгөөд надад ч энхрий санагдана. Хэрэв миний ард намайд чамаас гаргаагүй байсан бол би чамаас өөр газар нутаглахгүй, гэр барихгүй байв," хэмээв. (Тирмизий, Мэнакиб, 68/3926)

Агуу Пайгамбарын уг гунигийг тэнгэрлэг вахий нь тайтгаруулав:

اِنَّ الَّذِي فَرَضَ عَلَيْكَ الْقُرْاٰنَ لَرَآدُّكَ اِلٰى مَعَادٍ قُلْ رَبّٖي اَعْلَمُ مَنْ جَآءَ بِالْهُدٰى وَمَنْ هُوَ في ضَلَالٍ مُبينٍ

"Чамд Кур'аныг (унших, тэблийг хийх ба түүнийг дагахыг) **фарз болгосон** (Аллах) **Чамайг буцах газар чинь буцаах болно..."** (эл-Касас, 85)

Эдгээр үгс нь буцахын сайн мэдээг өгч, мөн Маккагийн ялалтын анхны тэмдэг болохоор Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн сэтгэл дэх гунигийг баяр болгож байв.

❀

Макка Мадина хоёрын хооронд 400 гаруй километрийн зам байдаг. Тэр үед тэмээний явдлаар найман хоногт явууштай байв. Зам нь урт, агаар нь халуун, элс нь дөл шиг бөгөөд ариун хамт олон нь анхны хоррин дөрвөн цаг огт зогсолгүй яваад одов.

Хазрат-и Эбү Бэкир -радъяллаху анх- нь наймааны зорилгоор заримдаа Дамаскад яваад ирсэн тул олон хүн таньдаг байв. Энэ зорчих хугацаанд танил хүнтэй тааралдах тусмаа:

"–Эбү Бэкир ээ! Чиний өмнөх энэ хүн хэн бэ?" гээд Орчлонгийн Хүндэт Эзнийг маань асуугсдад:

"–Миний газарч юм! Надад зам заадаг!" гээд арга хэмжээг хойшоо тавьдаггүй, энэ үгээрээ үнэндээ: "Тэр надад хамгийн буянт замыг заадаг!" гэмээр байв. (Ибн-и Са'д, I, 233-235; Ахмад, III, 211)

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-, Эбү Бэкир Сиддийк ба түүний чөлөөлсөн Амир бин Фүхэйрэгийн хамт Абдуллах бин Үрэйкитйн[252] удирдамжаар Күдэйд гэсэн газар буй нэгэн майханд оров. Энэ майхан нь Үммү Мабэдын байв. Тэр өнгөрж яваа зорчигчийн ус ба хоолны хэрэгцээг хангахыг хичээдэг байв. Мадинагийн ариун зорчигчид ч Үммү Мабэдаас сүү гуйв.

Майханд Үммү Мабэдын нэгэн хонь байсан ч, сүү ба тосноос байтугай, хэтэрхий туранхай байсан тул хөөрхий амьтны сүргээ дагаж бэлчээрт очих хүч ч байгаагүй. Ийм учраас майхны буланд үлдсэн байв. Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- хонийг саахаар зөвшөөрөл асуусанд Үммү Мабэд:

"–Аав ээж минь чамд золиос болог! Хэрэв түүнд сүү олж чадвал саа!" гэв.

Хайрт Пайгамбар маань, Аллах Таалагийн элбэг хайрласны төлөө залбирсны дараа бэсмэлээ татан өөрийнх гараараа тэр өдөр хониноос олон удаа сүү саав.

---

252. **Абдуллах бин Үрэйкит** нь тэр хооронд мүшрик, харин итгэмжтэй хүн байв. Дараа нь мусульман болсон эсэх нь маргалдаантай байсан ч мусульман болсны тухай яриа нь хүчтэй юм.

Үммү Мабэд -радъяллаху анхаа-гийн мэдүүлснээр тэр хонь нь Хазрат-и Умарын калиф байсан үед гарсан гантай үед ч амьдарчээ.

Дахиад Үмүү Мабэд -радъяллаху анхаа-:

“Дэлхий даяар мал амьтан идэх юм олж чаддаггүй байхад бид түүнийг өглөө орой саадаг байлаа,” гээд хонин дахь элбэгийг илэрхийлэв.

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- тэндээс салсны дараа майханд Үммү Мабэдын нөхөр Эбү Мабэд хүрч ирэв. Майханд их сүү олохлоороо гайхаад:

“–Үммү Мабэд ээ! Энэ сүү нь хаанаас ирээ вэ? Хонь хол бэлчээрт, , энд бол саах мал үгүй! Энэ юу вэ?” гэж асуув.

Эхнэр нь:

“–Өнөөдөр манайд ариун нэгэн хүн ирэв. Ийм ийм сайхан байдалтай байв,” гэж тэр өдөр үзсэн зүйлсийг ярив.

Нөхөр нь:

“–Энэ хүнийг надад тайлбарлаад өгөөч дээ!” гэхлээр нь, Үммү Мабэд нь Оршигчдын Туяаг ингэж тайлбарлав:

“–Миний харсан нь гадны төрх нь сайхан, царай нь туяат, ёс суртахуун нь ижилгүй хүн байв. Өөрт нь ямар нэгэн санаа зовох юм байдаггүй бөгөөд, хэтэрхий ялдам биетэй ба гоё галбиртай байв. Нүд нь хар, сормуус нь өтгөн, дуу нь эелдэг байв. Нүдний цагаан нь нэлээд цагаан, хар нь ч нэлээд хар ба байгалийн нүдний будагтай байв. Сормуусны үзүүр нь нарийн, гэзэг нь хар бараан байв. Хүзүү нь урт өндөр бөгөөд, сахал нь өтгөн ба жаахан урт байв.

Дуугүй байхад нь дээр нь тайван ба хүндтэй нь илэрч, ярихад нь гоо сайхан, мишээл ба таатай үг илэрч байв. Үг нь сувдан хэлхээ шиг бөгөөд амнаас нь нэг нэгээр гарч байв. Яриа нь ил, үнэн худлыг маш сайн ялгаж байв. Хүчгүй гэмээр бага ч, залхмаар их ч ярьдаггүй байв.

Холоос харвал хүний хамгийн хүдэр, хамгийн гоё нь, ойрт ирвэл хамгийн нүдэнд дулаахан нь байв. Дунд зэрэг нуруутай бөгөөд, хэт өндөр биш, нүдээр олзлохоор намхан ч байгаагүй. Соёолжийн хооронд ургасан нэгэн соёо бөгөөд, гоо сайхнаараа тэднийг давсан юм шиг байв. Хажуугийн андууд нь бол ямар нэгэн юм хэлбэл амар тайван сонсч, өгсөн тушаалын хэрэгжүүлэхээр гүйлддэг байв. Тэдний үйлчлүүлсэн ба хүндэлсэн нэгэн байв. Мишээсэн царайтай байв. Хэнийг ч буруушахгүй ба загнахгүй байв.”

Эбү Мабэд ийм сайхан тэмдгийг сонсохлоороо тангараг өргөн:

“–Энэ хүн Курайш аймагт илэрсэн Пайгамбар мөн. Би Түүнтэй хамт болоод нөхөрлөхийг маш их хүссэн шүү. Ямар нэгэн арга олбол Түүнийг заавал олно!” гэв.

Тэр үед Маккад хэн гэсэн нь мэдэгдээгүй нэгэн дууны Үммү Мабэдын майханд орсон зочдыг шагших мэдрэмжтэй шүлэг уншсан нь дуудсан байв. Хөнгөн чимээтэй энэ шүлгийг сонссон Хассан бин Сабит ч, Пайгамбар нь дундаас нь гарч явсан ард заавал мөхсөнийг ба Тэр Пайгамбарын Мадинад авралыг тарааж Аллахын үгийг уншсаныг ярьдаг шүлгээрээ хариулсан байв. (Ибн-и Са’д, I, 230-231; VIII, 289; Хаким, III, 10-11)

Эбү Мабэд болон түүний жаргалтай гэр бүлийнхэн бүгдээрээ Исламд ороод сахабий болох нэр хүндэд хүрцгээв.

❁

Ариун хамт олныг яасан ч олж чадсангүй мүшрикчүүд, ологчдод том шагнал амлацгаав. Ийм том шагналд нүд нь гялбагсад ч замд гарсан байв. Сүрака бин Малик ч тэдний нэг байв.

Сүрака нь удаан хайсны дараа Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-тэй тааралдав. Түүнийг харангуутаа морио хурдлуулав. Гэтэл гэнэтхэн морины хөл нь элсэнд бүдрээд, өөрөө ч газар унав.

Хэдий их хичээсэн ч элснээс гараад Пайгамбар Эзэн маань -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн тийш урагшилж чадаагүй. Нэлээд хичээсний дараа ухаан ороод гэмшив. Аллахын Элчийн өршөөлд хоргодов. Хазрат-и Пайгамбар ч түүний төлөө залбирав. Уг залбирлын элбэгээр Сүракагийн морь элснээс аврагдаж гарав. Энэ гайхамшгийг харсан Сүракагийн зүрх нь шууд өөрчилж Расулаллахад дотно анд болчхов. Хамт олны газрыг нууц байлгахаар буцаж явав. Тэдний тийш явагчдыг буцааж эсвэл өөр тийш залав. (Мүслим, Зүхд, 75)

Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн энэ сайхан мэдээ нь бараг Сүразагийн чихэнд хангинаж байв:

"–Аяа Сүрака! Хосровын бугуйвчийг зүүх, бүсийг нь бүслэх ба титмийг тавих үедээ өөрийгөө яаж мэдрэх вэ?"

Үнэхээр Ираныг эзэлж Хосровын бугуйвч, бүс ба титмийг Мадинад авчрахлаар нь Хазрат-и Умар -радъяллаху анх- Сүракаг дуудаж эдгээрийг түүнд зүүлгэж:

"–Сүрака! Гараа өргөж: «Аллаху экбэр! Эдгээрийг "Би хүмүүсийн Раб мөн!" гэсэн Хосров бин Хурмасаас гаргаж Мүдлижийнхнээс Сүрака бин Маликад зүүлгэсэн Аллахад хамд болог!» гэ!" гэв. (Ибн-и Эсир, *Усдү'л-Габэ,* II, 332; Ибн-и Хажар, *эл-Исабэ,* II, 19)

Пайгамбар Эзэн маань Гамим гэсэн газар хүрээд Бүрэйдэ бин Хусайб болон ардтай нь тааралдав. Тэднийг Исламд урив. Тэгэхлээр нь тэд ч Аллахын Элчийг дагаж Исламаар нэр хүнд олцгоов. Оршигчдын Туяа -саллаллаху алэйхи вэ сэллэм- Бүрэйдэ -радъяллаху анх-ад тэр шөнө Мэрьем Сурагийн эхний хэсгийг сургаж өгөв.[253]

Бүрэйдэ толгой дээрх цагаан ороолтыг тайлан:

"–Аяа Расулаллах аа! Та зөвшөөрвөл таны туг баригч болъё!" гэв.

Ингээд Куба тосгон хүртэл Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн тугийг барив.

Бүрэйдэгийн дараа ариун хамт олон Дамаскаас буцаж буй наймааны жинтэй тааралдав. Тэдний хооронд Зүбэйр бин Аввам ч байв. Зүбэйр нь Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- болон Хазрат-и Эбү Бэкир -радъяллаху анх-ад цагаан машлах гэдэг хүрэм өмсгөв. [254]

Хижрэтийн хамт олон Мадина руу аажим аажмаа дөхсөөр байв. Мүшрикчүүд Аллахын Элчийг алахаар хүн бүрийг хөдөлгөсөн ба бусад олон аюул байсан ч Тэр үүргээ биелүүлж, замдаа тааралдсан хүмүүст Исламыг таниулж байв.

Асхаб-и кирамаас Са'д эд-Дэлил[255] -радъяллаху анх- ингэж ярина:

"Нүүдлийн хугацаанд Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- Эбү Бэкир -радъяллаху анх-ын хамт бидэнд ирэв.

253. Ибн-и Са'д, IV, 242.
254. Бухарий, Мэнакибу'л-Энсар, 45.
255. Энэ ариун сахабий нь Мадинад явах дөт замыг Эзэнд маань зааж Рэкүбэгийн зам дээр газарч хийсэн тул "Дэлил" гэсэн нэрээрээ алдаршив.

Тэр хооронд Эбү Бэкирийн нэгэн охин бидний дэргэд сүүний ээжтэй хамт байв. Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- богино замаар Мадинад хүрмээр байв. Бид Түүнд:

«–Энэ нь Рэкүбэ давааны Гаир зам юм. Энд Эслэм аймгаас Мүханан гэж танигдсан хоёр хулгайч бий. Хүсвэл тэднийг бид дайрья,» гэцгээлээ.

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-:

«–Чи биднийг тэдний дэргэд хүргээд өг!» хэмээв.

Тэгээд замд гарцгаав. Рэкүбэг гараад налуу дээр хүрэхдээ, тэр хоёр хулгайчаас нэгэн найздаа:

«–Энэ нөхөр Йеменийх юм,» гэж байв.[256]

Оршигчдын Туяа тэднийг хажуудаа дуудаж Исламыг таниулж мусульман болохыг нь гуйв. Тэд ч мусульман болцгоов. Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- нэрийг нь асуусанд:

«–Бид Мүнахан (доромжилсон хоёр хүн)» гэцгээв.

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-:

«–Эсрэгээр нь та Мүкрэман (цуутай хоёр хүн)» хэмээж сайхан мэдээг хүргэхээр урдуур нь Мадинад очихыг нь тушаав.” (Ахмад, IV, 74)

Хүлээгдсэн Эрхэм Зорчигч

256. Энэ згээрээ Орчлонгийн Хүндэт Эзэн маань Маккагийн хүн буйг илэрхийлэв. Учир нь Маккаг Тихамагийн тойрогт, Тихамаг ч Йемений хил дотор гэж тоолсон байв. Иймл учраас Кабаг “эл-Кабатү’л-Йэманийе” гэдэг байв. (Ибн-и Эсир, *эн-Нихае*, V, 300)



Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- Эзний маань замд гарсны мэдээллийг авсан Мадиначуудын бишрэл оргилд байв. Тэр ариун зорчигчийн замыг үгүйлэн хүлээж байцгаав. Тэр туяат хамт олныг угтах, тэр мөнхийн жаргалын хамт олны

шангаас өчүүхэн ч хүртэхээр хотын гадаа гараад тэсэн ядан хүлээж байцгаав.

Эцэст нь номлохын арван дөрөв дэх жилийн Рэбиүлэввэл сарын 12ны Даваа гаригт[257] нэгэн дуу хамаг мусульманчуудын цээжинд баяр хөөрөөр цуурайтав:

“Хүлээсэн ариун зорчигч ирж байна!..”

Ийм сайхан мэдээгээр тэкбир дуу нь хамаг Мадинаг цуурайтуулж эхлэв.

Мусульманчууд зэвсэглэв. Зарим нь морьтой, зарим нь хөлөөрөө ариун зочныг угтахаар гүйгээд эхлэв.

Хүлээсэн ариун хамт олон нь тэнгэрлэг хамгаалалт доор Мадинад ойрхон Кабад хүрэхлээр нь орчин бялхсан, баяр баясгаланд автсан байв.

Даваануудаас “Талэа’л-бэдрү алэйна”гийн[258] ая ба үг нь долгионоор тэнгэрийг бүрдүүлж, сэтгэлийг хөөрүүлж байв. Түүх нь тэр мөчөөс эхлэн киямат хүртэл болох хамаг юмыг бичих “хижрэтийн тооллыг” эхлүүлж байв.

Угтахаар ирсэн мусульманчуудын ихэнх нь орчонгийн бий болохын учир, Хорвоогийн Эзэн Хазрат-и Мухаммед Мустафаг өмнө нь харж үзээгүй тул таньдаггүй байв. Хэсэг хугацаагаар Хазрат-и Эбү Бэкир -радъяллаху анх-ыг манай Пайгамбар Эзэн гэж бодоцгоов.

Хүндэт Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- Эзэн маань чимээгүй байв. Дээр нь нар тусахлаар нь Хазрат-и Эбү Бэкир -радъяллаху анх- шууд босч хувцасаараа Түүнийг сүүдэрлэж

257. Билгийн тооллын 622 оны 9 сард таарна.
258. Тэргэл сар бидэн дээр мандав.

эхлэв. Мусульманчууд тэгээд л Оршигчдын Туяаг таньж мэдэв.[259]

Мадина энэ өдрөөс хойш Исламын хөгжих ба дэвших орон ба толь нь болов. Күфүрийн харанхуй царай нь энэ хүжрэтээр цонхийв. Мэсжид-и Саадэт ба Мэсжид-и Куба хоёр нь агуу утга агуулан дэлхийн цагаа бартал энэ ариун нүүдлийн хүндэт орон ба дурсамжаар үлдэв.

Энсар нь Мухажирчуудад бараа ба хөрөнгөөр дайлан:

“Энэ миний бараа! Май, тал нь чинийх!..” гэв. Өгөөмөр ба үнэнч зантай Исламын найрамдлын суурийг тавив. Мадина нь Исламын түүхэн дэх арилшгүй орноо эзлэв. Мадинад эзанууд, Рамазанууд, баярууд, зэкатууд, дайнууд тустай илрэлээр үммэтэд үлгэр жишээ болцоов.

Оршигчдын Туяа Кубад байхдаа Амр бин Авфынхнаас Гүлсүм бин Хидмийн гэрт зочин болов. Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- эндээс гараад Са’д бин Хэйсэмэгийн гэрт очоод, тэнд мусульманчуудын хамт сууж ярилцдаг байв.

Са’д бин Хэйсэмэ -радъяллаху анх- гэрлээгүй байсан тул, Мухажирчуудын гэрлээгүйчүүд нь тэнд суудаг байв. Ийм учраас Са’д -радъяллаху анх-ын гэрийг “Мэнзилү’л-Уззаб: Гэрлээгүйчүүдийн Гэр” гэцгээв. (Ибн-и Хишам, II, 110; Ибн-и Са’д, I, 233)

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- Кубад байсан өдрүүдэд шарил оршуулж, өвчтөнийг эргэж, урилганд очдог байв.

259. Бухарий, Мэнакибу’л-Энсар, 45.

Эбү Саид эл-Худрий -радъяллаху анх- асхабын мэдрэмжийг заасан, тэр үетэй хамаатай нэгэн дурсамжийг ингэж дамжуулна:

“Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- Мадинад саяхан ирсэн биднээс нэгнийг орсондоо нас барсныг мэдээлдэг байв. Тэр ч ирээд өвчтөнтэй уулзаж, өршөөл гуйдаг байв. Хүнийг нас барахаар нь хэн нэгэнтэй хамт харьдаг байв. Заримдаа оршуултал нь хүлээдэг байв.

Түүнд зүтгэл учруулахаас санаа зовоод хоорондоо ингэж ярив:

“–Манай өвчтөнийг нас бартал Аллахын Элчид юм хэлэхгүй. Нас барахлаар нь Түүнд хэлнэ. Ингээд Тэр ядрах ч үгүй, цагаа алдах ч үгүй.”

Ингэж эхэлцгээлээ. Манай өвчтөнийг нас барахад Түүнд мэдээлдэг байв. Тэр ч ирээд мөргөлийг нь үйлдэж, өршөөл гуйж, харьдаг байв. Заримдаа ч шарилыг бултал хүлээдэг байв.

Хэсэг хугацаа нь ингэж явав. Дараа нь:

“–Валлахи ингэж ч хийхгүй нь дээр. Энэ ч Расулаллахыг ядраадаг. Шарил байхад түүнийг Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн гэрийн үүдэн дээр аваачаад, мөргөлийг нь тэнд үйлдүүлэг. Энэ нь Түүний хувьд илүү амархан болно,” гэцгээж хийцгээлээ.

Хадисыг дамжуулсан Мухаммед бин Умар их гэж хэлнэ:

“Ийм учраас тэндийг «шарилын мөргөл үйлдэх газар» гэсэн утгаар «мусалла» гэцгээв. Шарилыг байнга тэнд хүргэдэг байв. Аллахын Элчийн таалал төгссөний дараа ч тэр ёсоор үргэлжлэв.” (Ибн-и Са’д, I, 257, Хаким, I, 519/1349)

Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийг Кубад байхад, Хазрат-и Али -кэррэмаллаху вэжхэх- ч, түүнд өгсөн хадгаламжийн барааг эзэн бүрт нь буцааж тэдэнд гүйцэв.

Асхаб-и кирамын Аллахын Элч болон Түүнийг эрхэм дурсгалыг

мэдэрсэн хайрын хөөр ба хэмжээг үзүүлсэн маш олон яриа байдаг. Жишээлбэл асхабаас Бэра бин Азиб -радъяллаху анх-[260] аавынхаа завшаан бүрт Аллахын Элчтэй хамаатай дурсамж сонсох хүслийг ингэж ярина:

“Эбү Бэкир Сиддийк -радъяллаху анх- манай ааваас арван гурван дирхэмээр нэгэн шоохой аваад:

«–Бэрад хэлчих, энийг манайд хүргэж өгчих,» гэв.

Аав:

«–Үгүй! Надад Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн Маккагаас Мадинад яаж нүүснийг ярьтал нь болохгүй,» гэв.

Тэгэхлээр нь Эбү Бэкир -радъяллаху анх- нүүдлийн тухай урт удаан ярив.” (Бухарий, Асхабу’н-Нэбий, 2; Ахмад, I, 2)

Суурь нь Таквагаар Тавьсан Мэсжид: Куба Мэсжид

Нүүдлийн замын анхны буудал асан Кубад Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- нь Амр бин Авфынхахд арван дөрөв хоног зочин болов. Нөгөө алдартай Мэсжид-и Куба энэ

260. **Бэра бин Азиб** -радъяллаху анх- нь Энсар бөгөөд хоч нь Эбү Аммарэ юм. Хижрэтээс өмнө мусульман болов. Ухуд Дайнаас хойш дайн бүрт оролцов. Хижрэтийн тооллын 73 онд Куфад нас барав. Гурван зуун гаруй хадис дамжуулав.

хооронд баригдав. Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм- ч мэсжидийн барилганд биеэрээ ажиллав.

Куба Мэсжид нь Исламын барьсан анхны мэсжид юм. Хижрэт шиг чухал нэгэн байдалд барьсан учраас чухал байр эзэлнэ. Энэ мэсжидийг Кур'ан-и Кэрим:

لَمَسْجِدٌ اُسِّسَ عَلَى التَّقْوٰى مِنْ اَوَّلِ يَوْمٍ

“…Мадинад нүүсэн **анхны өдөрт таквагаар барьсан Мэсжид...”** (эт-Тавба, 108) гэж дурдсан байдаг.[261]

Эбү Хүрэйрэ -радъяллаху анх-:

فِيهِ رِجَالٌ يُحِبُّونَ أَنْ يَتَطَهَّرُواْ وَاللّٰهُ يُحِبُّ الْمُطَّهِّرِينَ

“...Тэнд, цэвэрлэгээнд дуртай хүмүүс байдаг. Аллах ч ихээр цэвэрлэдэг хүмүүст дуртай байдаг,” (эт-Тавба, 108) аетын ч Кубагийн ардын тухай буусныг мэдээлэв. (Тирмизий, Тэфсир, 9/3099; Эбү Давуд, Тахарэт, 23/44; Ибн-и Мажэ, Тахарэт, 357)

Нүүсэн анхны Мухажирчууд Кубад хүрэхдээ, Амр бин Авфынхны хасарваан хатаах газрыг шулуудуулж тэнд мөргөл үйлдэж эхэлсэн байв. Эбү Хүзэйфэгийн чөлөөлсөн Салим нь Кур'аныг хамгийн сайхан уншиж мэддэг байсан тул анхны Мухажирчуудад тэр имам хийж байв.[262]

Оршигчдын Туяа -саллаллаху алэйхи вэ сэллэм- анхны Мухажирчуудын мөргөл үйлдсэн энэ талбайг өргөтгөж Куба Мэсжидийг барив. Мэсжид нь ам дөрвөлжин бүтэцтэй бөгөөд

261. Хазрат-и Умар -радъяллаху анх- дараа нь Хижрэтийг тооллын эхлэлийг уг ает-и кэримэ дэх “анхны өдрөөс” хэмээх үгээс үүсгэв. (Сэмхүдий, I, 248)
262. Ибн-и Са'д, III, 87; IV, 311.

хэмжээ нь ойролцоогоор 32 х 32 метр байв. Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- Кубачуудаас чулуу авчрахыг нэхсэн, тэдгээрээс нэгийг авч киблэгийн зүгт тавиад, Эбү Бэкир ба Умар -радъяллаху анхүма-д ч тэр чигээр хажууд нь чулуу тавихыг тушаасан байв.

Мэсжидийн барилгад хамгийн том зүтгүүрийг Аммар бин Ясир -радъяллаху анх- үзүүлж байв. Ийм учиртай түүнийг “Исламд анх мэсжид барьсан” гэцгээв. [263]

Абдуллах бин Руваха -радъяллаху анх- ч нэг талаар ажиллаж нөгөө талаар шүлэг хэлдэг, ингээд итгэгчдийн ядаргааг тайлдаг байв.[264]

Мэсжидийн мүэззиний үүргийг асхаб-и кирамаас Са’д эл-Куразий -радъяллаху анх- хариуцаж байв.

Мэсжид-и Нэбэвий ба Мадина дахь бусад есөн мэсжид шиг Куба Мэсжидэд ч хүмүүжил ба боловсролын үйл ажиллагаа явж, Пайгамбар Эзэн маань -саллаллаху алэйхи вэ сэллэм- энд ирэх бүртээ үүнийг үздэг байв.[265]

Орчлонгийн гэрэл гэгээ, хоёр ертөнцийн жаргалын удирдагч Эзэн маань -алэйхиссалату вэссэлам-, Бямба гараг бүрт Кубад заримдаа унаатай заримдаа алхаж очоод тэнд хоёр рэкат мөргөл үйлддэг байв.[266] Нэгэн хадис-и шарифдаа бол ингэхийг мусульман бүрт зөвлөж ингэж айлдав:

“–Хэн нь гэртээ сайхан абдэст аваад, дараа нь Куба Мэсжидэд ирж тэнд мөргөл үйлдвэл түүнд нэгэн үмрэгийн ач буян байдаг.” (Ибн-и Мажэ, Икамэ, 197; Нэсаи, Мэсажид, 9)

---

263. Ибн-и Хишам, II, 114.
264. Камил Мирас, *Тэжрид Орчуулсан нь,* X, 106.
265. Хамидуллах, *Исламын Пайгамбар,* II, 771.
266. Бухарий, Фазлу’с-Салат 3, 4; Мүслим, Хаж, 516.

Хазрат-и Умар -радъяллаху анх- калиф байсан үедээ даваа болон пүрэв гаригт энэ газарт зочилж, Кубаг маш хол байсан ч тэмээгээр тийш гүйлгэн ирдэг байв.[267]

Куба Мэсжидийг Хазрат-и Усман ба Умар бин Абдүлазиз өргөтгөв. Дараа нь олон удаа засварт ороод шинэчлэгдэв. Хижрий тооллын 1245 / билгийн тооллын 1829 онд Султан II Махмудын хийлгэсэн ганц минара ба шулуун таазтай мэсжидийг Сауди Арабын засгийн газар нурааж, домтой ба дөрвөн минаратай хийлгэж өргөтгөн дахиад барив.



267. Ибн-и Са'д, I, 245.

Ранунa Хөндийд Анхны Жума Мөргөл

Кубад арван дөрвөн хоног зочин болсны дараа Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- ба хамт олон нь Мадина руу хөдлөв. Баасан гариг байв. Үдийн үеэр “Ранунa Хөндий”д хүрсэн, мөргөлийн үе орсон байв. Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- тэмээнээсээ буув. Тэр хооронд Исламын улс төрийн нэгэн тэмдгээр фарз болсон “Жума буюу Баасан гаригийн мөргөл”ийг үйлдүүлэв. Тэнд эдгээр хутбануудыг хэлэв:

1-р Хутба:

“Аяа хүмүүс ээ!

Үхэхээс өмнө тавба хийцгээ; завшаан байхад салих үйл хийхийг хичээцгээ! Нууц ба ил ихээр садака хандив өгөх ба Аллахыг ихээр дурдаж Рабтайгаа сайхан харилцаа тогтооцгоо! Ингэвэл шим бууж, тусламж хүрч алдсан юмаа гардана.

Аллахын энэ жилийн энэ сарын энэ газарт танд «жума мөргөл»ийг киямат хүртэл фарз болгосныг мэдэцгээ. Эрх тэгш байсан ч үгүй ч тэргүүндээ нэгэн имам байхад намайг амьд байхад эсвэл миний дараа хэн ч тоохгүйгээр эсвэл үгүйсгэж энэ мөргөлийг орхивол, түүний хоёр зах бүү нэгдэг! Тэгээд Аллах түүнд ажил амжилт үл үзүүлэг! Тэр хүний бусад мөргөл ч үгүй; тавба хийвэл өршөөгдөнө... Хэн ч тавба хийвэл, Аллах түүний тавбаг хүлээж авна.” (Ибн-и Мажэ, Икамэ, 78)

“Аяа хүмүүс ээ!

Эрүүлдээ ахиратынхаа төлөө бэлтгэл хийцгээ! Андашгүй нь аль нэг тань ч нас бараад сүргээ малчингүй үлдээх болно. Дараа нь Аллах түүнд хэлмэрчгүй ба багажгүйгээр ингэж хэлнэ: «Миний Расул ирээд тамд тушаалын минь мэдүүлээгүй юү? Би чамд эд бараа, хөрөнгө өгсөн, маш олон сайн сайхныг хайрлав; чи өөрийнхөө төлөө юу авчраа вэ?»

Энэ асуулттай тааралдсан хүн бүр нь хоёр тийшээ харад юу ч олохгүй, урагшаа харвал тамыг л олно...

Тэгэхээр сэрцгээ! Хэн ч хагас хасарваанаар ч гэсэн өөрийгөө галаас хамгаалж чадвал, тэрийг хийг! Хэн ч тэр хагас хасарвааныг олж чадахгүй бол, ядаж сайхан үг хэлээд сайн үйл хийхийг хичээг! Учир нь аливаа сайн сайханд арав дахинаас долоон зуун дахин хүртэл ач буян бичдэг юм.

Аллахын мэнд, энэрэл ба элбэг нь танай дээр байх болтугай!" (Ибн-и Хишам, I, 118-119, Бэйхакий, *Дэлаил*, II, 524)

2-р Хутба:

"Аллахад хамд хийж, Тэрээрээс тусламж гуйя. Бид нэфсинхээ муухайнаас ба үйлсийнхээ муугаас Аллахад хорогдоно. Аллахын авралтад хүргэснийг хэн ч төөрүүлж чадахгүй; төөрүүлснийг ч хэн ч зөв замд залж чадахгүй.

Би гэрчилнэ, Аллахаас өөр бурхан үгүй. Тэрээр цорын ганц; ижил үгүй юм. Үгийн хамгийн сайхан нь Аллахын ном мөн. Аллах хэний зүрхийг Кур'анаар чимэглэж, түүнийг күфүрийн дараа Исламаар аварч, тэр ч Кур'аныг бусад үгсээс илүүд үзвэл, тэр хүн авралд хүрсэн байдаг.

Үнэндээ Аллахын ном нь үг ярианы хамгийн гоё ба хамгийн ойлгомжтой нь мөн.

Аллахын дурласанд дурлаарай! Аллахын үг ба Тэрээрийг дурдахаас битгий залхацгаа. Аллахын үгээс таны зүрх бүү давчдаг! Учир нь Аллахын үг нь бүх юмын давууг хайж сонгоно. Буянт үйлсийг, боолчуудын шилмэл буй Пайгамбарчуудыг,

туульсын хамгийн гоё ба сургамжтайг нь ярина.[268] *Халал ба харамыг тайлбарлана.*

Та зөвхөн Аллахад боолчлогдож, Тэрээрт ямар ч туншь битгий зөвшөөрцгөө! Тэрээрийг ёсоор нь авгайлцгаа! Хийсэн сайхан үйлсийг таны хэл батлаг! Аллахын үгээр нэг нэгээ хайрлаарай! Аллах Таалагийн амласнаа эвдсэнийг тамласныг ав мэдэцгээ.

Аллахын мэнд танд байх болтугай!" (Бэйхакий, *Дэлаил*, II, 524-525)

Эдгээр хутбанууд нь Исламын итгэл үнэмшил, залбирал үйлчилгээ, ёс суртахуун, хууль мэтийн сэдвээр шашны ерөнхий нэгэн тойм шиг байдаг.

Жума мөргөлийг Хижрэтийн хугацаанд фарз болсон нь, мусульманчуудын чуулга болохын чухал ба хэрэгтэйг заадаг.

Мадинад Биширсэн Хүлээлт

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- Кубагаас Мадина руу хөдлөхөд, нагац Нэжжарынхандаа мэдээ илгээв. Тэд ч зэвсэглэж ирээд Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм- Эзэнд маань мэнд хүргэж:

"–Таны аюулгүй байдлыг бид хангасан, та тэмээгээ унаж болно!" гэцгээв.[269]

Жума мөргөлийн дараа Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- тэмээ Касваг унаж, Хазрат-и Эбү Бэкир -радъяллаху

268. Кур'ан-и Кэримийн гуравны нэгээс илүү хэсгийг пайгамбарчуудын туульс бүрдэнэ. Туульсын эрдэм ба нууц учрын тухай хар. Усман Нури Топбаш, *Нэбийчүүдийн Дараалал,* б. 1, х. 11-28, Истанбул 2004.
269. Бухарий, Мэнакибу'л-Энсар, 46.

анх-, Нэжаарынхны хамт олон ба бусад мусульманчуудын хамт Мадинад оров.

Хоёр ертөнцийн Нар Имаму'л-Энбияа -алэйхиссалатү вэс-сэлам- Эзнийг маань илүү зочин болгох нэр хүндээ алдахаа ухаарсан Кубачууд Түүнээс салахын гунигаараа:

"–Аяа Расулаллах аа! Биднээс залхсан учраас уу, эсвэл биднийхээс буянтай газар очихоор уу эндээс салж байна вэ?" гэцгээв.

Пайгамбар Эзэн маань -саллаллаху алэйхи вэ сэллэм-:

"–Надад Мадинад очихыг тушаав!" хэмээж тэдэнд дуртай байснаа илэрхийлэв. (Диярбэкрий, I, 339)

Мадинагийн хамаг итгэгчид нь Аллахын Элчийг зочин болгох хүсэлтэй байцгаав. Хүн бүр Түүнийг гэртээ аваачаад дайлахааар сандраад, энэ тухай нэг нэгтэйгээ маргалдаад байв. Тэгэхлээр нь Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- тэмээ Касвагаа хэлээд:

"–Амьтныг чөлөөт тавьж, замаас нь холдоцгоо; тэр томилогдов (хаана сөхөхийг түүнд мэдүүлсэн байдаг)!" хэмээв. (Ибн-и Хишам, II, 112-113)

Учир нь, ийм байхад л хэнийг ч гомдоохгүйгээр Расулаллахыг хэн зочин болгохыг шийдсэн байхсан.

Тэгээд ариун тэмээ нь нэг хоёр газар сөхөрч боссоны дараа Халид бин Зэйд -радъяллаху анх- буюу Эбү Эйюб эл-Энсарий Хазратын гэрийн өмнөх хөрөнгөд сөхөрч тогтов. Аз жаргалтай сахабий Эбү Эйюб Хазратын сэтгэл тайлбарлашгүй баяр хөөрт автав. Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- Эзнийг маань:

"–Ороод ирэгтүн, аяа Аллахын Расул аа! Гэрийг маань алдаршуулагтун!" гээд гэртээ урив.

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийг Эбү Эйюб -радъяллаху анх-ын гэр лүү явахад, Нэжаарынхны жижигхэн охид хэнгэрэг дэлдэн өөдөөс нь гараад:

نحن جوار من بين الندار   يا حبذا محمد من جار

“Бид Нэжжарынхны охид! Хазрат-и Мухаммедин садан болж, Түүнтэй хөрш болох нь ямар том жаргал, ямар том алдар вэ!” гээд дуулж байв.

Сэтгэлийн хаан Пайгамбар маань -саллаллаху алэйхи вэ сэллэм- тэдэнд:

“–Хэлээч дээ, надад хайртай юу?” хэмээн асуув.

Тэд ч:

“–Тийм аяа Расулаллах аа, Чамд маш их хайртай байна!” гэцгээв.

Тэдний жаргалаар хөөрсөн Орчлонгуудын Эзэн -саллаллаху алэйхи вэ сэллэм- ч:

“–Аллах мэддэг шүү дээ, валлах би ч та нарт хайртай! Валлахи, би ч та нарт хайртай! Валлахи, би ч та нарт хайртай!” хэмээв. (Ибн-и Мажэ, Никах, 21; Диярбэкрий, I, 341)

Бэра бин Азиб -радъяллаху анх- үүнийг ярина:

“Би Мадиначуудыг Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн ирсэнд баяссан шигээ өөр юунд ч баяссаныг харж үзээгүй! Хамаг Мадинагийнхан том-бага, эр-эм нь гудамжид гараад гэрийн дээвэр дээр гарсан:

«–Аллахын Нэбий ирэв! Аяа Мухаммед аа! Аяа Расулаллах аа! Аяа Мухаммед аа! Аяа Расулаллах аа!» гээд баяр хөөрөөр хашхирч байв.” (Бухарий, Мэнакибу’л-Энсар, 45; Мүслим, Зүхд, 75)

Энэс бин Малик -радъяллаху анх- Хазрат ч:

“Би Расулаллахын Мадинад хүрсэн өдрөөс гоё, баяртай, туяатай өдөр харж үзээгүй. Түүнийг ирэхлээр хамаг Мадина нь саруулд автав,” гэсэн байдаг. (Ахмад, III, 122; Тирмизий, Мэнакиб, 1/3618)

Мадинагийн мусульманчууд Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн Мадинад хүрээд ирсэнд мэдэрсэн баяр хөөрийн талархлаар тэмээгээр тахил болгов.[270]

Шүлэгч нь итгэгчдийн Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-д мэдэрсэн хайрыг маш сайхан илэрхийлэв:

Тусламж нэхэх “Аман” гэсэн үг ба “Мухаммед” гэсэн нэрийн эбжэд тооцоо нь тэнцүү байдаг; хоёулаа ч 92 болно. Шүлэгч нь шүлэгтээ хайртын “Аман!” гэж хашхирахдаа үнэндээ Хазрат-и Пайгамбарыг дурдмаар буйг илэрхийлсэн нь шүлгийн уранд үнэхээр маш байсан нэгэн санаачилга юм. Үнэхээр атаархам юм!..

Хижрэт-и Сэнийегээр номлохын Маккагийн эрин дуусч, Мадинагийн эрин эхэлсэн байв.

270. Ахмад, III, 301.

Гарчиг

Өмнөх Үг / 7

Орц / 13

Исламыг Ойлгох ба Амьдралд Сиер-и Нэбигийн
(Хазрат-и Пайгамбарын Амьдралын) онцлог 13
Исламыг Төрөхөд Араб орон Өлгий нь болсны учир. 22
Кабагийн Тэнгэрлэг Хамгаалалт Доор Байсныг
илэрхийлэх Сургамжтай Нэгэн Явдал: Зааны түүх 41
Ибрахим -алэйхиссэлам- ба Ханиф шүтлэг 45

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НОМЛОХООС ӨМНӨХ ХАЗРАТ-И МУХАММЕД
-саллаллаху алэйхи вэ сэллэм-

Хазрат-и Пайгамбарын Мэндэлсэн ба Бага Нас 55

Нүр-и Мухаммедий 55
Пайгамбар Эзний маань Ариун Удам Угсаа 59
Хазрат-и Пайгамбарын Эцэг Абдуллах
Эх Аминатай гэрлэсэн нь 61
Пайгамбар Эзний маань Эцэг Абдуллах Өөд Болсон нь 65
Пайгамбарын маань илчлэх батлах бэлгэ тэмдэг 65
Агуу Мухамед Мэндэлсэн ба Ер Бусын Явдлууд 79

Пайгамбар Эзний маань Нэрүүд 84
Сүүний Эхэд Өгсөн нь 85
Нэг дэх Шэрх-и Садр: Зүрхийг нь Нээсэн Байдал 92
Мадинагийн Аялал ба Ээж нь Нас Барсан нь 94
Өвөө Абдүлмутталибын Хамгаалалт 96
Авга Ах Эбү Талиб Асарсан нь 99
Хоёр дахь Шэрх-и Садр: Пайгамбарын Зүрхийг Энэрэл,
Халамж ба Рахматаар Дүүргэсэн нь 101

Хазрат-и Пайгамбарын Залуу Нас 104

Пайгамбар Эзний маань Тэнгэрлэг Хамгаалалт Доор Өссөн нь .104
Пайгамбар Хонь Хариулсан нь 108
Авга Ах нарынхаа Хамт Аялсан нь 110
Лам Бахиратай Учирсан нь ба Бахирагийн Шннжээ 112
Хилфү'л-Фүдүүл 117
Расулаллах Эзэн Худалдаа Хийсэн нь 119
Лам Настурагийн Тогтоосон нь 123
Хазрат-и Хатижатай Гэрлэсэн нь 124
Аллахын Элч Олон эхнэр авдгийн Нууц Учир нь 126
Пайгамбарын Зэйд бин Харисэг Чөлөөлөн Өргөж Авсан нь 136
Пайгамбар Эзэн Хазрат-и Алиг Хажуудаа Авсан нь 138
Пайгамбар Эзний Хүүхдүүд 139
Кабад Шүүгч Хийсэн нь 142
Кусс бин Саидагийн Яриа 144
Хира Агуйн Ганцаардал 147
Хүүхэд ба Залуу Үеийнх нь Шинж 152

ХОЁРДУГААР БҮЛЭГ
НОМЛОЛ, МАККАГИЙН ЭРИН

Номлол, Маккагийн Эрин 157
Вахийн Эхлэл: Зөнч Зүүднүүд 157

Номлохын Анхны Гурван Жил: Далд Урих Эрин 159

Вахийн Үнэн ба Ирэх Аргууд нь 168
Нүбүввэт ба Рисалэт 183
Пайгамбарчуудын Бэлгэ Тэмдэг 186
Пайгмбар Эзэн маань Хүн Байсан нь 203
Пайгамбар Эзний Үммий Байсны Олон Учир 208
Хилье-и Саадэт 212
Вахий Дахиад Эхэлсэн нь 221
Анхны Мусульманчууд 223
Дару'л-Эркам: Анхны Мусульманчуудын Боловсрол ба Сургаалын Төв 236

Номлолын Дөрөв Дэх Жил 238

Зарлигийг Илэрхийл: Хамгийн Ойртоо Үзүүл 238
Пайгамбар Эзний маань Сафа Даваанд Курайшчуудыг Исламд Урьсан нь 244
Тэблигийн Чухал Тал ба Хэв Маяг нь 253
Исламын Тэблиг ба Шашин Номлох 272
Эбү Лэхэб ба Эхнэр нь Даварсан нь 275
Маккачуудын Тохиролцох Оролдлого 278
Кур'ан-и Кэримийн Ижаз ба Сонсогчид Дээрх Нөлөө нь 289
Мүшрикчүүдийг Кур'аны Эсрэг Хандлага нь 304
Расулаллах ба Кур'аны Эсрэг 311
Тамлалын Эрин 318
Мусульманчуудад Тэсвэр ба Тэвчээрийг Санал Болгох нь ..332

Номлолын Тав Дахь Жил 338

Абиссинид Нүүдэл 338
Гараник Асуудал 340
Абиссинийн Хоёр дахь Нүүдэл 344

Номлолын Зургаа Дахь Жил 348

Курайшийн Нэжашийнаас Нүүдэлчдийг Нэхсэн нь 348
Хазрат-и Хамза Мусульман Болсон нь 354
Хазрат-и Умар Мусульман Болсон нь 360

Номлохын Долоо-Ес Дэх Жил: Дарамт 369

Мүшрикчүүдийн Мусульманчуудыг Гадуурхах Бодлого 369
Дарамт Дууссан нь 374
Шакк-и Камэр: Саран Хоёр Хагалсны Гайхамшиг 378
Пайнамбар Эзэн маань Ямар ч Тохиолдолд Тэблигээ Үргэлжлүүлсэн нь 382

Номлохын Арав Дахь Жил 385

Гунигт Жил: Хазрат-и Хатижа ба Эбү Талиб Өөд Болсон нь ..385
Таифын Аялал 390
Ижилгүй Энэрэл ба Рахманы Тайтгарлууд 393
Оршигчдын Туяанаас Кур’ан Сонсч Итгэж Үнэмшсэн нь ...396
Зарим Аймгуудтай Уулзаад Тэднийг Исламд Урьсан нь 402
Пайгамбар маань Хазрат-и Сэвдэтэй Гэрлэсэн нь 411

Номлохын Арван Нэг Дэх Жил 413

Акабагийн Уулзалт 413
Гурав дахь Шэрх-и Садр: Миражийн Бэлтгэл 415
Ижилгүй Бэлэг нь: Мираж 415
Миражаас Зарим Тэмдгүүд 434
Миражийн Ойлтууд 436

Номлохын Арван Хоёр Ба Арван Гурав Дахь Он 441

Акабагийн Нэг дэх Бий’ат 441

Мус’аб аин Үмэйрийн Багшаар Томилогдсон ба Мадинаг
Кур’анаар Ялсан нь (Номлохын 12-р Жил) 442
Акабагийн Хоёр дахь Бий’ат (Номлхын 13-р Жил) 447
Маккагийн Эриний Тайлан 455
Маккий Аетуудын Шинжүүд 457
Пайгамбарчуудын Сүүлийн Арга: ХИЖРЭТ (Номлохын 13-р
Жил) Хижрэтэд Зөвшөөрөл Олсон ба Мадинад Нүүсэн нь 461
Мүшрикчүүдийн Халдах Төлөвлөгөө 466
Бэрхшээлт Аялал 473
Хүлээгдсэн Эрхэм Зорчигч 490
Суурь нь Таквагаар Тавьсан Мэсжид: Куба Мэсжид 494
Рануна Хөндийд Анхны Жума Мөргөл 498
Мадинад Биширсэн Хүлээлт 500

....

....

....

....

....

....

....

....

....

....

....

....

....

....

....

....

....

....

....

....

....

....

....

....

....

....

....

....

....

....

....

....

....

....

....

....

....

....

....

....

....

....